**УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР**
**МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**

# СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ

## XXVII
## БОТЬ

**ТОЙМ АГУУЛГА**

- **Эдийн засаг**
- **Нийгэм**
- **Эрх зүй, төрийн байгуулал**

УЛААНБААТАР ХОТ, 2018

“Судалгааны эмхэтгэл” (XXYII боть)- ийг
Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргав.

Хянасан: Б.Эрдэнэбилэгт (Ph.D)
Ц.Норовдондог (Ph.D)

Эмхэтгэсэн: Д.Жигваагүнсэл

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Т.Цэнд-Аюуш

## ГАРЧИГ

**I БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСАГ**


**1.1 Төрийн мэдлийн банкууд, тэдгээрийн үйл ажиллагааны онцлог, эрх зүйн орчны талаарх гадаадын зарим орны туршлага ..................................................** 6

*Ц.Норовдондог (Ph.D), Г.Алтан-Оч (Ph.D), Д.Халиун Г.Билгээ, И.Жаргалзаяабямба, Д.Жигваагүнсэл О.Нарантуяа, Р.Нургүл, Р.Оргилмаа, Ц.Элбэгзаяа*

**1.2 Төсвийн хяналт, шинжилгээний хараат бус байгууллагын эрх зүйн орчны талаарх гадаадын зарим орны туршлага ……………………………………………….……..** 37

*Д.Халиун, О.Нарантуяа Р.Нургүл, Ц.Элбэгзаяа*

**1.3 Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын эрх зүйн зохицуулалтын талаарх гадаадын зарим орны туршлага ...............................................................** 71

*Г.Билгээ, И.Жаргалзаяабямба, Ц.Элбэгзаяа*

**1.4 Түрээсийн харилцааны эрх зүйн зохицуулалтын талаарх гадаадын зарим орны туршлага………………………………………………………………………………............** 89

*Г.Билгээ, И.Жаргалзаяабямба, Д.Жигваагүнсэл, Р.Оргилмаа*

**1.5 Оюуны өмчийн үнэлгээ ба эдийн засгийн эргэлтэнд оруулахтай холбоотой гадаадын зарим орны туршлага, эрх зүйн зохицуулалт ........................................** 109

*Г.Алтан-Оч (Ph.D), И.Жаргалзаяабямба, Д.Жигваагүнсэл Р.Нургүл, Р.Оргилмаа, Ц.Элбэгзаяа*

**1.6 Казахстан улсын ашигт малтмалын нөөц ашигласны татвар (роялти)-ын хувь хэмжээний талаарх мэдээлэл, лавлагаа …………………………………………………** 143

*Г.Билгээ*

**1.7 Казахстан улсын газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хууль: 2010, 2017 оны хуулийн харьцуулалт ..........................................................................................** 146

*Г.Билгээ*

**1.8 Бүсчилсэн хөгжил, орон нутаг (сумд)-ийн дэд бүтэц болон хөдөө аж ахуйн зарим нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн талаарх мэдээлэл, лавлагаа..** 163

*Ц.Норовдондог (Ph.D), Г.Билгээ, Д.Жигваагүнсэл, Ц.Элбэгзаяа*


**II БҮЛЭГ. НИЙГЭМ**


**2.1 Сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн эрх зүйн орчин: гадаадын зарим орны туршлага ..........................................................................................** 210

*Д.Халиун, Д.Жигваагүнсэл, Р.Оргилмаа, Ц.Элбэгзаяа*

**2.2 Бага, дунд боловсролын тогтолцоо ба үндэсний өв, соёлыг сургалтын агуулга, хөтөлбөрт тусгасан байдлын талаарх гадаадын зарим орны туршлага** 246

*Д.Халиун, Б.Нандингэрэл, И.Жаргалзаяабямба*

**2.3 Албан журмын даатгалын төрөл, хэлбэр ба эрх зүйн орчны талаарх гадаадын зарим орны туршлага ..........................................................................................** 278

*Г.Алтан-Оч (Ph.D), И.Жаргалзаяабямба, Д.Жигваагүнсэл, Р.Нургүл, Р.Оргилмаа*

**2.4 Алсын зайн удирдлагатай, хүнгүй хөдөлгөөнт төхөөрөмж (дрон) ашиглалтын эрх зүйн зохицуулалт: Монгол Улс болон бусад орнуудын туршлага .................** 305

*Г.Алтан-Оч (Ph.D), И.Жаргалзаяабямба*

**III БҮЛЭГ. ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛ**

**3.1 Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг ард нийтийн санал асуулгаар баталсны дараа албажуулах, хэвлэн нийтлэх, хүчин төгөлдөрт тооцох процесстой холбоотой гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт …..** 322

*Г.Билгээ, Ц.Болормаа, Р.Оргилмаа*

**3.2 Гадаадын зарим орны Үндсэн хууль дахь улс төрийн нам ба намын санхүүжилтийн талаарх зохицуулалт ........................................................................** 331

*Г.Билгээ, Ц.Болормаа*

# 1
# БҮЛЭГ

## ЭДИЙН ЗАСАГ

**ТӨРИЙН МЭДЛИЙН БАНКУУД, ТЭДГЭЭРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**

(Харьцуулсан судалгаа)

*Ц.Норовдондог (Ph.D), Г.Алтан-Оч (Ph.D), Д.Халиун*
*Г.Билгээ, И.Жаргалзаяабямба, Д.Жигваагүнсэл*
*О.Нарантуяа, Р.Нургүл, Р.Оргилмаа*

**АГУУЛГА**

УДИРТГАЛ

Нэг. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой банкуудын хэрэгцээ шаардлага, үйл ажиллагааны онцлог, өнөөгийн байдал

Хоёр. Гадаадын зарим улсын төрийн өмчит банкууд, тэдгээрийн хууль, эрх зүйн орчин:

- ОХУ
- БНХАУ
- ХБНГУ
- БНКАЗ.У
- ЯПОН
- БРАЗИЛ
- ТАЙЛАНД
- БНСУ
- КАНАД
- АВСТРАЛИ

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Хавсралт 1. Гадаадын (2012-2013) болон төрийн өмчит банкны (2010) эзэмшиж буй хөрөнгийн эзлэх хувь

Хавсралт 2. Гадаадын болон төрийн өмчит банкуудын банкны секторт эзлэх хувь хэмжээ (1995-2013)

## УДИРТГАЛ

***Судалгааны хамрах хүрээ:*** Энэхүү судалгаагаар бусад орнуудын төрийн мэдлийн банк, тэдгээрийн үйл ажиллагааны онцлог, төрийн мэдлийн банк байгуулах хэрэгцээ шаардлага, эрх зүйн орчныг харьцуулан судалсан болно.

***Судалгааны үр дүнгийн тойм:*** Төрийн банк гэж төрөөс бүрэн болон хэсэгчилсэн байдлаар шууд болон шууд бусаар хувьцааг нь эзэмшдэг, эсхүл үйл ажиллагаанд нь хяналт тавьдаг банкийг хэлнэ.

Дэлхийн ихэнх орнуудад Төв банк нь төрийн банк байх бөгөөд капитал болон өмч хөрөнгө нь төрийн мэдэлд байдаг учраас ашгийн төлөө бус, үндэсний эдийн засгийн хөгжлийн шаардлагад нийцүүлэн төрийн санхүүжилтийн бодлогыг хэрэгжүүлдэг. Төв банкны үндсэн үүрэг нь эдийн засгийг зохицуулах, арилжааны банкуудын үйл ажиллагаанд хяналт тавих, олон улсын санхүүгийн харилцаанд оролцох, төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд санхүүжилтийн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

Төрийн өмчит арилжааны банкуудын үүрэг нь үндэсний аж ахуйн нэгжүүдийг санхүүжүүлэх замаар төрийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, хөрөнгө оруулалт, санхүүгийн зуучлалын болон төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэх замаар харилцагчдынхаа санхүүгийн байдал, эдийн засгийн идэвхжилд нөлөө үзүүлэхэд чиглэгдэнэ. Төрийн өмчит банкуудын хувьд хувийн банкууд төдийлөн зээл олгох сонирхолгүй, тэдний хувьд ашиггүй боловч ирээдүйд улс орны хөгжилд чухал ач холбогдолтой, олон улсын эдийн засгийн системд улс орны байр суурийг тодорхойлох, стратегийн салбарын аж ахуйн нэгжүүдийг санхүүжүүлэхэд чиглэсэн зээлийн бодлого явуулдгаараа онцлогтой. Бусад орнуудын туршлагаас үзвэл, Иракт Хөдөө аж ахуйн хоршооллын банк болон Иракийн аж үйлдвэрийн банк гүйцэтгэсэн байх жишээтэй. ОХУ-д л гэхэд Россельхозбанк, Внешэкономбанк, Сбербанк болон ВТБ банкууд эдийн засгийн тодорхой салбарыг дэмжих санхүүжилтийн бодлогыг хэрэгжүүлж байна.

Судлаачдын үзэж байгаагаар төрийн мэдлийн банкууд дараах давуу тал болон онцлох шинжийг агуулдаг. Тухайлбал, банкны бизнесийн хувьд арай хуучинсаг хэв маягийг баримталдаг боловч банкны хадгаламжийн хүү харьцангуй бага, төрийн статус нь харилцагчдын мөнгөн хөрөнгийн найдвартай байдлыг хангах баталгаа болж байдаг. Мөн түүнчлэн төр өөрийнхөө бүтцээр дамжуулан хэрэглээний зах зээлийг дэмжих боломжтой байдаг ба энэ хэрээр төрийн банкны зээлийн хүү харьцангуй бага байх боломжтой. ОХУ-ын хувьд л гэхэд, жижиг хэрэглээний зээл олгодог томоохон банкууд нь төрийн банкууд байдаг. Дэлхийн ихэнх орнуудад төрийн банкинд итгэх иргэдийн итгэл өндөр байдаг сэтгэлгээ нийтлэг ажиглагддаг.

Төрөөс банк санхүүгийн байгууллагын хувь эзэмшилд дараах байдлаар оролцдог. Үүнд:

1. ***Хуульчилсан оролцоо*** - Төрийн бодлого, зорилгыг хэрэгжүүлэх тусгайлсан чиг үүрэгтэй банкийг хуулийн дагуу төр өөрийн мэдэлд байлгах, жишээ нь Төв банк. Төв банкны үйл ажиллагааг тусгайлсан хуулиар зохицуулдаг бөгөөд төрийн зүгээс тухайлан хувь эзэмшдэггүй, өөрөөр хэлбэл, Төв банк өөрөө төрийн төлөөллийг гүйцэтгэдэг гэж ойлгож болно.

2. ***Бүрэн оролцоо*** - Төр банкийг 100% (улсын болон орон нутгийн) мэдэлдээ байлгах. Өөрөөр хэлбэл, төрөөс тухайн банкны нийт хувьцааг 100% эзэмшинэ.

3. ***Хэсэгчилсэн оролцоо*** - Төрөөс банкны тодорхой хувь буюу хяналтын багц эзэмшихийг хэлнэ. Үүний сонгодог жишээ нь ОХУ-ын Сбербанк юм. Хэдийгээр хүн бүхэн Сбербанкийг төрийн банк гэдэг ч үнэн хэрэгтээ төрөөс хувьцааных нь 52,32%-ийг “Банк России”-аар дамжуулан эзэмшдэг ба “Банк России”-ийн хувьцааг төрөөс “АСВ”-аар дамжуулан 100% эзэмшдэг.

4. ***Шууд бус оролцоо*** - Төрөөс банкны хувьцааг шууд эзэмшихгүй ч төрийн байгууллагууд болон төрийн өмчит компаниудаар дамжуулан банкны тодорхой хувийг эзэмшихийг хэлнэ. Жишээлбэл, ОХУ-ын Связь Банкны 99%-ийг төрийн мэдэлд байдаг Внешэкономбанк эзэмшдэг бөгөөд тус банкны үйл ажиллагааг

тусгайлсан хуулиар зохицуулдаг төрийн мэдлийн банк юм. Бас нэгэн жишээ бол ВТБ банк санхүүгийн групп нь ВТБ24-ийн 99%-ийг эзэмшдэг бол ВТБ-ийн 60,9%-ийг төр эзэмшдэг учраас ВТБ24 ч гэсэн төрийн мэдлийн банкинд тооцогдоно.

5. ***Хяналтын оролцоо*** - Төрийн байгууллагаас банкны үйл ажиллагаа, актив хөрөнгөнд хяналт тавих замаар оролцох. Жишээ нь, эрх хүлээн авагч томилох, лиценз цуцлах, банкуудыг нэгтгэх, санхүүгийн хүндрэлийг даван туулахад нь дэмжлэг үзүүлэх (санаци хийх) зэргээр төрөөс оролцдог.

Төрийн оролцоотой банкууд төрийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй оролцдогийн хувьд банкны уламжлалт үйл ажиллагаа явуулахаас гадна тухайн банкийг байгуулсан зорилго, статусаас хамаарч тусгайлсан тодорхой зорилтот үйл ажиллагаа явуулж болдог. Тухайлбал:

***Нэг. Арилжааны банк болон төрийн оролцоотой банкны нийтлэг үүрэг***

1. ***Идэвхжүүлэх үүрэг***- Эдийн засаг дахь хуримтлалыг идэвхжүүлэх;
2. ***Татан төвлөрүүлэх*** - Хуулийн этгээд болон хувь хүний гар дээрх мөнгөн хөрөнгийг татан төвлөрүүлж дараа дараагийн хөрөнгийн эргэлтэд оруулах;
3. ***Санхүүгийн зуучлалын*** - Эдийн засагт сул чөлөөтэй байгаа мөнгөн хөрөнгийг зээл хэлбэрээр дахин хуваарилах, ААН хоорондын төлбөр тооцоо гүйцэтгэх, үнэт цаас гаргах, байршуулах;
4. ***Хөрөнгийн зохистой хуваарилалтын*** - Татан төвлөрүүлсэн хөрөнгийг эдийн засгийн үр ашигтай салбаруудад эрсдэлийн аль болох бага түвшинд зохистой хуваарилах;
5. ***Хамгаалалтын*** - Банк дампуурсан тохиолдолд хадгаламж эзэмшигчдийн хохирлыг барагдуулах, нөхөн олговор олгох.

***Хоёр. Төрийн оролцоотой банкны онцлох үүрэг***

1. ***Нийгмийн*** - Үндэсний банкны системд итгэх хувь хүн болон хуулийн этгээдийн итгэлцлийг бий болгох;
2. ***Хөгжлийн*** - Хувийн хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахгүй боловч улс орны эдийн засагт чухал ач холбогдолтой, стратегийн салбарыг зээлийн бодлогоор дэмжих, хөгжүүлэх;
3. ***Эрүүлжүүлэх*** - Эдийн засгийн тодорхой салбаруудыг санхүүгийн хувьд эрүүлжүүлэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

## СУДАЛГААНЫ ХЭСЭГ

### Нэг. ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ БАНКУУДЫН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Төр нь банкны салбарт оролцох ёстой юу? Хэрэв тийм бол төр нь банкны өмчлөгч байх уу? эсхүл татаас өгөх, зохицуулалт хийх зэргээр оролцох уу? гэдэг асуудал бол хөгжлийн эдийн засгийн маргаан дагуулсан асуудлуудын нэг юм. Зарим эдийн засагчид, бодлого боловсруулагчид банкуудын төрийн өмчлөл нь санхүүгийн хөгжилд түлхэц өгөх, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд хэрэгтэй гэж үздэг бол зарим нь банкуудын төрийн өмчлөл нь санхүүгийн хөгжил, эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлдөг гэж үздэг байна.

Банкуудын төрийн өмчлөл, төрийн өмчийн оролцооны асуудлаар дараах дөрвөн онол/үзэл баримтлал түгээмэл хэлэлцэгддэг байна. Нэгдүгээрт, “нийгмийн” үзэл баримтлал талаас нь авч үзвэл, төрийн өмчит банкууд нь зах зээлийн хүндрэлийг даван туулахад туслан, гадаад орчны хүчин зүйлсийг үр дүнтэй ашигласнаар нийгмийн халамжийг хангасан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ гэж үздэг бол “хөгжлийн” үзэл баримтлал талаасаа төрийн өмчит банкууд хувийн секторт санхүүжилт олгохыг хүсдэггүй, зөвхөн арилжааны банкуудаас санхүүжүүлэх боломжгүй эдийн засгийн хөгжлийн суурь болохуйц стратегийн ач холбогдолтой салбарт хөрөнгийн хуваарилалт хийхэд гол үүрэг гүйцэтгэнэ гэж үздэг байна. Мөн эсрэгээр, банкны төрийн өмчлөл нь хөрөнгийн буруу, зохисгүй хуваарилалтыг бий болгож, үр ашиггүй байдалд хүргэж болзошгүй гэж үздэг онолууд байдаг бөгөөд үүнийг “агентын” болон “улс төрийн” онол/үзэл баримтлал гэнэ. “Агентын” онолын дагуу, төр хэдийгээр зөв сэдэл агуулж байвч төрийн хүнд сурталтай холбоотой агентын зардал (төр болон төрийн өмчит банкийг удирдах үүрэг бүхий албан тушаалтны ашиг сонирхлын зөрчил) нь үйл ажиллагааны үр дүнгүй байдал, үргүй зардалд хүргэж болзошгүй гэж үздэг байна. “Улс төрийн” онолын дагуу, төрийн өмчит банкууд нь улс төрчдийн өөрсдийн ашиг сонирхлыг (дахин сонгууль явуулах, хувийн ашиг хонжоо олох гм.) гүйцэлдүүлэх, хөрөнгийн зохисгүй хуваарилалт (дэмжигчдээ санхүүжүүлэх гм.) хийх боломж олгож улмаар эдийн засгийн үр ашиггүй байдалд хүргэнэ гэж үздэг байна.

1990-ээд оноос өргөжин цэцэглэсэн санхүүгийн даяаршил нь дэлхий дахинаа банкны өмчлөлийн тогтолцоонд ихээхэн өөрчлөлтүүдийг авчирч, хөгжингүй хийгээд хөгжиж буй орнуудад гадаадын банкуудын тоо өсөхийн сацуу төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой банкуудын тоо буурч эхэлсэн. 2008-2009 оны Дэлхийн санхүүгийн хямрал (ДСХ)-аас хойш банкны салбарын өмчлөлийн тогтолцоо болон түүний санхүүгийн зуучлалын үр дагаврын талаарх хэлэлцүүлгүүд идэвхтэй сэргэж эхэлсэн бөгөөд зарим судлаачид санхүүгийн хямрал хөгжингүй орнуудаас хөгжиж буй орнуудад шилжсэн/нөлөөлснийг хөгжиж буй орнууд дахь гадаадын банкуудтай холбоотой гэж үздэг байна. Үүний зэрэгцээ төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой банкууд нь системийн хувьд чухал үүрэг гүйцэтгэдэг Бразил, БНХАУ, Энэтхэг зэрэг хөгжиж буй орнууд санхүүгийн хямралаас хурдан гарч чадсан нь хямралын үед төрийн банкуудын боломжит нөлөөллийг бууруулах үүргийн талаарх судлаачдын сонирхлыг нэмэгдүүлсэн байна.

Төрөөс дараах үе шатанд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой банкны хувь эзэмшилд оролцож болдог. Үүнд:

Нэгдүгээрт, ААН нь банк байгуулах тусгай зөвшөөрөл хүссэн бол төрийн зүгээс анх байгуулах үед нь хувьцаа эзэмших буюу эргэлтэд оруулсан хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшиж том хувьцаа эзэмшигч (*major shareholder*) болох;

Хоёрдугаарт, төрөөс нийгмийн болон хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор банк байгуулах, эсхүл банкийг төрийн мэдэлд шилжүүлэн авахаар хуульчилсан бол;

Гуравдугаарт, үйл ажиллагаа нь доголдож буй банкны хувьцааг төр худалдаж авах зэргээр төр банкны хувь эзэмшилд оролцоно.

***Төрийн өмчит банкуудын үйл ажиллагааны онцлог.*** Америк Хоорондын Хөгжлийн банк (IADB)–наас төрийн өмчит банкуудыг гүйцэтгэж буй үйл ажиллагааны төрлөөр нь *first tier* болон *second tier* гэх зэргээр ангилдаг байна.

IADB нь төрийн өмчит банкуудыг дараах 4 бүлэгт хувааж байна. Үүнд: Төрийн

Арилжааны банк, Хөгжлийн банк, *quasi-narrow banks* (Хязгаарлагдмал чиг үүрэгтэй банк) болон Хөгжлийн агентлаг.

Төрийн Арилжааны банкууд нь ерөнхий чиг үүргийн хүрээнд нийгмийн болон хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх боловч хувийн арилжааны банкуудтай ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг. Тухайлбал, хадгаламж хүлээн авах, ААН, хувь хүмүүст зээл олгох бөгөөд хөрөнгө, эх үүсвэрийн хувьд I tier банкинд тооцогдоно.

Хөгжлийн банкууд нь хадгаламж хүлээж авахгүй боловч олон талт агентлагуудын санхүүжилт, бондын санхүүжилт, мөн Засгийн газрын шилжүүлэг зэргээс санхүүждэг. Тиймээс тэд өр төлбөрийн хувьд II tier банкинд (бусад банкаар дамжуулан үйл ажиллагаа явуулдаг) тооцогддог бол хөрөнгийн хувьд бусад банкуудаар дамжуулан зээл олгодог, мөн тодорхой салбаруудад үйл ажиллагаа явуулдаг компаниудад шууд зээл олгодог учраас I болон II tier-т хамаардаг байна. Зарим тохиолдолд эдгээр байгууллагууд нь цэвэр Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүргийг гүйцэтгэх ба Засгийн газрын бүтцийн шинэчлэлд оролцдог байна.

*Quasi-narrow bank*-ууд нь хадгаламж хүлээн авдгаараа төлбөрийн хувьд I tier банкинд тооцогддог боловч олон нийтэд зээл олгодоггүй харин богино хугацааны Засгийн газрын үнэт цаасанд хөрөнгө оруулдаг учраас II tier-т багтдаг байна.

Хөгжлийн агентлагууд нь зээлэх, зээлдүүлэх зэрэг банкны үйл ажиллагааг явуулдаггүй хэдий ч батлан даалт, буцалтгүй тусламж, татаас, техникийн туслалцаа үзүүлэх зэрэг өргөн хүрээ бүхий хэрэгслүүдийг ашиглан үйл ажиллагаагаа явуулдаг.

Төрийн өмчит арилжааны банкууд гол төлөв дараах зорилтуудыг хэрэгжүүлдэг. Үүнд:

i) тодорхой секторуудад зээл олгох;

ii) хувийн секторын зээл олгох сонирхолгүй/сонирхол багатай сегмент, бүс нутагт банкны үйлчилгээ үзүүлэх;

iii) мэдээллийн тэгш бус байдлаас үүссэн зах зээлийн уналтын нөлөөллийг бууруулах;

iv) санхүүгийн хувьд ашиггүй хэдий ч нийгмийн хэрэгцээ, шаардлага өндөр төслүүдийг санхүүжүүлэх;

v) хувийн банкуудтай өрсөлдөх замаар санхүүгийн зуучлалын зардал, зээлийн хүүг бууруулах, эсхүл зохистой хэмжээнд барихыг оролдох.

Эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэхдээ арилжааны бус нөхцөлөөр, эсхүл эдийн засгийн бус шалгуурыг үндэслэн зээл олгодог учраас ашгийн хэмжээ буурахад нөлөөлдөг. Энэ нь эргээд эдийн засгийн эрсдэлийг нэмэгдүүлэх, хөрөнгийн зохисгүй хуваарилалт бий болоход хүргэдэг сул талтай. Түүнчлэн, эдгээр институцийн засаглал сул байх тохиолдолд улс төрийн нөлөө, гадаад хүчин зүйлсээс үүдэн ашигт ажиллагаа нь доогуур үзүүлэлттэй байх магадлалтай бөгөөд чанаргүй зээлийн хэмжээ их байдаг байна. Зарим судалгаанд төрийн өмчит банкуудын зээл олголт нь сонгуулийн мөчлөгтэй эерэг холбоотой болохыг дурдсан байна. Гэвч үүний эсрэг зарим судлаачид төрийн өмчит банкуудын үйл ажиллагааг ил тод, оновчтой явуулснаар эдийн засгийн өсөлт, хөгжлийг дэмжих ба гагцхүү тухайн улс орны санхүүгийн хөгжил сул, институцийн чанар муу тохиолдолд сөрөг нөлөөтэй гэж үздэг байна.

***Төрийн өмчит банкуудын өнөөгийн байдал.*** Өдгөө гадаадын банкууд нь дэлхий дахинаа банкны тогтолцоонд голлох үүргийг гүйцэтгэж байгаа бол төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой банкууд цөөн тооны оронд (үүнд: БНХАУ, БНЭУ, ОХУ) голлох үүргийг гүйцэтгэж байна. (Хавсралт 1.)

Дэлхийн нийт улс орнуудын хэмжээнд гадаадын банкны эзэмшиж буй хөрөнгийн хувь хэмжээ дунджаар 43 хувьтай тэнцүү байгаа бол төрийн өмчит банкуудын эзэмшиж буй хөрөнгийн хувь хэмжээ 18 хувьтай тэнцэж байна. Нэгдсэн дүнтэй харьцуулахад улс орнуудын банкны төрийн өмчлөлийн тогтолцоо харилцан адилгүй байна. (Хавсралт 2.) 2017 онд ОУВС-аас явуулсан судалгаанд 93 улсын гадаадын болон төрийн өмчит банкуудын эзэмшиж буй хөрөнгийн хувийг судалсан байна. Судалгаанд улс орнуудын тогтолцоо нь бүс нутгийн хэмжээнд харьцангуй ижил төстэй байдалтай гарсан ба Латин

Америк, Дэд Сахарын Африк, Зүүн Европ болон Төв Азид гадаадын банкууд хүчтэй байгаа бол Зүүн Ази, Ойрх Дорнод болон Хойд Африкт төрийн өмчит банкууд түгээмэл дэлгэрсэн байна.

*Зураг 1. Банкны тогтолцоон дахь төрийн өмчит банкны (2008-2010 оны дундаж) эзлэх хувь*




Source: World Bank, Global Financial Development Report 2013 (Database and Survey).

Банкны өмчлөлийн бүтцэд гарсан өөрчлөлт 1990-ээд оноос дэлхийн санхүүгийн хямрал хүртэл харьцангуй нэг хэвийн хэмнэл, хуртай явагдаж байсан. Шилжилтийн эдийн засгийн хүрээнд улс орнуудад болж өнгөрсөн банкуудын хувьчлалын давалгаа, либералчилсан шинэчлэл, санхүүгийн даяаршлын хурдацтай өсөлтийн хүрээнд гадаадын банкны оролцоо эрчимтэй нэмэгдсэн. Хөгжиж буй орнуудын хувьд, гадаадын банкуудын эзэмшиж байсан хөрөнгийн голч/медиан (дундаж) нь 1995 онд 8 (16) хувь байсан бол 2000-аад онд 35 (40 хувь) болж, 2010 он гэхэд 52 (50 хувь)-т хүрсэн байна. Өндөр

орлоготой орнуудын хувьд 1995 онд гадаадын банкуудын эзэмшиж байсан хөрөнгийн голч (дундаж) 5 (15) хувь эзэлж байсан бол 2000-аад онд 12 (28) хувь болж 2008 онд 27 (43) хувь болж өссөн байна (Зураг 2.1). Үүний эсрэгээр, төрийн өмчит банкуудын хөрөнгийн хувь бүх бүс нутгуудад буурах хандлага ажиглагдаж байна. Хөгжиж буй орнуудын хувьд төрийн эзэмшлийн банк 1995 онд 40 (40) хувиас 2008 онд 8 (17) хувь болж буурсан байна. Өндөр орлоготой орнуудын төрийн эзэмшлийн банкуудын эзэмшиж буй хөрөнгийн хэмжээ 1995 онд 30 (36) хувь байсан бол 2008 онд 4 (10) хувь болж буурчээ.

Дээр дурдсан чиг хандлагад дэлхийн санхүүгийн хямрал тодорхой нөлөө үзүүлж эхэлсэн ба 2008-2010 онд гадаадын банкуудын эзэмшиж буй хөрөнгийн хувь хэмжээ хөгжиж буй орнуудад 0.2 (3.1) пунктээр, өндөр орлоготой орнуудад 1.6 (2.2) пунктээр тус тус буурсан байна. Хямралын үед ажиглагдсан энэхүү хэлбэлзэл нь банкуудын хил дамнасан цочрооноос гадна хямралд нэрвэгдсэн орнуудын санхүүгийн байгууллагууд гадаад дахь хөрөнгөө татан санхүүгийн алдагдлаа нөхөх, хөрөнгөд тавигдсан илүү чанга шаардлагуудыг хангах зорилготой байсан гэж тайлбарлажээ. Үүний эсрэгээр Зүүн бүсийн банкны салбар дахь хил дамнасан хөрөнгө оруулалт хэвээр үргэлжлээд зогсохгүй, нэмэгдсэн дүнтэй гарсан байна. ЭЗХАХБ-ын гишүүн бус орнуудад 2009-2013 оны хооронд гадаадын эзэмшлийн банкуудын тоо нэмэгдсэн байна.

Гадаадын банкуудын эзлэх хувь багассан бол төрийн өмчит банкуудыг сонирхох сонирхол нэмэгдсэн бөгөөд дэлхийн санхүүгийн хямралаас хойш өндөр орлоготой болоод хөгжиж буй олон орнуудад хямралд өртсөн банкуудыг төрийн мэдэлд авах, дахин хөрөнгөжүүлэх явдал нэмэгдэх хандлагатай байна. Үүний тод жишээ нь Исланд, Казахстан, ИБУИНВУ болон Венесуэл зэрэг орнууд ба тус орнуудын банкны сектор дахь төрийн эзэмшлийн хувь хэмжээ 2008-2010 онд 10 гаруй пунктээр өссөн байна.

Эдгээр ерөнхий чиг хандлагууд нь бүс нутгийн хэмжээнд нийтлэг байгаа ч улс орон бүрт ялгаатай байна. Латин Америкт Испанийн банкууд орон нутгийн банкуудыг худалдан авч, 1990-ээд онд банкны хувьчлалын давалгааны дараа зах зээлийн ихээхэн хэмжээг эзлэх болсон. Гадаадын өмчлөлийн банкуудын тухайн бүс нутагт банкны активт эзлэх хувийн жин өндөр буюу 1999-2010 онд ойролцоогоор 40%, харин төрийн өмчит банкууд 1999-2010 онд ойролцоогоор 13%-тай байсан нь хөгжиж буй орнуудын дунджаас ялимгүй доогуур үзүүлэлт юм. Латин Америк дахь гадаадын өмчлөлийн банкууд дэлхийн санхүүгийн хямралын үед харьцангуй бага алдагдал амссан нь тухайн банкууд нь орон нутгийн санхүүжилтээс ихээхэн хамааралтай, салбаруудын хараат бус байдал харьцангуй өндөр байсан зэргээр тайлбарласан байна.

Зүүн Европ, Төв Азийн банкны системүүд нь гадаадын банкуудын эзлэх хувь өндөр, төрийн өмчит банкны оролцоо дундаж хэмжээтэй гэж тодорхойлогддог. 1990-2000-аад оны хооронд тус бүс нутагт гадаадын банкуудын тоо дэлхийд хамгийн хурдтай өсөлтийг үзүүлсэн нь ЗХУ-ын бутралын дараах хувьчлалын давалгаанаас үүдэлтэй. Гадаадын өмчлөлийн банкуудын эзэмшиж буй хөрөнгийн хэмжээний голч 1995 онд 5 хувиас 2008 онд 60 хувь болж өссөн бол, 2008-2010 онд 60 хувиас 48 хувь болтлоо огцом буурсан байна. Энэ нь барууны зарим банкууд санхүүжилтийн хомсдолд орж, тухайн бүс нутаг дахь үйл ажиллагаагаа зогсоосонтой холбоотой байна. Хямралын үед тухайн орон зайг төрийн эзэмшлийн банкууд дүүргэсэн ба 2008-2010 онд Зүүн Европ болон Төв Азид төрийн өмчлөлийн банкуудын активын дундаж хувь 5 пунктээр өссөн нь бүс нутгийн хувьд хамгийн өндөр үзүүлэлт юм.

Дэд Сахарын Африкийн хувьд гадаадын банкууд тухайн бүс нутагт колончлолын үеэс оршин тогтнон ирсэн ба 1990-2000-аад онд явагдсан санхүүгийн секторын либералчлалаас хойш гадаадын банкуудын эзлэх хувь нэмэгдсээр ирсэн байна. Гадаадын банкуудын эзэмшиж байсан хөрөнгийн голч/медиан нь 1995 онд 34 хувь байсан бол 2000-аад онд 66 хувь болж, 2010 он гэхэд 73 хувьд хүрсэн нь хөгжиж буй орнуудын дунд хамгийн өндөр үзүүлэлт юм. Хөгжиж буй орнуудад дэлхийн эдийн засгийн хямралаас хойш барууны банкууд ихээр гарч явсан ч гадаадын банкуудын эзлэх хувь буураагүй нь хөгжиж буй бүс нутгийн томоохон банкууд, тухайлбал Өмнөд Африк, Нигери, Марокко, Кени болон Того зэрэгт төвтэй Пан-Африкийн банкууд хурдацтай өргөжин тэлж, хөгжсөнтэй холбоотой байна.

Дээрхийн эсрэгээр Зүүн Ази нь гадаадын банкны хөрөнгийн хувь хамгийн бага, төрийн өмчит банкуудын хөрөнгийн хувь хамгийн өндөртэй бүс нутаг юм. Зүүн Ази дахь гадаадын банкуудын оролцоо 1990-ээд оны сүүлээс улс орнууд өөрсдийн банкны сектороо либеральчилж, төрийн оролцоог багасгаж эхэлснээс хойш аажмаар нэмэгдэж ирсэн (гадаадын банкуудын хөрөнгийн хэмжээ 1995 онд 1 хувиас 2008 онд 15 хувьд хүрсэн) ба Мальдив, Пакистанаас бусад оронд харьцангуй бага хувьтай байна. Харин тухайн бүс нутаг дахь төрийн эзэмшлийн банкууд 1995 онд 72 хувиас 2010 онд 39 хувь хүртлээ үлэмж буурсан байна.

1990-ээд оны сүүлээр гарсан Азийн санхүүгийн хямралын дүнд Засгийн газрууд банкны системийг эрүүлжүүлэх бүтцийн өөрчлөлт хийн, банкны тогтолцоогоо нээлттэй болгож эхэлсэн байна. 2001 онд БНХАУ-д явагдсан банкны системийн шинэтгэлээр гадаадын банкуудын оролцоо нэмэгдсэн байна. Бүс нутгийн хэмжээнд гадаадын өмчит банкуудын эзэмшиж буй хөрөнгийн хэмжээ дунджаар 1995 онд 8 хувь байсан бол дэлхийн эдийн засгийн хямралын өмнө 30 хувь болж өссөн байна. 2000-аад оны сүүлээр болсон хямралын үед тухайн бүс нутагт хөрөнгийн урсгалын гэнэтийн саатал үүссэн боловч 2008-2010 оны хооронд дэлхийн банкууд нь бусад бүс нутгуудтай адил үйл ажиллагаагаа хумиагүй байна. Төрийн эзэмшлийн банкуудын хөрөнгийн хувь хэмжээ 1995 онд 23 хувь байсан бол 2008 онд 13 хувь болж буурсан байна.

***Дотоодын банкны салбарын эзэмшил, гүйцэтгэл, өрсөлдөөн.*** Банкуудын төрийн өмчлөл нь банкны салбар дахь өрсөлдөөнд нөлөөлдөг. Төрийн өмчит банкууд хувийн банкнаас илүү үр дүнтэй ажиллах тохиолдолд өрсөлдөөнд түлхэц болж үнийг бууруулахад нөлөөлж болно. Харин хөгжиж буй орнуудын туршлагаас харахад төрийн өмчит банкууд дахь агентын (өндөр албан тушаалтны) зардал нь үйл ажиллагааны үр ашиггүй байдал, зуучлалын чанар муутай байдалд хүргэн, өрсөлдөөний дарамт шахалт үзүүлэх чадварыг нь хязгаарладаг байна.

Банкны төрийн өмчлөл, өрсөлдөөний талаарх судалгаанууд нь харилцан адилгүй үр дүнг харуулах ба төрийн эзэмшлийн банкуудыг хувийн банкуудын үйл ажиллагаатай харьцуулсан бүс нутгийн хэмжээний түүвэр судалгаанд (Латин Америк, Зүүн Ази, Зүүн Өмнөд Ази, Төв болон Зүүн Европ) төрийн өмчит банкууд нь хувийн болоод гадаадын банкуудаас доогуур үзүүлэлттэй гарсан байна. Баруун Европын орнуудын хувьд 1999-2004 онд төрийн өмчит банкууд нь хувийн банкуудтай харьцуулахад ашиг болон зардлын хувьд үр ашиг багатай гарсан бол Германы хувьд (2000 оны байдлаар төрийн өмчит банкны хөрөнгийн эзэмших хувь - 42) ашиг болон зардлын хувьд хувийн банкуудтай харьцуулахад өндөр үзүүлэлттэй гарсан байна.

Олон улс орныг хамруулсан судалгаануудын дүнгээс үзэхэд, хөгжиж буй орнуудад төрийн эзэмшлийн банкуудын үйл ажиллагаа тааруу явагдаж байгаа нь дээрх улс орнууд дахь төрийн эзэмшлийн банкуудын үйл ажиллагааны зорилго нь ашиг олохоос илүүтэйгээр хөгжлийн зорилгуудын хангахад чиглэгддэгтэй холбоотой гэж дүгнэсэн байна.

## Хоёр. ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ТӨРИЙН ӨМЧИТ БАНКУУД, ТЭДГЭЭРИЙН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

### 1. ОХУ

Эдийн засгийн бодит нөхцөл байдал талаас нь авч үзвэл ОХУ-ын банкны системд төрийн оролцоотой банк давамгайлах шинжтэй байдгаараа онцлог юм. Төрөөс банкуудын хувь нийлүүлсэн хөрөнгөнд эзэмшиж байгаа хувиа багасгах, төрийн оролцоог үе шаттайгаар бууруулах арга хэмжээ авч байгаа хэдий ч банкны салбар дахь төрийн оролцоо, эдийн засагт үзүүлж буй үр нөлөөний талаар судлаачид янз бүрийн байр суурьтай байдаг.

Төрийн оролцоотой банкийг эрх зүйн болон эдийн засгийн талаас нь авч үзвэл:

Хууль зүйн хүрээнд "төрийн оролцоотой банк"-ны эдийн засгийн мөн чанарыг тодорхойлсон хуулийн тодорхойлолт, төрийн оролцоотой банкны ангилал болон төрийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд төрийн өмчит банкуудын гүйцэтгэх үүргийг тодорхойлсон хууль зүйн тодорхойлолт хараахан гараагүй байна. ОХУ-ын төрийн өмчит банкны үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын талаарх судалгаа, дүн шинжилгээнээс үзэхэд[1] хууль, эрх зүйн хүрээнд "Төрийн оролцоотой банк" гэсэн тусгайлсан нэр томьёо болон төрөөс банк байгуулах, банкны үйл ажиллагаа эрхлэхийг зохицуулсан эрх зүйн актууд байхгүй байна. Одоогийн байдлаар ОХУ-д төрийн оролцоотой банкны үйл ажиллагааг Иргэний хууль (Гражданский кодекс)-ийн 124,125,214-р зүйл, "Банк болон банкны үйл ажиллагааны тухай" хууль, ОХУ-ын Төв банкны Ерөнхийлөгчийн баталсан "Төрийн болон орон нутгийн удирдах байгууллагын бүх шатны төсөв, төсвийн гадуурх данс, сул чөлөөтэй мөнгөн хөрөнгө болон өмчлөлийн объектоор зээл-санхүүгийн байгууллагын дүрмийн санг бүрдүүлэх тухай" журам мөрдөгдөж байгаа бөгөөд энэ хүрээнд төр болон төрөөс эрх олгогдсон Холбооны улсын төрийн байгууллагууд банкны хувьцааг бүрэн болон хэсэгчлэн эзэмшиж байгаа болно.

*Хүснэгт 1. ОХУ-ын төрийн оролцоотой банкуудын жагсаалт (2018 оны байдлаар)*

| № | Банкууд | Оролцооны хувь | Хувьцаа эзэмшигч | Үйл ажиллагааны онцлог ба эрх зүйн зохицуулалт |
|---|---|---|---|---|
| ***Тусгайлсан хуулиар үйл ажиллагааг нь зохицуулдаг төрийн банкууд*** | | | | |
| 1 | Банк России (ОХУ-ын Төв банк) | | | ФЗ-86 "ОХУ-ын Төв банкны тухай" хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулна |
| 2 | Внешэкономбанк (Эдийн засгийн гадаад харилцаа, хөгжлийн банк) | | | ФЗ-82 "Хөгжлийн банкны тухай" хуулиар үйл ажиллагааг нь зохицуулна. |
| ***Төрийн бүрэн оролцоотой банкууд*** | | | | |
| 3 | АО" Россельхозбанк | 100% | Росимушество | Саналын эрхтэй хувьцаа Төрийн мэдэлд |
| 4 | РНКБ банк (ОХУ-ын Үндэсний арилжааны банк) | 100% | Росимушество | Төрийн мэдэлд |
| 5 | АКБ "Российский капитал" | 100% | АО" АИЖК" | Орон Сууцны Ипотекийн Зээлийн Агентлагийн мэдэлд |
| 6 | АО" МСП Банк" | 100% | ФК РМСБ | Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх Холбооны улсын корпорацийн мэдэлд |
| 7 | АО РОСЭКСИМБАНК | 100% | Внешэкономбанк | Төрийн өмчит компанийн мэдэлд |
| ***Төрийн хэсэгчилсэн оролцоотой банкууд*** | | | | |
| 8 | АО "ГЛОБАЛЭКСБАНК" | 99,99% | Внешэкономбанк | |
| 9 | ПАО АКБ" Связь-Банк" | 99,7745% | Внешэкономбанк | |

[1] Магазинер Я.А "Банки с государственным участием в современной банковской системе РФ", 2013

| | | | | |
|---|---|---|---|---|
| 10 | АО “Всероссийский банк развития регионов” (ВБРР) | 84,67% | НК” Роснефть” | |
| 11 | ОИКБ “Русь” | 48,5972%<br>51,2747% | Оренбургская область<br>Банк Оренбург | 99,73% (Оренбургская область) |
| 12 | ВТБ (ПАО) | 60,93% | Росимушество | Төрийн мэдэлд |
| 13 | АК БАРС | 64,222% | Республика Татарстан | |
| 14 | Сбербанк | 52,32% | Центрбанк | |
| 15 | АКБ “НОВИКОМБАНК” | 53,83613%<br>46,16387% | Ростех<br>Рособоронэкспо рт | |
| 16 | КБЭР “Банк Казани” | 42,1724% | Г. Казань | |
| 17 | АО ГАЗПРОМБАНК | 87,5955%<br>8,5341% | ПАО Газпром, охин компаниуд<br>Внешэкономбанк | |
| 18 | Хакасский муниципальный банк | 33,362% | Г. Абакан | |
| 19 | АО “Рускобанк” | 25%(+1хувьц аа) | Ленинградская область | |
| ***Төрийн шууд бус оролцоотой банкууд*** | | | | |
| 20 | РНКО “Нарат” | 100% | АК БАРС | |
| 21 | ПАО “Крайинвест банк” | 99,99% | РНКБ | |
| ***Төрийн хяналтанд байдаг банкууд*** | | | | |
| 22 | Банк ФК Открытие | 99,99% | Центрбанк | |
| 23 | Генбанк | 72.45%<br>6,89%<br>6,89% | АСБ<br>Республика Крым<br>Город Севастополь | |
| 24 | ТРАСТ | 99,99% | Банк России | |
| 25 | Промсвязь банк | 99,99% | АСВ | |
| 26 | Автоваз банк | 100% | Банк России | |
| 27 | Рост банк | 99,99% | Банк России | |
| *Төрөөс дараах нэр бүхий банкуудад санхүүгийн дэмжлэг үзүүлж хүндрэлээс гаргах арга хэмжээ (санация) авч байна. Үүнд: Банк “Советский”, БИНБАНК, Акиатско-Тихоокеанский банк, ФОНДСЕРВИСБАНК.* | | | | |

## 2. БНХАУ

БНХАУ-д өмчийн олон бүтэцтэй, янз бүрийн чиг үүрэгтэй олон төрлийн банкууд үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- хуульчилсан оролцоотой банкууд (3);
- хэсэгчилсэн оролцоотой банкууд (109);
  - а) төв засгийн газрын оролцоотой банкууд (5);
  - б) арилжааны хамтарсан банкууд (12);
  - в) хотын захиргааны оролцоотой банкууд (133).

БНХАУ-ын банкуудын удирдлагын тогтолцооны хувьд Хятадын Төрийн зөвлөлд харьялагдах Хятадын банкны үйл ажиллагааны зохицуулах хороо[2] нь тус улсын банкны бүх байгууллагуудын үйл ажиллагааг хянах үүрэгтэй ажиллаж байна.

[2] China Banking Regulatory Commission (CBRC).

### Хуульчилсан оролцоотой буюу бодлогын банкууд

БНХАУ-д Хятадын Хөдөө аж ахуйн банк (ХХААБ)[3], Хятадын банк[4], Хятадын Барилгын банк (ХББ)[5], Хятадын Үйлдвэр, худалдааны банк (ХҮХБ)[6] гэсэн бүрэн төрийн өмчит 4 томоохон банк үйл ажиллагаа явуулж байсан. Эдгээрээс гадна Харилцаа холбооны банк[7], Хятадын Хөгжлийн банк[8] (эсхүл Хятадын Улсын хөгжлийн банк), Хятадын Экспорт импорт банк[9] зэрэг олон жижиг банкууд үйл ажиллагаа эрхэлж байсан.

2005 оноос эхлэн бүрэн төрийн өмчит банкуудыг хувьцаат корпораци болгон өөрчлөн байгуулсны үр дүнд БНХАУ-д бүрэн төрийн өмчит 3 банк үлдсэн бөгөөд тодорхой зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд:

1. Хятадын Хөдөө аж ахуйн хөгжлийн банк (ADBC) – БНХАУ-ын хөдөө аж ахуй болон хөдөө аж ахуйн бүсийг хөгжүүлэх;
2. Хятадын Хөгжлийн банк (CDB) – томоохон дэд бүтцийн төслийн хөрөнгийн хариуцна;
3. Хятадын Exim банк – тус улсын экспорт (тэр дундаа дэвшилтэд болон шинэ технологи)-ыг хөгжүүлэх, мөн технологийн сайжруулсан машин, техникийг импортлох зорилготой санхүүжилт олгоно.

### Хэсэгчилсэн оролцоотой банкууд

***а) Төв засгийн газрын оролцоотой буюу төрийн өмчит банкууд***

Хуучин төрийн өмчит бодлогын 5 банк нь хувь нийлүүлсэн арилжааны банк болж өөрчлөн байгуулагдсан. Эдгээрээс 4 банкны дийлэнх хувьцааг Хятадын Ардын банк (PBOC)[10], Сангийн Яам болон Засгийн газрын бусад байгууллагууд эзэмшдэг байна. (Хүснэгт 2.) Үүнээс гадна эдгээр банкны арилжааны бус зарим хувьцааг гадаадын банк эзэмшдэг байна.

*Хүснэгт 2. Төв засгийн газрын оролцоотой банкуудын төрийн эзэмшлийн хувь хэмжээ (2009 оны байдлаар)[11], санхүүжилтийн чиглэл[12]*

| | ***Банк*** | ***Арилжих хөрөнгө (ам.дол, их наяад)*** | ***Төрийн эзэмшлийн хувь*** | ***Санхүүжилтийн чиглэл*** |
|---|---|---|---|---|
| 1. | Хятадын Хөдөө аж ахуйн банк (ХХААБ) (Agricultural Bank of China (ABC)) | 1.019 | 83.13 | хөдөө аж ахуйн салбар |
| 2. | Хятадын банк (Bank of China (BOC)) | 1.084 | 67.53 | гадаад худалдаа, хөрөнгө оруулалт |
| 3. | Харилцаа холбооны банк (Bank of Communications) | 398 | 26.52 | |
| 4. | Хятадын Барилгын банк (ХББ) (China Construction Bank (CCB)) | 1.717 | 57.0 | барилгын болон үндсэн хөрөнгө |
| 5. | Хятадын Үйлдвэр, худалдааны банк (ХҮХБ) (Industrial and Commercial Bank of China (ICBC)) | 1.810 | 70.7 | төрийн өмчийн үйлдвэрлэл |

***б) Арилжааны банкууд***

БНХАУ 1978 онд эдийн засгийн шинэчлэлийг эхлүүлснээс хойш 12 банкыг

[3] Agricultural Bank of China (ABC).
[4] Bank of China (BOC).
[5] China Construction Bank (CCB).
[6] Industrial and Commercial Bank of China (ICBC).
[7] Bank of Communications.
[8] China Development Bank (also known as the State Development Bank of China).
[9] Export Import Bank of China (China Exim Bank).
[10] People’s Bank of China (PBOC).
[11] China’s Banking System, Michael F. Martin, Specialist in Asian Affairs, Congressional Research Service, February 20, 2012.
[12] Banking System Reform in China: The Challenges of Moving Toward a Market-Oriented Economy. Kumiko Okazaki. Published 2007 by the RAND.

арилжааны банк болгож, дараа нь хамтарсан хувьцаат компани болгон тус тус өөрчлөн шинэчилсэн. Ихэнх тохиолдолд, төрийн өмчит банкууд нь ААН болж өөрчлөн шинэчлэгдсэний дараа ч гол хувьцаа эзэмшигчид хэвээр үлдсэн бөгөөд тэдэнд хувьцаагаа заавал эзэмших тодорхой хугацааны дараа хувьцаагаа чөлөөтэй худалдах эрх үүссэн. Зарим банкуудын хувьд төрийн өмчит ААН байж гол хувьцаа эзэмшигч хэвээр үлдэв. (Жишээ нь, CITIC Bank). Дор дурдсан 12 банкнаас 10-аас багагүй нь гадаадын хөрөнгө оруулалттай ААН байна. (Хүснэгт 3.)

*Хүснэгт 3. Хотын арилжааны банкуудын эзэмшлийн хувь нийлүүлсэн бүтэц, хувь хэмжээ[13] (2010 оны байдлаар)*

| | ***Банк*** | ***Төрийн болон төрийн өмчийн ААН-ийн эзэмшиж байгаа хувьцааны хувь*** | ***Дотоодын ААН-ээс эзэмшиж байгаа хувьцааны хувь*** | ***Гадаадын ААН-ийн эзэмшиж байгаа хувьцааны хувь*** | ***Дотоодын гол хувьцаа эзэмшигч*** | ***Гадаадын гол хувьцаа эзэмшигч*** |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | China Bohai Bank | 62.01 | 18.00 | 19.99 | Tianjin TEDA Investment Holding Co. | Standard Chartered Bank (HK) |
| 2. | China Everbright Bank | 74.04 | 21.61 | 4.35 | Central Huijin Investment Co. | China Everbright Ltd. (HK) |
| 3. | China Merchants Bank | 35.3 (доод тал нь) | Тодорхойгүй | 17.83 (доод тал нь) | China Merchants Steam Navigation Co. | JPMorganChase & Co. (USA) |
| 4. | China Minsheng Bank | Тодорхойгүй | 26.91 (доод тал нь) | 15.27 (доод тал нь) | New Hope Investment Co. | Morgan Stanley & Co. (USA) |
| 5. | China Zheshang Bank | 14.29 (доод тал нь) | Тодорхойгүй | Тодорхойгүй | Zhejiang Province Financial Services Development Co. | Тодорхойгүй |
| 6. | CITIC Bank | 63.08 (доод тал нь) | Тодорхойгүй | 30.82 (доод тал нь) | CITIC Group | BBVA (Spain) |
| 7. | Evergrowing Bank | Тодорхойгүй | Тодорхойгүй | 8.33 (доод тал нь) | Yantai Blue Sky Investment Holding Co. | Daiwa Bank (Singapore) |
| 8. | Guangdong Development Bank | 72.20 | 4.11 | 23.69 | China Life Insurance Co. | Citigroup (USA) |
| 9. | Huaxia Bank | 35.99 (доод тал нь) | 6.65 (доод тал нь) | 17.12 (доод тал нь) | ShougangCorp. | DeutscheBank (Germany) |
| 10. | Industrial Bank | 28.89 (доод тал нь) | 3.64 (доод тал нь) | 12.80 (доод тал нь) | Finance Bureau of Fujian Province | Hang Seng Bank (HK) |
| 11. | Shanghai Pudong Bank | Тодорхойгүй | Тодорхойгүй | 2.71 (доод тал нь) | China Mobile Ltd. | Citibank (USA) |
| 12. | Shenzhen Development Bank | Тодорхойгүй | Тодорхойгүй | Тодорхойгүй | Ping An Insurance Group Ltd. | Тодорхойгүй |

***в) Хотын захиргааны оролцоотой буюу хотын арилжааны банкууд***

Хотын захиргааны оролцоотой банкууд нь аймаг, мужийн түвшинд үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны банкууд юм. Зарим аймаг, мужийн засаг захиргаа өөрсдийн банкуудыг (жишээлбэл, Guangdong Development Bank, Shanghai Pudong Development Bank) байгуулсан.

Эдгээр банкуудыг орон нутгийн засаг захиргаанаас бүрэн эзэмшдэг байсан бөгөөд орон нутгийн засаг захиргаанаас орон нутгийн хөгжлийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ашигладаг байсан. 2000 оноос хойш эдгээр банкуудыг хувьцаат компани

---

[13] China's Banking System, Michael F. Martin, Specialist in Asian Affairs, Congressional Research Service, February 20, 2012.

болгон өөрчлөн байгуулж, орон нутгийн засаг захиргаа нь тодорхой хэмжээний хувь эзэмшигч болсон. Хувьцааны дийлэнх нь Хятадын бусад банк, корпорациуд, гадаадын банкууд, банкны ажилтнууд, хувийн хөрөнгө оруулагчдын эзэмшилд байдаг.

*Хүснэгт 4. Хотын зарим арилжааны банкуудын зэмшлийн хувь нийлүүлсэн бүтэц, хувь хэмжээ[14] (2010 оны байдлаар)*

| | **Банк** | **Төрийн эзэмшил** | **Хуулийн этгээд** | **Хувь хүмүүс (үүнд банкны ажилтнууд)** |
|---|---|---|---|---|
| 1. | Chongqing Bank | 53.9 | 43.2 | 2.8 |
| 2. | Fujian Haixia Bank | 29.9 | 49.9 | 20.2 |
| 3. | Guangxi Beibu Gulf Bank | 28.7 | 68.2 | 0.7 |
| 4. | Hankou Bank | 3.7 | 91.9 | 4.4 |
| 5. | Harbin Bank | 33.7 | 61.2 | 5.1 |

Хятадын банкны үйл ажиллагаа зохицуулах хорооны 2015 оны жилийн тайланд дурдсанаар 2015 оны эцсээр тус улсад 133 хотын арилжааны банкууд үйл ажиллагаа явуулж байна. Судалгааны хавсралтад хотын захиргааны оролцоотой буюу хотын арилжааны 92 банкны жагсаалтыг гаргасан болно.

*Хүснэгт 5. Хятадын банкнуудын жагсаалт (төрлөөр)*

| **Банкны төрөл** | **Банкны нэр** |
|---|---|
| **Хуульчилсан оролцоотой банкууд (3)** | |
| | Agricultural Development Bank of China, China Development Bank, Export-Import Bank of China |
| **Хэсэгчилсэн оролцоотой банкууд (109/150)** | |
| а) төв засгийн газрын оролцоотой буюу төрийн өмчит банкууд (5) | Agricultural Bank of China, Bank of China, Bank of Communications, China Construction Bank, Industrial and Commercial Bank of China |
| б) арилжааны банкууд (12) | China Bohai Bank, China Citic Bank, China Everbright Bank, China Merchants Bank, China Minsheng Bank, China Zheshang Bank, Evergrowing Bank, Guangdong Development Bank, Hua Xia Bank, Industrial Bank, Shanghai Pudong Development Bank, Shenzhen Development Bank |
| в) хотын захиргааны оролцоотой буюу хотын арилжааны банкууд (92/133) | Anshan City Commercial Bank, Baotou City Commercial Bank, Bank of Beijing, Cangzhou City Commercial Bank, Changchun City Commercial Bank, Changsha City Commercial Bank, Chengdu City Commercial Bank, Chengde City Commercial Bank, Bank of Chongqing, Bank of Dalian, Dan Dong City Commercial Bank, Daqing City Commercial Bank, Deyang City Commercial Bank, Dezhou City Commercial Bank, Dongying City Commercial Bank, Fuzhou City Commercial Bank, Fushun Commercial Bank, Fuxin City Commercial Bank, Ganzhou City Commercial Bank, Guiyang Commercial Bank, Guilin City Commercial Bank, Harbin City Commercial Bank, Hangzhou City Commercial Bank, Hengyang City Commercial Bank, Huhhot City Commercial Bank, Huludao City Commercial Bank, Huzhou City Commercial Bank, Huangshi City Commercial Bank, Huishang Bank Corporation, Jilin City Commercial Bank, Jinan City Commercial Bank, Jiaxing City Commercial Bank, Bank of Jiangsu, Commercial Bank of Jiaozuo, Jinhua City Commercial Bank, Jin Zhou City Commercial Bank, Jingzhou City Commercial Bank, Jiujiang City Commercial Bank, Kunming City Commercial Bank, Laiwu City Commercial Bank, Lanzhou City Commercial Bank, Langfang City Commercial Bank, Leshan City Commercial Bank, Liaoyang City Commercial Bank, Liuzhou City Commercial Bank, Luzhou City Commercial Bank, Commercial Bank of Luoyang, Mudanjiang City Commercial Bank, Nanchang City Commercial Bank, Bank of Nanjing, Nanning City Commerce Bank, Bank of Ningbo, Ordos Commercial Bank, Panjin City Commercial Bank, Qiqihar City |

[14] China's Banking System, Michael F. Martin, Specialist in Asian Affairs, Congressional Research Service, February 20, 2012.

| | |
|---|---|
| | Commercial Bank, Qinhuangdao City Commercial Bank, Qingdao City Commercial Bank, Qujing City Commercial Bank, Quanzhou City Commercial Bank, Rizhao City Commercial Bank, Bank of Shanghai, Shangrao City Commercial Bank, Shaoxing City Commercial Bank, Shenzhen Pingan Bank, Shengjing Bank, Shijiazhuang City Commercial Bank, Taizhou City Commercial Bank, Tang Shan City Commercial Bank, Bank of Tianjin, Tieling Commerial Bank, Weifang City Commercial Bank, Wenzhou City Commercial Bank, Wuhai City Commercial Bank, Urumqi City Commercial Bank, WuhanUrban Commercial Bank, Xiamen City Commercial Bank, XiangTan City Commercial Bank, Xiangfan City Commercial Bank, Xiaogan City Commercial Bank, Xinxiang City Commercial Bank, Yantai City Commercial Bank, Yichang City Commercial Bank, Yinchuan City Commercial Bank, Yingkou Commercial Bank, Yuxi City Commercial Bank, Yueyang City Commercial Bank, Zhangjiakou City Commercial Bank, Zhejiang Chouzhou Commercial Bank, Zhejiang Mintai Commercial Bank, Zhejiang Tailong Commercial Bank, Zhuzhou City Commercial Bank, Zunyi City Commercial Bank |

### 3. ХБНГУ

ХБНГУ-ын банкны салбар нь дэлхийн хамгийн том банкны систем бөгөөд бүтцийн хувьд олон улсаас ялгаатай өвөрмөц нэгэн онцлог нь банкны нийт зах зээлд хувийн банкны эзлэх хувь хэмжээ нийтийн өмчийн болон хоршооны зээлийн байгууллагатай харьцуулахад маш бага байдагт оршино. Олон улстай харьцуулахад, банкны салбар дахь нийтийн өмчийн хувийн жин өндөр буюу ойролцоогоор 45% байдаг.[15]

Германы банкны салбарын үйл ажиллагааг Зээлийн салбарын тухай хуулиар зохицуулдаг бөгөөд банкны үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийг “Зээлийн байгууллага” гэж тодорхойлдог. Гэвч уг хуулинд эс хамаарах дараах байгууллагуудыг ч мөн тодорхойлсон байдаг. Үүнд: Германы Холбооны банк (төв банк), Сэргээн босголтын зээлийн газар, Нийгмийн даатгалын газар, Холбооны хөдөлмөрийн агентлаг.[16]

Банкны салбарын бүтцийг “Гурван-Баганат-Бүтэц” гэх бөгөөд хувийн хэвшлийн, нийтийн эрх зүйт болон хоршооны банк гэсэн 3 секторт хуваагдана. Үүнд **Хоршооны банк** (1 144 Зээлийн хоршоо болон 2 Хоршооны төв банк), **Нийтийн эрх зүйт зээлийн байгууллага** (431 Хадгаламжийн касс, 10 Муж улсын банк болон Төрөлжсөн банкууд) болон 218 **Хувийн банк** (4 том банк, 159 бүсийн буюу бусад банк болон гадаадын банкны 96 салбар) багтана.[17]

Нийтийн эрх зүйт зээлийн байгууллагад дараах зээлийн байгууллагууд багтана.[18] Үүнд:

- Муж улсын 7 банк[19] (LBBW, BayernLB, HSH Nordbank, LBB, Helaba, NORD/LB, SaarLB). Эдгээр нь жижиглэнгийн үйлчилгээ үзүүлэхгүй бөгөөд зарим нь үүнийг гүйцэтгэх охин компаниудтай байдаг: LBBW банкны харьяа BW-Bank, NORD/LB банкны харьяа Braunschweigische Landessparkasse, BayernLB группийн харьяа DKB болон Helaba банкны харьяа Frankfurter Sparkasse. Муж улсын банкны бүтээгдэхүүнийг холбогдох Хадгаламжийн кассууд хэрэгжүүлдэг. Түүнээс гадна Муж улсын банк нь тухайн улсынхаа төв банкны үүргийг гүйцэтгэх ба том хэрэглэгчдэд үйлчилдэг.
- “Сэргээн босголтын зээлийн газар” банкны групп[20] нь нийтийн эрх зүйт газар бөгөөд нийтийн үүрэг (төрийн даалгавар) гүйцэтгэх Холбооны байгууллага юм. Нийтийн

[15] Г.Алтан-Оч, И.Жаргалзаяабямба “Банк ба банк бус санхүүгийн байгууллагын эрхлэх үйл ажиллагааны хүрээ, түүний хязгаар, үүнтэй холбоотой үүсч буй асуудлын талаарх лавлагаа мэдээлэл” (СТ-16/417) 2017 УИХТГ-ын Судалгааны эмхэтгэл-24
[16] Өмнөхтэй мөн адил
[17] Мөн адил
[18] Германы банкны салбар-Deutsches Bankwesen-германаар https://de.wikipedia.org/wiki/Deutsches_Bankwesen#%C3%96ffentlich-rechtliche_Kreditinstitute
[19] Landesbanken-германаар
[20] KfW Bankengruppe-германаар

үүрэгт нь нийгмийн дундаж давхарга[21] болон амьжиргаа үүсгэн байгуулагч (бизнесийн старт-ап)-дийн дэмжлэг, жижиг дунд үйлдвэрийн газрын хөрөнгө оруулалтын зээл, дэд бүтцийн зориулалтын болон орон сууцны барилгын санхүүжилт, эрчим хүч хэмнэлтийн төхөөрөмжийн санхүүжилт, орон нутгийн дэд бүтэц, боловсролын зээл, экспортын болон төслийн санхүүжилт болон хөгжлийн хамтын ажиллагааны салбар багтана.

- Хадгаламжийн кассуудын төв байгууллага болох DekaBank[22].
- Ойролцоогоор 450 орчим Хадгаламжийн касс[23]. Тэдгээрийн өмчлөгч нь хотууд болон мужийн тойргууд юм. Олсон ашгийг нийтийн сайн сайхны төлөө зарцуулах үүрэг хүлээдэг байна.
- Муж улсын барилгажилтын хадгаламжийн кассууд (LBS)[24]

ХБНГУ-ын Банкны холбооноос жил тутам гаргадаг топ 20 банкны жагсаалтыг 2016 оны байдлаар доорх хүснэгтэнд харуулав.[25]

*Хүснэгт 6. Германы хамгийн том банкнуудын жагсаалт, 2016 оны байдлаар*

| Байр | Нэр | Хэвшил (эрх зүйн хэлбэр) | Хөрөнгө (тэрбум €) | Ажилт-ны тоо | Салбарын тоо |
|---|---|---|---|---|---|
| 1. | Deutsche Bank | Хувьцаат компани (ХК) | 1.591 | 99.744 | 2.656 |
| 2. | DZ Bank | ХК | 509 | 29.341 | 17 |
| 3. | KfW | Нийтийн эрх зүйт газар | 507 | 5.944 | 1 |
| 4. | Commerzbank | ХК | 480 | 49.941 | 1.000 |
| 5. | Unicredit Bank | ХК | 302 | 14.748 | 579 |
| 6. | Landesbank Baden-Württemberg | Нийтийн эрх зүйт газар | 244 | 10.839 | 180 |
| 7. | Bayerische Landesbank | Нийтийн эрх зүйт газар | 212 | 7.133 | 8 |
| 8. | Norddeutsche Landesbank | Нийтийн эрх зүйт газар | 175 | 6.427 | 19 |
| 9. | Landesbank Hessen-Thüringen | Нийтийн эрх зүйт газар | 175 | 6.086 | 15 |
| 10. | ING-DiBa | ХК | 158 | 3.938 | 4 |
| 11. | Postbank | ХК | 147 | 18.112 | 1.043 |
| 12. | NRW.Bank | Нийтийн эрх зүйт газар | 142 | 1.309 | 2 |
| 13. | Landwirtschaftliche Rentenbank | Нийтийн эрх зүйт газар | 95 | 269 | 1 |
| 14. | DekaBank Deutsche Girozentrale | Нийтийн эрх зүйт газар | 86 | 4.556 | 1 |
| 15. | HSH Nordbank | ХК | 84 | 2.164 | 13 |
| 16. | Deutsche Kreditbank | ХК | 77 | 3.032 | 17 |
| 17. | L-Bank | Нийтийн эрх зүйт газар | 75 | 1.236 | 2 |
| 18. | Bausparkasse Schwäbisch Hall | ХК | 66 | 3.186 | 1 |
| 19. | Deutsche | ХК | 63 | 785 | 10 |

[21] Mittelstand-германаар
[22] Zentralinstitut der Sparkassen DekaBank-германаар
[23] Sparkassen-германаар
[24] Landesbausparkasse (LBS)-германаар
[25] Германы хамгийн том банкнуудын жагсаалт-Liste der größten Banken in Deutschland-германаар https://de.wikipedia.org/wiki/Liste_der_gr%C3%B6%C3%9Ften_Banken_in_Deutschland

| Байр | Нэр | Хэвшил (эрх зүйн хэлбэр) | Хөрөнгө (тэрбум €) | Ажилт-ны тоо | Салбарын тоо |
|---|---|---|---|---|---|
| | Pfandbriefbank | | | | |
| 20. | Volkswagen Bank | Хязгаарлагдмал хариуц-лагатай компани (ХХК) | 56 | | |

Эндээс үзэхэд, тухайн салбарыг хувийн хэвшлийн Германы банк (Deutsche Bank) тэргүүлж, Хоршооны төв банк (DZ Bank) удаалж, төрийн өмчийн Сэргээн босголтын зээлийн газар (KfW) гуравдугаар байрт тус тус орсон байна.

## 4. БНКАЗ.У

Казахстан Улс нь төрийн мэдлийн нэг банктай ба энэ нь Казахстаны Хөгжлийн банк юм.[26] Тус банкны цорын ганц эзэмшигч нь “Байтерек Үндэсний Удирдах Холдинг” *(«Национальный управляющий холдинг «Байтерек»)* юм. Байтерек холдинг нь Ерөнхийлөгчийн зарлиг болон Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан төрийн эзэмшлийн байгууллага болно[27]. Түүний төрийн эзэмшлийн хувьцааг эзэмших, ашиглах эрхийг Казахстан Улсын Хөрөнгө оруулалт, хөгжлийн яам хариуцдаг[28].

Хөгжлийн банк нь Ерөнхийлөгчийн ”Казахстаны Хөгжлийн банкны тухай” зарлиг[29], БНКазУ-ын “Казахстаны Хөгжлийн банкны тухай” хууль[30], Засгийн газрын “Казахстаны Хөгжлийн банк” хаалттай хувьцаат компанийг байгуулах тухай тогтоолоор[31] байгуулагдсан.

**Банкны зорилго:** Улсын түүхий эдийн бус салбаруудад хөрөнгө оруулалт хийх замаар эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжих юм.

**Зорилт:**

- хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, сайжруулах;
- үйлдвэрлэлийн дэд бүтэц болон боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- эдийн засагт гадаад, дотоод хөрөнгө оруулалтыг татахад дэмжлэг үзүүлэх юм.

**Банкны баримтлах зарчим:**

- нийгэм, эдийн засгийн хувьд өндөр ач холбогдолтой төслүүдийг дэмжих;
- хоёрдугаар түвшиний банкуудтай[32] стратегийн түншлэл байгуулах;
- төслүүдийн эргэн төлөлт, хүүгийн төлбөр, төслийг буцаах талаар шийдвэр гаргах;
- үйл ажиллагаа нь улсын үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтын бодлоготой уялдах;
- үйл ажиллагаа ил тод байх;
- мөнгө угаах үйл ажиллагаатай тэмцэх зэрэг болно.

***Хөгжлийн банкны үйл ажиллагаа, түүний онцлог, хэрэгцээ шаардлага***

Хөгжлийн банк нь хувийн банкуудаар бүрэн санхүүжүүлэх боломжгүй бөгөөд нийгэм, эдийн засгийг хөгжүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг урт хугацааны санхүүжилтээр хангах зорилготой. Өөрөөр хэлбэл, хөгжлийн банкны төсөл хөтөлбөрүүд нь эдийн засгийн өсөлт, эдийн засгийг төрөлжүүлэх болон шинэчлэх, нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд

[26] https://www.kdb.kz/kz/about/
[27] http://adilet.zan.kz/kaz/docs/P1400000674#z764
Об утверждении Стратегии развития акционерного общества "Национальный управляющий холдинг "Байтерек" на 2014 - 2023 годы, Постановление Правительства Республики Казахстан от 18 июня 2014 года
[28] https://www.baiterek.gov.kz/kz/about/management/owner/
[29] http://adilet.zan.kz/rus/docs/U000000531_
О Банке развития Казахстана, Указ Президента Республики Казахстан от 28 декабря 2000 года N 531
[30] http://adilet.zan.kz/kaz/docs/Z010000178_
О Банке Развития Казахстана, Закон Республики Казахстан от 25 апреля 2001 года N 178
[31] http://adilet.zan.kz/rus/docs/P010000659_
О создании закрытого акционерного общества "Банк Развития Казахстана", Постановление Правительства Республики Казахстан от 18 мая 2001 года N 659
[32] Төв банкнаас бусад арилжааны чиглэлийн банкууд

дэмжлэг үзүүлнэ.

**Хөгжлийн банкны үндсэн үүрэг:**

- хөрөнгө оруулалтын төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор урт хугацааны зээл олгох;
- гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтыг татахад дэмжлэг үзүүлэх;
- эдийн засгийн тэргүүлэх салбаруудын томоохон төслүүдийг үнэлэх, төслүүдийн бүтцийг тодорхойлох;
- эдийн засгийг сэргээх зорилгоор хэрэгцээт зээлийн эх үүсвэрээр хангаж, санхүүгийн хямралын сөрөг үр дагаврыг багасгах юм.

Хөгжлийн банк нь урт хугацааны хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн хомсдлыг нөхөх бөгөөд өндөр эрсдэлтэй, урт хугацаанд эргэн төлөгдөх, өгөөж бага, их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай төслүүдийг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлдэг. Үүрэг, зориулалт нь өөр учраас арилжааны банктай өрсөлдөхгүй.

Хөгжлийн банкны үндсэн үйл ажиллагаа нь зээл олгох юм. Зээлийг дараах салбаруудад олгоно, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- эрчим хүч, харилцаа холбоо, тээврийн салбарын дэд бүтцийн объектууд;
- төмөрлөгийн үйлдвэрлэл, төмөр эдлэлийн үйлдвэр, машин үйлдвэрлэх, химийн болон газрын тос-химийн үйлдвэрлэл, бусад салбарын үйлдвэрүүд;
- хүнс болон унд үйлдвэрлэх салбарын объектууд;
- арилжааны чиглэлийн үйлчилгээний салбарын объектууд: аялал жуулчлал, байгаль орчин, эрүүл мэнд, боловсрол, биеийн тамир, зочид буудал зэрэг болно.

Зээлийг голдуу үндэсний мөнгөн тэмдэгтээр олгохыг зорьдог. Ер нь хөгжлийн банкууд олгож буй зээлийнхээ ихэнх хэсэг буюу 80-аад хувийг үндэсний валютаар олгодог жишигтэй байна.

**Хууль эрх зүйн орчин:** Хөгжлийн банкны үйл ажиллагааг “Казахстаны Хөгжлийн банкны тухай” хуулиар (*О Банке Развития Казахстана*) зохицуулдаг. Мөн “Казахстаны Хөгжлийн банк”-ыг 2014-2023 онуудад хөгжүүлэх стратегийг хэрэгжүүлдэг.

## 5. ЯПОН[33]

**Төрийн санхүүгийн байгууллагын бүтцэд** Development Bank of Japan(DBJ), the Japan Bank of International Cooperation (JBIC), the The Shoko Chukin Bank (SCB), Japan Finance Corporation(JFC), The Okinawa Development Finance Corporation and The Japan International Cooperation Agency (JICA) зэрэг ордог байна.

### 1. <u>Япон Улсын Хөгжлийн банк[34] (DBJ)</u>

DBJ нь: 2008 оны 10-р сарын 1-ны өдөр Японы Хөгжлийн банк болон Хөгжлийн банкны шинэ корпорацийг үүсгэн байгуулсан ба Хөгжлийн банкны тухай хуулийг 166 дахь ээлжит Парламентын дээд танхимын нэгдсэн хуралдаанаар баталсан байна.

**Хөгжлийн банкны эзэмшлийг** Сангийн сайдаар уламжлан Япон Улсын Засгийн газар эзэмшдэг. (Токио хотод төвтэй, Японы Хөгжлийн банк нь төрийн өмчит 100% санхүүгийн байгууллага юм[35]).

**Хөгжлийн банкны үйл ажиллагааны зорилго нь:** урт хугацааны бизнесийн хөрөнгө оруулалт, зээлийг хадгалах, хөрөнгө оруулалт, зээлийн нэгдсэн арга хэлбэрээр үйл ажиллагааг хангах замаар бизнесийн үйл ажиллагааг санхүүжүүлэх, хөгжүүлэх асуудал юм.

**Санхүүжилт:** Японы Засгийн газрын баталгаатай бонд, баталгаат бус бондыг гаргах замаар санхүүжүүлдэг. Хямралын үйл ажиллагаанд Засгийн газраас өргөн барьсан нийт

---

[33] Засгийн газрын экспорт ,2017https://www.export.gov/article?id=Japan-Banking-Systems
[34] Японы Хөгжлийн банк http://www.dbj.jp/en/co/info/law.html
[35] Оксфорд Их Сургууль “Японы Хөгжлийн банк” http://www.dbj.jp/en/topics/dbj_news/2018/files/0000030152_file1.pdf

санхүүжилт (2017 оны 3-р сарын 31-ний байдлаар) 206,529 сая иен байна. 2017 оны 3-р сарын 31-ний байдлаар арилжааны үнэт цаас худалдан авалт, алдагдлын баталгааны гэрээтэй зээл:

- Зээл: 6,130.6 тэрбум иен (1,145 төсөл)
- Баталгааны гэрээ, бүхий зээлүүд: 268,3 тэрбум иен

(Японы Санхүүгийн Корпорацид өргөдөл гаргахаар төлөвлөж буй 47 төслүүд) Арилжааны үнэт цаас худалдан авалт: 361.0 тэрбум иен байна[36].

**Японы Хөгжлийн Банкны тухай хууль** (Development Bank of Japan Inc Act)[37] Хуулийн зорилго нь: урт хугацааны бизнесийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүгийн үйл ажиллагааг бэхжүүлэх, хөрөнгө оруулалт, санхүүжилт болон бусад санхүүгийн аргыг ашиглан бизнесийн үйл ажиллагаа явуулах замаар хувьчлалыг бий болгох, менежментийн бие даасан байдлыг хадгалах, урт хугацааны бизнесийн сан, санхүүжилт шаардагдах төсөл, аж ахуйн нэгжид хөрөнгө оруулалт хийх, баталгаа гаргахад оршино.

## 2. Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Банк[38] (JBIC)

JBIC нь Японы Экспорт-Импортын банк (JEXIM) болон Гадаад орнуудтай харилцах эдийн засгийн хамтын ажиллагааны сан (OECF)-ийг нэгтгэж Японы төрийн санхүүгийн байгууллага, экспортын зээлийн агентлаг болон 1999 оны 10-р сарын 1-ний өдөр байгуулагдсан байна. 2008 оны 10-р сарын 1-нд байгуулагдсан Японы Санхүүгийн Корпорацийн (JFC) олон улсын салбарыг байгуулсан. 2012 оны 4-р сарын 1-ний өдөр JFC-ээс бие даасан байна. Токио хотод төвтэй, 21 салбартай 18 оронд үйл ажиллагаа явуулдаг.

**JBIC [39] нь:** Японы Засгийн газар эзэмшдэг бөгөөд Засгийн газар, олон улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор дараах 4 чиглэлээр санхүүгийн үйл ажиллагаа явуулдаг байна. Үүнд:

- чухал ач холбогдолтой гадаад эх үүсвэрийг хөгжүүлэх, нөөцийг эх үүсвэрээр хангах;
- үйлдвэрлэлийн олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, сайжруулах;
- дэлхийн хэмжээнд урьдчилан сэргийлэх, байгаль орчныг хамгаалах, гадаад бизнесийг дэмжих;
- олон улсын санхүүгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хохирол учирсан тохиолдолд арга хэмжээ авах зэрэг болно.

**Банкны гол зорилго нь:** Япон, гадаад улс орнуудын хооронд эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх, олон улсын худалдааг хөгжүүлэх замаар дэмжих явдал юм. Мөн Японы экспорт, импортыг дэмжих, гадаадад үйл ажиллагаа явуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Олон улсын санхүүгийн дэглэмийг тогтворжуулах, тогтвортой хөгжлийг дэмжихэд хувь нэмрээ оруулж, санхүүгийн институциудтай өрсөлдөхгүй байх бодлого баримталж байна. Тус банк нь Япон улсын албан ёсны хөгжлийн тусламжийн[40] (ODA) арга хэрэгсэл бөгөөд энэ нь улс орны гадаад бодлогыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулдаг.

**Санхүүжилт** [41]

- Хөрөнгийн хэмжээ - 1,683.0 тэрбум иен
- Зээл, үл хөдлөх хөрөнгө - 14,657.4 тэрбум иен
- Гаргасан баталгаа 2,385.0 тэрбум иен байна.

**Хууль эрх зүйн зохицуулалт[42]:** 1999 оны 4-р сарын 23-ны өдөр “Японы олон улсын хамтын ажиллагааны тухай” хуулийг Парламентын дээд танхимын нэгдсэн хуралдаанаар баталсан. Энэ хууль нь Японы олон улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмэр

---

[36] Японы Хөгжлийн банкны 2017 судалгаа, 33х http://www.dbj.jp/en/pdf/CSR_disclo/2017/02.pdf
[37] Засгийн газар https://www.sec.gov/Archives/edgar/data/1109609/000119312513362157/d570406dex1.htm
[38] Japan Bank for International Cooperation
[39] JBIC 2017 тайлан https://www.jbic.go.jp/en/information/annual-report/pdf/2017E_00_full.pdf
[40] Official Development Assistance
[41] JBIC 2017 тайлан https://www.jbic.go.jp/en/information/annual-report/pdf/2017E_00_full.pdf
[42] Япон Засгийн газар https://www.sec.gov/Archives/edgar/data/1551322/000119312513375292/d575453dex996.htm

оруулах, гадаад хөгжлийг дэмжих, нөөц баялгийг хангах, санхүүгийн үүрэг хариуцлагыг хүлээх зорилготой. Япон Улсын хувьд үйлдвэрүүдийн олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, сайжруулах, дэлхийн дулаарлаас урьдчилан сэргийлэх зорилгоор дэлхийн бизнесийг дэмжих зорилготой. Түүнчлэн, олон улсын санхүүгийн дэглэмийг тасалдуулахаас урьдчилан сэргийлэх, шаардлагатай санхүүгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүгийн байгууллагаас хэрэгжүүлж буй гүйлгээг сайжруулах, хохирол учирсан тохиолдолд зохих арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Энэ хуулийн нэмэлт өөрчлөлтийг 2016 оны 5 дугаар сарын 11-ний өдөр тусгажээ. Нэмэлт өөрчлөлтийн зорилго нь JBIC-ийн гадаад дахь дэд бүтэц болон нийгэм-эдийн засгийн бусад үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийг даван туулахын тулд JBIC-ийг Японы компаниудын гадаадад бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх, JBIC функцийг сайжруулах явдал юм.

## 3. Японы Шуудан Банк (JPB)

2007 оны 10-р сарын 1-нд Япон шуудан нь өөрийн бизнесийг Япон Шуудан Холдинг ХХК болон Шуудангийн үйлчилгээ, Япон Шуудан банк, Япон Шуудан Даатгал гэсэн 4 компанид хувьчлалыг хуулийн дагуу шилжүүлсэн байна.

**Шуудан банкны эзэмшил нь:** 2007 оны 10-р сард Японы Шуудан Банкны хувьчлагдах хууль хэрэгжиж, Японы Шуудан Банк, Япон Шуудан Даатгал, Японы Шуудан Холдинг ХХК-ны охин компаниудыг Засгийн газраас санхүүжүүлж, үйл ажиллагаагаа эхэлсэн. Энэ байгууллагууд 100% хувийн Засгийн газрын санхүүжилттэй байдаг тул тэдгээрийг "Төрийн санхүүгийн байгууллагууд" гэж нэрлэдэг байна.

**Санхүүжилт:** Санхүүгийн жилийн эцэст нийт актив 292,126.5 тэрбум иен, цэвэр актив 10,935.3 тэрбум иен болсон байна. Японы Пост Группийн нэгдсэн цэвэр орлого нэг тэрбум 1,176.8 тэрбум иен, цэвэр орлого 468.9 тэрбум иен болсон байна. (2012-03-31)

2016 оны байдлаар банкны нийт актив 714,4 тэрбум доллар, нийт орлого 3 тэрбум ам доллар байна[43].

**Хууль эрх зүйн зохицуулалт[44]:** 2012 оны 4-р сарын 27-нд энэ хувьчлалын дараа 180 дэх ээлжит чуулганы Парламентын дээд танхимын нэгдсэн хуралдаанаар "Шуудан үйлчилгээний хувьчлалын хууль, бусад баримт бичгийн хэсэгчилсэн засвар хийх тухай" хуулийг баталж, 2012 оны 5-р сарын 8-нд нэмэлт өөрчлөлт оруулсан. Энэхүү шинэчилсэн хууль нь Япон Шуудан үйлчилгээ ХХК, Япон Шуудангийн сүлжээ ХХК, (цаашид "Япон Шуудан ХХК) Пост групп зэрэг таван компанийг дөрвөн компани болгон өөрчилсөн байна.

Япон Шуудан Холдинг ХХК, Японы Шуудан ХХК нь шуудангийн үйлчилгээ үзүүлэхээс гадна шуудангийн салбаруудад банкны болон даатгалын үндсэн үйлчилгээг үзүүлнэ. Японы Шуудан Холдинг ХХК -ийн хувьцааны талаар 2011 оны 11-р сарын 30-ны өдрийн 171-р чуулган "Дорно дахины Японы газар хөдлөлтийн сэргээн босголтыг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг хамгаалах тусгай арга хэмжээнүүд" баталсан. Энэ хуулиар Японы Засгийн газар нь өөрийн эзэмшлийн хувьцааг борлуулалтын орлогын аргаар хурдан гаргах үүрэгтэй бөгөөд энэ нь менежментийн нөхцөл байдал, орлогын урьдчилсан тооцоо, нэмэлт өөрчлөлт сэргээн босголтын бондыг эргүүлэн авахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг гаргасан байна.

## 4. Шоко Чукин Банк (Shoko Chukin Bank)

2008 оны 10-р сард Шоко Чукин банк нь ЖДҮ-ийн санхүүжилтийг дэмжих зорилгоор Шоко Чукин банкны хуулийн дагуу удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд хамтарсан үйлдвэр, санхүүгийн байгууллага, хувьцаат компанийн төлөөлөлтэйгээр байгуулсан. Шоку Чукин банк болон ХХК нь төрөл бүрийн банкны үйлчилгээг үзүүлдэг. Мөнгөн хадгаламж, хадгаламжийн данс, хугацаат хадгаламж, татвар төлөгчийн хадгаламж, оршин суудаггүй иргэдийн иений хадгаламж, гадаад валютын хадгаламж, харилцах боломжтой сертификат зэрэг олон төрлийн хадгаламжийн үйлчилгээг санал болгодог. Тус банк нь капитал хөрөнгө оруулалт, урт хугацааны эргэлтийн хөрөнгө, богино хугацааны эргэлтийн хөрөнгө, банкны

[43] Санхүүгийн Корпораци https://corporatefinanceinstitute.com/resources/careers/companies/top-banks-in-japan
[44] Япон Шуудан банк https://www.jp-bank.japanpost.jp/en/ir/financial/pdf/en2012_12.pdf

өрийн асуудлыг шийдвэрлэхэд зориулсан жижиг, дунд үйлдвэрүүдэд олон төрлийн зээл олгодог байна[45].

**Шоко Чукин банкны зорилго** нь: банкны бие даасан засаглалыг хангахын зэрэгцээ, ЖДҮ-ийн хоршоод, гишүүдээс бүрддэг байгууллагуудын тэгш эрхийн оролцоо, бизнес эрхлэхэд шаардлагатай үйл ажиллагааг явуулахад хувь нэмэр оруулах зорилготой.

**Шоко Чукин банкны хувьчлал:**

2018 оны 01-р сарын 10-ны өдрийн байдлаар Япон Улсын Шоко Чукин банкны бүрэн хувьчлалыг гаргах шинжээчдийн саналыг дэвшүүлжээ. Энэхүү ажилд Эдийн Засаг, Худалдаа Аж Үйлдвэрийн Яамны ажлын хэсэг байгуулан оролцож байна.

**Хувьчлалын дараа Засаглал бүрдүүлэх талаар**[46]

Банкны статусын өөрчлөлтийг тусгай компанид (тусгай хуультай холбоотой хамтарсан компанид) шилжүүлнэ. Банкны статусын өөрчлөлт нь Банкны засаглалыг бэхжүүлэх, сайжруулахын тулд өөрийн санхүүгийн чадавхыг сайжруулна. ЖДҮ-ийн хувьцаа эзэмшигчид, ЖДҮ-ийн хоршоодын гишүүд Засгийн газрын гишүүд нь Шоко Чукин банкны хязгаарлалтын тухай хууль, Компаниудын тухай хуулийн дагуу зах зээлийн сахилга батыг чанд баримтална. Банк нь захирлуудын зөвлөл, аудитор болон нягтлан бодох бүртгэлийн аудиторуудыг томилно.

**Үндэсний бодлогод суурилсан тусгай зээлийг зохицуулах талаар**

Банк нь үндэсний бодлогын зориулалтаар шинэ тусгай зээл олгохгүй бөгөөд одоо байгаа тусгай зээлийг үргэлжлүүлэх болно. Үүнээс гадна Засгийн газар нь томилогдсон санхүүгийн байгууллагын хувьд эдийн засаг, санхүүгийн тогтворгүй байдал, байгалийн гамшгийн үед нөхөн сэргээх санхүүжилтийг үргэлжлүүлэх болно. Цаашилбал, өөрийн зээлийн бүтээгдэхүүнээ үндэсний болон орон нутгийн Засгийн газрын бодлоготой уялдуулан бизнесийн хэрэгцээгээ хангахын тулд зээлийн үйлчилгээг боловсруулна.

**Санхүүжилт** Засгийн газрын оруулсан дийлэнх хэсэг нь тусгай нөөцөд шилжих ба Банкны санхүүгийн байдлыг хангахад ихээхэн хөрөнгө шаардагдах болно.

2016 оны 3-р сарын сүүлээр нийт хямралын хүрээнд нийт 210,132 төслийг 11,882.7 тэрбум еврогоор үнэлүүлсэн бөгөөд энэ нь ЖДҮ-т дэмжлэг үзүүлэхэд чухал хувь нэмэр оруулж чадлаа[47].

**Шоко Чукин банкны хязгаарлагдмал хууль болон** Жижиг, дунд үйлдвэрийн зээлийн даатгалын тухай хуулийг 2015 оны 5 дугаар сард баталжээ.

## 6. БРАЗИЛ

2012 оны байдлаар Бразилын улсын банкны систем нь 13 байгууллагаас бүрдэх бөгөөд эдгээр нь улсынхаа нийт банкны нөөц хөрөнгийн 43.8% эзэлдэг. Эдгээрээс 4 нь хөгжлийн банк байна. Энэхүү улсын банкны системийн дотроо хамгийн том нь:

- Banco Nacional de Desenvolvimento Econômico e Social (BNDES),
- Banco do Brasil (BB)
- Caixa Econômica Federal- (CEF) байна. 2012 он байдлаар нийт хөрөнгийн 11.6%, 18.2%, 11.8% хувийг тус тус бүрдүүлж байсан.

Энэхүү системд бас бүс нутгийн үйл ажиллагааг эрхэлдэг холбооны санхүүгийн байгууллагууд багтана. Үүнд:

- Банко да Амазониа (BASA),
- Банко до Нордесте до Бразил (BNB). Эдгээр нь нийт банкны хөрөнгийн тодорхой хувийг бүрдүүлнэ[48].

Мөн үүнчлэн нийтийн банкны бүтэцэд багтах бүс нутгийн хэмжээний банкууд бий.

[45] Блюмберг https://www.bloomberg.com/research/stocks/private/snapshot.asp?privcapid=875369
[46] Шоко Чукин ХХК https://www.shokochukin.co.jp/english/introduction/about.html#Q01
[47] Шоко Чукин банк https://www.shokochukin.co.jp/english/report/2016/pdf/ar16_3.pdf
[48] 2012 оны 12 дугаар сарын байдлаар нийт банкны санхүүгийн системийн 0.2% ба 0.5% -ийг тус тус бүрдүүлж байжээ.

Үүнд:

- Банко до Эстадо до Рио Гранде до Сул (Banco do Estado do Rio Grande do Sul (Banrisul)),
- Банко до Эстадо до Эспирито Санто (Banco do Estado do Espírito Santo (Banestes)),
- Банко до Эстадо до Сергипе (Banco do Estado do Sergipe (Banese)),
- Банко до Эстадо до Пара (Banco do Estado do Pará (Banpará)) – эдгээр нь 2012 оны байдлаар энэхүү системийн 0.8% бүрдүүлдэг.

Эдгээрийн эрх зүйн бүтэц ба хөрөнгийн эзэмшигчийн тухайд авч үзвэл “Улсын сан” (Treasury) нь CEF ба BNDES –ийн хөрөнгийг 100% удирдана. Харин BB, BASA ба BNB тухайд бол Улсын Сангийн үндсэн удирдлага зохицуулалттайгаар нийтийн арилжаа худалдаанд хамрагдана. Эдгээр гурваас зөвхөн BB–ны нэлээд их хувьцаа хөрөнгийн бирж дээр худалдаалагддаг ба тус компаний хувьцааны 59%-ийг Холбооны Засгийн газар эзэмшдэг байна.

Хөгжил, Аж Үйлдвэр ба Гадаад Худалдааны Яамны (Ministry of Development, Industry and Foreign Trade - MDIC) харьяанд байх BNDES-ийг эс тооцвол холбооны банкууд нь Санхүүгийн Яамны удирдлага зохицуулалтаар үйл ажиллагаагаа эрхлэн явуулдаг байна.

Доорх хүснэгтэд Бразилын төрийн өмчит томоохон 4 банкны талаарх мэдээллийг оруулсан болно.

*Хүснэгт 7. Бразил улсын төрийн өмчийн банкны талаарх мэдээлэл*[49]

| Төрийн өмчит банкны нэр | Төрийн эзэмшлийн хувь, хэмжээ | Үйл ажиллагааны онцлог, хууль эрх зүйн зохицуулалт |
|---|---|---|
| **Үндэсний нийгэм, эдийн засгийн хөгжлийн банк**<br><br>*(Banco Nacional de Desenvolvimento Econômico e Social* **)**<br><br>https://www.bndes.gov.br/ | Засгийн газрын эзэмшлийн корпораци, 100 хувь удирдана. | - Бразилын нийгэм, эдийн засгийн хөгжлийн банк (BNDE) нь 1952 оны 6-р сарын 20-нд 1628 дугаар хуулийн дагуу байгуулагдсан бөгөөд эдийн засгийн үндэсний хөгжлийн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх зорилгоор байгуулагдсан. Дараа нь 1971 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 5662 дугаар хуулийн дагуу (BNDE) төрийн өмчит компанид шилжсэн бөгөөд энэ нь улс төрийн хөндлөнгийн оролцоог багасгаж, хөрөнгө босгох, хөрөнгө оруулалт хийх уян хатан боломжийг бий болгосон.<br>Холбогдох хуулийг доорх эх сурвалжаас үзнэ үү.<br>https://www.bndes.gov.br/SiteBNDES/export/sites/default/bndes_en/Galerias/Download/other_BNDES_norms.pdf<br>- 2017 оны 2-р сарын 20-нд Үндэсний нийгэм, эдийн засгийн хөгжлийн банк (LAWS OF BANCO NACIONAL DE DESENVOLVIMENTO ECONÔMICO E SOCIAL – BNDES)-ны тухай бие даасан хуулийг баталж, үүрэг, үйл ажиллагааг тодорхой зохицуулсан байна.<br>Хуулийг доорх эх сурвалжаас үзнэ үү.<br>https://www.bndes.gov.br/SiteBNDES/bndes/bndes_en/Institucional/The_BNDES/BNDES_bylaws.html |
| **Холбооны хадгаламжийн банк**<br><br>Caixa Econômica Federal- (CEF)<br><br>http://www.caixa.gov.br/ | Засгийн газрын эзэмшлийн корпораци, 100 хувь удирдана. | Анх 1891 онд байгуулагдсан 150 гаруй жилийн түүхтэй Caixa Econômica Federal банк нь хөрөнгийн хувьд Бразилын гурав дахь том банк, харин Латин Америктаа 5 том банкны нэг юм. Санхүүгийн яаманд харьяалагддаг энэхүү банк нь Бразил дахь удирдлагын төвүүдээрээ дамжуулан дэд бүтэц, барилгажилт, эрүүл мэндийн салбаруудад Холбооны Засгийн газрын стратегийн түншийн үүрэг, үйл ажиллагааг гүйцэтгэж, улс орныхоо нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр болдог байна.<br>Тус банк нийт 78.3 сая харилцах болон хадгаламжийн данс эзэмшигчдэдээ банкны үйлчилгээг үзүүлэхээс гадна хөдөлмөрийн тэтгэмж, нийгмийн болон орлогын шилжүүлэг хийх, кредит бүхий Минха Каса Минха Вида(Minha Casa |

[49] https://www.globalbankingandfinance.com/list-of-banks-in-brazil/

| | | |
|---|---|---|
| | | Minha Vida), Болса Фамилиа(Bolsa Família), Засгийн газрын үйлчилгээний албан хаагчийн сан (FGTS) гэх зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ирсэн байна. Мөн Оюутныг санхүүжүүлэх хөтөлбөр, Нийгмийн барилгажилтын даатгалын сан, Нийгмийн хөгжлийн сан гэх зэрэг Засгийн газрын сангуудыг ажиллуулдаг ба Холбооны Засгийн газрын нийгмийн хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилгоор мөнгө босгодог холбооны лоттерей (хонжворт сугалааг) удирдан зохион байгуулдаг юм. Түүнчлэн тогтвортой хөгжлийн төлөө орон нутгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид, компаниуд ба байгууллагуудад баталгаатай кредит ба санхүүгийн шийдлийг санал болгодог байна. |
| **Бразилын банк** (Banco do Brazil)<br><br>http://www.bb.com.br/ | Бразилын Засгийн газар 59%-ийг эзэмшдэг.[50] | Анх 1808 онд байгуулагдсан. Төв банк болон арилжааны банк хэлбэрээр ажиллаж байгаад 1992 оноос эхлэн арилжааны банк болсон.<br><br>Төрийн удирдлага хяналт бүхий холимог хэлбэрийн байгууллага болох Банко до Бразил нь арилжааны банк, засгийн газрын санхүүгийн агент, Бразилын анхны банк бөгөөд Засгийн газрын зүгээс “Бүс нутгийн тогтвортой хөгжил” (Sustainable Regional Development - DRS) гэх зэрэг улсын хөтөлбөрүүдийг санхүүжүүлдэг нэгэн гол бүтэц болсон байна.<br><br>Тус банк нь банк, санхүүгийн үйлчилгээг үзүүлнэ. Үүнд: банк, хөрөнгө оруулалт, хөрөнгийн менежмент, даатгал, бонд ба төлбөрийн системүүдийн хүрээний шийдэл, үйлчилгээ, бүтээгдэхүүнийг нийлүүлэх, Фирмийн аж ахуйг дэмжих улсын тэтгэлэг, “Ядуурлыг бууруулах”, DRS, PASEP гэх зэрэг олон тооны Засгийн газрын санхүүжилттэй хөтөлбөрүүдийн үйлчилгээ зэрэг багтана.<br><br>Улсын эзэмшлийн арилжааны банк учраас зээлийн хүү нь дундаж үзүүлэлттэй явж ирсэн байна.<br><br>Банко де Бразилыг үндсэн хөрөнгийн хэмжээгээр нь тус улсын тэргүүлэх банк гэж зэрэглэсэн байдаг. |
| **Banco do Estado do Rio Grande do Sul (Banrisul)**<br><br>www.banrisul.com.br | Засгийн газар нь 51-ээс доошгүй хувийг эзэмшихээр дүрмэндээ заасан.[51] | Анх 1927 онд фермерүүдийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор зээлийн банкны хэлбэрээр байгуулагдсан. Банрисул бол Өмнөд Бразилын хамгийн том банк бөгөөд Рио Гранде до Сул (RS) муж улсад үйл ажиллагаа явуулдаг, 365 гаруй хотод үйлчилгээ үзүүлдэг сүлжээтэй банк юм. Тус банк нь Бразилын бусад орон нутгуудад ч үйлчилгээ үзүүлдэг байна. Тодорхой хэлбэл, энэ банк Рио Гранде до Сул, Холбооны дүүрэг болон Парана, Рио де Жанейро, Санта Катарина, Сао Пауло муж улсуудад үйлчилгээний 1312 гаруй цэг, 500 гаруй агентлаг, 593 ATM машинтай. Үүнээс гадна Миами, Гранд Гэймэн зэрэгт агентлаг ажиллуулдаг.<br>Компаний зорилго нь зээл авах ба өгөх, холбогдох зөвшөөрөлтэй ажлууд (арилжааны, үл хөдлөх хөрөнгийн зээл- 2-8 дугаар Бүс нутгуудад, кредит,санхүүжүүлэлт, хөрөнгө оруулалт, лизинг ба хөгжлийн болон хөрөнгө оруулалтын ажлууд), мөн хууль, журмын дагуу (валют) арилжааны үйл ажиллагаатай холбоотой бусад нэмэлт үйл ажиллагааг явуулахад оршино.<br>1971 онд Банкны дүрмийг баталсан бөгөөд компанийн удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, дүрмийн сангийн талаар Банкны дүрмээрээ[52] тодорхой зохицуулсан байна. Дүрмийг доорх эх сурвалжаас үзнэ үү. |

[50] https://en.wikipedia.org/wiki/Banco_do_Brasil#Relationship_with_the_government
[51] Bylaws- Chapter I - Nature, Duration and Head Office, paragaraph 1 http://ri.banrisul.com.br/banrisul/web/conteudo_en.asp?idioma=1&conta=44&tipo=8486
[52] Bylaws- http://ri.banrisul.com.br/banrisul/web/conteudo_en.asp?idioma=1&conta=44&tipo=8486

| | | |
|---|---|---|
| | | http://ri.banrisul.com.br/banrisul/web/conteudo_en.asp?idioma=1&conta=44&tipo=8486<br>Банрисул нь 1990 оны 3 дугаар сард Бразилын төв банкнаас хүлээн авах, моргежийн зээлийн ба кредит, санхүүжилтийн ба хөрөнгө оруулалтын данстай Арилжааны банкны үйл ажиллагааг албан ёсоор эрхлэх зөвшөөрөл авсан.<br>Тус банк нь 1998 онд хуучнаар "Кайкса Экономика" (үгчилбэл, улс нийтийн) хадгаламжийн банкны агентлагуудтай нэгдэн худалдааны банк болохын зэрэгцээ улсын өмнөд хэсэгт түгээлтийн илүү том сүлжээг бий болгожээ. |

### 7. ТАЙЛАНД

| Төрийн өмчит банкны нэр | Төрийн эзэмшлийн хувь, хэмжээ | Үйл ажиллагааны онцлог, хууль эрх зүйн зохицуулалт |
|---|---|---|
| **Хөдөө аж ахуй ба хөдөө аж ахуйн хоршооллын банк**<br><br>Bank for Agriculture and Agricultural Co-operatives (BAAC) | Сангийн яам 99.79%,<br>Олон нийт 0,03%<br>Хуулийн этгээд (ХК, ХАА-н маркетингийн хоршоод, санхүүгийн байгууллагууд) 0.18%-ийг тус тус эзэмшдэг.[53] | 1966 онд ХАА, ХАА-н хоршооллын банк (BAAC) байгуулагдсан.<br>Гол чиглэл нь:<br>- ХАА болон ХАА-н бусад төрлийн бизнес эрхэлдэг аж ахуйн нэгж болон фермерүүд, фермерүүдийн холбоо, ХАА-н хоршоодод санхүүгийн туслалцаа, дэмжлэг үзүүлэх явдал байсан.<br>- Амьжиргааны түвшинг дээшлүүлэхийн тулд фермерүүд, тэдний гэр бүлд шаардлагатай мэдлэг, технологийг нэвтрүүлэх.<br>- Бизнес, ХАА-тай холбоотой үйл ажиллагааг дэмжихийн тулд төрийн болон хувийн хэвшлийн бусад байгууллагуудтай хамтран ажиллах.<br>**Хууль, эрх зүйн зохицуулалт:** Bank for agriculture and agricultural cooperatives act, 2509 (1966)[1] 10 бүлэг 43 зүйл бүхий бие даасан хуулиар зохицуулагдана. |
| **Экспорт–Импортын банк**<br><br>Export–Import Bank of Thailand | Тайландын Экспорт-Импортын Банк (EXIM) нь Сангийн яамны хяналт дор үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит санхүүгийн байгууллага бөгөөд 1994 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн Сайд нь банкны үйл ажиллагааг ерөнхийд нь хянах бөгөөд банкны захирлыг 3 жилээр томилдог. | Экспорт-Импортын банкны тухай хуулийн 7-д заасны дагуу EXIM банк нь зээлийн, баталгаа, байгууламж, эрсдэлийн даатгал эсвэл бусад шаардлагатай үйлчилгээг үзүүлэх замаар экспортыг импортлох, хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжихэд чиглэсэн бизнесийн үйл ажиллагааг явуулах зорилготой гэж заасан байна.<br>Тус банк нь хуулийн дагуу бизнесийн үйл ажиллагаанд оролцохыг зөвшөөрдөг. EXIM нь олон нийтийн зүгээс хадгаламж хүлээн авах боломжгүй бөгөөд арилжааны банкны бусад санхүүгийн аливаа үйл ажиллагаа эрхлэх эрхтэй.<br>Богино болон урт хугацааны зээлийг гадаад, дотоодын зах зээлд батлан даана. **Хууль, эрх зүйн зохицуулалт:** "Тайландын EX-IM банкны тухай дугаар 2536" хууль, 1993[54]<br>Хааны зарлиг №265<br>- Хааны зарлиг №266<br>Эрх зүйн 1999 онд "Тайландын Экспорт- мпорт Банк" (№ 2) Б.Е. 2542 банкны үйл ажиллагааны зорилго, цар хүрээг тодотгон, өргөжүүлэх зорилгоор нэмэлт өөрчлөлт оруулсан. Тайландын хөрөнгө оруулагчид болон гадаад валютын ашиг орлого буюу хадгалалт, экспорт, бизнесийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг дотоодын хөрөнгө оруулагч нарт илүү цогц дэмжлэг үзүүлэх боломжийг олгоход чиглэсэн. |

[53] http://www.baac.or.th/baac_en/content-about.php?content_group_sub=0024
[54] http://www.exim.go.th/en/about_exim/act2536.aspx

| | | |
|---|---|---|
| **Тайландын Исламын банк**<br><br>Islamic Bank Of Thailand | Исламын банк<br>- Сангийн яам 48.54%<br>- Төрийн хадгаламжийн банк 39.81%<br>- Krung Thai банк 9.83%, | Тайландын Исламын Банк нь 2002 онд Парламентын тусгай хуулийн дагуу Сангийн яамны хяналтан дор байгуулагдсан. Гол зорилго нь Исламын банкны үйлчилгээг шашин шүтлэгээс үл хамааран бүх хэрэглэгчдэд хүргэхэд чиглэгдсэн.<br>Исламын банкийг Исламын шашин шүтлэгийн зарчмууд болон тус улсын гурван мужид оршин суудаг Исламын шашинт хүн амын хэрэгцээ шаардлагын улмаас байгуулсан.<br>**Хууль, эрх зүйн зохицуулалт:** Исламын банкны тухай хуулийн дагуу 2002 онд байгуулагдсан.[55] 108 салбар бүхий томоохон банк юм.<br>2007 оны 10-р сард Сангийн яам нь үндсэн хувьцаа эзэмшигч болсон бөгөөд дараа нь төрийн өмчит аж ахуйн нэгжийг байгуулсан.<br>/The Islamic Bank of Thailand Act', 2002./[56] |
| **Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх банк[57]**<br><br>Small and Medium Enterprise Development Bank of Thailand | Сангийн яам 97.0%[58] | Тус банк нь жижиг дунд үйлдвэрийг үүсгэн байгуулах, тэдгээрийг хөгжүүлэх, өргөжүүлэх, үйл ажиллагааг нь дэмжих хөгжүүлэх зэрэг шаардлагатай бусад үйлчилгээг энэ хуулийн дагуу хэрэгжүүлэх, мөн кредит, баталгаа гаргах, хөрөнгө оруулалтад оролцох, зөвлөмж өгөх, санал болгох зорилгын дагуу байгуулагдсан. **Хууль, эрх зүйн зохицуулалт:** "Тайландын ЖДҮ-ийн хөгжүүлэх банкны тухай дугаар 2545" хууль 2002 |
| **Төрийн хадгаламжийн банк**<br><br>Government Savings Bank | Төрийн хадгаламжийн банк нь 1947 оноос одоог хүртэл Сангийн Яамны хяналтын дор үйл ажиллагаагаа явуулдаг. | Тус банк нь одоо Сангийн яамны хяналтан дор Засгийн газраар баталгаажсан санхүүгийн институци байдлаар үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд, улсын үйлдвэрийн газар юм.<br>1913 онд анх хадгаламжийн алба нэртэйгээр үүсгэн байгуулж улмаар 105 жилийн түүхтэй банк болтлоо үйл ажиллагаа нь өргөжсөн.<br>Сангийн сайд байнкны үйл ажиллагаанд ерөнхий хяналт тавьж ажиллах үүрэгтэй.<br>**Хууль, эрх зүйн зохицуулалт:** Сангийн сайд нь энэ хуулийг хэрэгжүүлэхэд хяналт тавьж ажиллах ба, шаардлагатай дүрэм журмыг батална.<br>"Төрийн хадгаламжийн банкны тухай дугаар 2489" хууль |
| **Төрийн орон сууцны банк**<br><br>Government Housing Bank | Төрийн орон сууцны банк нь Сангийн яамны харьяанд төрийн орон сууцны банкны тухай хуулийн дагуу байгуулагдсан. | Засгийн газрын орон сууцны банк 1953 онд байгуулагдсан. Төрийн орон сууцны банк нь Тайландын ард иргэдэд зориулсан орон сууцны санхүүжилтийг олгох зорилготой бөгөөд бага болон дунд орлоготой иргэдэд зориулсан орон сууцны санхүүжилтийг олгоход онцгойлон анхаардаг байна.<br>Орон сууцны Банкны эрхэм зорилго нь орон сууцны санхүүжилттэй холбоотой бүхий л үйлчилгээг засгийн газрын бодлоготой уялдуулан, нийгмийн ашиг тусыг хүртээх, хүн бүрийн амьдралын чанарыг сайжруулахад оршино.<br>Мөн төслийн тусгай зээл, орон сууц худалдан авагчид зориулсан зээлийн үйлчилгээ, халамжийн зээл зэрэг төрөл бүрийн зээл олгодог.<br>**Хууль, эрх зүйн зохицуулалт:** "Төрийн орон сууцны банкны тухай хууль"/"Government housing bank act"[59] гэсэн 7 бүлэг 43 зүйл бүхий бие даасан хуультай. |

[55] The Islamic Bank of Thailand Act', 2002.
[56] http://www.ibank.co.th/2010/en/about/about_detail.aspx?ID=12
[57] https://www.smebank.co.th/en/about/act
[58] https://www.fsa.go.jp/frtc/kenkyu/event/20080430/08e.pdf
[59] http://thailaws.com/law/t_laws/tlaw0109_3.pdf

**8. БНСУ**

| Төрийн өмчит банкны нэр | Төрийн эзэмшлийн хувь, хэмжээ | Үйл ажиллагааны онцлог, хууль эрх зүйн зохицуулалт |
|---|---|---|
| **Солонгосын Хөгжлийн банк**<br><br>(Korea Development Bank)[60] | 100% | 1954 онд аж үйлдвэрийн томоохон төслүүдийг санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, аж үйлдвэрийн хөгжлийг эрчимжүүлэх зэргээр үндэсний эдийн засгийг дэмжих зориулалтаар байгуулагдсан. Аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх, дэд бүтцийг өргөжүүлэх, бүс нутгийн хөгжил, санхүүгийн зах зээлийг тогтворжуулах, тогтвортой хөгжлийг дэмжих зэрэгт шаардагдах хөрөнгийг нийлүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулж байна.<br>**Хууль, эрх зүйн зохицуулалт:** Солонгосын Хөгжлийн банкны тухай хууль (The Korea Development Bank Act)[61],<br>Хөгжлийн банкны тухай хуулийг хэрэгжүүлэх журам (Enforcement decree of the Korea Development Bank Act)[62] болон<br>Банкны тухай хууль (The Banking Act)[63]-аар тус тус зохицуулна. |
| **Солонгосын Аж үйлдвэрийн банк**<br><br>(Industrial bank of Korea)[64] | Засгийн газрын харьяа Стратеги болон Сангийн яам (Ministry of Strategy and Finance) 51.8%, Төрийн өмчит Солонгосын хөгжлийн банк 1.9%, Төрийн өмчит Солонгосын экспорт-импортын банк 1.5%, гадаадын иргэд 22.9%, бусад 21.9% тус тус эзэмшиж байна. | 1961 онд анх Жижиг, дунд бизнесийг дэмжих банк нэртэйгээр байгуулагдсан байна. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлж ажилладаг.<br>**Хууль, эрх зүйн зохицуулалт:** Солонгосын Аж үйлдвэрийн банкны тухай хууль (Industrial Bank of Korea Act)[65],<br>Солонгосын Аж үйлдвэрийн банкны тухай хуулийг хэрэгжүүлэх журам (Enforcement decree of the Industrial Bank of Korea Act) болон<br>Банкны тухай хууль (The Banking Act)-аар тус тус зохицуулна. |
| **Солонгосын экспорт-импортын банк**<br><br>(Export-Import Bank of Korea (Korea Eximbank))[66] | Засгийн газар 74.4%, Солонгосын банк 22.1%, Солонгосын Санхүүгийн корпорац 3%-ийг тус тус эзэмшдэг байна. | 1976 онд экспорт болон импортын гүйлгээ хийгээд гадаад дахь хөрөнгө оруулалтын төслүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлснээр эдийн засгийн хөгжилд дэмжлэг үзүүлж, гадаадын улс орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор байгуулагдсан.<br>Гадаад орнуудтай хийх эдийн засгийн хамтын ажиллагаа (экспорт болон импорт)-нд шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэх, гадаадад хөрөнгө оруулалт хийх, гадаад дахь нөөц баялгийг ашиглах зэргээр үндэсний эдийн засгийн тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэн ажилладаг байна.<br>Банк нь Засгийн газрын харьяаны Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сан (Economic Development Cooperation Fund), Солонгос дахь хамтын ажиллагааны сан (Inter-Korean Cooperation Fund)-г удирдан ажиллуулдаг байна.<br>**Хууль, эрх зүйн зохицуулалт:**<br>Солонгосын экспорт-импортын банкны тухай хууль (Export-Import bank of Korea Act)[67],<br>Солонгосын экспорт-импортын банкны тухай хуулийг хэрэгжүүлэх журам (Enforcement decree of the Export- |

60 https://www.kdb.co.kr/ih/wcms.d
61 https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=39521&lang=ENG
62 https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=39524&lang=ENG
63 https://elaw.klri.re.kr/eng_service/lawTotalSearch.do
64 http://eng.ibk.co.kr/lang/en/index.jsp
65 https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=44444&lang=ENG
66 https://www.koreaexim.go.kr/site/homepage/menu/viewMenu?menuid=002001001002001
67 https://elaw.klri.re.kr/kor_service/lawView.do?lang=ENG&hseq=38475&joseq=JO0004000

| | | |
|---|---|---|
| | | Import bank of Korea Act), Банкны тухай хууль (The Banking Act)-аар тус тус зохицуулна. |

## 9. КАНАД

| **Төрийн өмчит банкны нэр** | **Төрийн эзэмшлийн хувь, хэмжээ** | **Үйл ажиллагааны онцлог, хууль эрх зүйн зохицуулалт** |
|---|---|---|
| **Канадын Бизнес хөгжлийн банк**<br><br>Business Development Bank of Canada | Засгийн газрын 100 хувь мэдэлд байдаг. | Банкны зорилго нь Канадын хувиараа бизнес эрхлэгчдэд санхүүгийн болон менежментийн үйлчилгээ үзүүлэх, үнэт цаас гаргах, тэдгээр үйлчилгээг дэмжих зорилгоор хөрөнгө босгох юм.<br>Хууль, эрх зүйн зохицуулалт: 1995 онд Канадын парламентаас Канадын Бизнес Хөгжлийн Банкны хуулийг батлан гаргаж тус банкыг шинэчилсэн.<br>Business Development Bank of Canada Act<br>http://lois-laws.justice.gc.ca/PDF/B-9.9.pdf<br>Засгийн газрын зөвлөл удирддаг. /Governor Council/<br>10 жил тутам Аж үйлдвэрийн сайд Бизнес хөгжлийн банкны хуулийн заалт, үйл ажиллагааны талаар дүн шинжилгээ хийж тайлан гаргах үүрэгтэй.<br>Тус банк үйл ажиллагаагаа Канадын Инноваци, Шинжлэх Ухаан, Эдийн Засгийн Хөгжлийн Яаманд тайлагнадаг. |
| Farm Credit Canada | Засгийн газрын 100 хувь мэдэлд байдаг | Корпорацийн зорилго нь Канадын ХАА-н бизнес эрхлэгчид, түүний дотор жижиг дунд фермерийн аж ахуй эрхлэгчдэд бизнес, санхүүгийн үйлчилгээ үзүүлэх явдал юм. Корпорацийн үйл ажиллагааны гол чиглэл нь фермерийн аж ахуйд чиглэнэ.<br>Хууль, эрх зүйн зохицуулалт: Farm Credit Canada Act<br>http://lois-laws.justice.gc.ca/PDF/F-2.2.pdf<br>Захирлуудын зөвлөл, дарга, ерөнхийлөгч гэсэн 3-аас доошгүй, 10-аас дээшгүй захирлуудаас бүрдэнэ.<br>The Corporation shall consist of a Board of Directors comprising a Chairperson, a President and not fewer than three nor more than ten other directors.<br>Үйл ажиллагаагаа Хүнс, хөдөө аж ахуйн сайдаар дамжуулан Парламентад тайлагнадаг.<br>FCC is one of Canada's many Crown corporations; they report to the Parliament of Canada through the Minister of Agriculture and Agri-Food. |
| ATB Financial (Government of Alberta Crown Corporation)<br><br>http://www.atb.com/ | Альберта мужийн 100 хувь мэдэлд байдаг. | Альберта муж дахь бизнес эрхлэгчдэд санхүүгийн үйлчилгээ үзүүлэх юм.<br>Статусын хувьд банк биш бөгөөд Альберта мужийн хууль тогтоомжийн дагуу санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг.<br>Хууль, эрх зүйн зохицуулалт: ATB financial act<br>http://www.qp.alberta.ca/documents/Acts/A45p2.pdf<br>Альберта мужийн засгийн газраас сонгосон Удирдах зөвлөлийн дарга болон захирлууд удирддаг. |

## 10. АВСТРАЛИ

Тус улсад төрийн өмчит банк болох Хамтын нөхөрлөлийн банк (Commonwealth bank) ажиллаж байсан боловч 1996 онд хувьд шилжсэнээр төрийн өмчит банк байхгүй болсон. Харин дотоодын компани аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дэмжих зорилгоор төрийн өмчит экспортын санхүүгийн корпорацийг 1952 онд байгуулсан бөгөөд энэ нь төрийн өмчит банкны үүргийг гүйцэтгэж байна[68].

[68] https://www.efic.gov.au/

| | |
|---|---|
| **Efic- санхүүгийн корпораци**<br><br>https://www.efic.gov.au/ | Efic (Эфик) буюу Экспортын Санхүү ба Даатгалын Корпораци (The **Export Finance and Insurance Corporation** - Efic) нь 1957 онд байгуулагдсан өргөн хүрээний үйл ажиллагаатай экспортын кредитийн агентлаг байсан. Улмаар “1991 оны Экспортын санхүү ба даатгалын корпорацийн тухай хуулиар” (the EFIC Act) 1991 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр одоогийн хэлбэрээрээ зохион байгуулагдаж Австралийн Хамтын Нөхөрлөлийн 100% эзэмшлийн хууль ёсны корпораци болсон байдаг.<br>Efic нь Австралийн компаниудыг хувийн зах зээлд нь бэрхшээл тулгарсан үед нь ухаалаг санхүүгийн шийдлээр хангаж олон улсын үйл ажиллагаан дахь өсөлтийг нь дэмжих үүрэгтэй байгууллага юм.<br>Австралийн Засгийн газрын экспортын кредитийн агентлагийн хувиар энэхүү байгууллага нь Австрали суурьтай бизнесийн үйл ажиллагааг амжилтанд хүрэхэд нь туслаж, хэрэгцээтэй тусламж дэмжлэгийг банк үзүүлж чадахгүй буй нөхцөлд экспортын санхүүжилт, гадаад дахь хөрөнгө оруулалт ба дотоод дахь экспортын хамааралтай боломжуудаар хангана.<br>Efic нь Хамтын Нөхөрлөлийн худалдааны байгууллага ба нь *“1991 оны Экспортын санхүү ба даатгалын корпорацийн тухай хууль” (the EFIC Act), Төрийн удирдлага ба хариуцлагын тухай 2013 оны хууль (PGPA Act)*-уудын холбогдох зүйл заалтуудад захирагдана.<br>Тус байгууллага нь Австралийн Засгийн газрын гадаад харилцаа ба Худалдааны хэргийн нэгэн бүрэлдэхүүн хэсэг ба, Худалдааны яам, Аялал жуулчлал ба Хөрөнгө оруулалтын яамдад бас зохих хүрээнд хамааралтай.<br>Efic-ийн захиргааны зөвлөл нь байгууллагын удирдлага, менежмент, үйл ажиллагааны хяналтын үүрэгтэй. Удирдлага ба эрсдэлийн менежментийн тухайд энэ байгууллага нь арилжааны сахилга батыг чанд мөрддөг. Үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайланг нь санхүүгийн жил бүр Австралийн Парламент авч хэлэлцдэг байна.<br>Австралийн экспортын кредитийн агентлагийн хувиар энэ байгууллага нь олон банктай арилжаа болон түншлэлийн үндсэн дээр дараах ажил хэргүүдийг санхүүгийн шийдлээр хангах үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:<br>- Экспортын үйл ажиллагаа эрхэлдэг бага ба дунд аж ахуйн нэгжүүд;<br>- Экспортын нийлүүлэлтийн сүлжээнд хамаарах Австралийн компаниуд;<br>- Үйлчлүүлэгчдэдээ хүргэх үйлчилгээгээ сайжруулах үүднээс бизнесийн үйл ажиллагаагаа гадаадад өргөжүүлэн эрхлэхийг эрмэлзэж буй Австрали компаниуд;<br>- Эрчимжиж буй болон ид магнаг болж буй зах зээлүүдэд үйл ажиллагаа эрхэлдэг Австрали компаниуд. |

**АШИГЛАСАН МАТЕРИАЛ**


- Bank Ownership: Trends and Implications, IMF Working Paper
- March 2017 https://www.imf.org/~/media/Files/Publications/WP/2017/wp1760.ashx
- State-Owned Banks and Fiscal Discipline, IMF Working Paper, October 2013 https://www.imf.org/external/pubs/ft/wp/2013/wp13206.pdf
- Should the Government Be in the Banking Business? The Role of State-Owned and Development Banks, Working Paper, Inter-American Development Bank, 2004 https://www.econstor.eu/bitstream/10419/88042/1/idb-wp_517.pdf
- The Role of Development Banks in Promoting Growth and Sustainable Development in the South, Economic Cooperation and Integration among Developing Countries UNCTAD December 2016 http://unctad.org/en/PublicationsLibrary/gdsecidc2016d1_en.pdf
- https://www.export.gov/article?id=Japan-Banking-Systems
- https://www.zenginkyo.or.jp/en/banks/financial-institutions/
- http://www.commercialbanksguide.com/japanese+commercial+banks/
- http://www.dbj.jp/en/co/info/law.html
- http://www.dbj.jp/en/topics/dbj_news/2018/files/0000030152_file1.pdf
- http://www.dbj.jp/en/pdf/CSR_disclo/2017/02.pdf
- https://www.sec.gov/Archives/edgar/data/1109609/000119312513362157/d570406dex1.htm
- https://www.jbic.go.jp/en/information/annual-report/pdf/2017E_00_full.pdf
- https://www.sec.gov/Archives/edgar/data/1551322/000119312513375292/d575453dex996.htm
- https://corporatefinanceinstitute.com/resources/careers/companies/top-banks-in-japan
- https://www.fsa.go.jp/en/news/2008/20080627-4/01.pdf
- https://www.zenginkyo.or.jp/en/banks/banking-act/
- https://www.jp-bank.japanpost.jp/en/ir/financial/pdf/en2012_12.pdf
- https://www.bloomberg.com/research/stocks/private/snapshot.asp?privcapid=875369
- https://www.shokochukin.co.jp/english/introduction/about.html#Q01
- https://www.japantimes.co.jp/news/2017/05/10/business/corporate-business/shoko-chukin-bank-reprimanded-shady-loans/#.Ww5Mki-B2-o
- https://www.fsa.go.jp/en/news/2008/20080627-4/01.pdf
- https://www.zenginkyo.or.jp/en/banks/banking-act/
- https://www.shokochukin.co.jp/english/report/2016/pdf/ar16_3.pdf
- https://www.kdb.kz/kz/about/
- http://adilet.zan.kz/kaz/docs/P1400000674#z764
- Об утверждении Стратегии развития акционерного общества "Национальный управляющий холдинг "Байтерек" на 2014 - 2023 годы, Постановление Правительства Республики Казахстан от 18 июня 2014 года № 674. http://adilet.zan.kz/rus/docs/U000000531_
- О Банке развития Казахстана, Указ Президента Республики Казахстан от 28 декабря 2000 года N 531 http://adilet.zan.kz/kaz/docs/Z010000178_
- О Банке Развития Казахстана, Закон Республики Казахстан от 25 апреля 2001 года N 178. http://adilet.zan.kz/rus/docs/P010000659_
- О создании закрытого акционерного общества "Банк Развития Казахстана", Постановление Правительства Республики Казахстан от 18 мая 2001 года N 659 https://www.kdb.kz/upload/iblock/178/Strategiya_razvitiya_BRK_kaz.pdf
- «Қазақстанның Даму Банкі» акционерлік қоғамының 2014-2023 жылдарға арналған даму стратегиясы
- Государственный банк России-на 2018 год, Клуб частных инвесторов, 2018 www.kudavlozitdeng.adne.info
- Магазинер Я. А “ Банки с государственным участием в современной банковской системе РФ”, 2016 http://institutiones.com/general/2431-banki-s-gosudarstvennym-uchastiem-v-sovremennoj-bankovskoj-sisteme.html

*Гадаадын (2012-2013) болон төрийн өмчит банкны (2010) эзэмшиж буй хөрөнгийн эзлэх хувь хэмжээ*

**Figure 1.1. Share of assets owned by foreign banks, 2012-2013**




Notes: The map reflects the most recent data available in the cited sources. 2012-2013 data are available for 80% of the sample.

Sources: Claessens and Van Horen (2015); Bank Regulation and Supervision surveys (World Bank).

**Figure 1.2. Share of assets owned by government banks, 2010**




Notes: The map reflects 2010 data, except for the MENA region where 2008 figures are used instead.

Sources: Bank Regulation and Supervision surveys (World Bank); Farazi et al. (2013); Cull and Martinez Peria (2012); China Banking Regulatory Commission; Beck et al. (2014).

*Эх сурвалж: Bank Ownership: Trends and Implications, IMF Working Paper March 2017* https://www.imf.org/~/media/Files/Publications/WP/2017/wp1760.ashx

**ХАВСРАЛТ 2.**

*Гадаадын болон төрийн өмчит банкуудын банкны секторт эзлэх хувь хэмжээ (1995-2013)*

| | | Гадаадын банк | | | | | Төрийн өмчит банк | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Улс** | **Орлогын түвшин** | **1995** | **1999-2001** | **2008** | **2010** | **2012-2013** | **1995** | **1999-2001** | **2008** | **2010** |
| **Зүүн Ази, Номхон далайн орнууд** | | | | | | | | | | |
| Australia | HI | 6% | 17% | 16% | 13% | 2% | 44% | 0% | 0% | **0%** |
| Fiji | DVP | | 99% | 100% | 100% | | | 1% | 0% | **0%** |
| Indonesia | DVP | 4% | 7% | 33% | 34% | 26% | 64% | 44% | 38% | **38%** |
| Korea, Rep. | HI | 2% | 15% | 77% | 77% | 7% | 29% | 35% | 22% | **22%** |
| Malaysia | DVP | 25% | 19% | 22% | 22% | 18% | 3% | 0% | 0% | **0%** |
| New Zealand | HI | 99% | 99% | 96% | 95% | 95% | 0% | 0% | 2% | **3%** |
| Philippines | DVP | 8% | 14% | 12% | 12% | 1% | 29% | 12% | 13% | **12%** |
| Taiwan, China | HI | 0% | 0% | 11% | 11% | | 62% | 35% | 19% | **18%** |
| Thailand | DVP | 7% | 7% | 6% | 7% | 7% | 18% | 31% | 22% | **18%** |
| Tonga | DVP | | 100% | 87% | 87% | | | 0% | 14% | **13%** |
| **Европ болон Төв Ази (OECD)** | | | | | | | | | | |
| Austria | HI | 5% | 5% | 23% | 18% | 26% | 22% | 2% | 5% | **12%** |
| Denmark | HI | 1% | 0% | 18% | 21% | 18% | 1% | 0% | 1% | **1%** |
| Estonia | HI | 81% | 92% | 99% | 99% | 97% | 0% | 0% | 0% | **0%** |
| Finland | HI | 0% | 7% | 72% | 74% | 85% | 32% | 11% | 0% | **0%** |
| Germany | HI | 5% | 4% | 13% | 12% | 12% | 27% | 42% | 35% | **32%** |
| Greece | HI | 2% | 8% | 22% | 21% | 7% | 86% | 18% | 10% | **11%** |
| Hungary | HI | 22% | 75% | 85% | 83% | 59% | 61% | 6% | 3% | **4%** |
| Iceland | HI | 0% | 0% | 0% | 0% | 0% | 95% | 32% | 28% | **41%** |
| Italy | HI | 2% | 5% | 18% | 18% | 6% | 34% | 14% | 0% | **0%** |
| Luxembourg | HI | 76% | 95% | 95% | 94% | 93% | 6% | 5% | 4% | **5%** |
| Norway | HI | 5% | 19% | 33% | 30% | 14% | 32% | 0% | 0% | **0%** |
| Poland | HI | 4% | 48% | 67% | 62% | 76% | 80% | 34% | 17% | **22%** |
| Portugal | HI | 13% | 15% | 21% | 22% | 23% | 25% | 22% | 21% | **23%** |
| Slovak Republic | HI | 9% | 71% | 96% | 94% | 83% | 84% | 15% | 1% | **1%** |
| Slovenia | HI | 7% | 13% | 31% | 28% | 26% | 48% | 26% | 51% | **51%** |
| Spain | HI | 6% | 10% | 11% | 8% | 2% | 3% | 0% | 0% | **0%** |
| Switzerland | HI | 2% | 10% | 11% | 12% | 2% | 21% | 15% | 13% | **16%** |
| Turkey | DVP | 0% | 35% | 17% | 17% | 13% | 54% | 33% | 31% | **32%** |
| United Kingdom | HI | 7% | 46% | 24% | 18% | 15% | 0% | 0% | 1% | **26%** |
| **Европ болон Төв Ази (Non-OECD)** | | | | | | | | | | |
| Armenia | DVP | | 51% | 60% | 67% | 84% | | 1% | 0% | **0%** |
| Belarus | DVP | 0% | 14% | 22% | 27% | 32% | 71% | 71% | 78% | **72%** |
| Bosnia and Herzegovina | DVP | | 54% | 93% | 92% | 86% | | 20% | 1% | **1%** |
| Bulgaria | DVP | 8% | 74% | 84% | 81% | 66% | 70% | 18% | 2% | **3%** |
| Croatia | HI | 10% | 48% | 91% | 89% | 90% | 71% | 21% | 4% | **4%** |
| Cyprus | HI | 28% | 12% | 44% | 35% | | 2% | 4% | 1% | **1%** |
| Kazakhstan | DVP | 13% | 15% | 13% | 17% | 15% | 19% | 1% | 1% | **23%** |
| Kyrgyz Republic | DVP | | 25% | 72% | 46% | 78% | | 15% | 18% | **20%** |
| Latvia | DVP | 18% | 65% | 68% | 69% | 59% | 25% | 3% | 11% | **16%** |
| Liechtenstein | HI | 0% | 2% | 6% | 4% | | 39% | 18% | 30% | **29%** |
| Lithuania | DVP | 19% | 63% | 86% | 81% | 93% | 43% | 28% | 0% | **0%** |
| Moldova | DVP | | 35% | 32% | 42% | 34% | | 10% | 9% | **13%** |
| Romania | DVP | 0% | 28% | 88% | 84% | 81% | 89% | 56% | 6% | **8%** |
| Russian Federation | DVP | 2% | 9% | 19% | 18% | 9% | 54% | 52% | 38% | **41%** |
| Tajikistan | DVP | | 28% | 7% | 6% | | | 6% | 12% | **14%** |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Ukraine | DVP | 0% | 11% | 51% | 48% | 32% | 35% | 12% | 12% | **17%** |
| **Латин Америк болон Карибын орнууд** | | | | | | | | | | |
| Argentina | DVP | 26% | 40% | 31% | 26% | 27% | 50% | 31% | 38% | **44%** |
| Belize | DVP | | 95% | 100% | 100% | | | 0% | 0% | **0%** |
| Brazil | DVP | 9% | 23% | 21% | 18% | 16% | 60% | 42% | 40% | **44%** |
| Chile | DVP | 31% | 39% | 41% | 39% | 27% | 19% | 13% | 15% | **19%** |
| Colombia | DVP | 6% | 22% | 22% | 20% | 14% | 37% | 18% | 6% | **6%** |
| Costa Rica | DVP | 0% | 23% | 36% | 31% | 29% | 78% | 62% | 50% | **54%** |
| Ecuador | DVP | | 70% | 3% | 2% | 16% | | 14% | 12% | **17%** |
| El Salvador | DVP | 1% | 12% | 94% | 93% | 98% | 31% | 6% | 5% | **6%** |
| Guatemala | DVP | 6% | 7% | 11% | 10% | 31% | 6% | 5% | 2% | **2%** |
| Guyana | DVP | 0% | 18% | 57% | 56% | | 59% | 17% | 0% | **0%** |
| Honduras | DVP | 2% | 10% | 50% | 50% | 55% | 0% | 1% | 2% | **1%** |
| Jamaica | DVP | 24% | 44% | 94% | 95% | 93% | 4% | 56% | 0% | **0%** |
| Mexico | DVP | 2% | 51% | 84% | 85% | 71% | 53% | 13% | 14% | **13%** |
| Peru | DVP | 52% | 41% | 51% | 49% | 50% | 28% | 1% | 0% | **0%** |
| Suriname | DVP | | 26% | 25% | 21% | | | 31% | 37% | **33%** |
| Trinidad and Tobago | HI | 14% | 5% | 52% | 46% | | 0% | 15% | 17% | **24%** |
| Uruguay | DVP | 24% | 43% | 52% | 54% | 73% | 63% | 43% | 48% | **46%** |
| Venezuela, RB | DVP | 5% | 38% | 26% | 17% | 16% | 63% | 6% | 12% | **33%** |
| **Зүүн Ази** | | | | | | | | | | |
| Bangladesh | DVP | 0% | 6% | 8% | 7% | 3% | 72% | 70% | 38% | **34%** |
| Bhutan | DVP | | 10% | 0% | 6% | | | 65% | 47% | **48%** |
| India | DVP | 1% | 4% | 8% | 7% | 3% | 77% | 78% | 70% | **74%** |
| Maldives | DVP | | 25% | 55% | 61% | | | 75% | 45% | **39%** |
| Nepal | DVP | 39% | 35% | 18% | 17% | 12% | 0% | 20% | 29% | **24%** |
| Pakistan | DVP | 1% | 20% | 54% | 59% | 52% | 76% | 54% | 21% | **21%** |
| Sri Lanka | DVP | 2% | 0% | 15% | 14% | 0% | 60% | 28% | 56% | **59%** |
| **Дэд Сахарын Африк** | | | | | | | | | | |
| Benin | DVP | | 91% | 66% | 73% | | | 0% | 8% | **8%** |
| Botswana | DVP | 80% | 99% | 94% | 93% | 79% | 4% | 1% | 7% | **7%** |
| Burkina Faso | DVP | | 56% | 66% | 73% | | | 0% | 8% | **8%** |
| Burundi | DVP | 39% | 0% | 12% | 16% | | 19% | 63% | 49% | **49%** |
| Côte d'Ivoire | DVP | 20% | 84% | 66% | 73% | | 62% | 11% | 8% | **8%** |
| Gambia, The | DVP | | 86% | 76% | 80% | | | 0% | 0% | **0%** |
| Ghana | DVP | 28% | 54% | 53% | 51% | 69% | 68% | 25% | 10% | **10%** |
| Guinea-Bissau | DVP | | 100% | 66% | 73% | | | 0% | 8% | **8%** |
| Kenya | DVP | 27% | 39% | 40% | 37% | 33% | 15% | 1% | 5% | **5%** |
| Lesotho | DVP | | 75% | 97% | 97% | | 26% | 3% | | **3%** |
| Madagascar | DVP | 42% | 68% | 100% | 100% | 100% | 42% | 0% | 0% | **0%** |
| Malawi | DVP | | 8% | 30% | 29% | 34% | | 49% | 8% | **9%** |
| Mali | DVP | 41% | 67% | 66% | 73% | | 38% | 22% | 8% | **8%** |
| Niger | DVP | | 73% | 66% | 73% | | | 0% | 8% | **8%** |
| Nigeria | DVP | 10% | 0% | 4% | 6% | 18% | 0% | 9% | 0% | **0%** |
| Senegal | DVP | | 79% | 66% | 73% | 94% | | 0% | 8% | **8%** |
| Seychelles | DVP | | 60% | 70% | 69% | 65% | | 40% | 30% | **31%** |
| South Africa | DVP | 0% | 6% | 30% | 28% | 25% | 2% | 0% | 0% | **0%** |
| Swaziland | DVP | | 86% | 84% | 84% | 89% | | 14% | 16% | **16%** |
| Togo | DVP | | 18% | 66% | 73% | 0% | | 51% | 8% | **8%** |
| Zimbabwe | DVP | 46% | 28% | 84% | 46% | 36% | 26% | 6% | 1% | **8%** |

*Эх сурвалж: Bank Ownership: Trends and Implications, IMF Working Paper March 2017 https://www.imf.org/~/media/Files/Publications/WP/2017/wp1760.ashx*

**ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХАРААТ БУС БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**

(Харьцуулсан судалгаа)

*Д.Халиун, О.Нарантуяа, Р.Нургүл, Ц.Элбэгзаяа*

**АГУУЛГА**

УДИРТГАЛ

Төсвийн хяналт, шинжилгээний албаны эрх зүйн байдлыг зохицуулж буй гадаадын зарим орны эрх зүйн орчин:

- Австрали
- Гүрж
- ИБУИНВУ
- БНСУ
- Швед
- Финланд

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

ХАВСРАЛТ

# УДИРТГАЛ

***Судалгааны хамрах хүрээ:*** Энэхүү асуудлыг төсвийн хяналт, шинжилгээний хараат бус байгууллага (ТХШХББ)[69] бүхий зарим орны эрх зүйн орчны хүрээнд судалсан болно.

***Судалгааны үр дүнгийн тойм:*** Олон улсын валютын сангаас 2018 онд гаргасан статистик too мэдээнээс үзэхэд улс орнуудын ТХШХББ-ын тоо сүүлийн 10 жилд эрчимтэй нэмэгдэж, нийт 39 байгууллагаас гуравны хоёр нь 2007-2008 оны эдийн засгийн хямралаас хойш, тал хувь нь 2013 оноос хойш байгуулагдсан байна. Түүнчлэн Европын Зөвлөлөөс 2011 онд баталсан “Гишүүн орнуудын төсвийн тогтолцоонд тавигдах шаардлага” удирдамжид “Гишүүн орнууд шаардлагатай бол төсвийн дүрэмтэй нийцэж буй эсэхийг хянах, холбогдох байгууллагаас боловсруулсан төсвийн төсөөллийн бодитой, хэрэгжих боломжтой эсэхийг үнэлэх үндэсний хэмжээний “хараат бус байгууллагатай” байна” гэж заасантай холбоотойгоор тус бүс нутаг дахь ТХШХББ-ын тоо нэмэгдсэн ба өдгөө хоёрны гурав нь ЕХ-ны гишүүн орон байна. Үүнээс гадна хөгжиж буй орнуудад ТХШХББ байгуулах сонирхол нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, Чили, Перу, Бразил зэрэг улс 2014, 2015, 2016 онд төсвийн хяналт, шинжилгээний хараат бус байгууллагыг байгуулсан байна.

Судалгааны явцад парламентын дэргэдэх төсвийн хяналт, шинжилгээний хараат бус байгууллага бүхий Австрали, Гүрж, ИБУИНВУ, БНСУ, Швед, Финланд зэрэг 6 орны туршлага, эрх зүйн зохицуулалтыг дэлгэрүүлэн авч үзэв.

Мөн эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-ын гишүүн 35 орноос төсвийн хяналт, шинжилгээний хараат бус байгууллагатай 26 орны ТХШХББ-ын холбоотой мэдээллийг (ТХШХББ-г байгуулсан хүрээ, эрх зүйн үндэс, институциональ загвар, хууль тогтоох байгууллагатай харьцах хэлбэр, мэдээлэл солилцох урсгал, хараат бус байдал, удирдлага, нөөц (орон тоо, төсөв), эрх үүрэг, тайлан-бүтээгдэхүүний тоо хэмжээ, хугацаа зэрэг) хавсралтаар оруулав. Хавсралт 1-7-оос үзнэ үү.

Судалгаанаас үзэхэд улс орон бүрт парламентад төсвийн болон эдийн засгийн холбогдолтой бодлого, шийдвэр гаргахад туслах үүрэгтэй хараат бус, мэргэшсэн судалгаа, шинжилгээний байгууллага (эсхүл алба) байгуулсан туршлага нь тухайн орны парламентын төлөвшил, мэргэшсэн судалгаа шинжилгээний байгууллагын дүгнэлт, судалгаа шинжилгээний материалыг шийдвэр гаргах үйл ажиллагаанд ашиглах эрэлт хэрэгцээ болон парламентыг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах тогтолцооны онцлогоос хамааран өөр өөр бүтэц, хэлбэртэй байна гэж хэлж болохоор байна. Тухайлбал, Австралийн Холбооны улсын парламентад Төрийн хариуцлага, аудитын хамтарсан хороо (1951) болон Парламентын төсвийн алба (2011 он) үйлчилгээ үзүүлдэг бол Бүгд Найрамдах Гүрж улсын парламентад Гүржийн парламентын төсвийн алба (2018), ИБУИНВУ-ын парламентад Төсвийн хариуцлагын алба (2010), БНСУ-ын Үндэсний Ассамблейд түүний төсвийн алба (2003), Швед улсын парламентад Шведийн Төсвийн бодлогын зөвлөл (2007), Финланд улсын парламентад Үндэсний аудитын газрын Төсвийн бодлогын үнэлгээний хэлтэс зэрэг байгууллага, нэгжүүд үйлчилгээ үзүүлдэг байна.

---

[69] **Independent fiscal institutions in the EU** (IFIs) are defined as non-partisan public bodies, other than the central bank, government or parliament aimed at promoting sustainable public finances through various functions, including monitoring compliance with fiscal rules, production or endorsement of macroeconomic forecasts for the budget, and/or advising the government on fiscal policy matters. These institutions are primarily financed by public funds and are functionally independent vis-à-vis fiscal authorities. Courts of Auditors are included in this definition if their activities go beyond the accounting control and cover any of the tasks mentioned above. In the EU, the recently enhanced EU fiscal governance framework (through the Council Directive 2011/85 on requirements for national budgetary frameworks, the Fiscal Compact and the 'Two- Pack' Regulation 473/2013) broadened the role and formalised the tasks of national IFIs in an attempt to foster budgetary discipline and to increase national ownership of EU fiscal rules.
https://ec.europa.eu/info/business-economy-euro/indicators-statistics/economic-databases/fiscal-governance-eu-member-states/independent-fiscal-institutions_en

## СУДАЛГААНЫ ХЭСЭГ

## ТӨСВИЙН АЛБАНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫГ ЗОХИЦУУЛЖ БУЙ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

### 1. АВСТРАЛИ[70]

Тус улс нь Үндсэн хуульт хаант засагтай парламентын холбооны улс. 1856 онд Өмнөд шинэ Уэльс, Викториа, Тасмани мужид, 1857 онд Өмнөд Австрали, 1860 онд Квинсленд, 1890 онд Хойд Австрали мужид анхны парламентууд тус тус байгуулагдсан.

1901 онд Австралийн колониуд нэгдэхэд Холбооны улсын парламентыг байгуулжээ. Холбооны улсын парламент нь хууль тогтоох дээд эрх мэдлийг хэрэгжүүлдэг бөгөөд хоёр танхимтай. Доод буюу Төлөөлөгчдийн танхим нь 3 жилийн хугацаатай сонгогдох 150 гишүүнтэй, Дээд танхим буюу Сенат нь 6 жилийн хугацаатай сонгогдох 76 гишүүнтэй. Хууль хэлэлцэн батлах эрх, үүргий хувьд хоёр танхим ижил боловч Сенат нь санхүүтэй холбогдолтой хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах эрхгүй.

Австралийн Хамтын Нөхөрлөлийн Улс нь засаг захиргааны хувьд 6 муж улс, 2 эх газар нутаг болон бусад жижиг арлаас бүрддэг. Муж улс бүр өөрийн Үндсэн хуультай бөгөөд тус бүрдээ хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагуудтай.

**Төрийн хариуцлага, аудитын хамтарсан хороо:**

**Бүтэц:** 1951 онд *Төрийн хариуцлага, аудитын хорооны тухай хуулийн* (1951 он) дагуу **Төрийн хариуцлага, аудитын хамтарсан хороо** (Joint Committee of Public Accounts and Audit – JCPAA) байгуулагдсан. Тус хорооны зарим эрх зүйн асуудлыг *Ерөнхий аудиторын тухай хуулиар* (1997 он) зохицуулна. Төлөөлөгчдийн танхимаас удирдана. 16 гишүүдийн бүрэлдэхүүнтэй, тэдний 6-г нь Сенатаас, 10-г нь Төлөөлөгчдийн танхимаас томилно.

Мөн Австралийн Хамтын нөхөрлөлийн 6 муж улс, 2 эх газар нь тус бүрдээ Төрийн хариуцлагын хороотой.

**Чиг үүрэг:** Дээр дурдсанаар Төрийн хариуцлагын хорооны үндсэн үүрэг нь төрийн байгууллагуудын санхүүгийн удирдлага, ялангуяа төсвийн гүйцэтгэлийг шинжлэн судлах замаар засгийн газрын хариуцлагыг нэмэгдүүлэх гэсэн гол зорилготой.

Австралийн Төрийн хариуцлага, аудитын хороо нь төсвийн хөрөнгийг хуулийн дагуу, үр ашигтай, бүтээмжтэй байгааг хянах үүрэгтэй. Тухайлбал:

- Төсвийн орлого, зарлагын тооцоог хянаж шалгах;
- Мужуудын захиргааны санхүүд шалгалт хийх;
- Парламентад танилцуулсан бүх аудитын тайланд шалгалт хийх;
- Парламентад танилцуулсан төсөвтэй холбоотой бүхий л асуудлуудыг хянаж шалгах;
- Хяналт, шалгалтын үр дүнг Парламентын хоёр танхимд танилцуулах;
- Парламентын сонирхсон асуудалд хариу өгөх;
- Парламентад зөвлөмж гаргах;
- Ерөнхий сайдын Ерөнхий аудитад санал болгосон нэр дэвшигчийг дэмжих, татгалзах бүрэн эрхтэй;
- Мужуудын захиргааны жилийн төсвийн удирдлага болгож байдаг үзэл баримтлалд Парламентын өмнөөс дэмжих эрхтэй.[71]

Мөн 2 жил тутамд Австралийн Татварын алба нь тус хорооны татвартай холбоотой асуулгад хариу өгдөг[72].

---

[70] http://www.oecd.org/gov/budgeting/Australia.pdf
https://www.aph.gov.au/About_Parliament/House_of_Representatives/Powers_practice_and_procedure/00_-Infosheets/Infosheet_4_-_Committees
https://www.parlament.gv.at/ZUSD/BUDGET/Towards_a_Common_Evaluation_Framework_xBudgeting_and_Public_Expenditures_Divisionx_OECDx.pdf

[71] Уг эрхийг 1999 оноос олгосон.

**<u>Парламентын төсвийн алба (Parliamentary Budget Office)</u>:**[73] 2011 онд батлагдсан "Парламентын Төсвийн албаны тухай хууль"-ийн хүрээн үүсгэн байгуулж, Парламентын төсвийн албаны анхны даргыг 2012 оны 7 дугаар сард томилсон. Төсөв нь 29.7 сая австрали доллар (4 жилээр 2014 оны байдлаар), орон тоо - 40.

Тус улсад сонгуулийн амлалтыг биелүүлэхтэй холбоотой төсвийн ил тод байдлыг хангах, хариуцлагыг нэмэгдүүлэх хүрээнд Парламентын төсвийн алба (ПТА) байгуулах асуудлыг 1980-аад оноос хойш хэлэлцэж ирсэн байна. Учир нь Засгийн газар болон сөрөг хүчний хувьд сонгуулийн амлалтаа биелүүлэхэд төсөв (Сангийн яам болон Төрийн сан)-өөс дэмжлэг авч амлалтуудаа санхүүжүүлэх боломжтой байдаг бол жижиг нам болон бие даагч гишүүдийн хувьд дээрх боломж дутмаг, мөн парламентад төсвийн болон эдийн засгийн бодлоготой холбоотой мэдээлэлд шинжилгээ хийх хараат бус байгууллагатай байх хэрэгцээ, шаардлага байна гэж үзсэнтэй холбоотой байна.

ПТА нь 2010 оны Холбооны улсын сонгуулийн үр дүнд байгуулагдсан цөөнхийн Засгийн газрын "Парламентын шинэтгэл"-ийн гэрээний үндсэн дээр байгуулагдсан ба ПТА-ны бүтэц, зохион байгуулалт, үзүүлэх үйлчилгээний цар хүрээг тогтоох үүднээс Парламентын Хамтарсан түр хороо байгуулсан байна. Хамтарсан түр хорооны бүрэлдэхүүнд парламентад суудал авсан намуудын Төлөөлөгчдийн танхимын болон Сенатын гишүүд, бие даагч гишүүд орсон байна. Ингэхдээ хамтарсан түр хороонд том болон жижиг намуудын удирдлага, бие даагч гишүүд, Сангийн яам, Парламентын Үйлчилгээний департмент, Төлөөлөгчдийн танхим болон Сенатын департмент, Шинэ Өмнөд Уэльсийн Парламентын Клеркууд болон олон улсын парламентын төсвийн албад болон олон нийтээс ирүүлсэн олон тооны саналуудыг судалж, 2011 оны 2 дугаар сард нээлттэй сонсгол явуулж, дүнг 3 дугаар сарын 23-ны өдөр танилцуулсан байна. Мөн оны 5 дугаар сард Засгийн газраас 4 жилийн хугацаанд хараат бус дарга (Parliamentary Budget Officer)-тай, бие даасан статустай Парламентын төсвийн албыг байгуулахад 24.9 сая австрали доллар олгохоо мэдэгдсэн байна. Үүний дараа Засгийн газар "Парламентын төсвийн албаны тухай" хуулийн төслийг 2011 оны 8 дугаар сарын 24-нд өргөн барьж, 2011 оны 11 дугаар сард Төлөөлөгчдийн танхим, Сенатаар хэлэлцэн баталж, 12 дугаар сард Хатан хаан ёсчлон, 2012 оны 2 дугаар сард хэвлэн нийтэлсэн байна.

*Зураг 1. Австралийн Парламентын департментууд*[74]




*<u>Засгийн газар, Парламенттай харилцах</u>*

Парламентын төсвийн алба (ПТА) нь Парламентын 4 департментын нэг юм. Парламентын төсвийн албаны тухай хуулийн[75] Тус хуулийн 64А (2)-т заасны дагуу ПТА нь дарга болон түүнд дэмжлэг үзүүлэх парламентын үйлчилгээний албаны албан хаагчдаас бүрдэнэ. 64В-д зааснаар ПТА-ны зорилго нь энэхүү хэсэгт (хуульд) заасны дагуу Парламентад төсвийн мөчлөг, төсвийн бодлого боловсруулах үе шат бүхэнд хуулийн төслийн зардлын тооцоо хийх бие даасан, хараат бус дүн шинжилгээгээр хангахад оршино. Хуулийн 64Е-д зааснаар ПТА-ны дарга нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

---

[72] Уг эрхийг 2007 оноос олгосон.
[73] https://www.aph.gov.au/About_Parliament/Parliamentary_Departments/Parliamentary_Budget_Office/About_the_PBO
[74] Parliamentary Departments, https://www.aph.gov.au/About_Parliament/Parliamentary_Departments
[75] Parliamentary Service Amendment (Parliamentary Budget Officer) Act 2011, No. 170, 2011 https://www.legislation.gov.au/Details/C2011A00170

ПТА-ын бие даасан байдлыг хангах хуульд тус байгууллагын удирдлагыг томилох, огцруулах процедурыг тусгаж өгсөн байна. ПТА-ны даргыг Тэргүүлэгчид (Сенат болон Төлөөлөгчдийн танхимын дарга нар) гагцхүү Төрийн хариуцлага, аудитын хамтарсан хорооноос зөвшөөрөл олгосны дараа томилох (64X) ба 4 жилийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болохоос өмнө хууль зөрчсөн, эсхүл бие, сэтгэцийн эрүүл мэндийн байдлаас үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй гэж үзсэн бол гагцхүү хоёр танхимын (Төлөөлөгчдийн танхим болон Сенатын) гишүүдийн олонхын саналаар чөлөөлнө. Мөн Тэргүүлэгчид нь ПТА-ны даргыг чадамжгүй гэж үзсэн тохиолдолд дээрх журмын дагуу огцруулж болно.

Парламентаас төсвийн албанд тавих хяналтыг дараах хоёр гол хэлбэрээр хэрэгжүүлнэ. Үүнд: үйл ажиллагааны тайланг хянан, жилийн төсөв, төлөвлөгөөг батлах явдал юм. Хуульд заасны дагуу ПТА-ны санхүүгийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлахдаа ПТА-ны дарга нь ирэх жилийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг Төрийн хяналт, аудитын хамтарсан хороотой зөвшилцсөн тохиолдолд батална.

Парламентын Төсвийн албаны дарга нь Сенатын Ерөнхийлөгч болон Төлөөлөгчдийн танхимын Спикерт албаны үйл ажиллагаа болон менежменттэй холбоотой асуудлаараа тайлагнана. Нөгөө талаас Парламентын төсвийн албаны тухай хуульд албаны дарга нь чиг үүргээ хэрэгжүүлэхдээ бие даасан эрх эдэлнэ гэж заасан байдаг.

## 2. БҮГД НАЙРАМДАХ ГҮРЖ УЛС

Гүржийн Парламентын Төсвийн албаны үйл ажиллагааг 2018 онд батлагдсан Гүржийн Парламентын Төсвийн албаны дүрмээр (*Charter of The Parliamentary Budget Office of Georgia*) зохицуулдаг. Энэхүү дүрмээр Гүржийн Парламентын төсвийн албаны бүтэц, зохион байгуулалт болон үүрэг, хариуцлагын талаар асуудлыг зохицуулна. Төсвийн алба нь Гүржийн Парламентын ажлын албаны бүтцэд хамаардаг. Төсвийн албаны шийдвэр, түүний хэрэгжилт нь аливаа улс төрийн нөлөөнөөс ангид, хараат бус, бие даасан байна. Төсвийн алба нь дараах бүрэн эрхийг эдэлнэ[76]. Үүнд:

1. Санхүү, төсөв, макро эдийн засгийн асуудал, мөн төрийн санхүүгийн удирдлагын асуудалтай холбоотой дүн шинжилгээ болон судалгаа шинжилгээний мэдээллээр Парламентыг хангана.
2. Төсвийн алба нь:
    - улсын макро эдийн засгийн өсөлтийн жилийн төсөөллийг бэлтгэх, Засгийн газрын төсөөлөл, мөн түүний үндсэн үзүүлэлтүүд болон таамаглалыг үнэлэх;
    - макро эдийн засгийн төлөвлөлттэй уялдуулан төсвийн төсөлд дүн шинжилгээ хийх, мөн төсвийн төслийг хэлэлцэх явцад гарсан аливаа өөрчлөлттэй холбоотой саналд дүн шинжилгээ хийх, Гүрж болон автономит Абхаз улс, автономит Аджара улс, бусад мужуудын сар, хагас жил, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх;
    - батлагдсан төсвийн орлого, зарлагын аливаа өөрчлөлтийг судалж шинжлэх;
    - “Үндсэн мэдээлэл ба чиглэл”-д тодорхойлсон (*Basic Data and Directions*) санхүү төсөв болон мөнгөний бодлогын үндсэн чиглэл, дунд хугацааны стратегийг үнэлэх;
    - улсын өр төлбөрийн асуудал болон төсвийн алдагдал, илүүдэл, төлбөрийн тэнцлийн байдал, мөн татвар, мөнгө, гаалийн бодлогод дүн шинжилгээ хийх;
    - хуулийн төслийн үр дагавар болон түүний санхүү, эдийн засгийн үндэслэлд дүн шинжилгээ хийх;
    - улсын төсвөөс зээл авах, олгох тухай олон улсын гэрээ, хэлэлцээрүүдэд дүн шинжилгээ хийх;
    - санхүү, төсөв, макро эдийн засгийн асуудлууд, мөн төрийн санхүүгийн удирдлагын талаар эрх мэдлийн хүрээнд өөрийн санаачилгаар мэргэжлийн судалгаа хийх юм.

---

[76] http://pbo.parliament.ge/images/Charter%20for%20the%20Parliamentary%20Budget%20Office%20of%20Georgia.pdf Парламентын Төсвийн албаны журам, 3 дугаар зүйл

3. Төсвийн алба нь Парламентын гишүүдийг, мөн хүсэлт гаргасны дагуу байнгын хороод болон ажилтнууд, Парламент дахь намын бүлгүүд, Парламентын ажлын албадыг судалгаа, шинжилгээ болон үнэлгээ дүгнэлтээр тогтмол хангана.
4. Төсвийн алба нь хуулийн төслийг боловсруулахаас өмнө болон боловсруулах явцад эрх мэдлийн хүрээнд өөрийн санаачилгаар, хэлэлцэх үеэр хүсэлт гаргаснаас хойш 4 долоо хоногийн дотор Парламентын гишүүдэд холбогдох зардлын тооцоог гаргаж өгнө. Уг хугацааг сунгах тохиолдолд хүсэлт гаргагч болон Төсвийн алба нь тохиролцсон байх ёстой.
5. Төсвийн алба нь төсөв, татвар, мөнгөний бодлого, мөн төрийн санхүүгийн удирдлагын бодлогыг тодорхойлох талаар зөвлөмж гаргахгүй.

**Үйл ажиллагааны зарчим[77]**

- Төсвийн алба нь өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхийн тулд Гүржийн Засгийн газар, яам, захиргаа, олон улсын болон бусад байгууллагын албан ёсны тоо баримт, статистик мэдээллийг ашиглана. Эдгээр байгууллагууд нь өөрт байгаа мэдээлэл, тоон үзүүлэлтийг Төсвийн албаны хүсэлтийн дагуу түргэн шуурхай, цаг алдалгүй, үнэ төлбөргүйгээр хүргэх үүрэгтэй.
- Төсвийн алба нь тайланд хийсэн дүн шинжилгээний үр дүн болон дүгнэлт, зөвлөх дүгнэлт, бодлогын хураангуйг танилцуулна, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй. Төсвийн албанаас тогтмол гаргадаг бүтээгдэхүүнийг Парламентын бүх гишүүн авч хэрэглэх боломжийг хангана.
- Төсвийн албанаас гаргасан судалгаа шинжилгээний бүтээл нь олон нийтэд нээлттэй байх бөгөөд дэвшүүлж буй бүх төсөөлөл, таамаглал болон мэдээллийн эх сурвалж, тоон үзүүлэлтүүд ил тод байна. Үүнд Төсвийн албаны нууцын холбогдолтой мэдээ материал, тоо баримтууд, судалгаа шинжилгээний дүгнэлтүүд хамаарахгүй.
- Төсвийн алба нь тогтвортой, үр дүнтэй ажиллах, санхүү, төсөв, макро эдийн засгийн асуудлууд болон төрийн санхүүгийн удирдлагын талаарх судалгаа шинжилгээний ажлыг улам боловсронгуй болгох зорилгоор их дээд сургуулиуд, эдийн засгийн судалгааны хүрээлэн, олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллах, эрдэм шинжилгээний бага хурал, мэтгэлцээн, хэлэлцүүлэгт оролцох, олон улсын туршлага солилцох замаар идэвхтэй хамтын ажиллагааг хэрэгжүүлнэ.

**Төсвийн албаны удирдлага[78]**

- Төсвийн албыг Төсвийн албаны дарга удирдах ба Төсвийн албаны Хяналтын зөвлөлийн өмнө хариуцлага хүлээнэ.
- Төсвийн албаны дарга нь албаны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, ажилтнуудын сахилга хариуцлага, бүтээгдэхүүний чанар, агуулга, Төсвийн албыг төлөөлөх үүргийг Парламент болон бусад байгууллагын өмнө хариуцна.
- Төсвийн албаны даргыг Төсөв, санхүүгийн Байнгын хорооны даргын санал болгосноор Парламентын дарга 5 жилийн хугацаатай томилно. Төсвийн албаны даргын албан тушаалд онолын болон мэргэжлийн өндөр ур чадвар, мэдлэг туршлагатай хүнийг нэр дэвшүүлнэ.
- Төсвийн албаны даргыг эзгүйд албаны дэд дарга буюу Төсвийн Судалгаа шинжилгээний нэгжийн дарга түүнийг орлон ажиллана.

**Төсвийн албаны ажилчид[79]**

- Төсвийн албаны ажилчид нь Парламентын ажлын албаны ажилтан, төрийн албан хаагч байна.

---

[77] http://pbo.parliament.ge/images/Charter%20for%20the%20Parliamentary%20Budget%20Office%20of%20Georgia.pdf Парламентын Төсвийн албаны журам, 4 дүгээр зүйл
[78] http://pbo.parliament.ge/images/Charter%20for%20the%20Parliamentary%20Budget%20Office%20of%20Georgia.pdf Парламентын Төсвийн албаны журам, 5 дугаар зүйл
[79] http://pbo.parliament.ge/images/Charter%20for%20the%20Parliamentary%20Budget%20Office%20of%20Georgia.pdf Парламентын Төсвийн албаны журам, 6 дугаар зүйл

- Төсвийн албаны албан хаагчдыг Гүржийн Төрийн албаны хуулийн дагуу Төсвийн албаны даргын санал болгосноор Парламентын ажлын албаны даргын тушаалаар томилох болон чөлөөлнө.
- Төсвийн албаны албан хаагчид нь ажил үүргээ мэргэжлийн түвшинд, аливаа улс төрийн намын нөлөөгүйгээр Гүрж улсын Үндсэн хууль, Гүрж улсын бусад хууль тогтоомж, Парламентын тухай хууль эрх зүйн зохицуулалт, Парламентын албан хаагчийн дүрэм журмын дагуу хийж гүйцэтгэнэ.
- Төсвийн албаны албан хаагчдын ажил үүргийн хуваарийг энэ дүрмээр болон холбогдох ажлын байрны тодорхойлолтоор тодорхойлно.

**Төсвийн албаны бүтэц, зохион байгуулалт[80]:**

Төсвийн албаны бүтэц, зохион байгуулалтыг Төсвийн албаны дүрэм болон орон тоо, бүтэц зохион байгуулах төлөвлөгөөнд тусгана. Төсвийн алба нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

- Төсвийн шинжилгээний нэгж;
- Макро эдийн засгийн шинжилгээ ба татварын бодлогын нэгж;
- Ханшийн үнэлгээ ба хуулийн дэмжлэг үзүүлэх нэгжтэй байна.

**Төсвийн шинжилгээний нэгж нь** дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Макро эдийн засгийн төлөвлөлттэй уялдуулан төсвийн төсөлд дүн шинжилгээ хийх, мөн төсвийн төслийг хэлэлцэх явцад гарсан аливаа өөрчлөлттэй холбоотой саналд дүн шинжилгээ хийх;
- Сар, хагас жил, бүтэн жилийн төсвийн гүйцэтгэлийн эцсийн үр дүнд дүн шинжилгээ хийх;
- Гүржийн Автономит Абхаз Улс, Автономит Аджара Улс болон бусад нутаг дэвсгэрийн нэгжийн төсвийн төлөвлөгөө болон гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх;
- Улсын төсвөөс нутаг дэвсгэрийн нэгжийн төсөвт хуваарилсан санхүүгийн тусламжийн зарцуулалтад дүн шинжилгээ хийх;
- Батлагдсан төсвийн орлого, зарлагын аливаа өөрчлөлтөд дүн шинжилгээ хийх;
- Төсвийн илүүдэл, алдагдал, өр төлбөрийн асуудалд дүн шинжилгээ хийх;
- Улсын төсөвт хийх нэмэлт өөрчлөлтөд дүн шинжилгээ хийх;
- “үндсэн мэдээлэл ба чиглэл”-д тодорхойлсон зардлууд болон дунд хугацааны стратегийг судалж шинжлэх;
- Улсын төсвийн мөнгийг зарцуулах эрх бүхий байгууллагуудын дунд хугацааны стратегийг судалж шинжлэх;
- Улсын төсөвт тусгасан хөтөлбөр, үйл ажиллагааны зорилго, тэдгээрийн үр дагавар, оновчтой эсэх, санхүүжилтийн хэмжээнд дүн шинжилгээ хийх;
- Төсөв боловсруулах, батлах болон төсвийн гүйцэтгэлтэй холбоотой хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал гаргах;
- Төсвийн болон төрийн санхүүгийн удирдлагын асуудлаар эрх мэдлийн хүрээнд өөрийн санаачилгаар мэргэжлийн судалгаа шинжилгээ хийх;

**Макро эдийн засгийн шинжилгээ ба татварын бодлогын нэгж** нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Макро эдийн засгийг хөгжүүлэх жилийн төсөөллийг боловсруулах, Засгийн газрын төсөөлөл, түүний үндсэн үзүүлэлтүүд болон таамаглалыг үнэлэх;
- “Үндсэн Мэдээлэл болон Чиглэл”-д тодорхойлогдсон мөнгө болон төсөв санхүүгийн бодлогын үндсэн чиглэл, дунд хугацааны стратегийг үнэлэх;
- Төлбөрийн тэнцэл, мөнгө, татвар, гаалийн бодлогуудад дүн шинжилгээ хийх;
- Макро эдийн засгийн хөгжлийн үндсэн чиглэлд судалгаа шинжилгээ хийх (ДНБ, экспорт импорт, инфляц, мөнгөний бодлого гэх мэт);
- Төсвийн үндсэн үзүүлэлтүүд болон аливаа зөрүү, хэлбэлзлийн шалтгаан нь улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн чадавхаас хэр хамаарч буйг судалж шинжлэх;

[80] http://pbo.parliament.ge/images/Charter%20for%20the%20Parliamentary%20Budget%20Office%20of%20Georgia.pdf Парламентын Төсвийн албаны журам, 7 дугээр зүйл

- Эрх мэдлийн хүрээнд өөрийн санаачилгаар макро эдийн засгийн асуудлууд болон төрийн санхүүгийн удирдлагын чиглэлээр мэргэжлийн судалгаа шинжилгээ хийх юм.

**Зардлын тооцоо, хууль эрх зүйн дэмжлэг үзүүлэх нэгж** нь дараах ажил үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- Төсвийн хуулийн төслийн үр дагавар, түүний эдийн засгийн үндэслэлд дүн шинжилгээ хийх;
- Улсын төсвөөс зээл авах, олгох тухай олон улсын гэрээ, хэлэлцээрүүдэд дүн шинжилгээ хийх;
- Хуулийн төслийг боловсруулахаас өмнө болон боловсруулах явцад, мөн хэлэлцэх үеэр парламентын гишүүдийг холбогдох зардлын тооцоогоор хангах;
- Эрх мэдлийн хүрээнд өөрийн санаачилгаар төрийн санхүүгийн удирдлага болон хуулийн төслийн санхүүгийн үр дагаврын асуудлаар мэргэжлийн судалгаа шинжилгээ хийх зэрэг болно.

**Төсвийн албанд хяналт тавих**[81]

Төсвийн албаны үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй Хяналтын зөвлөл ажиллах бөгөөд 5 гишүүнээс бүрдэнэ. Зөвлөлийг Парламентын дарга байгуулдаг, мөн тэргүүлдэг. Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнд Парламентын дарга болон Төсөв, Санхүүгийн Байнгын хорооны дарга шууд орно. Бусад 3 гишүүнийг Парламентын дарга зөвшилцлийн үндсэн дээр Парламентын олонхын бүлгээс нэг, цөөнхийн бүлгээс нэг, бие даагч эсвэл олонх болон цөөнхийн бүлэгт багтаагүй аль нэг гишүүнийг томилно. Хэрэв Парламентад олонх эсвэл цөөнхийн бүлэг байхгүй бол 3 гишүүнийг Парламентын дарга зөвшилцсөний үндсэн дээр намын бүлгүүдээс болон бие даагчдаас томилно.

Хяналтын зөвлөлийг Парламентын дарга удирдах ба зөвлөлийн эрх мэдэл болон ажил үүргийн журмыг Парламентын дарга тодорхойлно. Хяналтын зөвлөл нь жилд 2-оос доошгүй удаа хуралдана. Хяналтын зөвлөлийн 2-оос доошгүй гишүүний санал болгосноор онцгой хурал зарлана.

Төсвийн албаны дарга нь жил бүр нэгдүгээр сарын сүүлчээр дараах байдлаар Хяналтын зөвлөлд ажлаа тайлагнана. Үүнд:

- Төсвийн албаны ажлын бүх хүрээг хамарсан ирэх 3 жилийн дунд хугацааны хөгжлийн стратегийн шинэчилсэн хувилбарыг танилцуулна.
- Тухайн жилийн ажлын төлөвлөгөө, үүнд төлөвлөгөөт төсөл хөтөлбөрүүд болон тэдгээрийн тайлагнах хугацааг тусгасан байна.
- Жилийн гүйцэтгэлийн тайлан. Үүнд Төсвийн албаны өмнөх жилийн ажлын төлөвлөгөөнд оруулсан төсөл хөтөлбөр, бүтээгдэхүүн болон жилийн ажлын төлөвлөгөөний биелэлт, мөн дунд хугацааны стратегийн хөгжлийн төлөвлөгөөнд төлөвлөсөн арга хэмжээнүүдийн хэрэгжилт болон зорилтуудын биелэлтийг тусгана.
- Хяналтын зөвлөл нь Төсвийн албаны жилийн ажлын тайлангийн үр дүн, Парламентын ажилд оруулсан хувь нэмрийг харгалзан үзэж албаны үйл ажиллагааг үнэлж дүгнэнэ.

Хяналтын зөвлөл нь Төсвийн албаны тайлан, судалгаа шинжилгээтэй холбоотой тусгайлсан асуудлаар гадны мэргэжилтнүүдийн санал бодлыг сонсож болно. Төсвийн албаны жилийн гүйцэтгэлийн тайлан, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, дунд хугацааны (3 жил) шинэчилсэн стратегийг хүлээн авснаас хойш 1 сарын дотор хэлэлцэнэ. Мөн Төсвийн албаны ажлын талаар албаны даргад зөвлөмж хүргүүлж болно.

Төсвийн албаны дарга нь томилогдсоноос хойш 3 сарын дотор Төсвийн албаны ирэх 3 жилийн дунд хугацааны хөгжлийн стратегийг боловсруулж, Хяналтын зөвлөлд танилцуулах үүрэгтэй.

Төсвийн албаны дүрмийн өөрчлөлтийг Төсвийн албаны Хяналтын зөвлөл дэмжин

[81]http://pbo.parliament.ge/images/Charter%20for%20the%20Parliamentary%20Budget%20Office%20of%20Georgia.pdf Парламентын Төсвийн албаны журам, 8 дугаар зүйл

зөвшөөрснөөр Төсвийн албаны дарга өргөн мэдүүлж, Парламент хүлээн зөвшөөрснөөр Парламентын дарга батална.

## 3. ИХ БРИТАНИ, УМАРД ИРЛАНДЫН НЭГДСЭН ВАНТ УЛС

Төсвийн Хариуцлагын Алба (Office for Budget Responsibility-OBR) нь 2010 онд байгуулагдсан бөгөөд парламентын гишүүдийн төрийн санхүүгийн талаарх хараат бус, бие даасан шинжилгээгээр хангаж ажиллах үүрэгтэй. Албаны үйл ажиллагааг 2011 оны *Төсвийн хариуцлага болон Үндэсний аудитын тухай хуулиар (Budget Responsibility and National Audit Act 2011)* зохицуулна[82].

**Удирдлага, бүтэц зохион байгуулалт**

Төсвийн Хариуцлагын Алба нь Төсвийн Хариуцлагын Хороо, Хяналтын Зөвлөл, Зөвлөхүүдийн бүлэг, ТХА-ны орон тооны ажилтнуудаас бүрдэнэ.

*Зураг 2. Төсвийн Хариуцлагын Албаны удирдлага, зохион байгуулалтын бүтэц*[83]




*Төсвийн Хариуцлагын Хороо.* Төсвийн Хариуцлагын Албыг Төсвийн Хариуцлагын Хороо удирдах бөгөөд Хорооны даргыг оролцуулаад нийт 3 гишүүнтэй. Хорооны дарга болон гишүүдийг Канцлер Парламентын доод танхимын Төрийн сангийн Хороотой зөвшилцсөний үндсэн дээр 5 жилийн хугацаатай томилно[84].

*Хяналтын Зөвлөл* нь Төсвийн Хариуцлагын Хорооны 3 гишүүн, түүнээс гадна 2 гишүүн буюу нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй. Зөвлөл нь эрсдэлийн удирдлага, засаглал болон дотоод хяналтыг үр дүнтэй зохион байгуулах ажлыг хариуцна.

*Зөвлөхүүдийн бүлэг* нь эдийн засаг, төсвийн чиглэлээр мэргэшсэн мэргэжлийн шинжээчдээс бүрдэх бөгөөд ажлын төлөвлөгөө болон судалгаа шинжилгээний арга зүйн талаар тогтмол хэлэлцэж, Төсвийн Хариуцлагын Албанд зөвлөх үүрэгтэй ажилладаг.

*Орон тооны ажилтан.* Төсвийн Хариуцлагын алба нь байнгын 27 ажилтантай (төрийн албан хаагч) бөгөөд дараах ажил үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- эдийн засгийн төсөөллийг боловсруулж, дүн шинжилгээ хийх;

[82] http://obr.uk/docs/dlm_uploads/Budget-Responsibility-and-National-Audit-Act-2011.pdf
[83] http://obr.uk/docs/OBROrganogram2.jpg
[84] http://obr.uk/docs/dlm_uploads/Budget-Responsibility-and-National-Audit-Act-2011.pdf
2011 оны Төсвийн хариуцлага болон Үндэсний аудитын тухай хууль, Хавсралт 1

- төсвийн төсөөллийг боловсруулж, дүн шинжилгээ хийх;
- нийгмийн халамжийн төсөөллийг боловсруулж, дүн шинжилгээ хийх;
- төсвийн тогтвортой байдлын шинжилгээ хийх зэрэг болно.

Дээрхээс гадна үйл ажиллагаа, стратеги, харилцаа холбооны чиглэлийн ажил үйлчилгээг хариуцдаг байна.

**Албаны үндсэн ажил үүрэг:**

Төсвийн Хариуцлагын Алба нь төрийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор дүн шинжилгээ хийх болон тайлан бэлтгэх үүрэгтэй[85]. Тухайн санхүүгийн жилд 2-оос доошгүй удаа дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- эдийн засаг, төсвийн төсөөллийг бэлтгэх;
- төсвийн байгаа, байх ёстой, байж болох хэмжээ хязгаарыг үнэлэх юм[86].

Мөн тухайн санхүүгийн жилийн хугацаанд доорх ажлуудыг ядаж 1 удаа заавал хийнэ. Үүнд:

- өмнөх жилийн төсөв болон эдийн засгийн төсөөлөл үнэн зөв эсэхийг үнэлэх;
- төрийн санхүүгийн тогтвортой байдалд дүн шинжилгээ хийх зэрэг болно[87].

Төсвийн Хариуцлагын Алба нь гаргасан мэдээллээ хэвлэн нийтлүүлэх, Парламентад хүргүүлэх, хуулбарыг Төрийн сангийн Хороонд илгээх үүрэгтэй. Албанаас бэлтгэн гаргасан аливаа төсөөлөл, үнэлгээ дүгнэлт, дүн шинжилгээ зэргийг тайланд заавал тусгана.

Алба нь албан хэрэгцээнд шаардлагатай гэж үзсэн Засгийн газрын аливаа мэдээлэл, туслалцаа, тайлбарыг холбогдох албан тушаалтнаас үнэн зөв, түргэн шуурхай гаргуулж авах эрхтэй.

Төсвийн Хариуцлагын Алба нь 5 гол чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. *Эдийн засаг болон төсвийн төсөөлөл бэлтгэх.* *"Эдийн засаг болон төсвийн төлөв байдал"* (*Economic and fiscal outlook - EFO*) буюу эдийн засаг, төрийн санхүүгийн 5 жилийн нарийвчилсан төсөөллийг жилд 2 удаа гаргана. Энэ нь 11-р сарын сүүлээр Төсвийн тооцоолол (Budget Statement) болон 3-р сард Хаврын тооцоололтой (Spring Statement) хамт гардаг. Төсөөлөлд эдгээр тооцоололд тусгасан аливаа татварын нөлөөлөл болон зардлын үзүүлэлтүүдийг оруулна. Мөн *"Төсөөллийг үнэлэх тайлан"*-г (*Forecast evaluation report - FER)* жил болгоны намар гаргана. Үүнд гүйцэтгэлүүдийг харьцуулан авч үздэг тул ирээдүйн төсөөллийг таамаглахад хялбар болох юм.
2. *Гүйцэтгэлийн зөрсөн дүнг үнэлэх.* Төсвийн хариуцлагын алба нь өөрийн бэлтгэсэн төрийн санхүүгийн талаарх төсөөллийг Засгийн газрын гүйцэтгэл, ялангуяа төсвийн зорилтууд болон зорилтот халамжийн зарцуулалтыг хянахад хэрэглэдэг. *"Халамжийн чиг хандлагын талаарх тайлан" (Welfare trends report -WTR*) нь халамжийн зардлын зарцуулалтыг хянана.
3. *Тогтвортой байдал болон тайлан балансt дүн шинжилгээ хийх.* Алба нь төсвийн урт хугацааны тогтвортой байдлыг үнэлдэг. *"Төсвийн тогтвортой байдлын тайлан"*-г (*Fiscal sustainability report - FSR*) 2 жилд нэг удаа гаргах бөгөөд энэ нь төсвийн орлого, зарлага, санхүүгийн ажил гүйлгээний төрөл бүрийн ангилалд урт хугацааны төсөөллийг тодорхойлж, төрийн секторын өр төлбөрийн байдлыг үнэлнэ. Түүнээс гадна энэ тайлангаар төрийн секторын тайлан балансын үнэлгээг харуулдаг. Үүнд Үндэсний тайлан бүртгэл (National Account) болон Засгийн газрын нэгдсэн тайлан бүртгэлийг (Whole of Government Accounts - WGA) ашиглана.

[85] http://obr.uk/docs/dlm_uploads/Budget-Responsibility-and-National-Audit-Act-2011.pdf
2011 оны Төсвийн хариуцлага болон Үндэсний аудитын тухай хууль, Хавсралт 1, 4-р зүйлийн 1
[86] http://obr.uk/docs/dlm_uploads/Budget-Responsibility-and-National-Audit-Act-2011.pdf
2011 оны Төсвийн хариуцлага болон Үндэсний аудитын тухай хууль, Хавсралт 1, 4-р зүйлийн 3
[87] http://obr.uk/docs/dlm_uploads/Budget-Responsibility-and-National-Audit-Act-2011.pdf
2011 оны Төсвийн хариуцлага болон Үндэсний аудитын тухай хууль, Хавсралт 1, 4-р зүйлийн 4

4. *__Төсвийн эрсдэлийг үнэлэх.__* Эдийн засгийн болон санхүүгийн системийн эрсдэлийг үнэлэх зорилгоор *“Төсвийн эрсдэлийн тайлан” (Fiscal risks report - FRR)* гаргадаг. Энэ нь эрсдэлийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг харуулдаг бөгөөд 2 жилд нэг удаа гаргана.
5. *__Татвар болон нийгмийн халамжийн өртөг зардлыг задлан шинжлэх.__* Төсвийн Хариуцлагын Алба нь Засгийн газрын татварын өртөг зардал болон нийгмийн халамжийн зарцуулалтыг төсөв хэлэлцэх болгонд задлан шинжилдэг. Иймд энэ хугацаанд Засгийн газраас зардлын төслийг ирүүлнэ.

Төсвийн Хариуцлагын Албаны гүйцэтгэж буй эдгээр үүргүүд нь нэгдсэн улсын төрийн санхүүг бүх талаас нь өргөн хүрээнд харуулна.

Мөн Засгийн газрын хүсэлтээр *“Шотланд болон Уэльсийн орлогын төсөөлөл” (Scottish and Welsh revenue forecasts)*-ийг *“Эдийн засаг болон төсвийн төлөв байдал”*–ийн төсөөлөлтэй хамт гаргадаг.

Эдгээр үйл ажиллагааны хүрээнд алба нь жилийн турш янз бүрийн судалгаа шинжилгээний төслүүдийг хэрэгжүүлнэ. Иргэдэд мэдээлэл өгөх зорилгоор товч танилцуулгын материалуудыг гаргахаас гадна төрийн санхүүгийн статистик мэдээллийн танилцуулгыг сар бүр гаргана.

Төсвийн Хариуцлагын алба нь мэдээлэл авах хүсэлтэд хариу өгөх, мөн Вестминстер, Эдинбург, Кардиффын парламентын хороодод баталгаа гаргаж өгдөг.

Албаны үйл ажиллагааг жил бүрийн “Жилийн тайлан тооцоо”-нд (Annual Reports and accounts) нэгтгэн тайлагнана.

Төсвийн хариуцлагын алба нь төрийн санхүүгийн тогтвортой байдалд дүн шинжилгээ хийх, тайлагнах үүргээ гүйцэтгэхийн тулд засгийн газрын яам, хэлтэс албадтай нягт хамтран ажилладаг. Тэдгээр нь төрийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлдөг төрөл бүрийн орлого зарлагын урсгал, санхүүгийн ажил гүйлгээнүүд, тэдгээрийн талаарх төсөөллийг боловсруулах үүрэг бүхий албадууд байна.

Бие даасан хараат бус байдлаа хадгалахын тулд засгийн газартай харилцан ажиллахад ил тод байх зарчмыг баримталдаг.

Иймээс төрийн сан, гаалийн байгууллага, тэтгэврийн асуудал хариуцах хэлтэс зэрэг зарим байгууллага, хэлтэс албадтай хамтын ажиллагаа хэрэгжүүлэхэд “Харилцан ойлголцох санамж бичиг” байгуулсан байна. Энэ нь үр дүнтэй ажиллахад шаардагдах зохицуулалтыг тодорхойлохоос гадна талуудын гол үүрэг хариуцлага, урьдчилан таамаглах үйл ажиллагааг зохицуулах, харилцан мэдээлэл солилцох талаар зохицуулна.

Төсвийн хариуцлагын алба нь эдийн засгийн төсөөллийг боловсруулахад макро эдийн засгийн тусгай загвар ашигладаг бөгөөд түүнийг Төрийн Сангийн Хороо ч хэрэглэдэг.

## 4. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

БНСУ-ын Үндэсний Ассамблейн Төсвийн алба /National Assembly Budget Office/ (NABO) нь Үндэсний Ассамблейн тухай хууль болон Үндэсний Ассамблейн Төсвийн албаны хуулийн дагуу 2003 онд байгуулагджээ. Үндэсний Ассамблейн Төсвийн алба нь Үндэсний Ассамблейн даргын шууд удирдлага дор ажилладаг байна.

*Зураг 3. Үндэсний Ассамблейн даргын удирдлага доорх албадууд*




НАБО нь улсын төсөв, санхүү, төсвийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар судалгаа, дүн шинжилгээ хийж, үнэлэх, дүгнэх замаар Үндэсний Ассамблейд дэмжлэг үзүүлэх ерөнхий чиг үүрэгтэй. Төсвийн албаны мэргэжилтнүүд болон шинжээчид бие даасан, хараат бус, хөндлөнгийн судалгаа, шинжилгээгээр хангадаг. Төсвийн алба нь ерөнхийдөө судалгааны ажил ба тайлан, захиалгат судалгаа/customer service гэсэн 2 төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангаж ажилладаг. Үндэсний Ассамблейн Төсвийн албаны бүтцийг Зураг 2-оос харна уу.

Үндэсний Ассамблейн тухай хуулийн[88] 22-2 дугаар зүйлээр Үндэсний Ассамблейн Төсвийн албаны эрх зүйн үндсийг дараах байдлаар тогтоож өгсөн байна.

1. Төрийн санхүү болон сангийн менежмент, төсвийн зохицуулалттай холбоотой асуудлыг судлан шинжлэх, үнэлэх, дүгнэх түүнчлэн парламентын үйл ажиллагааг дэмжих зорилготой Үндэсний Ассамблейн төсвийн албыг байгуулна.
2. Үндэсний Ассамблейн Төсвийн алба нь нэг дарга, шаардлагатай бусад албан хаагчидтай байна.
3. Төсвийн албаны даргыг Үндэсний Ассамблейн Удирдах хороо(House Steering Committee)-ны зөвшөөрөлтэйгээр Үндэсний Ассамблейн тэргүүн томилж, чөлөөлнө.
4. Энэ хуульд өөрөөр заагаагүй бол Үндэсний Ассамблейн Төсвийн албатай холбоотой шаардлагатай бусад асуудлыг тусдаа хуулиар зохицуулна гэж заажээ.

БНСУ-ын Үндэсний Ассамблейн Төсвийн албаны үйл ажиллагаа 11 зүйл бүхий бие даасан хуулиар зохицуулж байна.

**Үндэсний Ассамблейн Төсвийн албаны хууль[89]-иас**

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Тус хуулийн зорилт нь Үндэсний Ассамблейн төсвийн алба, түүний чиг үүрэг болон холбогдох бусад асуудлыг тогтооход оршино.

2 дугаар зүйл. Эрх зүйн байдал
Үндэсний Ассамблейн Төсвийн алба нь (цаашид төсвийн алба гэх) Үндэсний Ассамблейн тэргүүний дор үйл ажиллагаагаа хэрэгжүүлнэ. Төсвийн алба нь эрх зүйн байдлын хувьд бие даасан байна.

3 дугаар зүйл. Чиг үүрэг
Төсвийн алба нь төрийн сангуудын удирдлага, төсвийн тайлан, тооцоотой холбогдох дор дурдсан чиг үүргийг гүйцэтгэнэ.
- Төсвийн тайлан, төрийн сангуудыг эрхлэн явуулахтай холбогдох төсөл, төсвийн тооцоололтой холбогдох асуудлаар судалгаа, шинжилгээ хийх;
- Төсвийн болон төрийн сангуудын зардалтай холбогдох асуудлаар болон өртөгтэй холбогдох тооцоолол гаргах;
- Макро эдийн засгийн хандлага болон төрийн санхүүтэй холбогдох асуудлаар судалгаа, шинжилгээ хийх;

[88] National Assembly act, http://korea.nabo.go.kr/assets/Files/1000000160E1.PDF
[89] National Assembly Budget Office Act, http://korea.nabo.go.kr/assets/Files/NABO_ACT.pdf

- Үндэсний хэмжээний чухал төсөл, хөтөлбөр, дунд болон урт хугацааны санхүүгийн нөхцөл байдлын талаар шинжлэх, үнэлэх;
- Зөвлөл болон Үндэсний Ассамблейн гишүүдээс шаардсан аливаа асуудлаар судалгаа, шинжилгээ хийж, гүйцэтгэх.

4 дүгээр зүйл. Тэргүүн
Төсвийн албаны дарга нь төрийн улс төрийн албан хаагчид хамаарах ба дэд сайдтай адил хэмжээний цалин хангамжтай байна гэж заажээ.
Төсвийн албаны дарга нь албан үүргээ гүйцэтгэхдээ туршлагатай бөгөөд асуудалд төвийг сахисан байр сууринаас хандах үүрэгтэй.
Дарга нь Үндэсний Ассамблейн тэргүүний тушаалаар томилсон Төсвийн албаны төрийн албан хаагчдын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах, үйл ажиллагааг нь удирдах чиг үүрэгтэй.

5 дугаар зүйл. Зөвлөх хороо
- Үндэсний Ассамблейн тухай хуулийн 22-2,3-т заасны дагуу Үндэсний Ассамблейн тэргүүн нь Төсвийн албаны даргыг томилохдоо эхлээд Зөвлөх хорооноос санал болгосон хүнийг авч хэлэлцэнэ.
- Зөвлөх хорооны гишүүд нь төсвийн албаны чиг үүрэгтэй холбогдох асуудлаар туршлагатай, улс төрийн хувьд төвийг сахисан байх ба Үндэсний Ассамблейн гишүүн болон Үндэсний Ассамблейн ажлын албаны албан хаагч бус этгээд байна.
- Зөвлөх хорооны үйл ажиллагаа, бүрэлдэхүүнтэй холбоотой асуудлыг журмаар зохицуулна.

6 дугаар зүйл. Томилгоо
Төсвийн албаны 5 болон түүнээс дээш зэрэглэл(grade) бүхий төрийн албан хаагчдыг Үндэсний Ассамблейн тэргүүн томилж, чөлөөлнө. Тэргүүн нь эрх мэдлийнхээ зарим хэсгийг журмын дагуу шилжүүлсэн тохиолдолд бусад албан хаагчдыг төсвийн албаны дарга томилж, чөлөөлж болно.

7 дугаар зүйл. Бүтэц
- Төсвийн албаны туслах байгууллага нь дэд тэргүүн, ерөнхий захирал болон захиралтай байна. Дээрх албан тушаалын нэрсийг дүрмийн дагуу өөрөөр тогтоож болно.
- Төсвийн албаны даргын дор дэд дарга ерөнхий захирал ажиллах ба мөн дэд захирлууд тэдгээрийн үйл ажиллагаанд шууд дэмжлэг үзүүлэх зорилгоор ажиллахыг зөвшөөрнө. Төсвийн албаны даргын харьяанд үндсэн бүтцэд хамаарахгүй ажлын хэсгийг байгуулан ажиллуулж болно.
- Төсвийн албаны даргын дэргэд зөвлөх чиг үүрэг бүхий зөвлөл ажиллаж болно. Төсвийн албаны бүтэц, бүрэлдэхүүнийг журмаар тогтооно. Албаны нэгжийн чиг үүрэг тэдгээрийг байгуулах болон дэд захирлуудтай холбогдох асуудлыг Төсвийн албаны дарга өөрөө тодорхойлно.

8 дугаар зүйл. Хороод болон Үндэсний Ассамблейн гишүүдэд материал танилцуулах.
Төсвийн албаны дарга нь албан үүргээ гүйцэтгэхдээ Хороо болон Үндэсний Ассамблейн гишүүдийн хүсэлтийн дагуу тэдэнд шаардлагатай материалыг танилцуулах үүрэгтэй.

9 дүгээр зүйл. Тайлан
Төсвийн албаны дарга болон бусад албан хаагчид нь Үндэсний Ассамблейн хороод болон гишүүдийн хүсэлтийн дагуу судалгаа, тайлан ба холбогдох тайлбарыг хороодод гаргаж өгнө. Албаны дарга нь албан үүргээ гүйцэтгэх явцад холбогдох төрийн байгууллага болон тэдгээрийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой хууль дүрэмд оруулбал зохих өөрчлөлт, хууль бус асуудлын талаар Үндэсний Ассамблейн төсөв, санхүүгийн болон бусад хариуцсан хороодод мэдээлэл, илтгэл хүргүүлэх үүрэгтэй.

10 дугаар зүйл.
Төсвийн албаны дарга нь албан үүрэгтэй холбоотой асуудлаар албан үүргээ

гүйцэтгэхэд шаардлагатай байгаа баримт мэдээллийг холбогдох төрийн байгууллагуудаас Үндэсний Ассамблейн тэргүүний зөвшөөрлөөр авах, танилцах эрхтэй байна. Төрийн байгууллагууд нь тухайн мэдээллийг нууцлах онцгой шалтгаангүй бол гаргаж өгөх үүрэгтэй.

11 дүгээр зүйл.
Энэ хууль болон холбогдох журамд заасан, мөн энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад асуудлуудыг Үндэсний Ассамблейн тэргүүн холбогдох хороотой зөвшилцөн тохиролцоно.

**НАБО-гийн үйл ажиллагааны талаар[90]:**

*<u>Зөвлөл, хяналт, үнэлгээ:</u>* НАБО нь төрийн алба, хэвлэл мэдээлэл, судалгаа, шинжилгээний байгууллага, их, дээд сургуулиудаас бүрдүүлсэн санхүү, эдийн засгийн чиглэлээр өндөр туршлагатай 15 гишүүн бүхий зөвлөхүүдийн зөвлөлтэй. Зөвлөлийн гишүүдийг 2 жилийн хугацаагаар томилдог ба зөвлөлийн гол чиг үүрэг нь НАБО-ийн тэргүүнд чиг үүрэг, бусад холбогдолтой асуудлаар зөвлөх үүрэгтэй.

НАБО жил тутам өөрийн дотоод үйл ажиллагаанд аудит явуулдаг ба Үндэсний ассамблейн удирдах хорооноос түүний үйл ажиллагаанд хяналт, шалгалт явуулж болно. Мөн хууль тогтоох байгууллагын төсөв батлахтай холбогдуулан Үндэсний Ассамблей болон түүний Төсөв санхүүгийн тусгай хорооноос НАБО-ийн төсвийн үйл ажиллагаа, үр дүнд хяналт, шалгалт явуулах эрхтэй байдаг байна. Мөн Аудит хяналтын зөвлөлөөс жил тутам НАБО-д аудит хийдэг.

НАБО байгуулагдсанаас хойших 10 жилийн хугацаанд түүний үйл ажиллагаа болоод нэр хүнд асар нэмэгдэж, үйл ажиллагааны үр дүн, тайлан, илтгэлийг өргөнөөр ашиглах болсон.

*<u>Ажлын хөтөлбөрүүд:</u>* Төсвийн алба нь жилийн ажлын төлөвлөгөөгөө өөрийн нэгжүүдийн ажлын ачаалал болон төлөвлөгдсөн ажил зэргийг харгалзан боловсруулдаг бөгөөд боловсруулсны дараа Үндэсний Ассамблейн даргад танилцуулж, түүний зөвлөгөө, санал зэргийг тусган батлуулдаг байна. Практикт ажлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах явдал маш бага байдаг байна.

Хэдийгээр хуулиар тусгайлан тогтоож өгөөгүй боловч НАБО жил бүрийн төсөв хэлэлцэх үеэр болон дунд хугацааны санхүүгийн хөтөлбөрүүд хэлэлцэхтэй холбогдон төсөвтэй холбогдох асуудлаар Парламентын хороодод олон тооны тайлан мэдээ гаргаж өгдөг. Жил тутам үндсэндээ Үндэсний Ассамблейд зориулан бусад олон тооны тайлан, мэдээллүүдийг боловсруулдаг. Мөн зарим хууль тогтоомжтой холбогдох санхүүгийн тооцоолол гарган, тухайн шинээр батлагдах хууль тогтоомжтой холбогдон шинээр гарч ирэх 5 жилд шаардагдах ачаалал, төсөвт нөлөөлөх нөлөөллийг үнэлж үздэг байна. Жил бүр төрийн тусгай бодлого, хөтөлбөрийн үнэлгээг хийхтэй холбоотой өөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулдаг байна.

Үндэсний Ассамблейн хороод болон гишүүд төсөвтэй холбогдох асуудлаар судалгаа гүйцэтгүүлэх хүсэлт гаргаж болно. Тухайн хүсэлтэд дурдсан асуудал нь хэтэрхий улс төрийн шинжтэй эсхүл, төсөвт үзүүлэх нөлөө хэтэрхий бага эсэхийг үл харгалзан хүсэлтийг хүлээн авдаг.

Гэхдээ хороодоос ирүүлсэн хүсэлт нь илүү өндөр ач холбогдолтой шалтгаанаар хувь гишүүдээс ирүүлсэн хүсэлттэй холбогдох асуудлыг урт хугацаанд хойш нь тавьж болох ба, ялангуяа төсөв хэлэлцэх үеэр хувь гишүүдээс ирүүлсэн хүсэлтийг хүлээн авах боломжгүй байдаг. НАБО өөрийн санаачилгаар төсөвтэй холбогдох ямар ч төрлийн судалгаа, шинжилгээ хийх эрхтэй боловч практикт Үндэсний Ассамблейгаас ирүүлсэн судалгаа, шинжилгээний ажлууд түүний ихэнх хувийг эзэлдэг.

*<u>Ил тод байдал:</u>* Жил бүрийн тогтмол хийгддэг судалгааны тайланг цаасан болон цахим хэлбэрээр өөрийн цахим хуудсанд нээлттэйгээр байршуулдаг. Гол үйлчлүүлэгч

[90] Principles for independent fiscal institutions and case studies, OECD.

болох Үндэсний Ассамблейн Санхүү эдийн засгийн хороо болон төсөв санхүүгийн тусгай хороод тухайн мэдээллүүдийг ашиглах нь олонтаа байдаг. Гол чухал тайлангуудыг англи хэл дээр орчуулан мөн тавьдаг. НАБО жилд 100 гаруй төсвийн судалгаа, шинжилгээний тайланг хэвлэн гаргадаг. Нэмж хэлэхэд жил бүр Үндэсний Ассамблейгаар хэлэлцсэн 400-500 орчим асуудлын санхүүгийн тооцоолол, гишүүдээс гаргасан татвартай холбогдох 200 орчим тооцооллыг бэлтгэдэг байна. Эдгээр тооцооллыг олон нийтэд нэн даруй нээлттэй болгодоггүй бөгөөд асуудал хэлэлцсэнээс хойш 25 хоногийн дараа тухайн илтгэлийг хэвлэх талаар зөвшөөрөл хүсдэг байна. Энэ хүсэлтийг Үндэсний Ассамблейн холбогдох хороо хүлээн авч хариу өгдөг. Мөн жилд гишүүдээс гаргасан 1000 гаруй хүсэлттэй холбогдох тооцоолол, судалгаа, шинжилгээг хариуцан гүйцэтгэдэг. Эдгээр судалгааны материалуудыг хэвлэн нийтлэхгүй бөгөөд судалгаа гаргуулсан гишүүд түүнийг нууцлахыг илүүтэйгээр үздэг байна.

НАБО хэвлэл мэдээллийн байгууллагатай харилцах тухайлсан хэвлэлийн төлөөлөгчгүй бөгөөд харин хэвлэл мэдээлэлд нийтлэгдсэн НАБО-ийн мэдээллийн давтамжид хяналт тавих үүрэг бүхий албан хаагчтай байна. НАБО-гийн зүгээс хэвлэл мэдээлэлд мэдээлэл, ярилцлага өгч болох боловч парламент гишүүдийн зүгээс биечлэн хэвлэл мэдээлэлтэй харилцах сонирхолтой байдаг. Энэ тохиолдолд НАБО хэвлэгдээгүй тайлан мэдээ, судалгаатай холбогдох материалаар хангах үүрэгтэй байна. Сүүлийн жилүүдэд НАБО төсвийн асуудлаар нээлттэй олон нийтийн бага хурлууд зохион байгуулж байна.

*Албан хаагчид:* Үндэсний Ассамблей нь өөрийн бие даасан шалгуур бүхий цалингийн сүлжээтэй парламентын үйлчилгээний албатай байдаг. НАБО-гийн албан хаагчид нь гэрээт болон ажилчдын ихэнх хувь нь дээрх парламентын үйлчилгээний албанд хамаардаг байна. Хуульд зааснаар 5 болон түүнээс дээш зэрэглэлийн албан хаагчдыг парламентын дарга бусад албан хаагчдыг НАБО-гийн дарга томилж, чөлөөлдөг. Дунд шатны албан хаагчдын хувьд туршлага эрдмийн зэрэг, цол, бүтээл зэргийг голлон анхаарч нээлттэй өрсөлдөөн зарлан сонгодог байна.

Мэргэжлийн албан тушаалуудад докторын зэрэг холбогдох мэргэжлийн туршлага зэрэг шалгуур тавьдаг байна. 2015 оны байдлаар 138 албан хаагчтайгаар дэлхийн 2 дахь том төсвийн судалгааны албанд тооцогдсон байна. АНУ нэгд орж байна. Бүтцийн хувьд НАБО 4 хэлтэстэй. Үүнд:

- Төсвийн шинжилгээний хэлтэс 51 ажилтантай;
- Эдийн засгийн судалгааны хэлтэс 34;
- Хөтөлбөр үнэлгээний хэлтэс 30;
- Төлөвлөлт, менежментийн хэлтэс 20.

Мөн өөрийн үйл ажиллагаанд бүтцийн бус зөвлөхүүдийг олноор татан оролцуулдаг байна.

*Мэдээлэл авах эрх:* Хуульд зааснаар НАБО албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг Үндэсний Ассамблейн даргын зөвшөөрлөөр төрийн байгууллагуудаас шаардаж авах эрхтэй. Тухайн хүсэлтийг хүлээн авсан төрийн байгуулагууд үндэсний аюулгүй байдалтай хамааралтай гэх мэт тусгай шалтгаангүй бол гарган өгөх үүрэгтэй байна.

*Зураг 4. БНСУ-ын Үндэсний Ассамблейн Төсвийн албаны бүтэц*[91]




[91] http://korea.nabo.go.kr/eng/01_about/organization.page

## 5. ШВЕДИЙН ВАНТ УЛС

Шведийн Төсвийн бодлогын зөвлөл (Swedish Fiscal Policy Council)-ийн талаарх товч мэдээлэл:

- 2007 онд байгуулагдсан;
- Засгийн газрын агентлаг;
- Орон тооны бус 6 гишүүн;
- 5 хүний бүрэлдэхүүн бүхий Тамгын газар;
- Жилийн төсөв нь ойролцоогоор 9 сая швед крон;
- Засгийн газраас хараат бусаар ажилладаг;
- Төсвийн бодлогын зөвлөлийн зөвлөмж, журмаар зохицуулдаг.

2002 онд *European Monetary Union* дахь Тогтворжилтын бодлогын комиссоос тус улсад бие даасан төсвийн бодлогын зөвлөлийг байгуулахыг санал болгосны үндсэн дээр байгуулсан. Төсвийн бодлогын зөвлөл нь төсвийн шинэчлэлийн өргөн хүрээтэй бүрэлдэхүүн хэсэг биш боловч эдийн засаг, санхүүгийн хямрал гүнзгийрч эхэлсэн 1990-ээд онд шинээр байгуулагдсан институцийг боловсронгуй болгох, бэхжүүлэх зорилготой байсан. Энэхүү шинэчлэлийн үр дүнд гүйцэтгэх засаглал болон хууль тогтоох байгууллага төсвийн дээд хэмжээг багасгаж, төсвийн шинэ тогтолцоог нэвтрүүлсэн. 2006 оны сонгуулийн дараа шинэ Засгийн газар 2007 онд Шведийн Төсвийн бодлогын зөвлөл (FPC)-ийг байгуулсан. Зөвлөлийн бүхий л үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй байдаг.

**Зөвлөлийн эрх зүйн байдал, бүрэлдэхүүн, бүрэн эрх**

Төсвийн бодлогын зөвлөлийн журмыг 2007 оны 11 сарын 1-д баталсан бөгөөд 2011 оны 4 дүгээр сарын 28-д шинэчлэн баталсан. Шинэ журмаар зөвлөл 8 гишүүнтэй байсныг 6 гишүүнтэй болгосон. 5 хүний бүрэлдэхүүнтэй Тамгын газар нь нэг дарга, 2 эдийн засагч, 2 туслах ажилтны бүрэлдэхүүнтэй.

Зөвлөлийн гишүүнээр томилогдох хүнд тодорхой хязгаарлалт тавьдаггүй боловч эдийн засгийн бодлогын болоод практик туршлагатай, жендерийн тэнцвэртэй байдлыг хадгалахыг эрмэлздэг. Зөвлөлийн гишүүнээр гадаадын иргэн томилогдож болно. Зөвлөлийн гишүүнд Засгийн газраас санал болгосон хүнийг заавал томилох албагүй бөгөөд зөвлөлийн зөвлөмжийн дагуу томилдог нь Зөвлөлийн хараат бус байдлыг хамгаалах нэг онцлог механизм гэж үздэг. 2011 оны шинэ журмаар агентлагийн дарга нь Тамгын газрын дарга бөгөөд Засгийн газраас томилогддог. Тамгын газрын дарга нь ажилтнуудыг томилох, чөлөөлөх зэрэг Тамгын газрын өдөр тутмын ажлыг удирддаг. Тамгын газрын дарга нь төсвийн асуудлаар хариуцлага хүлээдэг бол Зөвлөл нь жилийн тайлан болон түүнтэй холбоотой асуудлыг хариуцдаг.

Зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Үүнд:

1. Төсвийн бодлого нь зорилгоо биелүүлэх эсэхийг үнэлэх:
   - Төсвийн санхүүжилтийн урт хугацааны тогтвортой байдалтай уялдаж байгаа эсэх;
   - Төсвийн зорилт, ялангуяа нэмэлт зорилт зардлын дээд хязгаарт нийцэж байгаа эсэх.
2. Эдийн засаг дахь мөчлөгтэй холбоотой төсвийн бодлогын байр суурийг үнэлэх;
3. Төсвийн бодлого нь урт хугацааны эрүүл тогтвортой өсөлттэй уялдаж байгаа эсэхийг үнэлэх, урт хугацааны тогтвортой ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх эсэхийг үнэлэх;
4. Засгийн газрын төсвийн төслүүдийн ил тод байдал болон бодлогын олон төрлийн арга хэмжээнүүдийн талаарх урамшууллын хяналтыг хянах.
5. Нийгмийн халамжийн хуваарилалтын төсвийн бодлогын үр нөлөөг судлах.
6. Эдийн засгийн бодлогын талаар олон нийтийн хэлэлцүүлэг хийх.

2011 оны 6 дугаар сард Зөвлөлийн дүрэмд өөрчлөлт оруулсан бөгөөд өөрчлөлтөөр Зөвлөл нь Засгийн газрын эдийн засгийн бодлого болон түүний үр нөлөө, төсвийн ил тод байдал болон тогтвортой байдлыг үнэлэх эрхтэй болсон. Зөвлөлийн журамд зөвлөлийн ажлын хязгаарлалтыг нарийвчлан зааж өгөөгүй.

Зөвлөл нь жил бүрийн 5 дугаар сарын 10-наас хэтрэхгүйгээр Шведийн төсвийн бодлогын тайланг гаргаж Засгийн газарт танилцуулдаг. Гэхдээ Европын парламентын сонгууль болох жилүүдэд 5 сарын 10-ны дотор өгөх ёстой. Зөвлөл нь хийсэн дүн шинжилгээ, үнэлгээгээ тайланд тусгах бөгөөд хэрэв санал зөрсөн бол энэ талаар тайландаа тусгах ёстой.

**Зөвлөлийн нөлөө, ил тод байдал**

Зөвлөлийн тайлангууд нь Швед болон англи хэл дээр байгууллагын вэбсайт, хэвлэмэл хэлбэрээр нийтэд нээлттэй байдаг. Зөвлөл нь жил бүрийн тайлангаа 5 дугаар сард танилцуулж хэвлэлийн бага хурал хийдэг. Парламентын илтгэл, хэлэлцүүлгийн талаар цахимаар болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн хүрээтэй нэвтрүүлдэг.

Төсвийн төслийг хэлэлцэхдээ парламент төсвийн төслийн талаар Төсвийн бодлогын зөвлөлийн гаргасан тайланг хэрхэн авч үзэх талаар журамд нарийвчлан заагаагүй.

Зөвлөл нь Сангийн яаманд ажлаа хариуцан тайлагнадаг төрийн байгууллага юм. Зөвлөл нь Riksdag (Шведийн парламент) эсвэл төрийн бодлогод хяналт тавих бусад байгууллага, тухайлбал Үндэсний аудитын газар болон Төв банктай албан ёсны харилцаатай ажилладаггүй. Зөвлөл нь тайлан хэвлэгдсэний дараа Парламентын санхүүгийн хороотой хамтран олон нийтийн хэлэлцүүлэг хийдэг.

*Зураг 5. Шведийн төсвийн хяналтын тогтолцоо*[92]




## 6. ФИНЛАНД УЛС

Финландын Үндэсний Аудитын газар - Төсвийн бодлогын үнэлгээ /National Audit Office of Finland – Fiscal Policy Evaluation/-ий талаарх товч мэдээлэл:

- Финландын Үндэсний Аудитын газрын Төсвийн бодлогын үнэлгээний хэлтэс 2013 онд байгуулагдсан;
- Гүйцэтгэх захирал болон 4 хүний бүрэлдэхүүнтэй. Хэлтсийн бүх албан тушаалтан төрийн албан хаагч;
- Жилийн төсөв - 0.7 сая евро;
- Үйл ажиллагаа нь хараат бус бөгөөд парламентад ажлаа тайлагнадаг;

[92] https://www.oecd.org/gov/budgeting/49778630.pdf The Swedish Fiscal Policy Council

- Финландын Үндсэн хууль, Үндэсний Аудитын газрын тухай хууль, Европын холбооны хэлэлцээр, дүрэм журмууд болон бусад холбогдох дүрэм журмуудыг удирдлага болгон ажилладаг.

**Ерөнхий мэдээлэл:**

Финландын Үндэсний аудитын газар нь төрийн санхүүгийн удирдлага нь төсвийн бодлого, дүрэм журмуудад нийцэж байгаа эсэхийг хянадаг парламентын хараат бус байгууллага юм. Түүнчлэн улс төрийн нам, сонгуулийн сурталчилгааны санхүүжилтийг хянадаг. Финландын Үндэсний аудитын газар нь нэр хүндтэй, урт хугацаанд үйл ажиллагаа явуулж буй институт боловч төсвийн бодлогын үнэлгээний хэлтэс нь шинэ чиг үүрэг юм.

2013 оны 1 дүгээр сард Финландын Үндсэн хууль, Үндэсний аудитын газрын хууль болон эдийн засаг, мөнгөний холбооны хэлэлцээрийн */Act on the Implementation and Application of the Provisions of the Treaty on Stability, Co-ordination and Governance in the Economic and Monetary Union and on the Requirements of the Frameworks of Public Finances/* заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Финландын үндэсний аудитын газарт 4 хүний бүрэлдэхүүнтэй Төсвийн бодлогын үнэлгээний хэлтсийг байгуулсан бөгөөд Финландын төсөвт бие даасан хараат бус хяналт, үнэлгээ хийх чиг үүрэгтэй. Тус газрыг Ерөнхий аудиторын орлогч тэргүүлдэг. Ажлаа Финландын парламентад хариуцан тайлагнадаг.

Европын холбооны гишүүн, евро бүсэд хамаардаг улсын хувьд Финланд нь Европын тогтвортой байдал ба өсөлтийн гэрээний санхүүгийн журамд заасан тогтвортой байдлын хөтөлбөрүүдэд суурилсан дунд хугацааны зорилтуудыг баталсан. Финланд Улс нь 1990 оны эхэн үеэс төсвийн үндэсний зохицуулалтын тогтолцоог бүрдүүлсэн бөгөөд хамгийн ач холбогдолтой нь “зарлагын тааз” буюу зарлагад хязгаар тогтоох явдал /spending limit/ юм. Зарлагын хязгаарын систем нь 2002 оны Финландын төсвийн талаар гаргасан Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын шүүмжийн дагуу 2003 онд шинэчилсэн. 2006 оны Сангийн сайд дахин шинэчлэх талаар судлах ажлын хэсэг байгуулсан бөгөөд тус ажлын хэсэг нь Шведийн Үндэсний эдийн засгийн судалгааны хүрээлэн, Данийн эдийн засгийн зөвлөл болон Бельгийн санхүүгийн дээд зөвлөлийн туршлагыг судалж зарлагын хязгаарын хэрэгжилтийн талаар бие даасан үнэлгээ хийхийг санал болгосон.

| Greece | Parliamentary Budget Office | 6 | 4 quarterly fiscal reports, 2 reports on the annual State Budget. |
| Hungary | Fiscal Council (established 2011) | 4 | A biannual publication on the state of national economics and a further biannual publication on the national budget (before it is submitted to the Parliament and before its final vote). Note that the first publication on the national budget is specified in legislation as optional. |
| Iceland | Icelandic Fiscal Council | 1 | Produce an assessment of the annual 5-year fiscal plan in April each year, and an extra report is published upon a new government being elected (on their fiscal strategy). |
| Ireland | Irish Fiscal Advisory Council (IFAC) | 2 | Assessments of official forecasts twice a year. |
| Italy | Parliamentary Budget Office (PBO) | 0 | The mandate specifies a number of analyses, audits and assessments that the Italian PBO should undertake, but does not identify specific reports. |
| Korea | National Assembly Budget Office (NABO) | 0 | The mandate specifies a number of functions for NABO, but does not identify specific reports. |
| Latvia | Fiscal Discipline Council | 4 | A Surveillance report analysing the draft budgetary plan, two reports on macroeconomic forecasts and one ex-post assessment report. |
| Luxembourg | National Council of Public Finances (CNFP) | 2 | Assessments of official forecasts twice a year. |
| Mexico | Center for Public Finance Studies (CEFP) | 5 | Analysis of the government's quarterly reports on the state of the economy and analysis of the report on the National Development Plan. |
| Netherlands | Netherlands Bureau for Economic Policy Analysis (CPB) | 1 | Annual Central Economic Plan. |

| | | | |
|---|---|---|---|
| Portugal | Portuguese Public Finance Council (CFP) | 4 | Report on the Stability and Growth Programme, the Multiannual Framework of Budgetary Programming, The Proposed State Budget, Report on the Proposal for the State of Orcamento. |
| Slovak Republic | Council for Budget Responsibility (CBR) | 2 | Report on sustainability, report evaluating the implementation of the fiscal rules and fiscal transparency rules established in the law. |
| Slovenia | Slovenian Fiscal Council | 4 | Assessment of the Stability Programme, Assessment of the Draft Budgetary Plan, Execution of the Budget in the Previous Year and Report on Fiscal Council Operations. |
| Spain | Independent Authority of Fiscal Responsibility (AIReF) | 10 | Report on macroeconomic forecasts, Report on the methodology to calculate trend patterns of income and expenditure and the growth reference rate, Report on the draft Stability Programme, Reports on the analysis of budget implementation, public debt and debt-ceiling rule, Reports on the determination of individual objectives for autonomous regions, Report on economic-financial and re-balancing plans for the central administration and the autonomous regions, Report on the projects and main aspects of the budgets of public administrations, Report on the application of correction mechanisms foreseen in Organic Law 2/2012 of 27 April on Budgetary Stability and Financial Sustainability, Report on the occurrence of the exceptional circumstances referred to in Article 11.3 of Organic Law 2/2012, of 27 April, on Budgetary Stability and Financial Sustainability, and an annual opinion on the determination of the pension revaluation index. |
| Sweden | Swedish Fiscal Policy Council (FPC) | 1 | A report to government containing its analyses and assessments by 15 May each year. |
| UK | Office for Budget Responsibility (OBR) | 4 | Economic and fiscal forecasts and an assessment of the extent to which the fiscal mandate has been met (twice a year), Forecast Evaluation, Long Term Sustainability of Public Finances. |
| US | Congressional Budget Office (CBO) | 1 | One annual report including a discussion of national budget priorities and alternative ways of allocating budget spending among major programmes or functional categories. |

Footnotes: In **Austria**, the PBO does not have enabling legislation. In **Latvia**, the Fiscal Discipline Council is mandated to provide two reports (on macroeconomic forecasts) through its legislation and two reports through its MoU with the Ministry of Finance.

# НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН БУЦААН ОЛГОЛТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

(Харьцуулсан судалгаа)

*Г.Билгээ, И.Жаргалзаяабямба,*
*Ц.Элбэгзаяа*

**АГУУЛГА**

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН БУЦААН ОЛГОЛТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

- НӨАТ-ын талаарх дэлхийн чиг хандлага
- НӨАТ-ын эдийн засгийн өсөлтөд үзүүлж буй нөлөө

1. БНХАУ
2. ТАЙВАНЬ
3. ЕВРОПЫН ХОЛБОО
    3.1.Финланд
    3.2.Нидерланд
4. ОХУ

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

“Гадаадын зарим орны нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын талаарх зохицуулалт” судалгааны хүрээнд БНХАУ, Тайвань, ОХУ, Финланд, Нидерланд улс олон Европын холбооны нэмэгдсэн өртгийн албан татвар, түүний буцаан олголтын талаарх эрх зүйн зохицуулалтыг авч үзэв.

***Нэмэгдсэн өртгийн албан татвар***

Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) нь дэлхий даяар түргэн хугацаанд нэвтэрсэн бөгөөд одоогийн байдлаар дэлхийн 140 гаруй оронд хэрэгжиж байна. Дэлхийн улс орнуудын НӨАТ-ын дундаж хувь хэмжээг үзэхэд Азийн орнуудад бага буюу 12,3 хувьтай, Европын улсуудад харьцангуй өндөр буюу 20 хувьтай байна.

Судалгаанд хамрагдсан орнуудын хувьд НӨАТ-ын эрх зүйн орчинд өөрчлөлт оруулсан нийтлэг хандлага ажиглагдаж байх бөгөөд ингэхдээ НӨАТ-ын хувь хэмжээг өөрчлөн тогтоох, татварын цахим бүртгэлийн систем нэвтрүүлэх, татвар хураалтад хяналт тавих зэрэгт гол анхаарлаа хандуулсан байна.

Судалгаанд хамруулсан улс орнуудын хувьд НӨАТ-ын олон шатлалт хувилбарыг хэрэгжүүлж байна. Тухайлбал:

- БНХАУ-д -3-13 хувь;
- Тайваньд -0,1-25 хувь;
- ОХУ-д - 10-18 хувь;
- Финландад -10-24 хувь;
- Нидерландад -6-19 хувьтай байна.

НӨАТ-ын хөнгөлөлтийг эм, эмнэлгийн хэрэгсэл, тогтмол хэвлэл, ашгийн бус үйл ажиллагаанд нийтлэг байдлаар хэрэгжүүлж байна. БНХАУ-д жижиг бизнес эрхлэгчид, жижиг татвар төлөгчдөд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2018-2020 онд 20000-30000 юаны борлуулалт бүхий татвар төлөгчдийг НӨАТ-аас чөлөөлж байгаа бол Тайваньд ХАА-н бөөний зах зээлд оролцогч ХАА-н бүтээгдэхүүнийг борлуулдаг жижиг ААН-ийн төлөөлөгчдөд 0.1 хувийн НӨАТ-ын татвар авч байна. Харин Финландад Аланд арлын бүс нутаг НӨАТ-аас чөлөөлөгддөг байна.

***НӨАТ-ын буцаан олголтын онцлог зохицуулалтууд***

НӨАТ-ын эдийн засагт үзүүлж буй үр нөлөөг бууруулахгүй байх зорилгоор татвараас зайлсхийх явдлыг багасгах, далд эдийн засгийг хумих, татварын бааз суурийг нэмэгдүүлэх болон төсвийн орлогыг нэмэгдүүлэх үүднээс **НӨАТ-ын буцаан олголтыг** улс орнууд хэрэглэж ирсэн.

Европын холбоо (ЕХ)-ны гишүүн улсуудад бүртгэлтэй татвар төлөгч нь НӨАТ-ын буцаан олголтыг гишүүн аль ч орноос нэхэмжилж авах боломжтой болсон.

Финландад тухайн татварын жилд нэхэмжилж болох буцаан олголт ногдох борлуулалтын хэмжээ нь 400 евро, харин санхүүгийн сүүлийн улирлын тухайд нэхэмжилж болох буцаан олголт ногдох хэмжээ нь 50 еврогоос багагүй байхаар тогтоосон байна.

Нидерландад НӨАТ-ын буцаан олгох үйл явц нь татвар төлөгчөөс хамаарч байна. Тухайлбал, мэдүүлгийн маягтыг заавал бөглөж өгөх ба хугацаанаас нь хоцроосон тохиолдолд торгууль ногдуулна. Мөн татвар төлөгч нь НӨАТ-ын буцаан олголт авах хугацаагаа (сараар, улирлаар, жилээр) өөрөө тогтоох боломжтой зэрэг онцлог зохицуулалт байна.

ОХУ-д буцаан олголтыг татвар төлөгчийн дансанд татварыг буцаан олгохоос гадна татварын өр төлбөр (албан татварын дутуу төлөлт, анз, торгууль)-ийг төлөх, эсхүл ирээдүйд төлөгдөх татварт урьдчилж авах боломжийг хуулиар олгосон байна. Харин Тайваньд татварын илүү төлөлтийг ирээдүйд төлөгдөх татварт тооцон урьдчилж авах хуулийн зохицуулалт үйлчилж байна.

***Эдийн засагт үзүүлж буй үр нөлөө***

Дэлхийн улс орнуудын чиг хандлагаас харахад шууд бус татварын тогтолцоо болох НӨАТ нь татварын орлогын 25 ба түүнээс дээш хувийг бүрдүүлж байгаа нь шууд бус татварын тогтолцоонд илт давуу байр суурь эзэлж байна.

Судалгаанаас үзэхэд, **НӨАТ-ын буцаан олголт эдийн засагт дор дурдсан үр нөлөөг үзүүлж** байна. Үүнд:

- иргэдийн оролцоог идэвхжүүлэх замаар НӨАТ төлөгчдийг татвараас зайлсхийхээс урьдчилан сэргийлэх чухал үр нөлөөтэй;
- татвараас зайлсхийх замаар нуугдан үлддэг байсан татварын орлогыг төсөвт төвлөрүүлэх;
- иж бүрэн бүртгэлийн тогтолцоог бий болгох замаар далд эдийн засгийг хумих (*эцсийн хэрэглэгч болон худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийг урамшууллын системээр хөшүүрэгдэн татвар төлөгчид болон худалдаа үйлчилгээг бүртгэлжүүлэх*);
- татварын бааз суурийг тэлэх;
- татвар төлөгчийн худалдааны эргэлтийг сайжруулах, хариуцлагыг сайжруулах;
- албан бус секторт худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн мэдээллийг бүртгэлжүүлж, татварын тохирох хувь хэмжээ тогтоож болох эсэх бодлогын шийдвэр гаргах боломж бүрдэх (*учир нь албан бус сектор дахь худалдаа, үйлчилгээ эмзэг байдаг тул бага хэмжээний татварт ч мэдрэг байж, үйл ажиллагаа нь зогсох аюултай байдаг бөгөөд энэ салбарт төрийн уян хатан бодлого шаардагддаг*) зэрэг эерэг үр нөлөө үзүүлж байна.

## СУДАЛГААНЫ ХЭСЭГ

## НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН БУЦААН ОЛГОЛТЫН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

### НӨАТ-ын талаарх дэлхийн чиг хандлага

НӨАТ нь орчин үед ашиглагдаж байгаа “эцсийн хэрэглээнд ногддог” хэрэглээний татварын 2 төрлийн нэг юм. Энэ татвар нь дэлхийн бусад улс орнуудад түгээмэл байсан үйлдвэрлэгчдийн худалдааны татвар (жишээ нь: Канад Улс), бөөний худалдааны татвар (Австрали, Шинэ Зеланд), худалдан авалтын татвар (Нидерланд), үйлдвэрлэлийн түвшний НӨАТ (БНХАУ) зэрэг шууд бус татварын 4 хувилбарыг орлон гарч ирсэн.[94]

Шууд бус татваруудын боловсронгуй бус, үр ашиггүй байдал нь НӨАТ-ыг дэлхийн даяар түргэн хугацаанд нэвтрэхэд хүргэсэн. Ялангуяа, энэ үед татварын шинэчлэлүүд ихэвчлэн бизнес эрхлэлт, бизнесийн шийдвэр гаргахад сөрөг нөлөө үзүүлдэг гүйлгээний татваруудыг өөрчилж, хүчингүй болгоход чиглэгдэж байсан. Ийнхүү нээлттэй эдийн засаг бүхий дэлхийн улс орнууд бизнесийн ашиг болон эцсийн хэрэглэгчдэд буюу хувь хүмүүсийн хэрэглээнд шууд бус татвар ногдуулдаг тогтолцоо руу тасралтгүй шилжсээр байна.

[94] НӨАТ ба хэрэглээний татварын хувилбарууд. Р.Кревер. www.iltod.gov.mn

*Зураг 1. НӨАТ-ыг нэвтрүүлсэн орнуудын статистик үзүүлэлт (1960-2000 он)*[95]




НӨАТ-ын хувь хэмжээний хувьд Азийн орнуудад дунджаар 12,3 хувь, Америк, Номхон далайн орнуудад дунджаар 13 хувь, Африкийн орнуудад 15 хувьтай байна. Харин Европын улсуудад дунджаар 20 хувьтай байгаа нь дэлхийн бусад орнонтой харьцуулахад 5 хувиар өндөр байгааг дараах зургаас харьж болно.[96]

*Зураг 2. НӨАТ-ын хувь хэмжээ (бүс нутгаар, 2015 он)*




Дэлхийн улс орнуудын чиг хандлагаас харахад шууд бус татварын тогтолцоо болох НӨАТ нь татварын орлогын 25 ба түүнээс дээш хувийг бүрдүүлж байгаа нь шууд бус татварын тогтолцоонд илт давуу байр сууръ эзэлж байна.

Судлаачдын үзэж байгаагаар НӨАТ нь гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтанд сөрөг нөлөөгүй бөгөөд экспортод 0 хувиар татвар ногдуулж, импортод үндсэн хувь хэмжээгээр ногдуулдаг зарчим нь гадаад худалдааны олон талт гэрээ, хэлэлцээр

[95] “The VAT: Its Causes and Consequences”. M.Keen and B.Lockwood. International Monetary Fund. 2017. P.14.
[96] How Many Countries in the World Have a Value-Added Tax. Kyle Pomerleau. https://taxfoundation.org

Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-ын нийтлэг зарчимд нийцдэг байна.

НӨАТ-ын буцаан олголт нь татварын урамшуулал гэсэн ойлголтод хамаардаг тул ерөнхий утгаараа тухайн орны татварын тогтолцоо, тодорхой төрлийн татвар, тодорхой нэг буюу хэд хэдэн эдийн засгийн салбарын үр нөлөөг дээшлүүлэх, дотоодын болоод гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээ гэж үздэг байна. Эдийн засгийн онол, практик талаасаа НӨАТ нь өргөн хүрээнд хэрэглээнд үндэслэсэн, жижиглэн худалдааны үе шат бүрийг хамарч чадсан тохиолдолд НӨАТ-ын буцаан олголт нь үр дүнтэй байна гэж үздэг.

НӨАТ-ын буцаан олголтыг хэрэглэснээр бүртгэл, тайлагнал сайжирч, НӨАТ-ын орлогын хэмжээ дагаж нэмэгдэх, аж ахуйн нэгж (ААН)-ийн эргэлтийн хөрөнгийн хэмжээ сайжрах боломжтой байна. Судлаачдын үзэж байгаагаар онолын хувьд буцаан олголт нь НӨАТ-ын 30-50 хувьтай байх боломжтой гэж үзэж байна. Практикт буцаан олголтын хэмжээ Африкийн орнуудад хамгийн бага, орчин үеийн татварын систем хэрэгжүүлж байгаа, эсхүл эдийн засгийн хувьд хурдацтай байгаа орнуудын хувьд хамгийн өндөр байна.

Нэгэнт НӨАТ нь эцсийн хэрэглээнд татвар ногдуулах зорилготой тул тухайн тайлант хугацааны туршид худалдан авалтад төлсөн НӨАТ нь борлуулалтад ногдсон НӨАТ-аас давсан тохиолдолд түүнийг тухай бүр нь буцаан олгож байх ёстой. НӨАТ-ын илүү төлөлтийг цаг тухайд нь олгохгүй саатуулах нь бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааны өртгийг нэмэгдүүлдэг.

Татварт төлсөн мөнгөө аливаа эх үүсвэрээр нөхөх шаардлагатай ба татвараа буцаан автлаа хөрөнгө зээлэх шаардлага ч гарч болно. НӨАТ-ын буцаан олголтыг саадгүй болгох үүднээс төсвийн зарцуулалтад зарим өөрчлөлт оруулах, хуурамч буцаан олголт олгохгүй байлгах нөхцөлийг бүрдүүлсэн үйл ажиллагааны болон хяналтын тогтолцоо чухал байдаг байна.

**НӨАТ-ын эдийн засгийн өсөлтөд үзүүлж буй нөлөө**[97]

Юуны өмнө орчин үеийн эдийн засагч, эрдэмтэд нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-ыг хүн төрөлхтний түүхэнд хамгийн өргөн тархсан төсвийн орлого бүрдүүлэх шилдэг татвар гэж үздэг байна. Гарал үүслийн хувьд 1954 онд Франц Улсад анх бараанд ногдуулан хэрэглээний татварын хэлбэрээр нэвтрүүлж эхэлсэн бөгөөд дэлхийн хоёрдугаар дайнаас хойш нийтдээ 140 гаруй улс уг татварыг нэвтрүүлсэн байна.

НӨАТ нь ихэнх улсад амжилттай хэрэгжиж байгаа бөгөөд төсвийн орлогын 18-40 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд тодорхой шалтгаанаар цөөн тооны улс орнуудад энэ татвар амжилт олоогүй туршлага байдаг. Тухайлбал, Гана Улс татварын босгыг хэт бага тогтоосноос татвар төлөгчдийг хянах, татварын орлогыг бүрдүүлэх ажиллагааны зардал татварын орлогоосоо давж байсан нь тухайн үед НӨАТ-ын татварыг зогсооход хүрч байсан байна.

Харин Япон Улсад анх "хэрэглээний татвар" нэртэйгээр тогтоосон НӨАТ нь иргэдийн амьдралд хэт дарамт учруулснаар тус татварыг хүчингүй болгосон бөгөөд 1989 онд 3 хувьтайгаар дахин тогтоож, улмаар 1997 онд 5 хувьд хүргэж амжилттайгаар нэвтрүүлсэн байна.

Европын Холбооны хувьд НӨАТ нь Засгийн газрын орлогын (төсвийн) гол эх сурвалжуудын нэг юм. 2000 оноос хойш НӨАТ-ын орлого нь ДНБ-ний 0.6 хувиар өсч, улмаар төсвийн орлогын чухал эх үүсвэрүүдийн нэг болсон.

Өөрөөр хэлбэл, НӨАТ-ыг амжилттай хэрэгжүүлж буй 130 улсын туршлагаас нэгтгэн үзэхэд НӨАТ-ын **эдийн засагт үзүүлж буй гол үр нөлөө нь төсвийн орлогыг бүрдүүлэгч гол эх үүсвэр**ийн нэг болж буй нийтлэг үр дүн харагдаж байна.

Гэвч НӨАТ-ын орлоготой холбоотойгоор тулгарч буй гол асуудлуудын нэг нь татвараас зайлсхийх явдал гэж "The influence of VAT on economic growth" судалгаанд онцолсон байна. Иймд татвараас нуусан мөнгөн хөрөнгийн эргэлт буюу далд эдийн

[97] Stefan Gabriel ets. "The influence of VAT on economic growth". 2015.

засгийг ил болгох нь НӨАТ-ын орлогын эдийн засагт үзүүлж буй үр нөлөөг бууруулахгүй байхад ач холбогдолтой гэжээ.

Татвараас зайлсхийх хоёр төрлийн арга зам байх бөгөөд энэ нь:

a) ***Хууль тогтоомжийн хүрээнд татвараас зайлсхийх, эсхүл татварыг хүчингүй болгох (цуцлах)*** – эдийн засгийн үр ашгийг хүртэхийн тулд хуулийн цоорхойг ашиглан татвараас зайлсхийх;
b) ***Хууль бусаар татвараас зайлсхийх*** – хууль зөрчин татвараас зугтах замаар эдийн засгийн үр ашгийг өөртөө авах гэсэн хоёр төрлийн арга зам байна.

Иймд татвараас зайлсхийх явдлыг бууруулах, таслан зогсоохын тулд ЕХ нь **НӨАТ-ын онолын болон бодит орлогын зөрүүг тодорхойлох** замаар татвараас зайлсхийх явдалд дүн шинжилгээ хийж байна. ЕХ-нд Румын Улсын НӨАТ-ын зөрүү хамгийн өндөр буюу **48%**-ийн зөрүүтэй гарчээ. Энэ нь 2008 оны эдийн засгийн хямралаас үүдэлтэй хэрэглээ буурсантай холбоотойгоор **татвараас зайлсхийх явдал нэмэгдсэнээс үүссэн** гэж үзжээ[98]. Өөрөөр хэлбэл, энэ нь Румын Улсын татвараас зайлсхийж буй далд эдийн засгийн үзүүлэлт юм.

Иймд НӨАТ-ын эдийн засагт үзүүлж буй үр нөлөөг бууруулахгүй байх зорилгоос үүдэн татвараас зайлсхийх явдлыг багасгах, төсвийн орлогыг нэмэгдүүлэх үүднээс татварын урамшууллын нэг төрөл болох НӨАТ-ын буцаан олголтыг улс орнууд хэрэглэж ирсэн.

**НӨАТ-ын буцаан олголтын эдийн засагт үзүүлж буй үр нөлөө нь:**

- иргэдийн оролцоог идэвхжүүлэх замаар НӨАТ төлөгчдийг татвараас зайлсхийхээс урьдчилсан сэргийлэх чухал үр нөлөөтэй;
- татвараас зайлсхийх замаар нуугдан үлддэг байсан татварын орлогыг төсөвт төвлөрүүлэх;
- иж бүрэн бүртгэлийн тогтолцоог бий болгох замаар далд эдийн засгийг хумих (*эцсийн хэрэглэгч болон худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийг урамшууллын системээр хөшүүрэгдэн татвар төлөгчдийн болон, худалдаа үйлчилгээг хувийг бүртгэлжүүлэх*);
- татварын бааз суурийг тэлэх;
- татвар төлөгчийн худалдааны эргэлтийг сайжруулах, хариуцлагажуулах;
- албан бус секторт худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн мэдээллийг бүртгэлжүүлж, татварын тохирох хувь хэмжээ тогтоож болох эсэх бодлогын шийдвэр гаргах боломж бүрдэх (*учир нь албан бус сектор дахь худалдаа, үйлчилгээ эмзэг байдаг тул бага хэмжээний татварт ч мэдрэг байж, үйл ажиллагаа нь зогсох аюултай байдаг тул энэ салбарт төрийн уян хатан бодлого шаардагддаг*) зэрэг эерэг үр нөлөө үзүүлж байна.

## 1. БНХАУ

### 1.1. НӨАТ-ын эрх зүйн зохицуулалт ба шинэчлэл

Хэдийгээр БНХАУ 1994 онд НӨАТ-ын хуулийг албан ёсоор баталсан хэдий ч, НӨАТ-ыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор нэлээд хэд хэдэн алхмуудыг шат дараалан хийж, улмаар 2016 онд НӨАТ-ыг шинэчлэх зорилгодоо хүрч, гүйлгээний татвараас НӨАТ-ын системд шилжсэн. БНХАУ-ын НӨАТ-ын тогтолцоо нь дэлхийд хамгийн нүсэр бөгөөд хамгийн хүчтэй “орлого цуглуулагч”-д тооцогддог ба улсын төсвийн орлогын хамгийн их хувийг эзэлдэг татвар юм.[99] Тухайлбал 2015 оны байдлаар татварын орлогын бүтцэд НӨАТ хамгийн их буюу 32 хувь, онцгой татвар 21 хувь, бизнесийн татвар 14 хувь, ААН-ийн орлогын албан татвар 8 хувь, хувь хүний орлогын албан татвар 6 хувь, бусад татварууд нийлээд 19 хувийг бүрдүүлж байна. Бүтцийн хувьд төдийлөн стандарт хэлбэртэй бус боловч хэрэгжилтийн түвшин нь жил ирэх тусам улам эрчимжсээр байна.

[98] Stefan Gabriel ets. “The influence of VAT on economic growth”. 2015
[99] “Нэмэгдсэн өртөгийн албан татварын буцаан олголт, гадаадын зарим орны туршлага”. УИХ-ын Тамгын газрын Судалгаа, шинжилгээний хэлтэс. 2013 он

Хятадын шууд бус татварын систем олон жилийн хугацаанд салаалсан буюу бараа бүтээгдэхүүнд, бизнесийн үйлчилгээнд нэмүү өртгийн татвар ногдуулах байдлаар явж ирсэн. Хятад Улс 2012 оноос шууд бус татварын шинэчлэлийг хийж эхэлсэн бөгөөд өөрчлөлтийг салбар салбараар, муж мужаар хэрэгжүүлж явсаар 2016 оны 5 дугаар сарын 1 гэхэд шинэчлэлийг хийж дуусгасан байна. Одоо Хятадын НӨАТ нь тухайн татварыг хэрэглэдэг дэлхийн 140 гаруй улс орноос хамгийн өргөн хүрээг хамрах болсон бөгөөд санхүү, даатгал, үл хөдлөх хөрөнгө, барилга гээд санхүүгийн бүх салбарт, тухайлбал, хүүгийн орлого, үл хөдлөх хөрөнгө шилжүүлэх зэрэгт хэрэглэх болсон байна.

НӨАТ-ын шинэчлэл урт удаан хугацааны туршид хийгдсэн боловч, бизнес эрхлэгчид маш богино хугацаанд буюу зургаан долоо хоногт эдгээр өөрчлөлтүүдэд дасан зохицох, шинэ журмыг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай болсон бөгөөд шинэчлэлийн сүүлийн үе шатууд нь бизнес эрхлэгчид болоод татварын албаныханд их хүч хөдөлмөр шаардсан, бэрхшээлтэй ажил байсан талаар дурджээ.

Улс орнуудын татварын байгууллагууд БНХАУ-ын НӨАТ-ын бодлогын өөрчлөлтөд анхаарлаа хандуулсаар байна. Учир нь БНХАУ-д хийгдэх тус өөрчлөлтүүд бусад орнуудын санхүүгийн хэрэгсэл болон үл хөдлөх хөрөнгийн НӨАТ-ын хамгийн боломжит бодлогыг эргэн харахад хүргэж болзошгүй гэж үзэж байгаа ч зарим хүмүүс БНХАУ-д хийгдэх өөрчлөлт нь бодлогын болон техникийн талаас асуудал дагуулах эрсдэлтэй гэж үзэж байна.[100] Түүнчлэн БНХАУ-ын НӨАТ-ын систем нь бусад орнуудад байдаггүй, уламжлалт бус шинж чанаруудыг мөн агуулж байна.

Сүүлийн жилүүдэд БНХАУ-ын Засгийн газар зорилгодоо тулгуурлан үйлдвэрлэлийн эдийн засгаас илүү үйлчилгээний эдийн засагт шилжихийг зорьж байгаа бөгөөд НӨАТ-ын шинэчлэлийг амжилттай шилжих нэг арга зам гэж тодорхойлсон байна. Гэсэн хэдий ч Хятадын НӨАТ-ын систем нь хэт нүсэр, хамгийн төвөгтэй улс орны нэг гэж тооцогддог бөгөөд 2016 онд шинэчлэлийг бүрэн хийж дууссан ч НӨАТ-ын системийн төвөгтэй байдал нь хэвээр байх төлөвтэй байна гэж ажиглагчид үзэж байна.

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд Хятадын эдийн засгийн хурдацтай өсөлт, зах зээлийн даяаршил нь Хятад улс дотоодын болон олон улсын хэмжээнд өрсөлдөхүйц, хэвээр байхын тулд шууд бус татварын системээ орчин үеийн болгож шинэчлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн.

Одоо Хятад Улс нь Хонконг, Макаогоос бусад газарт буюу эх газарт нэмэгдсэн өртгийн болон хэрэглээний гэсэн 2 төрлийн шууд бус татварыг хэрэглэж байна. НӨАТ-ыг экспорт, импортын бүх худалдаа, бараа, ажил үйлчилгээнд хэрэглэдэг. Хэрэглээний татварыг үйлдвэрлэл, импорт болон тансаг хэрэглээний 14 нэр төрлийн барааны худалдаанд хэрэглэдэг. НӨАТ-ын ердийн хэмжээ 17 хувь байна. Ердийн хэмжээг ихэнх төрлийн барааны импорт, худалдаа, засварын үйлчилгээ боловсруулах үйлчилгээ, хөдлөх хөрөнгийн лизинг зэрэгт хэрэглэдэг. НӨАТ-ын бууруулсан хэмжээг бусад салбар, бараа үйлчилгээнд хэрэглэж байна. Тухайлбал:

| | |
|---|---|
| 3 хувь | 500000 - 5000000 юаны борлуулалт бүхий тогтвортой бус жижиг бизнес, ажил үйлчилгээ эрхлэгчдэд; |
| 5 хувь | тодорхой төрлийн үл хөдлөх хөрөнгийн худалдаанд; |
| 6 хувь | судалгаа үйлчилгээ, техник, мэдээллийн технологи, соёл, санхүү, даатгал, зөвлөх, зурагт радио, спорт, боловсрол, эрүүл мэнд зэрэг орчин үеийн ажил үйлчилгээнд; |
| 11 хувь | тээвэр, харилцаа холбоо, үл хөдлөх болон барилга, шуудангийн үйлчилгээнд; |
| 13 хувь | ном, сонин, сэтгүүл, үр тариа, тос, газ, халаалт, хөргөлтийн ажил үйлчилгээ, бараанд. |

Хөдөө аж ахуй (ХАА)-н болон жирэмслэлтээс хамгаалах эм, багаж хэрэгсэл, эртний ном зохиолтой холбогдох бараа, ажил үйлчилгээг НӨАТ-аас чөлөөлдөг байна.

Гадаадын ААН-үүд НӨАТ төлөгчөөр бүртгүүлэх шаардлагагүй бөгөөд худалдааны

[100] www.ibfd.org/sites/ibfd.org/files/content/pdf/ivm_2017_02_cn_1_PPV_AugNewsletter.pdf

бүсүүдэд үйл ажиллагаа явуулна.

Дотоодын ААН-үүд борлуулалтын дүнгээс хамааран ердийн болон жижиг татвар төлөгчөөр бүртгүүлдэг байна. Жилийн борлуулалт 800000 юанаас хэтрэхгүй, эсхүл бараа үйлдвэрлэх, засвар үйлчилгээ, боловсруулах чиглэлийн үйлдвэрлэлийн борлуулалт нь 500000 юаниас хэтрэхгүй ААН-ийг жижиг татвар төлөгчөөр бүртгүүлнэ.

Хятадын НӨАТ нь Европын орнуудын НӨАТ-аас ялгаатай нь зөвхөн бараанд, цөөн тооны үйлчилгээнд хамаардаг байна. Энэ нь зөвхөн үйлдвэрлэлийн болон борлуулалтын үе шат бүрт нэмүү өртөг нэмдэггүй учир нь төвийг сахисан явдал биш юм. Хэдийгээр Хятадын НӨАТ болон буцаан олголт нь үр өгөөжөө өсгөж, эдийн засгийн хөгжилд түлхэц үзүүлж байгаа боловч цаана нь олон бодлогын болоод үйл ажиллагааны асуудал байсаар байна гэжээ.

**1.2.НӨАТ-ын буцаан олголт**

ОУВС-ын тооцоолсноор буцаан олголт нь НӨАТ-ын нийт орлогын 30 хувиас хэтрэхгүй байх ёстой бөгөөд буцаан олголтын тогтолцоо нь НӨАТ-ыг хэрэгжүүлэх гол тулгуур нь гэж тооцогддог байна.

Хятадын НӨАТ-ын буцаан олголттой холбоотой асуудлуудыг НӨАТ-ын хууль, Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Сангийн яамнаас тухай бүр гаргасан шийдвэр, хэрэгжүүлэх журмуудаар зохицуулж байна. Энэ талаар Хятадын татварын хууль тогтоомж болон олон улсын татварын хөтөч цахим хаягнаас дэлгэрэнгүй үзэх боломжтой.[101]

НӨАТ-ыг буцаан олгох тал дээр Хятадын татварын алба ихээхэн хатуу байр сууринаас ханддаг бөгөөд үйл ажиллагааны төрөл, экспортын бүтээгдэхүүний ангиллаас хамааран буцаан олгох хувь хэмжээг тусгай жагсаалтаар ялгавартай тогтоодог байна.[102] Хэдийгээр 17 хувийн татвар төлсөн байсан ч 5-17 хувиар тооцож буцаан олголт олгодог байна. НӨАТ-ын буцаан олголт авах бүтээгдэхүүний жагсаалт жил ирэх тусам багасаж байгааг тэмдэглэжээ.

Санхүү татварын асуудал эрхэлсэн яамнаас 2017 оны 4 дүгээр сард баталсан журмаар буюу түүний хавсралтад тодорхойлон заасан тодорхой бараа үйлчилгээнд 11 хувь байхаар заасан байна. 10000 юанаас дээш буцаан олголтыг банк, бусад буцаан олголтыг тусдаа үйлчилгээний цэгүүдээр дамжуулан олгодог байна. Үүнээс 2 хувийг үйлчилгээний хөлсөнд суутган авч үлддэг байна.[103]

Жижиг бизнес эрхлэгчид болон жижиг татвар төлөгчдөд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарыг дуустал хугацаанд сарын 20000-30000 юаны борлуулалт бүхий татвар төлөгчдийг НӨАТ-аас чөлөөлөх шийдвэрийг санхүү татварын асуудал эрхэлсэн яамнаас гаргасан байна.

2016 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс дипломат төлөөлөгчийн болон олон улсын байгууллагын албан хаагч, ажилчдад олгох НӨАТ-ын буцаан олголтод дараах зүйлс хамаарахгүй байхаар шийдвэрлэсэн байна.

- хувийн болон албаны хэрэгцээндээ зориулан худалдан авсан өдөр тутмын ажил, амьдралд шаардлагатайгаас бусад эд зүйлс;
- нэг удаагийн баримтаар 800 юанаас доош үнэтэй бараа, 300 юанаас доош үнэ бүхий үйлчилгээ;
- НӨАТ-аас чөлөөлөгдсөн бараа үйлчилгээ.

Олон улсын болон дипломат төлөөлөгчийн газрууд нь буцаан олголтыг авахаас өмнө Гадаад хэргийн яамаар дамжуулан буцаан олголт авах эрх бүхий албан хаагчдын нэрс, холбогдох дансны дугаар зэрэг мэдээллийг өгөх шаардлагатай байдаг байна. Буцаан олголтын хүсэлтийг холбогдох цахим хуудсаар дамжуулан цахим хэлбэрээр гаргана.

2016 онд Бүгд Найрамдах Польш Улстай агаарын тээврийн үйлчилгээнд НӨАТ болон

[101] http://tax.mofcom.gov.cn/tax/taxfront/en/list.jsp?c=30105
[102] Борлуулалтын татвар ба НӨАТ-ын харьцуулсан судалгаа, О.Цогт
[103] http://tax.mofcom.gov.cn/

холбогдох татварыг харилцан ногдуулахгүй байхаар шийдвэрлэсэн.

2017 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс гадаадын дипломат төлөөлөгчдийн газрын ажилтнуудын хувийн хэрэгцээндээ худалдан авсан автомашин, орон сууц түрээслэхээс бусад бараа үйлчилгээд олгох НӨАТ буцаан олголтын хэмжээ нэг жилд нэг хүнд 180000 юанаас хэтрэхгүй байхаар холбогдох яамнаас шийдвэр гаргасан байна.

## 2.ТАЙВАНЬ

### 2.1.НӨАТ

НӨАТ-ын хэмжээний хувьд Тайваньд НӨАТ төлөгчийн болон НӨАТ төлөгчийн бус гэсэн 2 системтэйгээр татвар ногдуулдаг. Үүнийг НӨАТ төлөгчийн болон НӨАТ төлөгчийн бус бизнесийн хуулийн 10 дугаар зүйлд зааснаар “Бизнесийн татварын хувь хэмжээ 5 хувиас доошгүй, 10 хувиас дээшгүй байхаар заажээ. НӨАТ төлөгчийн татварын хамрах хүрээ нь НӨАТ төлдөг бүх ААН-үүд болон НӨАТ төлөгчийн бус ААН-үүдийг хамардаг. НӨАТ төлөгч нь бараа ажил, үйлчилгээний үйлдвэрлэлт, хуваарилалтыг нэмэгдсэн өртгийн дагуу ногдуулдаг. НӨАТ төлөгчийн татварын хувь хэмжээ нь 5 хувьтай байна. Харин НӨАТ төлөгчийн бус татварын хамрах хүрээ нь НӨАТ төлөгчийн бус санхүүгийн байгууллага, ресторан, жижиг компаниудын бизнесийн мөнгөний баримтыг бүрдүүлэх үндсэн дээр хийдэг. НӨАТ төлөгчийн бус нь нэмэлт худалдан авалтын зардлыг төлөхгүй. НӨАТ төлөгчийн бус татварын хэмжээг 0,1-25 хувиар ногдуулна.

| Хувь хэмжээ | НӨАТ төлөгч бус |
|---|---|
| 25 хувь | Салон ба цайны өрөө, кофе шоп, баар, үйлчлүүлэгчдийг зугаацуулагч, харилцагчийг хүлээн авах |
| 15 хувь | Шөнийн клуб болон ресторан, үзвэр үзүүлэх үзүүлбэр |
| үндсэн: 2 хувь | Банк болон даатгал, хөрөнгө оруулалтын итгэмжлэл, үнэт цаасны байгууллага, фючерс, арилжааны байгууллагууд, ломбардууд |
| бусад: 5 хувь | |
| 1 хувь | Даатгалын байгууллага, давхар даатгалын хураамж |
| 1 хувь | СЯ-наас чөлөөлөгдсөн жижиг ААН-үүд, массажны үйл ажиллагаа эрхлэх харааны бэрхшээлтэй иргэд |
| 0.1 хувь | ХАА-н бөөний зах зээлд оролцогч ХАА-н бүтээгдэхүүнийг борлуулдаг жижиг ААН-ийн төлөөлөгчид |

### 2.2.НӨАТ-ын буцаан олголт

Тайваний Үндэсний татварын алба (ҮТА), Сангийн Яам нь БНХАУ-д зорчиж байгаа гадаадын жуулчид, 183 хоногоос дээш хугацаагаар оршин сууж буй гадаадын иргэнд НӨАТ-ын буцаан олголт олгох зорилгоор Татварын буцаан олголтын цэгийг ажиллуулдаг бөгөөд нэг өдөрт 2,000NT$[104] тайвань доллараар ба түүнээс дээш хэмжээтэй худалдан авалт хийсэн бол 90 хоногийн дотор НӨАТ буцаан олголт авах хүсэлтийг гаргах эрхтэй. НӨАТ-ын буцаан олголтыг олгохын тулд жуулчдад дараах гурван аргын аль нэгийг сонгож болно. Үүнд:

1) Онгоцны буудал, далайн боомтын терминал дээр татвар буцаан олгох үйлчилгээг сонгохдоо: Жуулчид нисэх онгоцны буудал, далайн боомтоос өөрийн татварыг буцаан олгогч “НӨАТ-ын буцаан олголтын машин” (e-VAT, VAT refund machine)-аар үйлчлүүлэх буюу үйлчилгээний оператороор үйлчлүүлэн НӨАТ-ын буцаан олголтыг авч болно.

2) Жуулчид доорх нөхцөлийг хангасан тохиолдолд Татварын буцаан олголтын цэгээс НӨАТ буцаан олголтын үйлчилгээг авна. Үүнд:

а. худалдан авсан барааны дүн нь тухайн дэлгүүрээс нэг өдрийн 24,000NT$ ба түүнээс бага;

б. нийт худалдан авалтын хэмжээ 120,000NT $-с хэтрэхгүй байх;

[104] мөнгөн нэгжийн 2018.04.18-ны өдрийн ханш 1 USD= 29,3675 TWD буюу NT$ тэнцэнэ.

в. нийт худалдан авалтын хэмжээ нь хуанлийн жилдээ 240,000NT$ хэтрэхгүй байна.

3) Жуулчид үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн тохиолдолд НӨАТ-ын буцаан олголтын төлбөрийг буцаан авахдаа кредит карттай байх ёстой, (худалдан авалтын дүнгийн 7 хувьтай тэнцэх хэмжээний урьдчилсан төлбөр) зарлагадсан өдрөөс 20 хоногийн дотор буцаан олголтыг авна. Жуулчид онгоцны буудал болон хөлөг онгоц, далайн боомтод НӨАТ-ын цахим машинаар үйлчлүүлэх боломжтой. Дээрх журмуудыг дагаж мөрдөөгүй тохиолдолд буцаан олголтыг өгөх боломжгүй болно[105].

НӨАТ төлөгчийн болон НӨАТ төлөгчийн бус бизнесийн тухай хуулийн 35 дугаар зүйлд “Энэ хуульд зааснаар, ААН-ийн борлуулалтаас үл хамааран татварын буцаан олголтыг 2 дугаар сард төлсөн татварын хэмжээний дагуу олгоно. Татварын албанд дараа сарын 15-ны өдрийн дотор татвар буцаан олголтын холбогдох бичиг баримтыг бүрдүүлж өгнө. Бизнесийн татварын төлбөл зохих дүнг Засгийн газрын сангаас урьдчилан төлнө. Татвар төлсөн баримтыг татварын тайланд хавсаргана. Энэ хуулийн 7 дугаар зүйлд дурдсан бизнесийн татварын хувийг тэглэх заалтыг хангасан ААН-ийн хувьд сарын борлуулалтын дүнг дараа сарын 15-ны өдрийн дотор татвар төлөх эрх бүхий байгууллагад хандана. Сар бүр батлагдсан татварын буцаан олголтыг ААН-ийн мэдүүлгийн хугацааг нэг жилийн дотор өөрчлөх эрхгүй. Өмнөх 2 мөрөнд дурдсанаар ААН-үүд, төлбөрийн нэхэмжлэлийг ашиглаж байгаа бол ашиглагдаж буй нэгдсэн нэхэмжлэхийн дэлгэрэнгүй жагсаалтыг хавсаргана” гэж заажээ.

Мөн хуулийн 38 дугаар зүйлд зааснаар БНХАУ-ын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ААН, орон нутгийн бусад байгууллагууд татварын буцаан олголт, татвар төлөх, илүү төлөлтийн асуудлыг төв байгууллага болон орон нутгийн татварын албанд хүсэлтээ гарган шийдвэрлүүлнэ.

Энэхүү хуулийн 39 дүгээр зүйлд дурдсанаар доорх нөхцөлд ААН-ийн нэхэмжилсэн бизнесийн илүү төлсөн татварын дүнг эрх бүхий татварын алба баталгаажуулсны дараа татварыг буцаан олгоно. Үүнд:

1. бизнесийн татвараас илүү төлсөн төлбөр нь 7 дугаар зүйлд заасны дагуу 0 хувьтай татварт ногдуулсан бараа, үйлчилгээг хамаарна;
2. бизнесийн татвараас илүү төлсөн төлбөр нь худалдан авсан үл хөдлөх хөрөнгө хамаарна;
3. бизнесийн татвараас илүү төлсөн төлбөр нь бизнесийг нэгтгэх, бизнес шилжүүлэх, татан буулгах, хүчингүй болгохтой холбоотойгоор бүртгэлийг цуцалсан өргөдөл гаргасан ААН-ийг хамруулжээ.

Дээр дурдсанаас бусад нөхцөл байдлаас үүссэн татварын илүү төлөлтийг ирээдүйд төлөгдөх татварт тооцон урьдчилж авч болно. Тусгай нөхцөлтэй ААН-үүд татварын хөнгөлөлтийг хүлээн авах хүсэлтийг Сангийн яамд татварын хөнгөлөлт эдлэх өргөдлийг гаргаж болно” гэж тусгажээ.

**2.3.Хууль эрх зүйн орчин**

Тайвань нь НӨАТ-ыг дараах хууль тогтоомжийн хүрээнд зохицуулдаг байна. Үүнд:

1) Тайваний НӨАТ төлөгч болон НӨАТ төлөгч бус бизнесийн тухай хуулийн 1 дүгээр бүлэгт “Импортын бүтээгдэхүүн, БНХАУ-ын нутаг дэвсгэрт борлуулсан бараа, ажил, үйлчилгээнд НӨАТ-ыг ногдуулахад энэ хууль үйлчилнэ” гэж заажээ. Энэхүү хуульд бизнесийн татвар төлөгч, шилжүүлэг, татварын хувь хэмжээ, бизнесийн татвараас чөлөөлөх, татвар болон тусгай татварын тооцоолол, татвар бүрдүүлэх журам, бүртгэлийн маягт, татварын буцаан олголт, татвар төлөлтөнд тавих хяналт, татвар төлөгдөөгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлага зэрэг асуудлуудыг хамруулжээ.

2) НӨАТ төлөгчийн болон НӨАТ төлөгчийн бус бизнесийн тухай хуулийг дагаж мөрдөх журамд[106] нь НӨАТ төлөгчийн болон НӨАТ төлөгчийн бус бизнесийн тухай

---

[105] Сангийн яам https://www.mof.gov.tw/Eng/Detail/Index?nodeid=319&pid=71590

[106] Enforcement Rules of Value-added and Non Value - added Business Tax Act. 1931.06.31-ний өдөр батлагдсан. Энэ хууль нь 7 бүлэг, 60 зүйлтэй. Сангийн яамны Е татварын цахим хуудас.

хуулийн 59 дүгээр зүйлд заасны дагуу зохицуулагдана.

3) Тайваньд мөрдөгдөж буй "НӨАТ-ын буцаан олголтыг авах гадаадын зорчигчдын худалдан авсан бараанд буцаан олголт хийх, НӨАТ-ын талаарх дүрэм, журмыг[107] боловсруулсан.

4) БНХАУ-ын нутаг дэвсгэрт түр зуурын бизнес эрхэлдэг холбоод, эсвэл гадаадын аж ахуйн нэгж, нийгэмлэг, байгууллагаас худалдаж авсан НӨАТ-ын бараа, ажил үйлчилгээ үзүүлэхэд НӨАТ-ын буцаан олголтонд хяналт тавих журмыг[108] 2017 оны 5 дугаар сарын 25-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан.

5) Гадаадын зорчигчдын худалдан авах барааны НӨАТ-ын буцаан олголтыг зохицуулах журамд[109] гадаадын зорчигчдын БНХАУ-ын нутаг дэвсгэрт 183 хоногоос багагүй хугацаанд аялахдаа зөвшөөрөгдсөн дэлгүүрээс (TRS) худалдан авалт хийж, НӨАТ бүртгүүлж, шаардлага хангасан тохиолдолд НӨАТ-ын буцаан олголтод хамрагдах боломжтой.

6) Татвар бүрдүүлэх тухай хуулиар[110] татвар бүрдүүлэлтийг зохицуулдаг байна.

7) Татварын бүртгэл хөтлөх журмын[111] дагуу ААН-үүд татварын бүртгэлийг явуулна.

8) Мөнгөн шагнал нэхэмжлэх журам[112] нь НӨАТ төлөгчийн болон НӨАТ төлөгчийн бус бизнесийн тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу сугалааны мөнгөн урамшууллыг олгох асуудлыг зохицуулсан байна.

## 3.ЕВРОПЫН ХОЛБООНЫ УЛСУУД

НӨАТ-ын буцаан олголтыг илүү нарийвчлан зохицуулж, журамлах зорилготой Европын Холбооны НӨАТ-ын буцаан олголтын журам 2009 онд батлагдаж, улмаар 2010 оноос мөрдөгдөж эхэлжээ.

Үүний үр дүнд ЕХ-ны бизнес эрхлэгч, татвар төлөгч нар нь оршин суугаа буюу байгуулагдсан орныхоо татварын байгууллагын цахим хуудсаар дамжуулан НӨАТ-ын буцаан олголтын нэхэмжлэл гаргаж, буцаан олголтыг авах боломжтой болсон байна. Хуучин мөрдөгдөж байсан зохицуулалтаар бол НӨАТ-ын буцаан олголтыг авахдаа заавал бичгийн хэлбэрээр, НӨАТ-ын буцаан олголтыг өгөх улсаар дамжуулан нэхэмжлэл гаргадаг байсан байна.

Харин буцаан олголтын шинэ батлагдсан журмаар нэхэмжлэл гаргах үйл явц, нэхэмжлэл гаргах хугацаа, хүлээн авах журам зэргийг ихэд хялбарчилж өгсөн байна. ЕХ-ны гишүүн улсуудад бүртгэлтэй татвар төлөгч нь НӨАТ-ын буцаан олголтыг гишүүн орнуудаас нэхэмжилж авах боломжтой болсон бөгөөд одоо ЕХ-ны улсууд нь энэхүү журамд заасан зохицуулалтад үндэслэн НӨАТ-ын буцаан олголтыг хэрэгжүүлж байна. ЕХ-ны улс орнууд НӨАТ-ын буцаан олголтод хамрагдахгүй бараа, үйлчилгээг улс орон бүр харилцан адилгүй өөр өөр тогтоосон байна.

Судлаачдын үзэж байгаагаар НӨАТ-ын илүү төлөлтийг буцаан олгодгоос татвараас зайлсхийх хандлага сүүлийн жилүүдэд илүү гарч байна гэж үзэж байна. Экспортын

---

[107] Regulations Regarding the Claiming of VAT refund be Foreign Passengers Purchasing Goods Eligible for VAT refund. Сангийн яам, Зам тээвэр, Харилцаа холбооны яамны хамтарсан 2016 оны 1 дүгээр сарын 1-ний тушаалаар баталгаажсан. Энэ журам нь 6 бүлэг, 54 зүйлтэй. цахим хаяг: http://admin.taiwan.net.tw/upload/law/20150907/3db03f8f-b961-4da1-8fc5-8fd71579321a.pdf

[108] The Regulations Governing the Claiming of VAT Refunds for Goods and Services Eligible for VAT Purchased by Foreign Enterprises, Institutions, Organizations, or Associations Engaging in Exhibitions or Temporary Business Activities within the Territory of the Republic of China. БНХАУ-ын хууль, дүрэм журмын цахим хуудас: http://law.moj.gov.tw/eng/LawClass/LawAll_print.aspx?PCode=G0340126

[109] Regulations Governing VAT refund Claims by Foreign Travelers Purchasing Goods Eligible for VAT refund. 2016.12.30-ны өдөр нэмэлт, өөрчлөлт орсон. БНХАУ-ын хууль, дүрэм журмын цахим хуудас: http://law.moj.gov.tw/eng/LawClass/LawAll_print.aspx?PCode=K0110023

[110] Tax Collection Act. 2013.05.29-ны өдөр Ерөнхийлөгчийн зарлигаар нэмэлт, өөрчлөлт орсон. Сангийн яам http://law-out.mof.gov.tw/EngLawContent.aspx?Type=E&id=75

[111] Regulations Governing Taxation Registration. 2017.03.29-ны өдөр нэмэлт, өөрчлөлт орсон. Энэ журам нь 4 бүлэг, 20 зүйлтэй.Сангийн Яам: http://law-out.mof.gov.tw/EngLawContent.aspx?Type=E&id=250

[112] Inform Invoice Award Regulations. 2016.12.15-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан.

бараанд 0 хувиар татвар ногдуулдгаас, ялангуяа ЕХ-ны улсуудад төрөл бүрийн татвараас зугтах арга техникүүд бий болж хэдэн сая еврогийн хуурамч буцаан олголтууд хийгдэж байна. Хэдийгээр ихэнх улс орнууд НӨАТ-ын буцаан олголтыг олгохоос өмнө маш нарийн чанд хяналт хийж, хуурамч нэхэмжлэлийг илрүүлэх тогтолцоог бий болгож чадсан ч татвараас зайлсхийх аргуудад өртөмтгий хэвээр байна.

### 3.1.Финланд

1993 онд батлагдсан Финландын Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулиар бизнес эрхлэх хүрээн дэх бараа, үйлчилгээ, импортын бараа бүтээгдэхүүнд НӨАТ ногдуулж, улсад төлөх үүрэгтэй гэж заажээ. Бизнес эрхлэх хүрээ гэдэгт цалин хөлсийг хамруулахгүй гэж заасан байна. Татвар төлөгч гэдэгт бараа үйлчилгээг зарж, борлуулж буй этгээдийг нэрлэсэн байна. Тус улсын хуулиар үл хөдлөх хөрөнгө, түүнтэй холбогдох эрх, үл хөдлөх хөрөнгө эзэмшиж, ашиглахтай холбоотой цахилгаан, ус зэрэг хэрэглээнд НӨАТ ногдуулахгүй байхаар заасан байна.

Финландад НӨАТ-ын стандарт хэмжээ 24 хувь байх бөгөөд 14 болон 10 хувийн бууруулсан НӨАТ байна. “Европын орнуудын НӨАТ-ын буцаан олголтын хөтөч 2017”-д дурдсанаар Финландын НӨАТ-ын хэмжээ байнга нэмэгдэж ирсэн бөгөөд 2013 онд дээрх хэмжээнд хүрч түүнээс хойш өөрчлөлт ороогүй байна.

Хүнсний бараа бүтээгдэхүүн, ХАА-н бараа үйлчилгээнд 14 хувийн НӨАТ, эмийн бүтээгдэхүүн, тээвэр, ном сонин, соёлын үйлчилгээ, зугаа цэнгэл, ресторан, спортын бараа үйлчилгээнд 10 хувь зэргээр багасгасан НӨАТ ногдох бараа, ажил үйлчилгээг жагсаалтаар дэлгэрэнгүй тогтоож өгсөн байна. Ашгийн төлөө бус байгууллагуудын хэвлэх үйлчилгээ, нийтийн болон олон улсын тээврийн үйлчилгээ зэрэгт 0 хувийн татвар ногдуулдаг байна.[113] Финландад Аланд арлын бүс нутаг НӨАТ-аас чөлөөлөгддөг байна.

Финландад байгуулагдсан ААН буцаан олголтыг бусад гишүүн улсуудаас нэхэмжлэхдээ татварын цахим хуудсаар дамжуулан цахим хэлбэрээр гаргадаг. Хүсэлтээ өөрөө, эсхүл төлөөлөгчөөрөө дамжуулан гаргана. Нэхэмжлэлд НӨАТ буцаан олголтыг нэхэмжлэгчийн болон нэхэмжлэл, холбогдох гүйлгээний баримт нэхэмжлэх зэргийн мэдээллийг тусгаж, баримтыг хавсаргадаг байна. Харин ЕХ-ны бусад улсуудад байгуулагдсан ААН-үүд Финландаас буцаан олголт авахад дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Финланд Улсад үүсгэн байгуулагдаагүй бөгөөд тус улсад байнгын үйл ажиллагаа явуулдаггүй буюу байрладаггүй бол;
- тухайн гүйлгээ, худалдаа Финландад хийгдсэн бөгөөд хуулиар тус худалдааг НӨАТ бүртгэлд бүртгүүлэхээр, гадаадын компанид НӨАТ-ын буцаан олголт өгөхөөр заасан бол;
- тухайн компани Финланд Улсад ажил үйлчилгээ, бизнес эрхэлдэггүй бол;
- тээврийн болон бусад туслах үйлчилгээнээс чөлөөлөгдсөн борлуулалт.

Дараах тохиолдолд НӨАТ буцаан олголт олгогдохгүй[114]:

- татвар ногдох этгээд, түүний албан хаагчдын оршин суух буюу хэрэглэж, ашиглаж буй амьдрах, асаргаа сувилгаа, амралтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, тус зорилгоор хэрэглэж буй, эсхүл түүнтэй холбогдох бараа, үйлчилгээ;
- татвар ногдох этгээд, түүний албан хаагчдын оршин суугаа газар болон ажлын хооронд явах тээвэрлэлттэй холбогдох бараа, үйлчилгээ;
- бизнесийн зугаа цэнгэлтэй холбогдох бараа, үйлчилгээ албан ажлын хүрээний бэлэг, ресторааны үйлчилгээ зэрэг;
- амралтын болон спортын зориулалт бүхий мотоцикл, суудлын автомашин, завь, онгоц 1550 кг-аас хэтрэхгүй өөрийн жинтэй нисэх онгоц, албан ажлын зориулалт бүхий автомашин, жолооны курс, нийтийн тээврийн зориулалт бүхий тээврийн хэрэгслийн худалдаа, түрээсийн үйлчилгээнд буцаан олголтыг зөвшөөрнө;

[113] Europian VAT refund guide 2017, https://www2.deloitte.com/content/dam/Deloitte/global/Documents/Tax/dttl-tax-european-vat-refund-guide.pdf
[114] European VAT refund guide 2017, page 89.

- татвар ногдох этгээд, түүний албан хаагчдын зугаа цэнгэлийн зорилгоор хэрэглэж буй хувийн хэрэгцээний бараа, үйлчилгээ;
- гадаадын аялал жуулчлалын компанийн нэрээр хийгдэж буй бараа, үйлчилгээ;
- санамсаргүйгээр суутгагдсан НӨАТ үл ногдох бараа үйлчилгээ.

“Европын орнуудын НӨАТ-ын буцаан олголтын хөтөч 2017”-д тэмдэглэснээр тухайн татварын жилд нэхэмжилж болох буцаан олголт ногдох борлуулалтын хэмжээ нь 400 евро, харин санхүүгийн сүүлийн улирлын тухайд нэхэмжилж болох буцаан олголт ногдох хэмжээ нь 50 еврогоос багагүй байх шаардлагатай байна.

НӨАТ-ын буцаан олголтын нэхэмжлэл нь нэг жил дотор, түүн дотроо 3 сараас доошгүй хугацааг хамарсан байх бөгөөд холбогдох төлбөрийн нэхэмжлэлийн дагуу төлбөрийг төлсөн бараа үйлчилгээг хүлээн авсан байх ёстой.

Импортын барааны тухайд барааг гааль дээр мэдүүлсэн үеэс эхлэн нэхэмжлэх эрх үүснэ.

Татварын байгууллага буцаан олголтын нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш 4 сарын дотор шийдвэрлэнэ. Шийдвэрийг шуудан болон цахимаар илгээнэ. Нэмэлт материал шаардлагатай бол энэ тухай мөн шуудангаар мэдэгдэх бөгөөд нэхэмжлэл гаргагч нь 1 сарын дотор холбогдох материалыг бүрдүүлэн хүргүүлсэн байна.

Энэ тохиолдолд шийдвэрлэх хугацаа 6, эсхүл 8 сар болж сунгагдана. Олгох шийдвэр гарсан бол татварын байгууллага ажлын 10 хоногийн дотор холбогдох банкинд буцаан олголтыг шилжүүлнэ.

ЕХ-оос бусад улсын банкинд шилжүүлгийг хийхгүй. Татварын байгууллага буцаан олголтын хугацааг хэтрүүлсэн бол холбогдох хүүг төлөх үүрэгтэй. Олгох үндэслэлгүй гэж үзсэн бол нэхэмжлэгчид энэ талаараа мэдэгдэх ба нэхэмжлэгч нь энэ талаар Татварын давж заалдах хороонд гомдлоо гаргаж болно.

Гомдолд гомдол гаргагчийн нэр, татвар төлөгчийн дугаар, гаргасан шийдвэрийн үндэслэл, маргааны үндэслэл, холбогдох баримт сэлтийг хавсарган 60 хоногийн дотор гомдол гаргаж болно. Гомдлыг холбогдох материал дутуу буюу эргэлзээтэй гэсэн үндэслэлээр бүхэлд нь хэрэгсэхгүй болгохыг хориглох бөгөөд тухайн эргэлзээтэй гэж үзсэнээс бусад буцаан олголтын асуудлыг шийдвэрлэх үүрэгтэй байна. Татварын зөвлөл нь буцаан олголтыг нэмэгдүүлэх буюу багасган тогтоож болох бөгөөд шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор буцаан олголтыг олгох үүрэгтэй байдаг байна.

### 3.2.Нидерланд

Нидерландын гол татваруудын нэг болох НӨАТ нь 1968 онд батлагдсан НӨАТ-ын тухай хуулиар[115] зохицуулагдана.

НӨАТ-ын стандарт хувь хэмжээ 19 хувь байна. 6 хувийн бууруулсан хувь хэмжээ нь импорт болон Хамтын нийгэмлэгийн дотор бараа, үйлчилгээ авах үйл ажиллагаа болно. Буруулсан хувь хэмжээнд хоол хүнсний бүтээгдэхүүн болон эмчилгээний эмийн бүтээгдэхүүн хамаарна.

Ус, урлаг, ном, сонин, сэтгүүл, харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан туслах багаж, хиймэл эрхтэн, газар тариалангийн зарим бараа, үйлчилгээ, зорчих тээвэр, спорт, хөдөлмөр шаардсан үйлчилгээ болон театр, жүжиг, музей, кинотеатр, спортын арга хэмжээ, хөгжөөнт тоглоомын парк, амьтны хүрээлэн, циркийн орох тасалбар зэрэг бараа үйлчилгээнд ногдуулах татварын хэмжээ харьцангуй бага байна.

Татвар төлөгч НӨАТ-ын мэдүүлгийн маягтыг заавал бөглөж өгнө. Татвар төлөгч нь НӨАТ-ын буцаан олголтоо сар бүр, улирал бүр, жил бүр авах эсэхээ өөрөө тогтоох боломжтой. Татварын удирдах газар мэдүүлгийг хүлээн авснаас хойш нэг сарын дотор буцаан олголтыг хянаж шийдвэрлэнэ. Татвар төлөгч нь мэдүүлгийн маягтыг хугацаанаас нь хоцроосон тохиолдолд торгууль ногдуулна.

[115] ftnref1 Wet op de omzetbelasting 1968 - Wet OB.
http://wetten.overheid.nl/BWBR0002629/geldigheidsdatum_04-07-2013

### 3.3. ОХУ

#### *3.3.1.НӨАТ-ын буцаан олголт*

НӨАТ-ын эрх зүйн харилцааг ОХУ-ын Татварын тухай хуулийн (2000 он) 21 дүгээр бүлгээр[116] зохицуулах бөгөөд уг татвар нь Холбооны татварт хамаарна. Татварын тухай хуулийн 145 дугаар зүйлд зааснаар ААН, хувь хүний өмнөх (дараалсан) 3 сарын хугацааны бараа (ажил, үйлчилгээ)-ны борлуулалтын дүн нь 2 сая рублээс хэтрээгүй бол жилийн хугацаанд чөлөөлөгдөнө.

НӨАТ-ын ерөнхий хувь хэмжээ нь 18 хувь бөгөөд эрүүл мэндийн болон хүүхдийн бүтээгдэхүүн, тогтмол хэвлэл, ном болон зарим хүнсний бараанд 10 хувиар ногдуулахаар Татварын тухай хуулийн 164 дүгээр зүйлд заасан байна.

НӨАТ-ын буцаан олгох журмыг ОХУ-ын татварын хуулийн 21 дүгээр бүлэгт тодорхойлсон. НӨАТ-ын тооцоолсон дүнгээс хэтэрсэн дүнг буцаан олгоно.

*Зураг 3. НӨАТ-ыг буцаан олгох үйл явц*




*1) Татвар төлөгч нь ХТА-нд татварын тайлангаа гаргаж өгөх:* Экспортод гаргасан барааны НӨАТ-ын буцаан олголтыг баталгаажуулж буцаан олгохын тулд дор дурдсан шаардлага тавина. Үүнд:

- тэдэнд экспортын орлого нь бараа хилээр гарснаас хойш 6 сарын дотор ОХУ-ын банкин дахь дансанд орсон байх,
- бараа солилцоогоор төлбөрийг авахаар тохиролцсон бол уг бараа нь ОХУ-ын нутаг дэвсгэрт орж ирсэн нь гаалийн байгууллагаар нотлогдсон байх,
- бэлэн мөнгө хүлээн авсан бол уг мөнгөө ОХУ-ын арилжааны банкин дахь дансанд төвлөрүүлсэн нь банкны тодорхойлолтоор нотлогдсон байх гэх мэт.

Мөн барааг экспортод гаргасан тухай гаалийн мэдүүлэг, экспортын барааны орлого дансанд төвлөрсөн тухай банкны тодорхойлолт, санхүүгийн тайланд тусгасан тэмдэглэл, татвар төлөгчийн өргөдөл, экспортын гэрээ зэрэг Татварын тухайн хуулийн 165 дугаар зүйлд заасан баримт бичгүүдийг хавсаргана.

*2) ХТА нь татварын тайланг хянах:* Холбооны татварын алба (ХТА) нь татвар төлөгчийн НӨАТ-ын тайланг Татварын тухай хуулийн 88 дугаар зүйлд заасан журмын дагуу тайлан ирсэн өдрөөс хойш 3 сарын хугацаанд хянаж үзнэ. Хянах явцад ХТА нь татвар төлөгчөөс татварын хасалт хийхэд хуульд заасан нотлох баримт бичгээс өөр нэмэлт мэдээлэл, баримт бичгийг шаардах эрхгүй.

*3) ХТА нь татварын шийдвэр гаргах:* Холбооны татварын алба (ХТА) нь татвар төлөгчийн НӨАТ-ын тайланг хянаж үзээд татварын тайланд мэдүүлсэн НӨАТ-ыг (бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн) буцаан олгох, эсхүл олгохгүй байх шийдвэрийг гаргана.

ХТА нь НӨАТ-ын буцаан олгох шийдвэр (бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн)-ийг НӨАТ-ын дүнг буцаан олгох, эсхүл холбогдох шийдвэрийг гарснаас хойш 5 хоногийн дотор буцаан олгохоос татгалзсан шийдвэрийн талаар бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

*4) НӨАТ-ыг буцаан олгох:* Буцаан олголтын дүнг татварын хууль тогтоомжийн дагуу татварын өр төлбөр (албан татварын дутуу төлөлт, анз, торгууль)-ийг төлөх, ирээдүйд төлөгдөх татварт урьдчилж авах, эсхүл татвар төлөгчийн дансанд буцаан олгоно. Тайланг хянаж дууснаас хойш 3 сарын хугацаанд НӨАТ-ыг буцаан олгоно.

[116] "Налоговый кодекс Российской Федерации (часть вторая)" от 05.08.2000 N 117-ФЗ (ред. от 07.03.2018), Раздел VIII. Федеральные налоги, Глава 21. Налог на добавленную стоимость. www.consultant.ru

### 3.3.2.НӨАТ-ын орлого ба тулгамдсан асуудлууд

НӨАТ-ын орлого нь түүхий эд, эрчим хүчний дэлхийн зах зээлийн үнэ цэнээс хамааралтай байдаг тул улсын санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангаж байдаг тул төсөвт ихээхэн үнэ цэнтэй байдаг бөгөөд энэ нь эдийн засгийн хямралын үед улам бүр мэдрэгдэж байдаг.[117]

НӨАТ нь ОХУ-ын Төсвийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу Холбооны төсөвт орох бөгөөд Холбооны 2015 онд төсвийн орлогын 35,6 хувийг бүрдүүлсэн томоохон эх үүсвэр болдог байна.

*Хүснэгт 1. НӨАТ-ын орлогын хэмжээ, Холбооны төсөвт эзлэх хувь (2014-2015 он)*[118]

| | *2014 он* | | *2015 он* | |
|---|---|---|---|---|
| | *Дүн (тэрбум рубль)* | *Эзлэх хувь* | *Дүн (тэрбум рубль)* | *Эзлэх хувь* |
| Нийт татварын орлого | 6 214,60 | 100,0 | 6 880,50 | 100,0 |
| Үүнээс: НӨАТ | 2 181,40 | 35,1 | 2 448,30 | 35,6 |

Тус улсын Холбооны 2015 оны төсөвт НӨАТ-аас 2448,3 сая рубль орж ирсэн нь 2014 оныхтой харьцуулахад 11 хувь, харин 2010 оныхоос 46 хувиар, 2000 оныхоос 7 дахин өссөн байна. (Зураг 3.)

*Зураг 4. НӨАТ-ын орлогын үзүүлэлт (2000-2015 он, тэрбум рубль)*




Эдийн засгийн ухааны доктор М.В.Мишустины судалгаанаас үзэхэд НӨАТ-ын суурийн динамик нь инфляцийн түвшин, бодит худалдааны эргэлтээс хамаардаг. Мөн татварын дүнг тооцоолохдоо импортын, ам.долларын ханшийн өөрчлөлтөд нөлөөлдөг НӨАТ-ын хасалтыг харгалзан үзэх шаардлагатай.

Ам.долларын ханшийн өсөлт нь импортын бараа (үйлчилгээ)-ны өртөгт нөлөөлж үнийн өсөлтийг бүрдүүлж байна. Инфляц нь мөн үнийн өсөлтөөс хамаарч татварын суурийг нэмэгдүүлж байна. Үүнтэй зэрэгцэн иргэдийн худалдан авах чадвар буурч, үйлдвэрлэл, барааны хэмжээ багасаж байдаг.

Доорх зургаас үзэхэд, татварын орлогын гол өсөлт нь инфляцийн өсөлт (+158 тэрбум рубль), импортын бууралт (+76 тэрбум рубль)-аас гадна худалдааны эргэлт буурч, рублийн ханш суларсантай зэрэгцэн татварын хэмжээ буурсан зэргээс хамаарсан байна.

[117] “Факторы роста налоговых доходов: макроэкономический подход”. М.В.Мишустин (доктор экономических наук). Экономическая политика. 2016. Т. 11. No 5, стр. 8-27. https://cyberleninka.ru/

[118] “Роль косвенных налогов в формировании доходов бюджета”. Н.М.Турбина, А.Ю. Фёдорова. Социально-экономические явления и процессы, 2016, No 7, стр. 41-47. https://cyberleninka.ru/

Ийнхүү инфляц, худалдааны эргэлт, импортын өөрчлөлт, ам.долларын ханш зэрэг үзүүлэлтүүд өөрчлөгдснөөс хамаарч 2016 оны эхний хагас жилийн татварын орлого 22 тэрбум рублээр өссөн байна.

*Зураг 5. НӨАТ-ын бүрдүүлэлтэд макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн нөлөөллийн дүн (2000-2015 он, тэрбум рубль)*




Хэдийгээр Холбооны төвийн орлогод НӨАТ-аас бүрдүүлж орлогын хэмжээ тогтмол өсөж байгаа боловч дор дурдсан асуудлууд шийдвэрлэгдээгүй байна.[119] Үүнд:

- Шууд бус татварууд нь дотоодын үйлдвэрлэлийн өсөлт, үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалтыг саатуулж байна. Үүнийг хөрөнгө оруулалтыг дэмжихийн тулд татварын хууль тогтоомжид өөрчлөх;
- НӨАТ-аас үүдэн инфляц тогтмол өсөж байна. Энэ асуудлыг шийдэхийн тулд НӨАТ-ын үндсэн хувь хэмжээг бууруулах, татварын хөнгөлөлтүүдийг багасгах;
- Экспортын барааны НӨАТ-ын буцаан олголтыг хууль бусаар олгож байна. Үүний тулд татварын зарим хөнгөлөлтүүдийг цуцлах;
- НӨАТ-ыг бүрдүүлэлт, ялангуяа НӨАТ-ын тооцоолол болон буцаан олголтод учирч байгаа хүндрэлүүд нь Оросын ААН, компаниудыг олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулахад саад болж байна.

[119] "Роль косвенных налогов в формировании доходов бюджета". Н.М.Турбина, А.Ю. Фёдорова. Социально-экономические явления и процессы, 2016, No 7, стр. 41-47. https://cyberleninka.ru/

**АШИГЛАСАН МАТЕРИАЛ**


- ftnref1 Wet op de omzetbelasting 1968 - Wet OB. Эх сурвалж: http://wetten.overheid.nl/BWBR0002629/geldigheidsdatum_04-07-2013
- Налоговый кодекс Российской Федерации (НК РФ),Раздел VIII. Федеральные налоги, Глава 21. Налог на добавленную стоимость
- The SII Commissioner Julio Pereira, 2011, 2010 Official Accounts address, Santiago
- "Налоговый кодекс Российской Федерации (часть вторая)" от 05.08.2000 N 117-ФЗ (ред. от 07.03.2018), Раздел VIII. Федеральные налоги, Глава 21. Налог на добавленную стоимость. www.consultant.ru
- “Факторы роста налоговых доходов: макроэкономический подход”. М.В.Мишустин (доктор экономических наук). Экономическая политика. 2016. Т. 11. No 5.
- “Роль косвенных налогов в формировании доходов бюджета”. Н.М.Турбина, А.Ю. Фёдорова. Социально-экономические явления и процессы, 2016, No 7.
- http://www.government.nl/issues/taxation
- www.chinatax.gov.cn
- http://tax.mofcom.gov.cn/tax/taxfront/en/list.jsp
- www.ibfd.org/sites/ibfd.org/files/content/pdf/ivm_2017_02_cn_1_PPV_AugNewsletter.pdf
- http://world.salestaxhandbook.com/cn-china/vat-refund
- https://assets.kpmg.com/content/dam/kpmg/pdf/2016/03/china-tax-alert-09-vat-implementation-rules.pdf
- European VAT refund guide 2017.
- www2.deloitte.com/global/en/pages/tax/articles/vat-refund-guide.htm
- www.vatlive.com/country-guides/europe/finland/finnish-vat-rates/
- Value added tax act. www.finlex.fi/en/laki/kaannokset/1993/en19931501.pdf
- Тайвань өнөөдөр цахим хуудас https://taiwantoday.tw/news.php?unit=6,23,6,6&post=12463
- 2015 оны албан татвар судалгаанаас https://home.kpmg.com/content/dam/kpmg/pdf/2015/10/taiwan-2015.pdf
- БНХАУ-ын хууль, дүрэм журмын цахим хуудас http://law.moj.gov.tw/eng/LawClass/LawAll.aspx?PCode=G0340080
- Сангийн яамны е- татварын цахим хуудасhttps://www.etax.nat.gov.tw/etwen/Value_sub_in04.html
- http://admin.taiwan.net.tw/upload/law/20150907/3db03f8f-b961-4da1-8fc5-fd71579321a.pdf
- БНХАУ-ын хууль, дүрэм журмын цахим хуудас http://law.moj.gov.tw/eng/LawClass/LawAll_print.aspx?PCode=G0340126
- Сангийн яамны цахим хуудас
- http://law-out.mof.gov.tw/EngLawContent.aspx?Type=E&id=75
- СЯамны цахим хуудас http://law-out.mof.gov.tw/EngLawContent.aspx?Type=E&id=250
- “НӨАТ төлөгч болон НӨАТ төлөгч бус бизнесийн хууль”-ийн 3-р бүлгийн 10-13 зүйл http://law.moj.gov.tw/eng/LawClass/LawAll.aspx?PCode=G0340080
- Сангийн яам https://www.mof.gov.tw/Eng/Detail/Index?nodeid=319&pid=71590
- “The VAT: Its Causes and Consequences”. M.Keen and B.Lockwood. International Monetary Fund. 2017.
- How Many Countries in the World Have a Value-Added Tax. Kyle Pomerleau. https://taxfoundation.org
- Stefan Gabriel ets. “The influence of VAT on economic growth”. 2015.
- www.ibfd.org/sites/ibfd.org/files/content/pdf/ivm_2017_02_cn_1_PPV_AugNewsletter.pdf
- “Нэмэгдсэн өртөгийн албан татварын буцаан олголт, гадаадын зарим орны туршлага”. УИХ-ын Тамгын газрын Судалгаа, шинжилгээний хэлтэс. 2013 он.
- Борлуулалтын татвар ба НӨАТ-ын харьцуулсан судалгаа, О.Цогт
- НӨАТ ба хэрэглээний татварын хувилбарууд. Р.Кревер. www.iltod.gov.mn

# ТҮРЭЭСИЙН ХАРИЛЦААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

(Харьцуулсан судалгаа)

*Г.Билгээ, Д.Жигваагүнсэл*
*И.Жаргалзаяабямба, Р.Оргилмаа*

## АГУУЛГА

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

ТҮРЭЭСИЙН ХАРИЛЦААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

- ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС
- БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС
- БҮГД НАЙРАМДАХ ИРЛАНД УЛС
- КАНАД УЛС

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Судалгаанд гадаадын зарим орны түрээсийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Ирланд Улс, Канад зэрэг орнуудын холбогдох хууль тогтоомжийн хүрээнд судалсан болно.

Судалгаанд хамрагдсан орнуудад түрээсийн харилцааг ихэвчлэн Иргэний хуулиар зохицуулж байгаа бөгөөд нарийвчилсан зохицуулалтыг түрээсийн тухай бие даасан хууль, түрээсийн төрөл, онцлогоос хамааруулан зохицуулсан тусгайлсан хууль эрх зүйн актуудаар зохицуулж байна. Тухайлбал:

1.ОХУ-ын хувьд түрээсийн үндсэн харилцааг Иргэний хуулиар зохицуулдаг. Иргэний хуулийн зохицуулалтанд хөдлөх эд хөрөнгийн түрээс (прокат), тээврийн хэрэгслийн түрээс, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн түрээс, үйлдвэр аж ахуйн газрын түрээс, санхүүгийн түрээс (лизинг), газрын түрээс зэрэг түрээсийн харилцааг хамруулан зохицуулсан байна. Нарийвчилсан харилцааг Санхүүгийн түрээс (лизинг)-ийн тухай, Газрын тухай, Ойн тухай, Усны тухай, Газрын хэвлийн тухай хуулиудаар;

2.БНСУ-ын хувьд түрээсийн харилцааны тухай бие даасан хуульгүй бөгөөд энэхүү харилцааг Иргэний хууль, Худалдааны тухай хууль, Орон сууцны түрээсийн тухай хууль, Худалдааны зориулалттай барилга байгууламжийн түрээсийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор;

3.БНИУ-ын хувьд түрээсийн харилцааг Түрээслүүлэгч ба түрээслэгчийн тухай, Орон сууцны түрээсийн тухай хууль болон холбогдох бусад эрх зүйн актуудаар;

4.Канад Улсад түрээсийн харилцааг Орон сууцны түрээсийн тухай, Арилжааны түрээсийн тухай, Түрээсийн шударга байдлын тухай, Түрээсийн хамгаалалтын тухай хуулиудаар тус тус зохицуулж байна.

Түрээсийн гэрээ гэдэг нь түрээслүүлэгчээс түрээслэгчид тодорхой үнээр, тодорхой эд хөрөнгийг түр хугацаагаар эзэмшүүлэх буюу ашиглуулахаар шилжүүлэх тухай хэлэлцээр юм. Түрээсийн харилцааны иргэний эрх зүйн бусад харилцаанаас ялгарах онцлох шинжүүд нь:

- гэрээгээр талууд харилцан үүрэг хүлээх (төлбөр төлсөний үндсэн дээр эд хөрөнгийг шилжүүлэх);
- эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэхгүй байх (түрээслэгч хөрөнгийг зөвхөн эзэмших эрхтэй бөгөөд захиран зарцуулах эрхгүй);
- бодитой байдал (түрээсийн харилцаа нь гэрээнд талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш гэрээнд заасан хугацааны туршид эрх зүйн чадамжтай байх);
- хугацаат шинжтэй (эд хөрөнгийг зөвхөн тодорхой хугацаагаар ашиглуулах);
- түрээслүүлэх эд хөрөнгө нь зөвхөн ашиглалтын явцад шинж байдлаа алдахгүй (хэрэглээний бус) эд хөрөнгө байх (ашиглалтын дараа эд хөрөнгийн анхны шинж байдал болон функциональ үйл ажиллагаа нь алдагдахгүй байх);
- улсын бүртгэлд бүртгүүлсэн байх;
- түрээсийн хугацааг гэрээнд заавал тусгасан байх.

Орчин үед санхүүгийн түрээс, үйл ажиллагаа (бизнес)-ны түрээс зэрэг түрээсийн харилцааны шинэлэг хэлбэрүүд бий болохын хэрээр эрсдэл болон ашиг орлого хуваах, татвар, нягтлан бодох бүртгэл, түрээсийн хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой илүү нарийвчилсан харилцаануудыг зохицуулах шаардлага бий болж байгаа нь судалгаанаас харагдаж байна.

# ТҮРЭЭСИЙН ХАРИЛЦААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫТУРШЛАГА

## 1.ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

### *Түрээсийн гэрээний ерөнхий нөхцөл*

Оросын Холбооны Улсын (ОХУ)-ын Иргэний хууль (ИХ)-ийн 34 дүгээр бүлэгт[120] зааснаар **түрээс** (эд хөрөнгийн түрээс)**-ийн гэрээгээр** түрээслүүлэгч нь түрээслэгчид эд хөрөнгөө тодорхой хугацаагаар төлбөртэй эзэмшүүлэх, ашиглуулахаар шилжүүлэх үүрэг хүлээнэ. Түрээслэгчийн түрээсэлж авсан эд хөрөнгийг гэрээний дагуу ашигласны үр дүнд бий болсон үр шим, бүтээгдэхүүн, орлого нь түүний өмч болно.

Түрээсийн **6 төрөл** байна. (ИХ-607) Үүнд:

- хөдлөх эд хөрөнгийн түрээс (прокат);
- тээврийн хэрэгслийн түрээс;
- барилга байгууламж, тоног төхөөрөмжийн түрээс;
- үйлдвэр, аж ахуйн газрын түрээс;
- санхүүгийн түрээс (лизинг);
- газрын түрээс

Эдгээрээс гадна орон сууц хөлслөх гэрээтэй холбоотой харилцааг ОХУ-ын Иргэний хуулийн 35 дугаарт бүлэгт[121] зохицуулсан байна.

Түрээсийн **гэрээний зүйл** нь ашиглалтын явцад үндсэн шинж чанараа алдахгүй буюу хэрэглээний бус (непотребляемые вещи) хэн нэгэн этгээдийн өмчлөлд байгаа эд хөрөнгө байна. Түрээсийн гэрээнд тавигдах нэг шаардлага бол түрээслүүлэгч нь түрээслэх эд хөрөнгийг тодорхой заах бөгөөд хэрэв заагаагүй бол уг гэрээг байгуулаагүйд тооцно. (ИХ-607.3)

**Түрээсийн гэрээний талууд:**

- Түрээслүүлэгч нь хуулиар эрх олгосон этгээд, эсхүл түрээслүүлэх эд хөрөнгийн өмчлөгч байна. (ИХ-608)
- Түрээслэгч нь ямар ч этгээд байх бөгөөд гэрээний зарим төрлүүдэд түрээслэгч нь дараах онцлогтой байна. Үүнд:
  - үйлдвэрлэлийн объектын түрээсийн (ИХ-656) болон санхүүгийн түрээс (лизинг)-ийн гэрээ (ИХ-608)-ний талууд нь хуулийн этгээд байна.
  - Ахуйн хэрэглээний хөдлөх хөрөнгийн түрээс (прокат)-ийн гэрээнд зөвхөн түрээслүүлэгч тал нь хуулийн этгээд байна.

Нэгээс дээш жилийн хугацаатай байгуулах түрээсийн гэрээг, мөн гэрээний нэг тал нь хуулийн этгээд байгаа тохиолдолд түрээсийн гэрээг хугацаа хамаарахгүйгээр бичгээр байгуулна. Үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээг улсын бүртгэлд бүртгүүлнэ. (ИХ-609)

**Түрээсийн гэрээний хугацаа** нь гэрээний үндсэн нөхцөл болохгүй. Хэрэв хугацааг гэрээнд тогтоогоогүй бол түрээсийн гэрээг тодорхой бус хугацаагаар байгуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд талууд гэрээнээс хэзээ ч татгалзаж болох бөгөөд гэрээнээс татгалзаж байгаа тал нь нөгөө талд энэ талаар 1 сар (үл хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээ бол 3 сар)-ын өмнө мэдэгдэх үүрэгтэй. Эсхүл энэ хугацааг хууль, гэрээгээр тогтоож болно. (ИХ-610)

Түрээслэгчийн үндсэн үүрэг бол **түрээсийн төлбөр**ийг хугацаанд нь төлөх юм. Түрээсийн төлбөрийг төлөх журам, нөхцөл, хугацааг түрээсийн гэрээгээр тодорхойлно. Хэрэв гэрээнд эдгээрийг тодорхойлоогүй бол ижил төстэй эд хөрөнгө түрээслэх гэрээтэй адил түрээсийн төлбөр төлөх журам, нөхцөл, хугацааг тогтооно. (ИХ-614.1)

Эд хөрөнгийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн түрээслэх тохиолдолд түрээсийн төлбөрийг

---

[120] Гражданский кодекс РФ. Часть вторая от 26 января 1996 г. N 14-ФЗ. Глава 34. Аренда.
[121] Гражданский кодекс РФ. Часть вторая от 26 января 1996 г. N 14-ФЗ. Глава 35. Наем жилого помещения.

дараах байдлаар тогтоож болно. (ИХ-614) Үүнд:

- төлбөрийн дүнг хатуу тогтоож, нэг удаа, эсхүл тогтмол хугацаанд төлөхөөр;
- түрээслэгчийн аж ахуйн үйл ажиллагааны үр дүнд бий болсон үр шимийн тодорхой хувийг авахаар;
- түрээслэгч тодорхой үйлчилгээ үзүүлэхээр;
- түрээслэгч нь гэрээний дагуу түрээслүүлэгчид эд юмс өмчлүүлэх, эсхүл түрээслүүлэхээр;
- түрээслэгч гэрээний дагуу түрээсэлж байгаа эд хөрөнгийг сайжруулсан зардлыг суутгахаар.

Талууд түрээсийн гэрээнд түрээсийн төлбөрийн мөнгөн болон бусад хэлбэрийг хослуулан хэрэглэж болно. Түрээсийн төлбөрийн хэмжээг талууд тохиролцон өөрчилж болно, гэхдээ жилд нэгээс илүүгүй удаа өөрчилнө. (ИХ-614) Түрээсийн гэрээний талуудын эрх, үүргийг Хүснэгт 1-ээр харуулав.

*Хүснэгт 1. Түрээсийн гэрээний талуудын эрх, үүрэг*

| Түрээслүүлэгчийн үүрэг | Түрээслэгчийн эрх | Тайлбар |
|---|---|---|
| Түрээслэгчид гэрээний дагуу эд хөрөнгө шилжүүлэх (ИХ-611.1) | | |
| Гэрээнд заасан хугацаанд түрээслэгчид түрээсийн эд хөрөнгийг шилжүүлэх (ИХ-611.3) | Хэрэв түрээслүүлэгч нь гэрээний дагуу түрээслэгчид түрээсийн эд хөрөнгийг шилжүүлээгүй тохиолдолд түрээслэгч дараах эрхтэй:<br>- Иргэний хуулийн 398-д заасны дагуу түрээсийн эд хөрөнгийг шаардах, хугацаа хоцроосны улмаас үүссэн алдагдлыг төлүүлэх,<br>- эсхүл гэрээг цуцлах, гэрээний үр дүнд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх (ИХ-611.3) | |
| Үл хөдлөх эд хөрөнгө түрээслэх бол түүний холбогдох хэрэглэгдэхүүн, баримт бичгийг хамт шилжүүлэх (ИХ-611.2) | Түрээслүүлэгчээс үл хөдлөх хөрөнгийн баримт бичгийг шилжүүлээгүй бол тэдгээрийг шаардах, эсхүл гэрээг цуцлах, хохирлыг нөхөн төлүүлэх (ИХ-611.2) | Түрээслүүлэгчээс үл хөдлөх хөрөнгийн баримт бичгийг шилжүүлээгүй үед түрээслэгч нь үл хөдлөх эд хөрөнгийг ашиглах боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд (ИХ-611.2) |
| Эд хөрөнгийн доголдлыг хариуцах (ИХ-612.1) | Хэрэв эд хөрөнгийн доголдол илэрсэн бол дараах эрхүүдээс сонголт хийнэ: (ИХ-612.1)<br>- түрээслүүлэгчээр эд хөрөнгийн доголдлыг арилгуулах<br>- түрээсийн хэмжээг багасгах,<br>- эд хөрөнгийн доголдлыг арилгах зардлыг нөхөн төлүүлэх;<br>- гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах. | Эд хөрөнгийн доголдлыг гэрээ байгуулахаас өмнө, эсхүл дараа нь илрүүлж болно. Харин доголдлыг илрүүлэх боломжтой, эсхүл шаардлага хангаж байгаа эсэхийг шалгахад доголдол илрээгүй бол хамаарахгүй. (ИХ-612.2) |
| | Хэрэв түрээслэгчээс үл хамаарах нөхцөл байдал үүссэн, гэрээнд заасан ашиглах нөхцөл өөрчлөгдсөн, эсхүл түрээсэлж байгаа эд хөрөнгийн байдал илт муудсан бол түрээслэгч нь түрээсийн төлбөрийн хэмжээг бууруулахыг түрээслүүлэгчээс шаардах эрхтэй. (ИХ-614.4) | |
| Тогтоосон хугацаанд түрээсийн | Хэрэв их засвар хийгээгүй бол | |

| | | |
|---|---|---|
| эд хөрөнгөнд их засвар хийх (ИХ-616.1) | дараах эрхүүдээс сонголт хийнэ:<br>- их засварын зардлыг түрээсийн төлбөрөөс суутгах;<br>- түрээсийн төлбөрийг зохих хэмжээнд буулгах;<br>- гэрээг цуцлах, хохирлыг нөхөн төлүүлэх. (ИХ-616.1) | |
| | Гуравдагч этгээдэд түрээслэх, шилжүүлэх эрхтэй (ИХ-615.1):<br>- эд хөрөнгийг дамжуулан түрээслэх (поднаем);<br>- гэрээнд заасан өөрийн эрх, үүргийг шилжүүлэх (перенаем). | Энэ тохиолдолд түрээслүүлэгчээс зөвшөөрөл авна. Эд хөрөнгийг дамжуулан түрээсэлсэн (поднаем) тохиолдолд түрээслэгч нь түрээслүүлэгчийн өмнө хариуцлага хүлээнэ. (ИХ-615.1) |
| **Түрээслэгчийн үүрэг** | **Түрээслүүлэгчийн эрх** | **Тайлбар** |
| Түрээсийн төлбөрийг хугацаанд нь төлөх (ИХ-614.1) | Хэрэв түрээслэгч нь төлбөрөө гэрээнд заасан хугацаанд төлөх үндсэн үүргээ зөрчвөл түрээсийн төлбөрийг хугацаанаас нь өмнө төлөхийг шаардаж болно. (ИХ-614.5) | |
| Түрээсэлж байгаа эд хөрөнгөнд тогтоосон хугацаанд өөрийн зардлаар урсгал засвар хийх (ИХ-616.1) | Хэрэв түрээслэгч нь энэ үүргээ биелүүлээгүй бол гэрээг цуцалж болно. | |
| Эд хөрөнгийг түрээсийн гэрээний дагуу ашиглах (ИХ-615.1) | Түрээслэгч нь эд хөрөнгийг гэрээний дагуу ашиглаагүй бол гэрээг цуцлах буюу хохирлыг нөхөн төлүүлнэ. (ИХ-615.3) | Хэрэв гэрээнд энэ талаар тусгайлан заагаагүй бол тухайн эд хөрөнгийн зориулалтын дагуу ашиглана. (ИХ-615.1) |
| Гэрээ дуусгавар болоход эд хөрөнгийг түрээслүүлэгчид гэрээний дагуу буцаан өгөх (ИХ-622) | Хэрэв түрээслэгч нь эд хөрөнгийг тогтоосон хугацаанд буцаан өгөөгүй бол тэрээр илүү ашигласан хугацааны түрээсийн төлбөр шаардах эрхтэй. (ИХ-622) | |

Түрээсийн **гэрээ дуусгавар болох** үндэслэл:

- гэрээний хугацаа дууссан;
- түрээслүүлэгч, эсхүл түрээслэгч хуулийн этгээд татан буугдсан (ИХ-419);
- гэрээг хугацаанаас нь өмнө цуцалсан:
    - талууд зөвшилцсөнөөр (ИХ-450.1);
    - нэг талын шаардсанаар (ИХ-619, 620);
    - түрээслэгч нь түрээсийн эд хөрөнгийн худалдан авсанаар (ИХ-624.1).

Дараах тохиолдлуудад түрээсийн **гэрээний талууд өөрчлөгдсөн ч гэрээ хэвээр хадгалагдана**. (ИХ-617) Үүнд:

- түрээсэлсэн эд хөрөнгийн өмчлөх эрх өөр хүнд шилжсэн нь түрээсийн гэрээг өөрчлөх буюу цуцлах үндэслэл болохгүй;
- түрээслүүлэгч нас барсан бол түүний эрх, үүргийг өв залгамжлагчид шилжинэ (энэ тохиолдолд түрээслэгч гэрээнээсээ татгалзаж болно).

Дор дурдсан үндэслэлээр талууд түрээсийн **гэрээг хугацаанаас нь өмнө цуцлахыг** шаардсанаар шүүх гэрээг хүчингүй болгоно. Үүнд:

- түрээслүүлэгчийн шаардсанаар (ИХ-619):
    - түрээслэгч нь эд хөрөнгийг ашиглахдаа гэрээний дагуу, эсхүл зориулалтын дагуу ашиглаагүй зөрчил удаа дараа давтагдсан бол;
    - эд хөрөнгийн байдлыг илт муутгасан бол;
    - гэрээнд заасан хугацаа дуусгавар болсноос хойш түрээсийн төлбөрийг 2-оос дээш удаа төлөөгүй бол;

- түрээслэгчийн шаардсанаар (ИХ-620):
  - түрээслүүлэгч нь гэрээний дагуу эд хөрөнгийг түрээслэгчид шилжүүлээгүй, эсхүл эд хөрөнгийг гэрээний дагуу, эсхүл зориулалтын дагуу ашиглахад саад учруулсан бол;
  - эд хөрөнгийн доголдол илэрсэн бол;
  - түрээслүүлэгч нь эд хөрөнгөнд тогтоосон хугацаанд их засвар хийгээгүй бол;
  - түрээслэгчээс үл хамаарч түрээсийн эд хөрөнгийг ашиглах боломжгүй нөхцөлд байдал үүссэн бол.

Түрээслүүлэгч нь түрээслэгчид гэрээгээр хүлээсэн үүргээ тодорхой хугацаанд биелүүлэх шаардлагатайг анхааруулсан бичиг явуулсаны дараа түрээсийн гэрээг хугацаанаас нь өмнө цуцлахыг шаардах эрхтэй. (ИХ-619)

Түрээсийн гэрээ дуусгавар болоход түрээслэгч нь түрээслүүлэгчид ***эд хөрөнгийн буцаан өгөх*** бөгөөд эд хөрөнгийг анх хүлээн авсан тэр байдлаар нь буцаан өгөхдөө элэгдэл тооцно, эсхүл энэ талаар гэрээнд нарийвчлан тусгана. Хэрэв түрээслэгч нь эд хөрөнгийг тогтоосон хугацаанд буцаан өгөөгүй бол түрээслүүлэгч хоцроосон хугацааны түрээсийн төлбөр шаардах эрхтэй. (ИХ-622)

***Хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээ (прокат)***

**Хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээ (прокат)**-гээр аж ахуйн зориулалттай эд хөрөнгийн түрээсийн үйл ажиллагааг тогтмол эрхэлж буй түрээслүүлэгч нь түрээслэгчид хөдлөх эд хөрөнгө (суудлын автомашин, цахилгаан бараа, тавилга, спортын тоноглол, хувцас гм)-ийг түр хугацаагаар төлбөртэй эзэмшүүлж, ашиглуулахаар шилжүүлэх үүрэг хүлээнэ. Энэ нь нийтийн гэрээ бөгөөд **бичгээр** байгуулна. Түрээслэгч нь түрээсийн эд хөрөнгийг хэрэглээний зорилгоор ашиглана. (ИХ-626)

Хөдлөх эд хөрөнгийн түрээсийн **гэрээний хугацаа** нь хязгаартай буюу нэг хүртэл жил байна. Энэ гэрээг шинэчлэн байгуулахгүй, харин түрээслэгч нь гэрээнээс хэдийд ч татгалзаж болох бөгөөд энэ талаар түрээслүүлэгчид 10 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ. (ИХ-627)

**Түрээслүүлэгч** нь ашгийн төлөө хуулийн этгээд, эсхүл хувиараа аж ахуй эрхлэгч байх бөгөөд дараах үүрэг хүлээнэ:

- түрээсийн эд хөрөнгийг шилжүүлэхээс өмнө бүрэн бүтэн байдлыг нь түрээслэгчийн дэргэд шалгаж, түүнд эд хөрөнгө ашиглах зааварчилгааг өгөх (ИХ-628);
- түрээслүүлэх эд хөрөнгийн урсгал болон их засварыг хийх (ИХ-631.1).

Түрээсэлсэн эд хөрөнгийг дамжуулан түрээслэх, гэрээнд заасан эзэмших, ашиглах эрхээ гуравдагч этгээдэд шилжүүлэх, үнэ төлбөргүй эзэмших, ашиглах болон нөхөрлөл, нийгэмлэгт хувь оруулах маягаар шилжүүлэн өгөхийг **түрээслэгчид** хориглоно. (ИХ-631.2)

Хэрэв хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээ (прокат)-ний түрээслэгч тал нь иргэн бол холбогдох эрх зүйн харилцааг ОХУ-ын Иргэний хуулиас[122] гадна Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай[123] хуулиар зохицуулна.

***Тээврийн хэрэгслийн түрээсийн гэрээ***

ОХУ-ын Иргэний хуулиар[124] **тээврийн хэрэгслийн түрээсийн гэрээнд** түрээслүүлэгч нь түрээслэгчид тээврийн хэрэгслийг түр хугацаагаар төлбөртэй эзэмшүүлж, ашиглуулахаар шилжүүлэх үүрэг хүлээнэ. Гэрээний хоёр төрөл байх ба гэрээний төрлөөс хамаарч гэрээний үүргийг ялгаатай биелүүлнэ. (ИХ-632, 642) Тодруулбал:

---

[122] Гражданский кодекс РФ. Часть вторая, Глава 34.Аренда, §2.Прокат, Статья 626-631.
[123] Закон РФ от 7 февраля 1992 г. № 2300-1 О защите прав потребителей.
[124] Гражданский кодекс РФ. Часть вторая, Глава 34.Аренда, §3.Аренда транспортных средств, Статья 632-649.

1. **жолоодлогын удирдлагын багтай тээврийн хэрэгслийн түрээсийн гэрээнд -** түрээслүүлэгч нь өөрийн хүчээр тээврийн хэрэгслийн жолоодлогын удирдлага, техник ашиглалтын үйлчилгээг үзүүлнэ (ИХ-632);
2. **жолоодлогын удирдлагын баггүй тээврийн хэрэгслийн түрээсийн гэрээнд -** түрээслүүлэгч нь дээрх үйлчилгээг үзүүлэхгүй (ИХ-642).

Энэ хоёр төрлийн гэрээний эрх зүйн зохицуулалтанд талуудын үүргийн ялгааг Хүснэгт 2-оос үзнэ үү.

*Хүснэгт 2. Тээврийн хэрэгслийн түрээсийн гэрээний төрлүүд дэх талуудын үүргийн ялгаа*

| Хариуцах үүрэг | Жолоодлогын удирдлагын багтай тээврийн хэрэгслийн түрээсийн гэрээгээр | Жолоодлогын удирдлагын баггүй тээврийн хэрэгслийн түрээсийн гэрээгээр |
|---|---|---|
| тээврийн хэрэгслийн техник ашиглалт | **түрээслүүлэгч** (ИХ-632, 635) | **түрээслэгч** (ИХ-645) |
| гэрээний хугацаанд тээврийн хэрэгслийг зохих байдалд байлгах, урсгал болон их засвар | **түрээслүүлэгч** (ИХ-634) | **түрээслэгч** (ИХ-644) |
| тээврийн хэрэгслийг заавал даатгах үүргийг | **түрээслүүлэгч** (ИХ-637) | **түрээслэгч** (ИХ-646) |
| гуравдагч этгээдийн тээврийн хэрэгсэлд гэмтэл учруулсан бол хариуцлага хүлээх | **түрээслүүлэгч** (ИХ-640, 1079) | **түрээслэгч** (ИХ-648) |
| тээврийн хэрэгслийн үйл ажиллагаатай холбоотой гарах зардлыг | **түрээслэгч** (ИХ-636) | **түрээслэгч** (ИХ-646) |
| тээврийн хэрэгсэлд гэмтэл учруулсан, эсхүл бүрэн ажиллагаагүй болгосон, үүнийг түрээслүүлэгчээс түрээслэгчийн хууль, эсхүл гэрээгээр хүлээсэн хариуцлага болохыг нотолсон бол хохирлыг барагдуулах | **түрээслэгч** (ИХ-639) | - |

Тээврийн хэрэгслийн түрээсийн гэрээний объект нь зорчигч, ачаа тээш зөөвөрлөх зориулалт бүхий тээврийн хэрэгсэл байна.

Тээврийн хэрэгслийн түрээсийн гэрээг бичгээр байгуулах бөгөөд улсын бүртгэлд бүртгэхгүй (ИХ-633, 643), мөн хугацааны хязгаар тавигдаагүй.

### ***Барилга байгууламж, тоног төхөөрөмжийн түрээсийн гэрээ***

ОХУ-ын Иргэний хуулийн[125] 650 дугаар зүйлд зааснаар **барилга байгууламж, тоног төхөөрөмжийн түрээсийн гэрээгээр** түрээслүүлэгч нь түрээслэгчид барилга, эсхүл тоног төхөөрөмжийг түр хугацаагаар эзэмшүүлж, ашиглуулахаар шилжүүлэх үүрэг хүлээнэ. Энэхүү гэрээнд Иргэний хуульд заасан үйлдвэрийн газрыг түрээслэх гэрээтэй холбоотой зарим харилцаа хамаарна.

Барилга байгууламж, тоног төхөөрөмжийн түрээсийн гэрээг **бичгээр** байгуулж, талууд гарын үсэг зурна. Гэрээний хэлбэрийг мөрдөөгүй бол уг гэрээг байгуулаагүйд тооцно. Нэг жилээс доошгүй хугацаагаар байгуулсан гэрээг улсын бүртгэлд бүртгэх бөгөөд гэрээг бүртгэснээр хүчин төгөлдөр болсонд тооцогдоно. (ИХ-651)

Барилга байгууламж, тоног төхөөрөмжийн түрээсийн гэрээ нь дараах онцлогтой байна:

[125] Гражданский кодекс РФ. Часть вторая, Глава 34.Аренда, §4.Аренда зданий и сооружений, Статья 656-664.

- Гэрээнд түрээсийн төлбөрийг заавал заах бөгөөд хэрэв гэрээний энэ нөхцөлийг хангаагүй бол уг гэрээг байгуулаагүйд тооцно (ИХ-654.1);
- Түрээслүүлсэн барилга, тоног төхөөрөмж байрласан тухайн газрын эрхийг түрээслэгчид шилжүүлнэ (ИХ-652.1);
- Хэрэв түрээслүүлсэн барилга, тоног төхөөрөмж байрласан газрыг өөр этгээдэд худалдсан бол тухайн газрыг ашиглах эрх түрээслэгчид хадгалагдана (ИХ-653);
- Түрээслүүлэгч гэрээний зүйлийг түрээслэгчид шилжүүлэхэд эд хөрөнгийн акт үйлдэж, талууд гарын үсэг зурна (ИХ-655.1).

***Үйлдвэрийн газрын түрээсийн гэрээ***

ОХУ-ын Иргэний хуулийн[126] 656 дугаар зүйлд зааснаар **үйлдвэрийн газрын түрээсийн гэрээгээр** түрээслүүлэгч нь түрээслэгчид газар, барилга байгууламж, тоног төхөөрөмж болон үйлдвэрлэлийн бусад үндсэн бүрэлдэхүүн хэсгийг түр хугацаагаар, төлбөртэйгээр, гэрээнд заасан журам, нөхцөл, хязгаарын дагуу эзэмшүүлж, ашиглуулахаар шилжүүлэх үүрэг хүлээнэ. Гэрээнд заасан журам, нөхцөл, хязгаарт түүхийн эдийн нөөц, шатахуун, эргэлтийн хөрөнгүүд, газар, усан дээрх объект болон байгалийн баялгийг ашиглах эрх, барилга байгууламж, үйлдвэрлэлийн объекттой холбоотой түрээслүүлэгчийн бусад өмчийн эрх, үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбоотой эрх болон бусад холбогдох эрх, мөн үйлдвэрлэлийн объектод хамааралтай шилжүүлэх өр зэрэг хамаарна. Харин түрээслүүлэгчийн холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл буюу лицензийг түрээслэгчид шилжүүлэхгүй.

Үйлдвэрийн газрын түрээсийн гэрээг **бичгээр** байгуулах бөгөөд талууд гарын үсэг зурсан байна. Энэ төрлийн гэрээг улсын бүртгэлд бүртгэх бөгөөд түүнийг бүртгэснээр гэрээ хүчин төгөлдөр болсонд тооцно. (ИХ-658)

Түрээслүүлэгч үйлдвэрийн газрыг түрээслэгчид шилжүүлэхэд эд хөрөнгийн акт үйлдэж, талууд гарын үсэг зурна. Түрээслүүлэгч нь үүнтэй холбоотой үүрэг, холбогдох зардлыг хариуцна. (ИХ-659)

Түрээслэгч нь үйлдвэрийн газрын үндсэн үнийг буулгахгүй, гэрээний нөхцөлийг зөрчөөгүй бол түрээслүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр (гэрээнд өөрөөр заагаагүй бол) үйлдвэрийн газрын бүрэлдэхүүнд хамаарах хөрөнгийг зарах, солих, түр ашиглуулах, зээлдэх, мөн дамжуулж хөлслүүлэх, өөрийн гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бусдад шилжүүлэх эрхтэй. (ИХ-660)

Түрээслэгч нь дараах үүргийг хүлээнэ (ИХ-661):

- гэрээний хугацаанд үйлдвэрийн газрыг зохист байдалд байлгах, урсгал болон их засварыг хариуцах;
- үйлдвэрийн газрын үйл ажиллагаатай холбоотой зардал, эд хөрөнгийн даатгалыг хариуцах.

***Санхүүгийн түрээс (лизинг)-ийн гэрээ***

Санхүүгийн түрээс (лизинг)-ийн гэрээтэй холбоотой эрх зүйн харилцааны үндсэн зохицуулалтыг ОХУ-ын Иргэний хууль[127], нарийвчилсан зохицуулалтыг Санхүүгийн түрээс (лизинг)-ийн тухай[128] хуулиар тус тус зохицуулж байна.

Санхүүгийн түрээсийн гэрээгээр түрээслүүлэгч нь түрээслэгчийн заасан эд хөрөнгийг тодорхой худалдагчаас түүний өмчлөлд авч өгөх буюу тухайн эд хөрөнгийг түр хугацаагаар төлбөртэйгээр түрээслэгчийн эзэмшил, ашиглалтад шилжүүлэх үүрэг хүлээнэ. Энэ тохиолдолд түрээслүүлэгч нь түрээсийн зүйлийн сонголт болон худалдагчийн өмнөөс хариуцлага хүлээхгүй. Түрээслүүлэгч нь худалдагч болон худалдан авсан эд хөрөнгийг сонгож болох эсэхийг санхүүгийн түрээсийн гэрээгээр тогтоож болно. (ИХ-665)

---

[126] Гражданский кодекс РФ. Часть вторая, Глава 34.Аренда, §4.Аренда предприятий, Статья 650-655.
[127] Гражданский кодекс РФ. Часть вторая, Глава 34.Аренда, §6.Финансовая аренда (лизинг), Статья 665-670.
[128] Федеральный закон от 29 октября 1998 г. № 164-ФЗ “О финансовой аренде (лизинге)”. Эх сурвалж: www.consultant.ru

Гэрээний зүйлийг Иргэний хуулийн 607, 666-д “газар, бусад байгалийн объектоос бусад хэрэглээний бус (непотребляемые вещи) эд хөрөнгө”, харин Санхүүгийн түрээс (лизинг)-ийн тухай хуулийн 3.1-т “хэрэглээний бус эд хөрөнгө, үүнд үйлдвэр болон бусад цогцолбор хөрөнгө, барилга, байгууламж, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл болон бусад хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө” байхаар тус тус хуульчилсан байна.

Санхүүгийн түрээсийн гэрээний онцлог нь гэрээг удаан хугацаагаар байгуулах ба гэрээ дуусгавар болоход түрээслэгч эд хөрөнгийг өөрийн өмчлөлд авна. Санхүүгийн түрээс (лизинг)-ийн тухай хуулийн 11.1-д зааснаар гэрээний зүйлийн өмчлөх эрх нь түрээслүүлэгчид байх боловч энэ эрх нь санхүүгийн түрээсийн гэрээний нөхцөлөөр хязгаарлагддаг байна. Энэ хуулийн 17-д зааснаар түрээслүүлэгч нь өмчийг түрээслэгчийн эзэмшил, ашиглалтад шилжүүлнэ. Гэрээ дуусгавар болоход буюу гэрээний дагуу төлбөрийг төлж дуусахад гэрээний зүйлийн өмчлөх эрх түрээслэгчид шилжихийг Санхүүгийн түрээс (лизинг)-ийн тухай хуулийн 19.1-д заасан байна.

Энэ гэрээний өөр нэг онцлог бол гэрээний талууд нь түрээслүүлэгч, түрээслэгчээс гадна гуравдагч субъект буюу худалдагч байна.

***Газрын түрээсийн гэрээ***

Газрын түрээсийн гэрээний эрх зүйн харилцааны үндсэн зохицуулалтыг Иргэний хуулийн 34 дүгээр бүлэгт[129] тусгасан, харин нарийвчилсан зориулалтыг Газрын тухай хуулийн 22 дугаар зүйл[130], Ойн тухай (2006)[131], Усны тухай (2006)[132], Газрын хэвлийн тухай (1992)[133] хуулиудаар зохицуулна.

Гадаадын иргэн, харьяалалгүй хүн ОХУ-ын нутаг дэвсгэрт түрээсийн харилцаа үүсгэн газар ашиглаж болохыг Газрын тухай хууль (ГТХ)-д заасан байна. (ГТХ-22.1)

Газрын түрээсийн гэрээнд дараах нийтлэг зохицуулалт үйлчилнэ:

- Түрээслүүлэгч нь түрээслүүлэх эд хөрөнгийн өмчлөгч байна. (ИХ-608)
- Газрын түрээсийн гэрээг улсын бүртгэлд бүртгүүлнэ. (ИХ-609)
- Түрээсийн гэрээний хугацаа нь гэрээний үндсэн нөхцөл болохгүй. (ИХ-610)
- Түрээслэгч нь хуульд заасан хязгаарын хүрээнд газрыг дамжуулан түрээслүүлэх эрхтэй (ИХ-615.1, ГТХ-22.5).

Энэ гэрээ нь эрх зүйн дараах онцлог зохицуулалттай байна. Үүнд:

- Гэрээний **объект** нь Холбооны аюулгүй байдлын албаны объектоос бусад газар байна. (ГТХ-22.2)
- Түрээсийн төлбөрийн хэмжээг гэрээний нөхцөлд тусгана. (ГТХ-22.4, 22.12)

***Орон сууц хөлслөх гэрээ***

ОХУ-ын Иргэний хуулийн 35 дугаарт бүлэгт[134] зааснаар **орон сууц хөлслөх гэрээгээр** хөлслүүлэгч нь хөлслөгчид орон сууцыг сууцны зориулалтаар төлбөртэй эзэмшүүлэх, ашиглуулахаар шилжүүлэх үүрэг хүлээнэ. Хуулийн этгээдийн хувьд түрээсийн гэрээ буюу бусад гэрээний үндсэн дээр эзэмшүүлэх, ашиглуулах зорилгоор орон сууцыг олгож болох ба орон сууцыг зөвхөн сууцны зориулалтаар ашиглана. (ИХ-671)

Гэрээний талууд болох хөлслүүлэгч нь орон сууц өмчлөгч, эсхүл итгэмжлэгдсэн этгээд (ИХ-671) байх бол хөлслөгч нь зөвхөн хувь хүн (ИХ-677.1) байна.

Төрийн болон орон нутгийн нийгмийн орон сууцны сангууд нийгмийн орон сууц хөлслөх гэрээгээр иргэдэд орон сууц хөлслүүлнэ. Нийгмийн орон сууц хөлслөх гэрээний

---

129 Гражданский кодекс РФ. Часть вторая от 26 января 1996 г. N 14-ФЗ. Глава 34. Аренда.
130 Земельный кодекс РФ от 25 октября 2001 г. № 136-ФЗ.
131 Лесной кодекс РФ от 4 декабря 2006 г. № 200-ФЗ.
132 Водный кодекс РФ от 3 июня 2006 г. № 74-ФЗ.
133 Закон РФ от 21 февраля 1992 г. № 2395-1 “О недрах”.
134 Гражданский кодекс РФ. Часть вторая от 26 января 1996 г. N 14-ФЗ. Глава 35. Наем жилого помещения.

дагуу амьдарч байгаа гэр бүлийн гишүүд нь хөлслөгчийн адил эрх, үүрэгтэй байна. (ИХ-672)

Зөвхөн хувь хүн орон сууцанд амьдрах зориулалтаар орон сууц хөлслөх гэрээ байгуулна, харин орон сууц хөлслөгч нь хуулийн этгээд байгаа тохиолдолд өмнө нь дурдагдсан түрээсийн гэрээг байгуулна.

Орон сууц хөлслөх гэрээний зүйл нь байнга оршин суухад нийцсэн, тусгаарлагдсан сууц (сууц, байшин, сууц, эсхүл байшингийн нэг хэсэг) байна. Оршин суухад нийцэх гэдгийг орон сууцны тухай хууль тогтоомжид заасан журмын дагуу тодорхойлно. (ИХ-673)

Энэ гэрээг **бичгээр** байгуулах бөгөөд талууд гарын үсэг зурсан байна. Нэг жилээс доошгүй хугацаагаар байгуулсан гэрээг улсын бүртгэлд бүртгэнэ. (ИХ-674)

Хөлслүүлэгчийн үүрэг:

- хөлслөгчид сууцны зориулалттай сул орон сууцыг шилжүүлэх (ИХ-676);
- орон сууцанд засвар, үйлчилгээ хийх (ИХ-676);
- гэрээнд өөрөөр заагаагүй бол орон сууцны их засвар хийх (ИХ-681.2);
- орон сууц хөлслөх гэрээг 5 жилээс илүүгүй хугацаагаар байгуулах бөгөөд хэрэв гэрээнд ингэж заагаагүй бол гэрээг таван жилийн хугацаагаар байгуулсанд тооцно (ИХ-683.1).

Хөлслөгчийн үүрэг:

- орон сууц хөлслөх гэрээний нөхцөлийн дагуу хугацаандаа төлбөр төлөх (ИХ-678, 682.3);
- орон сууц хөлслөх гэрээний нөхцөлд хөлслөгчтэй хамт байнга амьдрах хүний талаар гэрээнд тусгах (ИХ-677.2) бөгөөд гэрээнд өөрөөр заагаагүй бол хамт байнга амьдрах хүн нь гэрээний үүргийг зөрчсөн бол түүний өмнөөс хариуцлага хүлээх (ИХ-676);
- орон сууцыг зөвхөн оршин суух зориулалтаар ашиглах, сууцны аюулгүй байдлыг хангах, зохистой нөхцөлийг хэвээр хадгалах (ИХ-678);
- зээлдүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр сууцны барилгыг сэргээн босгох, сэргээн засварлалт хийхгүй байх(ИХ-678);
- гэрээнд өөрөөр заагаагүй бол орон сууцны урсгал засвар хийх (ИХ-681.1).

Хөлслөгч нь орон сууц хөлслөх гэрээний хугацаа дуусгавар болоход орон сууцны байрны гэрээгээ үргэлжлүүлэн сунгах давуу эрхтэй бөгөөд хөлслүүлэгч гэрээний хугацаа дуусахаас 3 сарын өмнө энэ талаар санал болгоно. Харин хөлслүүлэгч нь гэрээг сунгахгүй бол энэ талаар гэрээний нөгөө талд 1-ээс жилийн өмнөөс урьдчилан хэлэх үүрэгтэй. (ИХ-684)

Хөлслөгчийн эрх:

- хөлсөлж байгаа орон сууцыг хөлслүүлэгчийн зөвшөөрөлтэй дамжуулан хөлслүүлэх (ИХ-681.1);
- хөлслөгчтэй хамт байнга амьдрах хүнийг хөлслүүлэгчийн зөвшөөрөлтэйгээр өөрчлөх (ИХ-686.1);
- орон сууц хөлслөх гэрээг цуцлах (гэрээ цуцлах хүсэлтээ 3 сарын өмнө бичгээр урьдчилан мэдэгдэнэ) (ИХ-687.1).

## 2.БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ) нь түрээсийн харилцааны тухай бие даасан хуульгүй бөгөөд энэхүү харилцааг Иргэний хууль (Civil Act)[135], Худалдааны тухай хууль (Commercial Act)[136], Орон сууцны түрээсийн тухай хууль (Housing Lease Protection Act)[137],

[135] https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=40944&lang=ENG
[136] https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=29875&lang=ENG
[137] https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=39955&lang=ENG

Худалдааны зориулалттай барилга байгууламжийн түрээсийн тухай хууль (Commercial Building Lease Protection Act)[138] болон холбогдох бусад хууль тогтоомжоор тус тус зохицуулж байна.

Түрээсийн эрхийн харилцааг **Иргэний хуулийн** I хэсгийн VI дугаар дэд хэсэг (Барьцаа төлбөрийн үндсэн дээр түрээслэх эрх)-ийн 303-319 дүгээр зүйлээр зохицуулсан байна. Үүнд:

303-р зүйл. Түрээслэх эрхийн тухай;
304-р зүйл. Бусдын газар дээрх үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх болон түрээслэх эрх;
305-р зүйл. Барилга байшин болон бусдын газар дээрх үл хөдлөх эд хөрөнгө түрээслэх эрх;
306-р зүйл. Түрээслэх эрхийг шилжүүлэх болон түрээслэгч этгээд бусдад түрээслэх;
307-р зүйл. Түрээслэх эрхийг шилжүүлснээс үүдэх харилцаа;
308-р зүйл. Давхар түрээслүүлэхэд хүлээх хариуцлага;
309-р зүйл. Түрээслэгч засвар үйлчилгээний тал дээр хүлээх үүрэг;
310-р зүйл. Түрээсийн төлбөрийн нэхэмжлэл;
311-р зүйл. Түрээслэх эрхийг цуцлах нэхэмжлэл;
312-р зүйл. Түрээслэх эрхийн хугацаа;
312-2 зүйл. Түрээсийн урьдчилгаа төлбөрийг өсгөх болон бууруулах хүсэлт гаргах;
313-р зүйл. Түрээсийн гэрээг цуцлах мэдэгдэл;
314-р зүйл. Байгалийн гамшгаас шалтгаалан учрах хохирол;
315-р зүйл. Түрээслэгчийн хохирол барагдуулах хариуцлага;
316-р зүйл. Түрээсэлсэн эд хөрөнгийг үндсэн байдлаар нь хүлээлгэн өгөх;
317-р зүйл. Түрээсийн гэрээг дуусгавар болгох;
318-р зүйл. Түрээслэгч түрээсийн эд хөрөнгийг дуудлага худалдаанд оруулах тухай хүсэлт гаргах;
319-р зүйл. Холбогдох бусад зүйл заалт.

Барьцаа төлбөр төлж бусдын үл хөдлөх эд хөрөнгийг түрээслэх эрх эзэмшсэн хэн боловч тухайн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, ашиг олох эрхтэй байна. Тариалангийн газрыг түрээсийн зорилгоор ашиглахгүй. Барилгын түрээс, бусдын газар дээрх үл хөдлөх эд хөрөнгө түрээслэх эрхийн хувьд уг түрээсийн эрх нь тухайн үл хөдлөх хөрөнгө, бусдын газар дээрх хөрөнгийг өмчлөх эрх бүхий этгээдэд хамаардаг байна.

Түрээсийн гэрээгээр хориглоогүй тохиолдолд түрээслэгч нь түрээслэх эрхээ шилжүүлэх болон давхар түрээсийн гэрээ байгуулж болно. Түрээслэх эрхийг шилжүүлэн авсан түрээслэгч нь үндсэн түрээслэгчтэй адил эрх, үүрэг хүлээнэ. Гэрээнд өөрөөр заагаагүй тохиолдолд түрээслэгч нь давхар түрээсийн хугацаанд учирсан хохирлыг арилгах үүрэг хүлээнэ.

Түрээслэгч нь түрээсийн эд хөрөнгөний бүрэн бүтэн байдлыг хангаж, шаардлагатай засвар үйлчилгээг хийнэ. Түрээслэгч нь түрээслүүлэгчийн шаардсаны дагуу түрээсийн эд хөрөнгийг сайжруулан засварлахад өөрийн зүгээс гаргасан зардлыг түрээслүүлэгчээс шаардах эрхтэй. Хэрэв түрээслэгч нь гэрээнд заасны дагуу түрээсийн эд хөрөнгийг хэрэглэх, мөн түрээсийн эд хөрөнгөнөөс ашиг олж чадахгүй байгаа тохиолдолд түрээсийн гэрээгээ цуцлахыг шаардах эрхтэй. Түрээслүүлэгч нь түрээсэлж буй эд хөрөнгөө анх хүлээлгэн өгсөн байдлаар нь буцаан авах, алдагдлыг нөхөн төлөхийг шаардах эрхтэй.

Түрээслэх эрхийн хүчинтэй хугацаа нь 10 жилээс илүү байж болохгүй бөгөөд холбогдох этгээдийн хувьд хэрэв 10 жилээс урт хугацаагаар хийсэн тохиолдолд түүнийг богиносгож тооцно. Барилга түрээслэхтэй холбоотой түрээсийн гэрээг 1 жилээс богино хугацаагаар хийсэн тохиолдолд 1 жилээр сунгаж тооцно. Түрээсийн гэрээнд өөрчлөлт оруулж болох ба өөрчлөлт орсон өдрөөс эхлэн 10 жилээс урт хугацаатай байж болохгүй. Гэрээнд түрээсийн хугацааг заагаагүй тохиолдолд гэрээнд оролцогч талуудын аль нэг нь гэрээгээ цуцлах тухай саналаа нөгөө талд мэдэгдэж болно. Мэдэгдлийг хүлээн авснаас хойш 6 сарын дараа гэрээг дуусгавар болгоно.

Хэрэв байгалийн гамшгийн улмаас түрээсийн эд хөрөнгө бүхэлдээ, эсхүл тодорхой

---

[138] https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=40757&lang=ENG

хэсэг нь эвдэрч хэмхрэн, ашиглах боломжгүй болсон тохиолдолд тухайн хэсгийг түрээсийн төлбөрөөс хасч тооцуулах эрхтэй. Түүнчлэн түрээсийн эд хөрөнгөний гамшигт өртөөгүй үлдсэн хэсгийг түрээсийн гэрээнд зааснаар ашиглах боломжгүй болсон тохиолдолд түрээслэгч нь түрээслүүлэгчид гэрээгээ дуусгах тухай хүсэлт гаргах эрхтэй бөгөөд урьдчилгаа төлбөрөө буцаан нэхэх эрхтэй байна.

Түрээсийн гэрээг мөн хуулийн III хэсгийн II дэд хэсэг (Гэрээ)-ийн 618-654 дүгээр зүйлээр зохицуулсан байна.

Түрээсийн гэрээ нь, түрээслүүлэгч бусдад эд хөрөнгөө ашиглахыг зөвшөөрөн үүнээсээ ашиг олж, түрээслэгч нь эд хөрөнгө ашигласны төлбөр төлөхийг зөвшөөрсөн нөхцөлд хэрэгжиж эхэлнэ. Эд хөрөнгийн түрээсийн төлбөр нь байшин барилгатай холбоотой бол сар бүр, газартай холбоотой бол жил бүр төлөгдөнө. Эд хөрөнгө түрээслэх гэрээ нь доор заасан хугацаанаас хэтрэхгүй байна:

1. ургамал, ногоо тариалах, давс олборлох (шүүх), чулуу, шохойн чулуу, тоосгоор барилга байгууламж барих зориулалтаар газар түрээслэхэд 10 жил;
2. бусад зориулалтаар газар түрээслэхэд 5 жил;
3. барилга байгууламж түрээслэхэд 3 жил;
4. хөдлөх эд хөрөнгө түрээслэхэд 6 сар байна.

Дээр дурдсан хугацааг сунгаж болох бөгөөд хугацаа дуусгавар болохоос өмнө буюу газрыг 1 жил, барилга байгууламжийг 3 сар, хөдлөх хөрөнгийг 1 сарын өмнө сунгах боломжтой байна. Эд хөрөнгө түрээслэх тухай гэрээнд хугацаа заагаагүй бол холбогдогч тал хэдийд ч гэрээнээс татгалзах тухай мэдэгдэл гаргаж болно.

Үл хөдлөх эд хөрөнгийг түрээслэгч нь түрээслүүлэгчтэй харилцан тохиролцож, түрээсийн гэрээгээ бүртгүүлнэ. Түрээслэгч этгээдийн хувьд түрээсийн гэрээнд тухайн хөрөнгийн хууль ёсны эзэмшигч мөн эсэх, түрээсийн эрхийг гуравдагч этгээдэд шилжүүлэх, давхар түрээсийн зохицуулалт, түрээсийн төлбөрийг өсгөх, бууруулах шаардлага гаргах, түрээсийн татварын зохицуулалт, гэрээг дуусгавар болгохыг шаардах эрхийн талаар зайлшгүй тусгасан байна.

БНСУ-д 2 төрлийн түрээсийг тусгайлсан хуулиар зохицуулсан байна. Үүнд:

- орон сууцны түрээс (housing lease);
- худалдааны зориулалттай барилга байгууламжийн түрээс (commercial building lease).

Иргэд дээрх 2 төрлийн түрээсийн харилцаанд ороход энэ талаар зохицуулсан хууль, эрх зүйн орчин хангалтгүй байсны улмаас ихэвчлэн түрээслэгч тал (урьдчилгаа төлбөрөө буцаан авч чадахгүй гэх мэт) хохироод үлддэг байдал түгээмэл байсан учраас энэхүү харилцааг нарийвчлан зохицуулсан хуулиудыг батлан, хэрэгжүүлж эхэлсэн байна.

Орон сууцны түрээсийг 1981 онд батлагдсан **Орон сууцны түрээсийн тухай хуулиар** зохицуулна. Тус хууль нь Иргэний хуулиар зохицуулсан орон сууцны түрээстэй холбогдсон харилцааг илүү нарийвчилсан бөгөөд иргэдийг амар тайван аж төрөх баталгаагаар хангахад чиглэгдсэн байна. Тус хуулиар түрээслэгч нь харьяа нутаг дэвсгэрийнхээ засаг захиргааны байгууллагад хандан орон сууцны түрээсийн бүртгэлд бүртгүүлэх ёстой байна. Хэрэв түрээслэгч нь түрээсийн бүртгэлд бүртгүүлээгүй ч иргэнийхээ үүргээр оршин суугаа газраа бүртгүүлсэн тохиолдолд түрээстэй холбоотой аливаа маргаан үүсэхэд түрээслэгчийн эрхийг хамгаалах зохицуулалтуудыг хуульд оруулсан байна.

Худалдааны зориулалттай барилга байгууламжийн түрээсийг 2001 онд батлагдсан **Худалдааны зориулалттай барилга байгууламжийн түрээсийн тухай хуулиар** зохицуулдаг байна. Тус хуулиар түрээсийн харилцаанд орж буй санхүүгийн хувьд эмзэг худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийг хохирохоос сэргийлэх зорилготой зохицуулалтуудыг хуульчилсан байна. “Орон сууцны түрээсийн тухай хууль”-ийн хэрэгжилтэд үндэслэн тус хуулийг батлан, хэрэгжүүлж эхэлсэн байна.

Солонгос Улсад орон байрны түрээсийн төлбөрийн “jeongsei”, “wolsey” гэсэн

хэлбэрүүд ашиглагдаж байна.[139]

“Jeongsei” буюу бүтэн барьцаатай түрээсийн байрыг түрээслэгч нь байрны эзэнд тодорхой хэмжээний мөнгийг барьцаа болгон өгч, тодорхой хугацааны турш тухайн байранд оршин сууж байгаад гэрээний хугацаа дуусахад барьцааны мөнгөө эргүүлж авна. Барьцааны мөнгө байрны үнийн 25-70 хувьтай тэнцдэг байна.

“Wolsey” буюу сарын түрээсээр байр түрээслэгч нь тодорхой хэмжээний барьцаа төлөхийн хамт сар бүр түрээсийн төлбөр төлдөг байна. Барьцааны мөнгө их бол сар бүрийн түрээсийн төлбөрийн хэмжээ багасч, барьцааны мөнгө бага бол сарын түрээсийн төлбөр тэр хэмжээгээр ихэсдэг байна.

Түүнчлэн түрээсийн нийт хугацааны (1-3 жил) төлбөрийг төлөөд байр түрээслэх хэлбэр мөн байдаг байна. Энэ тохиолдолд түрээслүүлэгч нь урьдчилгаа төлбөр шаарддаггүй байна.

Мөн БНСУ-д түрээсийн дараах хэлбэрүүд байна. Үүнд:

- санхүүгийн түрээс (finance lease)[140];
- үйл ажиллагааны түрээс (operating lease)

***Санхүүгийн түрээс***

Санхүүгийн түрээс буюу капитал түрээс гэдэг нь түрээслэгч (үйлчлүүлэгч болон зээлдэгч) түрээслүүлэгчийн (санхүүгийн компани) үйлдвэрлэсэн болон гуравдагч этгээдээс худалдан авсан хөрөнгийг (тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, программ хангамж гэх мэт) сонгон түрээслэх ба улмаар худалдан авахыг хэлнэ. Санхүүгийн түрээсийг **Худалдааны тухай хуулийн** 168 дугаар зүйлээр зохицуулсан байна. Тус хуульд санхүүгийн түрээсийн хөрөнгө буюу машин, тоног төхөөрөмж, үйлчилгээ болон бусад эд хөрөнгийг түрээслэгч болон түрээслүүлэгчийн эрх, ханган нийлүүлэгч гуравдагч этгээдийн эрх, санхүүгийн түрээсийг цуцлах нөхцөл болон талуудын хүлээх үүрэг, хариуцлага зэргийг хуульчлан зохицуулсан байна.

***Үйл ажиллагааны түрээс***

Харьцангуй богино хугацаанд хөдлөх хөрөнгийг үйл ажиллагаандаа авч ашиглахыг үйл ажиллагааны түрээс гэнэ. Санхүүгийн түрээстэй харьцуулахад үйл ажиллагааны түрээс нь богино хугацаатай байх ба түрээсийн төлбөр нь илүү өндөр байна. Үйл ажиллагааны түрээсийн хугацаа дуусахад түрээсийн эд хөрөнгө түрээслүүлэгчид үлдэнэ. Тус улсад үйл ажиллагааны түрээсийг үйлдвэрийн тоног төхөөрөмж авч ашиглахад өргөнөөр ашиглах болсон байна.

## 3.БҮГД НАЙРАМДАХ ИРЛАНД УЛС

Ирланд Улсад түрээсийн аливаа харилцааг Түрээслүүлэгч ба түрээслэгчийн тухай хууль (the Landlord and Tenant (Amendment) act, 1980), Орон сууцны түрээсийн тухай хууль (the Residential Tenancies Act, 2004), Иргэний хууль (Civil law (Miscellaneous Provisions) Act, 2008)[141] болон холбогдох бусад эрх зүйн актуудаар зохицуулж байна.

Ирланд Улсад түрээсийн гэрээг санхүүгийн болон үйл ажиллагааны түрээс гэж ангилах ба хугацааны хувьд урт хугацааны болон богино хугацааны түрээс гэж ангилдаг.

*Санхүүгийн түрээс* нь үндсэндээ хөрөнгө эзэмшигчийн бүх эрсдэл ба ашгийг (*Эрсдэлд тухайн хөрөнгийн урсгал зардал, эсхүл технологийн элэгдэл хорогдолоос үүдсэн үнийн бууралт зэргийг хамруулна. Ашиг гэдэгт тухайн хөрөнгийн үр ашигтай байх бүх хугацааны туршид эзэмшин хэрэглэх, хэрэглээнээс бий болсон ашиг орлого хүртэхийг ойлгоно*) шилжүүлдэг түрээс юм.

---

[139] https://www.globalpropertyguide.com/Asia/South-Korea/Landlord-and-Tenant
[140] http://www.koreanlii.or.kr/w/index.php/Finance_lease
[141] Civil law (Miscellaneous Provisions) Act, 2008-http://www.irishstatutebook.ie/eli/2008/act/14/enacted/en/print.html, http://irishbarrister.com/tenancy.html

*Үйл ажиллагааны түрээс* гэж санхүүгийн түрээсээс бусад түрээсийг хэлнэ. Өөр өөр түрээсийн төрөл зүйлд өөр өөр нягтлан бодох бүртгэлийн стандартыг баримталдаг тул түрээсийг ангилал чухал байдаг байна.[142]

Санхүүгийн болон бизнесийн үйл ажиллагааны түрээсийн харилцааг Ирландын Орон нутгийн засгийн газраас баталсан "Капиталын санхүү ба нягтлан бодох бүртгэлийн тухай" (2011 оны 326 дугаар[143]) журмаар зохицуулсан байна. Журмын Капитал орлого (Capital receipts) хэмээх 6 дугаар бүлэгт зааснаар санхүүгийн болон үйл ажиллагааны түрээс нь хууль ёсны хэлэлцэн тохиролцсон аливаа гэрээний дагуу хийгдэх бөгөөд орлогыг капитал хуримтлал (орлого) хэлбэрээр ерөнхий санд бүртгэнэ. Капитал орлогыг дараах зориулалтуудын нэг ба нэгээс дээш зориулалтаар хэрэглэж болно:

(a) капитал зардал төлөх;
(b) аливаа зээлсэн мөнгөний үндсэн дүнг эргүүлэн төлөх;
(c) аливаа зээлсэн мөнгөтэй холбоотой тооцсон хураамж төлөх;
(d) зүй ёсны бус (практик бус) аливаа кредит тохиролцоотой үүрэг хариуцлагын ерөнхий санд ноогдох хэсгийг төлөх;
(e) тухайн хөрөнгийг эзэмших үед хийсэн гэрээ, эсхүл тэрхүү гэрээний үүрэгтэй холбоотойгоор хөрөнгийг худалдан борлуулах үед хүлээсэн үүргийн дагуу хэн нэгэнд бүх, эсхүл зарим төлбөрийг төлөх гэх мэт.

Санхүүгийн түрээст хамаарах аливаа газар, барилга байгууламж, эд хөрөнгийн түрээсийн эрхийн асуудлыг **Түрээслүүлэгч ба түрээслэгчийн тухай хууль**[144]-аар зохицуулах бөгөөд энэ нь Ирландын түрээсийн харилцааг зохицуулдаг гол тулгуур хуулийн нэг юм. Тус хуульд 1980 онд томоохон өөрчлөлт орж шинэчлэгдсэн бөгөөд 6 бүлэг 88 зүйлтэй, дараах агуулга, бүтэцтэй байна. Үүнд:

1-р бүлэг. Урьдчилсан заалт;
2-р бүлэг. Түрээсийн шинэ эрх;
3-р бүлэг. Түрээс буцаах (Reversionary Leases);
4-р бүлэг. Нөхөн олговор;
5-р бүлэг. Түрээсийн гэрээний үүрэг;
6-р бүлэг. Бусад.

Түрээсийн орлогын эх үүсвэр нь дараах хэлбэртэй байна:

- эд хөрөнгө түрээслэх (байшин, байр, орон сууц, ажлын байр ба тариалангийн газар);
- эзэмшигчийн эрхийг түрээслэх, (зар суртчилгааны тэмдэг, самбар босгох, тавих, харилцаа холбооны дамжуулагч хэрэглэх, замын эрхийг хэрэглэх);
- спортын эрх түрээслэх (загасчлах, буудлага хийх зөвшөөрөл);
- түрээсийн гэрээнд тусгагдаагүй орон байрны үйлчилгээ, урсгал засварын хөлсийг түрээслэгч талаас төлсөн төлбөрүүд;
- тариалангийн газар түрээслэх;
- эд хөрөнгө эзэмшихийг дагалдах туслах үйлчилгээний төлбөрүүд;
- түрээсээ төлөөгүй тохиолдлыг зохицуулах бодлогын дагуу төлөх даатгалын нөхөн төлбөрүүд.

Худалдааны байгууламж болон орон сууц түрээслэгчийн эрхийг мөн 1980 оны "Түрээслүүлэгч ба түрээслэгчийн тухай" хуулиар баталгаажуулсан. Хуульд зааснаар өмнөх түрээсийн гэрээ дуусгавар болж, шинэ түрээс эхлүүлэх эрхтэй байхын тулд түрээслэгч дараах 4 эрхийн аль нөхцөлөөр эрхээ баталгаажуулахаа батлах ёстой.

- ***Бизнесийн эрх:*** Хэрэв түрээслэгч бизнесийн зорилгоор бизнес эрхлэх байрыг тасралтгүй 5 жил эзэмшсэн бол түрээслэгчийг бизнесийн эрхтэй гэж үзнэ.

---

[142] Accounting for Leases - IAS 17 Leases- http://www.cpaireland.ie/docs/default-source/Students/Study-Support/P2-Advanced-Corporate-Reporting/accounting-for-leases---ias-17-leases-nbsp-.pdf?sfvrsn=0
[143] Local Government (Capital Finance and Accounting) Regulations (Northern Ireland) 2011 http://www.legislation.gov.uk/nisr/2011/326/pdfs/nisr_20110326_en.pdf
[144] the Landlord and Tenant (Amendment) act 1980- http://www.irishstatutebook.ie/eli/1980/act/10/section/64/enacted/en/html#sec64

- ***Урт хугацааны өмчлөлийн эрх:*** Орон сууц болон бизнесийн зориулалттай байрыг тасралтгүй 20 жил эзэмшсэн бол урт хугацааны өмчлөлийн эрхтэй гэж үзнэ.
- ***Засан сайжруулах эрх:*** Бизнесийн болон орон сууцны байр түрээслэх үндсэн хэмжээний 1/2-ээс багагүй хэмжээг засан сайжруулалт хийсэн бол засан сайжруулах эрхтэй гэж үзнэ.
- ***Түрээсийн хуулийн эрх:*** 1980 оны "Түрээслүүлэгч ба түрээслэгчийн тухай хууль"-ийн 14 ба 15 дугаар хэсгүүдэд заасны дагуу худалдааны болон орон сууцны зориулалттай байрны зарим түрээслэгч нарт 1960-1967 оны Түрээсийн хязгаарлалтын хуулиар шинээр түрээслэх эрх олгодог байна. Түрээсийн гэрээг сунгах болзол хангасан түрээслэгч хүсэлт гаргах бөгөөд түрээсийн гэрээг 5 жил тутамд сунгана.

Түрээслүүлэгчийн хувьд, худалдааны түрээс бол хөрөнгө оруулалтын хэлбэрээр өмчилж буй эд хөрөнгөөсөө орлого хүртэх, эсхүл эд хөрөнгөнийхөө үндсэн өртөгөөс илүү хэмжээгээр капитал буюу орлого олох арга зам юм. Харин түрээслэгчийн хувьд худалдааны түрээс гэдэг бол капитал бий болгох зорилгогүйгээр бизнесийн үйл ажиллагаагаа эрхлэхэд шаардагдах үл хөдлөх хөрөнгийг түрээслэж байгаа явдал юм.

Худалдааны түрээс нь ихэвчлэн:

- ажлын байрны;
- арилжаа худалдааны;
- аж үйлдвэрлэлийн гэх зэрэг өөр өөр түрээсийн хэлбэртэй байна.

Эдгээр нь олон янзын түрээсийн хэлбэртэй байж болно. Богино хугацааны буюу 5-аас доош жилийн хугацаатай түрээс, урт хугацааны түрээс хоорондоо ялгаатай. Тухайлбал,

- Богино хугацааны түрээсийн гэрээнд түрээсийн нөхцөлийг эргэн харах талаар ихэвчлэн заадаггүй ба засвар үйлчилгээний тухайд зөвхөн барилгын дотоод засалтай холбоотой заалтуудыг оруулж болно.

- Урт хугацааны түрээсийн гэрээнд түрээсийн нөхцөлийг эргэн харах, шаардлагатай бол "цуцлах" нөхцөлүүдийг заасан байх бөгөөд түрээслэгч нь барилгын бүтцийг оролцуулан дотоод ба гадаад засвар үйлчилгээг хийх үүрэгтэй байна.

Худалдааны түрээс нь харьцангуй энгийн хэлбэрээс орчийн үеийн нээлттэй зах зээлийн түрээсийн нөхцөлтэй, 5 жил тутамд сунгалт хийх үедээ үнэ ханшийг нэмж болохуйцаар 20 жилийн хугацааны нөхцөлтэй хийдэг *FRI буюу Бүрэн засварлаж, хариуцдаг түрээс хэмээн* нэрлэгддэг өргөн цар хүрээг хамарсан (бүгдийг багтаасан) хэлбэртэй болж хөгжсөн байна.

Үүнээс гадна түрээсийн гэрээнд оролцогч талууд стандарт түрээсийн нөхцөлийг харилцан адилгүйгээр өөрчлөн улам нарийвчилж, тусгай зөвшөөрлийн бичиг хэрэглэх болсон нь түрээсийн харилцааг улам бүр нарийн болгож байна. Тухайбал, түрээслүүлэгч буюу "Худалдааны төвийн" эзэн нь хэн нэгэн томоохон түрээслэгчид бусдаас илүү таатай нөхцөл олгохыг зөвшөөрдөгөөс үүдэлтэй юм. Ийм тусгай зөвшөөрөл нь тухайн түрээслэгчийн хувийн хэрэг болох бөгөөд түрээслүүлэгч болон түрээслэгч, түүний залгамжлагчдын хооронд хийгддэг байна.

Барилгыг бүхэлд нь түрээслүүлж байгаа тохиолдолд түрээслэгч нь тухайн барилгын бүх урсгал засварыг хариуцах үүрэгтэй. Барилгыг хэсэгчлэн түрээслүүлж байгаа тохиолдолд хуулийн дагуу түрээслүүлэгч барилгын үндсэн бүтэц болон нийтийн эзэмшлийн талбайн засвар үйлчилгээг хариуцах ба гарах зардалыг түрээслэгчийн үйлчилгээний төлбөр болгон тооцож авна. Аль ч тохиолдолд түрээслүүлэгч өөрийн хөрөнгө оруулалтыг хамгаалах үүднээс барилгын баталгаат байдлыг хянах ёстой ба түрээслэгч нар нь үүнд шаардагдах зардалыг түрээсийн төлбөр дээрээ нэмж төлөх үүрэгтэй байдаг байна.

Талууд зөвхөн түр зуурын түрээсийн гэрээ байгуулах тохиолдолууд бий. Бүх тохиолдолд, түрээслүүлэгчид нь 1980 оны Түрээслүүлэгч ба түрээслэгчийн хууль (2015 онд нэмэлт өөрчлөлт орсон), 2008 оны Иргэний хуульд заасны дагуу 5 жил тутамд (онцгой

тохиолдол биш бол) шинээр түрээсийн гэрээ хийх ёстой байдаг байна. Тэгэхээр түрээсийн гэрээ 4 жил 9 сараас хэтрэхгүй байх ёстой (*түрээсийг улиралаар төлөх тохиолдолд*) буюу, эсхүл 4 жил 11 сараас хэтрэхгүй (*түрээсийг сараар төлөх тохиолдолд*) байх ёстой. Одоогийн байдлаар, бүх бизнесийн түрээслэгчдийн хувьд 1980 оны хуулийн нөхцөлүүдийг 2008 оны Иргэний хуулийн 47 дугаар зүйлд заасны (олон өөр өөр нөхцөлүүд) дагуу гэрээ байгуулах эрхтэй байна.

Ирландын үл хөдлөх хөрөнгө, тэр дундаа орон сууцны түрээсийн харилцааг ***Орон сууцны түрээсийн тухай хуулиар***[145] нарийвчлан зохицуулсан байна. Хууль нь 9 бүлэг, 202 зүйлтэй бөгөөд дараах агуулга, бүтэцтэй байна. Үүнд:

1-р бүлэг. Урьдчилсан ба ерөнхий заалт;
2-р бүлэг. Эзэмшигч ба түрээслэгчийн эрх, үүрэг;
3-р бүлэг. Түрээс ба түрээсийн эрх;
4-р бүлэг. Орон сууцны түрээсийн аюулгүй байдал;
5-р бүлэг. Түрээсийн хугацаа: Зарлалын хугацаа ба бусад журмын шаардлагууд;
6-р бүлэг. Маргаан шийдвэрлэх;
7-р бүлэг. Орон сууцны түрээсийн бүртгэл;
8-р бүлэг. Хувийн орон сууцны түрээсийн зөвлөл;
9-р бүлэг. Бусад.

**Иргэний тухай хуулийн**[146] 4 дүгээр бүлгийн 47, 48 дугаар зүйлүүдэд заасан түрээслэгч болон түрээслүүлэгчийн хоорондын харилцааг "Түрээслүүлэгч ба түрээслэгчийн тухай" хууль болон "Орон сууцны түрээсийн тухай" хуульд нийцүүлэн зохицуулсан байна.

Түрээсийн татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн тухай 2011 оны **Санхүүгийн хуулийн**[147] 23, 24 дүгээр зүйлүүдэд заасначаар орон сууц түрээслэгчдийг хөнгөлөлтөнд хамруулах, эсхүл бүрмөсөн чөлөөлөх үндэслэлүүд байдаг ба үүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой тогтоолыг хэмжиж болохуйц үр дагавруудыг тооцоолсон эдийн засгийн үр нөлөөний үнэлгээний тайлан хэвлэн нийтлэгдсэнээс хойш 60 хоногоос багагүй хугацаанд гаргана.

*Хөнгөлөлтийн тухайд, татварын хөнгөлөлттэй бүс нутагт байршилтай эд хөрөнгийг орон сууцны зориулалтаар түрээслэх зорилгоор худалдан авах, барих болон шинэчлэн засварлахад гаргасан зарим тодорхой зардалд ногдуулна.*

Хөнгөлөлтийг тооцохдоо тухайн эд хөрөнгийн зөвшөөрөгдөхүйц хэмжээний өртгийн дүнг болзол хангаг түрээсэлж эхэлсэн анхны жилээс нь эхлэн түрээсийн орлогод хамруулалгүйгээр зардал гэж тооцоно. Аливаа эдлээгүй хөнгөлөлтийг дараах жилүүдэд нь түрээсийн орлого биш түрээсийн алдагдал хэмээн шилжүүлэн тооцож болно. Хэрвээ болзол хангаг анх түрээсэлж эхэлснээс хойших 10 жилийн хугацаанд тухайн эд хөрөнгийг бусдад худалдах зэргээр болзлын шаардлага хангахаа больсон тохиолдолд хөнгөлөлтийг цуцална.[148]

Орон сууцны зориулалттай түрээсийн байрыг шинэчлэн засвар хийсэн тохиолдолд тухайн зардлын зохих хэсгийг (эхний 1-6 жилд 15 хувь, 7 дахь жилд 10 хувь) долоон жилийн туршид түрээсийн орлогоос хасаж тооцдог. Хэрвээ засвар хийснээс хойш, эсвэл шинэчлэн засварлаад түрээслэж эхэлснээс хойших 10 жилийн хугацаанд тухайн хөрөнгийг худалдах, эсвэл болзол хангахаа больсон тохиолдолд өмнө нь үзүүлсэн хөнгөлөлтийг уг хөрөнгийг худалдсан эсвэл болзол хангахаа больсон өдрөөс эхлэн тооцож, энэ хугацаанд олгосон нийт хөнгөлөлтийн дүнг буцаан нэхэмжилж авна.[149]

Өрөөны түрээсийн тухайд, хөнгөлөлтийг хэдийд авахаа тухайн хүн жилийн үнэлгээний тайлангаа мэдүүлэхдээ, эсхүл мэдүүлэхийн өмнө сонгож болно.

[145] the Residential Tenancies Act, 2004- http://www.irishstatutebook.ie/eli/2004/act/27/enacted/en/print.html
[146] Civil law (Miscellaneous Provisions) Act, 2008-http://www.irishstatutebook.ie/eli/2008/act/14/enacted/en/print.html, http://irishbarrister.com/tenancy.html
[147] Finance act 2017- http://www.irishstatutebook.ie/eli/2017/act/41/enacted/en/html
[148] A Guide to Section 23) Relief - Rented Residential Relief in a Tax Incentive Area
[149] Countrywide Refurbishment Scheme

Хэрвээ хөнгөлөлт эдлэх хүсэлт гаргах бол жилийн татварын мэдүүлэгтээ ашиг, алдагдлаа мэдүүлэх ба орлогын татвар төлөх боломжгүй тэрхүү дүн хэмжээгээ тодорхой гаргаж өгөх ёстой байдаг байна.[150]

Тус улсын нутаг дэвсгэрээс гадна байрших хөрөнгийг түрээслэх явцад бий болсон алдагдалыг дотоод дахь хөрөнгө түрээслэсэн түрээсийн орлоготой (эсхүл эсрэгээрээ дотоод дахь хөрөнгийн түрээсийн алдагдалыг гадаад дахь хөрөнгийн түрээстэй) адилтган үзэхгүй.

Тус улсын нутаг дэвсгэрээс гадна өөр улсад эзэмшиж буй хөрөнгийг түрээслэснээс олсон орлогыг түрээслүүлэгчийн жил тутмын татварын мэдүүлгийн гадаад орлогын хүснэгтэнд бөглөх ёстой.

***а.*** Хувийн түрээсийн байранд ногдох түрээсийн хөнгөлөлтийг ямар нэгэн хувийн түрээсийн орон сууцыг үндсэн гэр орноо болгон түрээслэдэг түрээслэгчийн түрээсийн төлбөрөөс тооцно. Түрээслэгч энэхүү хөнгөлөлтийг авах хүсэлтээ *Form Rent 1-Claim for Rent Relief on Private Rented Accommodation* маягт бөглөн мэдүүлнэ. 2011 оны Санхүүгийн хуулийн 14-р хэсэгт заасанаар 2010 оны 12 дугаар сарын 7 ба түүнээс өмнө болзол хангасан түрээслэгчдэд энэ хөнгөлөлтийг 7 жилийн хугацаанд тодорхой үе шаттай үзүүлэхээр заасан байна. Хөнгөлөлт олгох замаар түрээсийн нийт дүнг аажим аажмаар бууруулах зарчмаар явсаар 2018 он ба удаах онуудад хамгийн их хөнгөлөлтийг үзүүлэхээр тогтоосон байдаг.

Харин 2010 оны 12 дугаар сарын 8-ны өдөр ба түүнээс хойш түрээсээ эхлүүлсэн түрээслэгчдийн хувьд энэ хөнгөлөлтөнд хамрагдах боломжгүй. Хуулийн дагуу тус улсад оршин суугч түрээслүүлэгч нь түрээслэгчийн хүссэн үед түрээс төлсөнийг гэрчлэх баримтыг гаргаж өгөх ёстой. Хэрэв түрээслүүлэгч нь тус улсад оршин суудаггүй бол төлбөрөө шууд төлөх болон банкны дансанд шилжүүлэх, эсхүл гадаадад оршин суудаг агентад нь шилжүүлэхдээ түрээслэгч нь нийт төлбөл зохих түрээсийн дүнгээс орлогын татвараас суутгах стандарт хувийг (20%) хасах ёстой байдаг байна. Энэхүү хөнгөлөлтийг мөн гадаад улсад байршилтай байрны түрээсийн төлбөрийг хийхэд хэрэглэдэг.

## 4.КАНАД УЛС

Канад Улсад Орон сууцны түрээсийн тухай, Түрээсийн шударга байдлын тухай, Түрээсийн хамгаалалтын тухай хуулиудаар түрээсийн харилцааг зохицуулдаг байна.

Эдгээрээс Канадын Манитоба мужийн Орон сууцны түрээсийн тухай хууль (ОСТТХ)[151]-д зохицуулсан түрээслүүлэгч, түрээслэгчийн эрх, үүрэгтэй холбоотой харилцааг авч үзье.

**Орон сууцны түрээсийн тухай хуулийн** 1(1) дүгээр зүйлд зааснаар “түрээсийн байр” гэдэгт түрээслүүлэгчийн бэлтгэсэн тавилгатай, цахилгаан зуух, хөргөгч, угаалгын машин, хатаагч зэрэг гэр ахуйн техник хэрэгсэлтэй байрыг ойлгоно хэмээн тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл, бүрэн тавилгатай байрыг хэлдэг байна. Дараах төрлийн байр сууцнууд түрээсийн байр хэмээх ойлголтод хамаарахгүй. (ОСТТХ-3(1)) Үүнд:

- зочид буудал, дэн буудал, жуулчдын байр, нийтийн дотуур байр;
- улирлын чанартай, эсхүл түр орогнох байр;
- орон сууцны барилгын барилгачдын түр оршин суух байр;
- нөхөн сэргээх болон эмчилгээний тусламж авах зорилгоор эмчлүүлэгчийн түр байрлаж байгаа байр;
- түр хугацааны орон байр шаардлагатай этгээдийн байрлаж байгаа байр;
- боловсролын байгууллагад суралцагсдад зориулсан дотуур байр;
- шашны байгууллагын ажиллагсдад зориулсан орон байр;
- өвчний сүүлийн шатандаа байгаа өвчтөнийг асрах зориулалттай эмнэлгийн, эсхүл асрамжийн газрын байр.

[150] Part 7.1.32 (PDF 54 KB) of the Income Tax, Capital Gains Tax and Corporation Tax Manual.

[151] The Residential Tenancies Act. Assented to December 14, 1990. This version is current as of May 1, 2013. Эх сурвалж: http://web2.gov.mb.ca/laws/statutes/ccsm/r119e.php.

Түрээсийн гэрээг амаар, бичгээр болон болзолт (implied) байдлаар байгуулж болно. Гэрээнд түрээслэх хугацааг заах ба түрээсийн хугацаанд ямар нэгэн үйлчилгээ үзүүлэх бол гэрээг бичгээр үйлдэнэ. Хэрэв түрээслүүлэгчийн зүгээс гэрээнд үйлчилгээ үзүүлэхээр тусгасан боловч түүнээсээ татгалзахаар болвол гэрээнд гарын үсэг зурсанаас хойш 48 цагийн дотор (бямба, ням болон баярын өдрүүд хамаарахгүй) гэрээг цуцлаж болно. Түрээслүүлэгч нь гэрээг цуцлахаар болсоныг бичгээр, эсхүл факсаар мэдэгдэх ба үүний дараа гэрээг хүчингүйд тооцно. (ОСТТХ -7(1)

Түрээслүүлэгч нь түрээсийн байрны төлбөрийг нэмэгдүүлэх, эсхүл хямдруулах гэж байгаа бол түрээслэгчид хуульд заасан журмын дагуу бичгээр 3 сарын дотор мэдэгдэх үүрэгтэй. Шинээр гэрээ байгуулан түрээсийн байранд орж байгаа түрээслэгчийн эхний 3 сарын байрны төлбөрийг нэмэгдүүлэхгүй. (ОСТТХ-25)

Орон сууцны түрээсийн тухай хуулийн 140.3(2) дугаар зүйлд түрээсийн үйлчилгээний төлбөрийн талаарх зохицуулалтыг зааж өгсөн бөгөөд түрээсийн төлбөрийн хэмжээнд хязгаар тогтоохгүй гэсэн байна. Өөрөөр хэлбэл, түрээслүүлэгч нь өөрөө түрээсийн үйлчилгээний төлбөрийг тогтооно.

Түрээслүүлэгч нь түрээслэгчээс дараах төрлийн барьцаа төлбөр (a security deposit)-ийг авна. (ОСТТХ-29):

1. гэрийн тэжээмэл амьтан тэжээсний барьцаа төлбөр (a pet damage deposit);
2. түрээслэгчийн аюулгүй байдлын барьцаа төлбөр (a tenant services security deposit).

*Барьцаа төлбөр* - түрээслүүлэгчийн түрээслэгчид үзүүлэх ажил, үйлчилгээний, эсхүл зөрчил гарсан тохиолдолд хүлээх хариуцлагын төлбөр. Түрээслүүлэгч нь түрээслэгчид энэ төрлийн барьцаа төлбөр авах тухайгаа түрээсийн гэрээ байгуулахаас өмнө мэдэгдэх үүрэгтэй.

*Гэрийн тэжээмэл амьтан тэжээсний барьцаа төлбөр* - түрээслэгчийн түрээсийн байранд тэжээж байгаа гэрийн тэжээмэл амьтантай холбоотой түрээслүүлэгчийн зүгээс гүйцэтгэх ажил, үйлчилгээний, эсхүл зөрчил гарсан тохиолдолд хүлээх хариуцлагын төлбөр. Түрээслэгч нь түрээсийн байрандаа гэрийн тэжээмэл амьтан байлгах бол түрээслүүлэгч түүнээс гэрийн тэжээмэл амьтны барьцаа төлбөрийг шаардах эрхтэй. Хэрэв тухайн амьтан нь хууль тогтоомжид заасан хөтөч нохой, туслагч амьтан бол энэхүү барьцаа төлбөрийг авахгүй.

*Түрээслэгчийн аюулгүй байдлын барьцаа төлбөр* - түрээслэгчийн аюулгүй байдал, түүнийг хангахтай холбоотой түрээслүүлэгчийн гүйцэтгэх ажил, үйлчилгээний, эсхүл зөрчил гарсан тохиолдолд хүлээх хариуцлагын төлбөр.

Дээрх барьцаа төлбөрүүд нь түрээсийн гэрээнд заасан түрээсийн эхний сарын төлбөрийн 1/2-оос хэтрэхгүй байна. Хэрэв түрээсийн байранд түрээслэгчтэй өөр этгээд хамт амьдрах бол түрээслүүлэгч нь барьцаа төлбөрийг нэмж төлөхийг шаардах эрхтэй.

Түрээслүүлэгч нь дараах тохиолдолд түрээсийн байрны нөхцөл байдалтай танилцана. (ОСТТХ -39) Үүнд:

- түрээсийн гэрээний хугацаа эхлэхээс өмнө;
- давхар түрээсээр шилжүүлэх үед;
- гэрийн тэжээмэл амьтан түрээсийн байранд байлгах зөвшөөрөл авсан түрээслэгчийн гэрээ эхлэх үед;
- түрээсийн гэрээний хугацаа дуусах үед түрээсийн байрны нөхцөл байдалтай тус тус танилцана.

Түрээслүүлэгч нь түрээсийн байрыг найдвартай байлгахын тулд хаалга, цоож болон бусад хэрэгслэлээр хангах үүрэгтэй ба талууд харилцан тохиролцохгүйгээр хаалга, цоож болон бусад хэрэгслэлийг дур мэдэн солихгүй. Түрээслүүлэгч нь онц ноцтой нөхцөл байдал үүссэн, түрээслэгч өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд түрээслэгчийн байранд нэвтрэх эрхгүй. Мөн түрээслүүлэгч нь гэрээтэй холбоотой албан ёсны мэдэгдэлийг түрээслэгчийн байранд оруулж өгч болох ба ингэхдээ энэ талаараа түрээслэгчид 24 цагийн өмнө мэдэгдэх үүрэгтэй.

Талууд хуулиар тогтоосон журмын дагуу бичгээр харилцан тохиролцсоны үндсэн дээр түрээсийн гэрээг цуцалж болно. Түүнчлэн түрээслэгч түрээсийн төлбөрийг төлөхөөс татгалзсан үед түрээсийн гэрээ дуусгавар болно. (ОСТТХ-81, 82)

Хэрэв түрээсийн гэрээг амаар, эсхүл болзолт хэлбэрээр байгуулахдаа талууд хугацаа заасан бол уг хугацаа дуусгавар болохоос нэг сарын өмнө түрээслэгч үргэлжлүүлэн суухгүй талаараа түрээслүүлэгчид мэдэгдэх үүрэгтэй. Хэрэв түрээсийн гэрээг амаар, эсхүл болзолт хэлбэрээр байгуулахдаа талууд хугацааг заагаагүй тохиолдолд түрээслэгч нь түрээсийн төлбөр төлөх сүүлийн өдөр түрээслүүлэгчид үргэлжүүлэн суухгүй тухайгаа мэдэгдэх ёстой. Энэ хугацаанаас хоцорсон тохиолдолд түрээсийн төлбөрийг үргэлжлүүлэн төлнө. (ОСТТХ-

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ


ОХУ:

- Гражданский кодекс РФ. Часть вторая от 26 января 1996 г. N 14-ФЗ.
- Закон РФ от 7 февраля 1992 г. № 2300-1 О защите прав потребителей.
- Федеральный закон от 29 октября 1998 г. № 164-ФЗ "О финансовой аренде (лизинге)".
- Гражданский кодекс РФ. Часть вторая от 26 января 1996 г. N 14-ФЗ. Глава 34. Аренда.

БНСУ:

- http://www.kpmg.com/Global/en/IssuesAndInsights/ArticlesPublications/taxation-international-executives/korea/pages/income-tax.aspx
- http://www.lexology.com/library/detail.aspx?g=37d137f2-b837-4e9e-a49e-8717e7ee257c
- http://www.itrworldtax.com/Guide/537/South-Korea.html
- http://www.itrworldtax.com/Guide/537/South-Korea.html

БНИУ:

- http://www.globalpropertyguide.com/ - Rental Income Tax- Ireland Compared to Continent
- http://www.taxworld.ie/taxes/it/current/summary-ireland - Income Tax Summary Ireland 2013
- http://www.ird.govt.nz/forms-guides/number/forms-200-299/ir264-guide-rental-income.html - Rental income IR264
- http://www.mcgibney.com/tax_on_rental_income.htm#To - Tax on Rental Income (A Guide)
- http://www.revenue.ie/en/tax/it/leaflets/it70.html - A Revenue Guide to Rental Income - IT 70
- http://www.revenue.ie/en/tax/it/rental-income.html - Rental Income
- http://www.irishstatutebook.ie/1980/en/act/pub/0010/print.htm - Landlord and Tenant (Amendment) Act, 1980
- http://irishtaxback.ie/rental-income-expenditure-news/ - Rental Income

Канад Улс:

- Орон сууцны түрээсийн тухай хууль, 2002 (Residential Tenancy Act) - www.bclaws.ca/civix/document/id/complete/statreg/02078_01
- Арилжааны түрээсийн тухай хууль, 1996 (Commercial Tenancy Act) - www.bclaws.ca/civix/document/id/complete/statreg/96057_01
- Түрээсийн шударга байдлын тухай хууль, 2017 (Tenancies and Distress for Rent Act)
- www.ontario.ca/laws/statute/S17013
- Түрээсийн хамгаалалтын тухай хууль, 2017 (Tenant Fairness Act) - www.ontario.ca/laws/statute/97t24

# ОЮУНЫ ӨМЧИЙН ҮНЭЛГЭЭ БА ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТЭНД ОРУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

(Харьцуулсан судалгаа)

*Г.Алтан-Оч (Ph.D), И.Жаргалзаяабямба*
*Д.Жигваагүнсэл, Р.Нургүл, Р.Оргилмаа, Ц.Элбэгзаяа*

## АГУУЛГА

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Нэг. Оюуны өмчийн үнэлгээний эрх зүйн орчин

Хоёр. Оюуны өмчийг ашиглах эрх зүйн зохицуулалт, гадаадын зарим орны туршлага

- АНУ
- ИЗРАИЛ
- ФИНЛАНД
- БНХАУ
- СИНГАПУР
- НИДЕРЛАНД
- НОРВЕГ

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Оюуны өмчийн эрхийн ач холбогдол тасралтгүй өсөн нэмэгдсээр байгаа бөгөөд компани (аж ахуйн нэгж)-ийн үнэ цэнийн салшгүй хэсэг болжээ.[152] Цаашлаад, эрхийн хамгаалалтыг мэдэх явдал улам нэмэгдэж, оюуны өмч нь хувьцаат аж ахуйн нэгжийн[153] ажил хэргийн[154] харилцаанд чухал үүрэг роль гүйцэтгэх болсон байна.

Оюуны өмч эзэмшигч нь доорх эрхүүдийг эдлэж, ашиг тус хүртэх боломжтой байдаг. Үүнд:

- Хууль бус ашиглалтын нөхөн олговор-лицензийн төлбөртэй тэнцүү хэмжээний (барааны тэмдэг болон патент);
- Хэрэв нэмэлт алдагдал нотлогдож байвал хохирол (лиценз дээр нэмээд)
- Зөрчилтэй барааг хураах болон устгах;
- Мэдүүлэг авахаас өмнө шүүхийн урьдчилсан хориг;
- Анхан шатны шүүхийн шийдвэрийн дагуу урьдчилсан шийдвэр гүйцэтгэл;
- Патент буюу барааны тэмдгийн санаатай зөрчилд эрүүгийн хариуцлага хүлээлгэх.

Патент, барааны тэмдэг болон зохиогчийн эрхийн санаатай зөрчилд торгох буюу 3 сар хүртэлх хугацаагаар баривчлах эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Ийм хариуцлагыг мөн их хэмжээний барааны дамын наймаанд хүлээлгэдэг байна.

Хохирлыг ерөнхийдөө урьдчилан тооцдог боловч шүүхээс бодит алдагдлаас хэтэрсэн хохирлыг барагдуулахад дурамжхан ханддаг. Шүүхээс хуулийн[155] (өмгөөллийн) зардлын нөхөн олговрыг голдуу гаргуулж өгдөг.

Ердийн шүүхээс гадна хувийн хэвшлийн зөвлөл (Өрсөлдөөний өмгөөлөл[156]) Зах зээлийн тухай хуулийн хүрээнд жишээлбэл, шударга бус маркетинг буюу бүтээгдэхүүн хуулбарласан зэрэг асуудлаар шийдвэр гаргаж болно. Ийм шийдвэрийг заавал биелүүлэх албагүй ч талууд голдуу хүлээн зөвшөөрдөг. Арбитраж болон Зуучлагч[157] байж болох боловч оюуны өмчийн асуудалд өргөн дэлгэрээгүй юм.

Орлогоо өсгөхийн тулд лицензийг хэрэглэх явдал улам нэмэгдэж байна. Лицензийн схемийг боловсруулахдаа оюуны өмчийн хөрөнгийнхөө хяналтыг хэрэгжүүлэх стратегийг анхаарах нь маш чухал. Технологи, брэнд буюу бусад эрхийг лицензжүүлэх нь ихэнхдээ дотооддоо хөгжүүлэхээс ч дутахгүй зардал ихтэй байдаг. Зарим компаниуд лицензийн гэрээ байгуулах замаар өөрийн оюуны өмчийн эрхээ лицензжүүлэн нэмэлт орлого олох боломж эрэлхийлж байдаг.

Патентын хамгаалалт нь патент эзэмшигчид зах зээлийн өрсөлдөөнд давуу байдал бий болгодог. Өмнө нь патент өргөн дэлгэрээгүй аж үйлдвэрийн салбарт гол технологио патентлаад хэвлэн нийтэлбэл, өрсөлдөгч тал нь тухайн технологийг патентлахыг таслан зогсоох болно.

Нууцыг ашиглах нь оюуны өмчийн хамгаалалтын адилаар таатай бус байдалд оруулах боломжтой. Хэрэв таны өрсөлдөгч танай технологитой төстэй ШБОС-ыг патентлаад эхэлбэл таны эрх патентын улмаас хязгаарлагдах болно.

Оюуны өмч нь хувьцааны асуудал, нэгдэл (ААН-үүдийг нэгтгэх), худалдан авах болон үнэт цаас гаргах зэрэг хувьцаат аж ахуйн нэгжийн ажил хэргийн харилцаанд ихэвчлэн чухал ач холбогдолтой. Иймэрхүү харилцаанд орохын тулд оюуны өмчийн эрхийн нэрийг[158] баримтжуулах болон үнэлж дүгнэхэд[159] чухал хөрөнгө учраас сайтар анхаарах шаардлагатай байдаг байна.

---

[152] Asbjørn Berg and Are Herrem “Key issues for IP rights owners” http://www.buildingipvalue.com/05_EU/267_270.htm
[153] corporate-*англиар*
[154] transaction-*англиар*
[155] legal-*англиар*
[156] Konkurranseutvalget-*норвегиар*
[157] Mediation-*англиар*
[158] title to intellectual property rights-*англиар*
[159] review-*англиар*

Судалгааны захиалгын дагуу АНУ, БНХАУ, Нидерланд, Израил, Норвег, Сингапур, Финланд зэрэг орнуудын оюуны өмчийн үнэлгээ ба эдийн засгийн эргэлтэнд оруулахтай холбоотой зохицуулалтын талаар холбогдох хууль, эрх зүйн орчны хүрээнд судалсан бөгөөд эдгээр улс орнууд нь Дэлхийн оюуны өмчийн байгууллага /World Intellectually property organization-WIPO/-ын гишүүн орнууд бөгөөд оюуны өмчийн аливаа харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн хувьд зохиогчийн эрх, патентын эрх, барааны тэмдгийн эрх тус бүрээр өөр өөр зохицуулалт бүхий бие даасан хуулиудтай байна. Тухайлбал, Зохиогчийн эрхийн тухай хууль, Патентын эрхийн тухай хууль, Барааны тэмдгийн тухай хууль гэх мэт. Мөн оюуны өмчийн хууль, дүрэм, журам, гэрээ, холбогдох эрх зүйн актуудыг Дэлхийн оюуны өмчийн байгууллагын холбогдох гэрээ, конвенц, стандарт, зөвлөмжийн хүрээнд уялдуулан, боловсруулдаг.

Судалгаанд хамрагдсан орнуудын хувьд оюуны өмчийн үнэлгээ болон тус харилцаанд оролцогч талуудын үүрэг хариуцлагын талаар холбогдох хуулиудад ямар нэгэн зохицуулалт байхгүй байна. Харин оюуны өмчийн үнэлгээг хийхдээ Дэлхийн оюуны өмчийн байгууллагаас батлан гаргасан “Олон улсын үнэлгээний стандарт”-ын арга, аргачлалын дагуу хийдэг нийтлэг жишигтэй байна. Тухайлбал, Финланд улсад эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан үл хөдлөх хөрөнгийн үнэлгээчин оюуны өмчийн үнэлгээг хийдэг. Энэхүү хөрөнгийн үнэлгээчин нь үнэлгээний үйл ажиллагаанд шаардлагатай мэдлэг, боловсрол эзэмшсэн бөгөөд үнэлгээний салбарт дор хаяж 3-5 жил ажилласан туршлагатай байхыг шаарддаг байна. Тусгай зөвшөөрөл бүхий хөрөнгийн үнэлгээчин нь Хөрөнгийн үнэлгээний зөвлөлийн дүрэм, журам, заавар, хөрөнгийн үнэлгээний конвенц болон Олон улсын үнэлгээний стандартыг дагаж мөрдөх үүрэг хүлээдэг байна.

Харин оюуны өмчийг үнэлэх, эдийн засгийн эргэлтэнд оруулах, ашиглах, бусдад шилжүүлэх, худалдах аливаа харилцааг улс орон бүрт Зохиогчийн эрхийн тухай хууль, Патентын эрхийн тухай хууль, Барааны тэмдгийн тухай хууль, Гэрээний тухай хууль, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль болон бусад холбогдох хууль, журмуудаар зохицуулжээ.

Хуулийн зохицуулалтаас харахад эдийн засгийн эргэлтэнд оруулах аливаа харилцааг судалгаанд хамрагдсан орнуудад лицензийн гэрээгээр шилжүүлэх, худалдах болон ашиглуулахаар зохицуулсан байна. Лицензийн гэрээг байгуулахдаа талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр хийх ба хуульд заасан нөхцөл, тавигдах шаардлагын дагуу гүйцэтгэж, тухайн улсын оюуны өмчийн газарт бүртгүүлдэг. Тухайлбал, Израил улсын хувьд Патентын тухай хуулийн Тавдугаар бүлэгт патент эзэмших эрхийн тухай (Ownership of patent) зохицуулсан[160]. Хуулинд зааснаар шинэ бүтээл болон түүний патентыг хэд хэдэн хүн хамтран эзэмшиж (joint patent) болно. Үүнд: эзэмшигч бүр адил эрхтэй байна. Адил биш байх тохиолдолд хоорондоо гэрээгээр, эсвэл хуулийн дагуу зохицуулна. Гэрээгээр, эсвэл хуулийн дагуу өөрөөр зохицуулаагүй бол патент хамтран эзэмшигч бүр тухайн бүтээлийг ашиглах эрхтэй. Ийнхүү ашиглахдаа бусад хамтран эзэмшигч нар нь *патент ашигласан эзэмшигчээс роялти, эсвэл олсон ашгаас хуваалцахыг нэхэж шаардахаас сэргийлэх зорилгоор гэрээгээр, эсвэл хуулийн дагуу зохицуулалт* хийдэг байх жишээтэй.

*Дэлгэрэнгүйг судалгааны хэсгээс үзнэ үү*.

[160] Патентын тухай хууль, Тавдугаар бүлэг http://www.wipo.int/wipolex/en/text.jsp?file_id=341499

## СУДАЛГААНЫ ХЭСЭГ

## НЭГ. ОЮУНЫ ӨМЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Судалгааны энэ хэсэгт АНУ, Израил, Финланд, Сингапур, БНХАУ, Нидерланд, Норвег зэрэг орнуудын оюуны өмчийн үнэлгээний хууль эрх зүйн зохицуулалтыг судлахыг зорьсон болно.

Судалгааны явцад дээрх орнуудын оюуны өмчийн холбогдох хуулиудыг судлан үзэхэд оюуны өмчийн үнэлгээний тухай ямар нэгэн тусгайлсан зохицуулалт байхгүй байна. Харин оюуны өмчийн үнэлгээг Дэлхийн оюуны өмчийн байгууллагаас баталсан “Олон улсын үнэлгээний стандарт”-ын арга, аргачлалын дагуу хийдэг нийтлэг жишигтэй байна. Учир нь судалгаанд хамрагдсан орнууд нь Дэлхийн оюуны өмчийн байгууллагын гишүүн орнууд бөгөөд оюуны өмчийг үнэлэх, хамгаалах асуудлыг тус байгууллагын конвенц, стандартын хүрээнд зохицуулдаг байна.

Оюуны өмчийн үнэлгээ хийхэд нийтлэг хэрэглэгддэг Олон улсын үнэлгээний стандарт[161] (International Valuation Standard)-ын талаар товч дурдъя.

*Олон улсын үнэлгээний стандарт*.

Оюуны өмчийн үнэлгээний стандартад тодорхойлсноор оюуны өмчийн үнэлгээ нь тодорхой оюуны өмчийн мөнгөн өртгийг тодорхойлох явцыг хэлнэ. Оюуны өмчийн үнэлгээ хийхээс өмнө урьдчилсан нөхцөлийг тодорхойлж, үнэлгээнд нөлөөлөх хүчин зүйлсийг тооцохоос гадна үнэлгээ хийх шалтгааныг мөн тодорхойлдог байна.

*Хүснэгт 1. Оюуны өмчийн үнэлгээний шалтгаан (IP Panorama, 2013.WIPO).*

| Ангилал | Үнэлгээний өдөөгч шалтгаан |
|---|---|
| Оюуны өмчийн хөрөнгийн наймаа, хэлцлийн үйл ажиллагаа | Оюуны өмчийн хөрөнгийн лиценз, франчайзинг |
| | Оюуны өмчийн хөрөнгийг худалдах ба худалдан авах |
| | Спин-офф, хамтарсан венчур, стратегийн альянс |
| | Оюуны өмчийн хөрөнгийг хандивлах |
| Оюуны өмчийн эрхийг албадан хэрэгжүүлэх | Оюуны өмчийн эрхтэй холбогдох зөрчил гарахад үүссэн хохирлыг тооцох |
| Дотоод хэрэглээ | Судалгаа, боловсруулалтын ажилд хөрөнгө оруулах |
| | Оюуны өмчийн хөрөнгийн дотоод менежмент |
| | Стратегийн санхүүжилт, үнэт цаас, хувьцаа, хөрөнгө босгох |
| | Хөрөнгө оруулагчийн харилцаа |
| Бусад зорилгоор ашиглах | Санхүүгийн тайлагналт |
| | Дампуурал/татан буулгах |
| | Татварын оптимизаци |
| | Оюуны өмчийн хөрөнгийн даатгал |

Оюуны өмчийн хөрөнгийн үнэлгээнд өргөнөөр ашигладаг олон улсын судалгааны 3 арга байна. Үүнд:

- ✓ Зардалд суурилсан аргачлал (Cost Method);
- ✓ Зах зээлд суурилсан аргачлал (Market Method);
- ✓ Орлогод суурилсан аргачлал (Income Method).

*Зардалд суурилсан аргачлал (Cost Method)*

**Зардалд суурилсан** оюуны өмчийн хөрөнгийн үнэлгээ гэж үнэлгээ хийж буй оюуны өмчийн хөрөнгөтэй ижил төстэй гадаад, дотоодын оюуны өмчийн зардлыг тооцон гаргадаг үнэлгээг хэлнэ. Тус үнэлгээг хийхэд хугацааны тодорхой цэгт шууд зардлын нийт дүн ба үр дүнг боловсруулахад шаардагдах боломжит зардал, ашиглалтаас гарах, элэгдэлд орох хүчин зүйлийг /obsolescence/ тооцон оюуны өмчийн хөрөнгийн өртгийг тооцоолох арга зүйг хэлнэ. Жишээлбэл, хэрэв оюуны өмчийн эзэмшигч нь өмнөх жилүүдэд гаргасан зардлаа

[161] “Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах нь” хэлэлцүүлгийн материалаас.

мэдэж байгаа тохиолдолд өөрийнхөө оюуны өмчийн хөрөнгийн ирээдүйн өртгийг гаргахдаа үр дүнгийн боловсруулалтын зардал, инфляцийг тооцсон зардал, ирээдүйд уг оюуны өмчийн хөрөнгө ашиглагдахгүй болох, **элэгдэл хорогдол** гарах зэрэг хүчин зүйлийг тооцон эцсийн байдлаар оюуны өмчийн хөрөнгийн өртгийн үнэлгээний саналыг гаргана. /*Оюуны өмчийн хөрөнгийн элэгдэл, хуучралт гэсэн ойлголтод биет физик шинж чанарын хуучралтыг оруулахгүйгээр зөвхөн функциональ, технологи, эдийн засгийн элэгдэл, хорогдлыг ойлгодог.*/

Зардалд суурилсан оюуны өмчийн хөрөнгийг үнэлэх арга зүйг түгээмэл хэрэглэдэггүй ба орлогод суурилсан арга зүйн нэг бүрэлдэхүүн хэсэг болгон ашигладаг. Түүнчлэн уг арга зүйг тухайн оюуны өмчийн сэдэв ямар ч орлого оруулах боломжгүй тохиолдолд ашигладаг байна.

Оюуны өмчийн хөрөнгийн зардалд суурилсан арга зүйг хоёр хуваадаг. Үүнд:
а) нөхөн үйлдвэрлэх зардлын арга зүй;
б) нөхөн солих зардлын арга зүй.

*Хүснэгт 2. Нөхөн бүтээх ба нөхөн өөрчлөх арга зүйн харьцуулалт*

| Нөхөн бүтээх | Нөхөн өөрчлөх |
|---|---|
| Нөхөн бүтээх арга зүй нь сэдэвчилсэн оюуны өмчтэй ижил загвар, хуулбарыг бүтээх зорилготой.<br>✓ Сэдэвчилсэн оюуны өмчийн яг ижил загвар, хуулбарыг боловсруулахдаа өнөөгийн үнийн нөхцөлийн хүрээнд нийт зардлыг тооцно.<br>✓ Хуулбар загварын хөрөнгийг боловсруулахдаа ижил, эсвэл төстэй чанар бүхий материал, стандарт, дизайн, зураг төсөл, схемыг ашиглана.<br>✓ Нөхөн бүтээх зардлын арга зүй нь технологийн өөрчлөлт, бусад материалын илүү өндөр ашиглалт, ба бусад хүчин зүйлийг тооцно. | Нөхөн өөрчлөх зардал нь сэдэвчилсэн оюуны өмчийн ашиглалт, функционал чадавхыг нөхөн бүтээхэд шаардлагатай зардлыг тодотгоохыг хэлнэ.<br>✓ Сэдэвчилэн оюуны өмчийн ижил ашиглалт эсвэл функционал чадавхыг шингээсэн хөрөнгийг өнөөгийн үнийн нөхцөлд нийт зардлыг нь тооцон гаргана.<br>✓ Хуулбар загвар нь оригналаас илүү төвшний функционал шинж чанар ба ашиглалтын түвшинтэй байж болно.<br>✓ Нөхөн өөрчлөх арга зүй нь орчин үеийн арга байх ба одоо мөрдөж буй стандарт, схем, байршлын дагуу гүйцэтгэх, шинэ технологи байх ба аль болох өндөр чанарын гүйцэтгэлийг хангана.<br>✓ Нөхөн өөрчлөгдсөн хуулбар загвар нь тухайн сэдэвт оюуны өмчийн хөрөнгөөс илүү байх тохиолдол байж болно. Тус тохиолдолд элэгдэл, хорогдлыг тооцно. |

Тус хоёр арга зүйн үндсэн нөхцөл/шаардлага нь тооцож буй зардлыг түүхэн зардал бус үнэлгээ хийж буй өдрөөр нь гаргана. Жишээлбэл, хөрөнгийн боловсруулалттай холбоотой олон хүчин зүйл эзэмшигчтэй байсан ба одоогоор нийтийн өмч болсон тохиолдолд хөрөнгийн үнэлгээ хийхэд илүү бага зардал гарах болно. Түүнчлэн судалгааны арга зүй сайжирсан тул өмнө нь судалгаандаа зарцуулсан түүхэн хугацааны зөвхөн 50 орчим хувь ижил түвшний үр дүн гаргахад шаардлагатай болно. Зардалд суурилсан оюуны өмчийн хөрөнгийн үнэлгээг хийхэд доорх үе шатаар гүйцэтгэнэ:

1) Нөхөн өөрчлөх зардлыг доорх томьёогоор тооцно:

**Нөхөн бүтээх зардал – зохицуулагдах функциональ ба технологийн элэгдэл, хорогдол = нөхөн өөрчлөх зардал**

Оюуны өмчийн хөрөнгийн дутагдалтай талыг засаж сайжруулахад гарах эдийн засгийн үр ашиг нь өөрчлөхөд шаардагдах материал, ажиллах хүч, хугацааны өнөөгийн зардлаас илүү өндөр байх тохиолдолд зохицуулах боломжтой гэж үнэлдэг.

Нөхөн өөрчлөх зардлыг ашиглан оюуны өмчийн хөрөнгийн өртгийг тооцно:

**Нөхөн өөрчлөх зардал - Эдийн засгийн элэгдэл, хорогдол - Зохицуулах боломжгүй функционал ба технологийн элэгдэл, хорогдол = Өртөг**

Оюуны өмчийн дутагдалтай талыг засаж сайжруулахад гарах /материал, ажиллах хүч, хугацаа/-ны өнөөгийн зардал нь өөрчлөхөд хүлээгдэх ирээдүйн эдийн засгийн үр

ашгаас илүү өндөр байхад зохицуулах боломжгүй гэж үнэлдэг.

2) Нөхөн бүтээх арга зүйг ашиглах нөхцөл байдал:

- Шүүн таслах ажиллагааны зорилго;
- Хөрөнгө оруулалтын нөхөн төлөлтийг хэмжих;
- Татварыг тайлагнах зорилго /эмбэддэд компьютерийн софт программ/.

3) Нөхөн өөрчлөх арга зүйг ашиглах нөхцөл байдал:

- Оюуны өмчийг худалдан авах наймаа, хэлэлцээрийн өмнөх зорилтот үнийг үнэлэх;
- Боломжит роялти хувийн суурийг тооцох;
- Шилжүүлэх үнийг тодорхойлох;
- 20 жилийн өмнөх хэрэглэгчийн брэндийг шинэ бүтээгдэхүүн бүхий өнөөдрийн зах зээлд нэвтрүүлэх;
- Интернет ба подкастинг г.м шууд хэрэглэгчтэй харьцах нөхцөл, тохиолдол.

Ашиглах арга зүйг сонгохдоо үнэлэх гэж буй оюуны өмчийн хөрөнгийн төрөл, үнэлгээ хийх огноо, үнэлгээ хийгдэж буй нөхцөл, орчинг тодорхойлно.

*Хүснэгт 3. Оюуны өмчийн хөрөнгийн зардалд суурилсан аргачлалын давуу, сул талууд*

| Давуу тал | Сул тал |
|---|---|
| Зардалд суурилсан аргачлалыг доорх тохиолдолд ашиглана:<br>✓ Оюуны өмч нь хялбар нөхөн бүтээгдэх боломжтой байх /жишээ: програм хангамж/;<br>✓ Эдийн засгийн үр ашиг, орлогын мөнгөн урсгалыг үндэслэлтэйгээр нягт нямбай хэмжих боломжгүй тохиолдолд;<br>✓ Технологийн боловсруулалтын эхний үе шатанд хянах эдийн засгийн үйл ажиллагааг явуулахгүй байгаа үе шатанд;<br>✓ Тус оюуны өмчийг ашиглан шууд мөнгөн урсгал орж ирээгүй тохиолдолд;<br>✓ Тус оюуны өмчийн хөрөнгө нь бусад хөрөнгийн нэг салшгүй хэсэг байх ба бусад аргаар үнэлэх боломжгүй байх тохиолдолд;<br>✓ Оюуны өмчийн хөрөнгийн минимум өртгийн /үнэ /floor/ тооцоог хийх ба хөрөнгөд өртөг нэмэхгүй бүрэлдэхүүнийг агуулсан зардал гарах тохиолдолд тус минимум зардал нь алдаатай гарахад;<br>✓ Тус оюуны өмчийг худалдаж авах дээд үнийг тогтооход олон орлох боломжууд байх. | ✓ Зардалд суурилсан аргачлал нь алдагдалд зардлыг оруулдаггүй. Жишээлбэл эм зүйн салбарт судалгаанд зарцуулсан асар их хэмжээний үр ашиггүй зардлыг оруулдаггүй.<br>✓ Тус арга зүй нь оюуны өмчийн шинэлэг ба онцгой шинж чанарыг тооцдоггүй. Иймд, тус үнэлгээ нь хүлээгдэх эдийн засгийн үр ашиг ба оюуны өмчийн хөрөнгөөс үүсэх орлоготой нэгддэггүй.<br>✓ Оюуны өмчийн хөрөнгийн эдийн засгийн үр ашигтай холбоотой эрсдэл, магадлашгүй байдал зэрэг хүчин зүйлийг тооцдоггүй.<br>✓ Оюуны өмчийн хөрөнгөтэй холбоотой ирээдүйн үр ашгийн чиг хандлагатай шууд нэгдэдэггүй.<br>✓ Үлдсэн эдийн засгийн эсвэл ашигай байх хугацаа /(Remaining Economic or UsefulLife (RUL)) нь тус үнэлгээний чухал хэсэг болно.<br>✓ Тус үнэлгээгээр нээлттэй зах зээлд хүлээж болох хамгийн өндөр үнийг *fair market value* таатай зах зээлийн өртгийн стандартын нөхцөлд олох боломжгүй. Энэ нь санхүүгийн чадамжтай худалдан авагчид оюуны өмчийг хуулбарлан загварчлах зардлаас илүү өндөр төлбөр төлөн тухайн хөрөнгийн эзэмшигч болох хүсэлт гаргахтай холбоотой болно. |

*<u>Зах зээлд суурилсан аргачлал (Market based)</u>*

Оюуны өмчийн хөрөнгийн үнэлгээний зах зээлд суурилсан арга зүй гэж харьцуулах боломжтой санхүүгийн нөхцөл байдал, орчинд ижил төстэй оюуны өмчийн хөрөнгийн бодит үнийн харьцуулалтад суурилсан арга зүйг хэлнэ. Тус үнэлгээг хийхэд доорх шаардлагыг хангана:

- Идэвхтэй зах зээл (үнийн мэдээлэл, цар хүрээ)

- Ижил төстэй тодорхой оюуны өмчийн хөрөнгө эсвэл харьцуулагдах ижил төстэй оюуны өмчийн хөрөнгийн багцын солилцоо
- Оюуны өмчийн хөрөнгүүдийг төгс байдлаар харьцуулах боломжгүй тохиолдолд зөрөөний хяналтыг тохируулан өөрчлөх хувьсагч шаардлагатай.

Түүнчлэн нэмэлт мэдээлэл болох шилжүүлж буй эрхийн шинж чанар, цар хүрээ ба наймаа хэлцлийн тодорхой заалт, нөхцөл, санхүүгийн нөхцөл г.м. (дамнасан лиценз, шүүхийн шийдвэрийн үеийн лицензийн хэлцэл) материалыг бүрдүүлэх нь илүү нягт нямбай үнэлгээний үр дүнг баталгаажуулна. Тус аргачлал нь өртөгт суурилсан орлогын арга зүйтэй харьцуулахад илүү зах зээлийн орчин, нөхцөл, мэдээллийг агуулдаг. Зах зээлд суурилсан үнэлгээний арга зүйн үндсэн үе шат нь дараах байдалтай байна:

- Зах зээлийн судалгаа;
- Мэдээллийн нотолгоо, баталгаажуулалтыг бүрдүүлэх;
- Харьцуулах зохистой нэгжийн сонголт ба харьцуулсан шинжилгээ хийх;
- Үнэлэгдэж буй оюуны өмч ба түүнтэй жишигдэх оюуны өмчийг судалж, хувьсагч хэмжигдэхүүнийг ашиглан харьцуулах, хөрөнгийн үнэд шаардлагатай тохируулгыг хийх;
- Шинжилгээ хийсэн олон өртгийн үзүүлэлтийг нэг өргийн үзүүлэлтээр эсвэл багцаар шилжүүлэн үнэлж буй хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг тогтоох.

*Хүснэгт 4. Зах зээлд суурилсан үнэлгээний сул, давуу талууд*

| Давуу тал | Сул тал |
|---|---|
| ✓ Хялбар арга зүй<br>✓ Зах зээлд суурилсан мэдээллийг ашигладаг<br>✓ Харьцуулах тодорхой материал /ижил төстэй технологитой холбоотой лицензийн гэрээ, хэлэлцээр/ бэлэн тохиолдолд ашиглахад хялбар.<br>✓ Роялти хувийг тогтооход олон боломжит хувилбарыг боловсруулах боломжийг бүрдүүлнэ.<br>✓ Татвартай холбогдох эрх бүхий байгууллагууд тус арга зүйг илүүд үздэг.<br>✓ Орлогод суурилсан үнэлгээний суурь өгөгдхүүнийг бүрдүүлэхэд шаардлагатай үнэлгээ болно. | ✓ Үнэлгээ хийх гэж буй оюуны өмчийн хөрөнгөтэй яг ижил, төстэй, харьцуулах боломжтой оюуны өмч байхгүй тохиолдолд ашиглах болмжгүй. Ижил төстэй оюуны өмч байсан тохиолдолд ч богино хугацаанд үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээллийг олох боломж хязгаарлагдмал байдаг.<br>✓ Зах зээлийн мэдээлэл хэт ерөнхий мэдлэг тул онцгой наймааны хэлэлцээр хийхэд шаардлагатай тусгай шинж чанартай хүчин зүйл дутмаг.<br>✓ Хугацааны фактор мэдээллийн түүхэн өгөгдлийн хуучирч, хэрэгцээгүй болсоныг илэрхийлнэ.<br>✓ Нөхөн төлбөрийн олон талт хэлбэртэй холбогдох мэдээллийг харьцуулахад төвөгтэй /хувьцаа, үнэт цаас, төлбөр, роялтийг хянах/<br>✓ Хэлэлцээрийн олон нууцлагдсан нөлөөллийн хүчин зүйлсийг тооцоолох боломжгүй /худалдан авах стратегийн урамшуулал/.<br>✓ Оюуны өмчийн хөрөнгийн роялти хувьд нөлөөлөх гадны нөлөөллийг тооцох боломжгүй. |

*Тухайн оюуны өмчийг зах зээлд нэвтрүүлсэнээс үүсэх үр ашгийг тооцох (Income) ба аудит хийх (Option) аргачлал*

**Орлогод суурилсан** оюуны өмчийн хөрөнгийн үнэлгээний аргачлал нь тус хөрөнгөөс хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн орлогыг өнөөдрийн үнэ цэнээр тодорхойлохыг хэлнэ. Тус аргачлалаар доорх зарчмаар эдийн засгийн орлогыг тодорхойлно:

- ✓ Хөрөнгийн үлдсэн ашигтай амьдралын хугацаанд (remaining useful life (RUL)) тус оюуны өмчийн хөрөнгөөс үүсэх **орлогын урсгалыг** эсвэл зардлын хэмнэлтийг төсөөлөн тооцно.
- ✓ Хэмнэлт/орлогын урсгалаас тухайн оюуны өмчийн хөрөнгөтэй шууд холбоотой зардлуудыг ялгаж авах. Үүнд ажиллах хүч, материал, шаардлагатай хөрөнгө оруулалт, эдийн засгийн орлого, зээл, хөрөнгийн татвар, тооцоо, бусад зардлууд орно.

- ✓ Бууруулсан мөнгөний эрсдлийн хүчин зүйлийг тооцно. Үүнд орлогыг өнөөгийн үнэ цэнээр /present value/ бууруулагч коэффициэнт /discount rate/эсвэл капиталжих коэффициэнтээр /capitalization rate/ олно.

Эдийн засгийн орлогыг хэмжих арга зүй нь олон орлогын арга зүйтэй холбоотой. Жишээлбэл:

- ✓ Нийт, цэвэр орлого;
- ✓ Нийт ашиг;
- ✓ Цэвэр ажлын/урсгал орлого;
- ✓ Татварын өмнөх орлого ;
- ✓ Цэвэр орлого /татварын дараах/;
- ✓ Үйлчилж буй/ажлын мөнгөн урсгал/;
- ✓ Цэвэр мөнгөн урсгал;
- ✓ Урт хугацааны өсөлттэй орлого;
- ✓ Зардлын хэмнэлт.

Дээрх олон төрлийн эдийн засгийн орлогын хэмжигдэхүүнийг бууруулагч коэффицент ба эсвэл капиталжих коэффициэнтийг ашиглан орлогыг тодорхойлох хэмжүүрийг ашиглаж болно. Олон төрлийн орлогын арга зүйг доорх хоёр үндсэн категорид хуваадаг:

**Шууд хөрөнгөжих коэффициент (Capitalization rate)**

Шинжээч тодорхой нэг хугацааны /үнэлгээ хийж буй огноогоос ирээдүйн нэг цэг хүртэл/ эдийн засгийн орлогын хэмжүүрийг үнэлэн тус хэмжүүрийг тохирох хөрөнгө оруулалтын өгөөжийн хувиар хувааж олно /Capitalization rate/. Тус капиталжих коэффициентыг тооцохдоо шинжээчийн хүлээж буй тухайн эдийн засгийн орлогын урсгалын хугацаанаас хамааран үргэлжилсэн хугацаа эсвэл онцгой заагдсан хугацаанд тооцож болно.

**Бууруулсан мөнгөний урсгал (Discounted future economic benefits)**

Шинжээч эдийн засгийн орлогыг хэмжихэд тохирох эдийн засгийн хэмжүүрээр ирээдүйн тодорхой хугацаан дах үе болгоноор төсөөлөн тооцох аргачлалыг бууруулсан мөнгөний урсгал гэж хэлнэ. Ирээдүйн эдийн засгийн орлого /мөнгөн урсгал/ -ыг таамаглан тооцохдоо өнөөгийн үнэ цэнийг бууруулах хувийг ашиглан өнөөгийн үнэ цэнэ рүү хөрвүүлнэ.

Өнөөгийн үнэ цэнийн бууруулсан хувь нь тооцсон эдийн засгийн орлогын төсөөллийн хугацааны цар хүрээндэх тодорхой хүлээгдсэн хугацаан дахь хөрөнгө оруулагчийн шаардах өгөөжийн хувь юм.

Дээр дурдсан аргачлалуудаас гадна Роялтийг чөлөөлөх аргачлал /Relief-from-royalty/ ба Сонголт/худалдан авах бүрэн эрх /Option-based аргачлал байдаг.

**Роялтийг чөлөөлөх аргачлал /Relief-from-royalty/.** Тус аргачлалаар компани тус хөрөнгийг эзэмшсэнээр чөлөөлөгдөх роялтийн төлбөрийн өртөг гэж төсөөлөн тооцдог байна. Иймд тухайн роялтийн шимтгэлийн хувийг тодорхойлох шаардлагатай тул ирээдүйд орох роялтийн орлогын урсгалыг үнэлэх шаардлагатай болно. Бууруулсан хувь нь хөрөнгийн өнөөгийн үнэ цэнийг тодорхойлоход шаардлагатай өгөгдөхүүн болно.

**Сонголтын аргачлал/ Option-based method.** Тус аргачлал нь бусад аргачлалаас ялгаатай ба хөрөнгө оруулалттай холбоотой сонголт ба боломжуудыг тооцон гаргадаг (Kamara, A., 2002).

**Бодит сонголт.** Бодит сонголтын арга зүй нь хөрөнгийн үнэлгээ, төсөвлөлтийн менежментийн сонголтын онолын илүү өргөтгөсөн, илүү сайжруулсан хувилбар болно. Тус аргачлал нь бусад аргачлалаас ялгаатай ба хөрөнгө оруулалттай холбоотой сонголт ба боломжуудыг тооцон гаргадаг. Тодорхой бус бизнесийн ертөнцөд компаниуд хугацаанаас хамааран технологийн болон эдийн засгийн хөгжлөөс хамааран төслийн цар хүрээг

өөрчлөх /өргөтгөх, гэрээ хийх, орхих/ уян хатан бодлоготой байдаг. Эдгээр боломж ба уян хатан байдлыг үнэлэхдээ үнэ бүрдэлтийн арга ба сонголтыг ашиглах аргачлалыг ашигладаг байна.

Тус аргачлал нь худалдах боломжгүй ба санхүүгийн сонголтууд шиг давтан ашиглах боломжгүй байдаг боловч үнэ, санхүүгийн сонголтуудын бүрдэлтийн арга зүйг ашиглан дүгнэлт гаргах ба өртгийг тооцох боломжтой. Тус аргаар дүн шинжилгээ хийхэд өнөөгийн цэвэр үнэ цэнэ, бууруулсан мөнгөний урсгал зэрэг уламжлалт үнэлгээний аргачлалыг ерөнхийлдөг.

Өнөөгийн цэвэр үнэ цэнэ ба бууруулсан мөнгөний урсгалын үнэлгээний зарчмын сул тал:

- Хөрөнгө оруулалтын дангаар нь хэрэглэнэ;
- Төслийг идэвхгүй хүчин зүйлээр тооцон зөвхөн хүлээгдэх мөнгөний урсгалын форкаст тооцоо хийдэг;
- Ирээдүйд орж ирэх боломжтой мөнгөний урсгалууд болон тэдгээрийн магадлал нь аль ч өгөгдсөн цагт зөвхөн хүлээгдэх мөнгөний урсгал гэсэн ганц параметраар хумигдан илэрхийлэгддэг;
- Менежерүүд ирээдүйн хөгжлийг зохион байгуулах давуу талыг тооцдоггүй. Гэтэл менежерүүд бодит байдал дээр үүсч байгаа бодит нөхцөл байдлын шахалтаар өртгийг нэмэх арга хэмжээ, зохион байгуулалтыг хийж чаддаг байна;
- Хүлээгдэх мөнгөний урсгалуудыг бууруулахдаа эрсдэлээс хамааралтай тогтмол бууруулагч коффициэнтийг ашигладаг;
  Үүнд өнөөгийн цэвэр үнэ цэнэ, бууруулсан мөнгөний урсгалын арга зүйг ашиглан хөрөнгө оруулалтын янз бүрийн сонголтын үед өртгийг тооцон гаргана.

Дэлхийн ихэнх улс орнуудад энэхүү стандартын арга, аргачлалын дагуу Оюуны өмчийн үнэлгээг мэргэшсэн үнэлгээчин хийхээс гадна оюуны өмч, төслийн чанарын болон тооны үнэлгээнд мэдээллийн технологи, программ хангамжийг өргөнөөр ашиглаж байна. Үүнд:

- Европын Холбооны патентын оффисын IP Score програм хангамж

IP Score үнэлгээний арга зүй нь патентаас гадна технологийн боловсруулалтын төслийг цогцоор нь үнэлэхэд ашигладаг (http://www.epo.org). Тус арга зүй нь тоон ба чанарын алгоритм, портфолио менежментыг агуулдаг ба үнэлэгдэж буй технологийн өнөөгийн цэвэр үнэ цэнийн санхүүгийн форкаст, график хэлбэрийн оношлогооны үр дүн, үнэлгээний тайланг гаргадаг. IP Score арга зүйг анх Дани улсын патент, барааны тэмдгийн оффис Копенгагены Их сургуультай хамран боловсруулан гаргасан ба Европын Холбооны патентын оффис түүнийг худалдаж авсан. Европын патентын оффис нь Данийн хувилбарыг бага зэрэг сайжруулж, олон хэл дээр ашиглах боломжтой болгон, ашиглалтын төлбөр төлөхгүйгээр хэрэглэх боломжийг нээсэн байна.

- Toolip Valuation програм хангамж

Toolip Valuation програм хангамж нь Tribalyte Technologies компаниас боловсруулсан ба өнөөдөр демо, бета туршилтаар ашиглаж байгаа ба IP Score арга зүйтэй ижил шинж чанарай (www.toolipvaluation.com). Тус арга зүйгээр тоон ба чанарын патентын үнэлгээг гүйцэтгэн мульти форматтай үнэлгээний тайланг гаргадаг.Тус арга зүйг патентын портфолио менежерүүд, патентын итгэмжлэгчид, технологийн лицензийн оффисууд буюу технологийн компаниудад өргөнөөр ашигладаг. Тус арга зүйгээр бууруулагч коэффицентыг ашиглан өнөөгийн цэвэр үнэ цэнийг тооцоолж ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалыг харгалзан патентын орлогын загварыг гаргадаг. Түүнчлэн тус арга зүй нь эрх зүйн өгөгдөхүүний мэдээллийг /патентын хүчинтэй хугацаа, газарзүйн тархал, үлдсэн хугацаа/ буюу санхүүгийн өгөгдөхүүн /нэг жилийн эргэл, компани буюу зах зээлд хүлээгдэх өсөлт, бууруулагч хүчин зүйл/, патенлагдсан технологийн технологи, стратеги, зах зээлийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийдэг байна. Тус арга зүйн алгоритм нь тухайн патентын амьдралын хугацаандах оролтын параметруудын статистик хэлбэрээр тооцож ирээдүйд орж ирэх мөнгөн орлогуудыг нэмж тооцож гаргадаг. Эрсдэл ба боломжийн хүчин зүйлийг бодит зах зээлийн үнэлгээнд ашигладаг. Тус арга зүйн нь лицензийн зорилготой роялти

хувийг харьцуулан тооцдог.

- Дэлхийн Оюуны өмчийн газрын IP Panorama модуль сургалт

IP Panorama арга зүйг Солонгосын Оюуны Өмчийн Оффис /Korean Intellectual Property Office (KIPO)/, Солонгосын Шинэ бүтээлийг дэмжих нийгэмлэг /Korea Invention Promotion Association (KIPA)/, Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллага /World Intellectual Property Organization (WIPO)/ хамтран боловсруулав. Ус арга зүй нь e-learning модулийн сургалтын багцаас бүрдэнэ (IP Panorama.2013.WIPO).

## ХОЁР.ОЮУНЫ ӨМЧИЙГ АШИГЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

Судалгаанд хамрагдсан улс орнуудын “Оюуны өмчийг ашиглах, шилжүүлэх, худалдах, эдийн засгийн эргэлтэнд оруулах” харилцааг холбогдох хууль, эрх зүйн орчны хүрээнд судлан үзэхэд ихэнх улс орнуудад лицензийн гэрээгээр шилжүүлэх, худалдах болон ашиглуулахаар зохицуулсан байна.

### 2.1. Америкийн Нэгдсэн Улс

Дэлхийн эдийн засгийн даяаршил бизнесийн төлөв байдалд чухал нөлөө үзүүлж байгаа бөгөөд сүүлийн үеийн хандлагаас харахад бизнесийн байгууллагуудын хувьд оюуны өмчийг үнэлэх, потенциалийг хөгжүүлэх нь онцгой байр суурь эзэлж байна.

Дэлхийн өндөр хөгжилтэй орнууд оюуны өмчийг үндэсний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх хэрэгсэл, мэдлэгт суурилсан эдийн засгийн түлхүүр гэж үздэг. Мөн оюуны хөрөнгө оруулалт нь нөөцийг байршуулах, ашиглах хамгийн үр ашигтай арга байхаас гадна байгууллагын хөрөнгөд биет бус - оюуны хөрөнгийн эзлэх хувь хурдацтай өсч байна.

Оюуны өмч нь биет шинж чанаргүй, эзэмшигчдээ онцгой эрх, эдийн засгийн үр өгөөж авчирдаг биет бус хөрөнгө юм. Жишээ нь: барааны тэмдэг, дизайн, гэрээ, програм хангамж, худалдааны тэмдэг, брэнд нэр, ноу-хау, технологи гэх мэт.

Биет бус хөрөнгө нь компаний урт хугацаат хөрөнгө оруулалтыг илэрхийлэх бөгөөд тухайн компаний оюуны өмчид хамаарна.

Оюуны өмчийн үндсэн төрөлд патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх, худалдааны нууц орно.

**Патент**. Энэ нь оюуны өмчийн бусад төрөлтэй харьцуулахад илүү үнэтэй, өртөг өндөртэй, олж авахад хүндрэлтэй байдаг. Шинэ бүтээлд патентын эрх авснаар бусад этгээдэд түүнийг зөвшөөрөлгүй хийх, ашиглах, худалдахыг санал болгох, худалдах, импортлох боломж олгохгүй, өөрөөр хэлбэл, патент эзэмшигчийн эрхийг хамгаалах юм.

**Барааны тэмдэг**. АНУ-ын Патент болон Барааны тэмдгийн байгууллагын (United States Patent and Trademark Office) тодорхойлсноор, барааны тэмдэг гэдэг нь өөрийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг бусдынхаас ялгахын тулд хэрэглэж буй ямар нэг тэмдэг, үг, үсэг, тоо, нэр зэрэг тэмдэгтүүд эсвэл тэдгээрийн хослол юм.

Барааны тэмдгийн эрх нь бусад этгээд тухайн барааны тэмдэгт орсон тэмдэгтийг (үг, үсэг, тоо, лого, загвар гэх мэт) зөвшөөрөлгүйгээр худалдаанд ашиглах, худалдахыг санал болгох, түгээх, бараа бүтээгдэхүүний сурталчилгаанд хэрэглэх боломжийг хааснаар барааны тэмдэг эзэмшигчийн (бараа бүтээгдэхүүн нийлүүлэгч, эсвэл худалдааны үйлчилгээ үзүүлэгч) эрхийг хамгаална.

**Зохиогчийн эрх**[162]. Зохиогчийн эрх нь хамгийн өргөн хэрэглэгддэг хэлбэрийн нэг бөгөөд зохиогчийн бодитой хэвлэсэн болон хэвлээгүй бүтээлийг хоёуланг хамгаалдаг. Зохиогчийн эрх нь зохиогчийн санаа гэхээс илүү оюуны хөдөлмөрөөр бий болсон ном, урлагийн бүтээл, дуу хөгжим зэрэг биет хөрөнгийг хамгаалдаг онцлогтой. АНУ-д 1909 оны Зохиогчийн эрхийн тухай хуулиар холбооны хэмжээнд зохиогчийн эрхийн талаар

---

[162] https://www.gpo.gov/fdsys/search/pagedetails.action?packageId=USCODE-2010-title17&granuleId=USCODE-2010-title17-chap1-sec106 United States Code, 17 USD 106

зохицуулах болсон. 1976 онд хуульд өөрчлөлт оруулсан бөгөөд зохиогчийн эрхийн хамгаалалт нь биет хөрөнгийг илүү хамгаалдаг.

Зохиогчийн эрх эзэмшигч нь бүтээлээ шинэчлэх, түгээх, дериватив ажлыг бэлтгэх, олон нийтийн хүртээл болгох, нийтэд толилуулах зэрэг онцгой эрхтэй. Зохиогч нь дараах эрхүүдийг эдэлнэ. Үүнд:

- зохиогчийн эрхтэй бүтээлийг олшруулах, бичлэг хийх зэргээр хуулбарлах;
- дериватив ажлыг бэлтгэх;
- зохиогчийн эрхтэй бүтээлийг хуулбар хийх, худалдах, бусдад эзэмших эрхийг шилжүүлэх, түрээслүүлэх, зээлдүүлэх зорилгоор олшруулах, эсвэл бичлэг хийх хэлбэрээр олон нийтэд түгээх;
- уран зохиол, дуу хөгжим, жүжгийн урлаг, бүжгэн жүжиг, пантомим (үггүй жүжиг), кино урлаг, дуу дүрс бичлэгийн бүтээлийг олон нийтэд үзүүлэх;
- уран зохиол, дуу хөгжим, жүжгийн урлаг, бүжгэн жүжиг, пантомим (үггүй жүжиг), уран зураг, график, уран баримал, кино урлаг, дуу дүрс бичлэгийн бүтээл зэргийг толилуулах болно.

Бүтээлд зохиогчийн эрх авах нь чухал ач холбогдолтой бөгөөд тухайн бүтээлийн хувьд дээрх үйлдлүүдийг зөвшөөрөлгүй хийх, өөрөөр хэлбэл, зөвшөөрөлгүй ашиглахаас сэргийлэх, хамгаалах боломжийг бүрдүүлнэ.

**Худалдааны нууц.** Худалдааны нууцын эрх нь түүнийг эзэмшигчид бусад этгээд хууль бусаар ашиглахаас хамгаалах боломж олгоно. Худалдааны нууцыг хууль бусаар ашигласан тохиолдолд эзэмшигч нь гомдлын шаардлага (claim) гаргах эрхтэй байна.

*Шилжүүлэх болон лиценз олгох.*

Оюуны өмчийн эрхийг шилжүүлэх, мөн оюуны өмчид лиценз олгох боломжтой. Шилжүүлэх болон лиценз олгох нь оролцогч талууд хооронд, эсвэл гуравдагч этгээдийн хувьд хийгдэнэ.

АНУ-ын Патент болон Барааны тэмдгийн байгууллага ( **The United States Patent and Trademark Office – USPTO** ) нь холбооны хэмжээнд патентын зөвшөөрөл олгодог, мөн барааны тэмдгийг бүртгэдэг байгууллага юм[163].

Зохиогчийн эрхийг Конгрессын номын санд бүртгүүлдэг. Зохиогчийн эрхийн байгууллага нь 1897 онд байгуулагдсан бөгөөд Конгрессын номын санд харьяалагдана[164].

Худалдааны нууцын хувьд түүнийг бүртгэдэггүй. Онцлог шинж нь түүнийг хамгаалахад ямар нэг тусгай процедур шаардлагагүй[165]. Мөн хязгааргүй хугацаагаар хамгаалагдаж болно. Тусгайлан бүртгэдэг байгууллага байдаггүй боловч худалдааны нууц, түүний бодлогын асуудлыг АНУ-ын Патент болон Барааны тэмдгийн байгууллага хариуцдаг.

Оюуны өмчийн зарим төрлийн хувьд шилжүүлэх болон лиценз олгоход холбогдох байгууллагад бүртгүүлснээр хүчин төгөлдөр болдог бол зарим нь оролцогч талууд хооронд тохиролцсоноор (гэрээгээр) хүчинтэй болно.

Зохиогчийн эрхийг хамтарч эзэмших боломжтой бөгөөд энэ тохиолдолд шилжүүлэх болон лиценз олгоход эзэмшигч бүр бусдаас хамааралгүй, хараат бус эрхтэй байна. Өөрөөр хэлбэл, хамтран эзэмшигч нар бие биеэсээ зөвшөөрөл авах шаардлагагүй. Харин хамтран эзэмшигч бүр бусад эзэмшигч нарт тайлбар гаргах үүрэгтэй, хэрэв хоорондоо гэрээгээр тохиролцсон бол үүнээс татгалзаж болно.

**Патентыг** шилжүүлэх, мөн патентэд лиценз олгох боломжтой бөгөөд энэ нь талууд хооронд, эсвэл гуравдагч этгээдийн хувьд хийгдэнэ.

Талууд хооронд патент шилжүүлэх, лиценз олгох аль ч тохиолдолд АНУ-ын Патент болон Барааны тэмдгийн байгууллагад (United States Patent and Trademark Organization -

[163] https://www.uspto.gov/
[164] https://www.copyright.gov/about/
[165] http://www.wipo.int/sme/en/ip_business/trade_secrets/protection.htm

USPTO) бүртгүүлэх шаардлагагүй, энэ нь талууд хоорондоо тохиролцсоноор хүчинтэй болно.

Гуравдагч этгээдийн хувьд патент шилжүүлэхэд тус байгууллагад бүртгүүлэх шаардлагатай. Энэ тохиолдолд патент шилжүүлэх нь “bona fide purchaser rule” буюу шударга худалдан авагчийн зарчмаар явагдана[166]. Харин лиценз олгоход бүртгүүлэхгүй[167].

Патентыг хамтарч эзэмших боломжтой бөгөөд патентыг ашиглах, патентад лиценз олгоход талууд гэрээгээр тохиролцсон бол хамтран эзэмшигч нь бусад хамтран эзэмшигчийн өмнө тайлбар гаргах үүргээс татгалзаж болно. Хамтарсан патентын хувьд аль нэг эзэмшигч нь бусдынхаа зөвшөөрөлгүйгээр лиценз олгох боломжтой.

**Барааны тэмдгийг** талууд хооронд шилжүүлэх, эсвэл барааны тэмдэгт лиценз олгоход АНУ-ын Патент болон Барааны тэмдгийн байгууллагад бүртгүүлэхгүй. Энэ талаар АНУ-ын Хуулийн (United States Code) 1060 дугаар зүйлийн (а)3-т “Шилжүүлгийг зохих ёсоор бичгээр хийнэ. Энэ нь шилжүүлсэн тухай нотлох баримт бөгөөд АНУ-ын Патент болон Барааны тэмдгийн байгууллагад мэдүүлэхэд шилжүүлснийг нотлох баримт болно.” гэж зохицуулсан[168].

Гуравдагч этгээдэд шилжүүлэхэд АНУ-ын Патент болон Барааны тэмдгийн байгууллагад бүртгүүлснээр хүчин төгөлөр болно. Үүнийг мөн хуулийн 1060 дугаар зүйлийн (а)4-т заасан[169].

Барааны тэмдгийн лицензийг талууд хооронд олгоход АНУ-ын Патент болон Барааны тэмдгийн байгууллагад бүртгүүлэхгүй, талууд хооронд тохиролцсоноор хүчин төгөлдөр болно. Гуравдагч этгээдийн хувьд мөн адил байна.

**Зохиогчийн эрх** эзэмших эрхийг шилжүүлэх гэдэгт шилжүүлэхэхээс гадна, моргайж, тусгай лиценз, зохиогчийн эрхэд хамаарах эрхүүдийг шилжүүлэх, барьцаалах, зохиогчийн эрхэд хамаарах тусгай эрхүүд зэргийг хамруулж ойлгоно. Үүнд онцгой бус лиценз хамаарахгүй[170].

Зохиогчийн эрхийг шилжүүлэхэд бүртгүүлэх шаардлагагүй (Конгрессын номын санд), талууд хооронд тохиролцсоноор хүчинтэй болно. Энэ нь зарим давуу талыг үүсгэнэ.

*Оюуны өмчийг хамгаалах*[171]

Оюуны өмчийн тухай ярихад анхаарлын төвд байдаг гол асуудлын нэг түүнийг хамгаалах явдал юм. Оюун ухааны хөдөлмөрийн үр дүнд бий болсон хөрөнгийг оюуны өмч гэж нэрлэдэг. Оюуны хөрөнгө нь биет бус хөрөнгийн нэг төрөл юм. Оюуны өмчийн эрх зүйн тогтолцоо нь хөрөнгө эзэмшигчийн эрхийг хамгаалдаг. Оюуны өмч эзэмшигчийн эрх болон хамгаалалт нь холбооны патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх болон худалдааны нууцын тухай хууль тогтоомжуудад үндэслэсэн байдаг.

**Зохиогчийн эрх.** АНУ нь 1988 онд Вернийн конвенцид нэгдэн орсон бөгөөд уг конвенцид зохиогчийн ёс суртахууны эрхийг авч үздэг. Харин АНУ-ын Зохиогчийн эрхийн тухай хуульд (US Copyright Act) энэ талаар тусгаагүй байна. Ёс суртахууны эрхийг хамгаалах талаар 1990 оны Дүрс бичлэгийн бүтээлчдийн эрхийн тухай хуулиар (Visual Artists Rights Act of 1990) зохицуулжээ.

Зохиогчийн эрхийн хугацаа нь 1978 оны 1-р сарын 1-нээс хойших бүтээлүүдийн хувьд зохиогчийн амьдралын хугацаа дээр нэмэх нь түүнийг нас барснаас хойш 70 жилийн турш хүчинтэй. Зохиогч нь тодорхойгүй бүтээл, эсвэл нууц нэрээр гарсан бүтээл, эсвэл хөлсөөр ажилласан бүтээлийн (work for hire) хувьд эрхийн хугацаа анх хэвлэгдэн гарснаас

[166] 35 USC 261, Title 35 Patent, Chapter 26 Ownership and assignment, Sec.261 Ownership; assignment https://www.gpo.gov/fdsys/granule/USCODE-2011-title35/USCODE-2011-title35-partIII-chap26-sec261
[167] Patent Recording Act - 35 USC 261 https://www.uspto.gov/web/offices/pac/mpep/s301.html
[168] 15 USC 1060(3) https://www.gpo.gov/fdsys/granule/USCODE-2011-title15/USCODE-2011-title15-chap22-subchapI-sec1060
[169] 15 USC 1060(4) https://www.gpo.gov/fdsys/granule/USCODE-2011-title15/USCODE-2011-title15-chap22-subchapI-sec1060
[170] 17 USC 101 https://www.gpo.gov/fdsys/granule/USCODE-2011-title17/USCODE-2011-title17-chap1-sec101
[171] https Guide to going global IPT //www.dlapiperintelligence.com/goingglobal/intellectual-property/

хойш 95 жил, эсвэл үүссэн цагаас хойш 125 жилийн хугацаатай байна. Харин 1978 оноос өмнө анх хэвлэгдэн гарсан бүтээлийн хугацаа нь зарим хүчин зүйлсээс хамаараад янз бүр байдаг.

1978 оны 1-р сарын 1-нээс өмнө хэвлэгдэн гарсан, эсвэл бүртгэгдсэн бүтээлүүдийг 28 жилийн дараа дахин шинэчлэн бүртгэх ба энэ нь хуулийн зүгээс зарим давуу талыг олгодог. Харин 1978 оны 1-р сарын 1-нээс хойших бүтээлүүдийн хувьд шинэчлэн бүртгэх шаардлагагүй.

**Патент нь** АНУ-ын Үндсэн хуулиар олгогдсон албан ёсны эрх юм. Патентын эрх нь хуулиар хамгаалагдсан бөгөөд бусдад патент бүхий бүтээлийг хийх, ашиглах, худалдах, худалдахыг санал болгох, импортлохыг зөвшөөрөхгүй.

АНУ-ын Хуулийн 35 дугаар бүлэг нь патентын талаар зохицуулна. Тус улс нь 1887 онд Парисын конвенцид (Paris Convention), 1970 онд Патентын хамтын ажиллагааны гэрээнд (Patent Cooperation Treaty) нэгдэн орсон.

Патент бүхий бүтээл нь эрхийн хүчинтэй хугацааны туршид хамгаалагдана. 1995 оны 6-р сарын 8-наас хойш бүртгэгдсэн патентын хувьд нь анх зөвшөөрөл олгогдсноос 20 жилийн хугацаанд хүчинтэй. Түүнээс өмнө бүртгэгдсэн бол анх бүртгүүлсэн хугацаанаас хойш 20 жил, эсвэл зөвшөөрөл олгосон хугацаанаас хойш 17 жил хүчинтэй (энэ хоёр хугацааны аль урт хугацаагаар тооцно). Америкт 2013 оны 3-р сарын 16-наас “first to file” системийг хэрэгжүүлж эхэлсэн.

Дизайны патентын хувьд 2015 оны 5-р сарын 13-наас эхэлж бүртгүүлсэн бол зөвшөөрөл олгогдсоноос хойш 15 жилийн хугацаатай байна.

**Барааны тэмдгий**г хамгаалах асуудлыг Ланхамын хуульд (Lanham Act) тусгасан. Барааны тэмдгийн бүртгэл нь 10 жилийн хугацаатай байх ба тухайн бизнесийн үйл ажиллагаа үргэлжилж байвал шинэчлэн сэргээж болно. Муж болгоны хувьд бүртгэлийн хугацаа харилцан адилгүй. Тухайлбал, Калифорнид 5 жил байхад Нью Йоркт 10 жил байна.

Барааны тэмдэг эзэмшигч нь лиценз олгохдоо барааны тэмдэгт алдаа гарахаас зайлсхийх, мөн эрхээ хамгаалах үүднээс хэл зүйн хувьд зохих хяналтыг сайн хийх хэрэгтэй.

**Худалдааны нууц.** 2016 оны 5-р сарын 16-нд Холбооны Засгийн газар нь Худалдааны нууцыг хадгалах тухай хуулийг (Defend Trade Secret Acts) баталсан. Энэ хууль нь худалдааны нууцыг хууль бусаар эзэмших тохиолдолд гомдол мэдүүлэх процессыг холбооны түвшинд зохицуулна. Үүнээс өмнө худалдааны нууцыг мужийн түвшинд хамгаалдаг байсан бөгөөд Нью Йорк, Массачусетаас бусад муж болгон тус тусын Худалдааны нууцын Нэгдмэл Төрөлжсөн хуультай (Uniform Trade Secrets Act) байжээ.

*<u>Оюуны өмчийн гэрээ, хэлэлцээр</u>*

Оюуны өмчийг ашиглахад шаардагдах гэрээ хэлэцээрийг худалдааны гэрээ хэлэлцээртэй адил зохицуулна. Америкт Монополийн тухай хууль, тусгай үйлдвэрлэлийн талаарх зохицуулалт зэрэг зарим Холбооны түвшний зохицуулалтууд байх боловч худалдааны гэрээ хэлэлцээрийг Холбооны хэмжээнд зохицуулдаг нэгдсэн зохицуулалт байхгүй. Тусгай үйлдвэрлэлд мөн адил мужийн зохицуулалтууд байдаг ба энэ нь худалдааны гэрээ хэлэлцээрт хамааралтай байж болно.

Худалдааны гэрээ хэлэлцээрийг Худалдааны Нэгдмэл Төрөлжсөн Хуулиар (Uniform Commercial Code) зохицуулах бөгөөд уг хууль нь 50 мужийн хувьд өөр өөр байдаг. Энэ хуулиар бараа бүтээгдэхүүний гэрээ хийх, тухайлбал, худалдан авах болон худалдах, аюулгүй байдалтай холбоотой асуудал, зээлийн гэрээ, худалдааны бусад хэлэлцээрүүдийг зохицуулна. Муж болгон өөр өөрийн Худалдааны Нэгдмэл Төрөлжсөн Хуультай учир эдгээр зохицуулалтууд муж бүрт адил биш байна.

Худалдааны гэрээ хэлэлцээрийг тайлбарлах болон хэрэгжүүлэх нь мужийн хуулиар зохицуулагдах бөгөөд гэрээ хэлэлцээрт мужийн хуулинд заасны дагуу тусгагдана. Худалдааны Нэгдмэл Төрөлжсөн Хуулийн заалтыг өмнө хэрэгжүүлсэн тохиолдол буюу

хуулийг тайлбарлах, хэрэгжүүлэх нь муж бүрт ялгаатай.

## 2.2. Израил улс

Израилд худалдааны нууцаас бусад оюуны өмчийн төрлүүд буюу зохиогчийн эрхийг Зохиогчийн эрхийн тухай хуулиар (Copyright Act, 2007) , патентыг Патентын тухай хуулиар (Patent law), барааны тэмдгийг Барааны тэмдгийн тухай хуулиар (Trade Mark Ordinance) зохицуулдаг. Харин худалдааны нууц нь Худалдааны эрх зүйн зөрчлийн тухай хуулиар (Commercial Tort law) хамгаалагддаг.

**Зохиогчийн эрх.** Зохиогчийн эрх нь зохиогчийн эд хөрөнгийн эрх болон эд хөрөнгийн бус буюу ёс суртахууны эрхийг хамгаалдаг. 2007 оны Зохиогчийн эрхийн тухай хуулийн 4-р зүйлийн (а)-д зааснаар уран зохиол, жүжиг, дуу хөгжим, бусад урлаг соёлын бүтээл зэргийг хуулиар хамгаална. Эд хөрөнгийн бус буюу ёс суртахууны эрхийг хамгаалах нь оюуны өмчийн жинхэнэ эзнийг албан ёсоор тогтоож, зөвшөөрөлгүй ашиглахаас сэргийлэх ач холбогдолтой.

Зохиогчийн эрхийн талаар зохицуулдаг гол хууль нь 2007 оны Зохиогчийн эрхийн тухай хууль (Copyright Act 2007) юм. Уг хуульд зохиогчийн эрх нь түүний амьд байх хугацаа дээр нэмэх нь нас барснаас хойш 70 жилийн турш хүчинтэй. Хэрэв зохиогч нь нэгээс олон хүн байвал хамгийн сүүлд амьд үлдсэн зохиогчийн амьд байх хугацаанд нэмэх нь түүний нас барснаас хойш 70 жилийн турш хэвээр байна.

Уран зохиол, жүжиг, дуу хөгжим, уран сайхны бүтээл зэргийн хувьд зохиогчийг, дуу бичлэгийн хувьд продюсерыг үндсэн эзэмшигчээр тооцно. Лицензийг (ашиглах эрх) зохиогчийн эрх эзэмшигч болон тусгай зөвшөөрөл авсан этгээд олгодог. Тусгай лиценз олгох, эсвэл зохиогчийн эрх шилжүүлэхэд заавал бичгээр хийх ба харин тусгай бус лиценз бол бичгээр хийх шаардлагагүй.

Эд хөрөнгийн бус эрх буюу ёс суртахууны эрхийг шилжүүлэх боломжгүй, харин өвлөх боломжтой гэж хүлээн зөвшөөрдөг. Оюуны бүтээлийн нэг хэлбэр болох программ хангамжийн хувьд энэ эрх байдаггүй онцлогтой.

Зохиогчийн эрхийг зөрчсөн, эсвэл эд хөрөнгийн бус буюу ёс суртахууны эрхийг зөрчсөн тохиолдолд хуулийн дагуу арга хэмжээ авна. Үүнд: хориглох, мөнгөн төлбөр, хуулийн дагуу хохирлыг тооцох (Statutory damages), хөрөнгийг хураан авах, устгах зэрэг орно.

**Патент.** Патент нь тодорхой зүйлийг хийх шинэ арга замыг нээсэн, эсвэл аливаа техникийн шинэ шийдлийг санал болгож буй бүтээгдэхүүн болон арга ажиллагаанд (шинэ бүтээлд) өгч буй онцгой эрх юм. Патент эзэмшигч нь эрхийнхээ хугацаанд бүтээлийг үйлдвэрлэх, ашиглах, худалдахыг санал болгох, худалдах, импортлох зэрэг эрхийг эдэлнэ. Патентын хугацаа 20 жилээр олгогдоно. Патент эзэмшигч нь түүний бүтээлийг гуравдагч этгээд зөвшөөрөлгүйгээр ашиглахаас сэргийлэх эрхтэй байна.

Патентын тухай хуулийн Тавдугаар бүлэгт патент эзэмших эрхийн тухай (Ownership of patent) зохицуулсан[172]. Хуулинд зааснаар шинэ бүтээл болон түүний патентыг хэд хэдэн хүн хамтран эзэмшиж (joint patent) болно. Үүнд: эзэмшигч бүр адил эрхтэй байна. Адил биш байх тохиолдолд хоорондоо гэрээгээр, эсвэл хуулийн дагуу зохицуулна.

Гэрээгээр, эсвэл хуулийн дагуу өөрөөр зохицуулаагүй бол патент хамтран эзэмшигч бүр тухайн бүтээлийг ашиглах эрхтэй. Энэхүү ашиглахдаа бусад хамтран эзэмшигч нар нь **патент ашигласан эзэмшигчээс роялти, эсвэл олсон ашгаас хуваалцахыг нэхэж шаардахаас сэргийлэх зорилгоор гэрээгээр, эсвэл хуулийн дагуу зохицуулалт** хийдэг.

Патент хамтран эзэмшигч нар хоорондоо өөрөөр тохиролцоогүй бөгөөд тэр тухай гэрээний баримтыг Бүртгэлийн байгууллагад бүртгүүлээгүй бол патент эзэмшигч бүр өөрийн эзэмших эрхийг бусад эзэмшигчдийн зөвшөөрөлгүйгээр шилжүүлж болно[173].

---

[172] Патентын тухай хууль, Тавдугаар бүлэг http://www.wipo.int/wipolex/en/text.jsp?file_id=341499
[173] Патентын тухай хууль, Тавдугаар бүлэг, 80-р зүйл http://www.wipo.int/wipolex/en/text.jsp?file_id=341499

Хэд хэдэн патент эзэмшигч нь патентын асуудлаар шүүхэд гомдол гаргаж болох ба Шүүх нь бусад эзэмшигч нарт патент ашиглах, лиценз олгох, патентад хамааралтай бусад зүйлийг, өөрөөр хэлбэл, гомдолд хамааралтай асуудлыг биелүүлэх шийдвэр гаргана. Мөн гомдол гаргасан патент эзэмшигч нараас аль нэгийг Шүүхээс итгэмжилсэн төлөөлөгчөөр томилж, асуудлыг зохицуулах эрх олгоно[174].

Бүтээл болон түүний патент эзэмших эрхийг хуульд заасны дагуу шилжүүлж болох бөгөөд энэ нь бичгээр хийгдэнэ.

Патентыг гуравдагч этгээдэд шилжүүлэхдээ талууд хооронд гэрээ байгуулснаар хүчин төгөлдөр болно[175].

Патент эзэмшигч нь патент бүхий бүтээлийг ашиглахын тулд тусгай ба тусгай бус лиценз олгож болох бөгөөд энэ нь бичгэн хэлбэрээр хийгдэнэ[176]. Лиценз олгохдоо талууд хооронд гэрээ байгуулснаар хүчинтэй болно.

**Барааны тэмдгийн** хувьд бүртгэлтэй, болон бүртгэлгүй буюу алдартай барааны тэмдэг гэж байдаг. Барааны тэмдгийг 1972 оны Барааны тэмдэгийн тухай хуулиар (Trade Marks Ordinance (New Version) 1972) зохицуулна.

Барааны тэмдгийн хугацаа ерөнхийдөө хязгааргүй байдаг. Барааны тэмдгийн байгууллагаас барааны тэмдгийг эзэмших эрхийг тогтооно. Лиценз олгох тохиолдолд Барааны тэмдгийн байгууллагад заавал бүртгүүлэх шаардлагатай. Sub-license буюу гуравдагч этгээдэд лиценз олгох талаар Барааны тэмдгийн тухай хуулинд дурдаагүй боловч Барааны тэмдгийн байгууллагад мөн адил бүртгүүлнэ гэж үздэг.

Барааны тэмдэгт хамааралтай зөрчлийн асуудлыг 1999 оны Худалдааны эрх зүйн зөрчлийн тухай хуулиар (Commercial Torts Law 1999) зохицуулна.

**Худалдааны нууц**. Худалдааны нууцад олон нийтэд нээлттэй бус бизнесийн мэдээлэл хамаарна. Худалдааны нууц нь эзэмшигчдээ өрсөлдөгчөөс ялгарах давуу тал олгодог.

1999 оны Худалдааны эрх зүйн зөрчлийн тухай хуулиар худалдааны нууцыг зохицуулна. Тухайн бизнесийн мэдээллийн нууцлал хэдий хүртэл үргэлжилнэ, худалдааны нууцын хугацаа тэр хүртэл үргэлжлэх онцлогтой. Худалдааны нууц эзэмшигч нь тухайн бизнесийн мэдээллийн эзэн байна.

Худалдааны нууцад лиценз олгох боломжтой бөгөөд заавал бүртгүүлэх шаардлагагүй.

Худалдааны эрх зүйн зөрчлийн тухай хуулийн 2 дугаар бүлэгт худалдааны нууцыг хууль бусаар ашиглах талаар зохицуулсан байна[177]. Хуулинд худалдааны нууцыг зүй бусаар ашиглахыг хориглосон. Бусдын худалдааны нууцыг хууль бусаар ашиглаж болохгүй бөгөөд дараах үйлдлүүд нь худалдааны нууцыг буруугаар ашигласанд тооцогдоно. Үүнд:

- Худалдааны нууцыг эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр хэрэглэхийг хууль бус гэж үзнэ. Энд худалдааны нууцыг эзэмшигчээс нь авах, эсвэл өмчилж буй өөр этгээдээс авах нь ялгаагүй гэж тооцогдоно.
- Худалдааны нууцыг эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр ашиглах, гэрээгээр эсвэл итгэлцлийн үндсэн дээр хүлээсэн үүргийг, мөн худалдааны нууцыг эзэмшигчийн олгосон давуу талыг буруугаар ашиглахыг хориглоно.

Оюуны өмчийн зарим төрөлд лиценз олгох, эрх шилжүүлэх процесс нь гэрээ хэлэлцээр хийснээр хүчинтэй болдог.

[174] Патентын тухай хууль, Тавдугаар бүлэг, 81-р зүйл http://www.wipo.int/wipolex/en/text.jsp?file_id=341499
[175] Патентын тухай хууль, Тавдугаар бүлэг, 83-р зүйл http://www.wipo.int/wipolex/en/text.jsp?file_id=341499
[176] Патентын тухай хууль, Тавдугаар бүлэг, 84-р зүйл http://www.wipo.int/wipolex/en/text.jsp?file_id=341499
[177] Худалдааны эрх зүйн зөрчлийн тухай хууль, 2 дугаар бүлэг, 6(a) http://www.wipo.int/wipolex/en/text.jsp?file_id=128055#LinkTarget_112

Израил улсын хувьд бүх төрлийн гэрээ хэлэлцээрийг Гэрээний тухай хуулиар (Contract Law) зохицуулдаг. Энэ хууль нь гэрээ байгуулах, гэрээний хэлбэр, гэрээний агуулга, гэрээний биелэлт, гэрээг цуцалснаас үүсэх үр дагавар болон гэрээтэй холбоо бүхий бусад харилцааг зохицуулна.

Гэхдээ зарим тохиолдолд тусгай гэрээгээр зохицуулдаг. Тухайлбал, худалдан борлуулах (үүнд бараа таваарын гадаад худалдаа хамаарна), зуучлал (гадаад худалдааны зуучлалыг оруулна), даатгал, батлан даалт, эрх үүрэг хуваарилах, стандарт гэрээ зэрэг орно.

**2.3. <u>Финланд улс</u>**

Финланд улс нь Дэлхийн оюуны өмчийн байгууллага /WIPO/ - д 1970 онд гишүүнээр элсэн орсон. Дэлхийн оюуны өмчийн байгууллагын цахим хуудсанд дурдсанаар Финланд улсад оюуны өмчийн харилцааг зохицуулж буй 48 хууль, 22 хэрэгжүүлэх дүрэм, журам, 78 гэрээ байна.[178] Финландын оюуны өмчийн үнэлгээний эрх зүйн орчин, үнэлгээний харилцаанд оролцогчдын үүрэг, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах лиценз, лицензийн гэрээ, эрх шилжүүлэх, оролцогчдын үүрэг хариуцлагын талаарх зохицуулалтуудыг тус улсын оюуны өмчийн харилцааг зохицуулж буй голлох хууль болох Патентын тухай хууль, Барааны тэмдгийн тухай хууль, Зохиогчийн эрхийн хууль, Ашигтай загварын тухай хууль, Дизайн хамгаалах хуулиуд болон Патент ба бүртгэлийн газар, Худалдааны танхимын цахим хуудаснаас ерөнхий байдлаар судалж үзлээ.

Финланд улсын Патент ба бүртгэлийн газар нь оюуны өмчийн аливаа асуудлыг хариуцдаг бөгөөд дан ганц оюуны өмчийг хариуцах бус бизнесийн бүртгэлийн бүхий л асуудлыг хариуцдаг байна.

*<u>Оюуны өмчийн үнэлгээний талаарх зохицуулалт</u>*:

Оюуны өмчийн үнэлгээний хувьд бие даасан хууль байхгүй бөгөөд дэлхийн оюуны өмчийн байгууллагын гишүүн орны хувьд үнэлгээний олон улсын стандартыг дагаж мөрдөхийн зэрэгцээ худалдааны танхимаас гаргасан дотоодын дүрэм, журмыг мөрддөг байна.

Тус улсад оюуны өмчийн үнэлгээчин гэсэн тусдаа зохицуулалт байхгүй бөгөөд эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан үл хөдлөх хөрөнгийн үнэлгээчин гэсэн ойлголт байна. Тусгай зөвшөөрөлтэй хөрөнгийн үнэлгээчин гэдэг нь Финландын Худалдааны танхимын Хөрөнгийн үнэлгээний зөвлөлөөс зөвшөөрөгдсөн шинжээчид юм. Тусгай зөвшөөрөл бүхий хөрөнгийн үнэлгээчин нь үнэлгээний үйл ажиллагаанд шаардлагатай мэдлэг, боловсрол эзэмшсэн бөгөөд үнэлгээний салбарт дор хаяж 3-5 жил ажилласан туршлагатай байхыг шаарддаг байна. Тусгай зөвшөөрөл бүхий хөрөнгийн үнэлгээчин нь Хөрөнгийн үнэлгээний зөвлөлийн дүрэм, журам, заавар, хөрөнгийн үнэлгээний конвенц болон **Олон улсын үнэлгээний стандартыг** дагаж мөрдөх үүрэг хүлээдэг.

Финландын Худалдааны танхимаас зөвшөөрөгдсөн үнэлгээчид нь Үл хөдлөх хөрөнгийн сангийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Ипотекийн банкны тухай хууль тогтоомжид тулгуурлан үйл ажиллагаа явуулдаг байна.

Финландын Хөрөнгийн үнэлгээний зөвлөл нь тусгай зөвшөөрөл бүхий хөрөнгийн үнэлгээчдэд эрх олгож, тэдний үйл ажиллагаанд хяналт тавих эрхтэй. Үүнээс гадна хөрөнгийн үнэлгээчний шалгалтыг зохион байгуулж, Финландын Худалдааны танхимаас эрх олгогдсон хөрөнгийн үнэлгээчдийг хөгжүүлэх, удирдан чиглүүлэхээс гадна хяналт тавьж, хөрөнгийн үнэлгээний олон улсын гэрээ, хэлэлцээрийг хөхиүлэн дэмжиж, ерөнхий зөвлөмж өгөх байдлаар үйл ажиллагааг хянадаг байна. Мөн хөрөнгийн үнэлгээний чиглэлээр сургалт, судалгааны ажлыг явуулдаг.

*<u>Оюуны өмчийг ашиглах, шилжүүлэх зохицуулалт</u>*:

Финланд улсын зохицуулалтаас харахад оюуны өмчийн эрх шилжүүлэх, лицензийн

[178] http://www.wipo.int/wipolex/en/profile.jsp?code=FI

асуудлыг гэрээний талууд хуулийн хүрээнд хууль зөрчихгүйгээр харилцан тохиролцож болохоор зохицуулж өгсөн байна. Ингэхдээ хамгийн чухал нь өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй байх асуудлыг тусгасан байна. Бусад асуудалд төр ямар нэг байдлаар оролцохгүй бөгөөд хуулийн хүрээнд **гэрээний талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээгээр зохицуулдаг** байна. Лиценз, лицензийн гэрээ, эрх шилжүүлэх асуудлуудыг хууль тус бүрт хэрхэн зохицуулсныг тоймлон харууллаа.

**Патентын тухай хууль.[179] /Patents Act, 1967 он/**

Патентын тухай хуулийн 6 дугаар бүлгээр лиценз, албан журмын лицензийн асуудлыг зохицуулсан бөгөөд хуулийн 43 дугаар зүйлд патент эзэмшигч нь бусад этгээдэд өөрийн ашиглах эрхээ шилжүүлж /лиценз/ байгаа бол хүлээн авсан этгээд нь гэрээгээр хэлэлцэн тохиролцоогүй бол гуравдагч этгээдэд тус эрхийг шилжүүлж өгөхийг хориглоно гэж заасан байна.

Мөн патентыг олгох, шилжүүлэхдээ патент, бүртгэлийн асуудал эрхэлсэн холбогдох байгууллагад бүртгүүлэх ба патент барьцаалах үйл ажиллагаанд дээрх зохицуулалтыг мөн адил дагаж мөрдөнө.

Бүртгэгдсэн патент нь хүчин төгөлдөр бус бол тухайн патентыг бүртгэлээс хасна. Дээрх зохицуулалтыг албан журмын лиценз болон хуулийн 53.2-т заасан патентыг хязгаарлах зохицуулалтын үед мөн адил хэрэглэнэ.

Патентаар бүртгүүлсэн сүүлчийн бүртгэл эзэмшигч нь патентын өмчлөгчид тооцогдон, нэхэмжлэл гаргах болон патенттай холбогдох бусад эрх эдлэнэ.

Хэрэв хэн нэгэн этгээдээс патентыг барьцаалбарын үндсэнд, эсхүл бусад байдлаар шилжүүлэн авсан, эсхүл лиценз эзэмшиж байгаа талаар бүртгүүлэхийг хүссэн нөхцөлд, бусад этгээдээс тухайн асуудлаар бүртгүүлэх хүсэлт гаргаагүй бол тухайн патенттай холбогдох өмнөх бүртгэлийг хүчингүйд тооцохоор тусгасан байна.

45 дугаар зүйлд зааснаар патент олгосноос хойш 3 жил, патент бүртгүүлэх хүсэлт гаргаснаас хойш 4 жил өнгөрсөн бөгөөд тухайн патентын бүтээл нь Финланд Улсад нийтийн хүрээнд ашиглагдаж эхлээгүй, ажиллаагүй бол тухайн патентын бүтээл дээр ажиллахыг хүссэн аливаа этгээд албан журмын лицензийг авч болдог байна.

Дээрх заалтыг хангах үүднээс Засгийн газраас тухайн патентын бүтээл дээр гадаадын улс оронд ажиллахыг дотоодод ажиллаж байгаатай адилтган үзэж болно.

46 дугаар зүйлд патентыг ашиглах нь патентын өмчлөгчөөс хамааралтай патент эзэмшигч нь онцгой чухал ач холбогдол бүхий шалтгаанаар тус патентыг албан журмын лицензээр авах хүсэлтийг гаргаж болно. Нийтийн ашиг сонирхлын үүднээс аливаа этгээд нь албан журмын лиценз олгох хүсэлтийг гаргаж болно. Албан журмын лицензийг тухайн ашиглаж байгаа үйл ажиллагаа, эсхүл ашиглахаар зорьж байгаа чиглэл, зорилгын хамт гуравдагч этгээдэд шилжүүлж болно.

Хуулийн 50 дугаар зүйлд зааснаар албан журмын лицензийг зөвхөн шүүхийн шийдвэрээр олгох ба үүнд нөхөн төлбөр, лиценз ашиглах үйл ажиллагаа, түүний хүрээ зэрэг холбогдох бусад асуудлуудыг шийдвэрлэдэг байна.

**Барааны тэмдгийн тухай хууль.[180] /Trademarks Act, 1964 он/**

Барааны тэмдэг шилжүүлэх болон лицензийн асуудлыг хуулийн 5 дугаар бүлгээр ерөнхийд нь зохицуулсан байна.

32-р зүйлд зааснаар барааны тэмдгийг бусдад шилжүүлж болох ба барааны тэмдгээр бүртгэгдсэн тухайн барааг бүхэлд нь, эсхүл зарим хэсгээр нь бусдад шилжүүлж болно. Барааны тэмдэг өмчлөгч хуулийн этгээд нь өөр өмчлөгчид шилжсэн тохиолдолд барааны тэмдэг өмчлөх эрх, өмнөх өмчлөгчид үлдэхээр тохиролцоогүй бол шинэ

[179] Patents Act, https://www.prh.fi/en/patentit/lainsaadantoa/patenttilaki.html
[180] Trademarks Act, https://www.prh.fi/en/tavaramerkit/lainsaadanto/Tavaramerkkilaki.html

өмчлөгчид дагалдан шилжих, эсхүл өмнөх болон шинэ өмчлөгч нь хоёулаа барааны тэмдгийг өөр төрлийн бараануудад ашиглаж болно.

Барааны тэмдгийг бусдад шилжүүлэхдээ заавал бүртгүүлнэ. Хэрэв бүртгэлийн байгууллага барааны тэмдгийг шилжүүлсний дараа ашиглах нь бусдыг төөрөгдүүлсэн байдалд хүргэнэ гэж үзвэл бүртгэлийг зогсоож, тухайн төөрөгдөлд хүргэж буй зүйлсийг барааны тэмдгээс арилах хүртэл саатуулах эрхтэй байдаг байна.

Барааны тэмдгийг бүртгүүлээгүй нь тухайн барааны тэмдгийг зохих ёсоор олж авсан гуравдагч этгээдэд ямарваа нэгэн байдлаар нөлөөлөхгүй.

Барааны тэмдгийн эрхийг барьцаалах тохиолдолд бичгээр гэрээг үйлдэж, энэ талаараа холбогдох байгууллагад бүртгүүлнэ. Энэ бүртгэл хийгдэх хүртэл барьцааны эрх хүчингүй байна.

Хуулийн 34-р зүйлд зааснаар барааны тэмдэг эзэмшигч нь өөрийн эрхээ алдахгүйгээр бусдад барааны тэмдгээ лизингээр ашиглуулж болно. Лиценз нь бүртгэлээр хамгаалагдсан барааны бүхэлд нь буюу зарим хэсгийг, мөн тухайн улсын газар нутгийн хүрээнд, эсхүл зохих газруудыг хамран хэрэглэж болно. Лиценз эзэмшигч нь нэг буюу түүнээс дээш байж болно. Бүртгэгдсэн барааны тэмдгийн хэрэглээ нь бусдыг төөрөгдүүлэхээр бол бүртгэлийн байгууллага бүртгэхээс татгалзаж болно. Лицензийн хугацаа дуусахад уг бүртгэлийг бүртгэлээс хасна.

Барааны тэмдгийн лицензийг бүртгүүлээгүй нь тухайн барааны тэмдгийг зохих ёсоор олж авсан гуравдагч этгээдэд ямарваа нэгэн байдлаар нөлөөлөхгүй. Мөн талууд өөрөөр тохиролцоогүй бол лиценз эзэмшигч нь лицензээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

Барааны тэмдгийн эрхийг барьцаалснаас бусад тохиолдолд ямарваа нэгэн өр төлбөр, үүргийн гүйцэтгэлд тооцохыг хориглоно. Барааны тэмдэг эзэмшигч дампуурсан тохиолдолд барааны тэмдэг нь түүний хөрөнгөд тооцогдоно.

### Зохиогчийн эрхийн тухай хууль.[181] /Copyright Act,1961 он/

Тус хуулийн гуравдугаар бүлэгт зохиогчийн эрхийг шилжүүлэхтэй холбоотой зохицуулалтуудыг тусгасан бөгөөд 27 дугаар зүйлд зохиогчийн эрхийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн шилжүүлж болохоор заасан байна. Талууд өөрөөр тохиролцоогүй бол зохиогчийн эрхийг шилжүүлэн авсан этгээд нь зохиогчийн эрхийн бүтээлийг өөрчлөх, бусдад шилжүүлэхийг хориглосон. Зохиогчийн эрхийг бизнесийн зорилгоор ашиглах бол тухайн бизнесийн үйл ажиллагаатай холбоотойгоор шилжүүлэн өгч болох боловч зохиогчийн эрхийг шилжүүлсэн этгээд нь тухайн гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлыг бие даан хариуцна.

Зохиогчийн эрх шилжүүлэх гэрээнд гэрээний нөхцөлүүд тодорхойгүй, эсхүл тухайн гэрээний хэрэгжилт нь тодорхойгүй нөхцөл байдал үүсгэхээр бол гэрээний дээрх нөхцөлийг зайлшгүй өөрчлөн тодорхой болгоно.

Зохиогчийн эрхийн нөхөн төлбөрийн асуудал нь гэрээний гол нөхцөлийн нэг байна. Дээрх зохицуулалтыг талууд өөрөөр харилцан тохиролцоогүй нөхцөлд л хэрэглэхээр заасан байна. Тус бүлэгт зохиогчийн эрхийг шилжүүлэхэд зохиогчийн эрхийн бүтээл тус бүрт тавигдах шаардлагуудыг заасан байх боловч энэ нь зөвхөн гэрээгээр талууд өөрөөр хэлэлцэн тохиролцоогүй нөхцөлд тус зохицуулалтыг дагаж мөрдөхөөр заасан байна.

### Ашигтай загварын тухай хууль.[182] /Act on Utility Model Rights, 1991 он/

Тус хуулийн 6 дугаар бүлэгт ашигтай загварыг бусдад шилжүүлэх, лиценз, албан журмын лицензтэй холбогдох зохицуулалтыг тусгажээ. Барааны ашигтай загварыг бусдад шилжүүлж болох ба шилжүүлэн авсан этгээд нь ашигтай загварыг арилжааны зорилгоор буюу лицензийн үндсэн дээр ашиглах бол өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр гуравдагч

---

[181] Copyright Act, http://www.wipo.int/wipolex/en/text.jsp?file_id=397616
[182] Act on Utility Model Rights, http://www.wipo.int/wipolex/en/text.jsp?file_id=254415

этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

Талууд өөрөөр тохиролцоогүй бол ашигтай загварыг аж ахуйн нэгж буюу компанид шилжүүлсэн бол тухайн ашигтай загварыг аж ахуйн нэгжийн хамт бусдад шилжүүлж болно. Энэ тохиолдолд тухайн шилжүүлж буй этгээд лицензийн гэрээнд заасан холбогдох хариуцлагыг хүлээнэ.

Ашигтай загварыг бусдад шилжүүлэх болон лицензээр эзэмшүүлэхдээ холбогдох эрх бүхий байгууллагад бүртгүүлж, тогтоосон төлбөрийг төлнө. Ашигтай загварыг барьцаалах нөхцөлд мөн адил бүртгүүлнэ. Хэрэв бүртгэлд бүртгэгдсэн лиценз буюу барьцаа хүчин төгөлдөр бус болохыг нотолсон тохиолдолд бүртгэлийг нэгдсэн системээс хасна.

Ашигтай загварыг бүртгэснээс хойш хоёр жилийн хугацаа өнгөрсөн боловч, шинэ бүтээлийг зохистой хэмжээнд, нийтийн хүрээнд ашиглаж эхлээгүй бол тухайн улсад шинэ бүтээл дээр ажиллахыг хүсч байгаа аливаа этгээд албан журмын лицензийг авч болохоор заасан байна.

### 2.4. <u>Бүгд Найрамдах Хятад Ард Улс</u>

Хятадад оюуны өмчийг худалдах, шилжүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлыг Патентын тухай хууль[183], Зохиогчийн эрхийн тухай хууль[184], Барааны тэмдгийн тухай хууль[185], Гэрээний тухай хууль[186], Шударга бус өрсөлдөөний тухай хууль[187] болон бусад холбогдох журам, гэрээгээр голчлон зохицуулдаг.

Харин оюуны өмчийн үнэлгээний талаар холбогдох хуулиудад ямар нэгэн тусгайлсан зохицуулалт байхгүй бөгөөд Дэлхийн оюуны өмчийн байгууллагын гишүүн орны хувьд Олон улсын үнэлгээний стандарт, арга, аргачлалыг баримтлан үнэлгээг хийдэг жишиг байна. Олон улсын үнэлгээний стандартад оюуны өмчийг үнэлэх арга, аргачлалын талаар нарийвчлан заасан байдаг бол талуудын үүрэг оролцоо, хариуцлагын талаар тодорхой зохицуулалт байхгүй байна.

Оюуны өмчийг худалдах, шилжүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулахдаа лицензийн гэрээ буюу тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулахыг шаарддаг бөгөөд гэрээгээ Оюуны өмчийн газарт бүртгүүлэхийг зөвлөдөг. Сүүлийн жилүүдэд Хятадын засгийн газраас ШУ, технологийн ололт амжилтыг арилжааны эргэлтэд оруулж, улс орныхоо эдийн засгийг эрчимжүүлэх зорилгоор олон хууль, журмыг баталж, шинэчлэх ажлыг хийсэн.

Патентын эрхийг хамгаалах, лицензийн үйл ажиллагааг зохицуулах, патентын эрхийн зөв зохистой ашиглалтыг сурталчлах зорилгоор Хятадын Оюуны өмчийн алба нь Патентын хууль ба Гэрээний тухай хуулийн үндэс болгон “Лицензийн гэрээг бүртгэх захиргааны арга хэмжээ” -г батлан 2011 оны 8 дугаар сарын 1-ээс хэрэгжүүлж эхэлсэн байна. Энэ арга хэмжээний дагуу патент эзэмшигчид нь лицензийн гэрээгээ өөрийн ашиг сонирхлоо хамгаалахын тулд бүртгүүлж болно.

**Лицензийн талаарх зохицуулалт**[188]: Хятадын лицензийн төрөлд бүх төрлийн оюуны өмч, технологи/ноу хау лицензийн зөвшилцөлтэй холбоотой барааны тэмдгийн лиценз, патентын лиценз, зохиогчийн эрхийн лицензийн зохицуулалтууд багтсан байдаг.

<u>*Барааны тэмдгийн лицензийг*</u> Барааны тэмдгийн тухай хууль ба худалдааны тэмдгийн линцензийн гэрээг бүртгэх арга хэрэгслүүдээр зохицуулж байна. Барааны тэмдгээ бүртгүүлэгч бусад этгээдэд барааны тэмдгийн линцензийн гэрээ байгуулснаар өөрийн бүртгэлтэй барааны тэмдгийг ашиглуулж болох ба, бүртгэлтэй барааны тэмдэг бүхий бүх бараанд линценз эзэмшигчийн нэр ба барааны гарал үүслийг заавал бичнэ. Хэдийгээр заавал бүртгүүлэх албагүй ч *линценз ашиглуулах гэрээг* гарын үсэг зурснаас хойш 3 сарын дотор Барааны тэмдгийн албанд бүртгүүлнэ. Барааны тэмдгийн, эсхүл

---

[183] Patent Law of the People's Republic of China http://www.wipo.int/wipolex/en/text.jsp?file_id=178664
[184] Copyright Law of the People's Republic of China http://www.wipo.int/wipolex/en/text.jsp?file_id=186569
[185] Trademark Law of the People's Republic of China http://www.wipo.int/wipolex/en/text.jsp?file_id=341321
[186] Contract law of the people's republic of china http://www.wipo.int/wipolex/en/text.jsp?file_id=182632
[187] Шударга бус өрсөлдөөний тухай хууль
[188] Intellectual Property Licensing in China https://www.hg.org/article.asp?id=35379

үйлчилгээний тэмдгийн эрх хууль ёсоор байддаггүй, *харин лиценз эзэмшигчийн зөвшөөрөл, гэрээний үндсэн дээр олгогддог*.

<u>*Патентын лицензийг*</u> Патентын тухай хуулиар зохицуулна. Шинэ бүтээл, загвар дизайн *ашиглах гэх зэрэг бүх төрлийн патентыг харилцан тохиролцсон гэрээний үндсэн дээр олгоно*. Патентын хуулийн дагуу лиценз эзэмшигч нь харилцан тохиролцсон гэрээнд патентыг ашиглуулахаар зааснаар өөр ямарваа этгээд, эсхүл хувь хүнд зөвшөөрөл өгөх эрхгүй. Лиценз олгогч Оюуны өмчийн албанд линценз эзэмшүүлэх гэрээгээ бүртгүүлнэ.

<u>*Зохиогчийн (Copyright) эрхийн линцензийг*</u> Зохиогчийн эрхийн хууль ба түүнийг хэрэгжүүлэгч журмуудаар зохицуулна. Зохиогчийн эрхийг өмчлөгч нь дахин олшруулах эрх, түгээх эрх, түрээслүүлэх эрх, дэлгэн үзүүлэх эрх, тайзнаа тоглуулах эрх, орчуулах эрх, эмхэтгэх эрх гэх зэрэг *өмчийн эрхийг бусдад линцензээр эзэмшүүлж болно*. *Харин хэвлэн нийтлүүлэх эрх, зохиогчийн эрх, сэлгэх эрх, бүтээлийн үл хөндөгдөх эрх зэрэг хувь хүний эрхийг линцензээр эзэмшүүлэхийг хориглодог*. Зохиогчийн эрхийг линцензээр ашиглуулах тухай гэрээгээ Зохиогчийн эрхийг хамгаалах төвд бүртгүүлэхийг зөвлөдөг ба энэ нь эрх зөрчигдсөн тохиолдолд баримт болно гэж үздэг байна.

Барааны тэмдгийн тухай хууль, Патентын тухай хууль ба бусад холбогдох эрх зүйн зохицуулалтууд нь бичгээр үйлдсэн лицензийн гэрээг албан ёсоор бүртгүүлэхэд тавигдах шаардлагуудыг заасан байдаг. Гэхдээ энэ нь патентын лицензийн хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй. Хэдий тийм боловч албан ёсоор бүртгүүлэх шаардлагыг хангаагүй бол тухайн лицензийг гурав дахь талын эсрэг зүй ёсоор хэрэглэх боломжгүй болно.

Лицензийн бүхий л гэрээ нь ерөнхийдөө дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:

- ✓ Лиценз олгогч ба эзэмшигчийн бүтэн нэр, хаяг, гэрээтэй холбоотой Хятадын патентын (өргөдлийн) дугаар гэх зэрэг дэлгэрэнгүй мэдээлэл;
- ✓ Хүчин төгөлдөр болох өдөр ба дуусгавар болох өдөр;
- ✓ Лицензийн төрөл;
- ✓ Лиценцийн төлбөр ба төлбөр төлөх практик арга зам;
- ✓ Лицензийг хэрэгжүүлэх газар.

Харин технологийн гэрээний нөхцөлийг талууд тодорхойлох ба гэрээнд тавигдах шаардлага буюу тусгах асуудлуудыг Гэрээний тухай хуулийн 324-р зүйлд тодорхой заасан байна. Тухайлбал,

1) Төслийн нэр;
2) Агуулга, цар хүрээ ба судлагдахууны шаардлага;
3) Төлөвлөгөө, хуваарь, хугацаа, байршил, газар нутаг, гүйцэтгэлийн арга;
4) Техникийн мэдээлэл ба материалын нууцлал;
5) Эрсдлийн хариуцлагын хуваарилалт;
6) Технологийн өмчлөл ба түүнээс олох ашгийн хуваарилалт;
7) Хэрэглэх стандарт, шалгуурыг зөвшөөрөх арга;
8) Үнэ, нөхөн төлбөр, лицензийн төлбөр ба төлбөрийн арга;
9) Гэмтлийн торгууль, эсхүл гэмтлийг тооцох арга;
10) Маргааныг шийдвэрлэх арга;
11) Нэр томьёо ба үг хэллэгийн тодорхойлолт.

Эдгээр гэрээнд тусгагдах зүйлс бүрэн тусгагдсан эсэхийг Хятадын оюуны өмчийн газраас бүртгэлийг хийхдээ шалгаж авдаг байна.

Талууд дараах материалуудыг гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой бүрэлдэхүүн хэсгүүд гэж хүлээн зөвшөөрч болно. Үүнд: Техникийн үндэслэлийн мэдээлэл, хэрэгжилтийн судалгаа ба техникийн үнэлгээний тайлан, төслийн зорилтын матрикс ба төслийн төлөвлөгөө, техникийн стандарт, техникийн үзүүлэлт, эх загвар, техникийн бичиг баримтууд зэрэг бусад холбогдох техникийн баримт бичгүүд орно.

Хятадад оюуны өмчийн гадаад эзэмшигч, эсхүл лиценз олгогч нь Хятад дахь лиценз эзэмшигчтэйгээ хамтралгүйгээр оюуны өмчийн эрх зөрчсөн гурав дахь талын эсрэг гомдол гаргаж шүүхээр шийдвэрлүүлж болох боловч практик амьдрал дээр ийм тохиолдолд

лиценз олгогч ба эзэмшигчид гол төлөв хамтдаа гомдол гаргадаг байна.

Гэсэн хэдий ч лиценз эзэмшигч дангаараа лиценз олгогчийн зөвшөөрөлгүйгээр лиценз бүхий оюуны өмчийн эрх зөрчсөн талын эсрэг гомдол гаргах боломжгүй байдаг. Лиценз олгогчоос зөвшөөрөөгүй ямарваа эрхийг лиценз эзэмшигч эдлэхгүй.

**Төлбөр ба татвар (Royalties and taxes):** Лицензийн төлбөрийг төлөх тухай тусгайлсан хууль Хятадад байхгүй ба, үүнийг талууд лицензийн гэрээндээ тусган оруулдаг зүйл байдаг байна.

Хятадын Үнэ шилжүүлэх тухай хуулийн зохицуулалтаар бол хэрвээ лиценз олгогч ба лиценз эзэмшигч хоёр нь холбоотой талууд бол үнэ шилжүүлэх дүрмийн тухайд олон улсын лицензийн зохицуулалтыг хэрэглэнэ.

Гадаадын аж ахуйн нэгжид лицензийн төлбөр төлдөг Хятадын аж ахуйн нэгжүүд нь Аж ахуйн нэгжийн орлогын татварын хуулийн дагуу ашиг орлогын татвар (10%) төлнө.

Хятадад 50.000 ам доллараас дээш хэмжээний шилжүүлгийг татварын албанд бүртгүүлэх шаардлагатай. Гадаадын валют арилжааны удирдлагын дүрмийн дагуу мөнгөн гуйвуулгыг тухайн мөнгө шилжүүлэгч татвар төлсөн гэрчилгээгээ үзүүлсэн тохиолдолд л банк хийдэг байна.

Гадаадын лиценз олгогч нь гагцхүү Хятадын нутаг дэвсгэр дотор олсон ашиг орлогынхоо татварыг төлнө. Харин Хятадад ямар нэг байгууллага байгуулсан лиценз олгогч нь тухайн байгууллагынхаа Хятадын нутаг дэвсгэрт болон гадаадад олсон ашиг орлогоос аж ахуйн албан татвар төлнө. Хятадад ямар нэг байгууллага байгуулаагүй, эсхүл байгуулсан боловч олсон ашиг орлого нь тухайн байгуулагын үйл ажиллагаатай хамааралгүй гадаадын лиценз олгогчийн тухайд бол зөвхөн Хятадын нутаг дэвсгэр дотор олсон ашиг орлогынхоо хувь хэмжээгээр татвар төлнө.

**Хариуцлагын талаарх зохицуулалт:** Хятадын хуулиудад тусгай зөвшөөрлийн гэрээг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох эрх, хязгаарлах, олон улсын лицензийн харилцааг сунгахгүй байх эрх, эсхүл дуусгавар болох ба дахин сунгагдахгүй болсны нөхөн төлбөр зэргийн тухай ямарваа нөхцөл заалт байдаггүй. Харин энэ бүхнийг гэрээндээ тусган оруулахыг зөвлөдөг байна.

Аливаа нэг лицензийн гэрээ цуцлагдахад гурав дахь этгээдэд цааш нь олгосон дагалдах лиценз бас давхар цуцлагдан дуусгавар болно. Гэрээнд энэ талаар дурдаагүй байсан ч дагалдах лиценз нь үндсэн лиценздээ суурилна. Тэгэхээр лиценз эзэмшигч нь тухайн лицензийг цааш олгох эрхээ алдаж байна гэсэн үг юм.

Хятадад олон улсын линцензийн харилцааг шууд зохицуулсан хууль эрх зүй байдаггүй ч *Хятадын зах зээлийн өрсөлдөх чадварыг мэдэгдэхүйц бууруулж болох аливаа үйл ажиллагааг Гадаад худалдааны тухай хуулиар хориглодог*. Олон улсын лицензийн харилцаанд оролцогч талууд татвар болон гадаад арилжааны заалтууд, IP хаягийн зохицуулалтын дагуу холбогдох засаг захиргааны байгууллагуудын бүртгэл тэмдэглэлүүдэд үйл ажиллагаагаа нийцүүлнэ.

Шударга бус өрсөлдөөний хуульд бизнес эрхлэгчдийг зөв шударга байхыг шаардахын зэрэгцээ хуурамч бараа, арилжааны авлигал, төөрөгдүүлсэн сурталчилгаа, худалдааны нууцыг зөрчих, хог хаягдал оруулах, үндэслэлгүй нөхцөл бүхий тохиролцоо хийх гэх зэрэг зарим тодорхой шударга бус өрсөлдөөнийг хориглодог.

Гэрээний тухай хуульд зааснаар талууд эрхээ эдэлж, үүргээ биелүүлэх шударга, сайн зарчмыг баримтална. Дараах нөхцөлүүдийн аль нэг нь бүрдсэн тохиодолд талууд гэрээгээ цуцална. Үүнд:

1) давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан гэрээний зорилгыг биелүүлэх боломжгүй болсон;

2) үйл ажиллагааны хугацаа дуусахаас өмнө нөгөө тал үндсэн үүргээ биелүүлэхгүй гэдгээ тодорхой мэдэгдсэн, эсхүл үйл үйлдлээрээ илэрхийлсэн;

3) нөгөө тал үндсэн үүргээ биелүүлэлгүй хойш суусан бөгөөд биелүүлэхийг шаардсанаас хойш зохих хугацаанд биелүүлээгүй;

4) нөгөө тал үүргээ биелүүлэлгүй удааширсан, эсхүл ямар нэг байдлаар гэрээгээ зөрчсөн бөгөөд гэрээний зорилгоо биелүүлэх боломжгүй болсон.

Аж ахуйн нэгжийн дампуурлын хуулийн дагуу лиценз эзэмшигчийн дампуурсан тухай өргөдлийг шүүх хүлээн авмагц шүүхээс томилогдсон албан хаагч лицензийн гэрээг үргэжлүүлэх, эсхүл даруй цуцлах тухайд шийдвэрлэх эрхтэй байна. Хэрвээ шүүхээс томилогдсон албан хаагч тийнхүү үргэлжлүүлэх шийдвэр гаргавал лиценз олгогч гэрээгээ үргэлжлүүлэн биелүүлж болох ч лиценз олгогч нь тухай албан хаагчаас баталгаа гаргаж өгөхийг шаардаж болно. Нэгэнт лиценз олгогчийн дампуурлыг зарлавал лиценз олгогч нь зээлдэгчийн ёсоор дампуурлын журмын дагуу нөхөх олгоговороо хүлээнэ.

Лиценз эзэмшигч лиценз олгогчийн албан ёсны зөвшөөрөлгүйгээр ямарваа гуравдагч талд дам лиценз олгож болохгүй.

БНХАУ-ын Гэрээний тухай хууль ба Иргэний хэргийн хуулиудад зааснаар бол олон улсын лицензийн гэрээ нь талуудын өөрсдийнх нь сонгосон өөр бусад шүүхээр зохицуулагдаж болдог байна. Талууд гэрээндээ маргаан гарсан тохиолдолд Хятадын аль нэг шүүхээр орохын оронд арбитарын шүүхээр шийвэрлүүлнэ гэж тохиролцож болно. Гэрээлэгч талуудын аль нэг нь ямар нэгэн гадаад улсад байрладаг бол арбитарын шүүх нь аль нэг өөр оронд болж болно.

Лиценз эзэмшигчийн зүгээс гадаадын лиценз олгогчийн оюуны эрх, эсхүл харилцан тохиролцсон нөхцөлдөө заасан хязгаарлалтуудын хүчин төгөлдөр байдалтай холбогдуулан маргалдахыг хориглож болдог байна. Учир нь ийм үйл үйлдлийг зохицуулах хууль байдаггүй. Гэхдээ ийнхүү маргалдахгүй гэх нөхцөлтэйгөөр гэрээ үйлдэхдээ БНХАУ-ын Шударга бус өрсөлдөөн ба Гэрээний тухай хуулийн дагуу шударга бус өрсөлдөөнгүй, аливаа зөрчилгүйгээр хийхийг заасан байна.

### 2.5. <u>Сингапур улс</u>

Сингапур улс нь 1990 онд Дэлхийн Оюуны өмчийн байгууллагын гишүүнээр элссэн байна. Оюуны өмчийн бодит зохицуулалт нь Сингапур улсад инновацид суурилсан эдийн засаг болон үйлдвэр, худалдааны өсөлтийг дэмжихэд чухал ач холбогдолтой байна. Тус улс нь оюуны өмчийн бүхий л талыг хамарсан бодлого хэрэгжүүлэхэд анхаардаг бөгөөд тухайлбал, патент, худалдааны тэмдэг, зохиогчийн эрх, бүртгэгдсэн загвар, үйлдвэрлэлийн төрлүүд, бараа бүтээгдэхүүний гарал үүсэл болон худалдааны нууц зэрэг болно. Оюуны өмчийн тухай дотоодын хууль, тогтоомжоо шинэчилж, мөрдлөг болгон ажиллах зэрэг тодорхой үйл ажиллагаануудыг Сингапур улсын Хууль зүйн яамнаас хэрэгжүүлж байна. Энэ нь эдийн засгийн зорилтыг дэмжих, оюуны өмчийн салбарын хөгжилд түлхэц үзүүлэх, Сингапур улсын эрх ашгийг олон улсын тавцанд хамгаалах зэрэг ач холбогдолтой байна.

Сингапур улс нь оюуны өмчийн салбарт хэрэгжүүлж буй бодлогоороо дэлхийд тэргүүлэгч юм. 2014 оноос хойш Дэлхийн эдийн засгийн форумаас эрхлэн гаргадаг Дэлхийн өрсөлдөх чадварын тайланд Оюуны өмчийг хамгаалах чадвараараа шилдэг 5 улсын нэгд багтсаар байна. 2013 онд тус улсын Засгийн газраас Ази тивдээ Сингапурын гол давуу талыг хөшүүрэг болгон, Дэлхийн оюуны өмчийн тэргүүлэгч болохын хувьд хүрсэн амжилтаараа замчлах Оюуны өмчийн тэргүүлэгч мастер төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байна.

2017 оны 2 дугаар сард Ирээдүйн эдийн засгийн хороо нь (Committee on the Future Economy) ирэх 10 жилийн хугацаан дахь эдийн засгийн стратегийн талаарх зөвлөмжийг гаргасан байна. Сингапурын Оюуны өмчийн байгууллага, Хууль зүйн яам хамтран Сингапурын инновацийн экосистемийг бэхжүүлэх талаарх Ирээдүйн эдийн засгийн хорооны зөвлөмжийг дэмжих болон эдийн засгийн үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор Оюуны өмчийн тэргүүлэгч мастер төлөвлөгөөг шинэчлэн гаргасан байна. Шинэчилсэн төлөвлөгөө нь тус салбарын хүрсэн ололт, амжилтанд суурилсан хийгээд шинийг санаачлагч аж ахуйн нэгжүүд өөрсдийн бүтээсэн оюуны өмчөө баталгаажуулах, арилжаалах замаар эдийн засгийн өсөлтөнд оюуны өмчийг ашиглахад дэмжлэг үзүүлэхэд

зорьж байна.[189]

*Тус улсад оюуны өмчтэй холбоотой аливаа харилцааг дараах хуулиуд, эдгээр хуулийг хэрэгжүүлэх болон дагаж мөрдөх 32 дүрэм, журам, тус улсын даган орсон олон улсын, олон талт, хоёр талт болон бүс нутгийн хэмжээний нийт 51 гэрээ хэлэлцээрээр зохицуулж байна.*[190] *Үүнд:*

- “Үйлдвэрийн төрөл зүйлийг хамгаалах тухай” хууль (Plant Varieties Protection Act) 2014;
- “Бүртгэгдсэн загварын тухай” хууль (Registered Designs Act) 2014;
- “Патентын тухай” хууль (Patents Act) 2014;
- “Оюуны өмчийн (бусад нэмэлт өөрчлөлтүүд) тухай” хууль (Intellectual Property (Miscellaneous Amendments) Act) 2012;
- “Зохиогчийн эрхийн тухай” хууль (Copyright Act) 2006;
- “Барааны тэмдгийн тухай” хууль (Trade Marks Act) 2005;
- “Сингапурын оюуны өмчийн байгууллагын тухай” хууль (Intellectual Property Office of Singapore Act);
- “Ашигтай загварын тухай” хууль (Layout-Design of Integrated Circuits Act) 1999;
- “Газар зүйн заалтын тухай” хууль (Geographical Indications Act) 1999.

*Оюуны өмчтэй холбоотой батлагдсан хуулиуд:*

- “Баримт нотолгооны тухай” хууль (Evidence Act) 2015;
- “Хууль тогтоомжийн (бусад нэмэлт өөрчлөлтүүд) тухай” хууль (Statutes (Miscellaneous Amendments) Act) 2014;
- “Үйлдвэрийн хяналтын тухай” хууль (Control of Plant Act) 1999;
- “Эмийн тухай” хууль (Medicines Act) 1998.

Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэнд оруулахад тухайн оюуны өмчид үнэлгээ хийх, оюуны өмчийг эзэмших, ашиглах эрхийн тухай асуудал үүснэ. Сингапур улсад оюуны өмч нь компаниудад чухал үүрэг гүйцэтгэх болсон тул олон тооны бизнес эрхлэгчид өөрсдийн патент болон худалдааны тэмдгээ үнэлүүлэх болсон байна. Жижиг компаниуд үйл ажиллагаагаа өргөжүүлж зах зээлээ тэлэхэд оюуны өмчийн үнэлгээний процесс чухал үүрэгтэй. Компаний үйл ажиллагаа жигдэрч, олон нийтэд танигдах нь хялбар болох үед компаний үнэ цэнэ биет хөрөнгөнөөс илүү биет бус хөрөнгөнд оршдог гэж үздэг байна. Ингэснээр Сингапур улс нь компаниудад биет бус хөрөнгөө барьцаалан, ялангуяа оюуны өмчийн эрхээ барьцаа болгон зээл авахыг зөвшөөрдөг дэлхийн анхдагч улсуудын нэг болсон байна. Засгийн газрын зүгээс дотоодын компаниудын бий болгосон патент болон худалдааны тэмдгийн хамгаалалтыг эрчимжүүлэхийг зорьсноор сүүлийн жилүүдэд Сингапур улс нь оюуны өмчөөр дэлхийд тэргүүлэгч улс болсон байна. Сингапур дахь бизнес эрхлэгчдийн тоо өсөн нэмэгдэхийн хэрээр оюуны өмчийн үнэлгээний асуудалд анхаарлаа улам хандуулах болжээ.

Сингапур улсад оюуны өмчийн үнэлгээний тусгайлсан зохицуулалт байхгүй бөгөөд оюуны өмчийн үнэлгээ хийхдээ Олон улсын үнэлгээний стандарт (International Valuation Standard) – ыг баримталж оюуны өмчийн үнэлгээг хийдэг:

- Өртөгт суурилсан;
- Зах зээлд суурилсан;
- Орлогод суурилсан зарчмуудыг баримталж байна.

Орлогод суурилсан үнэлгээний зарчмыг ихэвчлэн Сингапурт үйл ажиллагаа явуулж буй гадаадын компаниуд ашигладаг байна.[191]

Хуулийн дагуу оюуны өмчийг эзэмшигч нь дараах 2 замаар оюуны өмчөө ашиглах боломжтой. Үүнд:

- Оюуны өмчийг худалдах буюу шилжүүлэх;

---

[189] https://www.mlaw.gov.sg/content/minlaw/en/our-work/intellectual-property-policy.html
[190] http://www.wipo.int/wipolex/en/profile.jsp?code=SG
[191] https://www.lawyers-singapore.com/intellectual-property-valuation-in-singapore

- Оюуны өмчийг ашиглах лиценз эзэмших.

Лиценз нь оюуны өмчийг ашиглах эрх бүхий лиценз эзэмшигч талуудаас хамаараад онцгой лиценз, дангаар эзэмших лиценз, онцгой бус лиценз гэсэн 3 үндсэн төрөлд хуваагдаж байна. Сингапур улсын оюуны өмчтэй холбогдон гарах харилцааг зохицуулж буй хуулиудад оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэнд оруулахад зайлшгүй шаардагдах лиценз буюу тусгай эрхийн талаар хэрхэн хуульчилсныг авч үзье.

**“Патентын тухай” хууль (Patents Act)**[192]

“Патентын тухай” хуулийн VIII, X, XI хэсгүүдэд патентын лиценз, патентын өмчлөгч, эзэмшигч, патентын бүртгэл, лицензийн эрх, түүнийг эзэмшигч эрх бүхий талууд, тэдгээрийн хоорондын харилцааны тухай зохицуулсан байна.

VIII хэсэг. Өмчийг патентжуулж, бүртгүүлэх тухай

- Патентыг эзэмших, ашиглах, шилжүүлэх хүсэлтийн тухай;
- Патентын бүртгэл;
- Патентын эрх;
- Бүртгэлийг засварлах;
- Патентын хамтран өмчлөгч;
- Патентын эрхийг авсны дараа өмчлөгчийг нягтлах зэрэг асуудлуудыг зохицуулсан байна.

X хэсэг. Патентжуулсан бүтээгдэхүүнийг ашиглах гэрээний тухай

- Патентжуулсан бүтээгдэхүүний нийлүүлэлтийн гэрээ;
- Патентжуулсан бүтээлийг ашиглах лиценз;
- Патентжуулсан бүтээгдэхүүний нийлүүлэлт болон Патентжуулсан бүтээлийг ашиглах лицензийн гэрээний тухай зохицуулсан байна.

XI хэсэг. Лицензийн эрх болон албадан лицензийн тухай

- Лицензийн эрх;
- Лицензийн эрхийг цуцлах;
- Албадан лицензийн  талаар тус тус зохицуулсан байна.

Патент авахаар бүртгүүлж буй бүтээл нь шинэ, шинэлэг санаа агуулсан, үйлдвэрт хэрэгжүүлэх боломжтой байх ёстой. Патент нь бүртгүүлснээс хойш 20 жилийн хугацаанд хүчинтэй бөгөөд патентын хугацааг сунгах боломжтой. Патент олгосноос хойш түүний өмчлөгч нь Бүртгэлийн албанд патентын лицензийг бусдад эзэмшүүлэх хүсэлт гаргах эрхтэй. Гэрээний дагуу патент өмчлөгчийн эрхийг хязгаарлахгүй гэсэн нөхцөлтэйгөөр, патентыг эзэмших хүсэлтэй, бүртгэгдсэн этгээдэд патентын лиценз эзэмших эрхийг мөн олгоно. Ингэснээр хэд хэдэн хүн патентын лиценз эзэмших эрхтэй байна.

Патент өмчлөгч нь тухайн патентыг ашиглах гэрээ байгуулах бөгөөд энэхүү гэрээнд ямар үүрэг, хариуцлага хүлээх, гэрээгээр ашиглах гэж буй бүтээлээ нарийн тодорхойлох ба бүтээлээ хэрхэн яаж ашиглах (бүтнээр нь, эсхүл хэсэгчлэн) ямар нөхцөлд бүтээлээ ашиглахыг хориглох, гэрээнд заасан гуравдагч этгээд гэж хэнийг хэлэх, гэрээнд ямар эрх үүрэгтэй оролцох гэх мэт зүйлсийг тодорхой тусгах шаардлагатай байна.

Лиценз эзэмшигчидтэй холбогдон гарах маргааныг тус хууль болон Иргэний хууль (Civil Act), лиценз эзэмшигч талуудын хооронд байгуулсан гэрээгээр шийдвэрлэнэ.

**“Зохиогчийн эрхийн тухай” хууль (Copyright Act)**[193]

“Зохиогчийн эрхийн тухай” хуулиар хамгаалагдах бүтээл нь эх хувиараа, бодит хэлбэрээр илэрхийлэгдсэн байх, тодруулбал, бичлэг (recording) хийгдсэн, эсхүл бичиж тэмдэглэгдсэн байх ёстой байна. Бүтээлийн төрлөөс хамаарч зохиогчийн эрхийн хүчинтэй хугацаа 25 жилээс 70 жил байх ба зарим бүтээлд зохиогчийн нас барсан жилийг дуусгавар болтол хамгаалдаг байна.

---

[192] http://www.wipo.int/wipolex/en/details.jsp?id=14587
[193] http://www.wipo.int/wipolex/en/details.jsp?id=6132

Зохиогчийн эрхийн тухай хуулийн X хэсгийн 194, 195, 196 дугаар зүйлүүдэд зохиогчийн эрхэд лиценз олгох болон зохиогчийн эрхийг шилжүүлэх, зохиогчийн эрхийн ирээдүйн өмчлөгчийн талаар зохицуулсан байна. Мөн зохиогч өөрөө гуравдагч этгээдэд лиценз олгох эрхтэй гэжээ. Тус хуулийн 7 дугаар зүйлд зохиогчийн онцгой эрх эзэмшигч нь зохиогчийн эрхийг өмчлөгчтэй ижил эрхтэй байна гэж заасан байна. Үүнээс улбаалаад талуудын хооронд гарах маргааныг шийдвэрлэхэд хүндрэл гарч болзошгүй байдаг тул тус хуулийн 119, 126 (a,b) болон 127 дугаар зүйлүүдэд талуудын хоорондын маргааныг шийдвэрлэхэд шаардагдах илүү нарийвчилсан заалтуудыг нэмэлтээр оруулсан байна.[194]

Сингапурын Оюуны өмчийн газраас зохиогчийн эрхийг бусдад эзэмшүүлэх болон шилжүүлэхдээ гэрээ байгуулах шаардлагатай хийгээд гэрээнд дараах зүйлсийг анхаарахыг санал болгожээ.[195]

Зохиогчийн эрх (copyrights)-ийн лицензийн гэрээ (Licensing contract)-нд дараах зүйлсийг тусгах шаардлагатай байна. Үүнд:

- Гэрээнд оролцогч талууд;
- Лиценз олгосон бүтээл;
- Лиценз эзэмшигч нь лиценз бүхий бүтээлийг хэрхэн ашиглах талаар;
- Роялти төлбөрийн талаар;
- Гэрээгээ зөрчсөн талуудын хүлээх үүрэг;
- Лиценз эзэмших хугацаа зэрэг болно.

Зохиогчийн эрх (copyrights)-ийг шилжүүлэх гэрээ (Assignment contract)-нд дараах зүйлсийг тусгах шаардлагатай байна.

- Гэрээнд оролцогч талууд;
- Шилжүүлсэн бүтээл;
- Шилжүүлгийн төлбөрийн нөхцөл;
- Шилжүүлгийн хугацаа;
- Зохиогчийн эрхийн шинэ эзэмшигчээс хийх шаардлагатай зүйлс зэрэг болно.

Дээрх гэрээнүүдэд оролцогч талуудын эрх үүргийг нарийвчлан тодорхой заах шаардлагатай байна.

**“Барааны тэмдгийн тухай” хууль (Trade Marks Act)**[196]

Тус хуулиар барааны тэмдэгтэй холбогдон гарах харилцааг зохицуулах ба дуу авиа, 3D хэлбэр, өнгө, хөдөлгөөн, баглаа боодол, голограммын тэмдэг зэрэг уламжлалт бус барааны тэмдгийг мөн хамруулж болно. Барааны тэмдгийн бүртгэлийг 10 жил тутам шинэчилж хийх шаардлагатай байна. Тус хуулийн V хэсэгт барааны тэмдгийн лицензтэй холбогдох зохицуулалтуудыг хуульчилжээ.

V хэсэг. Лиценз олгох

- Бүртгэгдсэн барааны тэмдэгт лиценз олгох;
- Онцгой лиценз;
- Үүргээ зөрчсөн тохиолдолд лиценз эзэмшигчийн эрхэд хамаарах ерөнхий заалтууд;
- Барааны тэмдгийн лицензийг шилжүүлэн авсан этгээдтэй адил эрх бүхий онцгой лиценз эзэмшигч зэрэг болно.

Тус хуулийн 42 дугаар зүйлд барааны тэмдгийн лиценз нь бичгээр үйлдсэн, лиценз олгогчийн гарын үсэг бүхий байснаар хүчин төгөлдөрт тооцогдоно гэжээ. Мөн 39 дүгээр зүйлд барааны тэмдэгтэй холбогдон гарах харилцаанд оролцогч талууд нь албан ёсоор хүсэлт гаргаж Бүртгэлийн албанд бүртгүүлээгүй тохиолдолд лицензийг нь хүчингүйд тооцно гэсэн байна. Барааны тэмдгийн онцгой эрх эзэмшигч болон барааны тэмдгийн өмчлөгч нарын хоорондын маргааныг шийдвэрлэхэд хүндрэл гарч болзошгүй байдаг учраас дээрх “Зохиогчийн эрхийн тухай” хуультай адил нэмэлт зохицуулалтыг Барааны

---

[194] http://www.singaporelaw.sg/sglaw/laws-of-singapore/commercial-law/chapter-13
[195] https://www.ipos.gov.sg/understanding-innovation-ip/copyright/assignment-and-licensing
[196] http://www.wipo.int/wipolex/en/text.jsp?file_id=187981

тэмдгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн (1,5,8) дахь заалтуудаар хийсэн байна.

**“Бүртгэгдсэн загварын тухай” хууль (Registered Designs Act)**[197]

Энэ хуулиар бүртгэгдсэн загвартай холбогдон гарах харилцааг зохицуулах ба загвар нь бүртгэлийн шаардлагыг хангахын тулд шинэ, үйлдвэрт ашиглагдсан байх ёстой байна. Анх бүртгүүлэхээр хүсэлт тавьсан өдрөөс хойш бүртгэгдсэн загвар нь 5 жилийн хугацаанд хамгаалагдана.Үүнээс хойш төлбөрөөс хамааран 5 жил тутам 1 удаа, нийт 15 жилийн хугацаанд хамгаалагдана.

Тус хуулийн III хэсгийн 30 дугаар зүйлээр бүртгэгдсэн загварыг өмчлөгч бүртгэгдсэн эзэн, түүнд олгосон онцгой эрхийг зохицуулжээ. 31 дүгээр зүйлээр бүртгэгдсэн загварыг ашиглах гуравдагч этгээдийн эрх, үүргийн талаар, 32 дугаар зүйлээр бүртгэгдсэн загварын шинж чанар, 33 дугаар зүйлээр хамтран өмчлөгчийн талаар тус тус зохицуулсан байна. 34 дүгээр зүйлд бүртгэгдсэн загвар болон түүнийг өмчлөгчтэй холбогдон гарах аливаа харилцааг албан ёсоор бүртгүүлээгүй тохиолдолд хүчинтэйд тооцохгүй гэжээ. Бүртгэгдсэн загварын онцгой эрх эзэмшигч болон бүртгэгдсэн загвар өмчлөгч нарын хоорондын харилцааг тус хуулийн 38 дугаар зүйлээр зохицуулахаар нэмэлт өөрчлөлт хийсэн байна.

## 2.6. Нидерландын Вант Улс

Нидерланд улсын оюуны өмчийн хууль эрх зүйн орчинг Нидерландын Иргэний тухай хууль (Dutch Civil Code-DCC), Бенелукс Барааны тэмдэгийн тухай хууль (Benelux Trade Mark Act-BTMA), Нидерландын Патентын тухай хууль (Dutch Patent Act-DPA), Нидерландын оюуны өмчийн тухай хууль (Dutch Intellectual Property Act-DIPA), Нидерландын Зохиогчийн эрхийн тухай хууль (Dutch Copyrigth Act-DCA), Нидерландын Өрсөлдөөний тухай хууль (Dutch Competition Law), Эдийн засгийн өрсөлдөөний шинэ хууль (New Rules on Economic Competition Law-NRECL), Нидерландын Зохиогчийн эрхийн гэрээний тухай хууль (Copyright Contract Act- DCCA) -аар зохицуулдаг. Үүнээс:

Нидерландын оюуны өмчтэй холбоотой зүйлүүд нь:

- 1995 оны Патентын тухай хууль (Dutch Patent Act -DPA)-ийн 70-р зүйлийн 5 дах хэсэг хэсэгт;
- Бенелукс Барааны тэмдгийн тухай – (Benelux Trade Mark Act- BTA) хуулийн 11-р зүйлийн Д хэсэгт;
- Нидерланд Зохиогчийн эрхийн тухай хууль (Dutch Copyright Act- DCA)-ийн 27-р зүйлд тус тус тусгажээ.

Нидерландын Засгийн газар, Эдийн засгийн яам, Шинжлэх ухаан бодлогын зөвлөл, Нидерландын Аж үйлдвэрийн агентлаг (Netherlands Enterprise Agency), “Судалгаа ба Хөгжүүлэлт” (R&D) төсөл, бусад олон улсын байгууллагууд, Шүүхийн байгууллагууд нь оюуны өмчийн асуудлаар хамтран ажилладаг.

Нидерланд улсын хувьд Нидерландын Засгийн газрын байгууллага болох Патентын алба (DPO), Нидерландын Эдийн засгийн яамны харьяа Нидерландын Аж үйлдвэрийн агентлаг (NEA) нь оюуны өмчийг хөгжүүлэх, үндэсний болон олон улсын түвшинд оюуны өмчтэй холбоотой дүрэм, журмыг боловсруулах, хөгжингүй улс орнуудад томоохон компаниудыг дэмжих үйл ажиллагааг явуулдаг.

Нидерландын Патентийн алба[198] нь бизнес эрхлэгчдэд (ЖДҮ, бизнес эхлэх), үйлчилгээний салбар, эрдэмтэн, судлаачид, багш, оюутнуудад дэмжлэг үзүүлдэг. Энэ алба нь патенттай холбоотой асуултууд эсвэл оюуны өмчөө хамгаалахын тулд бүх төрлийн зохиогчийн эрх, патент, загвар, барааны тэмдэг зэрэгт үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлнэ.

Нидерландын Аж үйлдвэрийн агентлаг[199] (NEA)–ийн зорилго нь Нидерланд болон олон улсын бизнес эрхлэгчид, судлаачидтай хамтран нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, бизнес эрхлэх боломжийг сайжруулах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд оршино. Нидерландын Аж үйлдвэрийн агентлаг нь Business.gov.nl-ийн дамжуулан

[197] http://www.wipo.int/wipolex/en/text.jsp?file_id=362395
[198] http://www.knowledgesharingcentre.com/knowledge/the-netherlands-patent-office-octrooicentrum-nederland/
[199] https://business.gov.nl/about-us/netherlands-enterprise-agency/

Нидерландын Засгийн газраас олгодог бизнесийн байгууллагуудад мэдээлэл өгдөг ба энэхүү мэдээллээр ерөнхий салбарын хууль тогтоомж, дүрэм, журам, лиценз, татварыг дагаж мөрдөх, татаас олгох асуудлуудыг боловсруулдаг байна.

Нидерланд улс нь оюуны өмчийг хамгаалахад чиглэсэн шинэ санаачилга, практик, бодлого, хөгжлийн асуудлууд дэлхийн бусад орны жишигт нийцсэн стандарт байдаггүй. Нидерландын Яамд, санхүүжүүлэгч агентлагууд, үндэсний судалгааны хөтөлбөрүүд, олон нийтийн судалгааны байгууллагууд нь оюуны өмчийн бодлого хөгжлийн асуудлуудаар “Хөгжлийн баталгаа” оюуны өмчийн ерөнхий бодлого байдаггүй. Бодлого боловсруулагчид хөгжиж буй орнуудын технологид нэвтрэх чадвартай оюуны өмчийн эрхийн үр дагаврын талаар багахан ойлголттой байдаг.

*<u>Оюуны өмчийг хамгаалах</u>*

Нидерландад Оюуны өмч[200] -ийг дараах байдлаар хамгаалж байна. Үүнд:

• **Патент (Patents)** нь бүтээгдэхүүн үйлдвэрлэл, шинэ бүтээлд, техникийн үйл явцад патентын эрх авсанаар бусдад ашиглах, дахин худалдах, түрээслэх, нийлүүлэх хууль бус эрхийг олгохгүй. Патент эзэмшигч нь патентын лицензийн зөвшөөрлийг олгосноор бусдад эзэмшүүлж болно. Үндэсний болон Олон улсын гэрээний дагуу (Европын патентийн конвенц (EPC), Нидерландын бүс нутагт олгогдсон патентыг Нидерландын патентын тухай хууль (DPA)–аар зохицуулна. Патент эзэмшигчийн бүртгэлийг 18 сарын хугацаанд бүртгэх ба 20 жилийн хамгаалалтын хугацаатай байна. Нидерландын патентын хамгаалалтын хамрах хүрээг ЕХ -ны 69-р зүйлд заажээ.

• **Зохиогчийн эрх (Copyright**) энэ нь Зохиогчийн эрхийн хуулиар зохицуулагдах ба хамгаалагдсан бүтээлүүд, тэтгэлэгт хөтөлбөр, шинжлэх ухаан, урлагийн бүтээлүүдийг хамруулна. Эдгээрт ном, кино, зураг, дуу хөгжим, тоглоом, гэрэл зураг, програм хангамж багтана. Зохиогчийн эрх нь автоматаар байдаг тул бүртгүүлэх, бүртгэх шаардлагагүй. Нидерландын зохиогчийн эрхийн хууль (DCA)-ийн дагуу зохиогчийн эрх хамгаалалт нь бүтээлийг жинхэнэ бүтээлийнх нь дагуу олгодог. Нидерланд нь Бернийн конвенцид нэгдэн орсон тул зохиогчийн эрхийн бүртгэл нь аливаа шаардлагад нийцэхгүй. Нидерландад зохиогчийн эрх байхгүй гэж хэлж болно[201].

• **Холбогдох эрхүүд** (Neighbouring rights**)** Энэ "Хөрш зэргэлдээ эрх" буюу "холбогдох эрх" гэдэг нь жүжигчид, дуу хөгжим, киноны продюсерууд, өргөн нэвтрүүлгийн компаниудын ажлыг хамгаалах бөгөөд энэхүү хамгаалалт нь зохиогчийн саналтай нягт холбоотой байна. Зохиогчийн эрхийн адил эдгээр эрх нь “Хөрш зэргэлдээ эрхийн тухай хууль”-д заасны дагуу автоматаар үүсдэг.

• **Барааны тэмдэг (Trade marks)**

Бизнес эрхлэгчид өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг бусад бүтээгдэхүүн, үйлчилгээнээс ялгахын тулд барааны тэмдгийг ашиглаж болно. Барааны тэмдгийн эрх нь бүтээгдэхүүн, үйлчилгээний нэрийг хамгаална. Бүтээгдэхүүний лого ба сав баглаа боодлын загварыг хамгаална. Бизнес эрхлэгчид эдгээр бүтээгдэхүүнийг хамгаалахыг тулд барааны тэмдгийг бүртгэх ёстой. Бенелукс барааны тэмдэгийг Бенелукс оюуны өмчийн газар (BOIP)-тай холбох замаар 24 цагийн дотор бүртгүүлэх ёстой. Тодорхой шинж чанар дутагдалтай, бараа, үйлчилгээний тодорхой талыг тодорхойлсон шинж тэмдгүүд, эсвэл дүрсэлсэн шинж тэмдгүүдийг илтгэдэг шинж тэмдэг байгаа эсэх талаар үнэлнэ. Барааны тэмдгийн бүртгэлийг 10 жилийн хугацаанд хүчинтэй байх ба дахин 10 жилээр сунгаж болно. Бенелукс барааны тэмдгийг эзэмшигчид нь ижил буюу ижил төстэй тэмдгүүдийн эсрэг хэрэглэж болох онцгой эрх олгодог. Тухайн нэр хүндийн барааны тэмдэг нь тухайн нэр хүндийг харгалзан илүү өргөн хүрээний хамгаалалт олгодог.

• **Мэдээллийн баазын хамгаалалт (Database protection)**

Зохиогчийн эх, уран бүтээл, мэдээллийн баазыг зохиогчийн эрхээр хамгаалж болно. Энэ нь зөвхөн өгөгдлийг цуглуулсан мэдээллийн баазаас бүрдэнэ. Мэдээллийн

[200] Нидерландын Засгийн газрын цахим хуудас, Оюуны өмчийн хамгаалалт https://www.government.nl/topics/intellectual-property/protection-of-intellectual-property
[201] https://www.lexology.com/library/detail.aspx?g=3e5c3855-80b6-4209-9d3d-60ce9dde051e

санг бий болгосноос хойш их хэмжээний хөрөнгө оруулалт шаарддаг тул өгөгдлийн сангийн Мэдээллийн бааз (Databases Act Legal Protection) хууль эрх зүйн хамгаалалтаар зохицуулдаг байна.

• **Ургамлын үржүүлэгчдийн эрх (Plant breeders rights**) Энэ нь шинэ ургамал, сортын төрлийг хамгаална. Ургамлын сортуудын зөвлөл нь Нидерландад ургамал үржүүлэгчдийн эрхийг олгох үүрэгтэй. Нидерландын Ургамал тарималжуулалтын хяналт шалгалтын алба (The Netherlands Inspectuin Service for Horticulture) өргөдлийг хүлээн авч шинжлэн судалж, хяналт шалгалтыг явуулдаг. Хэрэв үр дүн сайн байвал Зөвлөл нь өргөдөл гаргагчдад ургамлын үржүүлэгчийн эрхийн зөвшөөрлийг өгнө.

• **Компьютерийн чипсийн загварыг хамгаалах эрх (Rights protecting design of chips**) нь компьютерийн чип дээрх электрон хэлхээний дизайныг хамгаалах хууль (хагас дамжуулагч бүтээгдэхүүний зураглал гэж нэрлэдэг) юм. Эдгээр хуулиуд нь тодорхой чиг үүргийг гүйцэтгэхэд чиглэсэн хэлхээ холбооны сүлжээг хамгаалж байдаг.

• **Зохиогчийн эрхийн гэрээний тухай хууль** (The Copyright Contract Act) нь Зохиогчийн эрхийн тухай болон Холбогдох эрхийн тухай хуулиар зохиогчийн эрхийн байр суурийг тодорхойлно. Зохиогчийн эрхийн гэрээний тухай хууль нь 2015 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон. Энэхүү актыг зохиогч, жүжигчид нь хэвлэн нийтлэгчид, үйлдвэрлэгчидтэй хийсэн гэрээгээ бүрэн буюу хэсэгчлэн байдлаар дуусгавар болгохыг зөвшөөрдөг. Зохиогчийн эрхийн гэрээний тухай хууль нь Зохиогчийн эрхийн тухай хууль болон Хөрш зэргэлдээ эрхийн тухай хуулийг сайжруулан өөрчилсөн байдаг.

*Лицензийн гэрээ байгуулах*[202]

Нидерландад лицензийн гэрээг зохицуулсан тусгай хууль тогтоомж байхгүй байна. Энэ нь Нидерландын хуулийн дагуу лицензийн гэрээ Нидерландын гэрээний хуулийн ерөнхий нөхцөлүүдэд хамаарна гэсэн үг юм. Лицензийн гэрээ нь Оюуны өмчийн тухай хууль болон Өрсөлдөөний тухай хууль (ЕХ-ны өрсөлдөөний тухай хууль) бусад хуультай холбоотой.

Лицензийн гэрээ гэдэг нь нэг талаас лиценз олгогч, нөгөө талаас лиценз эзэмшигчид өмчийг зөв ашиглахад хамтран оролцох эрх юм. Лицензийн гэрээ нь олон хэлбэртэй байна. Жишээлбэл; лицензийн гэрээ нь байнгын болон хүлээгдэж буй патенттай холбоотойгоор онцгой ба онцгой бус гэсэн хэлбэртэй байна.

Нидерландын хууль эрх зүйн чухал онцлог нь гэрээний бүх зохицуулалтанд хамаарах тэгш, шударга байх нь үндсэн үүрэг юм. Шүүх нь тэгш, шударга зарчимд харшилж байгаа гэж үзсэн заалтуудыг хүчингүй болгоно.

Нидерланд улсад лицензийн гэрээнд албан ёсны шаардлага тавьдаггүй. Энэ нь лицензийн гэрээг амаар эцэслэн дуусгах, жишээлбэл, баримт бичгийг солилцох замаар хийж болно. Зарим оюуны өмчийн лицензийг үнэн зөв бүртгэгдсэн үед гуравдагч этгээдийг үндэслэнэ. Нидерландын гэрээний төслийг боловсруулж, хэрэгжүүлэх нь хуулийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулна.

Харин Нидерландын Иргэний хуулийн 6-р зүйлийн 217 хэсгийн 1 дэх хэсэгт "Нидерландын хуулийн дагуу гэрээ байгуулна" гэжээ.[203] Мөн Иргэний хуулийн 3-р зүйлийн 37 хэсгийн (1)-д гэрээний хэрэгсэл нь гэрээ хэлцэлийг амаар буюу аман бус ойлгомжтой, оролцогч талууд нь хууль ёсны дагуу байгуулна" гэсэн байна[204].

Иргэний хуулийн 3-р зүйлийн 37-р хэсгийн 1-д зааснаар гэрээ байгуулахыг зөвшөөрсөнөө илэрхийлсэн, санал болгож буй нөхцөл, гүйцэтгэлийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн бол хуулийн дагуу дагаж мөрдөх ёстой. Гэрээний нөхцөл хувилбаруудыг зохих ёсоор баталгаажуулан санал болгосон нөхцөлөөс гажуудуулсан тохиолдолд хүлээн зөвшөөхөргүй байж болно.

---

202 Нидерландын хуулийн цахим хаяг: Лицензийн тухай https://dutch-law.com/license-dutch-law.html
203 https://aippi.org/download/commitees/190/GR190netherlands.pdf
204 Нидерландын хуулийн цахим хуудас https://dutch-law.com/acceptance-dutch-law.html

Хуулийн 6-р зүйлийн 221 дэх хэсгийн 1-д зааснаар аман болон бичгээр санал өгөх, бичгээр өгөх саналын хугацаа, уг саналыг хүлээн авсан шийдвэрээ мэдэгдэх, шаардагдах хугацааг хүчинтэй эсэхийг тус тус заажээ.

Иргэний хуулийн 3 зүйлийн 37 хэсэг (3)-т захиалагчийн өмнө хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлээгүй этгээд, нөхцөл байдлаас шалтгаалан хойшлуулсан санал, хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээнэ гэж тус тус зохицуулжээ.

***Лицензийн гэрээ байгуулахад анхаарах зүйлс:***

- ✓ **Лицензийн гэрээний хамрах хүрээ-** Лицензийн гэрээ байгуулахад гэрээний хугацаа, нутаг дэвсгэрийн хамрах хүрээг харгалзан үзэх нь чухал байдаг. Лицензийн гэрээ нь тодорхой хугацаанд буюу байнгын гэсэн хугацаатай байж болно. Аль ч тохиолдолд мэдэгдэл өгөх хугацааг оруулах нь зүйтэй. Лицензийн гэрээний нутаг дэвсгэрийн хамрах хүрээг гэрээнд тодорхой, ойлгомжтой заах өгөх ба зөвөөр илэрхийлэгдсэн утгатай байна.
- ✓ **Өмч буюу эрхийг шилжүүлэх болон дэд лиценз олгох-** Лицензийн гэрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн томилолт, тусгай зөвшөөрөл олгохыг хориглох, хязгаарлах заалтуудыг оруулж болно. Жишээ нь гэрээний нөхцөлд оюуны болон бусад эрхийг хэн эзэмших, болон шилжүүлэх эрхтэй болохыг батлана.
- ✓ **Нууцлал, ноу-хау, гүүдвилл** (khow-how and goodwill)- Олон лицензийн гэрээнүүдэд ноу-хау, гүүдвил болон нууцлалын заалтыг ил болгох, хамгаалах заалтуудыг тусгасан байдаг. Эдгээр нь Иргэний эрхийг зөрчих хууль болон Өрсөлдөөний тухай хуулиас гадна үүргийг зөрчсөн заалт юм.
- ✓ **Нидерландын хуулийн дагуу лицензийг хүчингүй болгох**-Лицензийн гэрээний (ихэвчлэн) урт хугацааны шинж чанарыг тодорхойлсон, зарим нөхцөлөөр дуусгавар болгохыг зөвшөөрсөн зөв заалтыг санал болгоно. Жишээлбэл; тусгай зөвшөөрөл эзэмшигч төлбөрийн чадваргүй болсон, оюуны өмчийн бүртгэл хүчингүй болсон тохиолдолд гэрээг цуцалж болно.
- ✓ **Нидерландын хуулийн дагуу маргааныг шийдэх**- Лицензийн гэрээнд гэрээний нөхцөл, арбитрын маргааныг шийдвэрлэхэд ээлжлэн солигдох (alternative) хувилбарыг оролцуулна. Асуудлыг шийдэх, маргааныг шийдвэрлэх аргуудын талаарх давуу болон сул талуудын талаар анхаарах хэрэгтэй байдаг.

**Гэрээ хэлэлцээр хийх болон гэрээний өмнө хүлээх хариуцлага**[205]

Нидерландын хууль гэрээний эрх чөлөөний зарчмыг баримталдаг. Эрх чөлөөтэй гэрээ байгуулах гэдэг нь оролцогч талууд хуулийн хүрээнд, чөлөөтэй нэвтрэн орох, эсхүл нэвтрүүлэхгүй байхыг хэлнэ. Нидерландын хуулийн онцлог нь гэрээ хэлцэл хийхдээ тэгш байдал, шударга зарчмыг дагаж мөрдөх явдал юм. Нидерландын хуулиар хэлэлцээр хийх оролцогч талууд нь тэгш, шударга, итгэлтэй, хариуцлагатай байх үүрэгтэй. Ерөнхийдөө, гэрээ хэлэлцээний нэг талаас шударга, тэгш байх, нөгөө тал нь хууль ёсны ашиг сонирхлыг харгалзан үзнэ.

Гэрээ хэлэлцээрийн үеэр талууд харилцан үүрэг, хариуцлага хүлээнэ.

Гэрээний өмнөх үе шатууд, хэлэлцээрүүд нь Нидерландын “Иргэний хууль” (Dutch Civil Code)-д тодорхой зохицуулагдаагүй болно. Гэсэн хэдий ч Дээд шүүх (Hoge Raad)-ээс хэргийг хэлэлцэн тохиролцох явцад оролцогч талуудын хүлээх үүргийг тодорхойлох арга замыг харуулжээ. Гэрээ хэлэлцээрийн байгуулах гурван үе шат байдаг. Үүнд:

1. Эхний шат нь "чөлөөт гэрээ хэлэлцээр" (free negotiation) гэсэн үе шатанд оролцогч талууд цуцлах, нөгөө талдаа нөхөн төлбөр төлөхгүйгээр хэлэлцээ хийх эрх чөлөөтэй болно.
2. Оролцогч талууд хэлэлцээний хоёрдугаар үе шатанд хэлэлцээрийг цуцлах, эрх чөлөөтэй хэвээр байгаа боловч нөгөө талыг зохистой, тэгш, шударга байх, үүргээ биелүүлэх, хохиролгүй болгохын тулд нөхөн төлбөр хийх шаардлагатай болно.

---

[205] Нидерландын хуулийн цахим хуудас: https://dutch-law.com/precontractual-liability.html

3. Гэрээ хэлэлцээрийн гуравдахь шатанд итгэлцлийн (good faith) үүрэг нь нөгөө талаас нөхөн олговор олгохгүй байх тал дээр хэлэлцээрийг цуцлах боломжгүй гэдгийг зааж өгнө. Хэрэв нэг тал нь гэрээ байгуулагдах үндэслэлтэй гэж үзвэл хохирлыг нөгөө тал нь барагдуулсан, өөрөөр хэлбэл ашгийн алдагдал нь ямар байх вэ гэсэн үндэслэлээр тооцож болно.

**Letter of intent[206] and Gentlement's Agreement[207]**

Гэрээ хэлэлцээрийн туршид баримт бичгүүдэд албан бусаар, гарыг үсэг зурахаас өмнө хэлэлцэн тохиролцох гэрээ нь ховор тохиолддог. Ийм баримт бичгийг нийтлэг 3 хуваана. Үүнд:

- ✓ гарын үсэг зурахас өмнөх ойлголцон тохиролцох гэрээ (letter of intent);
- ✓ эх гэрээ (heads of agreement);
- ✓ харилцан ойлголцлын санамж бичиг (memorandum of understanding) юм.

Дээр дурдсанчлан оролцогч талууд гэрээний бүх гол асуудлуудын талаар тохиролцоонд хүрэх шаардлагагүй юм. Нидерландын шүүхээс Гэрээний хуулийг хүчингүй болгох, гэрээний дутууг нөхөхүйц тэгш, шударга байх зарчмыг ашиглаж болно.

Талуудын баримт бичиг, тэдгээрийн бүрдэл хэсгүүдэд заавал дагаж мөрдөх ёстой гэж баримтжаагүй баримт бичгийг сонгож болно. Баримт бичгүүд нь "жишиг тогтоох нөхцөлийг" (conditions precedent) агуулж болох бөгөөд гэрээг байгуулахаас өмнө гүйцэтгэх ёстой нөхцөлүүд орно. Жишээ нь:

- ✓ гэрээний дагуу;
- ✓ бичгээр тохиролцсоны дагуу;
- ✓ гарын үсэг зурах; эсвэл
- ✓ Гүйцэтгэх зөвлөлөөс батлуулах;
- ✓ Хяналтын удирдах зөвлөлөөс батлуулах;
- ✓ Хувьцаа эзэмшигчдээс (ерөнхий уулзалт) баталсан. Илүү үр дүнтэй байлгахын тулд эдгээр заалтуудыг нарийвчилсан байдлаар боловсруулдаг байна.

*<u>Оюуны өмчийг бүртгэх, шилжүүлэх</u>*[208]

Оюуны өмчийн эрхийн лицензийг үр дүнтэй байлгахын тулд бүртгүүлэх болон шилжүүлэх шаардлагатай.

а) оролцогч талуудын хооронд

Нидерланд улсад оюуны өмчийн эрхийг улсын бүртгэлд "бүртгэгдсэн өмч"-г шилжүүлэх шаардлагагүй гэж үздэг. Нидерландын Иргэний тухай хууль (DCC)–ийн 10-р зүйлийн 3 дахь хэсэгт “Бүртгэгдсэн өмч гэдэг нь зохих ёсоор улсын бүртгэлд бүртгүүлж шилжүүлсэн хөрөнгө, эсвэл бүтээлийг хэлнэ”. Нидерландын Иргэний тухай хууль (DCC)-ийн 16-р зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар*:* “Улсын бүртгэлийг ямар журмаар хөтөлж байх, тухайн баримт бичгийг агуулга, бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх, бүртгэлийн маягт, төрөл зүйл, зөвлөгөө өгөх журам, хуульд зааснаар тогтооно” гэжээ. Нидерландын оролцогч талуудын хоорондох журмыг үр дүнтэй байхын тулд Нидерландын оюуны өмчийн лицензийг бүртгэх шаардлагагүй.

б) гуравдагч талын оролцоо

Нидерландын оюуны өмчийн үйл ажиллагаанд Бенелукс Барааны тэмдгийн тухай хууль ("BTA") 11-р зүйлийн (C), Нидерландын Патентын тухай хууль (DPA) -ийн 65 зүйлин (3) дагуу оюуны өмч, лиценз бүртгэгдсэн тохиолдолд, бүртгэгдээгүй гуравдагч этгээдийн хамгаалалтыг тогтоосон байна. Энэ нь Зохиогчийн эрхийн тухай хуульд эрх шилжүүлэх ба лицензийн бүртгэлд хамаарахгүй.

*Лицензийг шилжүүлэхдээ*[209]:

---

[206] letter of intent- гэрээнд гарын үсэг зурахаас өмнөх хэлэлцэн тохиролцон, ойлголцох асуудал
[207] Gentlemen's Agreement- албан бус, хууль бус гэрээ, өөрөөр хэлбэл аман гэрээ,
[208] Оюуны өмчийн эрх, лиценз, болон гуравдагч этгээдтэй байгуулсан Q190 тайлангаас
[209] Оюуны өмчийн эрх, лиценз, болон гуравдагч этгээдтэй байгуулсан Q190 тайлангаас

а) лиценз олгогч болон
б) лиценз эзэмшигч нарт шилжүүлнэ.

Лицензийг шилжүүлэхийн өмнө ажлын хэсэг лицензийн шинж чанарыг хэлэлцэнэ. Нидерландын ихэнх нь лиценз бол үйл ажиллагааны эрх юм. Үйл ажиллагааны эрх нь харилцан хоёр талын гэрээнээс гарган авах хувийн үүрэг юм. Нидерландын Иргэний тухай хуулийн 6-р зүйлд лицензийн шалгуурт мөнгөний эрхийг тодорхойлжээ. Нидерландын Иргэний тухай хуулийн 83-р зүйлд лицензийн шилжүүлгийг тусгасан байна. Лицензийг шилжүүлэх нь тодорхой байдлаар лиценцийн гэрээгээр зохицуулагддаг. Лицензийн гэрээ нь лиценз эзэмшигчийн шилжүүлэхийг хориглодог лиценз буюу гуравдагч этгээдэд лицензийг шилжүүлнэ. Лиценз олгогч ерөнхий эрхийг олгох ба лицензийн гэрээ болон оюуны өмчийн эрхийг гуравдагч этгээдэд хүлээлгэн өгөх үүргийг хүлээнэ. Лиценз олгогч лицензийг бүртгэх ба (оюуны өмчийн холбогдох) гуравдагч этгээдэд оюуны өмчийн эрхийг шилжүүлнэ. Энэхүү дээрх гуравдагч этгээдийн хамгаалалтыг Патентын тухай хуулийн 56-р зүйлийн 2 хэсэгт тодорхойлжээ. Мөн Бенелукс Барааны тэмдгийн тухай хуулийн 11-р зүйлийн В хэсэгт энэ тухай мөн дурджээ.

Зохиогчийн эрхийн тухай хуульд ийм тусгай заалт байхгүй. Зохиогчийн эрхийг шилжүүлэхэд түүний өмнөх зөвшөөрөл лицензэд хамааралгүй. Лиценз эзэмшигч нь тухайн бүтээлийг зохиогчдод өгнө. Патент эзэмшигч өмнөх гуравдагч этгээдэд лиценз олгогдсон эрхийг хүндэтгэн харьцана. Патент эзэмшигч патентаа ашиглах эрхгүй, шинэ бүтээлийг гуравдагч этгээдэд шилжүүлнэ. Лицензийг шилжүүлэх боломжтой нөхцөл байдал болон гэрээний агуулгаас ихээхэн хамаардаг байна.

## 2.7. <u>Норвег улс</u>

Норвегийн оюуны өмчийн талаарх хууль эрх зүйн орчин нь доорх хууль болон дүрэм, журмуудаас бүрдэж байна[210]. Үүнд:

<u>Гол хуулиуд:</u>

- Патентын тухай хууль (хууль №9 1967, 2018 онд шинэчилсэн найруулга)
- Өргөн нэвтрүүлгийн тухай хууль (№127 1992, 2017 онд шинэчлэгдсэн)
- Барааны тэмдгийн тухай хууль (№8 2010, 2015 онд шинэчлэгдсэн)
- Загварын тухай хууль (№15 2003, 2015 онд шинэчлэгдсэн)
- Ургамлын олон зүйлийн тухай хууль (№32 1993, 2015 онд шинэчлэгдсэн)
- Интеграл схемийн загварын тухай хууль (№27 1990, 2015 онд шинэчлэгдсэн)
- Бизнесийн (аж ахуйн) нэрийн тухай хууль (№79 1985, 2015 онд шинэчлэгдсэн)
- Ажилтны шинэ бүтээл, оновчтой санал (ШБОС)-ыг хүндлэх тухай хууль[211] (№21 1970, 2015 онд шинэчлэгдсэн)
- Зохиогчийн эрхийн тухай хууль (№2 1961, 2015 онд шинэчлэгдсэн)
- Хүрээлэн буй орчныг хамгаалахад ач холбогдолтой шинэ бүтээл, оновчтой санал (ШБОС)-ын тухай хууль[212] (№8 1953, 2015 онд шинэчлэгдсэн)
- 2013.05.31-ний өдрийн №25 хууль, Аж үйлдвэрийн өмчийн эрхийн хууль тогтоомжинд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн тухай (2013)
- Патентын зөвлөлийн тухай хууль (№58 2012) (2013)
- Норвегийн патентын тухай хууль болон патентын дүрмийн нэмэлт, өөрчлөлт (2007)
- Аж үйлдвэрийн өмчийн эрхийн тухай хууль тогтоомжийн нэмэлт, өөрчлөлт (1996)
- Хамгаалагдсан бүтээлийн фото хуулбарыг боловсролын үйл ажиллагаанд ашиглах тухай түр хууль[213] (1979)

<u>Дүрэм, журмууд:</u>

---

[210] Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллага: Норвег-WIPO: Norway http://www.wipo.int/wipolex/en/profile.jsp?code=NO
[211] Act Respecting the Right to Employees' Inventions
[212] Act on Inventions of Importance to the Defence of the Realm
[213] Provisional Act Relating to Photocopying of Protected Works for Use in Educational Activities

- №333 журам, 2014, Норвегийн Аж үйлдвэрийн өмчийн газар болон Аж үйлдвэрийн өмчийн эрхийн арбитрын зөвлөлд төлбөр төлөх тухай[214] (2015)
- Патентын дүрэм (№1417 2007) (2015 онд шинэчлэгдсэн)
- №1563 журам, 2001, Зохиогчийн эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх тухай (2015 онд шинэчлэгдсэн)
- Загварын дүрэм (№418 2003) (2014 онд шинэчлэгдсэн)
- Барааны тэмдгийн дүрэм (№937 2010) (2013 онд шинэчлэгдсэн)
- Гаалийн дүрэм (2009)
- Медиа өмчлөлийн тухай хуулийн дагуу хөндлөнгөөс оролцох журам[215] (2005)
- Өргөн нэвтрүүлгийн дүрэм (№153 1997) (2005 онд шинэчлэгдсэн)
- Домэйн нэрийн дүрэм[216] (2003)
- Хулгайлагдсан болон хууль бусаар авсан соёлын эд зүйлийг буцаах тухай журам (2002)
- Гадаадын улстай холбогдох бүтээлд зохиогчийн эрхийн тухай хуулийг хэрэглэх тухай журам (1997)
- Ургамал өсгөгчийн эрхийн тухай журам[217] (1997)
- Патентын хүсэлт гаргахтай холбогдох патентын байгууллагын журам (1994)
- Зохиогчийн эрх болон фото зурагтай холбогдох журам (1989)
- Оюуны ажил үйлчилгээний шинжээчийн хорооны журам[218] (1978)
- Оюуны өмчийн эрхийн хүсэлт гаргах журам[219] (1961)

Оюуны өмчтэй холбогдох Норвегийн хууль эрх зүйн орчин нь Европын Холбоо (ЕХ)-ныхтой ихээхэн уялдаатай байдаг. Норвеги нь Европын Эдийн засгийн Бүс (ЕЭЗБ)-ийн гишүүний хувиар ЕХ-ны удирдамж зааврыг биелүүлэх үүрэг хүлээдэг, мөн оюуны өмчтэй холбогдох олон улсын ихэнх гэрээ хэлэлцээрт нэгдэн орсон байдаг. [220]

Ерөнхийдөө оюуны өмчийг бүртгэл, гэрээ хэлцэл, нууцлах болон бусад арга замаар хамгаалдаг. Норвег нь доорх оюуны өмчийг хүлээн зөвшөөрдөг. Үүнд:

- Патент;
- Зохиогчийн эрх;
- Барааны тэмдэг (мөн барааны тэмдгийг хэрэглэх замаар хамгаалдаг);
- Загвар;
- Худалдааны нууц болон ноу-хау[221].

Компани өөрөө патент болон барааны тэмдгийг бүртгүүлэх ба харин гадаадын хүсэлт гаргагч нь Норвегийн патент болон барааны тэмдгийн итгэмжлэгдсэн хуульчтай/өмгөөлөгчтэй байх шаардлагатай.

Норвегийн оюуны өмчийн хамгаалалт, бүртгэлийн бүрдэл, шат дамжлага, зардлыг дараах хүснэгтээр нэгтгэн харуулав.

---

[214] Regulations No. 333 of March 26, 2014, relating to Payments, etc. to the Norwegian Industrial Property Office and the Board of Appeal for Industrial Property Rights
[215] Guidelines for Intervention pursuant to Media Ownership Act
[216] Regulations on Domain Names under Norwegian Country Code Top Level Domains
[217] Regulations concerning the Plant Breeder's Right
[218] Regulations for the Expert Committee on Intellectual Works
[219] Regulations relating to the Application of Intellectual Property Rights
[220] Asbjørn Berg and Are Herrem “Key issues for IP rights owners” http://www.buildingipvalue.com/05_EU/267_270.htm
[221] Know-how-*англиар*

**Figure 1 Intellectual property rights in Norway protection and enforcement in a nutshell**

| The right | Patents | Copyrights | Trademarks | Designs | Trade secrets |
|---|---|---|---|---|---|
| What legal conditions need to be satisfied for the IPR to arise? | Application for and grant of the patent. Conditions of patentability<br>• Invention<br>• Novelty<br>• Sufficient disclosure of the invention<br>• Non-obviousness<br>• Industrial application | Individual and original work | Successful application for the trademark:<br>• Capable of distinguishing goods or services<br>• Inherent distinctiveness<br>• Not violation upon mandatory law | Application for and grant of the design. Conditions for protection<br>• Novelty (new at the time of deposit)<br>• Originality (substantially different from known designs) | Information not readily accessible to a person normally dealing with this type of information<br>Owner of trade secrets takes reasonable steps to prevent misappropriation |
| **Protection**<br>Is an application necessary to protect the IPR? | Yes | No | No<br>Extensive use gives protection without registration | Yes | N/A |
| Do third parties have the right to contest the application? | Yes | N/A | Yes | No | N/A |
| Overall timeframe for obtaining registration? | Three to four years | N/A | 12 to18 months if the application is successful | Three to four months | N/A |
| If application is successful, for how long does the registration provide protection? | 20 years, subject to payment of renewal fees | N/A | Indefinite period of time, subject to payment of renewal fees | 25 years (renewal is due every five years) | N/A |
| Does registration grant exclusivity? | Yes | N/A | Yes | Yes | N/A |
| Exhaustion | Regional EU/EEA exhaustion. | Global exhaustion for copyrighted works. Regional EU/EEA exhaustion for producers and performing artists | Global exhaustion | Regional EU/EEA exhaustion. | N/A |
| What are the other means of protection? | Protection as a trade secret | N/A | The Marketing Act provides protection against similar designations | Protection under the Copyright and/or the Marketing Act | Protection as patent |
| **Enforcement**<br>In what circumstances and on what grounds can you bring an action for infringement? | Unauthorised production, selling, making, using or importing of a patented product or any product obtained directly by means of a patented process<br>Using a patented process | Unauthorised restricted acts such as making, selling, hiring, offering for commercial use or importing of a copyrighted product | Unauthorised restricted acts such as making, selling, marketing or importing of a trademarked product | Unauthorised production, selling and marketing of articles to which registered design applies or making anything which enables any such article to be made in Norway or elsewhere | Unfair methods of acquisition such as:<br>• Eavesdropping<br>• Breach of contractual or other obligations of confidence<br>• Wrongful disclosure by an employee or wrongful inducement of employee to disclose trade secrets |
| Which courts have jurisdiction? | • All ordinary courts<br>• Oslo City Court regarding patentability | • All ordinary courts | • All ordinary courts<br>• All ordinary courts. Oslo City Court regarding registration and validity | • All ordinary courts<br>• All ordinary courts. Oslo City Court regarding registration and validity | • All ordinary courts |
| What defences are available? | • Patent right invalid or not infringed<br>• Use for private and non-commercial purposes<br>• Experimental use<br>• Use begun before priority date | • Lack of individuality<br>• Not a substantial copy<br>• Use for private and non-commercial purposes | • Trademark right invalid or not infringed<br>• Use for private and non-commercial purposes<br>• Use begun before priority date | • Design was lacking novelty or originality when filed<br>• Not a substantial copy<br>• Use for private and non-commercial purposes | • Information not confidential or not first communicated in confidence<br>• Independent development |
| What civil remedies are available? | • Injunction<br>• Declaratory judgment<br>• Damages or surrender of profits | • Injunction<br>• Declaratory judgment<br>• Damages or surrender of profits<br>• Destruction of products | • Injunction<br>• Declaratory Judgment<br>• Damages or surrender of profits | • Injunction<br>• Declaratory judgment<br>• Damages or surrender of profits | • Injunction<br>• Damages or surrender of profits |
| Approximate costs | Professional fees €2,500<br>Registration fees €500 | N/A | Professional fees €1,200<br>Registration fees €250 | Professional fees €1,200<br>Registration fees €250 | N/A |

Оюуны өмчийн нэхэмжлэлийг Норвегид ерөнхийдөө ердийн шүүхэд гаргадаг байна. Оюуны өмчид зориулсан тусгай шүүх байхгүй боловч Осло Хотын Шүүх нь зөвхөн патент болон барааны тэмдгийн хүсэлт, патентын нэр болон ашиглалтгүй барааны тэмдгийг цуцлахтай холбогдох асуудлыг хүлээн авч шийдвэрлэдэг.

Анхан шатны шүүхээр хэргийг шийдвэрлэх хүртэл 6-18 сарын хугацаа ордог. Давж заалдах асуудлыг давж заалдах шатны шүүх ихэвчлэн 12-18 сарын хугацаанд шийдвэрлэдэг. Хэрэв дээд шүүхэд асуудал хүрсэн бол эцсийн шийдвэр гарахад 12 сар хүртэлх хугацаа шаардлагатай. ЕЭЗБ/ЕХ-ны хэмжээний асуудал бол түүнээс ч удах тохиолдол байж болно. Шүүхийн урьдчилсан хоригийг 1-4 долоо хоногийн хугацаанд гаргуулан авч болно.

Шүүх ажиллагааны зардал нь асуудлын түвэгтэй байдлаас ерөнхийдөө хамаарна. Барагцаагаар үзвэл, шүүхийн хоног тутамд NOK50,000-NOK70,000 (€7,000-€9,000) зардал гарна. Үүн дээр нэмээд шүүхийн багавтар хураамж гарах боломжтой. Шүүхэд зөрчлийн асуудлыг ихэвчлэн 1-3 хоногийн хугацаанд шийддэг. Гэвч ихээхэн түвэгтэй патентын асуудал удаан үргэлжлэх боломжтой.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ


- https://www.gpo.gov/fdsys/granule/USCODE-2011-title35/USCODE-2011-title35-partIII-chap26-sec261
  35 USC 261, Title 35 Patent, Chapter 26 Ownership and assignment, Sec.261 Ownership; assignment
- https://www.uspto.gov/web/offices/pac/mpep/s301.html
  Patent Recording Act - 35 USC 261
- https://www.gpo.gov/fdsys/granule/USCODE-2011-title15/USCODE-2011-title15-chap22-subchapI-sec1060
  15 USC 1060
- https://www.uspto.gov/ GUZU BILLAHI MINASHAITAN NIRAJIM BISMILLAHI RAHMANI
- https://www.copyright.gov/about/
- http://www.wipo.int/sme/en/ip_business/trade_secrets/protection.htm
- https://www.michigan.gov/documents/entireuccbook_18831_7.pdf
- UNIFORM COMMERCIAL CODE Act 174 of 1962
  https://www.dlapiperintelligence.com/goingglobal/intellectual-property/index.html?t=commercial-contract-framework
- http://www.wipo.int/wipolex/en/text.jsp?file_id=128055#LinkTarget_112
  Худалдааны эрх зүйн зөрчлийн тухай хууль (Израил)
- http://www.wipo.int/wipolex/en/text.jsp?file_id=341499
  Патентын тухай хууль (Израил)
- http://www.wipo.int/wipolex/en/profile.jsp?code=FI
- Patents Act, https://www.prh.fi/en/patentit/lainsaadantoa/patenttilaki.html
- Trademarks Act, https://www.prh.fi/en/tavaramerkit/lainsaadanto/Tavaramerkkilaki.html
- Copyright Act, http://www.wipo.int/wipolex/en/text.jsp?file_id=397616
- Act on Utility Model Rights, http://www.wipo.int/wipolex/en/text.jsp?file_id=254415
- Finnish patent and registration office, https://www.prh.fi/en/index.html
- Finland chamber of commerce, https://kauppakamari.fi/en/legislation/immaterial-property-rights/
- Registered Designs Act,
  https://www.prh.fi/en/mallioikeudet/lainsaadantoa/mallioikeuslaki.html
- https://www.mlaw.gov.sg/content/minlaw/en/our-work/intellectual-property-policy.html
- http://www.wipo.int/wipolex/en/profile.jsp?code=SG
- https://www.lawyers-singapore.com/intellectual-property-valuation-in-singapore
- http://www.wipo.int/wipolex/en/details.jsp?id=14587
- http://www.wipo.int/wipolex/en/details.jsp?id=6132
- http://www.singaporelaw.sg/sglaw/laws-of-singapore/commercial-law/chapter-13
- https://www.ipos.gov.sg/understanding-innovation-ip/copyright/assignment-and-licensing
- http://www.wipo.int/wipolex/en/text.jsp?file_id=187981
- http://www.wipo.int/wipolex/en/text.jsp?file_id=362395
- https://www.jpo.go.jp/index/kokusai_doukou/iprsupport/syutsugan/pdf/Singapore/SGP-D_form.pdf
- Нидерландын Засгийн газрын цахим хуудас: оюуны өмчийн хамгаалалт
  https://www.government.nl/topics/intellectual-property/protection-of-intellectual-property
- Нидерландын хуулийн цахим хуудас: лицензийн тухай
  https://dutch-law.com/license-dutch-law.html
- Оюуны өмчийг хамгаалах Олон улсын холбоо (AIPPI) цахим хуудас : тайлан Q190
  https://aippi.org/download/commitees/190/GR190netherlands.pdf
- Нидерландын хуулийн цахим хуудас: хүлээх үүрэг хариуцлага
  https://dutch-law.com/joint-liability-dutch-law.html
- Нидерландын хуулийн цахим хуудас: зохистой байдал, шударга
  https://dutch-law.com/reasonableness-fairness.html
- Нидерландын хуулийн цахим хуудас: хүлээн зөвшөөрөх
  https://dutch-law.com/acceptance-dutch-law.html
- Нидерландын хуулийн цахим хуудас: гэрээгээр хүлээсэн үүрэг хариуцлага
  https://dutch-law.com/precontractual-liability.html

# КАЗАХСТАН УЛСЫН АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТАТВАР (РОЯЛТИ)-ЫН ХУВЬ ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ, ЛАВЛАГАА

*Г.Билгээ*

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ


Бүгд Найрамдах Казахстан Улсад роялти буюу ашигт малтмалын нөөц ашигласны татварыг 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Татварын тухай хуулиар[222] зохицуулах ба энэ хууль 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Өмнөх Татварын тухай хуулийг 2008 онд баталж байжээ.

Ашигт малтмалын нөөц ашигласны татварын ерөнхий хувь хэмжээ 15 хувь байна. Зарим ашигт малтмалын төрөл, олборлолтын хэмжээнээс хамаарч татварын хувь хэмжээг янз бүрээр тогтоосон байна. Тухайлбал, газрын тосны хувьд олборлолтын хэмжээнээс хамаарч **5-18 хувь**, түүхий хийн олборлолтын татвар **10 хувь** ба хэрэв дотоодын зах зээлд түүхий хий борлуулах бол түүний олборлолтын хэмжээнээс хамаарч **0,5-1,5 хувь**, мөн зарим ашигт малтмал болон түүхий эдийн төрлөөс хамаарч 0-16,2 хувь байна.

2017 оны Татварын тухай хуулиар тогтоосон ашигт малтмалын нөөц ашигласны татварын хувь хэмжээг 2008 оны хуультай[223] харьцуулахад өөрчлөгдөөгүй байна.


## СУДАЛГААНЫ ХЭСЭГ

### КАЗАХСТАН УЛСЫН АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТАТВАР (РОЯЛТИ)-ЫН ХУВЬ ХЭМЖЭЭ

Ашигт малтмалын олборлолт, техногенийн хуримтлалын боловсруулалтын үйл явцад газрын хэвлий ашиглахад ашигт малтмалын нөөц ашигласны татварыг ногдуулах[224] ба татварын хувь хэмжээ 15 хувь[225] байна.

Татварын тухай хуулийн 743.1-д **газрын тосны олборлолтын** татварын хувь хэмжээг дараах байдлаар тогтоосон байна. Үүнд:

*Хүснэгт 1. Газрын тосны олборлолтын татварын хувь хэмжээ*

| № | *Жилийн олборлолтын хэмжээ* | *Татварын хувь хэмжээ* |
|---|---|---|
| 1. | 250 000 тонн хүртэл | 5 |
| 2. | 500 000 тонн хүртэл | 7 |
| 3. | 1 000 000 тонн хүртэл | 8 |
| 4. | 2 000 000 тонн хүртэл | 9 |
| 5. | 3 000 000 тонн хүртэл | 10 |
| 6. | 4 000 000 тонн хүртэл | 11 |
| 7. | 5 000 000 тонн хүртэл | 12 |
| 8. | 7 000 000 тонн хүртэл | 13 |
| 9. | 10 000 000 тонн хүртэл | 15 |
| 10. | 10 000 000 тонноос дээш | 18 |

Хэрэв газрын тосыг Казахстан Улсын дотоод зах зээлд борлуулах[226] бол ашигт

[222] Кодекс Республики Казахстан от 25 декабря 2017 года №120-VI «О налогах и других обязательных платежах в бюджет (Налоговый кодекс)». Эх сурвалж: https://online.zakon.kz
[223] Кодекс Республики Казахстан от 10 декабря 2008 года №99-IV «О налогах и других обязательных платежах в бюджет (Налоговый кодекс)». Эх сурвалж: https://online.zakon.kz
[224] Татварын тухай хуулийн 1.1.52.
[225] Татварын тухай хуулийн 646.1.5.
[226] Татварын тухай хуулийн 739.2.1-4.

малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг 0.5 коэффициентоор бууруулна[227]. Үүнд:

**Түүхий хийн олборлолтын** татварын хувь хэмжээ нь 10 хувь байх ба хэрэв түүхий хийг дотоодын зах зээлд борлуулах бол жилийн олборлолтын хэмжээнээс хамаарч татварын хувь хэмжээг дараах байдлаар тогтоосон байна[228]. Үүнд:

*Хүснэгт 2. Түүхий хийн олборлолтын татварын хувь хэмжээ*

| № | *Жилийн олборлолтын хэмжээ* | *Татварын хувь хэмжээ* |
|---|---|---|
| 1. | 1,0 тэрбум куб метр хүртэл | 0,5 |
| 2. | 2,0 тэрбум куб метр хүртэл | 1,0 |
| 3. | 2,0 тэрбум куб метрээс дээш | 1,5 |

Татварын тухай хуулийн 746 дугаар зүйлд зааснаар **ашигт малтмал, түүхий эдийн олборлолт** (үүнд анхан шатны боловсруулалт хийгдсэн ашигт малтмал, түүхий эд орно)-д ашигт малтмалын нөөц ашигласны татварын дараах хувь хэмжээг тогтооно.[229] Үүнд:

*Хүснэгт 3. Ашигт малтмал, түүхий эдийн олборлолтын татварын хувь хэмжээ*

| № | | *Ашигт малтмал, түүхий эд (үүнд зөвхөн анхан шатны боловсруулалт хийгдсэн ашигт малтмал, түүхий эд орно)-ийн нэр* | *Татварын хувь хэмжээ* |
|---|---|---|---|
| 1. | Хар, өнгөт болон цацраг идэвхт металлын хүдэр | Хромын хүдэр (баяжмал) | 16,2 |
| | | Мангантай болон төмөр-мангантай хүдэр (баяжмал) | 2,5 |
| | | Төмрийн хүдэр (баяжмал) | 2,8 |
| | | Уран | 18,5 |
| 2. | Металл | Мангантай болон төмөр-мангантай хүдэр (баяжмал) | 5,7 |
| | | Төмрийн хүдэр (баяжмал) | 7,0 |
| | | Уран | 8,0 |
| | | Алт, мөнгө, цагаан алт, паллади | 5,0 |
| | | Хөнгөн цагаан | 0,25 |
| | | Цагаан тугалга | 3,0 |
| | | Никель | 6,0 |
| 3. | Металл агуулсан эрдэс түүхий эд | Ванади | 4,0 |
| | | Хром, титан, магний, кобальт, вольфрам, бисмут, сурьма, мөнгөн ус, хүнцэл болон бусад | 6,0 |
| 4. | Ховор металл агуулсан эрдэс түүхий эд | Ниобий, лантан, церий, циркони | 7,7 |
| | | Галий | 1,0 |
| 5. | Сийрэг металл агуулсан эрдэс түүхий эд | Селен, теллур, молибден | 7,0 |
| | | Скандий, германий, рубиди, цезий, кадмий, индий, талли, гафний, рени, осмий | 6,0 |
| 6. | Цацраг идэвхт металл агуулсан эрдэс түүхий эд | Родий, торий | 5,0 |
| 7. | Ховор металл агуулсан эрдэс түүхий эд | Лити, берилли, тантал, стронци | 7,7 |
| 8. | Газрын ховор металл | Празеодим, неодим, прометий, самарий, | 6,0 |

[227] Татварын тухай хуулийн 743.1.
[228] Татварын тухай хуулийн 743.1.
[229] Татварын тухай хуулийн 746.

| | | | |
|---|---|---|---|
| | агуулсан эрдэс түүхий эд | европий, гадолиний, тербий, диспрозий, гольмий, эрбий, тулий, иттербий, лютений, иттрий | |
| ***Металл бус хатуу ашигт малтмал агуулсан эрдэс түүхий эд*** | | | |
| 9. | Түлш, химийн болон агрономийн эрдэс түүхий эд | Чулуун нүүрс, хүрэн нүүрс, шатдаг занар | 0 |
| | | Фосфорит | 4,0 |
| | | Борын хүчил (үүнд борын ангидрит хамаарна) | 3,5 |
| | | Кали болон кали-магнийн давс | 6,0 |
| | | Бари | 4,5 |
| | | Стеатит | 2,0 |
| | | Гипс | 5,6 |
| | | Хүхэр | 6,0 |
| | | Хайлуур жонш | 3,0 |
| | | Воластанит | 3,5 |
| | | Шунгит | 2,0 |
| | | Графит болон бусад | 3,5 |
| ***Өнгөт чулуун түүхий эд*** | | | |
| 10. | Үнэт чулуу агуулсан эрдэс түүхий эд | Алмаз, бадмаараг, индранил, маргад, анар, александрит, улаан (эрдэнийн) шпинель, эвклаз, молор, усан биндэрьяа болон бусад | 12,0 |
| 11. | Гоёл чимэглэлийн чулуу агуулсан эрдэс түүхий эд | Нефрит, хас, хаш, номин, радонит, малахит, авантюрин, гартаам, уулын болор, кварц, оюу, дипотаз, мана болон бусад | 3,5 |
| 12. | Үйлдвэрлэлийн чулуу агуулсан эрдэс түүхий эд | Техникийн алмаз, гартаам, корунд, циркон, хас, серпентинит, асбест, гялтгануур болон бусад | 2,0 |
| 13. | Бусад металл бус эрдэс түүхий эд | Хөнгөн цагаан агуулсан чулуу (хээрийн жонш, пегматит) | 2,5 |
| | | Калорин, вермикулит, бусад металл бус хатуу ашигт малтмал, металл бус эрдэс түүхий эд | 4,7 |

# КАЗАХСТАН УЛСЫН ГАЗРЫН ХЭВЛИЙ, ТҮҮНИЙГ АШИГЛАХ ТУХАЙ ХУУЛЬ: 2010, 2017 ОНЫ ХУУЛИЙН ХАРЬЦУУЛАЛТ

*Г.Билгээ*

## АГУУЛГА

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Нэг. Казахстан Улсын газрын хэвлий, түүнийг ашиглах хууль тогтоомжийн хөгжил

Хоёр. 2017 онд батлагдсан Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хуулийн ерөнхий танилцуулга

- Хуулийн төслийн зорилго
- Хуулийн зорилго, зорилт
- Хуулийн зарчим
- Газрын хэвлийг ашиглах тогтвортой байдлын баталгаа
- Хууль хүчин төгөлдөр болох
- Газрын хэвлийн өмчлөл
- Хуулиар зохицуулагдсан газрын хэвлийн нөөц
- Газрын хэвлийг ашиглах үйл ажиллагааны төрөл
- Геологийн мэдээлэл авах боломж

Гурав. 2010, 2017 оны Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хуулиудын харьцуулалт

- 2010, 2017 оны хуулиудын бүтцийн харьцуулалт
- Газрын хэвлийг ашиглах эрх
- Газрын хэвлийг ашиглагчийн эрх, үүрэг
- Газрын хэвлийг ашиглалтын салбар дахь төрийн байгууллагуудын тогтолцоо
- Газрын хэвлийг ашиглалтын салбар дахь төрийн удирдлага

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Бүгд Найрамдах Казахстан Улсын Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хууль тогтоомжийн хөгжлийг хэд хэдэн үе шатанд хуваан үздэг. Тус улсад газрын хэвлийг ашиглахтай холбоотой харилцааг зохицуулсан бие даасан хууль батлагдсанаас хойш эрх зүйн орчныг чангатгасан, үүний дараа гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор эрх зүйн орчныг либералчласан, харин сүүлийн шинэчлэлээр газрын хэвлийг ашиглах эрх олгох тогтолцоог шинэчилсэн зэрэг өөрчлөлтүүдийг олон удаа хийж байна.

Хамгийн сүүлд Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдөр баталсан.[230]

Ашигт малтмалын тухай хууль тогтоомжид “газрын хэвлий” гэсэн нэр томьёог ОХУ[231] болон Армени[232], Беларусь[233], Гүрж[234], Казахстан[235], Узбекистан[236], Украйн[237] зэрэг хуучин Зөвлөлт Холбоот Улсын бүрэлдэхүүнд байсан орнуудад түгээмэл хэрэглэдэг байна.

Казахстаны Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хуулийн 2.1-д энэ хуулийн үйлчлэх хүрээг заасан байна. Энэ хуулиар газрын хэвлийг ашиглах горим, газрын хэвлийг ашиглалтын салбар дахь төрийн удирдлага, зохицуулалтыг хэрэгжүүлэх журам, газрын хэвлийг ашиглах эрх үүсэх, хэрэгжүүлэх, дуусгавар болох, газрын хэвлийг ашиглагчийн эрх зүйн байдал болон явуулах үйл ажиллагаа, газрын хэвлий ашиглалт болон газрын хэвлийг ашиглах эрх болон бусад харилцааг зохицуулсан.

Шинэ хуулийн зохицуулалт нь дэлхийн шилдэг туршлагад нийцсэн, Казахстан Улсын газрын хэвлийг ашиглах салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлсэн бөгөөд хөрөнгө оруулалтыг татахад томоохон ахиц дэвшил гаргах, шинэ ордыг нээх, нэмэлт ажлын байр бий болгох эрх зүйн үндэс болно хэмээн үзэж байна.

Хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэхийн тулд Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хуулийг бүтцийн хувьд системчлэн, агуулгын хувьд дараах томоохон өөрчлөлтүүдийг оруулсан байна. Үүнд:

- тогтолцооны хувьд, төрийн байгууллагууд газрын хэвлийг ашиглах үйл ажиллагааг чиглэл тус бүрээр хариуцаж ажиллах;
- тусгай зөвшөөрөл, гэрээний нөхцөлийн хэрэгжилтэд хяналт тавих журмыг тусгах;
- төрийн давуу эрх зөвхөн нүүрсустөрөгч, уран зэрэг стратегийн ач холбогдолтой салбаруудад хамаарах;
- газрын хэвлийг ашиглах нөхцөлийг тогтвортой байлгах баталгаа гаргах,
- газрын хэвлийг ашиглах эрх олгох журмыг тогтоохдоо үйл ажиллагааны онцлогоос нь хамааруулан тусгай зөвшөөрөл, гэрээний тогтолцоог хэрэглэх;
- геологи, газрын хэвлийг ашиглалтын талаарх мэдээлэл авах боломж;
- гар аргаар хатуу ашигт малтмал олборлох харилцааг зохицуулах;
- газрын хэвлийг ашиглагчийн нийгмийн хариуцлагын үүргийг тодорхой болгох;
- дотоодын зах зээлийг түүхий эдээр хангах;
- гэрээний дагуу газрын хэвлийн талбайг өөрчлөх зэрэг асуудлуудыг тусгасан.

### Нэг. КАЗАХСТАН УЛСЫН ГАЗРЫН ХЭВЛИЙ, ТҮҮНИЙГ АШИГЛАХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХӨГЖИЛ

Казахстаны хуульчдын үзэж байгаагаар тус улсын орчин үеийн газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хууль тогтоомжийн хөгжлийг дор дурдсан үе шатуудад хуваан үзэж

[230] Кодекс Республики Казахстан от 2017.12.27 № 125-VI “О недрах и недропользовании”. Эх сурвалж: https://online.zakon.kz/Document/?doc_id=31764592
[231] Закон Российской Федерации от 21.02.1992 № 2395-1 (ред. от 30.09.2017) "О недрах".
[232] Кодекс Республики Армения от 2011.11.28 (ред. от 2017.12.21) “О недрах”.
[233] Кодекс Республики Беларусь от 2008.07.14 № 406-З (ред. от 2016.07.18) “О недрах”.
[234] Кодекс Республики Грузии от 2017.05.23 “О недрах”.
[235] Кодекс Республики Казахстан от 2017.12.27 № 125-VI “О недрах и недропользовании”.
[236] Закон Республики Узбекистана от 1994.09.23 № 2018-XII (ред. от 2002.12.13) “О недрах”.
[237] Кодекс Республики Украины от 2017.05.23 “О недрах”.

байна.[238] Үүнд:

| | | |
|---|---|---|
| I үе шат | - | 1990-1994 он; |
| II үе шат | - | 1994-1999 он; |
| III үе шат | - | 1999-2004 он; |
| IV үе шат | - | 2004-2014 он; |
| V үе шат | - | 2014 оноос хойш. |

**I үе шат (1990-1994 он) - Казахстан Улсад газрын хэвлийг ашиглахтай холбоотой харилцааг зохицуулсан бие даасан хууль, эрх зүйн орчин бий болсон.**

1992 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн Газрын хэвлий, эрдэс түүхий эдийг боловсруулах тухай хуулиар уг харилцааг зохицуулах эрх зүйн үндэс тавигдсан. Удалгүй энэ хуулийн цоорхой, зөрчил олноор илэрсэн төдийгүй хуулийн үзэл баримтлал нь өөрөө эдийн засгийн цоо шинэ нөхцөл байдалд тохирохгүй байгаа нь тодорхой болсон.

Гэсэн ч энэ хугацаанд гадаадын хөрөнгө оруулагчид уул уурхай, газрын тосны төслүүдэд хөрөнгө оруулж эхэлсэн. Тухайлбал, Казахстаны хамгийн том төсөл болох Тенгизшевройл[239] үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

**II үе шат (1994-1999 он) - Казахстан Улсын хууль тогтоомжид газрын хэвлийг ашиглалтын үндсэн асуудлуудыг хамруулах гэж оролдсон.**

Тухайн үед ихээхэн ач холбогдол бүхий Газрын тосны тухай (1995.06.28) болон Газрын хэвлийн тухай (1996.01.27) хуулиудыг баталсан. Гэвч эдгээр хуулиудаар гэрээ байгуулснаас хойш буюу уурхайн талбайг олборлолтод бэлтгэх, олборлох үе шатан дахь харилцааг зохицуулаагүй орхигдуулсан байв.

1996 оны Газрын хэвлийн тухай хуулийн онцлог нь газрын хэвлийг ашиглах тусгай зөвшөөрөл-гэрээний тогтолцоо; хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн хөрөнгөөр ашигт малтмалын орд илрүүлсэн бол түүнийг олборлох тусгай зөвшөөрөл авах онцгой эрх; холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт орсон бол тухайн өөрчлөлтөөс өмнө авсан тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эрх, үүргийг тогтворжуулах зэрэг асуудлууд юм.

Энэ үед Казахстанд газрын хэвлийг ашиглах журам харьцангуй чөлөөтэй (либерал) буюу хөрөнгө оруулагчдыг татахад чиглэж байсан бөгөөд холбогдох эрх зүйн орчныг боловсронгуй болгосноор Казахстаны уул уурхай, газрын тосны салбарт хөрөнгө оруулалтыг их хэмжээгээр татах боломжийг бүрдүүлсэн. Хөрөнгө оруулагчдын зүгээс Казахстаныг "хамгийн тааламжтай улс" болгохын тулд төр, засгийн зүгээс хүчин чармайлт гаргаж байгааг эерэгээр хүлээн авсан бөгөөд тус улсад газрын хэвлийг ашиглахын тулд актив болон газрын хэвлийг ашиглах эрх авч эхэлсэн. Тухайлбал, энэ хугацаанд "Южнефтегаз" ХК (одоогийн "ПетроКазахстан" ХК)-ийг Канадын "Hurricane Kumkol Limited" компани хувьчлан авсан. Хожим "Hurricane Kumkol Limited" компани нь "Южнефтегаз" үйлдвэрийн газартай хамтран "Казгермунай", "Тургай Петролеум"-ийн хувьцаа эзэмшигч болсон.

**III үе шат (1999-2004 он) - Газрын хэвлийг ашиглах тусгай зөвшөөрөл-гэрээний тогтолцооноос дан гэрээний тогтолцоо руу шилжин гэрээний нөхцөлийг чангатгаж эхэлсэн.**

1999 оны 08 дугаар сарын 11-ний өдөр Газрын хэвлийн тухай болон Газрын тосны тухай хуулиудад хэд хэдэн концепцийн шинжтэй өөрчлөлт орсон. Зарчмын томоохон шинэчлэл бол газрын хэвлийг ашиглах тусгай зөвшөөрөл-гэрээний тогтолцооноос дан гэрээний тогтолцоо руу шилжсэн явдал байв. Энэ нь газрын хэвлийг ашиглах гэрээний

[238] "Законодательство о недрах и недропользовании: история вопроса и новая концепция». Ольга Ченцова, Наталья Брайнина. Журнал "Petroleum", 2015, №4, с. 60-67; №5, с. 74-81. Эх сурвалж: www.zakon.kz/4755276-zakonodatelstvo-o-nedrakh-i.html

[239] Тенгизшевройл нь Казахстан Улсын Засгийн газар, АНУ-ын "Шеврон" корпорацийн хооронд байгуулсан гэрээний дагуу 1993 онд байгуулагдсан бөгөөд газрын тос, хий, хүхэр зэрэг үндсэн түүхий эдийг боловсруулах тус улсын хамгийн том бөгөөд аюулгүйд тооцогддог компани. Эх сурвалж: www.tengizchevroil.com/ru/about/overview

үндсэн дээр эрх олж авах, цаашлаад хэвлий ашиглагч нь эрхээ хэрэгжүүлэх зэрэг үйл явцуудыг хялбаршуулсан.

Хуулийг хэрэгжүүлэх явцад Газрын хэвлий ашиглалтын салбар дахь зарим чухал асуудлууд мөн л зохицуулагдаагүй үлдсэн байв. Тухайлбал, хүрээлэн буй орчныг хамгаалах, далайн нөөцийг боловсруулах зэрэг зохицуулагдаагүй үлдсэн зарим асуудлууд байсан хэдий ч өмнөх хуулиар ямар нэгэн байдлаар зохицуулсан байжээ.

1999 оны өөрчлөлтөөр газрын хэвлий ашиглалтын эрх зүйн орчныг чангатгах зарим өөрчлөлтүүдийг оруулсан. Тухайлбал, тендер буюу сонгон шалгаруулалтын дүнд үндэслэн газрын хэвлийг ашиглах эрх олгох ерөнхий журмыг тогтоох; Үндэсний компаниуд, тэдгээрийн давуу эрхийг тодорхой заах; орон нутгийн үйлдвэрлэгчдээс бараа, ажил үйлчилгээ худалдан авахад илүү хатуу шаардлага тавих гэх мэт.

**IV үе шат (2004-2014 он) - Газрын тос болон Газрын хэвлий ашиглалтын эрх зүйн орчныг чангатгахад чиглэсэн.**

2004 оноос 2014 оны 12 дугаар сар хүртэлх хугацаанд газрын тос, газрын хэвлийн хууль тогтоомж байнга өөрчлөгдөж байсан ба ингэхдээ эрх зүйн орчныг аль болох чангатгах бодлого барьж байжээ. Далай дотор газрын тос олборлох үйл ажиллагаанд бүтээгдэхүүн хуваах гэрээг ашиглах тухай хуулийг 2005 онд баталсан боловч 2009 онд хүчингүй болгосон. Түүнчлэн Газрын хэвлийн тухай болон Газрын тосны тухай хуулиудыг нэгтгэн Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хууль болгон өөрчилж, 2010 оны 06 дугаар сарын 24-ний өдөр баталсан.

2010 онд батлагдсан Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хууль (цаашид 2010 оны хууль гэх)-д өмнөх 1999 оны хуулийн гэрээний тогтолцоотой холбоотой харилцааг хэвээр үлдээсэн байна. Мөн 2010 оны хуулиар газрын хэвлий ашиглалтын компаниуд болон түүний туслан гүйцэтгэгчдийн аж ахуйн үйл ажиллагаанд төрөөс оролцох, хяналт тавих зэрэг асуудлуудыг хэвээр үлдээснийг Казахстаны энэ салбарын хөрөнгө оруулагчдад үзүүлэх дэмжлэг, хамгаалалт дутагдсан хэмээн зарим судлаачид шүүмжилдэг. Мөн экологи, татварын болон бусад хууль тогтоомжид ч хамааралтай зохицуулалтууд хэвээр байна.

Хууль тогтоогчид газрын хэвлий ашиглалтын хууль тогтоомжид олон удаа (5 жилийн хугацаанд 25 удаа) өөрчлөлт, шинэчлэл хийсэн байна.

**V үе шат (2014 оноос хойш) - Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хууль тогтоомжийг дахин либералчлах үйл явц эхэлсэн.** Улс орны ашигт малтмалын нөөцийн санг нөхөх асуудал тулгарч, шинэ орд газруудыг хайж илрүүлэх, шинэ хөрөнгө оруулалт татах хэрэгцээ шаардлагыг харгалзан 2014 онд газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хууль тогтоомжийн зарим зохицуулалтыг либералчилсан байна.

2014 оны 12 дугаар сарын 29-ний өдөр “Бүгд Найрамдах Казахстан Улс (цаашид “БНКУ”)-ын газрын хэвлий ашиглалтын асуудлаар зарим хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль[240] батлагдаж 2010 оны хуульд томоохон өөрчлөлт орсон. Энэ хуулийн нийт 129 зүйлийн 77-д нь өөрчлөлт орсон нь орчин үеийн газрын хэвлий ашиглалтын салбарын 15 жилийн түүхэнд хууль тогтоомжид оруулсан хамгийн том өөрчлөлтүүдийн нэг юм.

Үүний үр дүнд стратегийн ач холбогдол бүхий ордуудад төрийн давуу эрхийг зөвхөн гэрээгээр хязгаарлах; газрын хэвлийг ашиглах эрхийг тендерээр төдийгүй дуудлага худалдааны хэлбэр (шалгаруулалтын процедурыг хялбарчилсан, хугацааг богиносгосон хувилбар)-ээр олгох; 10 блок (нэгж тутам нь газарзүйн координатын тооцоогоор нэг минуттай тэнцүү)-оос хэтрэхгүй байх, бага судлагдсан газрын хэвлийд хайгуулын эрх авах журмыг хялбарчилаж ердийн хайгуулын гэрээ байгуулах зэрэг боломжуудыг бий болгосон.

Гэсэн хэдий ч газрын хэвлий ашиглалтын харилцааг зохицуулсан эрх зүйн хэм

[240] Закон Республики Казахстана от 2014.12.29 № 271-V “О внесении изменений и дополнений в некоторые законодательные акты Республики Казахстан по вопросам недропользования”.

хэмжээг улам сайжруулах, хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэхийн тулд **Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хуулийн**[241] шинэчилсэн найруулгыг 2017 оны 12 дугаар сарын 27-ний өдөр баталсан.

Энэ хууль батлагдснаар БНКУ-ын орчин үеийн газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хууль тогтоомжийн хөгжлийн V үе шат дуусаж дараагийн шатанд орж байна.

## Хоёр. 2017 ОНД БАТЛАГДСАН ГАЗРЫН ХЭВЛИЙ, ТҮҮНИЙГ АШИГЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАЛААРХ ТОЙМ ТАНИЛЦУУЛГА

**Хуулийн төслийн зорилго**[242]

Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай (цаашид "2017 оны хууль" гэх) хуулийн зорилго нь газрын хэвлий ашиглалтын салбарыг чанарын шинэ түвшинд гаргах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд газрын хэвлийг ашиглах, хамгаалах тухай хууль тогтоомжийн кодификацийг хийх замаар системчлэх явдал юм.

Түүнчлэн газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаарх Казахстаны хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хөгжүүлэх, хуулийн цоорхой, зөрчлийг арилгах, гадаадын орнуудад амжилттай үйл ажиллагаа явуулж байгаа эрх бүхий байгууллагуудтай төстэй шинэ байгууллагыг байгуулах, тус улсын ашигт малтмалын нөөцийн үр ашигтай ашиглалтыг хангах хууль эрх зүй, эдийн засаг болон нийгмийн нөхцөл, баталгааг тодорхойлоход уг хуулийн төслийг батлах зорилт оршино.

**Хуулийн зорилго, зорилт** (2017 оны хуулийн 3)

Улс орны эдийн засгийн өсөлт, нийгмийн сайн сайхны төлөө БНКУ-ын ашигт малтмал, түүхий эдийн суурь баазын тогтвортой хөгжлийг хангахад энэ хуулийн зорилго оршино. Хуулийн зорилтууд:

1. газрын хэвлийн төрийн өмчийн эрхийг хамгаалах;
2. газрын хэвлий ашиглалтын салбар дахь төрийн бодлогыг хэрэгжүүлэх, харилцааг зохицуулах;
3. БНКУ-ын төр, иргэдийн ашиг сонирхлыг болон газрын хэвлий ашиглагчдын эрхийг хангах;
4. БНКУ-ын ашигт малтмал, түүхий эдийн суурь баазыг хөгжүүлэх;
5. газрын хэвлийг ашиглах эрх үүсэх, хэрэгжүүлэх, өөрчлөх, дуусгавар болгох үндэслэл, нөхцөл, журмыг тогтоох;
6. газрын хэвлий ашиглалтыг тогтвортой хөгжүүлэх эрх зүйн үндсийг хангах;
7. газрын хэвлийн геологийн судалгаанд хөрөнгө оруулалт татах нөхцөлийг бүрдүүлэх;
8. газрын хэвлий ашиглалтын салбарын хуул тогтоомжийг бэхжүүлэх.

**Хуулийн зарчим**

2010, 2017 оны хуулиудад газрын хэвлий, түүнийг ашиглахтай холбоотой харилцааны эрх зүйн зохицуулалтын зарчмуудыг Хүснэгт 1-д харуулав.

[241] Кодекс Республики Казахстан от 2017.12.27 № 125-VI "О недрах и недропользовании".
[242] Концепция проекта Кодекса Республики Казахстан «О недрах и недропользовании». Эх сурвалж: http://mid.gov.kz/ru/

*Хүснэгт 1. 2010, 2017 оны хуулийн зарчмууд*

| 2010 оны хуулийн 5-р зүйл | 2017 оны хуулийн 4-р зүйл |
|---|---|
| 1. газрын хэвлийг зохистой, цогц, аюулгүй ашиглалтыг хангах;<br>2. газрын хэвлий, байгаль орчныг хамгаалах;<br>3. газрын хэвлийг ашиглах үйл ажиллагааны ил тод байдал;<br>4. газрын хэвлий ашиглалтын төлбөр;<br>5. газрын хэвлий ашиглалтын нөхцөлийн тогтвортой байдал. | 1. газрын хэвлийн төрийн сангийн зохистой удирдлага;<br>2. газрын хэвлийг ашиглахдаа экологийн аюулгүй байдлыг хангах;<br>3. газрын хэвлийг ашиглах салбарын мэдээллийн хүртээмжтэй байдал;<br>4. газрын хэвлийг ашиглах төлбөр;<br>5. газрын хэвлий ашиглагчдын шударга байдал;<br>6. газрын хэвлий ашиглалтын нөхцөлийн тогтвортой байдал |

**Газрын хэвлий ашиглалтын тогтвортой байдлын баталгаа** (2017 оны хуулийн 31.7, 36.7)

Хэрэв БНКУ-ын хууль тогтоомжид газрын хэвлийг ашиглах тусгай зөвшөөрөл (цаашид "тусгай зөвшөөрөл")-ийн нөхцөлд өөрчлөлт орвол өөрчлөлт орохоос өмнө олгогдсон тусгай зөвшөөрөлд шинэ нөхцөлүүд хамаарахгүй.

Түүнчлэн БНКУ-ын хууль тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлтөөр газрын хэвлийг ашиглах гэрээгээр үйл ажиллагаа явуулах нөхцөлийг дордуулсан бол нэмэлт, өөрчлөлт орохоос өмнө байгуулсан гэрээнд шинэ нөхцөлийг хэрэглэхгүй.

Харин БНКУ-ын үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, байгаль орчны аюулгүй байдал, эрүүл мэнд, татвар, гааль болон өрсөлдөөнийг зохицуулах хууль тогтоомжуудад нэмэлт, өөрчлөлт орсон бол дээрх баталгаанд хамаарахгүй.

**Хууль хүчин төгөлдөр болох** (2017 оны хуулийн 277.1)

Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хуулийг албан ёсоор нийтлэгдсэн өдрөөс хойш **6 сарын дараа** хүчин төгөлдөр болно (зарим тодорхой заалтуудаас бусад).

Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хуулийг "Казахстаны үнэн" сонины 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 249 (28628) дугаарт хэвлэгдсэн.

**Газрын хэвлийн өмчлөл** (2017 оны хуулийн 11)

Газрын хэвлий нь БНКУ-ын Үндсэн хуулийн[243] дагуу төрийн өмчид байна.

**Хуулиар зохицуулагдсан газрын хэвлийн нөөц**

Энэ хуулиар газрын хэвлийн дараах нөөцийг ашиглах талаар зохицуулна. (2017 оны хуулийн 10.2) Үүнд:

1. ашигт малтмал;
2. техноген эрдэсийн хуримтлал;
3. газрын хэвлийн орон зай.

Ашигт малтмалыг эдийн засгийн шинжээр нь, мөн газрын хэвлийг ашиглах зохих нөхцөлийг тогтоох зорилгоор дараах байдлаар ангилна. (2017 оны хуулийн 12.2) Үүнд:

а. газрын доорх ус;
б. нүүрсустөрөгчийн ашигт малтмал (нүүрсустөрөгч);
в. хатуу ашигт малтмал.

Техногенийн эрдэсийн хуримтлал нь ашигт малтмал, ашигт малтмалын агууламжтай уурхайн олборлолт, боловсруулалт болон эрчим хүчний үйлдвэрлэлээс гарсан хог хаягдлын хуримтлалыг ойлгоно. (2017 оны хуулийн 13.1)

---

[243] БНКУ-ын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг. www.akorda.kz/ru/official_documents/constitution

Газрын хэвлийн орон зай нь газрын хэвлийн гурван хэмжээст орон зайн шинж чанартай бөгөөд геотехник, геологи, эдийн засаг болон экологийн хүчин зүйлсийг харгалзан үйлдвэрлэл, судалгаа шинжилгээ болон бусад үйл ажиллагааны объектыг байрлуулах талбай болгон ашиглана. (2017 оны хуулийн 16)

**Газрын хэвлийг ашиглах үйл ажиллагааны төрөл** (2017 оны хуулийн 22)

Газрын хэвлийг ашиглах эрхийг дараах үйл ажиллагаанд олгоно. Үүнд:

1. газрын хэвлийн геологийн судалгаа;
2. ашигт малтмалын хайгуул;
3. ашигт малтмалын олборлолт;
4. газрын хэвлийн орон зай ашиглалт;
5. гар аргаар ашигт малтмал олборлолт.

**Геологийн мэдээлэл авах боломж**

Газрын хэвлий ашиглалтын салбар дахь өөр нэг чухал шинэчлэл нь нууцын зэрэглэлтэй, эсхүл төрийн нууцтай холбоотойгоос бусад геологийн мэдээллийг нээлттэй байлгахаар тусгайлан заасан явдал юм. (2017 оны хуулийн 7.1, 64.1, 77) Геологийн мэдээлэл авах боломж нь 2017 хуулийн үндсэн зарчмуудын нэг юм. (2017 оны хуулийн 4)

Энэ салбарт тэргүүлж байгаа орнуудын туршлагаас үзэхэд, хөрөнгө оруулагчид геологийн чанартай мэдээллээр хангагдаж чадвал геологийн эрсдэл бага байдаг учраас тэд мэдээлэл сайтай газрын хэвлийг ашиглах сонирхол их байдаг байна. Олгогдсон газрын хэвлийг ашиглах эрх, түүний эзэмшигчид, тэдгээрийн үйл ажиллагааны үндсэн мэдээлэл нээлттэй байна. (2017 оны хуулийн 60, 65, 66, 77)

## Гурав. 2010, 2017 ОНЫ ГАЗРЫН ХЭВЛИЙ, ТҮҮНИЙГ АШИГЛАХ ТУХАЙ ХУУЛИУДЫН ХАРЬЦУУЛАЛТ

**2010, 2017 оны хуулиудын бүтцийн харьцуулалт**

2010 оны Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хууль нь 15 бүлэг, 125 зүйлтэй (2017 оны 7 дугаар сарын 11-ний байдлаар).[244]

Харин 2017 оны Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хууль өөр бүтэцтэй: Ерөнхий болон Тусгай анги, 33 бүлэг, 268 зүйлтэй. Энэ хуулиар газрын хэвлийг ашиглахад ашигт малтмалын тодорхой төрөл тус бүрээр нь янз бүрийн харилцааг зохицуулсан; үйл ажиллагааны төрлөөс хамааран газрын тосны үйл ажиллагааг тусгаарлах, тухайлбал, нүүрсустөрөгчийн хайгуул болон олборлолтыг 2 тусдаа хэсэгт оруулсан байна. (Хүснэгт 2.)

*Хүснэгт 2. 2010, 2017 оны хуулиудын бүтцийн харьцуулалт*

| Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хууль (2010.06.24) | Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хууль (2017.12.27) |
|---|---|
| | **ЕРӨНХИЙ АНГИ** |
| 1-р бүлэг. Нийтлэг үндэслэл | **1-р хэсэг. Нийтлэг үндэслэл** |
| | 1-р бүлэг. Нийтлэг үндэслэл |
| | 2-р бүлэг. Газрын хэвлий болон түүний нөөцийн талаарх нийтлэг үндэслэл |
| | **2-р хэсэг. Газрын хэвлий ашиглалт** |
| 2-р бүлэг. Газрын хэвлий ашиглалтын салбар дахь төрийн зохицуулалт | } *9-р бүлгээр зохицуулах болсон* |
| 3-р бүлэг. Газрын хэвлийг ашиглах эрх | 3-р бүлэг. Газрын хэвлийг ашиглах эрхийн талаарх нийтлэг үндэслэл |
| 4-р бүлэг. Шалгаруулалтын үндсэн дээр газрын хэвлийг ашиглах эрх олгох | 4-р бүлэг. Газрын хэвлийг ашиглах эрх олгох журам |
| 5-р бүлэг. Шууд хэлэлцээрийн үндсэн дээр газрын хэвлийг ашиглах эрх олгох | |

[244] Закон Республики Казахстан от 2010.06.24 “О недрах и недропользовании” (с *изменениями и дополнениями* по состоянию на 2017.07.11). Эх сурвалж: http:///online.zakon.kz

| | |
|---|---|
| | §1. Газрын хэвлийг ашиглах зөвшөөрөл |
| 6-р бүлэг. Газрын хэвлийг ашиглах гэрээ | §2. Газрын хэвлийг ашиглах гэрээ |
| | 5-р бүлэг. Газрын хэвлийг ашиглах эрх болон эрхтэй холбоотой объектуудыг шилжүүлэх |
| | 6-р бүлэг. Газрын хэвлийг ашиглах үйл ажиллагаа эрхлэх оператор |
| 7-р бүлэг. Газрын хэвлий ашиглагчийн эрх, үүрэг | |
| 8-р бүлэг. Газрын тосны үйл ажиллагаа | *15-21-р бүлгүүдээр зохицуулах болсон* |
| 9-р бүлэг. Далай болон дотоодын усан санд газрын тосны үйл ажиллагаа явуулах | |
| 9-1-р бүлэг. Техногенийн эрдэс боловсруулалт, ашиглалт | |
| 10-р бүлэг. Хүчингүй болсонд тооцсон | |
| | **3-р хэсэг. Газрын хэвлийн аюулгүй ашиглалт** |
| 11-р бүлэг. Газрын хэвлий, хүрээлэн буй орчны хамгаалалт, газрын хэвлий зохистой, нэгдсэн ашиглалт, хүн ам, ажиллах хүчний аюулгүй байдал | 7-р бүлэг. Газрын хэвлий ашиглалтын аюулгүй ажиллагааны шаардлага |
| | 8-р бүлэг. Газрын хэвлий ашиглалтаас гарсан үр дагаврыг арилгах |
| | **4-р хэсэг. Газрын хэвлий ашиглалтын салбар дахь төрийн удирдлага** |
| *2-р бүлгээр зохицуулж байсан* | 9-р бүлэг. Газрын хэвлий ашиглалтын салбар дахь төрийн байгууллагуудын тогтолцоо |
| 12-р бүлэг. Газрын хэвлийн хамгаалалт, судалгаа, ашиглалтад тавих төрийн хяналт | 10-р бүлэг. Газрын хэвлий ашиглалтын салбар дахь хяналт тавих, мэдээлэх |
| 13-р бүлэг. Газрын хэвлийн төрийн сан | 11-р бүлэг. Газрын хэвлийн төрийн сан |
| | **5-р хэсэг. Газрын хэвлий ашиглалттай холбоотой маргаан, газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хууль тогтоомжийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, газрын хэвлийг ашиглах, хамгаалах чиглэлээрх олон улсын хамтын ажиллагаа** |
| 14-р бүлэг. Газрын хэвлий, газрын хэвлийг ашиглах тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага | 12-р бүлэг. Газрын хэвлий ашиглалттай холбоотой маргаан, газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хууль тогтоомжийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага |
| | 13-р бүлэг. Газрын хэвлийг ашиглах, хамгаалах чиглэлээрх олон улсын хамтын ажиллагааны зорилго, зарчим, үндсэн чиглэл, төрөл |
| | **ТУСГАЙ АНГИ** |
| | **6-р хэсэг. Геологийн судалгаа** |
| | 14-р бүлэг. Геологийн судалгаа хийх нөхцөл, журам |
| | **7-р хэсэг. Нүүрсустөрөгчийн хайгуул, олборлолт** |
| | 15-р бүлэг. Нүүрсустөрөгчийн чиглэлээр газрын хэвлийг ашиглах эрх олгох, дуусгавар болох |
| | §1. Нүүрсустөрөгчийн чиглэлээр газрын хэвлийг ашиглах эрхийг дуудлага худалдаагаар олгох |
| *2-р бүлгээр зохицуулж байсан* | §2. Нүүрсустөрөгчийн чиглэлээр газрын хэвлийг ашиглах эрхийг нүүрсустөрөгчийн салбар дахь үндэсний компанид шууд хэлэлцээрийн үндсэн дээр олгох |
| | §3. Нүүрсустөрөгчийн чиглэлээр газрын хэвлийг ашиглах эрх дуусгавар болох |
| | 16-р бүлэг. Нүүрсустөрөгчийн хайгуул, олборлолт хийх талбай, нутаг дэвсгэр |
| | 17-р бүлэг. Нүүрсустөрөгчийн хайгуул, олборлолт хийх хугацаа |
| | 18-р бүлэг. Нүүрсустөрөгчийн хайгуул, олборлолт хийх нөхцөл |

| | |
|---|---|
| | 19-р бүлэг. Нүүрсустөрөгчийн чиглэлээр газрын хэвлийг ашиглах төслийн баримт бичиг |
| *2-р бүлгээр зохицуулж байсан* | 20-р бүлэг. Нүүрсустөрөгчийн чиглэлээр газрын хэвлийг ашиглах |
| | 21-р бүлэг. Нүүрсний давхаргын метаны хайгуул, олборлолтын онцлог, далай болон дотоодын усан сан, аюулгүй байдлын бүс дэх нүүрсустөрөгчийн хайгуул, олборлолт |
| | **8-р хэсэг. Уран олборлолт** |
| | 22-р бүлэг. Уран олборлох чиглэлээр газрын хэвлийг ашиглах эрх олгох болон дуусгавар болох |
| | §1. Уран олборлох чиглэлд газрын хэвлийг ашиглах эрхийг ураны салбар дахь үндэсний компанид шууд хэлэлцээрийн дагуу олгох |
| | §2. Уран олборлох чиглэлд газрын хэвлийг ашиглах эрх дуусгавар болох |
| | 23-р бүлэг. Уран олборлох уурхайн газар нутаг, талбай |
| | 24-р бүлэг. Уран олборлох хугацаа |
| *2010 оны хуульд уран, хатуу ашигт малтмалын үйл ажиллагаатай холбоотой харилцааг ерөнхий байдлаар зохицуулсан.* | 25-р бүлэг. Уран олборлох нөхцөл |
| | 26-р бүлэг. Уран олборлох төслийн баримт бичиг |
| | **9-р хэсэг. Хатуу ашигт малтмалын хайгуул, олборлолт** |
| | 27-р бүлэг. Хатуу ашигт малтмалын хайгуул |
| | 28-р бүлэг. Хатуу ашигт малтмалын олборлолт |
| | 29-р бүлэг. Хатуу ашигт малтмалын олборлолт явуулах талбайг хадгалах |
| | 30-р бүлэг. Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт |
| | 31-р бүлэг. Хатуу ашигт малтмалыг хайх, олборлохын тулд газрын хэвлийн талбайг өөрчлөх |
| | 32-р бүлэг. Хатуу ашигт малтмал боловсруулах тухай хэлэлцээр |
| | **10-р хэсэг. Газрын хэвлийг ашиглах, гар аргаар ашигт малтмал олборлох, төгсгөлийн болон шилжилтийн нөхцөлүүд** |
| | 33-р бүлэг. Газрын хэвлийг ашиглах үйл ажиллагаа |
| | 34-р бүлэг. Гар аргаар ашигт малтмал олборлох |
| 15-р бүлэг. Төгсгөлийн болон шилжилтийн нөхцөлүүд | 35-р бүлэг. Төгсгөлийн болон шилжилтийн нөхцөлүүд |

## ГАЗРЫН ХЭВЛИЙГ АШИГЛАХ ЭРХ

**Газрын хэвлий ашиглагч** (2017 оны хуулийн 18)

Газрын хэвлийг ашиглах эрх эзэмшигч (цаашид “газрын хэвлий ашиглагч”) нь хувь хүн, хуулийн этгээд байна. Газрын хэвлий ашиглагч нь нэгэн зэрэг хэд хэдэн хувь хүн, эсхүл хуулийн этгээд байж болно. Энэ тохиолдолд газрын хэвлийг ашиглах эрх нь дундынх байна. Газрын хэвлийг ашиглах дундын эрх нь газрын хэвлийг ашиглах эрхийг хоёр болон түүнээс дээш этгээдэд нэгэн зэрэг олгосон, эсхүл газрын хэвлийг ашиглах эрхийн зарим хэсгийг нэг этгээдээс нөгөөд шилжүүлэхэд үүснэ.

**Газрын хэвлийг ашиглах эрх үүсэх үндэслэл** (2017 оны хуулийн 20)

Газрын хэвлийг ашиглах эрх дор дурдсан үндэслэлээр үүснэ. Үүнд:

1. газрын хэвлийг ашиглах тусгай зөвшөөрөл;
2. газрын хэвлийг ашиглах гэрээ.

Газрын хэвлийг ашиглах эрхийг дараах тохиолдолд авна:

1. газрын хэвлийг ашиглах эрхийг эрх бүхий байгууллагаас олгох;
2. иргэний эрх зүйн хэлцлийн дагуу газрын хэвлийг ашиглах эрх (эсхүл эрхийн зарим

хэсэг) шилжих;
3. хуулийн этгээд өөрчлөн байгуулагдах (өөрчлөн байгуулагдах замаар шинээр үүсгэх, эсхүл өв залгамжлах хамаарахгүй) замаар газрын хэвлийг ашиглах эрх шилжүүлэх.

**Газрын хэвлийг ашиглах эрх олгох зохицуулалт**

Газрын хэвлийг ашиглах үйл ажиллагааны төрлөөс хамаарч газрын хэвлийг ашиглах эрхийг тусгай зөвшөөрөл, эсхүл гэрээгээр олгохоор зохицуулсан байна.

Газрын хэвлийг ашиглах ***тусгай зөвшөөрлийг*** дараах үйл ажиллагаанд олгоно. (2017 оны хуулийн 30) Үүнд:

1. газрын хэвлийн геологийн судалгааны;
2. хатуу ашигт малтмалын хайгуулын;
3. хатуу ашигт малтмалын олборлолтын;
4. түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолтын;
5. газрын хэвлийн орон зай ашиглалтын;
6. гар аргаар хатуу ашигт малтмалын олборлолтын.

Харин дараах үйл ажиллагаанд газрын хэвлийг ашиглах эрхийг ***гэрээгээр*** олгоно. (2017 оны хуулийн 35.3) Үүнд:

1. нүүрсустөрөгчийн хайгуулын;
2. нүүрсустөрөгчийн олборлолтын;
3. ураны олборлолтын.

**Газрын хэвлийг ашиглах эрх олгох журам**

Шинэчилсэн найруулгад хатуу ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн тогтолцоог нэвтрүүлсэн, харин нүүрсустөрөгч, ураны чиглэлээр газрын хэвлийг ашиглах эрх үүсэх эрх зүйн хэрэгсэл болохын хувьд гэрээг хадгалж үлдсэн байна.

2010 оны хуулийн дагуу газрын хэвлийг ашиглах эрх олгох үйл явц 1,5-2 жил үргэлжилдэг байсан. Шинэ өөрчлөлтөөр тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг эрх бүхий байгууллага ажлын 10 хоногт хянаж үзэх, харин газрын хэвлийг ашиглах гэрээ байгуулах хугацаа 40 хоног хүртэл буурсан байна.

Хатуу ашигт малтмалын чиглэлээр газрын хэвлийг ашиглах эрхийг тухайн этгээдийн өргөдлийн дагуу тусгай зөвшөөрөл олгох замаар өрсөлдөөнгүйгээр олгоно:

1. газрын хэвлийн геологийн судалгааны - 3-аас доошгүй жил (2017 оны хуулийн 84.1);
2. хатуу ашигт малтмалын хайгуулын - дараалсан 6 жил (2017 оны хуулийн 193.1);
3. хатуу ашигт малтмалын олборлолтын - дараалсан 25-аас доошгүй жил (2017 оны хуулийн 211.1);
4. түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолтын - дараалсан 10-аас дээшгүй жил (2017 оны хуулийн 233.2);
5. газрын хэвлийн орон зай ашиглалт - дараалсан 25-оос дээшгүй жил (2017 оны хуулийн 256.1);
6. гар аргаар ашигт малтмал олборлолт - 3 жил. (2017 оны хуулийн 268)

Дуудлага худалдаанд үндэслэж байгаа газрын хэвлийг ашиглах эрхийг гэрээ байгуулах замаар олгоно:

1. нүүрсустөрөгчийн хайгуул, олборлолт - дараалсан 6-аас дээшгүй жил, далайд нүүрсустөрөгчийн хайгуул, эсхүл хайгуулын хүнд төсөл - 9-өөс дээшгүй жил (2017 оны хуулийн 116.1);
2. нүүрсустөрөгчийн олборлолт - 25-аас дээшгүй жил, харин том бөгөөд өвөрмөц ордод нүүрсустөрөгчийн олборлолт - 45-аас дээшгүй жил (2017 оны хуулийн 120.1);
3. уран олборлолт - 25-аас дээшгүй жил (үүнд туршилтаар олборлолт хийсэн хугацааг оруулна). (2017 оны хуулийн 172.1)

2010 оны хуулиар зохицуулж байсан нүүрс устөрөгчийн үйл ажиллагааны 3 төрөл

(1.хайгуул, 2.олборлолт, 3.хайгуул, олборлолт хосолсон)-ийн гэрээний оронд 2017 оны хуулиар 2 төрлийн гэрээ (1.олборлолт, 2.хайгуул, олборлолт хосолсон) болсон байна.

2017 оны хуулиар хатуу ашигт малтмал (уранаас бусад)-ын чиглэлээр газрын хэвлийг ашиглах эрх олгох дараах журмыг тогтоосон. Үүнд:

1. ***Өрсөлдөөний бус зарчмаар газрын хэвлийг ашиглах эрх олгох*** зарчмыг дараах нөхцөлд хэрэглэнэ. Үүнд:
    а) хатуу ашигт малтмал хайгуул, олборлолтын эрх (уранаас бусад);
    б) газрын хэвлийн орон зайг ашиглах эрх;
    в) гар аргаар ашигт малтмал олборлох тайлбай ашиглах эрх.
2. 2017 оны хуульд газрын хэвлийг ашиглах эрхийг ***дуудлага худалдааны үндсэн дээр олгох*** зохицуулалт хэвээр үлдээсэн. Нүүрсустөрөгчийн хайгуул, олборлолтын чиглэлээрх газрын хэвлийг ашиглах эрхийг дуудлага худалдааны үндсэн дээр олгоно. (2017 оны хуулийн 93)

**Газрын хэвлийг ашиглах эрх дуусгавар болгох** (2017 оны хуулийн 21.2)

Газрын хэвлийг ашиглах эрх нь газрын хэвлийг ашиглах тусгай зөвшөөрөл, эсхүл гэрээ хүчингүй болсноор дуусгавар болно.

**Тусгай зөвшөөрөл хүчингүй болох** (2017 оны хуулийн 33)

1. олгосон хугацаа дууссан;
2. цорын ганц эзэмшигч нь нас барсан (тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үүссэн газрын хэвлийг ашиглах эрхийг БНКУ-ын иргэний хууль тогтоомжийн дагуу эзэнгүй өмч хэмээн үзнэ);
3. тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, эсхүл хүчингүй болсонд тооцох;
4. газрын хэвлийг ашиглагч нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон газрын хэвлийн талбайг ашиглахаас татгалзсан.

**Гэрээ цуцлах** (2017 оны хуулийн 38.1)

1. гэрээний дагуу хугацаа дууссан;
2. гэрээний дагуу газрын хэвлийг ашиглах цорын ганц эрх эзэмшигч нь нас барсан (гэрээний үндсэн дээр үүссэн газрын хэвлийг ашиглах эрхийг БНКУ-ын иргэний хууль тогтоомжийн дагуу эзэнгүй өмч хэмээн үзнэ);
3. газрын хэвлий ашиглагч хуулийн этгээд татан буугдсан;
4. гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах, эсхүл хүчингүй болсонд тооцсон;
5. гэрээг талууд тохиролцож цуцалсан;
6. Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хуулийн дагуу БНКУ-ын Засгийн газар газрын хэвлийн талбайг ашиглахыг хориглосон;
7. газрын хэвлийг ашиглах эрх эзэмшигч нь гэрээний дагуу газрын хэвлийн талбайг ашиглахаас татгалзсан (эсхүл буцаах).

**Нүүрсустөрөгчийн чиглэлээрх гэрээг хугацаанаас нь өмнө дуусгавар болох үндэслэл** (2017 оны хуулийн 106.1)

Хүчилтөрөгчийн чиглэлээрх гэрээг дор дурдсан шинэ үндэслэлээр хугацаанаас нь өмнө дуусгавар болгоно. Үүнд:

1. газрын хэвлийг ашиглах үйл ажиллагааг хориглосон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон;
2. төслийн баримт бичгүүдийн шинжээчийн дүгнэлтгүйгээр нүүрсустөрөгчийн чиглэлээр газрын хэвлийг ашиглах үйл ажиллагаа явуулсан.

**Газрын хэвлийн талбайг гэрээний дагуу өөрчлөх**

Газрын хэвлийн талбайг гэрээний дагуу өөрчлөх асуудлыг 2010 оны хуульд талбайг зөвхөн таслах боломжтой байсан бол 2017 оны хуульд үйл ажиллагаа явуулж байгаа ашигт малтмалын төрлөөс хамааран талбайг нэмэх, багасгах, нийлүүлэх, таслах зэргээр өөрчилж болохоор зохицуулсныг Хүснэгт 3-т үзүүлэв.

*Хүснэгт 3. Газрын хэвлийн ашиглах талбайг өөрчлөх хувилбарууд*

| | **Нэмэх** | **Багасгах** | **Нийлүүлэх** | **Таслах** |
|---|---|---|---|---|
| Нүүрсустөрөгчийн хайгуул, олборлолт | ✓ | ✓ | | ✓ |
| Ураны олборлолт | ✓ | ✓ | | |
| Хатуу ашигт малтмалын хайгуул, олборлолт | | | ✓ | ✓ |

**Газрын хэвлийн геологийн судалгаа**

2010 оны хуулийн 43.3-т газар доорх усны нөөцийн геологийн судалгааны ажлыг төсөв болон БНКУ-ын хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс санхүүжүүлж болно гэж заасан нь хувийн хөрөнгө оруулагчдад энэ төрлийн үйл ажиллагаа явуулах боломжийг олгосон.

Гэтэл энэ хуулийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээгээр хөрөнгө оруулалт нь үр ашиггүй байна гэж дүгнэжээ. Тухайлбал, геологийн судалгааны үр дүнгээр хувийн хөрөнгө оруулагчдад эдийн засгийн эерэг үр нөлөө байдаггүй, тэд гаргаж авсан геологийн мэдээллээ худалдах, эсхүл өөрөөр ашиглах боломжгүйгээр төрд шилжүүлдэг байна.[245]

Тийм учраас 2017 оны хуулиар геологийн бүх эрсдэлийг төр хариуцах төрийн хөрөнгөөр газрын хэвлийн геологийн судалгааг гэрээгээр гүйцэтгэхийн зэрэгцээ энэ салбарт хувийн хөрөнгө оруулагчдыг татах механизмыг тодорхойлж өгсөн.

Геологийн судалгаа гүйцэтгэгч нь өөрийн хөрөнгөөр, эрсдэлээ өөрөө хариуцан газрын хэвлийн геологийн судалгаа хийсэн бол судалгаанаас гарсан геологийн мэдээллийг төрд өгөх үүрэгтэй. Төр нь тухайн мэдээллийг тогтоосон хугацаанд хадгалах үүрэгтэй бөгөөд хадгалах хугацаа дуусахад мэдээллийг нийтэд нээлттэй болгоно. Энэхүү тогтоосон хугацаанд геологийн судалгаа гүйцэтгэгч нь геологийн мэдээллээ хуулиар тогтоосон журмын дагуу сонирхогч талуудад зарах эрхтэй бөгөөд энэ харилцааг хуулиар зохицуулсан байна. **(2017 оны хуулийн 90-92)**

**ГАЗРЫН ХЭВЛИЙ АШИГЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

**Хадгалалтын статус** (2017 оны хуулийн 222)

2017 оны хуульд хатуу ашигт малтмалын хувьд хадгалах статусыг шинээр тусгасан байна. Хадгалалтын статус бол тусгай зөвшөөрөлд заасан талбайд хатуу ашигт малтмалын олборлолтыг дараалсан 5 жил хүртэлх хугацаанд эхлүүлэхгүй байх, эсхүл түр зогсоох, эрхийн хувьд дахин дараалсан 5 хүртэлх жил сунгах эрхийг олгоно.

**Төслийн баримт бичиг** (2017 оны хуулийн 23)

2017 оны хуульд ашигт малтмалын төрлөөс хамааран төслийн баримт бичгийн бүтэц болон төрөлд өөрчлөлт оруулсан.

2010 оны хуулиар төслийн баримт бичигт техник-эдийн засгийн үзүүлэлтүүдийг тусгах бөгөөд дараа нь ажлын хөтөлбөрт үүнийг оруулахдаа жил бүрийн зардлыг тэмдэглэх үүрэгтэй байсан. Шинэчлэгдсэн хуульд энэхүү журмыг шинэчилсэн. Одоо төслийн баримт бичгүүдийн техник-эдийн засгийн үзүүлэлтүүдийг илүү анхаарах бөгөөд энэ нь үүргийн хангалтад хяналт тавих шалгуур үзүүлэлт болно.

**Газрын хэвлийг ашиглах үйл ажиллагааны үр дагаврыг арилгах үүрэг**

2010 оны хуулиар газрын хэвлийн ашиглагч нь үр дагаврыг арилгах үүргээ биелүүлэхийн тулд БНКУ-ын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аль ч банканд тусгай хадгаламжийн дансанд мөнгөн хөрөнгө байршуулах замаар үр дагавар арилгах санг байгуулах ёстой. Үр дагавар арилгах сан байгуулах журам, тус сангаас хасагдах мөнгөн дүн, төлбөрийн давтамжийг газрын хэвлий ашиглагчтай байгуулсан гэрээгээр

[245] Концепция проекта Кодекса Республики Казахстан «О недрах и недропользовании». Эх сурвалж: http://mid.gov.kz/ru/

тогтоож байсан.

Шинэчилсэн найруулгад газрын хэвлий ашиглагчийн үйл ажиллагааны үр дагавар арилгах үүргийн нөхцөлд өөрчлөлт орсон.

Газрын хэвлийг ашиглах үйл ажиллагааны үр дагаврыг арилгах нь Казахстаны хууль тогтоомжид заасны дагуу үйлдвэрлэлийн объект, газар нутгийг хүн амын амь нас, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалсан, аюулгүй байдлыг хангасан нөхцөлд хүргэхийн тулд явуулах үйл ажиллагааны цогц юм. (2017 оны хуулийн 54, 55)

Үр дагаврыг арилгах ажиллагаа нь газрын хэвлийг ашиглах эрх дуусcан талбай дээр хийх бөгөөд ингэхдээ санхүүгийн хэрэгслийг ашиглах замаар дараах механизмыг ашигласан байна. Үүнд:

1. батлан даагч;
2. банкны хадгаламжийн барьцаа;
3. даатгал.

Үр дагаврыг арилгах үүргээ биелүүлээгүй, эсхүл тогтоосон хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд тогтоосон хэмжээгээр төрөөс авах аюулгүй байдлын хэмжээг авна.

1. ***Үр дагаврыг арилгах үүргийг хангах батлан даагч*** - газрын хэвлийн ашиглалтын үйл ажиллагааны үр дагаврыг бүрэн, эсхүл хэсэгчлэн арилгахын тулд газрын хэвлий ашиглагчийн хүлээсэн үүргийг хангахын тулд төрийн өмнө батлан даах үүрэгтэй. (2017 оны хуулийн 56)

2. ***Банкны хадгаламжийн барьцаа*** - үр дагаврыг арилгах үүргээ биелүүлээгүй тохиолдолд төр банкны хадгаламжийн барьцаанаас тодорхой мөнгөн дүнг тенге, эсхүл гадаад валютаар авч болно. (2017 оны хуулийн 57)

3. ***Даатгал*** - газрын хэвлий ашиглагч нь үр дагаврыг арилгах үүргээ баталгаажуулахын тулд даатгалын байгууллагатай даатгалын гэрээ байгуулж болох бөгөөд хэрэв тэрээр энэхүү үүргээ хангаагүй бол даатгалын байгууллага зохих төлбөрийг төрд төлнө. (2017 оны хуулийн 58)

**Дотоодын зах зээлийг түүхий эдээр хангах**

Өмнөх хуульд байсан газрын хэвлий ашиглагчийн дотоодын зах зээлийг түүхий эдээр хангаан нийлүүлэх үүргийг гэрээний дагуу зохицуулж байсан. Харин энэ үүргийг 2017 оны хуульд тусгайлсан зохицуулалт тусгасан бөгөөд газрын хэвлий ашиглагч нь БНКУ-ын нутаг дэвсгэрт боловсруулах газрын тосны хэрэгцээг хангахын тулд хуваарийн дагуу нийлүүлэх үүрэг хүлээсэн. (2017 оны хуулийн 118.2, 123.14, 130.1)

**Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журам** (2017 оны хуулийн 131, 213)

Нүүрсустөрөгчийн хайгуул, олборлолт болон хатуу ашигт малтмалын олборлолт (үүнд гэрээт гүйцэтгэгчид хамаарна)-ын үйл ажиллагаа явуулахад бараа, ажил, үйлчилгээ авахдаа дараах аргуудын аль нэгээр гүйцэтгэнэ.

1. нээлттэй сонгон шалгаруулалт;
2. нэг эх сурвалжаас;
3. цахим нээлттэй сонгон шалгаруулалт;
4. бараа таваарын бирж дээрээс.

Нүүрс устөрөгчийн хайгуул, олборлолт, хатуу ашигт малтмалын олборлолт (гэрээт гүйцэтгэгчид)-ын үйл ажиллагаа явуулахад бараа, ажил, үйлчилгээ авах журмыг **нүүрс** устөрөгчийн болон хатуу ашигт малтмалын асуудал хариуцсан эрх бүхий байгууллагууд батална.

**Газрын хэвлий ашиглагчийн нийгмийн хариуцлагын үүрэг**

Газрын хэвлий ашиглагч нь нийгмийн хариуцлагын хүрээнд дор дурдсан ажлуудыг санхүүжүүлэх талаар тодорхой заасан. (2017 оны хуулийн 178) Үүнд:

- Казахстаны боловсон хүчний сургалт - олборлолтын зарлагын 1%;

- судалгаа, шинжилгээний ажил - олборлолтын зарлагын 1%;
- бүс нутгийн нийгэм, эдийн засгийн болон дэд бүтцийн хөгжил - гэрээний дагуу хөрөнгө оруулалтын 1%-ийг тус тус бүрдүүлнэ.

Дээрх үүргүүд нь зөвхөн олборлолтын хугацаанд үүсэх бөгөөд үйл ажиллагааныхаа хоёр дахь жилээс эхлэн хэрэгжүүлнэ.

2017 оны хуулийн төслийн үзэл баримтлалаас үзэхэд, өмнөх зохицуулалтаар энэ үүрэг нь газрын хэвлий ашиглагчдад хайгуулын үйл ажиллагааны өндөр өртөгтэй зэрэгцэн нэмэлт санхүүгийн дарамт болж байсан учраас хөрөнгө оруулагчид эрсдэлд оруулж байжээ.

**Ашигт малтмал олборлох шинэ арга** (2017 оны хуулийн 263-276)

2017 оны хууль нь гар аргаар ашигт малтмал олборлох буюу бичиг уурхайг шинээр оруулсан. Гар аргаар хатуу ашигт малтмал олборлох энэхүү шинэ арга нь химийн урвалаас бусад зөвшөөрөгдсөн арга хэрэгсэл, төхөөрөмжөөр тогтоосон нутаг дэвсгэрт ашигт малтмал гаргаж авах арга юм.

Гар аргаар хатуу ашигт малтмал олборлох дор дурдсан ерөнхий нөхцөлийг шинэчилсэн найруулгад тусгасан байна. Үүнд:

1. үнэт металл, үнэт чулуу олборлох;
2. гар аргаар хатуу ашигт малтмал олборлох субъект - БНКУ-ын иргэн байх;
3. олборлох эрх үүсэх үндэслэл - тусгай зөвшөөрөл олгох (тусгай зөвшөөрөл авах тухай хүсэлтийн дагуу);
4. тусгай зөвшөөрлийн хугацаа – 3 жил (тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүсэлтээр нэг удаа 3 жилээр сунгана);
5. тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, эсхүл солилцохыг хориглосон;
6. тусгай зөвшөөрлийг орон нутгийн захиргааны байгууллага, улсын чанартай хот олгоно;
7. олборлолт явуулах гүний хэмжээнд хязгаарлалт тогтоосон;
8. гар аргаар хатуу ашигт малтмал олборлох үйл ажиллагааны үр дагаврыг арилгах үүрэгтэй.

Казахстаны нутаг дэвсгэр дээр алтны олборлолтыг ихэвчлэн гар аргаар гүйцэтгэж байгаа. Иймд олборлолтын энэ аргыг хууль тогтоомжоор зохицуулснаар хууль бус олборлолтыг зогсоох, тэдний үйл ажиллагаанд хяналт тавих, улсын төсөвт нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх боломж бүрдэж байгааг 2017 оны хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсан байна.[246]

## ГАЗРЫН ХЭВЛИЙ АШИГЛАЛТЫН САЛБАР ДАХЬ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ТОГТОЛЦОО

**Төрийн удирдлагын шинэ арга зүй**

Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хуулийн төслийн үзэл баримтлалаас үзэхэд[247], 2017 оны хуулиар газрын хэвлий ашиглалтын салбар дахь төрийн удирдлагын шинэ арга, хандлагыг нэгтгэсэн байна.

Захиргааны хүнд суртлыг багасгах, хатуу ашигт малтмалын (уранаас бусад) чиглэлээрх газрын хэвлий ашиглалтад төрийн хяналт тавих үйл явцыг хялбарчлах үүднээс газрын хэвлий ашиглагчид үйл ажиллагааны тодорхой үр дүнд хүрэхийг шаардах болсон байна.

Энэ арга нь газрын хэвлий ашиглагч нарт зохих шалгуурт хүрэхийн тулд экологийн болон үйлдвэрлэлийн аюулгүй байдлын шаардлагад нийцсэн газрын хэвлий ашиглалтын үйл ажиллагааг хэрхэн явуулах, хүлээн зөвшөөрөгдсөн дэвшилтэт ямар техник, технологи, аргыг нэвтрүүлэх, ашиглахаа бие даан шийдвэрлэх боломж гарч байгаа аж.

---

[246] Концепция проекта Кодекса Республики Казахстан «О недрах и недропользовании». Эх сурвалж: http://mid.gov.kz/ru/

[247] Концепция проекта Кодекса Республики Казахстан «О недрах и недропользовании». Эх сурвалж: http://mid.gov.kz/ru/

Энэхүү аргыг нэвтрүүлснээр газрын хэвлий ашиглалтын салбарынхнаас улсаас тогтоосон олон тооны зохицуулалтыг "багасгаж", шинэлэг, үр ашигтай, аюулгүй, өмнө нь Казахстанд ашиглаж байгаагүй технологийг оруулахад дэмжлэг үзүүлнэ хэмээн үзэж байна.

**Төрийн байгууллагуудын тогтолцооны харьцуулалт**

2010 оны хуулийн “Газрын хэвлий ашиглалтын салбар дахь төрийн зохицуулалт” гэсэн 2 дугаар бүлэгт дор дурдсан төрийн байгууллагуудыг тусгасан байна. Үүнд:

1. БНКУ-ын Засгийн газар;
2. газрын хэвлийн асуудал хариуцсан эрх бүхий байгууллага;
3. нефт, байгалийн хийн асуудал хариуцсан эрх бүхий байгууллага;
4. үйлдвэрлэл, инновацийн үйл ажиллагаан дахь төрийн дэмжлэг хариуцсан эрх бүхий байгууллага;
5. газрын хэвлийн судалгаа, ашиглалт хариуцсан эрх бүхий байгууллага;
6. ашигт малтмалын хайгуул, боловсруулалтын төв хороо;
7. түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, боловсруулалтын бүс нутаг дундын хороо;
8. газрын хэвлийг ашиглах эрх олгох шалгаруулалтын хороо;
9. түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, олборлолтын эрх олгох шалгаруулалтын хороо;
10. төрийн давуу эрхийг хэрэгжүүлэх асуудал хариуцсан салбар дундын хороо;
11. газрын хэвлийг ашиглах асуудал хариуцсан шинжээчдийн хороо;
12. түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, олборлолтын асуудал хариуцсан шинжээчдийн хороо;
13. байгаль орчин хамгаалах асуудал хариуцсан эрх бүхий байгууллага;
14. муж, улсын чанартай хот, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд.

2017 оны хуулийн “Газрын хэвлий ашиглалтын салбар дахь төрийн байгууллагуудын тогтолцоо” гэсэн 9 дүгээр бүлэгт дор дурдсан төрийн байгууллагуудын бүрэн эрхийг тусгасан байна. Үүнд:

1. БНКУ-ын Засгийн газар;
2. асуудал хариуцсан эрх бүхий байгууллага;
3. хатуу ашигт малтмалын асуудал хариуцсан эрх бүхий байгууллага;
4. нүүрсустөрөгчийн асуудал хариуцсан эрх бүхий байгууллага;
5. ураны олборлолтын асуудал хариуцсан эрх бүхий байгууллага;
6. газрын хэвлийн судалгаа хариуцсан эрх бүхий байгууллага;
7. муж, улсын чанартай хот, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд.

Эндээс харахад, газрын хэвлий ашиглалтын салбарт төрийн удирдлага хангах байгууллагууд нь газрын хэвлийг ашиглах үйл ажиллагааны чиглэлд тус бүрээр асуудлаа хариуцан ажиллахаар болсон байна. Тухайлбал, 2017 оны хуулиар төрийн давуу эрхийг хэрэгжүүлэх асуудал хариуцсан салбар дундын хорооны чиг үүргийг тухайн асуудал хариуцсан эрх бүхий байгууллага хэрэгжүүлэхээр болсон байна.

## ГАЗРЫН ХЭВЛИЙ АШИГЛАЛТЫН САЛБАР ДАХЬ ТӨРИЙН УДИРДЛАГА

БНКУ-ын Засгийн газрын бүрэн эрх **(2017 оны хуулийн 59)**

1. Төрийн өмчийн объект болох газрын хэвлийг удирдах ажлыг зохион байгуулах, газрын хэвлийн салбар дахь төрийн бодлогын үндсэн чиглэл, түүнийг хэрэгжүүлэх стратеги, тактикийн арга хэмжээг боловсруулах;
2. үндэсний аюулгүй байдлыг хангах, хүн амын амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчныг хамгаалах зорилгоор газрын хэвлий ашиглалтад тавигдах хязгаарлалт, хоригийг тогтоох;
3. стратегийн ач холбогдол бүхий газрын хэвлийн талбайн жагсаалтыг батлах.

Хатуу ашигт малтмалын асуудал **хариуцсан** эрх бүхий байгууллагын бүрэн эрх

**(2017 оны хуулийн 61)**

1. Энэ хуульд заасан хатуу ашигт малтмалын (уранаас бусад) хайгуул, олборлолтын салбарын эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулж батлах;
2. хатуу ашигт малтмалын (уранаас бусад) олборлолтын үйл ажиллагаа явуулахад бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журмын хэрэгжилтэд төрийн хяналтыг хэрэгжүүлэх;
3. татан буулгах төлөвлөгөөнд цогц шинжилгээ хийх;
4. чулуулгийн массыг гаргаж авах, (эсхүл) хайгуулын талбай руу 1000 куб метрээс дээш хэмжээтэй хөрс шилжүүлэх зөвшөөрөл олгох;
5. хатуу ашигт малтмалын хайгуул, олборлолтын (ураны олборлолтоос бусад) үйл ажиллагааг зохицуулах;
6. хатуу ашигт малтмалын хайгуул, олборлолтын (уран болон түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолтоос бусад) үйл ажиллагаанд хяналт тавих.

Нүүрсустөрөгчийн асуудал **хариуцсан** эрх бүхий байгууллагын бүрэн эрх **(2017 оны хуулийн 62)**

1. Энэ хуульд заасан нүүрсустөрөгчийн салбарын эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулж батлах;
2. нүүрсустөрөгчийн салбарын норм-техникийн баримт бичгүүдийг боловсруулж батлах;
3. нүүрсустөрөгчийн чиглэлээрх газрын хэвлийг ашиглах үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих;
4. төслийн баримт бичгийн журмын хэрэгжилтэд төрийн хяналтыг хэрэгжүүлэх;
5. газрын тос, шатдаг хийн олборлолт, эргэлтийн мэдээллийн нэгдсэн санг хөтлөх;
6. газрын тосны бүтээгдэхүүний дотоодын зах зээлийн хэрэгцээг хангахын тулд Казахстаны нутаг дэвсгэрт болон түүний гадна боловсруулах газрын тос нийлүүлэх хуваарийг бүрдүүлэх;
7. далай болон дотоодын усан санд нүүрсустөрөгчийн хайгуул, олборлолт явуулахад ашиглах далайн объектуудыг барих, байршуулах зөвшөөрөл олгох;
8. бамбарт шатдаг хий шатаах зөвшөөрөл олгох;
9. нүүрсустөрөгчийн үйлдвэрлэл, борлуулалт болон хэрэглээний үндэсний тэнцвэрт байдлыг хангах;
10. нүүрсустөрөгчийн хайгуул, (эсхүл) олборлолтын үйл ажиллагаа явуулахад бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журмын хэрэгжилтэд төрийн хяналтыг хэрэгжүүлэх;
11. БНКУ-ын далай, дотоодын усан сан болон аюулгүй байдлын бүсэд газрын тосны алдагдлыг устгах бэлэн байдал болон хариу арга хэмжээний үндэсний төлөвлөгөөг иргэний хамгаалалт, далайн худалдааны асуудал хариуцсан эрх бүхий байгууллагатай хамтран боловсруулж батлах.

Ураны олборлолтын асуудал **хариуцсан** эрх бүхий байгууллагын бүрэн эрх **(2017 оны хуулийн 63)**

1. Энэ хуульд заасан уран олборлолтын салбарын эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулж батлах;
2. уран олборлолтын салбарын норм-техникийн баримт бичгүүдийг боловсруулж батлах;
3. уран олборлолтын чиглэлээрх газрын хэвлийг ашиглах үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих;
4. төслийн баримт бичгийн журмын хэрэгжилтэд төрийн хяналтыг хэрэгжүүлэх;
5. уран олборлох явцад газрын хэвлийг зүй зохистой, цогцоор нь ашиглаж байгаа эсэхэд төрийн хяналтыг хэрэгжүүлэх;
6. уран олборлолтын үйл ажиллагаа явуулахад бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журмын хэрэгжилтэд төрийн хяналтыг хэрэгжүүлэх.

Улс, мужийн чанартай хот, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын бүрэн эрх **(2017 оны хуулийн 65)**

1. Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох эрх олгох;
2. газрын хэвлий ашиглагч түгээмэл тархацтай ашигт малтмал, гар аргаар ашигт малтмал олборлолтын тусгай зөвшөөрлийн нөхцөлийг хангаж байгаа эсэхэд болон эдгээрийн олборлолтын үйл ажиллагаанд төрийн хяналт тавих;
3. БНКУ-ын газрын тухай хууль тогтоомжийн дагуу газрын хэвлийг ашиглах зориулалтаар төрийн өмчийн газар өмчлөх, эзэмших эрх олгох;
4. ашигт малтмал тархац бүхий нутаг дэвсгэрийн барилга байгууламжийг зохицуулах, орон нутгийн ач холбогдол бүхий улсын тусгай хамгаалалттай газар нутгийн болон орон нутгийн ач холбогдол бүхий онцгой хамгаалалттай байгалийн газар нутагт хамаарах экологи, судалгаа шинжилгээ, түүх, соёл, амралтын онцгой үнэ цэнэтэй газрын хэвлийн нутаг дэвсгэрийн объектын геологи, геоморфологи, гидрогеологийн санг хөтлөх;
5. суурин газрын усан хангамжийг бүрдүүлэхийн тулд газар доорх усны нөөц илрүүлэх чиглэлээр улсын геологийн судалгааг зохион байгуулах, явуулах;
6. өөрсдийн олгосон түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлох, гар аргаар ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл олгох;

**Газрын хэвлий ашиглалтад тавих хяналт (2017 оны хуулийн 47.5)**

2017 оны хуульд хяналтын шууд ба шууд бус хэлбэрийг тогтоож, түүнийг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагуудыг тодорхой заасан байна.

Шууд хяналтыг дараах аргуудын аль нэгээр нь хэрэгжүүлнэ. Үүнд:

- хуулийн этгээд, эсхүл бусад байгууллагын үйл ажиллагаанд оролцох эрхийн 25-аас дээш хувийг эзэмших;
- байгууллагын удирдах дээд байгууллагад нийт саналын 25-аас дээш хувийн саналын эрхтэй;
- газрын хэвлий ашиглагчийн хуваарилах цэвэр орлогын 25-аас дээш хувийг авах;
- гэрээ, эсхүл Казахстаны хууль тогтоомжид заасны дагуу бусад байгууллагаас гаргасан шийдвэрийг тодорхойлох эрхтэй.

Шууд бус хяналт нь тухайн байгууллагыг шууд хянадаг гуравдагч байгууллагаар дамжуулан өөр хуулийн этгээд хянахыг ойлгоно.

***

**АШИГЛАСАН МАТЕРИАЛ**


- Конституция РК. Эх сурвалж: www.akorda.kz/ru/official_documents/constitution
- Кодекс Республики Казахстан от 2017.12.27 № 125-VI “О недрах и недропользовании”. Эх сурвалж: https://online.zakon.kz
- Сенат принял проект Кодекса о недрах и недропользовании. Эх сурвалж: www.zakon.kz
- “Законодательство о недрах и недропользовании: история вопроса и новая концепция». Ольга Ченцова, Наталья Брайнина. Журнал “Petroleum”, 2015, №4, с. 60-67; №5, с. 74-81. Эх сурвалж: www.zakon.kz
- Закон Республики Казахстана от 2014.12.29 № 271-V “О внесении изменений и дополнений в некоторые законодательные акты Республики Казахстан по вопросам недропользования”.
- Концепция проекта Кодекса Республики Казахстан «О недрах и недропользовании». Эх сурвалж: http://mid.gov.kz/ru/

# БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ, ОРОН НУТАГ (СУМД)-ИЙН ДЭД БҮТЭЦ БОЛОН ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ, ЛАВЛАГАА

*Ц.Норовдондог (Ph.D, Г.Билгээ,*
*Д.Жигваагүнсэл, Ц.Элбэгзаяа*

## АГУУЛГА

**Бүлэг нэг. БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ, ОРОН НУТАГ (СУМД)-ИЙН ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ, ЛАВЛАГАА**

**1.1. Бүсчилсэн хөгжил, орон нутаг (сумд)-ийн дэд бүтцийн хөгжлийн талаарх бодлогын баримт бичиг, судалгааны жагсаалт**
- Бодлогын баримт бичиг
- УИХ-ын Тамгын газрын Судалгаа, мэдээлэл, лавлагааны албанаас гүйцэтгэсэн судалгааны тайлан
- Бусад байгууллагуудын гүйцэтгэсэн судалгааны тайлан
- Илтгэл, мэдээлэл

**1.2. Монгол Улсын Засгийн газраас баримталж буй бүсчилсэн хөгжил, орон нутгийн дэд бүтцийн хөгжлийн бодлого, төлөвлөлт**
1.2.1. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал
1.2.2. Засгийн газрын мөрийн хөтөлбөр (2016-2020)

**1.3. Орон нутаг (сумд)-ийн дэд бүтцийн хөрөнгө оруулалт, төлөвлөлт, гүйцэтгэлийн статистик мэдээлэл**
1.3.1. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт (Зам, тээврийн хөгжлийн сайдын багц)
1.3.2. 2018 оноос өмнө барьж ашиглалтанд оруулсан дэд бүтэц, инженерийн байгууламжийн статистик мэдээлэл (аймаг, сумаар)
1.3.3. 2015-2017 онуудад барьж ашиглалтанд оруулсан зам барилгын объектууд
1.3.4. ЗТХЯ-аас хэрэгжүүлж буй авто зам, ложистикийн төслүүд

**Бүлэг хоёр. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ, ЛАВЛАГАА**

**2.1. Сүү үйлдвэрлэлийн салбарын статистик мэдээ**
2.1.1. Сүү үйлдвэрлэлийн салбарын танилцуулга
2.1.2. Сүүний боловсруулах үйлдвэрлэлийн салбарт хэрэгжүүлсэн томоохон арга хэмжээ
2.1.3. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн статистик мэдээ (аймгаар, 2015-2017)
2.1.4. Сүү үйлдвэрлэлийн статистик мэдээ (өрх, аж ахуйн нэгж байгууллагаар, 2015-2017)

**2.2. Хураасан төмс, хүнсний ногоо, үр тарианы статистик мэдээ**
2.2.1. Хураасан төмс, хүнсний ногооны статистик мэдээ (аймгаар, 2013-2017)
2.2.2. Хураасан үр тариа, улаан буудайн статистик мэдээ (бүс, аймгаар, 2013-2017)
2.2.3. Хураасан нийт ургацын статистик мэдээ (ургамлын төрлөөр, 2010-2017)
2.2.4. 2015-2017 оны ургац хураалт, оролцсон ААНБ, өрхийн статистик мэдээ (аймаг, өрх, аж ахуйн нэгж байгууллагаар, 2015-2017)

## Нэг. БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ, ОРОН НУТАГ (СУМД)-ИЙН ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ, ЛАВЛАГАА

### 1.1.БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ, ОРОН НУТАГ (СУМД)-ИЙН ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН ТАЛААРХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, СУДАЛГААНЫ ЖАГСААЛТ

**Бодлогын баримт бичиг**

| *Д/д* | *Бодлогын баримт бичиг* | *Баталсан субъект, огноо, шийдвэрийн дугаар* |
|---|---|---|
| 1. | Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал | УИХ-ын 2001.06.14-ний өдрийн 57-р тогтоол |
| 2. | Монгол Улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги | УИХ-ын 2003.06.12-ны өдрийн 24-р тогтоол |
| 3. | Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 | УИХ-ын 2016.02.05-ны өдрийн 19-р тогтоол |
| 4. | Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл хөгжлийн ажиллагааны хөтөлбөр | УИХ-ын 2016.09.09-ний өдрийн 45-р тогтоол |
| 5. | Монгол улсын нийгэм, эдийн засгийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл | УИХ-ын 2017.05.31-ний өдрийн 42-р тогтоол |
| 6. | Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл | Засгийн газрын 2009.06.10-ны өдрийн 178-р тогтоол |
| 7. | “Сумын төвийн шинэчлэл” төслийн хүрээнд хийх ажлын жагсаалт | Засгийн газрын 2015.06.29-ний өдрийн 265-р тогтоол |
| 8. | Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл хөгжлийн ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө | Засгийн газрын 2016.09.09-ний өдрийн 121-р тогтоол |

Эх сурвалж: www.legal.info.mn

**УИХ-ын Тамгын газрын Судалгаа, мэдээлэл, лавлагааны албанаас гүйцэтгэсэн судалгааны тайлан**

1. Монгол Улсын бүс нутгийн хөгжлийн өнөөгийн байдал, бүсийн нэмэгдэлд хамаарагдах “бичил бүс” тогтоох судалгаа, бусад орны туршлага, СТ-09/102, Судалгааны эмхэтгэл-1;
2. Монгол Улсын эдийн засгийн хөгжилд ХАА-н салбарын гүйцэтгэсэн үүрэг, СТ-10/210, Судалгааны эмхэтгэл-7;
3. Аймаг хотуудын үүсэл хөгжлийн талаар лавлагаа, мэдээлэл, СТ-10/411, Судалгааны эмхэтгэл-4;
4. Орон нутгийн хөгжлийн шалгуур үзүүлэлт, бүсчлэн хөгжүүлэх шаардлага, бусад орны туршлага харьцуулсан судалгаа, СТ-10/205, Судалгааны эмхэтгэл-3;
5. Монгол Улсын баруун бүсийн хөгжлийн хөтөлбөрт хийсэн дүн шинжилгээ, СТ-11/508;
6. “Алслагдсан бүс” нутгийн шалгуур үзүүлэлт, тэдэнд олгодог хөнгөлөлт, нэмэгдлийн талаарх судалгаа, СТ-11/220, Судалгааны эмхэтгэл-9;
7. Дэлхийн улс орнуудын бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс нутгуудад хуваах шалгуур үзүүлэлт, бусад орны туршлага, СТ-13/417, Судалгааны эмхэтгэл-16;
8. Монгол улсын бүсийн нэмэгдэл олгож ирсэн байдал, гадаадын зарим орны бүсийн нэмэгдэл олгодог туршлага, СТ-14/404, Судалгааны эмхэтгэл-16;
9. Хээлтэгч эх малын тоо, тэдгээрээс авах сүү, сүүн бүтээгдэхүүнтэй холбоотой лавлагаа мэдээлэл, СТ-14/414.

**Бусад байгууллагуудын гүйцэтгэсэн судалгааны тайлан**

1. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн нэгдсэн судалгаа. Эцсийн дэлгэрэнгүй тайлан. Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА), Алмек корпораци ЭКСи - Идеа ХХК. 2016 он 11 дүгээр сар.

Эх сурвалж: http://open_jicareport.jica.go.jp/pdf/12283339_01.pdf;

2. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн зарим асуудлууд. Дэлхийн банкны бодлогын мэдэгдэл. 2005 оны 8 дугаар сар.

   Эх сурвалж: https://forum.mn/res_mat/Mongolia_Regional_Development.pdf;

**Илтгэл, мэдээлэл**

1. “Орон нутаг бүсийн хөгжил, ХАА хөгжлийн бодлого, төлөвшин хөгжих хандлага”. Б.Энхтүвшин (ХЧМЗ Тэргүүн, ХБНГУ), Т.Болдгэрэл (Төвд агентур, ХБНГУ). 2017.

   Эх сурвалж: http://md-forum.eu/mon/wp-content/uploads/2017/04/enkhtuvshin_b.pdf;

2. “Монгол Улсын тогтвортой хөгжлийн бодлого”. А.Мөнхболд Ph.D (Үндэсний хөгжлийн газрын Судалгаа шинжилгээний албаны дарга). 2017.05.31.

   Эх сурвалж: http://nda.gov.mn/backend/f/u4Vep9HNkX.pdf.

## 1.2.МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС БАРИМТАЛЖ БУЙ БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ, ОРОН НУТГИЙН ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ

### 1.2.1.Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 4.3-т Монгол Улсын эдийн засгийн бүс бүрд хамаарах аймгуудын ерөнхий хуваарийг дараах байдлаар тогтоож, хөгжлийн тухайн үеийн нөхцөл байдалтай уялдуулан уг хуваарийг уян хатан өөрчилж байхаар заасан байна.

1. баруун бүсэд: Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд;
2. хангайн бүсэд: Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл;
3. 3.төвийн бүсэд: Говь-Сүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв;
4. зүүн бүсэд: Дорнод, Сүхбаатар, Хэнтий.
5. Улаанбаатарын бүсэд: нийслэл хот, түүний дүүргүүдийн нутаг дэвсгэр, хот орчмын бүсийн дагуул хотууд тус тус орно.

Мөн үзэл баримтлалын 4.4-д Монгол Улсын аймгууд нь байгаль орчны даац, хүн, малын байршил, эдийн засаг, нийгмийн зорилтоороо харьцангуй ойролцоо шинж төлөвтэйг харгалзан эдийн засгийн бүсүүдэд аж ахуйн дараах салбарыг нийтлэг байдлаар хөгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

1. мал аж ахуй;
2. хөнгөн, хүнсний үйлдвэр;
3. уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр;
4. барилга, барилгын материалын үйлдвэр;
5. оюуны багтаамж ихтэй үйлдвэрлэл, үйлчилгээ;
6. аялал жуулчлал, амралт, рашаан сувилал;
7. үйлдвэрлэл, нийгмийн үйлчилгээний дэд бүтцийн салбарууд;
8. зах зээлийн дэд бүтцийн бүрдэл хэсгүүд.

Бүсүүдийн байгаль, түүхий эдийн нөөц, оюуны чадавхыг харгалзан баруун бүсэд: бэлчээрийн мал аж ахуй, усалгаатай тариалан, жижиг, дунд боловсруулах үйлдвэрийг; хангайн бүсэд: бэлчээрийн мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлал, амралт, сувилал, жижиг дунд үйлдвэр, уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр; мод боловсруулах үйлдвэрийг; төвийн бүсэд: бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр, жижиг, дунд үйлдвэр, аялал жуулчлал, амралт сувиллын үйлчилгээ, оюуны багтаамж ихтэй бусад үйлдвэрлэл, үйлчилгээг; зүүн бүсэд: уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр, эрчимжсэн газар тариалан, мал аж ахуй, жижиг, дунд үйлдвэр, аялал жуулчлалыг; Улаанбаатарын бүсэд: оюуны багтаамж ихтэй бүх төрлийн үйлдвэр, үйлчилгээ, олон улсын банк санхүүгийн сүлжээг тус тус тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэхээр “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 4.4-д заасан байна.

### 1.2.2.Засгийн газрын мөрийн хөтөлбөр

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл хөгжлийн ажиллагааны хөтөлбөрт “Улсын Их Хурлын ээлжит 7 дахь удаагийн сонгуулийн үр дүнд шинээр байгуулагдсан Монгол Улсын Засгийн газар нь Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, 2016 оны Улсын Их Хурлын сонгуульд оролцсон Монгол Ардын Намын сонгуулийн мөрийн хөтөлбөр, иргэний нийгмийн байгууллагууд, иргэд сонгогчдын санал, олон улсын гэрээ хэлэлцээрүүдэд үндэслэн 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрөө” тодорхойлсон байна.

Хөтөлбөрт дэд бүтцийн салбарын хүрээнд авч хэрэгжүүлэхээр дараах арга хэмжээг тусгасан байна. Үүнд:

**Барилга, хот байгуулалтын чиглэлээр:**

Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангасан хот, суурин газрыг төлөвлөж, байгаль орчин, хүний эрүүл мэндийн шаардлагад нийцсэн барилгын

үйлдвэрлэлийг дэмжиж, аюулгүй, хүртээмжтэй орон сууцаар хангах төрийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлнэ.

2.80.Ипотекийн зээлийн нөхцөлийг хөнгөвчилж, зээлийн хөтөлбөрийг олон хувилбарт хэлбэрээр хэрэгжүүлэх бодлого баримталж, зээлийн цар хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.81.Хүн амын орон сууцны хэрэгцээг хангах зорилгоор нэгдсэн бодлого боловсруулж, “Хямд өртөгтэй орон сууц” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.82.Норм, нормативын баримт бичгийн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, олон улсын норм, нормативын баримт бичгийг хэрэглэх орчинг бүрдүүлнэ.

2.83.Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг бүс нутаг, бүлэг суурингийн тогтолцоог оновчтой тогтоох чиглэлээр үе шаттайгаар боловсруулна.

2.84.Газрын нэгдсэн бодлого, тогтолцоог бүрдүүлж, газар ашиглах, эзэмших, өмчлөх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.

2.85.Монгол Улсын нутаг дэвсгэрийг бүрэн зурагжуулах, шинэчлэх, геодезийн нэгдсэн сүлжээг бий болгох замаар орон зайн өгөгдөл, мэдээллийг нийтийн хэрэглээнд нэвтрүүлнэ.

2.86.Улаанбаатар хотыг хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

2.87.Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан “Гудамж”, “Дугуйн зам” дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

2.88.Улаанбаатар хот, аймгийн төвүүдийн ногоон байгууламжийг 3 дахин нэмэгдүүлэх бодлого баримтална.

2.89.Улаанбаатар хот болон томоохон хотуудыг дахин төлөвлөж, хөгжүүлэх бодлогын хүрээнд барилга байгууламжийг шинэчлэх, гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, агаарын бохирдлыг бууруулах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.90.Хот, суурин газруудад шинээр баригдах орон сууцны хорооллын инженерийн хангамжийн шугам сүлжээний техникийн шийдлийг хонгилын системээр төлөвлөн, үе шаттай хэрэгжүүлнэ.

2.91.Барилга байгууламжийн өөрийн өртгийг бууруулах, барилгын үйлдвэрлэлийн хугацааг уртасгах, барилгын жинг хөнгөрүүлэх, дулаан алдагдлыг бууруулах, галд тэсвэрлэлтийг сайжруулахад чиглэсэн барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

2.92.Хот, суурин газруудын газар хөдлөлтийн үйлчлэлийн давтамж, эрчмийг шинэчлэн тогтоож, барилга байгууламжийн төлөвлөлтөд тусгах, ашиглагдаж байгаа барилга байгууламжуудын бат бэх, найдвартай байдлыг сайжруулах арга хэмжээг төлөвлөж, үе шаттай хэрэгжүүлнэ.

2.93.Нийтийн аж ахуйн талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлогыг хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж хэрэгжүүлнэ.

2.94.Улаанбаатар хотод шинээр төлөвлөж байгаа орон сууцны хорооллын унд-ахуйн хэрэглээний цэвэр усыг тусад нь төлөвлөх, гарсан бохир усыг саарал усны стандартын шаардлагад нийцүүлэн дахин боловсруулж, ариутгах татуургын системд технологийн зориулалтаар болон ногоон байгууламжийн усалгаанд ашиглах зэрэг техникийн шийдлийг зураг төсөлд тусгаж, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ.

2.95.Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хот болон бусад томоохон хот, суурин газрын цэвэрлэх байгууламжийг үе шаттай шинэчлэх ажлыг эрчимжүүлнэ.

2.96.Цэвэрлэх байгууламжаар цэвэрлэсэн ус болон хөрсний усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах боломжийг бүрдүүлнэ.

2.97.Утасгүй интернетийн хүртээмжийг нэмэгдүүлж, амралт, зугаалгын бүс, номын санд ашиглах боломжийг бүрдүүлнэ.

2.98.Улаанбаатар хотын цэвэр усны хангамжийг сайжруулах ажлын хүрээнд Туул, Сэлбэ, Дунд голын урсацыг нэмэгдүүлж, эргийн дагуу олон нийтийн соёл, амралтад зориулсан тохилог орчныг бүрдүүлнэ.

2.99.Улаанбаатар хотын орон сууцны хороолол, нийтийн үйлчилгээний төвүүдийн дэргэд газар доорх болон давхар зогсоол барьж, авто зогсоолыг хоёр дахин нэмэгдүүлнэ.

2.100.Улаанбаатар хотын Сэлбэ, Баянхошуу дэд төвүүдийн инженерийн шугам сүлжээг барьж байгуулах ажлыг дуусгана.

**Эрчим хүчний салбарын чиглэлээр:**

Улс орны эдийн засгийн аюулгүй байдлын үндэс болсон эрчим хүчний тогтвортой, найдвартай ажиллагааг бүрэн хангаж, экспортын чадамжтай болох нөхцөлийг бүрдүүлнэ.

2.101.Улс орны эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийн үндэс болсон суурь салбарын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор ашиглалтад байгаа цахилгаан станцуудын хүчин чадлыг өргөтгөх, шинэчлэх ажлыг хэрэгжүүлнэ. /Чойбалсангийн ДЦС, Улаанбаатарын Гуравдугаар ДЦС/

2.102.Монгол Улсын эрчим хүчний хангамжийн найдвартай байдал, өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг бүрэн хангах шинэ эх үүсвэрийг барих, Өмнөд говийн уул уурхайн цахилгааны хэрэглээг хангах Тавантолгойн уурхайн нүүрсээр ажиллах цахилгаан станцыг барих асуудлуудыг шийдвэрлэнэ.

2.103.Шивээ-Овоо, Тэвшийн говь болон бусад нүүрсний ордыг түшиглэн экспортын зориулалттай том чадлын цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам барих төслийг эхлүүлнэ.

2.104.Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг зохистой харьцаагаар хөгжүүлж, Эгийн голын усан цахилгаан станц барих ажлыг эхлүүлнэ.

2.105.Бүс нутгийн эрчим хүчний систем, хүнд үйлдвэрүүд, том хэрэглэгчид, эрчим хүчний эх үүсвэрүүдийг холбосон цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барьж, эрчим хүчний нэгдсэн систем байгуулах ажлыг үргэлжлүүлнэ.

2.106.Аймгийн төвүүд болон томоохон хот, суурин газарт дулааны станц, шугам сүлжээг шинээр барих, өргөтгөх, эрчим хүчээр бүрэн хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

2.107.Сумын төвүүдийг төвлөрсөн цахилгаан системд бүрэн холбож дуусган сэргээгдэх эрчим хүч болон цэвэр технологид суурилсан төвлөрсөн инженерийн байгууламж буюу дулаан хангамж, цэвэр бохир усны сүлжээтэй болгох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

2.108.Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх, алдагдлыг бууруулах, инновацын түвшний шинэ техник технологи нэвтрүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.109.Дулаан, цахилгааны үнийг тогтвортой байлгана.

2.110.Метан хийг ашиглах боломжит нөөцийг бүрдүүлэх судалгааг эрчимжүүлэх, хийн хангамжийг хөгжүүлэх эрх зүй, дэд бүтцийн орчныг бүрдүүлэх, нүүрснээс хийн цэвэр түлш гарган авах үйлдвэр барих төслийг эхлүүлнэ.

**Зам тээврийн салбарын чиглэлээр:**

Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй, ая тухтай үйлчилгээ үзүүлэх зам, тээвэр, ложистикийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлнэ.

2.111.Олон улс, хот хоорондын болон орон нутгийн чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын сүлжээг өргөтгөж, бүх аймгийн төвийг нийслэл хоттой

хатуу хучилттай авто замаар холбож дуусгах, Мянганы замын хэвтээ тэнхлэгийн хэсгийг үргэлжлүүлнэ.

2.112.“Тавантолгой-Гашуун сухайт”, “Хөөт-Бичигт” чиглэлийн төмөр замыг барьж ашиглалтад оруулна.

2.113.“Тавантолгой-Гашуун сухайт” чиглэлийн төмөр замаас Оюутолгойн салбар төмөр зам, “Шивээ хүрэн-Сэхэ” чиглэлийн боомтын төмөр замыг барьж дуусгана.

2.114.“Зүүнбаян-Ханги” чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлнэ.

2.115.Улаанбаатар төмөр замын техникийн шинэчлэлт хийж нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлж, “Богд Хан” төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлнэ.

2.116.“Эрдэнэт-Овоот” чиглэлийн төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлнэ.

2.117.Үндэсний болон олон улсын тээвэр, ложистикийн сүлжээг хөгжүүлж, “Хөшиг”-ийн хөндийд холимог тээвэр ложистикийн төв байгуулна.

2.118.Төрөөс агаарын тээврийн салбарт баримтлах бодлогод тулгуурлан орон нутгийн болон олон улсын нислэгийн тоог нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг дэмжих замаар тус салбарт үнэ тарифыг бууруулна.

2.119.Жижиг нисэх онгоц, нисдэг тэрэгний зах зээлийг хөгжүүлж, гамшгаас хамгаалах, хүнс, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн түргэн тусламжийн үйлчилгээ, иргэний агаарын тээвэр, аялал жуулчлалын чиглэлээр ашиглана.

2.220.Тээврийн салбарын олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлж, бүс нутгийн дэд бүтэц, тээврийн интеграцид нэгдэн орох замаар дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлнэ.

2.221.Далайн тээвэр, хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааг өргөжүүлж, дотоодын гол, мөрөн нууруудад байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалын аюулгүй усан замын тээврийг хөгжүүлнэ.

2.222.Эрэлтэд нийцсэн, хүрээлэн байгаа орчинд ээлтэй тээврийн ухаалаг систем нэвтрүүлнэ.

2.223.Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан автозамын сүлжээг сайжруулах зорилгоор Баянзүрх, Яармаг, Сонсголонгийн гүүр болон Улаанбаатар-Налайх чиглэлийн автозамыг шинээр барина.

2.224.Улаанбаатар хотын автозамын ачааллыг бууруулах, түгжрэлийг багасгах зорилгоор гүүрэн гарцуудыг шинээр байгуулан, тусгай замын автобус /BRT/-ыг нийтийн тээврийн үйлчилгээнд шинээр нэвтрүүлнэ.

2.225.Автозамын засвар арчлалтын хугацааг уртасгах, чанарыг сайжруулах, хөрөнгийн эх үүсвэрийг үе шаттай нэмэгдүүлнэ.

| Улаанбаатар | Төмс | 2846.622 | 2388.584 | 458.038 |
| Улаанбаатар | Хүнсний ногоо | 5434.009 | 3826.693 | 1607.316 |
| **Нийт** | **Үр тариа** | **483453.4** | **28691.07** | **454762.3** |
| **Нийт** | **буудай** | **467052.79** | **26178.77** | **440874** |
| **Нийт** | **Төмс** | **165329.496** | **119054.5** | **46275** |
| **Нийт** | **Хүнсний ногоо** | **94447.2** | **76840.36** | **17606.84** |

**2017 оны ургац хураалт (тонн)**

| Аймаг/нийслэл | Төрөл | Нийт хураасан ургац | Үүнээс | |
|---|---|---|---|---|
| | | | Өрх | ААНБ |
| Баян-Өлгий | Үр тариа | 46.1 | 26 | 20.1 |
| Баян-Өлгий | Төмс | 3254.687 | 2225.156 | 1029.531 |
| Баян-Өлгий | Хүнсний ногоо | 1612.3 | 1193.792 | 418.508 |
| Говь-Алтай | Үр тариа | 324.07 | 124.87 | 199.2 |
| Говь-Алтай | буудай | 50.82 | 31.82 | 19 |
| Говь-Алтай | Төмс | 831.394 | 401.544 | 429.85 |
| Говь-Алтай | Хүнсний ногоо | 371.08 | 277.648 | 93.432 |
| Завхан | Үр тариа | 513 | 8 | 505 |
| Завхан | буудай | 513 | 8 | 505 |
| Завхан | Төмс | 2127.54 | 1823.92 | 303.62 |
| Завхан | Хүнсний ногоо | 1120.183 | 1022.195 | 97.988 |
| Увс | Үр тариа | 10090 | 4105.1 | 5984.9 |
| Увс | буудай | 9417.85 | 3789.15 | 5628.7 |
| Увс | Төмс | 3220.45 | 2588.4 | 632.05 |
| Увс | Хүнсний ногоо | 3114.941 | 2646.081 | 468.86 |
| Ховд | Үр тариа | 234.548 | 154.848 | 79.7 |
| Ховд | Төмс | 9462.16 | 9327.9 | 134.26 |
| Ховд | Хүнсний ногоо | 10805.97 | 10725.35 | 80.62 |
| Архангай | Үр тариа | 4401 | 1082 | 3319 |
| Архангай | буудай | 4308 | 1045 | 3263 |
| Архангай | Төмс | 2507.691 | 2409.943 | 97.748 |
| Архангай | Хүнсний ногоо | 753.997 | 698.346 | 55.651 |
| Баянхонгор | Үр тариа | 13.1 | 6.4 | 6.7 |
| Баянхонгор | буудай | 0 | 0 | |
| Баянхонгор | Төмс | 1547.88 | 1207.6 | 340.28 |
| Баянхонгор | Хүнсний ногоо | 794.289 | 590.899 | 203.39 |
| Булган | Үр тариа | 26124.3 | 2255.2 | 23869.1 |

**2017 оны ургац хураалтад оролцсон ААНБ, өрхийн тоо**
/аймаг тус бүрээр/

| Аймаг/нийслэл | Өрх | ААНБ |
|---|---|---|
| Баян-Өлгий | 12225 | 49 |
| Говь-Алтай | 232 | 35 |
| Завхан | 4782 | 56 |
| Увс | 6090 | 64 |
| Ховд | 6977 | 25 |
| Архангай | 12054 | 50 |
| Баянхонгор | 2003 | 59 |
| Булган | 4570 | 94 |
| Орхон | 1701 | 19 |
| Өвөрхангай | 4898 | 76 |
| Хөвсгөл | 2713 | 47 |
| Говьсүмбэр | 95 | 10 |
| Дархан-Уул | 2447 | 57 |
| Дорноговь | 144 | 21 |
| Дундговь | 2835 | 21 |
| Өмнөговь | 500 | 25 |
| Сэлэнгэ | 8804 | 322 |
| Төв | 2373 | 265 |
| Дорнод | 2784 | 60 |
| Сүхбаатар | 995 | 46 |
| Хэнтий | 5338 | 53 |
| Улаанбаатар | 2255 | 36 |
| **Нийт** | **86815** | **1490** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Булган | буудай | 25531.3 | 2136.1 | 23395.2 |
| Булган | Төмс | 3623.02 | 2954.87 | 668.15 |
| Булган | Хүнсний ногоо | 993.49 | 847.19 | 146.3 |
| Орхон | Үр тариа | 2542 | 7 | 2535 |
| Орхон | буудай | 2542 | 7 | 2535 |
| Орхон | Төмс | 2493.233 | 2251.883 | 241.35 |
| Орхон | Хүнсний ногоо | 2647.181 | 2625.931 | 21.25 |
| Өвөрхангай | Үр тариа | 2113 | 94 | 2019 |
| Өвөрхангай | буудай | 2094 | 90 | 2004 |
| Өвөрхангай | Төмс | 3917.56 | 2869.029 | 1048.531 |
| Өвөрхангай | Хүнсний ногоо | 2020.002 | 1573.063 | 446.939 |
| Хөвсгөл | Үр тариа | 7228.9 | 942 | 6286.9 |
| Хөвсгөл | буудай | 7156.9 | 922 | 6234.9 |
| Хөвсгөл | Төмс | 2793.45 | 2583.04 | 210.41 |
| Хөвсгөл | Хүнсний ногоо | 1846.912 | 1769.011 | 77.901 |
| Говьсүмбэр | Төмс | 100.59 | 71.5 | 29.09 |
| Говьсүмбэр | Хүнсний ногоо | 140.743 | 123.771 | 16.972 |
| Дархан-Уул | Үр тариа | 11201.5 | 922 | 10279.5 |
| Дархан-Уул | буудай | 10552.1 | 922 | 9630.1 |
| Дархан-Уул | Төмс | 8605.223 | 5803.723 | 2801.5 |
| Дархан-Уул | Хүнсний ногоо | 13665.791 | 11245.66 | 2420.13 |
| Дорноговь | Төмс | 100.27 | 57.56 | 42.71 |
| Дорноговь | Хүнсний ногоо | 346.459 | 245.58 | 100.879 |
| Дундговь | Үр тариа | 0 | 0 | |
| Дундговь | буудай | 0 | 0 | |
| Дундговь | Төмс | 169.079 | 164.419 | 4.66 |
| Дундговь | Хүнсний ногоо | 77.198 | 70.191 | 7.007 |
| Өмнөговь | Үр тариа | 0 | 0 | |
| Өмнөговь | Төмс | 544.262 | 477.767 | 66.495 |
| Өмнөговь | Хүнсний ногоо | 719.669 | 523.23 | 196.439 |
| Сэлэнгэ | Үр тариа | 151944.38 | 5619.1 | 146325.3 |
| Сэлэнгэ | буудай | 148273.88 | 5593.5 | 142680.4 |
| Сэлэнгэ | Төмс | 28557.938 | 17263.84 | 11294.1 |
| Сэлэнгэ | Хүнсний ногоо | 30803.038 | 21387.4 | 9415.634 |
| Төв | Үр тариа | 10535.5 | 677.6 | 9857.9 |
| Төв | буудай | 10415.5 | 663.6 | 9751.9 |
| Төв | Төмс | 41727.79 | 24370.36 | 17357.43 |
| Төв | Хүнсний ногоо | 3227.545 | 1946.12 | 1281.425 |
| Дорнод | Үр тариа | 3527 | 0 | 3527 |
| Дорнод | буудай | 3515 | 0 | 3515 |
| Дорнод | Төмс | 1323.76 | 648.56 | 675.2 |
| Дорнод | Хүнсний ногоо | 649.008 | 512.519 | 136.489 |
| Сүхбаатар | Үр тариа | 1894.5 | 0 | 1894.5 |
| Сүхбаатар | буудай | 1780 | 0 | 1780 |
| Сүхбаатар | Төмс | 572.414 | 381.796 | 190.618 |
| Сүхбаатар | Хүнсний ногоо | 255.947 | 175.479 | 80.468 |
| Хэнтий | Үр тариа | 5369 | 356 | 5013 |
| Хэнтий | буудай | 5214 | 354 | 4860 |
| Хэнтий | Төмс | 2966.4 | 1883.4 | 1083 |
| Хэнтий | Хүнсний ногоо | 2054.8 | 1088.035 | 966.765 |
| Улаанбаатар | Үр тариа | 0 | 0 | |
| Улаанбаатар | буудай | 0 | 0 | |
| Улаанбаатар | Төмс | 1361.629 | 681.679 | 679.95 |
| Улаанбаатар | Хүнсний ногоо | 4081.486 | 1920.577 | 2160.909 |
| **Нийт** | **Үр тариа** | **238101.898** | **16380.12** | **221721.8** |
| **Нийт** | **буудай** | **231364.35** | **15562.17** | **215802.2** |
| **Нийт** | **Төмс** | **121808.42** | **82447.89** | **39360.53** |
| **Нийт** | **Хүнсний ногоо** | **82102.029** | **63208.07** | **18893.96** |

# 2
# БҮЛЭГ

## НИЙГЭМ

# СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН: ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

(Харьцуулсан судалгаа)

*Д.Халиун, Д.Жигваагүнсэл*
*Р.Оргилмаа, Ц.Элбэгзаяа*

## АГУУЛГА

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

НЭГ. СУРГУУЛИЙН ХООЛЫГ ЕВРОПЫН ЗАРИМ ОРОНД ЗОХИЦУУЛСАН ТУРШЛАГА

ХОЁР. СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН ХООЛНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛЖ БУЙ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- Япон улс
- БНСУ
- БНХАУ
- ОХУ
- Словени улс

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

***Хамрах хүрээ:*** Энэхүү судалгаанд захиалагчийн хүсэлтэд дурдсан Япон, БНСУ, БНХАУ, ОХУ болон сургуулийн хоолны асуудлыг бие даасан хуулиар зохицуулсан Словени Улсын цэцэрлэг, сургуулийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээг зохицуулж буй эрх зүйн орчин, туршлагыг судалсан болно. Түүнчлэн, Европын зарим орнуудад сургууль, цэцэрлэгийн хоолыг хэрхэн зохицуулсан талаарх тоймыг бэлтгэв. Судалгааны сэдвийн хүрээнд сургуулийн хоолны бие даасан зохицуулалт бүхий орнуудын хууль тогтоомжийг хуулийн агуулга, бүтцийн хүрээнд (зохицуулж буй харилцаа, нэр томьёоны тодорхойлолт, сургуулийн хоолны удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт, хяналтын тогтолцоо, хариуцлагын механизм гэх мэт) судалж, судалгааны мэдээллийг Хүснэгт 1-д хураангуйлан үзүүлэв.

***Судалгааны үр дүнгийн тойм***: Сургуулийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээний асуудал нь үндэсний аюулгүй байдлын нэг хэсэг болох хүнсний аюулгүй байдалтай салшгүй холбоотой байдаг. Ихэнх орнуудын хувьд цэцэрлэг, сургуулийн сурагчдыг хоолоор хангах асуудал нь боловсрол, хүнсний аюулгүй байдал, нийтийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль тогтоомжууд, холбогдох бодлогын баримт бичгүүд, хоолны эрүүл ахуй, шим тэжээлийн стандартуудын хүрээнд зохицуулагдаж байна. Судалгаанд хамрагдсан орнуудаас Япон, БНСУ, Словени Улс нь сургуулийн хоолны бие даасан хуультай байна.

БНСУ-ын хувьд үйлдвэрлэгч болон нийлүүлэгчид Сургуулийн өдрийн хоол дэмжих төвөөр дамжуулан хоол, хүнсний бүтээгдэхүүнийг сургуульд нийлүүлдэг байна. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг нийлүүлэх компанийг уралдаант шалгаруулалтаар сонгон шалгаруулж хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн ханган нийлүүлэх гэрээ байгуулан ажилладаг. БНСУ-ын хувьд сүүлийн жилүүдэд сургуулийн хоолны хордлого, хордлогот халдварын тоо нэмэгдсэн (2017 онд өмнөх онтой харьцуулахад 34 хувь, 2011-2015 оны дундажтай харьцуулахад 52 хувиар тус тус нэмэгдсэн)[256]-тэй холбоотойгоор явуулсан хяналт, шалгалтаар сургууль, бэлтгэн нийлүүлэгчид шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн нийлүүлдэг, сургууль нь хүлээн авч буй хоол, хүнсэнд зохих хяналт, шалгалт явуулах чадавх муу, сургуулийн гал тогоонд тавигдах хяналт сул мөн бэлтгэн нийлүүлэгчийн сонгон шалгаруулалттай холбоотой зөрчлүүд ихээр илэрсэн байна. Боловсролын яамнаас холбогдох хууль тогтоомж зөрчигсдөд хүлээлгэх хариуцлагыг чангатгахаар мэдэгдсэн ба эцэг, эхчүүдийг сургуулийн хоолонд тавих хяналтад идэвхтэй оролцохыг уриалсан байна.

Японы хувьд сургуулийн хоолны эрүүл ахуйн асуудалд ихээхэн анхаарал хандуулан ажилладаг ба холбогдох статистик тоо, мэдээнээс үзэхэд[257] сургуулийн хоолны хордлого, хордлогот халдварын тоо сүүлийн жилүүдэд тасралтгүй буурсан үзүүлэлттэй гарсан байна. Сургуулийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээний хяналтыг 2011 оноос хойш (цацраг идэвхт бодисын аюул гм.) эрчимжүүлсэн ба бүх сургуулийн гал тогоонд хоол, хүнсний аюулгүй байдлын HACCP[258] тогтолцоог хэрэгжүүлж эхэлсэн. Бэлтгэн нийлүүлэгчдийг мужийн Сургуулийн хоолны холбоод нарийн шалгуураар сонгон шалгаруулдаг. Засгийн газрын хорооноос (Government Committee) сургуулийн хоолны эрүүл ахуйн хяналт, шалгалтыг сайжруулах асуудлаар нэлээдгүй хүчин чармайлт гарган ажилладаг ба сургуулийн ажилтнуудад эрүүл ахуйн хяналт, шалгалтыг хэрхэн үр дүнтэй явуулах талаар зааж сургаж, удирдамжаар хангадаг байна.

БНСУ болон Японд сурагчдын хооллох зөв дадал, зуршил бий болгох, мэдлэг өгөх үүднээс хоол зүй, шим тэжээлийн багш ажиллуулдаг. Эдгээр улсад сурагчдыг шим тэжээлтэй хоолоор хангаж, хооллолтын зөв дадал зуршлыг төлөвшүүлэхээс гадна хоолоор дамжуулан хүүхдийг хүмүүжүүлэх, амьдралд бэлтгэх, үндэсний уламжлалт хоолны соёлоо хадгалж, өвлүүлэхэд ихээхэн анхаардаг байна.

1964 онд Японы Боловсролын яамнаас хоол зүйчдийн цалинг хэсэгчлэн санхүүжүүлэх болсноор сургуулийн хоол зүйч бий болсон байна. Үүнээс өмнө сургуулийн

[256] http://www.koreaherald.com/view.php?ud=20160824000869
[257] The Japanese School Lunch and Its Contribution to Heath, Nutrition today, Dcember 2015
[258] Hazard Analysis and Critical Control Point

хоол зүйч гэх мэргэжил, орон тоо байгаагүй бөгөөд сургуулийн тогооч нь хоолны бэлтгэл, төлөвлөлтийг хариуцан, чөлөөт цагаараа шим тэжээлийн боловсролтой холбоотой үйл ажиллагаа явуулдаг байжээ. 1990 оноос хойш нийгэм, эдийн засагт гарсан өөрчлөлтүүдийг (түргэн хоолны үйлчилгээ нэмэгдсэн, эцэг, эхчүүдийн ажлын ачаалал ихэссэн, ажлын цаг уртассан гм.) даган сургуулийн хоол, шим тэжээлийн боловсролд анхаарал хандуулах шаардлага гарч, сургуулийн хоол зүй, шим тэжээлийн багшид тавигдах шаардлага нэмэгдсэн байна. Улмаар 2005 онд Шим, тэжээлийн багш нарыг линцензжүүлж, 2007 оноос хоол зүй, шим тэжээлийн боловсролын тогтолцоог нэвтрүүлжээ.

БНХАУ, ОХУ нь сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоол үйлдвэрлэлтэй холбоотой асуудлыг зохицуулсан бие даасан хуульгүй бөгөөд зарим бодлогын баримт бичгийн хүрээнд боловсруулагдсан хөтөлбөрүүд болон Хүнсний аюулгүй байдлын тухай хууль (БНХАУ), Боловсролын тухай хууль (ОХУ)-иар тус тус зохицуулж байна. Сургуулийн хоолны тогтолцоо нь сургууль, хот, хотын захиргаа, аймаг/субъект (ОХУ-ын засаг захиргааны нэгж)-ын хүрээнд бие даасан байдалтай явагдаж байна.

ОХУ-ын хувьд сүүлийн үед сургуулийн хоолны хордлого ихээр гарч байгаатай холбоотойгоор сургуулийн хоолны чанар, зохион байгуулалтыг сайжруулах асуудлаар субъектуудаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, зохион байгуулалтын талаарх мэдээлэл цуглуулах ажлыг Төрийн Думын орлогч даргын санаачилгаар эхлүүлсэн (2018 оны 1-р сарын байдлаар). Мэдээллийг цуглуулж дууссаны дараагаар хүнсний чанар, аюулгүй байдлыг сайжруулахтай холбоотой санал, дүгнэлтээ танилцуулахаа мэдэгдсэн байна. Сургуулийн хоолны асуудлаарх Парламентын ажлын хэсгийн хуралдаанаар сургуулийн хоолны үйлчилгээг тендерт ялсан этгээд гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй байх, сургуулийн хоолны бэлтгэн, нийлүүлэлтийг хангалтгүй биелүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийн “хар жагсаалт”-ыг хөтлөх, бэлтгэн нийлүүлэгчдэд тавих шаардлагуудыг чангатгах зэрэг саналуудыг хэлэлцсэн байна.

Словени Улсын хувьд сургуулийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээг 2010 онд баталсан Сургуулийн хоолны тухай хуулиар зохицуулж байна. Сургуулийн хоолонд тохирохгүй, эсхүл бага давтамж болон бага хэмжээтэй олгох хүнс болон тэдгээрийг орлуулах эрүүл хүнсний жагсаалтыг баталсан. Сургуулиуд нь эрүүл хооллолтыг дэмжихэд чиглэсэн сургалтыг агуулга, хөтөлбөрийг боловсруулдаг. Словенийн сургуулиуд нь Үндэсний удирдамжийн хүрээнд шим тэжээлийн хувьд тэнцвэртэй хоол хүнсээр хангах асуудлын хүрээнд жимс, ногооны долоо хоног, хоолны сургалт, хоол, хүнсний амталгаа, сургуулийн цэцэрлэг байгуулах, фермийн үйл ажиллагаатай танилцах болон орон нутгийн/дотоодын үйлдвэрийн хүнсний бүтээгдэхүүн худалдан авахыг дэмжих зэрэг нэмэлт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.

*Хүснэгт 1.Сургуулийн хоолны бие даасан хууль тогтоомж бүхий орнуудын эрх зүйн орчны харьцуулалт*

| | Асуудал | БНСУ | Япон | Словени |
|---|---|---|---|---|
| 1 | Хууль тогтоомжийн нэр | **Сургуулийн хоолны тухай хууль**, 2006<br>Сургуулийн хоолны тухай хуулийг хэрэгжүүлэх журам | **Сургуулийн үдийн хоолны тухай хууль,** 1954<br>**Хоол, шим тэжээлийн боловсролын суурь хууль (Шокуики),** 2005 | **Сургуулийн хоолны тухай хууль,** 2013 |
| 2 | Хуулийн зорилго | Сургуулийн хоолны үйлчилгээний чанарыг дээшлүүлж, сурагчдын оюун санаа, бие бялдрын хөгжилд хувь нэмэр оруулах, сургуулийн хоолны үйлчилгээгээр дамжуулан үндэсний хоолны дэглэмийг сайжруулах. | Сургуулийн үдийн хоол нь хүүхдүүд, ялангуяа сургуулийн насны хүүхдийн оюун санаа, эрүүл бие бялдрыг хөгжүүлэх, хүүхдийн ойлгох чадварыг сайжруулахад зохих хувь нэмрийг оруулж байгаа нөхцөл байдлыг харгалзан үзсэний дүнд тус хуулийн зорилго нь сургуулийн үдийн хоолны шим тэжээлийг нэмэгдүүлэх, сургуулийн үдийн хоолонд тавигдах үндсэн шаардлага, зөвлөмжөөр хангах | Энэхүү хуулийн зорилго нь сурагчдын сургуулийн хоолыг зохион байгуулах, сурагчдын хөнгөлөлттэй хоолоор хангах эрх, сургуулийн хоолонд олгох хөнгөлөлт, татаасын хэмжээ, нөхцөлийг тодорхойлох, хуулийн хэрэгжилтийг хянахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино. |
| 3 | Нэр томьёо | “***Сургуулийн хоолны үйлчилгээ***" гэж хуулийн зорилгод хүрэхийн тулд сургуулийн захирал, сурагч, сурагчдад 4-р зүйлд заасан хоолны үйлчилгээ;<br>"***Сургуулийн хоолны үйлчилгээ эрхлэгч***" гэж 15-р зүйлийн дагуу сургуулийн захиралтай гэрээ байгуулсны дагуу сургуулийн хоолны үйлчилгээ үзүүлэгч этгээдийг;<br>"***Хоолны үйлчилгээний зардал***" гэж хоол хүнсний зардал, хоол хүнсний үйлчилгээний үйл ажиллагааны зардал, үйлчилгээний байгууламж, тоног төхөөрөмжийн бусад зардал зэргийг багтаана. | “***Сургуулийн үдийн хоол***” гэдгийг хуульд дурдсан зорилтыг хангах үүднээс бүх ерөнхий боловсролын сургууль дахь сурагч, оюутнуудад хүргэж байгаа хоолны үйлчилгээ;<br>"***Заавал эзэмших суурь боловсрол олгох бүх сургуулиуд***" гэж Сургуулийн боловсролын тухай хуульд заасан бага, дунд сургууль, эсхүл тусгай хэрэгцээт боловсрол олгох бага, дунд сургуулиудыг хэлнэ. | “***Сургуулийн хоол***” гэж сургуулийн хичээлийн хуваарийн дагуу явагдах хичээлийн өдөр сургуулиас өгч буй хоолыг хэлнэ. Сургуулийн хоолонд өглөөний цай, үдээс өмнөх зууш, үдийн хоол, үдээс хойших зууш багтана.<br>“***Бага, дунд сургуулийн үдийн цайны үнэ***” - сургуулиас сурагчдад санал болгож буй үдийн цайны үнийг хэлнэ. Хоолны үнийг хичээлийн жилийн эхэн бүрт Боловсролын асуудал хариуцсан сайд тогтооно. Сургуулийн хоолны бусад үйлчилгээний үнийг сургууль тогтооно. |
| 4 | Удирдлага, зохион байгуулалт | 15-р зүйлд заасны дагуу Сургуулийн захирал нь сургуулийн хоолны үйлчилгээг шууд удирдан зохион байгуулах ба Сургуулийн үйл ажиллагааны хороотой хэлэлцсэний үндсэн дээр сургуулийн хоолны үйлчилгээг эрх бүхий байгууллагаас урьдчилан зөвшөөрөл авсны үндсэн дээр өөр хүнд хариуцуулж болно. Зайлшгүй | 4 дүгээр зүйлд заасны дагуу суурь боловсрол олгох сургуулийн үүсгэн байгуулагч бүр сурагчдыг өөрийн сургууль дээр үдийн хоолоор хангах хүчин чармайлт гаргах ёстой гэж заасан байна.<br>5 дугаар зүйлд төрийн төв болон нутгийн захиргааны байгууллага нь сургуулийн үдийн хоолны хөтөлбөрийг хөгжүүлэх, түгээн | Сургуулийн захирал нь сургуулийн хоол, шим тэжээлийн асуудлаар санал, зөвлөмж гаргах Хоол, шим тэжээлийн бүлэг (Nutrition group)-г томилж болно.<br>5-р зүйлд заасны дагуу Сургуулиуд нь хоол, хүнс худалдаж авах, боловсруулах, шаардлагатай мэдээллийг бүртгэх, хоол, шим тэжээлтэй холбоотой боловсролын үйл |

| | Асуудал | БНСУ | Япон | Словени |
|---|---|---|---|---|
| | | шаардлагаас бусад тохиолдолд хоол, хүнсний бүтээгдэхүүн сонгох, худалдан авах, хянан шалгах үүргийг шилжүүлэхгүй.<br>***Сургуулийн хоолны үйлчилгээний хороо* -** Орон нутгийн Боловсролын албаны дарга нь сургуулийн хоолны үйлчилгээний төлөвлөгөө, хоолны зардлын татаас болон холбогдох бусад асуудлаар тус хороог байгуулна.<br>**Сургуулийн хоолны үйлчилгээг дэмжих зөвлөлдөх хороо -** Орон нутгийн захиргаа нь сургуулийн хоолны үйлчилгээг дэмжих асуудлуудыг хэлэлцэх зорилгоор байгуулж болно.<br>**Сургуулийн өдрийн хоол дэмжих төв -** Орон нутгийн захиргаа нь сургуулийн хоол хүнсний үйлчилгээг дэмжих хүрээнд сайн чанарын хоол хүнсний бүтээгдэхүүнээр хангах үүрэг бүхий төвийг байгуулж, ажиллуулж болно. | дэлгэрүүлэх талаар хүчин чармайлт үүрэгтэй болохыг заасан байна.<br>6 дугаар зүйлд суурь боловсролын байгууллагын үүсгэн байгуулагч бүр 2 буюу түүнээс дээш сургуулийг үдийн хоолоор хангах гал тогоотой байж болно.<br>14-р зүйлд энэ хуульд тусгаагүй хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой журмыг Засгийн газрын тогтоолоор тогтооно гэж заасан байна. | ажиллагаа явуулах болон бусад ажлыг зохион байгуулна. Сургууль нь сургуулийн хоолны худалдан авалт, боловсруулалт болон түгээлт зэрэг үйлчилгээг бусад боловсролын байгууллагад шилжүүлж болох ба тус байгууллага нь энэхүү хуульд заасан журам, нөхцөлийн дагуу үйл ажиллагаа явуулна. Онцгой тохиолдолд сургууль нь сургуулийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээг бусад байгууллагаар гүйцэтгүүлж болно. Ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа сургуулийн зөвлөлөөс урьдчилан зөвшөөрөл авсан байна. |
| 5 | Хоол зүйч, хоолны шим тэжээлийн багш байх эсэх | 7 дугаар зүйлд заасны дагуу сургуулийн хоолоор хангах тоног төхөөрөмжөөр тоноглогдсон сургуулиуд нь *<u>хоол зүй, шим тэжээлийн багш,</u>* мэргэжлийн тогоочийг ажиллуулна. | 7 дугаар зүйлд заасны дагуу сургуулиудын үдийн *<u>хоолны шим тэжээл, гал тогоотой холбоотой мэргэжлийн асуудал хариуцсан ажилтан</u>* нь Хоол зүй шим тэжээлийн багшийн лицензтэй, эсхүл Хоол зүйчийн тухай хуульд заасан Хоол зүйчийн лицензтэй байхаас гадна сургуулийн үдийн хоолны талаар шаардлагатай мэдлэг туршлагыг хуримтлуулсан байх ёстой. | Тусгаагүй |
| 6 | Хоол, шим тэжээлийн боловсрол | 13 дугаар зүйлд заасны дагуу Сургуулийн захирал нь сурагчдад зөв хооллолт, хоолны зөв дадал зуршил бий болгоход чиглүүлж, хоол, хүнсний үйлдвэрлэл, хэрэглээний талаарх мэдлэгийг дээшлүүлж, уламжлалт хоол хүнсний соёлыг залгамжлуулж, эцэг, эхчүүдийг холбогдох мэдээллээр хангана.<br>14 дүгээр зүйлд заасны дагуу Сургуулийн захирал нь хооллолт, хоолны дадал | 10 дугаар зүйлд Хоол, шим тэжээлийн багш нь сурагчдад сургуулийн үдийн хоолоор дамжуулж хооллолтын заавар, зөвлөмж өгөх болон хоол хүнсний хэрэгцээт чанар, дэглэмийн талаарх ойлголтыг өгөх, энэ ойлголтыг хүүхдэд төлөвшүүлэх талаар сургуулийн захиргаанаас дэмжиж ажиллах ёстой. Хүүхдүүдэд эрүүл хооллолтын талаар мэдлэг мэдээлэл өгч, түүний ач тусын талаар | Шим тэжээлийн боловсрол олгох тусгай хөтөлбөр байхгүй бөгөөд 4.7-д заасны дагуу сургууль нь жилийн төлөвлөгөөндөө сурагчдын эрүүл хооллолт, хоол, шим тэжээлийн боловсролтой холбоотой үйл ажиллагааг тусгана. |

| | Асуудал | БНСУ | Япон | Словени |
|---|---|---|---|---|
| | | зуршлаас үүссэн шим тэжээлийн өөрчлөлтийг бууруулах мөн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үүднээс бага жинтэй, өсөлтийн хоцрогдол, цус багадалт, илүүдэл жин, таргалалт зэрэг хоол тэжээлийн зөвлөгөө шаардлагатай сурагчдад заавар, зөвлөгөөгөөр хангаж ажиллана. | эерэг ойлголттой болгохын тулд хоол, шим тэжээлийн багш өдрийн хоол тэдний эрүүл мэндэд хэрхэн сайнаар нөлөөлж буй талаар заавар зөвлөмж өгөхийн зэрэгцээ тухайн бүс нутгийн онцлог, өвөрмөц байдал, тухайн газар нутгийн хоолны соёл уламжлал, хоол үйлдвэрлэлийг танилцуулж, бүс нутгийн онцлог бүтээгдэхүүний шим тэжээл, ашиг тусын талаар тухай бүр ойлголт өгөх ёстой байна. | |
| 7 | Хоолны үйлдвэрлэл, үйлчилгээнд дагаж мөрдөх стандарт, шаардлага | - Сургуулийн үдийн хоолны стандарт (HACCP);<br>- 2018 оны 9-р сарын 14-нөөс эхлэн сургуулийн орчинд кофе худалдахыг хориглосон.[259]<br>Хуулийн 10, 11, 12-р зүйлүүдэд Хүнсний бүтээгдэхүүн, Хоол тэжээлийн менежмент, Ариун цэвэр, эрүүл ахуйн менежменттэй холбоотой асуудлыг тусгасан. Хоол, хүнсний аюулгүй байдал, шим тэжээл, эрүүл ахуйн шаардлагуудыг Боловсролын яамнаас баталсан журмаар тогтооно.<br>15-р зүйлд сургуулийн хоол, хүнс бэлтгэн нийлүүлэгчдэд тавигдах шаардлага болон Сургуулийн захирлын сургуулийн хоолны үйлчилгээтэй холбоотой эрхийг шилжүүлэхтэй холбоотой асуудлыг Ерөнхийлөгчийн захирамжаар тогтоохоор заасан. | - HACCP;<br>Хуулийн 8, 9-р зүйлд Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд нь сургуулийн хоолны шим тэжээл, сургуулийн хоолны хөтөлбөр болон түгээлт зэргийг хэрэгжүүлэхтэй холбоотой стандартуудыг нарийвчлан тогтооно. Мөн яамнаас сургуулийн үдийн хоолыг бэлтгэх, гал тогоо, түүнд тавигдах тоног төхөөрөмж, ариун цэвэр, эрүүл ахуйн холбогдох стандартыг баталж, мөрдүүлнэ. Сайд нь үдийн хоол бэлтгэн, үйлчлэх байр, тоног төхөөрөмжийн бэлтгэл ажил, зохион байгуулалт, хоол хийх явцын эрүүл ахуй болон үдийн хоол түүний бусад эрүүл ахуйн менежменттэй холбоотой шаардлагатай асуудлуудыг биелүүлэн хангах стандартуудыг бий болгох үүрэгтэй. | - Сургуульд хоол, ундаа борлуулах автомат машин байрлуулахыг хориглосон.<br>4-зүйлд заасны дагуу Словенийн Шинжээчдийн зөвлөлөөс баталсан Ерөнхий боловсролын байгууллага дахь хооллолтын удирдамжийг баримтлах ба дараахыг тусгана. Үүнд: сургуулийн хоол, шим тэжээлтэй холбоотой зорилго, баримтлах зарчим, боловсролын үйл ажиллагаа, хоол, хүнсний бүтээгдэхүүнийг сонгох, хоол төлөвлөх, хоолны хэмжээ болон бэлтгэх арга, хугацаа зэргийг тогтоосон Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газраас баталсан мэргэжлийн удирдамж, аргачлалууд. |
| 8 | Санхүүжилт, хөнгөлөлт | Сургуулийн хоолны зардлыг эцэг, эх, үйлчилгээний зардлыг сургууль хариуцна.<br>8, 9 дүгээр зүйлд сургуулийн хоолны зардал, татаас, дэмжлэгтэй холбоотой асуудлыг тусгасан ба шаардлагатай тоног | 11 дүгээр зүйлд сургуулийн гал тогоо тоног төхөөрөмжтэй холбогдох зардлыг сургууль, бусад зардлыг хүүхдийн эцэг, эх хариуцахаар тогтоож өгсөн байна.<br>12 дугаар зүйлд хувийн сургуулиуд Засгийн | 7 дугаар зүйлд заасны дагуу Сургуулийн сурагч буюу түүний эцэг, эх сургуулийн хоолны зардлыг хариуцна. Сургуулийн хоолны үнийг орон нутаг/хот, донор болон бусад эх үүсвэрээс хандив, санхүүжилт |

[259] On March 13, 2018, an amendment to the Special Act on Safety Management of Children's Dietary Lifestyle was promulgated by the President of South Korea. (The amended Act will come into effect on September 14, 2018. (Act No. 15485 add.).

| | Асуудал | БНСУ | Япон | Словени |
|---|---|---|---|---|
| | | төхөөрөмжийн зардлыг сургуулийн үүсгэн байгуулагч, эрхлэгч хариуцах боловч төр, орон нутгийн захиргаанаас татаас олгож болно. Хоолны үйлчилгээний зардлыг тухайн сургуулийн үүсгэн байгуулагч, эрхлэгч хариуцах боловч Ерөнхийлөгчийн захирамжид заасан зарим зардлыг эцэг, эх, асран хамгаалагч хариуцна. | газраас тогтоосон журмыг биелүүлж буй тохиолдолд сургуулийн өдрийн хоол бэлтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн болон байрны зардлыг санхүүжүүлэхэд тодорхой хэмжээний татаас олгож болно гэж заасан байна.<br>13 дугаар зүйлд олгосон татаасыг буцаан авах нөхцөлүүдийг тусгасан байна. | олгосон тохиолдолд бууруулж болно.<br>13 дугаар зүйлд заасны дагуу сургуулийн үдийн цайны татаас нь сургуулийн үдийн цайны үнийн 2/3-тай тэнцэх ба нэмэлтээр үдийн цайны 1/3-д татаас олгоно.<br>15-р зүйлд заасны дагуу сургуулийн хоолыг үнээр нь худалдан авах боломжгүй сурагчдад улсын төсвөөс татаас олгоно.<br>14, 18, 25, 26-р зүйлээр сургуулийн үдийн цай, хоолны дэмжлэгээд хамрагдах нөхцөл, шалгуур, дэмлэг, татаас олгохтой холбоотой асуудлыг зохицуулсан. |
| 9 | Хяналтын тогтолцоо | 18, 19 дугаар зүйлд Сургуулийн хоолны үйлчилгээний үнэлгээ, сургуулийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээ авагдаж буй газар хяналт шалгалт хийх үйл ажиллагаатай холбоотой асуудлууд тусгагдсан. Боловсролын сайд, эсхүл Боловсрол албаны дарга нь сургуулийн хоолны үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор сургуулийн хоолны үйл ажиллагааны үнэлгээ хийж болно. Хоолны эрүүл ахуй, эсхүл хоолны үйлчилгээ хариуцсан төрийн албан хаагчид Боловсролын сайд, эсхүл Боловсрол албаны даргын зөвшөөрснөөр сургуулийн хоолны үйлчилгээнд хамаарах барилга байгууламжид нэвтэрч, хоол, хүнс, барилга байгууламж, бичиг баримт, үйл ажиллагааны нөхцөл байдалд үзлэг, шалгалт хийх, эсхүл хоол, хүнсний дээж авахыг шаардаж болно.<br>Боловсролын сайд, Боловсролын албаны дарга нь илрүүлсэн зөрчлийг зогсоох, арилгуулах шаардлагыг сургуулийн захирал сургуулийн хоолны нийлүүлэгчид хүргүүлж болно. | Тусгаагүй | 19-22 дугаар зүйлд дотоод болон хөндлөнгийн хяналттай холбоотой асуудлыг тусгасан. Үүнд:<br>- Сургуулийн хичээлийн жилийн хугацаанд сурагч, эцэг, эхчүүдээс сургуулийн хоолны чанар, хоол, шим тэжээлийн боловсролын асуудлаар сэтгэл ханамжийн судалгаа авах;<br>- Сургуулийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээ нь мэргэжлийн удирдамжуудад нийцэж байгаа эсэхэд мэргэжлийн хяналт тавих;<br>- Захирал нь ажил гүйцэтгэгчийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавьж, илрүүлсэн зөрчлийг арилгуулах шаардлагыг ажил гүйцэтгэгчид бичгээр гаргана. Гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэгч шаардлагыг биелүүлээгүй бол сургууль нь гэрээгээ цуцална;<br>- Боловсрол, спортын хяналтын газар сургуулийн сургуулийн хоолны үйлдвэр, үйлчилгээтэй холбоотой холбоотой асуудлаар хяналт тавьж, бусад эрх бүхий хяналтын байгууллага нь төсвийн хяналт болон хувийн мэдээллийн ашиглалтад хяналт тавина. |
| 9 | Хариуцлагын механизм | 21-25 дүгээр зүйлээр захиргааны арга хэмжээ, сахилгын арга хэмжээ, шийтгэл | - Тусгаагүй | 23 дугаар зүйлд хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тусгасан. |

| | Асуудал | БНСУ | Япон | Словени |
|---|---|---|---|---|
| | | ногдуулах, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх, торгууль зэрэг асуудлыг зохицуулсан.<br>16, 19-р зүйлд заасан хоол, хүнсний чанар, аюулгүй байдлыг хангах, үзлэг шалгалт явуулахтай холбоотой зөрчил гаргасан этгээдэд 3-7 жилийн хорих ял, 30-100 сая воноос дээшгүй хэмжээний торгууль оногдуулахаар заасан байна. 24-р зүйлд хуулийн этгээдэд хариуцлага ногдуулах нөхцөлийг тусгасан байна. 25-р зүйлд заасан зөрчлийг арилгуулах шийдвэрийг үндэслэл, шалтгаангүйгээр биелүүлээгүй сургуулийн хоолны үйлчилгээ үзүүлэгчийг 3-5 сая воноос дээшгүй хэмжээний торгууль оногдуулахаар заасан. | | Сургуулийн байцаагч нь 1000-2000 хүртэлх еврогийн хэмжээтэй торгуулийг дараах хөнгөн гэмт хэрэг /misdemeanour/ үйлдсэн сургуульд, 500-1000 хүртэлх еврогийн хэмжээтэй торгуулийг этгэдээд тус тус ногдуулна. Үүнд:<br>- Сургуулийн хоолны үйлчилгээ үзүүлдэггүй, сургуулийн жилийн төлөвлөгөөндөө хоолны зөв дадал зуршил, шим тэжээлийн боловсролтой холбоотой үйл ажиллагаа тусгаагүй;<br>- Хоолны зардлыг холбогдох журмын дагуу тогтоогоогүй;<br>- Хүнс, ундааны автомат машин суурилуулсан;<br>- Ажил гүйцэтгэгчтэй холбогдох зөвшөөрөл авалгүй гэрээ байгуулсан;<br>- Сургуулийн хоолны шим, тэжээлийн баримтжуулалт үйлдээгүй;<br>- Сургууль нь төрөөс хоолны татаас, тэтгэмж авахад хуурамч мэдээлэл бүрдүүлсэн;<br>Сургуулийн байцаагч нь 100-200 хүртэлх еврогийн хэмжээтэй торгуулийг хөнгөн гэмт хэрэг үйлдсэн сургуулийн ажилтанд ногдуулна. |

## НЭГ. СУРГУУЛИЙН ХООЛЫГ ЕВРОПЫН ЗАРИМ ОРОНД ЗОХИЦУУЛСАН ТУРШЛАГА

**Болгар:** Сургууль (2009), цэцэрлэг (2011), ясли (2013) дахь Эрүүл хооллолтын тухай Эрүүл мэндийн сайдын тушаал, хууль эрх зүйн баримт бичиг тус бүрт зориулсан тусгай удирдамж бүхий номыг Эрүүл мэндийн яамнаас боловсруулсан. Эрүүл мэндийн яам болон 28 Бүсийн эрүүл мэндийн хяналтын газар /БЭМХГ/ (Regional Health Inspectorates) нь үндэсний хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг. Олон нийтийн эрүүл мэнд, шинжилгээний үндэсний төв (National Center of Public Health and Analyses) нь БЭМХГ-ын ажилтнуудад зориулсан сургалтын арга зүй, сургалтын материалыг боловсруулж, сургалт явуулдаг. 28 БЭМХГ-с цэцэрлэг, сургуулийн ажилтнууд (захирал, эрүүл мэндийн ажилтан, гал тогооны ажилтан г.м.)-ад сургалт зохион явуулж, хүүхэд, сурагчдад эрүүл хооллолтын чиглэлээр төрөл бүрийн мэдээлэл, сурталчилгааны ажил, арга хэмжээ зохион байгуулдаг.

**Франц:** Сургуулийн хоолны асуудлыг Бага болон дунд сургуулийн тухай хууль, Цэцэрлэгийн тухай хуульд заасан Байгууллагын хоолны үйлчилгээний хvнсний стандартаар зохицуулсан. Сургуулийн хоолны чанар, шим тэжээлийн журмыг 2011 онд баталсан. Сургуулийн хоолны бэлтгэл, түгээлтийн асуудал нь муж бүрээр ялгаатай байх ба ихэнх тохиолдолд хоолыг сургууль дээр бэлтгэнэ. Цөөн тохиолдолд сургуулийн хоолыг гадуур буюу бэлтгэн нийлүүлэгч компани хариуцна.

**Финланд:** Сургуулийн хоолны асуудлыг Боловсролын тухай хууль тогтоомж, үндэсний болон орон нутгийн сургалтын хөтөлбөрүүдэд тусгасан байна. Сургалтын хөтөлбөрт эрүүл мэнд, шим тэжээл, хоолны соёлын боловсролын талаар тусгасан. 1948 оны Суурь боловсролын тухай хуульд заасны дагуу сургуулийн өмнөх болон бага, дунд сургуулийн сурагчдад сургуулийн хоолыг үнэгүй олгоно.

**Герман:** Одоогийн байдлаар улсын хэмжээнд заавал дагаж мөрдөх хүнсний стандарт байхгүй. Холбооны хоёр муж улсын нэгд нь сургуулийн хоолны газарт (Хоол тэжээлийн нийгэмлэгээс боловсруулсан) олон нийтийн хоолны чанарын стандартыг мөрддөг бол нөгөө муж улсад цэцэрлэгт олон нийтийн хоолны чанарын стандартыг мөрдөж байна. Дээрх стандартуудыг бусад муж улсад мөрдөх зөвлөмжийг гаргасан байна.

**Грек:** Зөвхөн зарим хувийн сургуулиуд сурагчдыг өдрийн хоолоор хангадаг. Эдгээр сургуулиудын хувьд 1999 онд Эрүүл мэндийн яамнаас баталсан Грекийн хоол тэжээлийн удирдамжийг үндэслэсэн Газар дундын тэнгисийн хоолны дэглэмийг баримталдаг.

**Ирланд:** Зөвхөн сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад хоолны хөтөлбөр хэрэгждэг. 1991 онд батлагдсан Хүүхдийн асрамжийн тухай хууль болон 2016 оны тогтоолуудад "Бүртгэгдсэн үйлчилгээ үзүүлэгч нь сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхэд тус бүрт тохиромжтой, тэжээллэг хоол хүнс, ундаагаар хангана" гэж заасан байна.

**Испани:** Хоол, хүнсний сайн дураар мөрдөх стандартууд байдаг. Тухайлбал, Боловсролын төвүүд дэх хоолны зөвшилцлийн баримт бичиг (Consensus document on food in educational centres). Энэхүү баримт бичиг нь өдөрт авбал зохих илчлэгийн хэмжээ зэргийг сургуулийн хоолны шим тэжээлийн зөвлөмжид оруулах, сургуулийн орчинд хоолны газар, автомат машин болон түргэн үйлчилгээний цэгүүдэд зөв, эрүүл хоолны сонголт бий болгох шалгуур тогтоох зэрэгт чиглэсэн байна. Сургуулийн хоолны газрын тухай заалтууд 1990 оны Боловсролын тогтолцооны ерөнхий зохион байгуулалтын тухай хууль, 2006 оны Боловсролын тухай хуулиудад тусгагдсан. Сургуулийн удирдлага нь хоолны үйлчилгээгээр хангах асуудлыг хариуцна. Сургуулиуд нь хоолны үйлчилгээг өөрсдөө, эсхүл бэлтгэн нийлүүлэгчээр дамжуулан хэрэгжүүлдэг.

**Их Британи:** Сургуулийн удирдлага/ удирдах байгууллага нь сургуулийн хоолны үйлчилгээг Сургуулийн хоолны стандартад нийцүүлэн, хяналтыг ханган ажиллана. 2015 онд Сургуулийн хоолны төлөвлөгөөний хүрээнд батлагдсан дээрх стандартаар сургуулийн хоолны төрөл, хоол, хүнсний давтамж зэргийг тогтоосон.

**Латви:** 2012 оны Засгийн газрын 172 дугаар тогтоолоор "Боловсролын байгууллагын суралцагч, нийгмийн халамж болон нийгмийн нөхөн сэргээлтийн байгууллагуудын үйлчлүүлэгчид, эмчилгээний байгууллагуудын өвчтөнүүдийн шим

тэжээлийн стандартыг 2012 онд баталсан.

**Люксембург:** Сургуулиас гадуурх асрамжийн байгууллагуудаар (бүх хүүхдэд үйлчлэх) дамжуулан хоолоор хангадаг. Улсын хэмжээнд хоолны газруудын хоолны чанарыг сайжруулах, тогооч, сурган хүмүүжүүлэгч, багш нарын зөв хооллолт, шим тэжээлийн талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарал хандуулж байгаа. 2006 онд Боловсрол, Эрүүл мэнд, Гэр бүл ба Спортын сайд нарын хамтарсан тушаалаар Зөв хооллолт, дасгал хөдөлгөөнийг дэмжих үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан.

**Мальта:** "Эрүүл хооллолтын амьдралын хэв маягийн төлөвлөгөө" (сайн дурын)-г 2007 онд баталж, 2014 онд шинэчлэн найруулсан бөгөөд өдрийн хоолонд зөвшөөрсөн, хориглосон хүнсний жагсаалтыг багтаасан.

**Польш:** Эрүүл мэндийн сайдын 2015 оны 8-р сарын 26-ны тушаалаар Боловсролын орчинд хүүхэд, залуучуудыг хангаж буй хоол, хүнсний бүтээгдэхүүнд тавих шаардлагыг баталсан. Одоогийн байдлаар бага сургуулийн 60%, дунд сургуулийн гуравны нэг нь үдийн хоол олгодог.

**Румын:** 2008 оны Эрүүл мэндийн яамны тушаал дугаар 1563, хавсралт 3, 4, 5-д өөр өөр насны бүлгүүдэд тохирох илчлэгийн хэрэгцээ, хүнсний пирамид, хүнсний төрөл зэргийг тусгасан.

**Словак:** 2009 онд Боловсролын яамнаас баталсан Тунхагт сургуулийн хоолонд тавигдах шаардлагуудыг тусгасан. Сургуулийн хоолны газруудыг орон нутгийн удирдлагууд байгуулна. Сургуулийн тухай хуульд заасны дагуу сургуулийн хоолны газрууд нь хоол хүнс, ундаа бэлтгэх, үйлчилгээ үзүүлэх барилга, байгууламж байна. Сургуулийн хоолны газрууд нь үйлдвэрлэгч, түгээгч гэх хоёр хэлбэртэй байна. Үйлдвэрлэгч хоолны газарт сургуулийн хоолыг бэлтгэж, үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлдэг бол түгээгч хоолны газруудад хагас боловсруулсан болон бэлэн бүтээгдэхүүнээр үйлчилдэг.

**Словени:** 2010 онд Словенийн сургуулийн хоолны тухай хууль батлагдаж, 2013 онд нэмэлт, өөрчлөлт орсон. Тус хууль болон Цэцэрлэгийн эрүүл хооллолтын хоол тэжээлийн үндэсний удирдамжийн хүрээнд сургуулийн сурагч бүрт өдөрт нэг удаа шим тэжээлийн хувьд тэнцвэртэй үдийн цайгаар хангах Үндэсний сургуулийн хоолны хөтөлбөрийн стандартуудыг баталсан. Сургуулийн хоол (үдийн цай/зууш, эсхүл өдрийн хоол) нь тохиромжтой болон тохиромжгүй хоолны бүлгийн жагсаалт болон илчлэг, шим тэжээлд тавигдах шаардлагад нийцсэн байна. Сургуулийн хоолонд тохирохгүй, эсхүл бага давтамж болон бага хэмжээтэй олгох хүнсний жагсаалтыг баталж, орлуулах эрүүл хүнсний жагсаалтыг сургуулийн гал тогоонд олгодог. Тус хуулиар сургуулиуд өөрсдийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд оруулах эрүүл хооллолтыг дэмжихэд чиглэсэн боловсрол, сургалтыг үйл ажиллагааны хэмжээ, агуулгыг тогтоож өгөхөөр зохицуулсан. Шим тэжээлийн хувьд тэнцвэртэй хоол хүнсээр хангах асуудлын хүрээнд Үндэсний сургуулийн хоолны хөтөлбөр нь жимс, ногооны долоо хоног зэрэг нэмэлт санаачилгуудыг хэрэгжүүлдэг. Тус хөтөлбөр нь суурь боловсрол олгох байгууллагын сурагчдын 90.5 хувийг хамарч байгаа бөгөөд сурагчдыг шинэ ногоо, жимсээр хангадаг, үүнээс хатаасан, эсхүл нөөшилсөн бүтээгдэхүүн 10 хүрэхгүй хувийг эзэлдэг байна. Үүнээс гадна шим тэжээлийн боловсрол, хоол хийж сурах хичээл, амталгаа, сургуулийн цэцэрлэг (жимс/ногооны талбай), тариалангийн талбайд очиж, танилцах болон орон нутгийн/дотоодын үйлдвэрийн хүнсний бүтээгдэхүүн худалдан авахыг дэмжих зэрэг нэмэлт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг байна. Сургуулийн хоолны бэлтгэл, үйлдвэрлэл нь сургууль дээр, эсхүл гадуур явагдаж болдог. Сургуулийн болон орон нутгийн захиргаа нь сургуулийн хоолны үйлдвэрлэл сургууль дээр явагдаж байгаа тохиолдолд гал тогоогоор хангах, эсхүл гаднаас хоол авах тохиолдолд хоол, хүнсийг тогтмол нийлүүлэх гэрээт нийлүүлэгчээр хангах үүргийг хүлээнэ. Эрүүл, зөв хооллолтыг дэмжих бодлогын хүрээнд сургуулиудад хоол, ундаа борлуулдаг хүнсний автомат машинуудыг тавихыг хориглосон.

**Унгар:** Олон нийтийн хоолны тухай хууль нь 2014 онд батлагдаж, 2015 оны 9-р сард хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Тус хуульд олон нийтийн хоолны газруудад үйлчлэх хоол, хүнсний стандартуудыг тусгасан. Мөн хуулиар хоол тэжээлийн тоо, насны ангилалд тохирох хоолны порц, 10 өдрийн туршид тодорхой хоол хүнсээр хангах давтамж, насны ангилалд тохирох хоол, шим тэжээл, авбал зохих илчлэг зэргийг зохицуулсан байна.

Түүнчлэн тодорхой хүнс, бүтээгдэхүүнийг хэрэглэх журам, тэдгээрт тавигдах хязгаарлалт, хоригуудаас гадна тусгай хоолны дэглэмүүдэд зориулан үйлчилгээ үзүүлэх, мэдээллээр хангах (цэс, шошгонд тавигдах шаардлага) зэргийг тусгасан. Багш, эцэг, эх, сурагчдад зориулсан мэдээлэл, сурталчилгааны ажлууд болон нийтийн хоолны үйлдвэрлэгч нарт сургалт явуулдаг.

**Эстони:** Сургуулийн хоолны бодлого нь Боловсролын яамнаас 2008 онд боловсруулсан “Сургуулийн өмнөх боловсролын болон сургуулийн барилга байгууламжид тавигдах эрүүл ахуйн шаардлага”-аар зохицуулагддаг. Тус баримт бичгээр хоолны газар, өрөө тасалгаанд тавигдах шаардлагуудыг тогтоосон ба баримт бичгийг 2018 онд шинэчлэхээр төлөвлөсөн. Бага болон дунд сургуулийн сурагчдад сургуулийн хоолыг үнэгүй олгодог.

*Европын орнуудын хувьд*[260]:

- 53 хувь - сургуулийн орчинд хүнс, ундааны автомат машин байрлуулахыг хориглосон, эсхүл эрүүл хоол хүнсний сонголт бүхий хязгаарлалтуудыг тогтоосон;
- 76 хувь - хоол, хүнсний зар сурталчилгааг хориглосон;
- 68 хувь - хоол, шим тэжээлийн боловсрол нь заавал судлах хичээлийн хөтөлбөрт орсон;
- 65 хувь - хоол бэлтгэх, нийлүүлэх асуудал хариуцсан ажилтнуудад тусгай сургалт зохион байгуулдаг байна. Зарим улсад хоолны үйлдвэрлэлтэй холбоотой бүхий л ажилтан, бэлтгэн нийлүүлэгчдэд мэргэжлийн шаардлага, стандарт үйлчилдэг бол Итали, Латви, Швед зэрэг улсад дээрх шаардлагыг албажуулаагүй боловч зохих мэдлэг, чадвартай ажилтан байх ёстой гэж заасан байна. Сургуулийн хоолны бэлтгэн нийлүүлэлт хариуцсан ажилтанд мэргэжлийн сургалтад хамрагдсан байх шаардлага тавьдаггүй улсын тоонд Кипр, Чех, Ирланд, Литва, Нидерланд, Норвег, Португал болон Их Британи (Англи) орж байна.

Европын зарим орнуудад сургуулийн орчинд хүнсний автомат машиныг зохицуулсан байдал болон хоол, шим тэжээлийн боловсролыг хэрхэн зохицуулсныг доорх зургуудаас үзнэ үү.

*Зураг 1. Сургуулийн орчинд хүнсний автомат машиныг зохицуулсан байдал*



хүнсний автомат машин байхгүй/ сургуульд байрлуулахыг хориглосон
тодорхой хоол/ундааны зүйлийг хүнсний автомат машинаар худалдаалахыг хориглосон
хүнсний автомат машинаар эрүүл хооллолтын стандартад нийцсэн хүнс/ундаа борлуулдаг
илүү эрүүл хүнс/ундаа борлуулах зөвлөмж гаргасан
хүнсний автомат машинтай холбоотой хязгаарлалт байхгүй

*Зураг 2. Хоол, шим тэжээлийн боловсрол олгодог байдал*



хоол, шим тэжээлийн боловсрол – сургуулийн хичээлийн хөтөлбөрт багтсан
хоол, шим тэжээлийн боловсрол – сайн дурын

---

[260] ЕХ-ны 28 гишүүн орон болон Норвег, Швейцар

## ХОЁР. СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН ХООЛНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛЖ БУЙ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

### ЯПОН

Японы одоогийн хэрэгжүүлж буй сургуулийн үдийн хоол хөтөлбөр нь 1954 онд батлагдсан "Сургуулийн үдийн хоолны тухай хууль"-ийн дагуу хэрэгжүүлж байна. Сургуулийн үдийн хоол хөтөлбөрийн үндсэн зорилго нь сургуулийн хүүхдүүдийн оюун ухаан болоод бие бялдрын эрүүл саруул хөгжлийг дэмжихийг чухалчилсан. Хожим нь "Сургуулийн үдийн хоолны тухай хууль"-ийг 2008 онд шинэчилсэн бөгөөд түүний гол зорилго нь "Шокуики"[261] (Food education) хуулийг дэмжих явдал байсан. Японы сургуулийн үдийн хоол маш эртний түүхтэй бөгөөд 1889 онд хүүхдийн анхны үдийн хоолонд будааны бөмбөлөг, давсалсан яргай загас, даршилсан ногоо өгч байсан байна. Сургуулийн үдийн хоолыг хэрэгжүүлсэн байдлыг авч үзвэл:

- 1889 он – Анх өдрийн хоол өгч эхэлсэн;
- 1946 он – НҮБ-ын хүүхдийн сан болон бусад байгууллагын сүүний хөтөлбөр хэрэгжсэн;
- 1947 он – 2,9 сая хүүхдэд үдийн хоол /хот/;
- 1949 он – Сургуулийн хоол /улс даяар/;
- 1954 он – Сургуулийн үдийн хоолны тухай хууль батлагдсан;
- 2005 он – Хоол хүнс болон хоол тэжээлийн багшийн системийг эхлүүлж мөн хоол хүнсний боловсролын суурь хууль батлагдсан байна.

Зарим шүүмжлэгчид хооллох асуудал бол хувь хүний хэрэг тиймээс Засгийн газраас үүнийг хуулиар зохицуулах шаардлагагүй гэж үздэг боловч даяаршлын эрин үед уламжлалт хоолны соёлоо алдах, гадны хоол хүнснээс хэт хамааралтай болох, хүнсний аюулгүй байдалд учирч болох осол эндэгдэл, залуу эмэгтэйчүүдийн туранхай байх хүсэл, таргалалт, амьдралын хэв маягтай холбоотой өвчлөлийн өсөлт, тогтмол бус тэнцвэргүй хооллолт зэрэг хоол тэжээлтэй холбоотой маш олон санаа зовоосон асуудлууд хуулийн гадна байсан. Тиймээс эдгээр асуудлуудыг шийдвэрлэхийн тулд хуулиар зохицуулах шаардлагатай гэж үзэн “Шокүикү”-гийн хуулийг 2005 онд баталсан.

Тус хуулиар хоол, хүнсний тухай мэдлэгийг олж авах, эрүүл хооллолт, хоол, хүнсний зөв зохистой сонголт хийх чадвартай болгох хүрээнд “Хоол, хүнсний боловсролыг дэмжих ерөнхий төлөвлөгөө” гарган хэрэгжүүлж эхэлсэн байна. Үүнээс гадна сургуулийн хүүхдүүдэд хоол тэжээлийн боловсролыг олгохын тулд Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яам 2007 оны 4-р сард хоол зүй, шим тэжээлийн багшийн тогтолцоог бий болгосон.

Энэ ажлыг эхлүүлснээр хоол зүй, шим тэжээлийн багш нартай сургуулиудад багш, асран хамгаалагч болон хүүхдүүдийн дунд хоол тэжээлийн талаарх мэдлэг болоод сонирхлын хувьд маш олон эерэг үр дүн ажиглагдсан байна.

*Хоол, шим тэжээлийн багш нарын үүрэг*:

Өдөр тутмын сургуулийн үдийн хоолны менежментийн нэг хэсэг болгон хоол тэжээлийн удирдамжаар хангах.

1) Хоолны удирдамжаар ангийн багш нарыг хангаж, хамтран ажиллах;
2) Таргалалт, тохиромжгүй хоолны дэглэм, хоол хүнсний харшлаас урьдчилан сэргийлэх, арилгах талаарх удирдамжаар хангах;
3) Бусад багш, сурагч, гэр бүл, орон нутгийн иргэдтэй хамтран хоол тэжээлийн удирдамжийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах;
4) Хоол тэжээл, эрүүл ахуй, нийлүүлэлтийг ханган ажиллах.

Сургуулийн Үдийн хоолны тухай хуулийг 2008 онд шинэчлэн боловсруулсны дараа хэд хэдэн шинэ зорилтыг нэмж, сургуулийн үдийн хоолыг хүүхдийн боловсролд чухал ач холбогдолтой болгосон. Японы сургуулийн үдийн хоол хөтөлбөрийн зорилго нь:

[261] Shokuiku, (Basic Law of Food and Nutrition Education), http://www.maff.go.jp/e/pdf/shokuiku.pdf

1) Зөв зохистой хоол хүнсийг хэрэглэх замаар хүүхдийн эрүүл мэндийг сайжруулахад чиглэсэн хүчин чармайлт гаргах;
2) Өдөр тутмын хоол хүнсний талаарх зөв ойлголтыг төлөвшүүлэх, энэ ойлголтыг сайжруулах, эрүүл хоолны дэглэмийг бий болгох талаарх боломжийг хөгжүүлэх;
3) Зохистой сургуулийн амьдралаар амьдрах, нийгмийн эерэг орчинг бий болгох;
4) Хоол хүнс байгалиас хүн төрөлхтөнд зориулагдаж байдаг тул байгаль орчныг хамгаалах, өөрийн амьдралын үнэ цэнийг хүндлэх талаарх олон нийтийн ойлголт ухамсрыг сайжруулах;
5) Хоол хүнс ямар олон хүмүүсийн хүч хөдөлмөрөөр бий болдог, тэрхүү хөдөлмөрийн үнэ цэнийг ойлгож хүндлэх талаарх ухамсар, ойлгоцыг төлөвшүүлэх, тэрхүү ойлголтыг нэмэгдүүлэх;
6) Япон болон бусад орны хоолны соёлын талаарх ойлголтыг таниулж, дээшлүүлэх;
7) Хоол хүнсний үйлдвэрлэл, түгээлт, хэрэглээ зарцуулалтын талаарх мэдлэгийг дээшлүүлэх.

Сургуулийн хүүхдийн үдийн хоол хөтөлбөр нь өөрөө боловсролын үйл ажиллагааны нэг хэсэг юм. Сургуулийн хүүхдүүд өдрийн хоол идэх аяга таваг цэвэрлэх, ширээ засах, хоол аягалах зэрэг ажлыг өөрсдөө хариуцаж хийхээс гадна хүүхдүүд ангийнхантай хамт хооллож, цаашлаад зөв хооллолтын дэглэмийг сурч, зохистой хоолны дэглэм, хоолны соёлыг танин мэдэх зэрэгт суралцдаг байна.

Уг хуулийг хэрэгжүүлснээр өглөөний цайгаа алгасах хүүхдүүдийн тоо буурч, амьдралын хэв маяг сайжирч, сургуулийн хүүхдийн үдийн хоол хөтөлбөр нь хойч үедээ эрүүл саруул ухаан, бие махбодийг өвлүүлэн үлдээх чухал ач холбогдолтой хууль болсон хэмээн дүгнэсэн байна.

## СУРГУУЛИЙН ҮДИЙН ХООЛНЫ ТУХАЙ ХУУЛЬ

## /SCHOOL LUNCH ACT[262]/

## (1954 оны 6-р сарын 3-ны 160 дугаар хууль)[263]

Японы “Сургуулийн үдийн хоолны тухай хууль” нь анх 1954 онд батлагдаж, сүүлийн байдлаар 2015 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд 14 зүйл бүхий хуулиар зохицуулж байна. Тус хуулийн 1 дүгээр зүйлд хуулийн зорилгыг дараах байдлаар тодорхойлжээ.

1 дүгээр зүйл. Сургуулийн үдийн хоол нь хүүхдүүд, ялангуяа сургуулийн насны хүүхдийн оюун санаа, эрүүл бие бялдрыг хөгжүүлэх, ялангуяа хүүхдийн ойлгоцыг сайжруулахад зохих хувь нэмрийг оруулж байгаа нөхцөл байдлыг харгалзан үзсэний дүнд тус хуулийн зорилго нь сургуулийн үдийн хоолны шим тэжээлийг нэмэгдүүлэх, сургуулийн үдийн хоолонд тавигдах үндсэн шаардлага, зөвлөмжөөр хангах нь тус хуулийн зорилго юм.

2 дугаар зүйлд хуулийн зорилтыг дараах байдлаар тодорхойлсон байна. Ерөнхий боловсролын сургуулийн зорилгыг хангах үүднээс сургуулийн үдийн хоолны талаар дараах зорилтод хүрнэ.

1) Зөв зохистой хоол хүнсийг хэрэглэх замаар хүүхдийн эрүүл мэндийг сайжруулахад чиглэсэн хүчин чармайлт гаргах;
2) Өдөр тутмын хоол хүнсний талаарх зөв ойлголтыг төлөвшүүлэх, энэ ойлголтыг сайжруулах, эрүүл хоолны дэглэмийг бий болгох талаарх боломжийг хөгжүүлэх;
3) Зохистой сургуулийн амьдралаар амьдрах, нийгмийн эерэг орчинг бий болгох;
4) Хоол хүнс байгалиас хүн төрөлхтөнд зориулагдаж байдаг тул байгаль орчныг хамгаалах, өөрийн амьдралын үнэ цэнийг хүндлэх талаарх олон нийтийн ойлголт ухамсрыг сайжруулах;
5) Хоол хүнс ямар олон хүмүүсийн хүч хөдөлмөрөөр бий болдог, тэрхүү хөдөлмөрийн үнэ цэнийг ойлгож хүндлэх талаарх ухамсар, ойлгоцыг төлөвшүүлэх, тэрхүү ойлголтыг нэмэгдүүлэх;

[262] school lunch act, http://school-lunch-support.jp/en/act/
[263] Хамгийн сүүлд 2015 оны 6-р сарын 24-нд нэмэлт өөрчлөлт орсон. № 46

6) Японы болон бусад орны хоолны соёлын талаарх ойлголтыг таниулж, дээшлүүлэх;
7) Хоол хүнсний үйлдвэрлэл, түгээлт, хэрэглээ зарцуулалтын талаарх мэдлэгийг дээшлүүлэх.

3 дугаар зүйлд “сургуулийн үдийн хоол” гэдгийг дээр дурдсан зорилтыг хангах үүднээс бүх албан журмын боловсролын сургууль дахь сурагч, оюутнуудад хүргэж байгаа хоолны үйлчилгээ гэж тодорхойлсон байна.

4 дүгээр зүйлд суурь боловсролын сургуулийн үүсгэн байгуулагч бүр сурагчдыг өөрийн сургууль дээр үдийн хоолоор хангах хүчин чармайлт гаргах ёстой гэж заасан байна.

5 дугаар зүйлд төрийн төв болон нутгийн захиргааны байгууллага нь сургуулийн үдийн хоолны хөтөлбөрийг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх талаар хүчин чармайлт гаргах үүрэгтэй болохыг заасан байна.

6 дугаар зүйлд 2 буюу түүнээс дээш сургуульд үдийн хоолоор хангах бол сургуулийн гал тогоог нээн ажиллуулж болно гэж заажээ.

7 дугаар зүйлд хоолны шим тэжээл, дэглэмийн талаарх зохих мэргэжил бүхий ажилтан сургуульд ажиллах талаар заасан. Сургуулиудын үдийн хоолны шим тэжээл, гал тогоотой холбоотой мэргэжлийн асуудал хариуцсан ажилтан (“сургуулийн өдрийн хоолны мэргэжилтэн” гэх) нь Боловсролын байгууллагын ажилтныг гэрчилгээжүүлэх тухай хууль (Education Personnel Certification act)-ийн 4 дүгээр зүйлийн 2-т заасны дагуу Хоол зүй, шим тэжээлийн багшийн лицензтэй, эсхүл Хоол зүйчийн тухай (Dietitians act) хуулийн 2 дугаар зүйлийн нэгд заасан Хоол зүйчийн лицензтэй байхаас гадна сургуулийн үдийн хоолны талаар шаардлагатай мэдлэг туршлагыг хуримтлуулсан байх ёстой.

8 дугаар зүйлд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд нь сургуулийн хоолны шим тэжээл, хэмжээ зэрэг холбогдох стандарт журмыг баталж мөрдүүлэхээр заасан байна.

9 дүгээр зүйлд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд нь сургуулийн үдийн хоолыг бэлтгэх, гал тогоо, түүнд тавигдах тоног төхөөрөмж зэрэг ариун цэвэр, эрүүл ахуйн холбогдох стандартыг баталж, мөрдүүлэх үүрэгтэйг заасан байна. Үүнд: Сайд нь үдийн хоол бэлтгэн, хангах байр, тоног төхөөрөмжийн бэлтгэл ажил, зохион байгуулалт, хоол хийх явцын эрүүл ахуй болон үдийн хоол түүний бусад эрүүл ахуйн менежменттэй холбоотой шаардлагатай асуудлуудыг биелүүлэн хангах стандартуудыг бий болгох үүрэгтэй.

10 дугаар зүйлд Хоол, шим тэжээлийн багш нь сурагчдад сургуулийн үдийн хоолоор дамжуулж хооллолтын заавар, зөвлөмж өгөх болон хоол хүнсний хэрэгцээт чанар, дэглэмийн талаарх ойлголтыг өгөх, энэ ойлголтыг хүүхдэд төлөвшүүлэх талаар сургуулийн захиргаанаас дэмжиж ажиллах ёстой.

Хүүхдүүдэд эрүүл хооллолтын талаар мэдлэг мэдээлэл өгч, түүний ач тусын талаар эерэг ойлголттой болгохын тулд хоол, шим тэжээлийн багш өдрийн хоол тэдний эрүүл мэндэд хэрхэн сайнаар нөлөөлж буй талаар заавар зөвлөмж өгөхийн зэрэгцээ тухайн бүс нутгийн онцлог, өвөрмөц байдал, тухайн газар нутгийн хоолны соёл уламжлал, хоол үйлдвэрлэлийг танилцуулж, бүс нутгийн онцлог бүтээгдэхүүний шим тэжээл, ашиг тусын талаар тухай бүр ойлголт өгөх ёстой байдаг байна.

11 дүгээр зүйлд сургуулийн гал тогоо тоног төхөөрөмжтэй холбогдох зардлыг сургууль, бусад зардлыг хүүхдийн эцэг, эх хариуцахаар тогтоож өгсөн байна.

12 дугаар зүйлд хувийн сургуулиуд Засгийн газраас тогтоосон журмыг биелүүлж буй тохиолдолд сургуулийн өдрийн хоол бэлтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн болон байрны зардлын тодорхой хэмжээний татаас олгож болохыг заасан байна.

13 дугаар зүйл. Дээрх заалтад дурдсаны дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд дараах тохиолдолд улсаас олгосон татаасыг буцаан төлөхийг шаардаж болдог байна.

- Татаасыг зориулалтын дагуу ашиглаагүй;

- Татаасыг олгосноос хойш жилийн хугацаанд хүндэтгэх шалтгаангүйгээр дурдсан тоног төхөөрөмж болон материалаа аваагүй тохиолдолд;
- Заасан байгууламж, тоног төхөөрөмжийг өөр зорилгоор ашиглах;
- Татаас олгох нөхцөлийг зөрчсөн тохиолдолд;
- Хууран мэхлэх замаар татаас авсан буюу авахыг оролдсон үед.

14 дүгээр зүйлд Энэхүү хуульд зааснаас гадна хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай журам, бусад арга хэмжээг засгийн газраас тогтоохоор заажээ.

## СУРГУУЛИЙН ҮДИЙН ХООЛНЫ ХЭРЭГЖҮҮЛЭХ СТАНДАРТ[264]

1 дүгээр зүйл. Сургуулийн үдийн хоол нь сургуулийн үдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлж буй сургуульд суралцаж буй хүүхэд, сурагчдад хамаарна.

(Сургуулийн үдийн хоолны тоо)

2 дугаар зүйл. Сургуулийн үдийн хоолыг хичээлийн жилийн турш долоо хоногт 5 удаа буюу үдийн цайны цагаар хэрэгжүүлнэ.

(Сургуулийн хүүхэд бүрийн эрүүл мэндийн байдлыг харгалзан үзэх)

3 дугаар зүйл. Сургуулийн үдийн хоолны тухайд сургуулийн хүүхдийн амьдралын идэвх, бүс нутгийн нөхцөл байдал, эрүүл мэндийн байдлыг нэг бүрчлэн харгалзан үзнэ.

(Сургуулийн үдийн хоол хөтөлбөр дэх хоол тэжээлийн зураглал)

4 дүгээр зүйл. Сургуулийн үдийн хоолон дахь хоол тэжээлийн стандарт нь доорх хүснэгтэд харуулснаар нэг хүүхэд, сургуулийн хүүхдэд оногдох өдрийн хэрэглээний стандартад тулгуурлана.

*Хүснэгт 2. Сургуулийн үдийн хоолны нэг хүүхдийн өдрийн хэрэглээний стандарт*

| Шим тэжээлийн орц | Стандарт хэмжээ | | | |
|---|---|---|---|---|
| | 6-7 нас | 8-9 нас | 10-11 нас | 12-14 нас |
| Илчлэг (ккал) | 530 | 640 | 750 | 820 |
| Ураг | 20<br>16-26 | 24<br>18-32 | 28<br>22-38 | 30<br>25-40 |
| Өөх тос | Сургуулийн үдийн хоолны энергийн хэрэглээ 25-30% | | | |
| Натри | 2-с доош | 2,5- с доош | 2,5-с доош | 3-с доош |
| Кальци | 300 | 350 | 400 | 450 |
| Төмөр | 2 | 3 | 4 | 4 |
| Витамин А | 150 | 170 | 200 | 300 |
| Витамин В1 | 0,3 | 0,4 | 0,5 | 0,5 |
| Витамин В2 | 0,4 | 0,4 | 0,5 | 0,6 |
| Витамин С | 20 | 20 | 25 | 35 |
| Ислэг | 4 | 5 | 6 | 6,5 |

Дээрх хүснэгтээс гадна дор дурдсан зүйлсийг анхаарч хэрэгжүүлдэг байна. Үүнд:

- Магни - Сурагч (6-7 настай) 70мг;
  Сурагч (8-9 настай) 80мг;
  Сурагч (10-11 настай) 110мг;
  Сурагч (12-14 настай) 140мг;
- Цайр - Сурагч (6-7 настай) 2мг;
  Сурагч (8-9 настай) 2мг;
  Сурагч (10-11 настай) 3мг;
  Сурагч (12-14 нас) 3мг.

[264] http://school-lunch-support.jp/en/implementation-standards/

Энэ стандарт нь улсын дундаж үзүүлэлтийг харуулж байгаа ба сургууль тус бүр хүүхэд, сургуулийн хүүхдүүдийн эрүүл мэнд, амьдралын хэв маяг, бүс нутгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж уян хатан үйл ажиллагаа явуулах ёстой.

**<u>БНСУ</u>**

Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)-д сургуулийн үдийн хоол хөтөлбөрийг Сургуулийн хоолны тухай хууль[265], Сургуулийн хоолны тухай хуулийг хэрэгжүүлэх журам[266], Бага болон дунд боловсролын тухай хууль, Хүнсний эрүүл ахуйн тухай хууль зэрэг хуулиудаар зохицуулдаг байна. Сургуулийн хоолны тухай хуулийг 1981 онд баталсан бөгөөд үүнээс хойш хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт оруулж, 2006 онд тус хуулийг бүрэн өөрчилсөн байна.

Анх 1953 онд Солонгосын дайны дараа НҮБ-ын Хүүхдийн сан (UNICEF), CARE, USAID зэрэг олон улсын тусламжийн байгууллагууд болон Канад Улсын Засгийн газрын тусламжтайгаар сургуулийн үдийн хоолыг өгч эхэлсэн байна.

Сургуулийн өдрийн хоолны аюулгүй байдлыг хангах, цаашдын хөгжлийг дэмжихийн тулд хууль батлах шаардлагатай болсон байна. Тусламжийн өдрийн хоолноос хүүхдийн физиологийн хэрэгцээг хангахуйц шим тэжээллэг өдрийн хоол руу шилжиж сурагчийн эрүүл мэндийг сайжруулах болон ард иргэдийн хоолны дадал, зуршлыг өөрчлөхөд хувь нэмэр оруулах үүднээс Засгийн газрын санаачилгаар 1981 онд Сургуулийн хоолны тухай хуулийг баталсан байна. Тус хуулийн зорилго нь сургуулийн хоолны үйлчилгээний чанарыг дээшлүүлснээр сурагчдын оюун ухааны болон биеийн хөгжлийг сайжруулж, үндэсний хэмжээнд хооллох зөв дадлыг дэмжиж, ард иргэдийн эрүүл мэндийг сайжруулах зэрэг болно.

Тус хуулийн гол агуулга нь:

- Улс болон орон нутгийн удирдах шатны байгууллага нь сургуулийн өдрийн хоолны үйлчилгээг жигд, тогтмол хэрэгжүүлэхийн төлөө санаачилгатай ажиллах;
- Сургуулийн өдрийн хоолны хөтөлбөрт бүх бага сургуулиуд, Боловсрол, Соёлын яамны сайдын шаардлагатай гэж үзсэн (дунд болон ахлах) сургуулийг хамруулах;
- Сургуулийн өдрийн хоолны гал тогоо, тоног төхөөрөмж болон хэрэглэлээр хангах;
- Сургуулийн өдрийн хоол хэрэгжүүлэгч сургуульд хоол зүйч томилон ажиллуулах;
- Сургуулийн өдрийн хоолны барилга, байгууламж, тоног төхөөрөмж, үйл ажиллагааны зардал, хөдөлмөрийн хөлсийг сургуулийг үүсгэн байгуулагч, эрхлэгч хариуцах, хүнсний түүхий эдийн зардлыг асран хамгаалагч хариуцах зэрэг болно.

Бага, дунд, ахлах болон тусгай сургуулийн үдийн хоолны үйлчилгээ 1991 онд 13.3%-тай байсан бол 2003 оны байдлаар бараг 100%-д хүрсэн байна. 2010 оны байдлаар улсын хэмжээнд 11,396 сургууль буюу нийт сургуулийн 99.9% нь хүүхдүүдэд үдийн хоолоор үйлчилж (Зураг 3.), 7,263,000 сурагч буюу 98.8% өдөр бүр сургууль дээрээ үдийн хоолоор үйлчлүүлсэн байна. Бараг ихэнх дунд сургуулиуд үдийн хоолоор үйлчилж байгаа боловч цөөн хэдэн дотуур байртай сургууль сурагчиддаа өглөөний цай өгдөг байна.

- 1953~1972 онуудад ядуу өрхийн бага сургуулийн сурагчдыг үнэгүй өдрийн хоолоор хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэв (нийт сурагчдын гуравны нэг).
- 1981 онд Сургуулийн хоолны тухай хууль батлагдсанаас хойш алслагдсан орон нутгийн бага сургуульд үнэгүй өдрийн хоолны үйлчилгээг хэрэгжүүлж, газар тариалан, загасчлалын бүсийн хүнсний зардлын 1/3 хангав.
- 1988 оноос ядуу өрхийн бага сургуулийн сурагчидыг үнэгүй өдрийн хоолоор хангаж эхэлсэн.
- 1997 оноос ядуу өрхийн дунд, ахлах сургуулийн сурагчдыг үнэгүй өдрийн хоолоор хангаж эхэлсэн.
- 2011 оноос орон нутагт бүрэн үнэгүй өдрийн хоолоор хангадаг болсон.

---

[265] https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=29851&lang=ENG
[266] https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=31660&lang=ENG

*Зураг 3. БНСУ-ын Сургуулийн үдийн хоол үйлчилгээ /1991-2010/*[267]




***Тайлбар:*** *Үдийн хоолоор үйлчилж буй сургуулийн хувь*
*Үдийн хоолоор үйлчилж буй сургуулийн тоо*

Сурагчдыг үдийн хоолоор хангах асуудлыг янз бүрээр шийдвэрлэж ирсэн байна. Орон нутгийн байгууллага ба эцэг, эхийн оролцоонд тулгуурлан алслагдсан орон нутгийн бүх сурагчид болон нэн ядуу өрхийн хүүхдүүдэд үнэгүй өдрийн хоолоор үйлчлэх, хотын сургуулиудад гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэх цех байгуулах, орон нутгийн сургуулиудад фермийн аж ахуй эрхлэлтээр (гахай, тахиа үржүүлэг, хүнсний ногоо тариалалт гэх мэт) дамжуулан бие даасан өдрийн хоолны үйлдвэрлэл үйлчилгээг бий болгох зэргээр шийдвэрлэж ирсэн байна.

Сургуулийн өдрийн хоолны тогтолцоог бэхжүүлэх талаар олон төрлийн ажлууд хийгдсээр ирсэн бөгөөд мэргэшсэн хоол зүйчийг томилж ажиллуулах, сургуулийн өдрийн хоолны үр дүнтэй холбоотой судалгаа (өдрийн хоол өгдөг болон өгдөггүй сургуулийн сурагчдын биеийн өндөр, жингийн харьцуулалт, сурлагын дүн, өвчлөлийн хувь, хичээл таслалтын хувь, сургуулийн өдрийн хоолны сэтгэл ханамж гэх мэт), сургуулийн өдрийн хоолны стандартын цэстэй холбоотой судалгаа, сургуулийн өдрийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний барилга байгууламж болон тоног төхөөрөмжийн судалгаа зэрэг судалгаа шинжилгээнүүдийг хийж 1977 онд сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг зохион байгуулах зарчим, төрөл, хэрэгжүүлэлтийн стандарт зэргийг нарийвчлан журамласан байна.

1996 онд Сургуулийн хоолны тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр хоол хүнс үйлдвэрлэгч компаниуд гэрээгээр сургуулийн үдийн хоолны үйлчилгээ үзүүлэх эрхтэй болсон бөгөөд дунд болон ахлах ангийн сурагчид өдөр сургууль дээрээ хооллох боломжтой болсон байна. Сургуулиуд хоол, хүнс үйлдвэрлэгч компаниудтай үдийн хоолны гэрээ байгуулах нь эрс нэмэгдсэн ба 2004 оны байдлаар нийт сургуулиудын 17% хамрагдсан байна. 2006 онд олон тооны сурагчдыг хамарсан хоолны хордлого гарснаас улбаалан “Сургуулийн хоолны тухай” хуулийг шинэчлэх шаардлага гарсан байна. Хуулийг шинэчлэн найруулсны үр дүнд олон сургуулиуд хоол хүнс үйлдвэрлэгч компаниудтай байгуулсан гэрээгээ цуцалж, сургууль дотроо өдрийн хоол үйлдвэрлэх болсон байна. 2010 оны байдлаар нийт сургуулиудын 5% хоол хүнс үйлдвэрлэгч компаниудтай үдийн хоолны гэрээтэй ажилласан байна. Мөн хоол, шим тэжээлийн багшийн орон тоог бий болгохоор хуульд заасны дагуу 2007 оноос сурагчдын эрүүл мэнд ба хооллох зөв дадал, зуршил бий болгох, мэдлэг өгөх үүднээс системтэй шим тэжээлийн сургалтыг хэрэгжүүлэхийн тулд хүнсний эрүүл ахуйч гэгдэж байсан сургуулийн хоол зүйчийг хоол, шим тэжээлийн багшийн үүрэгтэйгээр албажуулсан байна.

Сургуулийн хоолны тухай хуулийн 5 дугаар зүйлд Сургуулийн өдрийн хоолыг дэмжих төвийн талаар хуульчилсан бөгөөд БНСУ-ын муж, хот, аймаг, дүүргийн засаг дарга нар нь сургуулийн өдрийн хоолонд аюулгүй, чанартай хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэхэд хүнсний

[267] https://apec.org/-/.../APEC/.../Research-School-Feeding-in-APEC-Economies/2012_scs

үйлдвэрлэл, нийлүүлэлт, төсвийг ил тод удирдах тогтолцоо юм гэжээ. Хоол, хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч болон нийлүүлэгчид Сургуулийн өдрийн хоол дэмжих төвөөр дамжуулан сургуульд нийлүүлдэг байна. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг нийлүүлэх компанийг Хүнсний эрүүл ахуйн тухай хуулийн дагуу сонгон шалгаруулдаг байна. Хуульд зааснаар, хүнсний стандартад тохирсон орчин, хөргөгч, хөлдөөгчтэй хадгалах байгууламж, хөргөгч, хөлдөөгч хөргүүр бүхий автомашин, ажилчдын эрүүл ахуй зэрэг үнэлгээ хийгдсэн байх шаардлагатай бөгөөд уралдаант шалгаруулалтаар (тендер) сонгон шалгаруулж, хамгийн бага үнийн санал болгосон компанитай Сургуулийн хоолны үйлчилгээний хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанарын стандартын дагуу аюулгүй, чанартай, хүнсний түүхий эд ханган нийлүүлэх гэрээг байгуулдаг байна. Хүнсний бүтээгдэхүүний чанарын стандартыг Сургуулийн хоолны тухай хуулийг хэрэгжүүлэх журмаар тогтоосон байна.

*Хүснэгт 3. Сургуулийн өдрийн хоолны хүнсний бүтээгдэхүүний чанарын стандарт*[268]

| | |
|---|---|
| Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн | Органик хүнс, бордоогүй хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний стандартын журмаар “сайн” зэрэглэлээс дээш, тэргүүний **зохицуулалттай нотлогдсон** хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, гарал үүслийн байдал тодорхой хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, цагаан будаа нь 1 жилийн доторх ургац гэх мэт |
| Мал аж ахуйн бүтээгдэхүүн | HACCP[269] хангасан нядалгааны газар ба HACCP хангасан мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрт бэлтгэсэн үхрийн мах нь 3-р зэргээс дээш, гахайн мах нь 2-р зэргээс дээш гэх мэт |
| Далайн бүтээгдэхүүн | Газар зүйн тэмдэглэгээ бүхий далайн бүтээгдэхүүн, барааны чанар “сайн” –аас дээш |
| Боловсруулсан бүтээгдэхүүн | Уламжлалт хүнс гэдэг нь нотлогдсон бүтээгдэхүүн, чанарын баталгаатай, HACCP хангасан байгууллагад үйлдвэрлэсэн гэх мэт |
| Бусад | Гарал үүслийн тэмдэглэгээтэй хүнс хэрэглэх,<br>Экспортын хүнс нь дээрх стандартад тохирох чанарыг хангасан байна |

2010 оны байдлаар бага сургуулийн сурагчдын үдийн хоолны дундаж үнэ 1900 вон буюу (1.76 ам доллар), харин дунд болон ахлах сургуулийн сурагчдынх 2700 вон (2.5 ам доллар) байсан байна. 2011 оны байдлаар нийт сургуулийн 79% сургууль доторх хоолны газраараа үйлчилж, 16% нь ангидаа, үлдсэн 5% нь сургууль доторх хоолны газрын багтаамжаас шалтгаалж хоолны газар болон ангидаа хооллоцгоосон байна.

Анх буюу 1953 оны үед сургуулийн өдрийн хоолны цэсэнд:

- Сүү, эсхүл эрдэнэшишийн зутан;
- Гурилтай шөл, талх, эсхүл хатаасан талх орж байв.

Ерөнхийдөө Солонгос Улсын ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоолны цэсэнд агшаасан будаа, шөл, эсхүл жигнэсэн мах, уургаар баялаг хачир, нэмэлт хачир (-ууд), дарсан байцаа болон амттан ордог байна. Үдийн хоолтой хамт юмуу, эсхүл үдийн хоолноос хэдэн цагийн өмнө цэвэр сүү өгдөг байна. 2007 онд батлагдсан Сургуулийн хоолны тухай хуулийг дагаж мөрдөх журамд хүүхдийн насны ангилал, хүйсэнд тохируулж хоолны илчлэг, уураг амин дэмийн хэмжээг нарийвчлан тогтоосон байна. Сурагчдын үдийн хоолны цэсэнд шим тэжээлийг тэнцвэржүүлсэн хоол өгөхөөс гадна:

[268] БНСУ-д сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ (СХҮҮ)-г хэрэгжүүлсэн арга зам, тогтолцоо: эрхзүйн орчин ба хяналт, үнэлгээ илтгэл

[269] HACCP-Hazard Analysis Critical Control Point (Аюулын дүн шинжилгээ ба эгзээтэй цэгийн хяналт тогтолцоо-хүнсний аюулгүй байдал баталгаажуулах тогтолцоо)

- Солонгос үндэсний уламжлалт хоолны соёлыг хадгалах;
- олон төрлийн үр тариа, жимс, ногоо, загас, мах, буурцаг, шош, вандуй, сүү, сүүн бүтээгдэхүүнийг багтаах;
- давс, тос, өөх, сахар болон хүнсний нэмэлтийг хэтрүүлэн хэрэглэхгүй байх;
- байгалийн гаралтай, улирлын чанартай хоолыг түлхүү хэрэглэх;
- олон төрлийн хоол хийх аргыг ашиглах шаардлагатай гэсэн байна.

Сургуулийн хоолны шим тэжээлийн стандарт нь дараах байдалтай байна. Үүнд:

- *Илчлэгийн зохицуулалт:*
  - нүүрс ус: уураг: өөх-тосны илчлэгт эзлэх хувь= 55~70%:7~20%:15~30%
- *Шим тэжээлийн тэмдэглэл болон хүнсний бүтээгдэхүүний гарал үүслийн тэмдэглэл:*
  - сургуулийн өдрийн хоолны цэс бүрээр шим тэжээлийн агууламж тооцож, хоолны газар болон ангийн самбарт байршуулах, мэдээлэх;
  - сургуулийн өдрийн хоолны цэсэнд ашиглагдсан хүнсний бүтээгдэхүүний гарал үүслийг тэмдэглэж самбарт байршуулах, мэдээлэх.
- *Натрийн хэрэглээг багасгах (2017 оны зорилт:)*
  - бага анги: 900 мг, дунд анги: 1,000 мг, ахлах анги: 1,300 мг.
- *Харшил үүсгэгч хүнсний тэмдэглэгээ:*
  - цэсэн дэх харшил үүсгэх хүнсний тэмдэглэгээг сар бүрээр цэс, шим тэжээлийн мэдээллийн хамт хүүхдийн гэр лүү явуулах, сургуулийн сайтанд байршуулах;
  - харшилтай сурагчид орлох цэсийг бэлдэх шаардлага тавигддаг байна.

*Хүснэгт 4. Сургуулийн хоолны шим тэжээлийн зохицуулалтын стандарт*

| Ангилал | Анги | Илчлэг (ккал) | Уураг (г) | Витамин A (R.E) | | Тиамин (витамин $B_1$) (мг) | | Рибофлавин (витамин $B_2$) (мг) | | Витамин C (мг) | | Кальци (мг) | | Төмөр (мг) | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Дундаж хэмжээ | Зөвлөмж хэмжээ | Дундаж хэмжээ | Зөвлөмж хэмжээ | Дундаж хэмжээ | Зөвлөмж хэмжээ | Дундаж хэмжээ | Зөвлөмж хэмжээ | Дундаж хэмжээ | Зөвлөмж хэмжээ | Дундаж хэмжээ | Зөвлөмж хэмжээ |
| Эрэгтэй | Бага сургууль 1~3 анги | 534 | 8.4 | 97 | 134 | 0.20 | 0.24 | 0.24 | 0.30 | 13.4 | 22.0 | 184 | 234 | 2.4 | 3.0 |
| | Бага сургууль 4~6 анги | 634 | 11.7 | 127 | 184 | 0.27 | 0.30 | 0.30 | 0.37 | 18.4 | 23.4 | 184 | 267 | 3.0 | 4.0 |
| | Дунд сургууль | 800 | 16.7 | 167 | 234 | 0.34 | 0.40 | 0.44 | 0.50 | 25.0 | 33.4 | 267 | 334 | 3.0 | 4.0 |
| | Ахлах сургууль | 900 | 20.0 | 200 | 284 | 0.37 | 0.47 | 0.50 | 0.60 | 28.4 | 36.7 | 267 | 334 | 4.0 | 5.4 |
| Эмэгтэй | Бага сургууль 1~3 анги | 500 | 8.4 | 90 | 134 | 0.17 | 0.20 | 0.20 | 0.24 | 13.4 | 20.0 | 184 | 234 | 2.4 | 3.0 |
| | Бага сургууль 4~6 анги | 567 | 11.7 | 117 | 167 | 0.24 | 0.27 | 0.27 | 0.30 | 18.4 | 23.4 | 184 | 267 | 3.0 | 4.0 |
| | Дунд сургууль | 667 | 15.0 | 154 | 217 | 0.27 | 0.34 | 0.34 | 0.40 | 23.4 | 30.0 | 250 | 300 | 3.0 | 4.0 |
| | Ахлах сургууль | 667 | 15.0 | 167 | 234 | 0.27 | 0.34 | 0.34 | 0.40 | 25.0 | 33.4 | 250 | 300 | 4.0 | 5.4 |

## СУРГУУЛИЙН ХООЛНЫ ТУХАЙ ХУУЛЬ
## /SCHOOL MEALS ACT 2006/

*(Албан бус орчуулга)*

**1 дүгээр зүйл. Зорилго**

Энэ хуулийн зорилго нь сургуулийн хоолны үйлчилгээний чанарыг дээшлүүлж, сурагчдын оюун санаа, бие бялдрын хөгжилд хувь нэмэр оруулах, сургуулийн хоолны үйлчилгээгээр дамжуулан үндэсний хоолны дэглэмийг сайжруулахад оршино.

**2 дугаар зүйл. Нэр томьёо**

Энэ хуульд хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

1."Сургуулийн хоолны үйлчилгээ" гэж 1 дүгээр зүйлд заасан зорилгод хүрэхийн тулд сургуулийн захирал, сурагч, сурагчдад 4 дүгээр зүйлд заасан хоолны үйлчилгээ;

2. "Сургуулийн хоолны үйлчилгээ эрхлэгчид" гэж 15 дугаар зүйлийн дагуу сургуулийн захиралтай гэрээ байгуулсны дагуу сургуулийн хоолны үйлчилгээ үзүүлэгч этгээдийг;

3. "хоолны үйлчилгээний зардал" гэж хоол хүнсний зардал, хоол хүнсний үйлчилгээний үйл ажиллагааны зардал, хоол хүнсний үйлчилгээний байгууламж, тоног төхөөрөмжийн бусад зардал зэргийг багтаасан байна.

**3 дугаар зүйл. Төрийн болон орон нутгийн хүлээх үүрэг**

1. Төрийн болон орон нутгийн засаг захиргаа нь сайн чанарын хөнгөлөлттэй чанартай сургуулийн хоолоор хангахад захиргааны болон санхүүгийн дэмжлэг үзүүлж, хоол тэжээлийн сургалтаар дамжуулан сурагчдад зөв хооллолт, хоолны дэглэмийг зөв зохистой зохицуулах чадварыг эзэмшүүлэхэд шаардлагатай бодлогыг боловсруулах, уламжлалт хооллолтын соёлыг хадгалах, хөгжүүлэхэд оршино.

2. Нийслэлийн хот, Нийслэлийн тусгай хот, муж болон өөртөө засах тусгай мужийн Боловсролын албаны дарга (цаашид "Боловсролын албаны дарга" гэх) - нь жил бүр сургуулийн хоолны үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлнэ.

**4 дүгээр зүйл. Сургуулийн хоолны үйлчилгээнд хамрагдах оюутнууд ба сурагчид**

Ерөнхийлөгчийн зарлигт заасны дагуу дараах дэд хэсгүүдэд заасан сургуулийн сурагчдад сургуулийн хоолны үйлчилгээ үзүүлнэ. Үүнд:

1. Бага, дунд боловсролын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1-4 дүгээр хэсэгт заасан сургууль;

2. Бага, дунд боловсролын тухай хуулийн 52 дугаар зүйлд заасны дагуу хөдөлмөр эрхэлж буй залуучуудад зориулсан тусгай ангиуд болон аж үйлдвэрийн байгууллагын дэргэдэх дунд сургууль, ахлах сургуулиуд;

3. Боловсролын албаны даргын хүлээн зөвшөөрсөн бусад сургуулиуд.

**5 дугаар зүйл. Сургуулийн хоолны үйлчилгээний хороо**

1. Боловсролын албаны дарга бүр дараах асуудлыг хэлэлцэх зорилгоор Сургуулийн хоолны үйлчилгээний хороог байгуулна:

1) 3 дугаар зүйлийн (2) дахь хэсэгт заасан сургуулийн хоолны үйлчилгээний төлөвлөгөө;

2) 9 дүгээр зүйлд заасан хоолны зардлыг татаас;

3) Боловсролын албаны даргын сургуулийн хоолны үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх, зохион байгуулах шаардлагатай гэж үзсэн бусад асуудлууд.

2. 1. дэх хэсгийн заалтад заасан Сургуулийн хоолны үйлчилгээний хорооны бүтэц, үйл ажиллагаа зэрэг холбогдох асуудлыг Ерөнхийлөгчийн зарлигаар тогтооно.

3. Нийслэлийн хотын дарга, Нийслэлийн тусгай хотын дарга, муж болон өөртөө засах тусгай мужийн захирагч нь 8 дугаар зүйлийн (4) дэх хэсгийн заалтын дагуу сургуулийн хоолны үйлчилгээг дэмжих асуудлуудыг хэлэлцэхэд чиглэсэн сургуулийн хоолны үйлчилгээг дэмжих зөвлөлдөх хороог байгуулж болно.

4. Өөртөө засах тусгай мужийн захирагч, эсхүл Хот, тойрог, автономит дүүргийн дарга нь сайн чанарын хоол хүнсний бүтээгдэхүүнээр хангах зэрэг сургуулийн хоол

хүнсний үйлчилгээг дэмжихийн зорилго бүхий Сургуулийн өдрийн хоолыг дэмжих төвийг байгуулж, ажиллуулж болно.

5. 3 дахь хэсэгт заасан сургуулийн хоолны үйлчилгээг дэмжих зөвлөлдөх хороо болон (4) хэсэгт Сургуулийн өдрийн хоолыг дэмжих төвийн бүтэц, бүрэлдэхүүн, байгуулах, үйл ажиллагаатай холбоотой асуудлыг холбогдох орон нутгийн засаг захиргааны захирамжаар тогтооно.

**6 дугаар зүйл. Хоолны үйлчилгээний барилга байгууламж, тоног төхөөрөмж**

1. Сургуулийн хоолны үйлчилгээг гүйцэтгэх сургуулиуд нь сургуулийн хоолны үйлчилгээнд шаардагдах тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна. Хоёр сургуулиас доошгүй сургууль ойрхон байрлах байх тохиолдолд тэдгээр нь сургуулийн хоолоор хангах тоног төхөөрөмж, байгууламжийг хамтран байгуулж, ашиглаж болно.

2. 1 дэх хэсэгт заасан байгууламж, тоног төхөөрөмж, тоног төхөөрөмжийн төрөл, шалгуур үзүүлэлтийг Ерөнхийлөгчийн зарлигаар тогтооно.

**7 дугаар зүйл. Хоол зүй, шим тэжээлийн багш (Nutrition teachers)**

1. 6 дугаар зүйлд зааснаар сургуулийн хоолоор хангах тоног төхөөрөмжөөр тоноглогдсон сургуулиуд нь Бага, дунд боловсролын тухай хуулийн 21.2-т заасан хоол зүй, шим тэжээлийн багш, Хүнсний эрүүл ахуйн тухай хуулийн 53.1-т заасан мэргэжлийн тогоочийг ажиллуулна.

2. Боловсролын алба хариуцсан ахлах мэргэжилтэн нь сургуулийнхаа хоолны газрын үүрэгт онцгой үүрэг гүйцэтгэх сургуулийн хоолны үйлчилгээнд мэргэшсэн ажилтнуудыг өөрийн эрх мэдлийн хүрээнд байрлуулж болно.

**8 дугаар зүйл. Сургуулийн хоолны зардал**

1. Сургуулийн хоолны үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн зардлыг тухайн сургуулийн үүсгэн байгуулагч, эрхлэгч хариуцах боловч төр, орон нутгийн захиргаанаас татаас олгож болно.

2. Зарчмын хувьд, хоолны үйлчилгээний зардлыг тухайн сургуулийн үүсгэн байгуулагч, эрхлэгч хариуцах боловч Ерөнхийлөгчийн захирамжид заасан зарим зардлыг хамгаалагч хариуцна (эцэг, эх, асран хамгаалагч болон хуулиар эрх олгогдсон бусад хүмүүс)

3. Сургуулийн хоолны зардлыг зарчмын хувьд хамгаалагч хариуцна.

4. Тусгай хотын дарга, өргөтгөсөн хотын дарга, мужийн захирагч, өөртөө засах тусгай мужийн захирагч, болон хот, гүн, өөртөө засах дүүргийн дарга нь сургуулийн хоолны үйлчилгээний чанарыг сайжруулах, үүнд хөдөө аж ахуйн сайн чанарын бүтээгдэхүүн хэрэглэх, хоолны үйлчилгээний барилга байгууламжийг өргөтгөх, тоног төхөөрөмжийг сайжруулах зэрэгт хоол хүнс, байгууламж, тоног төхөөрөмжийн зардлын татаас олгож болно.

**9 дүгээр зүйл. Хоол хүнсний үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх**

1. 8 дугаар зүйлд заасан хамгаалагчийн хариуцах зардлыг төр, эсхүл орон нутгийн захиргаа бүрэн буюу хэсэгчлэн хариуцаж болно.

2. Хэрэв хамгаалагчийн хариуцах зардлыг 1-р хэсэгт зааснаар татаас олгох бол дараах сурагчдад, дор дурдсан төрлийн татаас олгоно:

1) Сурагч, эсхүл түүний хамгаалагч нь тусламж авах нөхцөлийг хангасан, эсхүл Үндэсний амьжиргааны суурь баталгааны тухай хуулийн 2 дугаар заасан ангилалд багтах, эсхүл Ганц бие эцэг, эхийг дэмжих тухай хуулийн 5-д заасны дагуу тусламж авдаг бол;
2) Арал болон алслагдсан бүс нутаг дахь боловсролыг дэмжих тухай хуулийн 2-р зүйлд заасны дагуу арал, эсхүл алслагдсан нутаг дахь сургуульд суралцагч, эсхүл Ерөнхийлөгчийн захирамжаар тогтоосон сургуулиудын сурагч;
3) Хөдөө аж ахуй, загас агнуурын тосгоныг дэмжих, хөдөө аж ахуй эрхлэгч, загасчдын амьдралын чанарыг сайжруулах тухай тусгай хуулийн 3.4-т заасан хөдөө аж ахуй, уулархаг, загас агнуурын тосгонд байрлах сургуульд сурч буй сурагчид, эсхүл Ерөнхийлөгчийн захирамжаар тогтоосон сургуулиудын сурагч;
4) Боловсролын албаны даргын хүлээн зөвшөөрсөн бусад сурагчид.

**10 дугаар зүйл. Хүнсний бүтээгдэхүүн**

1. Сургуулийн хоолны үйлчилгээнд сайн чанарын, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэнэ.

2. Хүнсний бүтээгдэхүүнд тавигдах шалгуур болон хүнсний бүтээгдэхүүнтэй холбоотой бусад асуудлыг Боловсролын яамны тогтоолоор тогтооно.

**11 дүгээр зүйл. Хоол тэжээлийн менежмент**

1. Сургуулийн хоолны үйлчилгээнд сурагчдын эрүүл мэнд, өсөлт хөгжилтөд шаардлагатай хоол тэжээлийг хангаж, хоолны зөв дадал зуршлыг бий болгоход туслах хоол хүнсийг хэрэглэнэ.

2. Сургуулийн хоолны шим тэжээлд тавигдах шалгуурыг Боловсролын яамны тогтоолоор тогтооно.

**12 дугаар зүйл. Ариун цэвэр, эрүүл ахуйн менежмент**

1. Сургуулийн хоолны үйлчилгээг хоол хүнсэнд аюултай материалыг холихгүй байх, цэсийг төлөвлөх, худалдан авах, шалгах, хадгалах, угаах, хоол бэлтгэх болон хоол, хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэх, борлуулах, түгээх, ариутгах зэрэг бүхий л шатанд эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах замаар зохион байгуулна.

2. Сургуулийн хоол хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдалд тавигдах шалгуурыг Боловсролын яамны тогтоолоор тогтооно.

**13 дугаар зүйл. Хооллох дадал, зуршил**

Сургуулийн захирал нь сурагчдад зөв хооллолт, хоолны зөв дадал зуршил бий болгоход чиглүүлж, хоол, хүнсний үйлдвэрлэл, хэрэглээний талаарх мэдлэгийг дээшлүүлж, уламжлалт хоол хүнсний соёлыг залгамжлуулж, хамгаалагчдыг холбогдох мэдээллээр хангана.

**14 дүгээр зүйл. Шим тэжээлийн зөвлөгөө**

Сургуулийн захирал нь хооллолт, хоолны дадал зуршлаас үүссэн шим тэжээлийн өөрчлөлтийг бууруулах мөн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үүднээс бага жинтэй, өсөлтийн хоцрогдол, цус багадалт, илүүдэл жин, таргалалт зэрэг хоол тэжээлийн зөвлөгөө шаардлагатай сурагчдад заавар, зөвлөгөөгөөр хангаж ажиллана.

**15 дугаар зүйл. Сургуулийн хоолны үйлчилгээний үйл ажиллагааны зохион байгуулалт**

1. Сургуулийн захирал нь сургуулийн хоолны үйлчилгээг шууд удирдан зохион байгуулах бөгөөд Бага, дунд боловсролын тухай хуулийн 31-д заасан Сургуулийн үйл ажиллагааны хороотой хэлэлцсэний үндсэн дээр сургуулийн хоолны үйлчилгээг тодорхой шаардлагыг хангасан хүнд хариуцуулж болно. Тухайн хүнд сургуулийн хоолны үйлчилгээний нөхцөл байдлын зайлшгүй шаардлагаас бусад тохиолдолд хоол, хүнсний бүтээгдэхүүн сонгох, худалдан авах, хянан шалгах үүргийг шилжүүлэхгүй.

2. Ерөнхий боловсролын байгууллага нь 1 дэх хэсэгт заасны дагуу эрх шилжүүлэх тохиолдолд эрх бүхий байгууллагаас урьдчилан зөвшөөрөл авна.

3. 1 дэх хэсэгт заасан сургалтын хоолны үйлчилгээг шилжүүлэхтэй холбоотой сургуулийн хоол, хүнс бэлтгэн нийлүүлэгчдэд тавигдах шаардлага болон дээрх эрхийг шилжүүлэхтэй холбоотой бусад асуудлыг Ерөнхийлөгчийн захирамжаар тогтооно.

**16 дугаар зүйл. Чанар, аюулгүй байдлыг хангахтай холбоотой асуудал**

1. Сургуулийн захирал болон сургуулийн хоолны үйлчилгээтэй хариуцсан сургуулийн ажилтан (цаашид "сургуулийн хоолны үйлчилгээтэй холбоотой сургуулийн ажилтан" гэх) болон сургуулийн хоолны үйлчилгээ үзүүлэгчид нь дор дурдсан хүнсний бүтээгдэхүүнийг хүнсний чанар болон аюулгүй байдлыг хангахтай холбоотойгоор хэрэглэхгүй:

1) Хөдөө аж ахуй, загас агнуурын бүтээгдэхүүний гарал үүслийн тухай хуулийн 5.1-т заасан гарал үүслийн тэмдэглэгээний зөрчилтэй хоол, хүнс;
2) Хөдөө аж ахуй, загасны аж ахуйн бүтээгдэхүүний чанарын хяналтын тухай хуулийн 56-р зүйлд заасан генийн өөрчлөлттэй хөдөө аж ахуйн болон загас агнуурын бүтээгдэхүүний тэмдэглэгээний зөрчилтэй хоол, хүнс;

3) Мал аж ахуйн тухай хуулийн 40-р зүйлд заасан мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ангиллыг тэмдэглэгээний зөрчилтэй хоол, хүнс;
4) Зүйл 14.3-р зүйлд заасан чанарын гэрчилгээ, эсхүл газар зүйн заалтад заасан чанарын баталгаажуулалтыг Хөдөө аж ахуй, загасны аж ахуйн бүтээгдэхүүний чанарын хяналтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн (2) дахь стандартын бүтээгдэхүүний стандартыг заана. 34 (3) дугаар зүйл.

2. Сургуулийн захирал, сургуулийн хоолны үйлчилгээтэй холбоотой сургуулийн ажилтан болон сургуулийн хоолны үйлчилгээ үзүүлэгч нь дараахыг дагаж мөрдөнө:

1) 10.2-т заасан хүнсний бүтээгдэхүүний чанарын хяналтын шалгуур, 11.2-т заасан хоол тэжээлийн менежментийн шалгуур, 12.2-т заасан эрүүл ахуй, аюулгүй байдлын хяналтын шалгуур үзүүлэлт;
2) Боловсролын яамны тогтоолоор баталсан сургуулийн хоол хүнсний чанар, аюулгүй байдлыг хангахад шаардлагатай бусад зүйлс.

3. Сургуулийн хоол нь харшил үүсгэгч/өдөөгч хоол хүнсний бүтээгдэхүүн агуулсан бол, сургуулийн захирал, сургуулийн хоолны үйлчилгээтэй холбоотой сургуулийн ажилтан сургуулийн хоолны үйлчилгээ үзүүлэгч нь тус хоол, хүнсний талаар сурагчдад мэдэгдэж, сургуулийн хоолоор үйлчлэхдээ харшил үүсгэгчтэй болохыг тэмдэглэнэ.

4. 3-р хэсэгт заасан харшил үүсгэгчтэй хүнсний талаар мэдээлэх, тэмдэглэгээ хийхтэй холбоотой асуудлыг Боловсролын яамны тогтоолоор шийдвэрлэнэ.

**17 дугаар зүйл. Үйлдвэрлэсэн хоол, хүнсний шууд хэрэглээ**

Сургууль дээр хоол, хүнсний бүтээгдэхүүнийг тариалах, мал өсгөх болон бусад үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас олж авсан хоол, хүнсний бүтээгдэхүүн, эсхүл тэдгээрийн борлуулснаас олсон бусад хуульд заасныг үл харгалзан сургуулийн хоолны үйлчилгээнд шууд ашиглаж болно.

**18 дугаар зүйл. Сургуулийн хоолны үйлчилгээний үнэлгээ**

1. Боловсролын сайд, эсхүл Боловсрол албаны дарга нь сургуулийн хоолны үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор сургуулийн хоолны үйл ажиллагааны үнэлгээ хийж болно.

2. 1 дэх хэсгийн үнэлгээний арга, шалгуур болон сургуулийн хоолны үйлчилгээний үйл ажиллагааг үнэлэхэд шаардлагатай бусад асуудлыг Ерөнхийлөгчийн захирамжаар тогтооно.

**19 дүгээр зүйл. Нэвтрэх, үзлэг хийх, хурааж авах**

1. Боловсролын сайд, эсхүл Боловсрол албаны дарга шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хоолны эрүүл ахуй, эсхүл хоолны үйлчилгээ хариуцсан төрийн албан хаагчдад сургуулийн хоолны үйлчилгээнд хамаарах барилга байгууламжид нэвтэрч, хоол, хүнс, барилга байгууламж, бичиг баримт, үйл ажиллагааны нөхцөл байдалд үзлэг, шалгалт хийх, эсхүл хоол, хүнсний шинжилгээнд хамруулахад шаардагдах хамгийн бага хэмжээтэй хоол хүнсийг нөхөн олговоргүй хураан авах эрх олгож/дээж авах/ шаардаж болно.

2. 1 дэх хэсэгт заасны дагуу нэвтрэх, хянан шалгах, дээж авах үйл ажиллагаа явуулах гэж буй төрийн албан тушаалтан нь өөрийн бүрэн эрхийг гэрчилсэн үнэмлэхийг биедээ авч явж, холбогдох хүмүүст үзүүлнэ.

3. Хяналт шалгалтаар 16.1.1-2 дахь хэсэг болон 16.3-т заасныг зөрчсөнийг илрүүлсэн тохиолдолд Боловсролын сайд, Боловсролын албаны дарга нь илрүүлсэн зөрчлийг зогсоох, арилгуулах шаардлагыг сургуулийн захирал сургуулийн хоолны нийлүүлэгчид хүргүүлж болно.

**20 дугаар зүйл. Эрх шилжүүлэх**

Энэхүү хуульд заасан Боловсролын сайд, Боловсролын албаны даргын эрхийг хэсэгчлэн Ерөнхийлөгчийн захирамжаар тогтоосон журмын дагуу Боловсролын албаны дарга, эсхүл дүүргийн боловсролын албаны даргад шилжүүлж болно.

**21 дүгээр зүйл. Захиргааны арга хэмжээ**

1. 19-р зүйлд заасан хяналт шалгалтын дүнд Хоол хүнсний эрүүл ахуйн тухай хууль, Хөдөө аж ахуй, загасны аж ахуйн бүтээгдэхүүний чанарын хяналтын тухай хууль, Мал аж

ахуйн тухай хууль, Мал аж ахуйн бүтээгдэхүүний эрүүл ахуйн хяналтын тухай хуульд заасан зөвшөөрөл авсан, томилогдсон буюу баталсан этгээд холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн нь тогтоогдсон бол Боловсролын сайд, эсхүл Боловсролын албаны дарга нь холбогдох захиргааны байгууллагад захиргааны арга хэмжээ зэрэг шаардлагатай арга хэмжээ авахыг хүсэлт гаргаж болно.

2. 1 дэх хэсэгт заасан захиргааны байгууллагын дарга нь тусгай шалтгаанаас бусад тохиолдолд дээрх хүсэлтийг биелүүлэх бөгөөд Боловсролын сайд, эсхүл холбогдох Боловсролын албаны даргад авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдэгдэнэ.

**22 дугаар зүйл. Сахилгын арга хэмжээ**

Сахилгын шийтгэл ногдуулах санал гаргах эрхтэй этгээд нь холбогдох сахилгын хэргийг хамаарах сахилгын хороонд сургуулийн хоолны үйлчилгээний зохих ёсны үйл ажиллагаа явуулах, аюулгүй байдлыг хангуулах зорилгоор өөрийн харьяа сургуулийн захирал, болон дараах ажилтанд сахилгын шийтгэл ногдуулах хүсэлтийг гаргана:

1) Хоол хүнсний хордлого зэрэг эрүүл ахуй, аюулгүй байдалд санаатай, эсхүл санамсаргүй байдлаар осол/зөрчил гаргасан хүнд;
2) Сургуулийн хоолны үйлчилгээний гэрээг цуцлах үндэслэл бий болсон хэдий ч гэрээг цуцлаагүй хүнд;
3) 19.3-т заасны дагуу Боловсролын сайд, эсхүл Боловсролын албаны даргын зөрчлийг арилгуулахаар гаргасан шийдвэрийг үндэслэлгүйгээр биелүүлээгүй хүнд;
4) Сургуулийн хоолны үйлчилгээтэй холбоотой авлигын хэрэгт холбогдсон хүнд.

**23 дугаар зүйл. Шийтгэл ногдуулах**

1. 16-р зүйлийн 1.1, 1.2 дахь хэсгийг зөрчсөн сургуулийн хоолны үйлчилгээ үзүүлэгчийг 7 жилээс дээшгүй хугацаагаар хорих (imprisonment with labor), эсхүл 100 сая воноос дээшгүй хэмжээний торгууль оногдуулна.

2. 16-р зүйлийн 1.3 дахь хэсгийг зөрчсөн сургуулийн хоолны үйлчилгээ үзүүлэгчийг 5 жилээс дээшгүй хугацаагаар хорих (imprisonment with labor), эсхүл 50 сая воноос дээшгүй хэмжээний торгууль оногдуулна.

3. Дараах этгээдийг гурван жилээс илүүгүй хугацаагаар хорих (imprisonment with labor), эсхүл 30 сая воноос дээшгүй хэмжээний торгууль оногдуулна.

1) 16-р зүйлийн 1.4 дэх хэсгийг зөрчсөн сургуулийн хоолны үйлчилгээ үзүүлэгч;
2) 19-р зүйлийн 1 дэх хэсэгт заасны нэвтрэх, хянан шалгах, дээж авах, хураан авах ажиллагаанд үндэслэлгүйгээр татгалзсан, саад учруулсан, эсхүл зайлсхийсэн этгээд.

**24 дүгээр зүйл. Хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх**

Компанийн төлөөлөгч, ажилтан, эсхүл хувь хүний аливаа ажилтан нь компани буюу хувь хүний үйл ажиллагаатай холбоотойгоор 23 дугаар зүйлд заасан зөрчлийг гаргасан бол зохих зөрчилд оногдуулах шийтгэлээс гадна, компаний, эсхүл хувь хүнд холбогдох зөрчилд тохирох торгох шийтгэлийг оногдуулна. Дээрх нь компани, эсхүл хувь хүн дээр дурдсан зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих зэрэгт хайхрамжгүй хандаагүй тохиолдолд үйлчлэхгүй.

**25 дугаар зүйл. Торгууль**

1. 16.2-р зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчилд 19.3-р зүйлд заасан зөрчлийг арилгуулах шийдвэрийг үндэслэлгүйгээр биелүүлээгүй сургуулийн хоолны үйлчилгээ үзүүлэгчид 5 сая воноос дээшгүй хэмжээний торгууль оногдуулна.

2. 16.2-р зүйлийн 2 дахь хэсэг, 16.3-р зүйлд заасан зөрчилд 19.3-р зүйлд заасан зөрчлийг арилгуулах шийдвэрийг үндэслэлгүйгээр биелүүлээгүй сургуулийн хоолны үйлчилгээ үзүүлэгчид 3 сая воноос дээшгүй хэмжээний торгууль оногдуулна.

3. 1, 2 дахь хэсэгт заасан захиргааны шийтгэлийг Боловсролын сайд, Боловсролын албаны дарга Ерөнхийлөгчийн захирамжид заасны дагуу ногдуулж, хурааж авна.

**БНХАУ**[270]

Бүгд Найрамдах Хятад Ард Улс сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоол үйлдвэрлэлтэй холбоотой асуудлыг зохицуулсан бие даасан хуульгүй бөгөөд Хятад Улсын Хүнсний аюулгүй байдлын тухай хууль (*China's Food Safety Law, 2015*) болон зарим бодлогын баримт бичгийн хүрээнд боловсруулагдсан хөтөлбөрүүдээр зохицуулж байна. Сургуулийн хоолны системийн түгээлт, нийлүүлэлт, үйлдвэрлэлтийн талаар албан ёсны нэгдсэн бодлого одоогоор байхгүй. Тус улсад Үндэсний сургуулийн хоолны хөтөлбөрийн нэгдсэн төсөв болон дэмжих бодлого одоохондоо байхгүйгээс сургуулийн хооллолтын систем нь сургууль, хот, хотын захиргаа, аймгуудын хүрээнд бие даасан байдалтай явагддаг байна.

**Сургуулийн хооллолтын үйлчилгээ:**

Тус улсад сургуулийн хоолны үйлчилгээг 1980 оны эхэн үеэс "сургуулийн өдрийн хоолны хөтөлбөр" хэлбэрээр далайн эргийн хэдэн том хотуудад эхэлсэн. Мөн 1988 онд "Хятадын сурагч, оюутнуудын хоол тэжээлийг дэмжих холбоо" /Chinese Students Nutrition Promoting Association/ гэх бие даасан байгууллагыг сургуулийн хүүхдийн хоолны хөтөлбөрийг өргөжүүлж, үйлчилгээний чанарыг сайжруулахад бүх оролцогчдыг /хувийн болон улсын/ нэгтгэх зорилгоор байгуулсан. Улмаар 2000 оны эхээр "БНХАУ-ын Сургуулийн Сүүний Хөтөлбөр" (China School Milk Programme) дөрвөн хотод хэрэгжиж эхэлсэн байна.

Засгийн газраас Сургуулийн сүүний хөтөлбөрт дэмжлэг үзүүлээгүй ч хэлэлцээрээр нөхөн төлөгдөх зах зээлийн үнээс 25-30 хувиар хямдралтай үнээр сүүг хотын сургуулийн хүүхдүүдэд өгөх болсон нь улсын эдийн засаг болон сүүний үйлдвэрлэлд хувь нэмэр оруулахын зэрэгцээ сурагчдын хоол тэжээлийг нэмэгдүүлэхэд ихээхэн ач холбогдолтой байсан байна.

Сургуулийн сүүний хөтөлбөрийн эхний туршилтын үед 223 ажлын байр шинээр бий болж, 100,000 гаруй сурагчийг сүү хөтөлбөрт хамруулсан байна. 2007 онд Сургуулийн сүү хөтөлбөрт Тэтра Пак савлагааг нэвтрүүлж, сурагчдад 5,3 тэрбум сав сүүгээр хангасан байна.

Сургуулийн өдрийн хоолны хөтөлбөр нь ихэнхдээ хотын бүсэд байрладаг сургуулиудад хэрэгждэг бол хөдөөгийн алслагдмал бүсэд амьдардаг сурагчдын дунд хоол тэжээлийн дутагдал хамгийн түгээмэл байдаг байна.

Мөн сурагчдын үдийн хоолыг маш шим тэжээлтэй мэтээр ойлголт өгч мэдээлэх хэдий ч ихэнх үдийн хоол нийлүүлэгчид сурагчдын амтанд тааруулж шим тэжээлийг бага анхаардаг ажээ. Дээрх шалтгаануудаас үүдэн 2005 онд хүлээн зөвшөөрөгдсөн сургуулийн үдийн хоолны сүлжээ том хотуудын сургуулиудын 30-50% болон дунд, жижиг хотын сургуулиудын 18-35%-ыг хамарсан. Хөдөөгийн бүсийн сургуулиудад, ялангуяа Хятадын баруун хэсгийн ядуу бүсийн сургуулиудад сургуулийн хоолны хөтөлбөр одоог хүртэл байдаггүй байна.

Хятадын Засгийн газраас сургуулийн хоолны хөтөлбөрүүдийг төдийлөн санхүүжүүлдэггүй ч сүүлийн жилүүдэд хөдөөгийн бүсийн захиргаад бага сургуулийн сурагч бүрт 500 юань/73 ам.доллар болон дунд сургуулийн сурагч бүрт 750 юань/110 ам.долларыг сурагчдын хоолны шим тэжээлийг сайжруулахын тулд санхүүжүүлэхээр болжээ.

Вьетнамын хилийн дагуу Өмнөд Хятадад байрладаг GuangXi өөртөө засах бүсэд Хятадын хөгжлийн судалгааны сангаас жил бүр нэг сурагчид дунджаар 1000 юаны санхүүжилт бүх сургуулийн үдийн хоолны туршилтын хөтөлбөрийг явуулж эхэлсэн ба нэг өдрийн хоол 2,5-5 юаний үнэтэй байна.

**Бодлогын зохицуулалт:**

Сургуулийн хоолны тогтолцооны тараалт, нийлүүлэлт, үйлдвэрлэлтийн талаар албан ёсны нэгдсэн бодлого одоогоор Хятадад байхгүй. Мөн Үндэсний сургуулийн хоолны

270 https://apec.org/-/.../APEC/.../Research-School-Feeding-in-APEC-Economies/2012_scs

хөтөлбөрийг санхүүжүүлэх болон дэмжих бодлого байхгүйн улмаас сургуулийн хоолны хөтөлбөрүүд нь сургууль, хот, аймгуудын хүрээнд бие даасан байдалтай явагдаж байна. Үүнээс улбаалан хөтөлбөрийн чанар, зардал, сурагчдыг хамрах байдлын хувьд ихээхэн ялгаатай байна.

Эцэг, эхчүүд хоолны төлбөрийг төлөх, эсхүл хоолны зардлыг бууруулахад будаа зэрэг хүнсээр хангаж оролцдог. Ядуу өрхийн сургуулийн сурагчдад үнэгүй, эсхүл хөнгөлөлттэй хоолоор хангах тогтолцоо бүрдээгүйн улмаас маш олон хүүхэд сургууль дээрээ хоолгүй, эсхүл бүтэн порц хоол худалдаж авах боломж бага байдаг байна. Цөөн тооны том хотуудад ядуу өрхүүдэд Нийгмийн халамжийн газраас сургуулийн хоолны дэмжлэг үзүүлдэг байна.

Хятадын Хүнсний аюулгүй байдлын тухай хуулийн 57 дугаар зүйлд зааснаар “Сургууль, цэцэрлэг, асрамжийн газар, сувиллын хоол үйлдвэрлэлийн газрууд нь хууль тогтоомж, дүрэм журам, хүнсний аюулгүй байдлын стандартыг бүрэн дагаж мөрдөнө. Хоол үйлдвэрлэл эрхлэгчдийн хувьд аливаа байгууллага, хувь хүн хүнсний үйлдвэрлэл, хуваарилалтын лицензтэй байхыг шаардана. Хоолны үйлчилгээ үзүүлэгч нь хууль тогтоомж, дүрэм журам, хүнсний аюулгүй байдлын стандартыг дагаж мөрдөн, энэхүү хуульд заасан журмын дагуу хоол боловсруулж, хүнсний аюулгүй байдлыг хангана” гэж заажээ.

Мөн хуульд тусгаснаар “Сургууль, цэцэрлэг, асрамжийн газар, сувиллын хоолны газраар үйлчлүүлэх эрх бүхий байгууллага, этгээд нь хүнсний баталгаат байдлыг хангахын тулд хүнсний аюулгүй байдлын талаарх боловсрол, өдөр тутмын менежментийг нэгтгэснээр хүнсний аюулгүй байдалд учирч болох эрсдэлийг бууруулна” гэжээ.

**Хүнс худалдан авах ажиллагаа: /Сычуань мужийн жишээ/**

Орон нутгийн нөөц боломжоор сургуулийн шим тэжээллэг хоолны хөтөлбөрүүдийг дэмжих боломжтой юм. Зорилтот сургуулиудад хэрэгжиж буй сургуулийн хооллолтын загвар хөтөлбөрүүд нь сургуулийн хоолны хөтөлбөрүүдийг үе шаттай хэрэгжүүлэх үндэс суурь болж болох боловч хөтөлбөрийг хөгжүүлэх, өргөжүүлэхэд Засгийн газрын дэмжлэг дутмаг байна.

Deyang сургууль (Сычуант мужид байрлалтай) нь жимс, ногоо, загас, мах зэргийг хүнсний захуудаас худалдан авдаг бол түргэн мууддаггүй хүнсний бүтээгдэхүүн болох гурил, будаа, ургамлын тос зэргийг Хүнсний хяналтын байгууллага /DEB/-аас чанарын шаардлага хангасан, итгэмжлэгдсэн нийлүүлэгчдээс худалдан авахыг шаардлага болгодог байна. Бүх сургуулиудад худалдан авахтай холбоотой ажиллагааг (бэлтгэн нийлүүлэгчийн мэдээлэл) баримтжуулахыг шаарддаг. Ялангуяа худалдан авах эх үүсвэр болон нийлүүлэгчийг хянахыг шаарддаг. Мөн түүнчлэн, сургуулиудад 24-48 цагийн турш бүх хоолноос дээж авахыг шаарддаг байна. Хэрвээ ямар нэг хоолтой холбоотой асуудал гарвал эдгээр дээжүүдээс асуудлыг тодруулах шинжилгээ хийгддэг. DEB нь чанаж болгоогүй хоол хүнс вирусыг илүү хялбар тархаадаг учир сургуулиудад хүйтэн хоолоор үйлчлэхгүй байхыг зөвлөдөг.

Хэдийгээр сургууль нь орон нутгийн үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүнийг ашигладаг боловч фермерүүд нь фермийг хөнгөвчлөхийн тулд хоршоо, эсхүл бусад маркетингийн бүлгүүдэд зохион байгуулагддаггүй байна. Үр тариа, мах, шувуу зэрэг хүнсний бүтээгдэхүүнийг сургуулиудад сонгон шалгаруулалтаар сонгогдсон тухай үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий бэлтгэн нийлүүлэгчид орон нутгийн эрүүл мэндийн хэлтэс хянан, Ихэвчлэн 2-3 тендер зах зээлийн үнээс 10%-иар бага байдаг. Жимсийг орон нутгийн фермерүүдээс худалдаж авахаас гадна хүнсний ногоог ихэнхдээ шинэ хүнсний захаас худалдаж авдаг байна.

Хятад Улсын Хүнсний аюулгүй байдлын тухай хуулийн 125 дугаар зүйлд зааснаар “Төвлөрсөн хоолны газар (кафетери)-тай сургууль, цэцэрлэг, асрамжийн газар, барилга байгууламж нь хүнсний аюулгүй байдлыг хангах хариуцлагаа биелүүлээгүй, хүнсний үйлдвэрлэгчид болон хоолны үйлчилгээ үзүүлэгчид нь үйлдвэрлэлийн болон түгээлтийн үйл явцад хяналт тавих үйл ажиллагааг зохицуулж чадаагүй зэрэг тохиолдолд тухайлбал, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч буюу түгээгч нь хууль бусаар үйлдвэрлэсэн,

худалдаалагдсан хүнсний болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, түүнчлэн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, хүнсний түүхий эд, мужийн түвшний ба түүнээс дээш түвшний Засгийн газруудын хүнсний болон бусад хууль бус үйлдвэрлэл, түгээлтийг ашигласан бол бараа бүтээгдэхүүний нийт үнэ 10,000 юань буюу түүнээс бага бол 5,000-50,000 юаньтай тэнцэх, 10,000 юанаас дээш тохиолдолд барааны нийт үнийг 5-10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгууль ногдуулах, мөн ноцтой зөрчил гаргасан тохиолдолд үйлдвэрлэлийн буюу аж ахуйн үйл ажиллагааны лицензийг хүчингүй болгох шийтгэлийг тус тус ногдуулдаг байна.

## ОХУ

ОХУ-д сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоолны үйлдвэрлэлтэй холбоотой асуудлыг зохицуулсан бие даасан хууль, сургуулийн үдийн цайны үндэсний хөтөлбөр байхгүй бөгөөд тухайн асуудлыг "ОХУ-ын боловсролын тухай хууль"[271] болон зарим бодлогын баримт бичгийн хүрээнд боловсруулагдсан томоохон бүс нутгуудын хөтөлбөрүүд, эрүүл ахуйн шаардлагуудаар зохицуулж байна. ОХУ-ын хувьд сүүлийн жилүүдэд сургуулиудад хоолны хордлогуудын тохиолдлууд ихэссэн зэрэг хоолны үйлдвэрлэл, үйлчилгээ, эрүүл ахуйтай холбоотойгоор сургуулийн хоолны эрх зүйн орчныг сайжруулах асуудлаар холбооны болон субъектуудын удирдлагууд тодорхой алхмууд авч эхлээд байгаа. Тухайлбал, *(ОХУ-ын сургуулийн хоолны үйлдвэрлэлийн тогтолцоо, оролцогч талуудыг Зураг 4-с үзнэ үү.)*

Холбооны хэмжээний боловсролын салбарын хууль тогтоомжуудад сургууль, цэцэрлэгийн сурагчдын хоолны үйлдвэрлэл үйлчилгээтэй холбоотой асуудлыг ерөнхий хүрээнд зохицуулсан байх бөгөөд тодорхой эрх, үүрэг, нөхцөлүүдийг тусгаагүй байна. Сургуулиудын хоолны үйлдвэрлэл, үйлчилгээг боловсролын байгууллага хариуцна. Хуульд заасны дагуу сургуулийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээний эрх зүйн норм, нормативуудыг ОХУ-ын субъектуудын төрийн эрх барих байгууллага болон нутгийн өөрөө удирдах байгууллагууд тогтооно. Мөн дээрх байгууллагууд нь хоолны үнэ өртөг, санхүүжилтийн эх үүсвэр болон холбогдох дүрэм, журам, хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдах сурагчдын ангиллыг тогтоох болон бусад зохион байгуулалтын асуудлыг хариуцна.

*ОХУ-ын боловсролын тухай хууль (2012)-ийн 4 дүгээр бүлгийн 37 дугаар зүйлд:*

1. *"Сурагчдын хоолны зохион байгуулалтын асуудлыг боловсролын байгууллага хариуцна.*
2. *Хичээлийн хуваарийг сурагчид хооллож хүрэлцэхүйц хугацааны завсарлагатай байхаар зохион байгуулна.*
3. *Батлан хамгаалах, аюулгүй байдлын салбар, ОХУ-ын Үндэсний харуулын цэрэг, далайн хөлөг онгоц, дотоодын усан хөлөг онгоц, загас агнуурын хөлөг онгоцны бие бүрэлдэхүүн бэлтгэх, нисэх онгоц, нисэхийн ажилтан, нислэгийн хөдөлгөөний удирдлагын ажилтан бэлтгэхэд чиглэсэн холбооны улсын боловсролын байгууллагын сурагч болон насанд хүрээгүй хүүхдийг цэргийн болон төрийн бусад албанд бэлтгэхэд чиглэсэн нэмэлт боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэгч мэргэжлийн болон ерөнхий боловсролын байгууллагуудын сурагчдын өдрийн хоолыг холбогдох холбооны улсын боловсролын байгууллагын үүсгэн байгуулагчаас тогтоосон нөхцөл, журамд заасан норм, стандартын дагуу зохион байгуулна.*
4. *ОХУ-ын субъектийн төсвөөр санхүүждэг сургуулийн сурагчдын өдрийн хоолыг ОХУ-ын субъектийн төрийн эрх барих байгууллагаас тогтоосон журам, нөхцөлийн дагуу, орон нутгийн төсвөөс санхүүждэг сургуулийн сурагчдын өдрийн хоолны зардлын орон нутгийн удирдлагын байгууллагаас тус тус санхүүжүүлнэ." гэж заажээ.*

Мөн хуулийн 28.7-д[272] Боловсролын байгууллага нь сурагч болон боловсролын

---

[271] Закон об Образовании в РФ, 2012 http://zakon-ob-obrazovanii.ru

[272] Образовательная организация несет ответственность в установленном законодательством Российской Федерации порядке за невыполнение или ненадлежащее выполнение функций, отнесенных к ее компетенции, за реализацию не в полном объеме образовательных программ в соответствии с учебным планом, качество образования своих выпускников, а также за жизнь и здоровье обучающихся, работников

байгууллагын ажилтны амь, нас эрүүл мэндэд хариуцлага хүлээхээр заасан байна. Хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй, зөрчсөн боловсролын байгууллага болон түүний удирдлага нь ОХУ-ын захиргааны зөрчлийн тухай хуульд заасан захиргааны хариуцлага хүлээнэ. Ийнхүү сургуулийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээг гэрээт байгууллага хэрэгжүүлсэн ч тухайн сургууль болон удирдлагууд нь сурагчдыг хоолны зохион байгуулалтад хариуцлага хүлээнэ.

Холбооны гүйцэтгэх засаглалын эрүүл мэнд, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, хүн амын эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналттай холбоотой хууль тогтоомжийг[273] судалж үзэхэд сурагчдын хоолны үйлдвэрлэлтэй холбоотой асуудлыг гол төлөв эрүүл ахуй, халдвар хамгааллын дадлын дүрмүүдээр зохицуулсан байна.

Сургуулийн хоолны эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын асуудлаар Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, нийгмийн хамгааллын албаны дарга – ОХУ-ын Улсын эрүүл ахуйн ерөнхий эмчийн тогтоолоор холбогдох норм, дүрмүүд[274], Ерөнхий боловсролын бага, бүрэн дунд боловсролын сургуулийн сурагчдын хооллолтыг зохион байгуулахад тавигдах эрүүл ахуй, халдвар хамгааллын шаардлагыг[275] баталсан байна.

Түүнчлэн, эрүүл ахуй, халдвар хамгааллын дадлын дүрмийн хүрээнд сурагчдын хоолны зохион байгуулалтад дараах шаардлагуудыг баримтлахаар заасан байна.

1. Нийтийн хоолны үйлдвэрлэл, тэдгээрийн түүхий эд, хүнсний бүтээгдэхүүнийг бэлтгэх, эргэлтэд оруулах (худалдах, худалдан авах)-ад тавигдах ерөнхий эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын шаардлагууд.[276]
2. Түргэн муудах хүнсний бүтээгдэхүүний хадгалах хугацаа, хадгалах нөхцөлд тавигдах эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын шаардлагууд.

Сургуулийн хоолны үйлчилгээ, үйлдвэрлэлд тавигдах шаардлага, хүүхдийн хоолны хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал, үйлдвэрлэл, хадгалалт, тээвэрлэлт, боловсруулалт болон дахин боловсруулах нь техникийн шаардлагуудаар зохицуулагдаж байна.

Нийтийн хоол үйлдвэрлэлийн ерөнхий зохион байгуулалтыг "Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай хууль"-ийг хэрэгжүүлэх ОХУ-ын Засгийн газрын тогтоолоор батлагдсан Хоолны үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад тавигдах нийтлэг шаардлагаар

---

образовательной организации. За нарушение или незаконное ограничение права на образование и предусмотренных законодательством об образовании прав и свобод обучающихся, родителей (законных представителей) несовершеннолетних обучающихся, нарушение требований к организации и осуществлению образовательной деятельности образовательная организация и ее должностные лица несут административную ответственность в соответствии с Кодексом Российской Федерации об административных правонарушениях.

[273] Федеральный закон «О санитарно-эпидемиологическом благополучии населения» от 03.03.1999 г. № 52-ФЗ;
- Федеральный закон «О защите прав потребителей» от 07.02.1992 г. № 2300-1-ФЗ;
- Федеральный закон «О качестве и безопасности пищевых продуктов» от 02.01.2000 г. № 29-ФЗ;
- Федеральный закон «О техническом регулировании» от 27.12.2000г. №184-ФЗ;
- Технические регламенты Таможенного союза на пищевые продукты;
- СанПиН 2.3.2.1940-05 «Организация детского питания»;
- СанПиН 2.3.2.1078-01 «Гигиенические требования к безопасности и пищевой ценности пищевых продуктов»;
- СП 1.1.1058-01 «Организация и проведение производственного контроля за соблюдением санитарных правил и выполнением санитарно-противоэпидемических (профилактических) мероприятий»;
- СП 2.3.6.1079-01 «Санитарно-эпидемиологические требования к организациям общественного питания, изготовлению и оборотоспособности в них продовольственного сырья и пищевых продуктов»;
- МР 2.4.5.0107-15 «Организация питания детей дошкольного и школьного возраста в организованных коллективах»;

[274] "О введении в действие санитарно – эпидемиологических правил и нормативов СанПиН 2.4.2.1178-02", СанПиН 2.4.5.2409-08;

[275] "Санитарно-эпидемиологические требования к организации питания обучающихся в общеобразовательных учреждениях, учреждениях начального и среднего профессионального образования" (от 23 июля 2008г. № 45);

[276] "О введении в действие санитарных правил" (вместе с Санитарно-эпидемиологическими правилами "Санитарно-эпидемиологические требования к организациям общественного питания, изготовлению и оборотоспособности в них пищевых продуктов и продовольственного сырья".

зохицуулж байна.

Дээрх шаардлагууд нь хэрэглэгч болон нийтийн хоолны үйлдвэрлэгч/үйлчилгээ үзүүлэгч хоёрын хоорондын харилцаа, хэрэглэгчдэд шаардлага хангасан, эрүүл мэнд, амь насанд аюулгүй үйлчилгээ авах, үзүүлж буй үйлчилгээ болон үйлчилгээ үзүүлэгч/нийлүүлэгчдийн талаарх мэдээ, мэдээллийг авах зэрэгтэй холбоотой эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлыг журамласан байна. Дээрх шаардлага, дүрмүүд нь нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд оролцогч бүхий л хэлбэр бүхий субъектуудад хамаарна. Дээрх дүрмүүдэд нийтийн хоол үйлдвэрлэгч болон хэрэглэгч хоёрын хоорондын харилцаа гэрээний үндсэн дээр явагдахыг заасан байна.

Нийтийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээ үзүүлэх ерөнхий дүрэмд боловсролын байгууллагатай холбоотой тусгай заалт, хязгаарлалт тусгаагүй байна.

ОХУ-ын орчин үеийн практикт ерөнхий боловсролын сургуулиудад дараах хоёр хэлбэрээр сургуулийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээг үзүүлж байна. Эхний тохиолдолд гуравдагч этгээд (гэрээт нийлүүлэгч) сургуулийн хоолны газарт хоол, хүнсний бүтээгдэхүүн нийлүүлж, сургуулийн хоолны газар нь өөрийн гал тогоондоо хоолоо бэлтгэх. Нөгөө хувилбар нь гуравдагч этгээд (гэрээт нийлүүлэгч) нь хоолны үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой бүхий л асуудлыг хариуцах байна.

Дээрхээс үзэхэд сургууль, цэцэрлэгийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээг сургуулийн хоол хүнсний комбинат, боловсролын байгууллагын цайны газар, буфет болон нийтийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлсэн компаниуд гүйцэтгэж байна. Хоол хүнсний бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэгч нь боловсролын байгууллагатай гэрээ байгуулахдаа хоол, хүнсний бүтээгдэхүүний чанар, хадгалалтын горим, тээвэрлэлт зэргийг хариуцдаг бол сурагчдын хоолыг сургууль дээр бэлтгэх тохиолдолд хоол, хүнс хадгалалтын горим, үйлдвэрлэлийн технологийг сургуулийн удирдлага хариуцдаг байна. Гуравдагч этгээд бэлэн бүтээгдэхүүнээр хангах тохиолдолд бүтээгдэхүүний чанар, үйлдвэрлэлийн технологи, хангамж зэрэг асуудлыг нийлүүлэгч хариуцах хэдий ч гэрээ байгуулсан сургууль нь мөн адил хариуцлага хүлээнэ. Сургуулийн эрүүл мэндийн ажилтнууд нь бүтээгдэхүүний чанар болон боловсруулалтад хяналт тавьж ажиллана.

*Зураг 4. ОХУ-ын Сургуулийн хоолны үйлдвэрлэлийн тогтолцоо, оролцогч талууд*




*Эх сурвалж: School Feeding in APEC Economies, APEC Subcommittee on Standards and Conformance, 2012*

## СЛОВЕНИ

Словени Улс нь Сургуулийн хоол тэжээлийн тухай анхны хуулийг 1953 онд баталсан бөгөөд тухайн цагаас хойш бага, дунд сургуулийн бүх сурагчдыг хоол хүнсээр хангаж, хүүхдийн эрүүл мэндэд хөрөнгө оруулалт хийж ирсэн байна. Дэлхийн хоёрдугаар дайны дараагаар Словенийн бүх бага сургуулиуд нь сургуулийн гал тогоо, хоолны танхимтай болсон байна.

2010 онд батлагдсан Словенийн Сургуулийн хоолны тухай хуульд 2013 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан, мөн хуульд тусгагдсан Цэцэрлэгийн эрүүл хоол тэжээлийн Үндэсний Хоолны удирдамж (2005) нь Үндэсний сургуулийн хоолны хөтөлбөрийн стандартыг тогтоож өгсөн ба тус хөтөлбөрийн хүрээнд сургуулийн бүх сурагчдыг өдөр бүр хоол тэжээлийн тэнцвэртэй хоолоор хангах ёстой. Сургуулийн хоол нь гол төлөв үдийн цай, эсхүл хоол байх ба илчлэг, шим тэжээлийн агууламжид тавигдах шаардлага болон хэрэглэвэл зохих болон хэрэглэхээс татгалзвал зохих хоол, хүнсний жагсаалтад нийцсэн байна.

Сургууль, цэцэрлэг болон бусад байгууллагууд хоол бэлтгэхдээ Ерөнхий боловсролын үндэсний зөвлөлийн экспертүүдээс боловсруулан гаргасан мэргэжлийн удирдамжийг даган мөрдөнө. 2010 онд батлагдсан Словенийн Сургуулийн хоолны тухай хуулиар сургуулийн орчинд хоол, хүнсний автомат машин байрлуулахыг хориглосон ба үйлдвэрлэгч, нийлүүлэгчид тус заалтыг эсэргүүцэн Үндсэн хуулийн шүүхэд маргаан үүсгэсэн ч шүүх хориглосон заалтыг хэвээр үлдээсэн байна.

### СУРГУУЛИЙН ХООЛНЫ ТУХАЙ ХУУЛЬ<br>/SCHOOL MEALS ACT 2012/[277]

*(Албан бус орчуулга)*

**Нийтлэг үндэслэл**

**1 дүгээр зүйл. Хуулийн зорилго**

Энэхүү хуулийн зорилго нь сурагчдын сургуулийн хоолыг зохион байгуулах, сурагчдын хөнгөлөлттэй хоолоор хангах эрх, сургуулийн хоолонд олгох хөнгөлөлт, татаасын хэмжээ, нөхцөлийг тодорхойлох, хуулийн хэрэгжилтийг хянахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ**

1. Энэхүү хууль нь бага, дунд сургууль болон тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхэд, залуучуудад бүх нийтийн боловсрол олгодог сургуулиудыг хамарна.
2. Энэхүү хууль нь насанд хүрэгчдийн боловсролын хөтөлбөрт хамрагсдад үйлчлэхгүй.
3. Тус хуулийн 4.6, 4.8-р заалт, 19-20-р зүйл нь цэцэрлэгт хамаарна.

**3 дугаар зүйл. Хуулийн зорилт**

Энэхүү хуулийн зорилт нь:

- Тогтвортой хэрэглээний зарчмыг харгалзан, сургуулийн хоолны шим тэжээлийн чанарыг хангах замаар сурагчдын хөгжлийг дэмжих, эрүүл зөв хооллолт болон хоолны соёлын талаарх ойлголтыг дээшлүүлж, өөрийн үүрэг хариуцлага (өөрийн эрүүл мэнд болон байгаль орчинд хариуцлагатай хандах)-ыг ухамсарлуулах, сурагчдад сургуулийн эрүүл хоолоор хангагдах нөхцөлийг бүрдүүлэх;
- Дээрх зорилтыг хэрэгжүүлэхэд амьдралын боломж муутай өрхийн сурагчдыг адил тэгш боломжоор хангана.

**Сургуулийн хоолны зохион байгуулалт**

**4 дүгээр зүйл. Сургуулийн хоол**

1. Энэхүү хуульд заасан “сургуулийн хоол” гэж сургуулийн хичээлийн хуваарийн дагуу явагдах хичээлийн өдөр сургуулиас өгч буй хоолыг хэлнэ.

---

[277] https://www.uradni-list.si/glasilo-uradni-list-rs/vsebina/111596

2. Сургуулийн хоолонд өглөөний цай, үдээс өмнөх зууш, үдийн хоол, үдээс хойших зууш багтана.

3. Сургуулиуд нь төрөөс үзүүлэх үйлчилгээний хүрээнд бүх сурагчдыг хөнгөн хоолоор хангана. Сургуулиуд нь сурагчдад халуун хоол, эсхүл шим тэжээлтэй, илчлэг хүйтэн зуушаар хангана.

4. Сургуулиуд нь нэмэлтээр өглөөний цай, үдийн хоол, үдээс хойших зуушаар хангаж болно. Сургуулиуд нь өөрсдийн боломж бололцооныхоо хэмжээгээр сурагчдыг нэмэлт хоолоор хангана.

5. “Бага, дунд сургуулийн үдийн цайны үнэ” - сургуулиас сурагчдад санал болгож буй үдийн цайны үнийг хэлнэ. Хоолны үнийг хичээлийн жилийн эхэн бүрт Боловсролын асуудал хариуцсан сайд тогтооно (Цаашид “Сайд” гэх). 4 дэх хэсэгт заасан бусад үйлчилгээний үнийг сургууль тогтооно.

6. Сургуулийн хоолыг зохион байгуулахад Словенийн Шинжээчдийн зөвлөлөөс баталсан Ерөнхий боловсролын байгууллага дахь хооллолтод баримтлах удирдамжийг баримтлах ба дараахыг тусгана. Үүнд:

- сургуулийн хоол, шим тэжээлтэй холбоотой зорилго, баримтлах зарчим, боловсролын үйл ажиллагаа;
- хоол, хүнсний бүтээгдэхүүнийг сонгох, хоол төлөвлөх, хоолны хэмжээ болон бэлтгэх арга, хугацаа зэргийг тогтоосон Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн яамны Нийтийн эрүүл мэндийн газраас баталсан мэргэжлийн удирдамж, аргачлалууд.

7. Сургууль нь жилийн төлөвлөгөөндөө сурагчдын эрүүл хооллолт, хоол, шим тэжээлийн боловсролтой холбоотой үйл ажиллагааг тусгана.

8. 2-р зүйлд заасан боловсролын байгууллагын барилга, байгууламж, орчин тойронд хоол, ундаа борлуулах автомат машин байрлуулахыг хориглоно.

9. Боловсролын байгууллагын ажилтнуудад зориулсан барилга, байгууламжид халуун ундаа борлуулах автомат машин байрлуулж болно.

**5 дугаар зүйл. Зохион байгуулалт**

1. Сургуулиуд нь хоол, хүнс худалдаж авах, боловсруулах, шаардлагатай баримт бичгийн хөтлөх, хоол, шим тэжээлтэй холбоотой боловсролын үйл ажиллагаа явуулах болон бусад ажлыг зохион байгуулна.

2. Сургууль нь сургуулийн хоолны худалдан авалт, боловсруулалт болон түгээлт зэргийг бусад боловсролын байгууллагад гэрээний үндсэн дээр шилжүүлж болно. Дээрх сургуулийн хоол, шим тэжээлтэй холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудлыг гэрээгээр хүлээсэн боловсролын байгууллага нь энэхүү хуульд заасан журам, нөхцөлийн дагуу үйл ажиллагаа явуулна.

3. Онцгой тохиолдолд сургууль нь сургуулийн хоол, хүнсний худалдан авалт, боловсруулалт, түгээлт зэргийг худалдан авах ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжид заасны дагуу гэрээний үндсэн дээр бусад байгууллагаар гүйцэтгүүлж болно. Сургууль нь ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг явуулахаас өмнө сургуулийн зөвлөлөөс зөвшөөрлийг авна.

4. 3 дахь хэсэгт дурдсан ажил гүйцэтгэгч нь боловсролын үйл ажиллагаатай холбоогүй хуулийн этгээд, эсхүл хувь хүн байж болно.

5. Захирал нь сургуулийн хоол, шим тэжээлийн асуудлаар санал, зөвлөмж гаргах Хоол, шим тэжээлийн бүлэг/зөвлөлийг томилж болно.

**6 дугаар зүйл. Сургуулийн хоолны талаар баримтлах дүрэм**

1. Сургууль нь сургуулийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой тоо, мэдээ, хоол үйлдвэрлэх, үйлчлэхэд шаардагдах хугацаа, арга зүй зэргийг Сургуулийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээнд баримтлах дүрмээр нарийвчлан тогтооно.

2. Сургууль нь Хоол, шим тэжээлийн бүлэг/зөвлөлтэй тохиолдолд тэдгээрийн бүтэц, бүрэлдэхүүн, эрх үүргийн Сургуулийн хоолны талаар баримтлах дүрмээр тогтооно.

3. Сургуулийн хоолны талаар баримтлах дүрмийг сургуулийн захирал боловсруулж, эцэг, эхийн зөвлөл, багш сурагчдаар хэлэлцүүлнэ. Дүрмийг сургуулийн хамт олон батална.

4. Сургуулийн хоолны талаар баримтлах дүрэм нь Сургуулийн дүрмийн нэг хэсэг байж болно.

**7 дугаар зүйл. Сургуулийн хоолны зардал**

1. Сургуулийн сурагч, эсхүл түүний эцэг, эх сургуулийн хоолны зардлыг хариуцна.
2. Сургуулийн хоолны үнийг орон нутаг/хот, донор болон бусад эх үүсвэрээс хандив, санхүүжилт олгосон тохиолдолд бууруулж болно.

**8 дугаар зүйл. Сургуулийн хоолны үйлчилгээнд бүртгүүлэх**

1. Эцэг, эх, асран хамгаалагч, болон хүүхдийн харгалзан дэмжигч бусад иргэд нь сургуулийн хоолны үйлчилгээ авах өргөдөл гаргана.
2. Сургуулийн хоолны үйлчилгээ хүссэн өргөдлийн загварыг Сайд батлах ба тус баримт бичгийг жилийн турш хадгална.
3. Дээрх өргөдлийг аль ч үед хүчингүй болгож болох ба өргөдлийн буцаан авах тухай хүсэлт хүлээж авсны дараах өдрөөс хүчингүйд тооцно.

**9 дүгээр зүйл. Сургуулийн хоолноос татгалзах**

1. Сурагч нь сургуулийн хоолны үйлчилгээнээс татгалзаж болно.
2. Сурагчийн эцэг, эх нь сурагчийн өдрийн хоолыг өөрсдөө бэлтгэж өгөх тухай мэдэгдэх хуудсаар мэдээлнэ.
3. Сурагч нь сургуулийг төлөөлөн спортын тэмцээн, соёл, урлагийн арга хэмжээнд оролцох тохиолдолд тухайн өдрийн хоолыг олгохгүй.

**10 дугаар зүйл. Үүрэг**

Сургуулийн хоолны үйлчилгээнд бүртгүүлснээр сурагч, эцэг, эх нь дараах үүргийг хүлээнэ:

- Сургуулийн хоолны талаар баримтлах дүрмийг дагаж мөрдөх, хүндэтгэх;
- Сургуулийн хоолны дүрэмд заасны дагуу сургуулийн хоолоор үйлчлүүлэхгүй тухайгаа цаг тухайд нь мэдээлэх.

**11 дүгээр зүйл. Сургуулийн хоолны талаар баримтлах дүрмийг сурагч, эцэг, эхчүүдэд танилцуулах**

Сургууль нь хичээлийн жилийн эхэнд сургуулийн хоолны зохион байгуулалт, сургуулийн хоолны талаар баримтлах дүрэм, сургуулийн хоолонд олгох татаас, хөнгөлөлт зэргийн талаар Сургуулийн хоолны талаарх баримтлах дүрэмд заасан журмын дагуу танилцуулна.

**12 дугаар зүйл. Хэрэглээгүй хоол, хүнс**

Тогтоосон хугацаанд хэрэглээгүй хоол хүнсийг сургууль нь бусад сурагчдад үнэ төлбөргүй тараах, эсхүл хүмүүнлэгийн байгууллагын жагсаалтад бүртгэлтэй хүмүүнлэгийн байгууллагад тарааж болно.

**13 дугаар зүйл. Үдийн цайнд олгох татаас**

1. Сургуулийн үдийн цайнд олгох татаас нь үдийн цайны үнийн 2/3, болон үдийн цайны нэмэлт 1/3 татаасаас бүрдэнэ.
2. Улсын төсвөөс амьдралын боломж муутай өрхийн сурагчдад сургуулийн үдийн цайны санхүүжилтэд татаас олгоно.

**14 дүгээр. Татаас хүлээн авагч**

1. Сургуулийн хоолны татаас авах эрх бүхий сурагч нь хууль тогтоомжоор татаас, тэтгэмж авах эрх бүхий, сургуульд тогтмол хамрагддаг, татаас авах хүсэлт гаргасан сурагч байна.
2. Дээр дурдсаныг үл харгалзан ерөнхий болон нэмэлт татаасыг тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай боловсролын байгууллагын сурагчид, эсхүл гэрээр, сургуулиас гадуур боловсролын байгууллагад суралцдаг сурагч байна.
3. 1-2-т дурдсан сурагчид нь сургуульд хамрагдсан өдөр тутам болон сургуулийн хичээлийн хуваарийн дагуу зохион байгуулагдсан заавал оролцох бусад хөтөлбөрт хамрагдах тохиолдолд сургуулийн хөнгөн үдийн хоол татаас авах эрхтэй байна.

**15 дугаар. Үдийн хоолны татаас**

1. Улсын төсвөөс сургуулийн хоолыг үнээр нь худалдан авах боломжгүй, бололцоогүй сурагчдад татаас олгоно.

2. Үдийн хоолны тэтгэмж авах орлогын хэмжээ, нөхцөл зэргийг төрөөс дэмжлэг авах асуудлыг зохицуулсан хууль журмыг баримтална.

**17 дугаар зүйл. Сургуулийн хоол тэжээлийн баримтжуулалт**

1. Сургууль нь сургуулийн хоолны үйлчилгээ авагч сурагчдын дараах мэдээллийг бүртгэнэ. /2-4-р заалтад Сурагчийн хувийн мэдээллийг ашиглахтай холбоотой болон тэтгэмж, татаастай холбоотой мэдээллийг тусгасан/

5. Сургууль нь сургуулийн хоолтой холбоотой тоо, мэдээг холбогдох яаманд жилд нэг удаа хүргүүлнэ.

6. Энэхүү заалтад заасан мэдээллийг хувийн нууцын тухай хууль тогтоомжийн дагуу цуглуулж, ашиглаж, хадгална. Яам нь энэхүү хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор зөвхөн нийт дүн, мэдээ, статистикийг ашиглана.

7. Статистик дүн мэдээнд сурагч, эцэг, эхийн талаарх хувийн мэдээллийг (овог, нэр) ил болгохгүйгээр ашиглаж болно.

8. Холбогдох статистик тоо мэдээг 5 жил хадгална.

**18 дугаар зүйл. Татаас олгох**

Сургууль нь татаас авахтай холбоотой өмнөх сарын тоо мэдээг дараа сар бүрийн 10-ны дотор Яаманд хүргүүлнэ. Сургуулийн хоол, үдийн цайны татаастай холбоотой дараах мэдээллийн нийт дүнг:

- Бүртгүүлсэн сурагчдын тоо;
- Хөнгөлөлттэй үнээр олгосон хоолны тоо;
- Татгалзсан сурагчдын тоо;
- Өвчтэй, эсхүл бусад шалтгаанаар хоолны үйлчилгээнд хамрагдаагүй сурагчдын тоо.

**Хяналт үнэлгээ**

**19 дүгээр зүйл. Дотоод мониторинг**

Сургуулийн хичээлийн жилийн хугацаанд сурагч, эцэг, эхчүүдээс сургуулийн хоолны чанар, хоол, шим тэжээлийн боловсролын хүрээнд хийгдэж буй арга хэмжээ, үйл ажиллагааны сэтгэл ханамжийн судалгаа явуулна.

**20 дугаар зүйл. Мэргэжлийн хяналт**

Сургуулийн хоолыг 4.6-д заасан мэргэжлийн удирдамжуудад нийцэж байгаа эсэхэд мэргэжлийн хяналт тавьж, сургуулиудад зохих зөвлөмж гаргана. Мэргэжлийн хяналтыг нийтийн эрүүл мэндийн хяналтыг хэрэгжүүлэгч төрийн байгууллагаас төлөвлөж, хэрэгжүүлнэ. Тодорхой боловсролын байгууллагад мэргэжлийн хяналт, шалгалтыг Боловсрол, шинжлэх ухаан, спортын яамны Боловсрол, спортын хяналтын газрын санаачилгаар явуулж болно. (Inspectorate of the Republic of Slovenia for Education and Sport)

**21 дүгээр зүйл. Дотоод хяналт**

Захирал нь ажил гүйцэтгэгч, эсхүл бусад боловсролын байгууллагын гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавина. Захирал нь илрүүлсэн зөрчлийг арилгуулах шаардлагыг ажил гүйцэтгэгчид бичгээр гаргана. Гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэгч шаардлагыг биелүүлээгүй бол сургууль нь гэрээгээ цуцлах эрхтэй байна.

**22 дугаар зүйл. Гадаад/Хөндлөнгийн хяналт**

Боловсрол, спортын хяналтын газар сургуулийн сургуулийн хоолны үйлдвэр, үйлчилгээтэй холбоотой холбоотой асуудлаар хяналт тавьж, бусад эрх бүхий хяналтын байгууллага нь өөрсдийн эрх мэдлийн хүрээнд даарах хяналт тавина.

- Энэхүү хуульд заасан хөрөнгийн зарцуулалт зорилгын дагуу зарцуулагдсан эсэхэд төсвийн хяналт,

- Хувийн мэдээллийн хамгаалалтын асуудлаар хуульд заасан зохицуулалтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий мэдээллийн ажилтан.

**Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

**23 дугаар зүйл. Торгууль**

1. Сургуулийн байцаагч (School Inspector) нь 1000-2000 хүртэлх еврогийн хэмжээтэй торгуулийг дараах хөнгөн гэмт хэрэг /misdemeanour/ үйлдсэн сургуульд ногдуулна.

- Сургуулийн хоолны үйлчилгээ үзүүлдэггүй, сургуулийн жилийн төлөвлөгөөндөө хоолны зөв дадал зуршил, шим тэжээлийн боловсролтой холбоотой үйл ажиллагаа тусгаагүй.
- 4.5-д заасан хоолны зардлыг харгалзан үзээгүй;
- 8.8-9-т заасныг зөрчин хүнс, ундааны автомат машин суурилуулсан;
- Ажил гүйцэтгэгчтэй холбогдох зөвшөөрөл авалгүй гэрээ байгуулсан;
- Сургуулийн хоолны шим, тэжээлийн баримтжуулалт үйлдээгүй;
- Төрөөс хоолны татаас, тэтгэмж авахад хуурамч мэдээлэл бүрдүүлсэн.

2. Сургуулийн байцаагч нь 500-1000 хүртэлх еврогийн хэмжээтэй торгуулийг дараах хөнгөн гэмт хэрэг /misdemeanour/ үйлдсэн этгээдэд ногдуулна.

- Сургуулийн хоолны үйлчилгээ үзүүлдэггүй, сургуулийн жилийн төлөвлөгөөндөө хоолны зөв дадал зуршил, шим тэжээлийн боловсролтой холбоотой үйл ажиллагаа тусгаагүй;
- 4.5-д заасан хоолны зардлыг харгалзан үзээгүй;
- 8.8-9-т заасныг зөрчин хүнс, ундааны автомат машин суурилуулахыг зөвшөөрсөн;
- Ажил гүйцэтгэгчтэй холбогдох зөвшөөрөл авалгүй гэрээ байгуулсан;
- Сургуулийн хоолны үйлчилгээ авагч сурагчдын жагсаалтыг гаргаагүй;
- Төрөөс хоолны татаас, тэтгэмж авахад хуурамч баримт бүрдүүлсэн.

3. Сургуулийн байцаагч нь 100-200 хүртэлх еврогийн хэмжээтэй торгуулийг дараах хөнгөн гэмт хэрэг /misdemeanour/ үйлдсэн сургуулийн ажилтанд ногдуулна.

- Сургуулийн хоолны дүрэмд санал өгөөгүй;
- Дотоод мониторинг явуулаагүй;
- Ажил гүйцэтгэгчийн үйл ажиллагааг хянаагүй, зөрчил илрүүлсэн тохиолдолд арилгуулах арга хэмжээ аваагүй, сануулга өгөөгүй.

24 дүгээр зүйлд сургуулийн үдийн цайны үнийн талаар шийдвэр хүчин төгөлдөр үйлчилж эхлэх талаар, 25 дугаар зүйлд Үдийн цайны татаас олгох шалгуур, өрхийн орлогын хэмжээг, 26 дугаар зүйлд Үдийн хоолны татаас олгох шалгуур, өрхийн орлогын хэмжээг тус тус нарийвчлан заасан байна.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ


*Судалгааны тайлан:*

- Schools as a System to Improve Nutrition: A new statement for school-based food and nutrition interventions, United Nations System Standing Committee on Nutrition, 2017
- School meals in Europe, Report by the Polish Eurydice Unit, 2016
- Global School Feeding Sourcebook, Lessons from 14 countries, Imperial College Press, 2016
- Country profiles on across the EU28 national school food policies plus Norway and Switzerland, European Commission, 2015
- Policies and Guidelines Shaping the School Food Environment, A Review of the Literature, Nutrition Resource Centre, 2015
- The State of School Feeding Worldwide 2013, World Food Programme
- School Feeding in APEC Economies, APEC Subcommittee on Standards and Conformance, 2012

*Япон*

- http://www.mext.go.jp/en/
- http://school-lunch-support.jp/en/act/
- http://school-lunch-support.jp/en/implementation-standards/
- http://www.mext.go.jp/english/museumofmext/ ; http://www.mext.go.jp/joho-hiroba/rooms/kyouiku.htm
- https://pdfs.semanticscholar.org/010c/4141daaa8ac20a0abde52591b78cf75199ac.pdf
- https://www.nier.go.jp/English/educationjapan/pdf/201303SLP.pdf
- The Japanese School Lunch and Its Contribution to Heath, Nutrition today, Dcember 2015
- https://www.japanfs.org/en/news/archives/news_id035892.html

*БНХАУ*

- https://apec.org/-/.../APEC/.../Research-School-Feeding-in-APEC-Economies/2012_scs

*БНСУ*

- https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=29851&lang=ENG
- https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=31660&lang=ENG
- https://apec.org/-/.../APEC/.../Research-School-Feeding-in-APEC-Economies/2012_scs
- http://www.koreaherald.com/view.php?ud=20160824000869
- http://www.loc.gov/law/foreign-news/article/south-korea-coffee-banned-in-schools/

*ОХУ*

- Федеральный закон от 29.12.2012 № 273-ФЗ «Об образовании в Российской Федерации».
- https://www.menobr.ru/article/65396-qqq-18-m1-organizatsiya-pitaniya-v-shkole?from=PW_Timer_other&ustp=W
- https://www.audit-it.ru/articles/account/otrasl/a100/916425.html
- http://www.kremlinrus.ru/news/165/77186/
- http://39.rospotrebnadzor.ru/content/organizaciya-pitaniya-v-shkole

*Словени Улс*

- https://www.uradni-list.si/glasilo-uradni-list-rs/vsebina/111596
- http://www.nycfoodpolicy.org/slovenia-school-nutrition-law/

# БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦОО БА ҮНДЭСНИЙ ӨВ, СОЁЛЫГ СУРГАЛТЫН АГУУЛГА, ХӨТӨЛБӨРТ ТУСГАСАН БАЙДЛЫН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

(Харьцуулсан судалгаа)

*Д.Халиун, Б.Нандингэрэл*
*И.Жаргалзаяабямба*

## АГУУЛГА

УДИРТГАЛ

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦОО БОЛОН ҮНДЭСНИЙ ӨВ, СОЁЛЫГ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ТУСГАСАН БАЙДЛЫН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

- БНСУ
- СИНГАПУР
- ЯПОН
- ФИНЛАНД
- НОРВЕГ
- КАНАД
- ХБНГУ
- ЭСТОНИ
- ШИНЭ ЗЕЛАНД
- НИДЕРЛАНД

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

## УДИРТГАЛ

***Судалгааны хамрах хүрээ:*** Энэхүү судалгаагаар Олон улсын боловсролын үнэлгээний хөтөлбөр (PISA)[278]-ийн чанарын үнэлгээний эрэмбэд тогтмол дээгүүр байр эзэлдэг БНСУ, Канад, Нидерланд, Норвег, Сингапур, Финланд, ХБНГУ, Шинэ Зеланд, Эстони, Япон зэрэг улсын ерөнхий боловсролын тогтолцооны талаар судалсан болно. Судалгааны сэдвийн хүрээнд дээрх орнуудын ерөнхий боловсролын тогтолцоо (сургуульд хүүхдийг хэдэн наснаас хамруулдаг, гадаад хэлийг хэдэн наснаас заах эхэлдэг, ерөнхий боловсролын сургалтын агуулга буюу сургалтын хөтөлбөр, сурах бичигт үндэсний өв, соёлыг ямар хувь хэмжээтэй тусгадаг гэх мэт)-ны асуудлуудыг холбогдох хууль эрх зүйн орчны хүрээнд судаллаа. Судалгааны дүнг Хүснэгт 2-т хураангуйлан үзүүлэв.

***Судалгааны үр дүнгийн тойм:*** НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага (ЮНЕСКО)-ын тоо мэдээнээс үзэхэд дэлхийн 218 улсаас хүүхдийг 6 наснаас нь эхлэн сургуульд хамруулдаг - 151 улс, 5 наснаас эхлэн хамруулдаг - 31 улс, 7 наснаас эхлэн хамруулдаг- 36 улс байна.

*Хүснэгт 1. Дэлхийн улс орнууд сургуульд хүүхдүүдийг хэдэн наснаас хамруулдаг*

| № | Бага сургуульд хамрагдах эхлэх нас | Улсын тоо, хувь | Улсын нэр |
|---|---|---|---|
| **1** | 5 нас | **31 улс -** 14 хувь | Австрали, Ирланд, Мальт, Мьянмар, Непал, Шинэ Зеланд, Пакистан, Их Британи зэрэг |
| **2** | 6 нас | **151 улс -** 69 хувь | АНУ, Австри, Бельги, Канад, Хятад, Хонконг, Макао, Кипр, Чех, Дани, Франц, Гүрж, ХБНГУ, Грек, Исланд, Израил, Итали, Япон, Люксембург, Малайз, Нидерланд, Норвег, БНСУ, Сингапур, Словак, Словени, Турк, Украйн зэрэг |
| **3** | 7 нас | **36 улс -** 17 хувь | Афганистан, Болгар, Хорват, БНАСАУ, Эстони, Финланд, Унгар, Индонез, Казахстан, Кыргыз, Латви, Лихтенштейн, Литва, Польш, Молдов, ОХУ, Серби, Өмнөд Африк, Швед, Швейцар, Узбекистан зэрэг |

*Эх сурвалж: НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага, 2016*[279]

### Ерөнхий боловсролын тогтолцоо

Дэлхийн улс орнуудын ерөнхий боловсролын тогтолцоонд сүүлийн 15-20 жилийн хугацаанд хэд хэдэн үзүүлэлтээр "ижилсэх" хандлага ажиглагдаж ирсэн. Эдгээр үзүүлэлтийн тоонд: ерөнхий боловсролын сургалтын үргэлжлэх хугацаа (12 жилийн сургалттай тогтолцоо давамгай), дунд боловсролын төгсөх ангиудад мэргэжлийн чиг баримжаа олгох, төгсөлтийн ерөнхий шалгалтын үндсэн дээр аттестатжуулах зэрэг байна.

Дэлхийн улс орнуудын хувьд дийлэнх буюу 80%-д нь ерөнхий боловсролын 12 жилийн тогтолцоотой байна. ОХУ болон зарим Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн орон (СНГ), Латин Америкийн зарим улс 11 жилийн тогтолцоотой байгаа бол франц, англи загварын тогтолцоо бүхий Ази, Африкийн орнууд голчлон 12 жилийн тогтолцоотой байна. Хамгийн түгээмэл хэлбэр нь бага боловсрол 4-6 жил, дунд болон ахлах сургуулиуд нь 3-5, 2-4 жил байна. Ийнхүү ерөнхий боловсролын дараах загварууд түгээмэл байна. Үүнд:

6+3+3=12 (хамгийн түгээмэл)
5+4+3=12
6+5+2=13

Финланд, Дани, Швед болон АНУ-ын зарим муж улсад бага боловсрол гэж тухайлан заадаггүй ба сургуулийн анхан шатны 8-9 жилийн тогтолцоог суурь боловсрол гэж тооцдог байна.

[278] https://www.theguardian.com/education/2014/may/06/oecd-pisa-tests-damaging-education-academics
[279] http://data.uis.unesco.org

***Мэргэжлийн чиг баримжаа олгох***. Хөгжингүй болон шилжилтийн эдийн засаг бүхий орнуудын дийлэнхэд сургуулийн ахлах ангиудын 2-4 жил (гол төлөв 3 жил)-ийн хугацаанд тодорхой чиглэлээр дагнан суралцах нь түгээмэл байх ба үүнийг боловсролын гэрчилгээнд тодорхой байдлаар тэмдэглэдэг байна. Их, дээд сургуульд элсэн суралцахад тодорхой чиглэлээр суралцаж төгссөн сурагчид давуу эрх эдлэх ба тухайн их, дээд боловсролын байгууллагын чиглэл нь сурагчийн сонгон суралцсан чиглэлээс зөрөх тохиолдолд нэмэлт шалгалт авах, эсхүл элсүүлдэггүй байна. Энэхүү тогтолцооны сонгодог жишээ нь Францын боловсролын тогтолцоо юм. Гурван жилийн лицейн сургалт нь тодорхой чиглэлүүдэд хуваагдах ба сурагчид сургуулиа төгсөхдөө тодорхой чиглэлээр суралцсан төгссөнийг гэрчлэх тэмдэглэгээ бүхий гэрчилгээ авна. Францын ерөнхий боловсролын сургуулийн гэрчилгээ, сургалтын чиглэл нь одоогийн байдлаар 7 салбарт хуваагдах ба үүнээс 3 салбар нь академик сургалт, 4 салбар нь мэргэжлийн чиглэлээр олгогддог байна. Бельги, ХБНГУ, Испани, Португал, Швед, АНУ-ын зарим муж, Ази, Африк, Латин Америкийн цөөнгүй орнуудад дээрхтэй ерөнхий боловсролын ахлах боловсролын тогтолцоотой байна.

Гадаадын улс орнуудад ерөнхий боловсролын төгсөх ангид мэргэжил олгоход чиглэсэн сургалтыг 3 хувааж үздэг. Нэгдүгээрт, тодорхой хичээл, бүлэг хичээлээр сургалт явуулдаг ИБУИНВУ, АНУ-ын зарим муж улс, Канад болон Азийн зарим улс ордог. Хоёрдугаарт, хамгийн түгээмэл дэлгэрсэн загвар буюу нийгэм, байгалийн ухаан, хүмүүнлэгийн ухаан, эдийн засаг, технологийн зэргээр хуваарилдаг Франц, Бельги, БНСУ болон бусад орнууд. Гуравдугаар загварт, ирээдүйд эзэмших мэргэжлийн чиглэээр сургалт явуулдаг ХБНГУ (хэсэгчлэн), Швед зэрэг орж байна. Практикт мэргэжил олгоход чиглэсэн сургалтын холимог тогтолцоо түгээмэл дэлгэрсэн байдаг ба энэ нь 2-3 үндсэн чиглэлийн хүрээнд сургалт явагдсаны дараагаар илүү мэргэшүүлсэн чиглэлд шилжих загвар юм.

***Олон үндэстний соёлын сургалт***. Үндэсний болон дэлхийн өв соёлын мэдлэг, үндэс суурийг тавих нь улс орон бүрийн сургуулийн боловсролын гол зорилтын нэг байдаг. Үүнийг түүх, уран зохион, философи, урлаг, дуу хөгжим зэрэг бага, дунд боловсролын хичээлийн агуулгад тусгах замаар хэрэгжүүлдэг. Өнөө цагт дэлхий дахинаа үндэсний өв соёлд чухал ач холбогдол өгөхөөс гадна “cross-culture” буюу олон соёлын боловсрол эзэмшүүлэхэд чиглэгдэж байгаа нь дэлхий дахинаа нийгэм, эдийн засгийн даяаршил эрчимтэй явагдаж байгаатай холбоотой. Үүнийг улс орнуудын ерөнхий боловсролын сургалтын төлөвлөгөөнд гадаад хэлний мэдлэг, сургалтад тавигдаж буй шаардлагаас харж болох юм. Тухайлбал, Европын Холбооны гишүүн орнуудад дунд боловсролын хүрээнд хоёр гадаад хэл сурах шаардлага тогтоон, гурав дахь гадаад хэл судлахыг хөхүүлэн дэмждэг. Түүнчлэн, дунд боловсролын төгсөх ангиудад, нэн ялангуяа хүмүүнлэгийн чиглэлээр суралцаж буй сурагчдад “дэлхийн шашин”, “дэлхийн соёл иргэншлүүд”, “соёл хоорондын харьцаа” зэрэг соёл иргэншлийн олон янз байдал, тэвчих үзэлд суурилсан хичээлүүд ордог байна. Дээрхтэй ижил, төстэй хичээлүүд АНУ, Япон, БНСУ, Сингапур зэрэг улсын ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрийн агуулгад туссан байна. Европын Холбооны Болонийн процесст хамрагдсан улс орнуудын ерөнхий боловсролын сургалтын төлөвлөгөө болон хичээлийн агуулгад европ өв соёлыг хадгалахад чиглэсэн, “европ хэв загвар/хэв шинж” оруулах үйл ажиллагаа хийгдэж ирсэн байна.

***Хичээлийн ачаалал, гэрийн даалгавар***. Сүүлийн жилүүдэд хөгжингүй улс орнуудад бага боловсролын хүрээнд хийгдэж буй шинэтгэлүүд нь хичээлийн ачааллыг бууруулах, хичээлийг илүү сонирхолтой, тоглоом, наадгай байдлаар явуулах, бие бялдрыг хөгжүүлэхэд чиглэсэн хичээлийн тоог нэмэгдүүлэхэд чиглэгдэж байна. Дунд, болон ахлах сургуулийн хүрээнд мөн хичээлийн ачааллыг бууруулж, бие даан судлах, сонголтоор судлах хичээлийн цагийг нэмэгдүүлж байна. Ихэнх улс орны хувьд гэрийн даалгавартай холбоотой асуудлыг харьцангуй ижил төстэй байдлаар зохион байгуулсан ба бага сургуульд гэрийн даалгавар төдийлөн өгдөггүй (Бельги, Франц Улсад хориглосон) бол дунд болон ахлах ангиудад гэрийн даалгаврын уламжлалт бүх хэлбэрүүд түгээмэл дэлгэрсэн байна.

***<u>Гадаад хэлний сургалт</u>***

Бага боловсролын хүрээнд хүүхдэд гадаад хэлийг нэгдсэн хөтөлбөрийн дагуу зааж

эхлэх насны хувьд:

- БНСУ-д бага сургуулийн 3 дугаар ангиас;
- Сингапурт бага сургуулийн 1 дүгээр ангиас англи болон эх хэл (малай, мандарин, тамил);
- Японд гадаад хэлийг 7-р ангиас; (гадаад хэл зааж эхлэхээс өмнө япон хэл, соёлыг бүрэн танин мэдсэний дараа гадаад хэл заах нь үр дүнтэй гэсэн бодлогыг баримталдаг байна).

Харин Европын орнуудын хувьд ерөнхий боловсролын сургууль дахь гадаад хэлний сургалт дараах байдалтай байна.

1995 оны Европын холбооны Цагаан баримт бичигт "суурь сургалтыг дүүргэснээр хүн бүр Холбооны 2 гадаад хэлийг эзэмшсэн байна" гэж заасан, 2000 оны Лисабоны Саммитаар гадаад хэлний мэдлэгийг 5 үндсэн чадварын тоонд оруулсан байна. 1990-ээд оноос олон улсын гадаад хэлний "**Common European Framework of Reference for Languages"** стандартыг нэвтрүүлж, гадаад хэлний сургалтыг ижилсүүлэх, уялдуулах ажлууд хийгдэж ирсэн байна.

1974 онд Европын холбооны гишүүн орнуудаас Ирланд, Их Британиас бусад бүх оронд заавал судлах хичээлийн тоонд нэг гадаад хэл орж байсан бол 1998 онд Ирландаас (Ирланд болон Англи хэл дээр хичээл явагдах боловч, аль нь ч гадаад хэлд тооцддоггүй, түүнчлэн гурав дахь гадаад хэлийг заадаг) бусад бүх оронд гадаад хэлний сургалт суурь боловсролын тогтолцоонд багтсан. Бельги, Франц, Дани, Нидерланд, Герман, Люксембург, Финланд, Швед, Исланд, Швейцар, Грек, Хорват, Кипр, Эстони, Латви, Литва, Польш, Румын, Серби, Словени болон Словак зэрэг улсын ахлах дунд боловсролын сургуулиудын сурагчид доод тал нь хоёр гадаад хэл судалдаг байна.

Европын хэмжээнд гадаад хэлний анхан шатны хичээл долоо хоногт 3-4 цагаар ордог ба бага сургуулийн төгсөлд, эсхүл дунд сургуулийн эхэнд гадаад хэл дээрх хичээлүүдийг зааж эхэлдэг байна. Люксембург, Норвег, Итали, Мальт зэрэг улсад нэгдүгээр гадаад хэлийг 6 наснаас, Шведэд 7 наснаас, Бельгид 10 наснаас тус тус зааж эхэлдэг байна. Европын Холбооны бага сургуулиудын тал хувьд нь гадаад хэлний сургалт явуулдаг байна.

Дунд сургуульд хамгийн түгээмэл заадаг гадаад хэл нь англи хэл байх ба Европын Холбооны гишүүн орнуудын сурагчдын 93 хувь нь англи хэл судалдаг байна. Ахлах дунд сургуулиудад англи хэлний хэрэглээ, сургалт илүү өргөн хүрээтэй явагддаг. Словениас бусад бүх Европын Холбооны гишүүн оронд франц хэлийг дунд сургуульд үздэг ба Европын Холбооны орнуудын дунд сургуулийн сурагчдын 33 хувь нь франц хэл судалдаг бол ахлах дунд сургууль тус үзүүлэлт 28 хувьтай байна. Герман хэлийг Европын Холбооны гишүүн улсын дийлэнхэд судалдаг ба дунд сургуулийн сурагчдын 13%, ахлах дунд сургуулийн 20% нь герман хэлийг судалдаг байна.

***<u>Үндэсний өв, соёлыг сургалтын хөтөлбөр, агуулгад тусгасан байдал</u>***

Судалгаанд хамрагдсан 10 улсын хувьд ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөр, агуулгад үндэсний өв соёлыг хэрхэн тусгасныг авч үзвэл эх хэл, уран зохиол, түүх, газар зүй, нийгмийн ухаан, дуу хөгжим зэрэг хичээлүүдээс гадна ёс зүй/ёс суртахууны хичээл (БНСУ, Япон), иргэний боловсролын хичээл (Сингапур), библи судлал (Норвег) зэрэг хичээлийн хөтөлбөрт туссан байна.

***Иргэний боловсролын хичээл***. Ерөнхий боловсролын сургуулийн Иргэний боловсролын сургалтад хийсэн үнэлгээ, мониторинг судалгааны тайланд "Иргэний боловсрол"[280]-ыг дараах байдлаар тайлбарласан байна. Иргэний боловсрол хэмээх ойлголт нь Civic education, Citizenship education хэмээх хоёр ойлголтоор илэрхийлэгддэг бөгөөд боловсролын харилцаанд янз бүрийн утгаар хэрэглэгдэж байна. Зарим судлаач "civic education" буюу иргэний боловсрол нь хүүхэд, залуучуудыг нийгмийн идэвхтэй гишүүн болгон бэлтгэх боловсролын салбар, харин "citizenship" буюу иргэншил нь тухайн

[280] Иргэний боловсролын сургуулийн Иргэний боловсролын сургалтад хийсэн үнэлгээ, мониторинг, Судалгааны тайлан, ННФ. УБ., 2011. 68-70 дахь тал

нийгмийн гишүүд иргэн болон төлөвших үйл явцыг тэмдэглэсэн ойлголт хэмээн ялган үздэг байна.

НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага (ЮНЕСКО)-аас 1987 онд "Хүний эрхийн сургалт, мэдээлэл ба баримт бичиг" сэдвээр Мальт Улсад зохион байгуулсан олон улсын бага хурлаас НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад хандан "бүх иргэн, хүн амын бүлэгт хүртэх боломжтой хүний эрхийн боловсрол, сургалтын иж бүрэн тогтолцоог бүрдүүлэх шаардлагатайг гишүүн улс орнуудын анхааралд хүргэн", "түүх, иргэний боловсрол зэргийн хөтөлбөрт хүний эрхийн агуулгыг тусгаж, зөрчлийг энхийн замаар шийдвэрлэх, хүчирхийллийн бус стратегийг боловсруулах, улмаар гишүүн орон бүрийн тухайн боловсролын талаарх амжилт ололтыг 5 жил тутамд үнэлж байх" талаар зөвлөжээ.

1999 онд хэрэгжүүлсэн Иргэний боловсролын олон улсын харьцуулсан судалгаанд хамрагдсан улс орнууд Иргэний боловсролтой холбогдох зорилго, зорилтуудыг янз бүрээр тодорхойлдог болохыг онцолжээ. Тэдгээрийг тоймлон үзвэл дараах хэдэн зорилт илүү нийтлэг байна:

- Хувь хүний чадавх, боломцоог нэмэгдүүлэх;
- Тэгш боломцоог дэмжих;
- Залуу үеийг ажил хөдөлмөрт бэлтгэх;
- Цаашдын буюу дээд боловсрол эзэмших үндэс суурийг тавих;
- Мэдлэг, чадвар, ойлголт бий болгох;
- Иргэншил буюу ардчилал ба нийтлэг хэм хэмжээнд суралцуулах;
- *<u>Соёлын өв уламжлалаа хадгалах, эдлэх явдал</u>* зэрэг болно.

Үүнээс үзэхэд иргэний боловсрол нь хүний эрх, ардчилал, улс төр, иргэн - төрийн харилцаа, шийдвэр гаргах үйл явцын талаар мэдлэг эзэмших, чадвар, хандлагаа хөгжүүлэх үйл явцыг багтаасан, олон бүрэлдэхүүн хэсэг бүхий насан туршийн боловсрол юм. Иргэний боловсролын агуулгад мөн плюрализм, олон соёлт орчин, угсаатны ба соёлын өв уламжлал, нийгмийн ялгарал, хүлээцтэй хандах байдал, нийгмийн зүй ёс, үндэсний онцлог, ухаалаг байдал, байгаль орчны ач холбогдлын мэдрэмж зэрэг олон шинэлэг асуудал тусдаг байна.

Баримт бичгүүд болон судлаачдын үзэл бодлоос харахад иргэний боловсролын гол зорилго нь суралцагч, өсвөр үе, залуучууд өөрсдийн эрх, эрх чөлөөгөө мэдэж, шийдвэр гаргах үйл явцад оролцох, байр сууриа илэрхийлэх чадвараа хөгжүүлэхэд туслах, оролцоо бүхий нийгмийн хариуцлагатай гишүүн болон төлөвшихөд нь дэмжлэг үзүүлэх, чиг баримжаа олгоход чиглэж байна. Хүн нийгмийн амьдралын олон талт харилцаанд оролцдог учир тухайн хүнд нийгмийн харилцааны үндэс суурь, зарчмууд, үүрэг хариуцлагын талаар тодорхой мэдлэг, ойлголт байх шаардлагатай. Тиймээс иргэний боловсролын хичээлийн агуулга нь улс төр, эдийн засаг, нийгэм, ёс суртахуун, соёлын гэсэн 5 үндсэн ай (домайн)-н хүрээнд боловсрогдож, эдгээрийн талаар зохих мэдлэг, хандлага төлөвшүүлэхэд чиглэх нь зүйтэй хэмээн судлаачид үздэг байна.

Дэлхийн улс орнуудад "Иргэний боловсрол"-ын агуулгыг олон хичээлийн хүрээнд багтаан олгодог. Тухайлбал, нийгмийн ухаан, нийгэм судлал, дэлхий судлал, хүн ба нийгэм, амьдралын ухаан, албан ахихуй, хүний эрхийн боловсрол, ёс зүйн боловсрол, эрх зүйн боловсрол зэрэг олон хичээлийн хүрээнд улс орнууд өөрийн иргэддээ орчин үеийн нийгмийн улс төр, эдийн засаг, соёл, ёс суртахууны харилцааны үндсийг заан сургаж, тэдгээр харилцаанд үр ашигтай оролцох талаар зохих чадвар, хандлагыг төлөвшүүлж иржээ. Түүнээс гадна иргэний боловсрол нь түүх, газар зүй, эдийн засаг, улс төр судлал, байгаль орчин судлал, шашин судлал, төрөлх ба гадаад хэл зэрэг бусад хичээлүүдтэй харилцан холбогдож, иргэдийг нийгмийн харилцаанд бэлтгэхэд чиглэдэг байна.

*Хүснэгт 2. Гадаадын зарим улсын ерөнхий боловсролын тогтолцоо*

| № | Улсын нэр | Бага сургуульд хамрагдах нас | Ерөнхий боловсролын тогтолцоо (жилээр) | | | Гадаад хэлийг зааж эхлэх нас, анги | ЕБС-н сургалтын хөтөлбөрт үндэсний өв, соёлын талаар тусгасан байдал |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Бага сургууль | Дунд сургууль | Ахлах сургууль | | |
| 1 | ХБНГУ | 6 нас | 4 жил | 6 жил | 4 жил | 9 нас | Газар зүй, улс төрийн шинжлэх ухаан, түүх, эх хэл, дуу хөгжим, шашин |
| 2 | Канад[281] (Онтарио) | 6 нас | 6 жил* | 4 жил* | 1-4 жил | - | |
| 3 | Нидерланд | 5 нас | 8 жил | 4-6 жил | 1-4 жил | 7-р анги | |
| 4 | Норвег | 6 нас | 4 жил* | 3 жил* | 3 жил* | 1-р анги | Эх хэл, библи судлал |
| 5 | БНСУ | 6 нас | 6 жил* | 3 жил* | 3 жил | 3-р анги | Эх хэл, түүх , ёс зүйн хичээл |
| 6 | Сингапур | 6 нас | 6 жил* | 4-5 жил* | 2-3 жил | 1-р анги | Иргэний боловсролын хичээл |
| 7 | Финланд | 7 нас | 9 жил | | 3 жил | 3-р анги | |
| 8 | Шинэ Зеланд | 5 нас | 8 жил* | 2 жил* | 3 жил | 1-р анги | |
| 9 | Эстони | 7 нас | 4 жил* | 5 жил* | 3 жил | 1-р анги | |
| 10 | Япон | 6 нас | 6 жил* | 3 жил* | 3 жил | 7-р анги | Ёс зүйн хичээл |

Тайлбар: *суурь боловсрол

## ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦОО БОЛОН ҮНДЭСНИЙ ӨВ, СОЁЛЫГ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ТУСГАСАН БАЙДЛЫН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

### 1.БНСУ

БНСУ-д боловсролын салбарын хууль эрх зүйн орчинг Үндсэн хууль, Боловсролын суурь хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Насан туршийн боловсролын тухай хууль, Боловсон хүчний хөгжлийн суурь хууль зэрэг хууль болон холбогдох бусад хууль тогтоомжууд бүрдүүлж байна.

*БНСУ-ын Үндсэн хуульд боловсролтой холбоотой асуудлыг дараах байдлаар тоймлосон байна. (31 дүгээр зүйл):*

1. *Иргэн бүр тэгш эрхтэйгээр сурч боловсрох эрхтэй байна;*
2. *Иргэн бүр хүүхэд дээ бага сургуулийн болон хуульд заасан бусад боловсролыг олгох үүрэгтэй;*
3. *Суурь боловсролыг үнэ төлбөргүй олгоно;*
4. *Боловсролын байнгын, мэргэшсэн, төвийг сахисан байдлыг хуулиар тогтооно;*
5. *Төр насан туршийн боловсролыг хөхүүлэн дэмжинэ;*
6. *Сургууль болон насан туршийн боловсрол, удирдлага, санхүүжилт, багш нарын эрх зүйн байдал зэрэг боловсролын тогтолцоонд хамаарах суурь асуудлуудыг хуулиар тогтооно” гэж заасан.*

*Суурь боловсрол*

1997 онд батлагдсан Боловсролын суурь хууль (*Framework Act on Education*)-ийг[282] баталсан бөгөөд уг хуулиар иргэдийн эрх, үүрэг, Засгийн газар болон орон нутгийн засаг захиргааны үүрэг, боловсролын тогтолцоо болон үйл ажиллагааны суурийг тогтоож өгсөн

[281] Муж бүрээр ялгаатай
[282] http://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=42697&type=part&key=16

байна. Хуулийн 8 дугаар зүйлд Суурь (заавал эзэмших) боловсрол[283] нь **бага боловсрол 6 жил, дунд боловсрол 3 жил** байна. Үндсэн хуулийн 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу суурь боловсролыг үнэ төлбөргүй олгоно.

1997 онд батлагдсан Бага, дунд боловсролын тухай хууль (*Elementary and Secondary Education Act*)-ийн 46 дугаар зүйлд заасны дагуу **ахлах сургууль 3 жил** байна. Харин 49 д үгээр зүйлд заасан цагийн сургалт болон зайны сургалт[284] нь 4 жил байна.

*Сургуульд хамрагдах нас*

Бага, дунд боловсролын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу иргэн бүр хүү/охиноо, эсхүл өөрийн асрамжид байгаа хүүхдийг **6 нас хүрч буй** тохиолдолд 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн бага боловсрол эзэмшиж дуустал нь бага сургуульд хамруулах үүрэг хүлээнэ. 1 дэх хэсэгт заасныг үл харгалзан иргэн нь хүү/охин, эсхүл өөрийн асрамжид байгаа хүүхдийг 5, эсхүл 7 нас хүрэхэд нь бага сургууль оруулж болно. Иргэн бүр өөрийн хүү/охиноо, эсхүл өөрийн асрамжид байгаа хүүхдийг бага сургуулиа төгссөний дараах жил дунд сургууль явуулж, дунд боловсрол эзэмшиж дуустал нь дунд сургуульд хамруулах үүрэг хүлээнэ.

Мөн хуулийн 68-р зүйлд заасны дагуу иргэн нь өөрийн хүү/охин, эсхүл өөрийн асрамжид байгаа хүүхдээ дунд сургуульд хамруулаагүй бол 1 сая хүртэлх воны торгууль ногдуулна.

*Гадаад хэлний сургалт*

1997 оноос англи хэлийг ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт оруулж, бага сургуулийн хувьд **бага ангийн 3 дугаар ангиас эхлэн** 3-4 дүгээр ангид долоо хоногт 1 цаг, 5-6 дугаар ангид 2 цаг тус тус заадаг болсон.

*Боловсролын агуулга*

Бага сургуулийн сургалтын хөтөлбөрт үндсэн хичээлүүд болох ёс зүй/ёс суртахуун[285], эх хэл, гадаад хэл, математик, шинжлэх ухаан, нийгмийн ухаан, биеийн тамир, дуу хөгжим болон урлагийн хичээлүүд ордог байна. Жилд 34 гаруй долоо хоногийн хичээл орох бөгөөд, бага ангийн 1-2 дугаар ангид 850 цаг, 3-4 дүгээр ангид 986 цаг, 5-6 дугаар ангид 1088 цагийн хичээл тус тус үздэг байна.

Дунд сургуульд математик, эх хэл, англи хэл, нийгмийн ухаан болон шинжлэх ухааны чиглэлээр гүнзгийрүүлэн, ёс зүй/ёс суртахуун, биеийн тамир, дуу хөгжим, урлаг болон дүрслэх урлаг зэрэг бусад үндсэн хичээлүүд орно. Дээрх үндсэн хичээлүүдээс гадна сурагчид нэмэлт болон сонгон суралцах хичээлүүд болох хөдөлмөр (гэр ахуй), технологи, гадаад хэл, мэдээлэл зүйн болон технологи болон байгаль орчин (хүрээлэн буй орчин) зэрэг хичээлүүд ордог байна.

Бага, дунд боловсролын тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу ахлах сургуульд дунд сургуульд суралцаж төгссөн, шаардлагатай шалгалтуудыг өгч тэнцсэн сурагч ахлах сургуульд суралцах эрхтэй байна. Ахлах сургуулиуд нь энгийн/ерөнхий, тусгай/гүнзгийрүүлсэн (гадаад хэл, урлаг, шинжлэх ухааны гүнзгийрүүлсэн сургалттай), мэргэжлийн ахлах сургууль, бие даасан ахлах сургууль[286] гэсэн 4 төрөлтэй байна.[287]

Улсын болон хувийн сургуулиуд нь Боловсролын яамнаас боловсруулж, баталсан үндэсний сургалтын хөтөлбөрийн дагуу сургалт явуулах бөгөөд ахлах сургуулийн 1 дүгээр анги (10-р анги)-д үндсэн 10, өөрийн сонирхсон 10 хичээл сонгон суралцах бөгөөд үндсэн хичээлд: эх хэл, ёс зүй, нийгмийн ухаан (түүх), математик, шинжлэх ухаан, хөдөлмөр болон гэр ахуй, биеийн тамир, дуу хөгжим, дүрслэх урлаг болон англи хэлний хичээлүүд ордог байна.

Ахлах сургуулийн 1 дүгээр ангиа (10-р анги) дүүргэсний дараа сурагчид хүмүүнлэг,

---

[283] compulsory education
[284] part-time and correspondence systems
[285] ethics/moral education
[286] autonomous high school
[287] Ministry of Education, Korea http://english.moe.go.kr/sub/info.do?m=020103&s=english

нийгмийн ухаан (газар зүй, түүх, улс төр, эдийн засаг, соёл), байгалийн ухаан (физик, хими, биологи, дэлхий судлал/гео судлал) гэх дөрвөн чиглэлээс, эсхүл мэргэжлийн сургалтыг сонгон гүнзгийрүүлэн суралцах юм. Ахлах сургуульд суралцаж төгссөн сурагчдад Бүрэн дунд боловсролын гэрчилгээ олгоно.

Мэргэжлийн ахлах сургуулиуд /техникийн сургууль нь эхний жилдээ ерөнхий дунд боловсрол олгох бөгөөд хөдөө аж ахуй, аж үйлдвэр, худалдаа, загасны аж ахуй/далайн, хөдөлмөр, гэр ахуй[288] зэрэг чиглэлээрх тусгай хичээлүүд 2-3 дугаар анги (11-12-р анги)-д ордог байна. Дээрх сургуульд суралцаж төгссөнөөр сурагчдад Мэргэжлийн дунд боловсролын гэрчилгээ олгоно.

Бие даасан ахлах сургууль нь бусад сургуультай харьцуулахад олон талт, тусгай/онцгой сургалтын хөтөлбөрийг харьцангуй бие даасан байдлаар хэрэгжүүлэх боломжтой байдаг. Бие даасан ахлах сургуулиуд улсын болон хувийн сургууль байж болно.

Бага, дунд боловсролын тухай хуульд заасны дагуу Боловсролын яамнаас боловсруулж, баталсан сургалтын агуулга, стандартын дагуу бүх суралцагчид ижил, тэнцүү боломжоор хангагдаж, эрх тэгш ерөнхий боловсрол эзэмшинэ.

Сургалтын хөтөлбөрийг нийгэмд гарч буй өөрчлөлтүүдтэй уялдан гарч буй хэрэгцээ, шаардлага, шинээр гарч ирж буй мэдлэгийн салбар зэрэгтэй уялдуулан шинэчлэн боловсруулах бөгөөд БНСУ-ын хувьд сургалтын хөтөлбөрөө нийт 7 удаа шинэчилсэн байна. 7 дугаар буюу хамгийн сүүлийн шинэчлэлийг 1997 оны 12 дугаар сарын 31-ний өдөр баталсан бөгөөд бага, дунд сургуульд 2000 оноос нэвтрүүлж эхэлсэн байна. Тус хөтөлбөрийг даяаршил болон мэдээлэлд суурилсан нийгмийн шаардлагад нийцүүлэхийг зорьсон ба уламжлалт сургалтын арга барил буюу мэдлэг, мэдээллийг “халбагадаж” олгодгоос бие даан суралцах, сурагч тус бүрийн хэрэгцээ, шаардлагад тохирсон хэлбэрийг нэвтрүүлэх, өргөжүүлэх, хичээлийн ачааллыг бууруулах тал дээр анхаарсан байна.

Шинэ хөтөлбөрийн хүрээнд бага сургуулийн 1 дүгээр ангиас ахлах сургуулийн 1 дүгээр анги (1-10-р анги)-н үндсэн хөтөлбөрөөр хичээллэх бол ахлах сургуулийн 2-3 дугаар анги (11-12-р анги)-д сурагчид өөрсдийн ирээдүйн зорилго, зорилтод нийцүүлэн сурах хичээлүүдээ сонгон суралцах юм.

*Хүснэгт 3. Бага, дунд, ахлах сургуулийн хөтөлбөрт орсон өөрчлөлтүүдийн тойм*

| Хөтөлбөрийн шинэчлэл явагдсан тойм | Огноо | Хөтөлбөр | Онцлог |
|---|---|---|---|
| 1 дүгээр шинэчлэл | 1954.04.20<br>1955.08.01 | Ordinance on class time assignment<br>Бага сургуулийн хөтөлбөр Дунд сургуулийн хөтөлбөр Ахлах сургуулийн хөтөлбөр | Сургуулийн боловсрол дээр төвлөрсөн сургалтын хөтөлбөр |
| 2 дугаар шинэчлэл | 1963.02.15 | Бага сургуулийн хөтөлбөр Дунд сургуулийн хөтөлбөр Ахлах сургуулийн хөтөлбөр | - Туршилтын сургалтын хөтөлбөр<br>- Ханз<br>- Цэргийн дасгал |
| 3 дугаар шинэчлэл | 1973.02.14<br>1973.08.31<br>1974.12.31 | Бага сургуулийн хөтөлбөр Дунд сургуулийн хөтөлбөр Ахлах сургуулийн хөтөлбөр | - Академик сургалтыг баяжуулах, өргөжүүлэхэд чиглэсэн хөтөлбөр<br>- Ёс зүй<br>- Түүх<br>- Япон хэл |
| 4 дүгээр | 1981.12.31 | Бага сургуулийн | - Сурах хичээлийн хэмжээг |

[288] home economics

| | | | |
|---|---|---|---|
| шинэчлэл | | хөтөлбөр Дунд сургуулийн хөтөлбөр Ахлах сургуулийн хөтөлбөр | бууруулах/зохицуулах<br>- Бага сургуулийн 1-2 ангийн хөтөлбөрийн нэгтгэсэн удирдлага |
| 5 дугаар шинэчлэл | 1987.03.31<br>1987.07.31<br>1988.03.31 | Бага сургуулийн хөтөлбөр Дунд сургуулийн хөтөлбөр Ахлах сургуулийн хөтөлбөр | - Шинжлэн ухааны ахлах сургууль, Дүрслэх урлагийн ахлах сургууль<br>- Бага сургуулийн нэгтгэсэн сургалтын хөтөлбөр<br>- Шинэ хичээл: Мэдээллийн салбар<br>- Эдийн засгийн боловсролд чиглэсэн<br>- Бүс нутгийн шинж чанарт ач холбогдол өгсөн |
| 6 дугаар шинэчлэл | 1992.06.31<br>1992.09.31<br>1992.10.31<br>1995.11.01 | Дунд сургуулийн хөтөлбөр Бага сургуулийн хөтөлбөр Ахлах сургуулийн хөтөлбөр | - Удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог сайжруулсан<br>- Төр, бүс нутаг, сургуулийн үүргийн хуваарилалт<br>- Шинэ хичээл: Компьютер, хүрээлэн буй орчин, Орос хэл. Ажил мэргэжил<br>- Гадаад хэл дээрх мэргэшсэн хичээлүүд<br>- Бага сургуулийн англи хэл |
| 7 дугаар шинэчлэл | 1997.12.31<br>1998.06.31 | Бага/дунд сургуулийн хөтөлбөр<br>Сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөр Тусгай боловсролын хөтөлбөр Мэргэжлийн боловсролын ахлах сургуулийн хөтблөр | - Сурагч төвтэй сургалтын хөтөлбөр<br>- Үндэсний сургалтын хөтөлбөр дээр суурилсан хөтөлбөр<br>- Өөрийн сонирхсон хичээлийг сонгон судлах сургалтын хөтөлбөр<br>- Түвшинд суурилсан сургалтын хөтөлбөр<br>- Бие даасан үйл ажиллагаа үүсгэн байгуулах, өргөтгөх<br>- Зорилго (чадвар) дээр суурилсан сургалтын хөтөлбөр<br>- Бүсийн болон сургуулийн хараат бус байдлыг өргөжүүлэх |

<u>*Сурах бичиг*</u>

Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийг үндэсний сургалтын агуулгын хүрээнд боловсруулах бөгөөд Боловсролын яам нь зохиогчийн эрхийг эзэмшдэг, Боловсролын яамны зөвшөөрөл бүхий хувийн хэвлэх үйлдвэрүүдэд хэвлэгдэж буй сурах бичиг, Боловсролын яамнаас ач холбогдолтой, хэрэгтэй тусгай гэж хүлээн зөвшөөрсөн сурах бичгүүд гэж 3 ангилж болох юм.

Бага сургуулийн хувьд хичээл тус бүр нэг сурах бичиг үздэг байсныг нэг хичээлд олон сурах бичиг ашиглах тогтолцоонд шилжсэн. 1997 онд англи хэлний хичээл нэмэгдсэнээр англи хэл дээрх сурах бичгүүд хэвлэгдэж эхэлсэн. Ахлах сургуулийн сурах бичгүүдийн хувьд энгийн ахлах сургууль болон мэргэжлийн болон бусад тусгай ахлах сургуулиудад зориулсан сурах бичиг гэж хуваaж байна. Үүний дотор сурах бичгүүдийг үндсэн хичээлийн болон ахисан түвшний[289] гэж 2 ангилж байна. Ихэнх үндсэн хичээлүүдийн (эх хэл, ёс зүй, түүхээс бусад) сурах бичгүүдийг боловсруулж, хэвлүүлэхэд Боловсролын яам зөвшөөрөл олгох бол ахисан түвшний сурах бичгүүдийг Боловсролын яамны захиалгын дагуу судалгааны байгууллагууд, их дээд сургуулиуд боловсруулдаг байна. Засгийн газраас баталдаг сурах бичгүүдийг Боловсролын яам зөвшөөрөл олгодог болох асуудал хэлэлцэгдэж байгаа.

*Хүснэгт 4. Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилд үзэх хичээлийн цаг*

| **Хичээл** | | **Бага сургууль** | | | | | | **Дунд сургууль** | | | **Ахлах сургууль** | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| Сургалтын | Эх хэл Урлаг | Эх хэл Урлаг | Эх хэл Урлаг | 238 | 204 | 204 | 204 | 170 | 136 | 136 | 136 | Сонгон | |

[289] advanced level

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| хөтөлбөр | **Ёс зүй** | 210 | 238 | **34** | **34** | **34** | **34** | **68** | **68** | **34** | **34** | судлах хичээл |
| | Нийгмийн ухаан | Математик 120 | Математик 136 | 102 | 102 | 102 | 102 | 102 | 102 | 136 | 170 (Түүх 68) | |
| | Математик | **Ёс зүй 60** | **Ёс зүй 68** | 136 | 136 | 136 | 136 | 136 | 136 | 102 | 136 | |
| | Шинжлэх ухаан | **Ухаалаг амьдрал 90** | **Ухаалаг амьдрал 102** | 102 | 120 | 102 | 102 | 102 | 136 | 136 | 102 | |
| | Практик сургалт | | | - | - | 68 | 68 | Техникийн боловсрол/Хөдөлмөр-гэр ахуй | | | | |
| | | | | | | | | 68 | 102 | 102 | 102 | |
| | Биеийн тамир | **Хөгжилтэй амьдрал 180** | **Хөгжилтэй амьдрал 204** | 102 | 102 | 102 | 102 | 102 | 102 | 68 | 68 | |
| | Дуу хөгжим | | | 68 | 68 | 68 | 68 | 68 | 34 | 34 | 34 | |
| | Урлаг | Бид 1-р анги 80 | | 68 | 68 | 68 | 68 | 34 | 34 | 68 | 34 | |
| | Гадаад хэл (Англи) | | | 34 | 34 | 68 | 68 | 102 | 102 | 136 | 136 | |
| **Бие даан суралцах** | | 60 | 68 | 68 | 68 | 68 | 68 | 136 | 136 | 136 | 204 | |
| **Тусгай арга хэмжээ** | | 30 | 34 | 34 | 68 | 68 | 68 | 68 | 68 | 68 | 68 | 8 нэгж |
| **Жилд үзэх хичээл (Цаг)** | | 830 | 850 | 986 | 986 | 1,088 | 1,088 | 1,156 | 1,156 | 1,156 | 1,156 | 144 нэгж |

*Үндэсний өв, соёлыг ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт тусгасан байдал*

1997 онд батлагдсан Боловсролын суурь хууль (*Framework Act on Education*)-ийг[290] 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Сургуулиуд нь олон нийтийн шинжтэй байх бөгөөд шинжлэх ухаан, ***соёлын өвийг хадгалж, хөгжүүлэх***, иргэдийн насан туршийн боловсролыг хөгжүүлэх бөгөөд сурагчдыг сурган хүмүүжүүлнэ." гэж заажээ.

Ерөнхий боловсролын үндэсний хөтөлбөрт бага, дунд, ахлах сургуулийн зорилго, зорилтыг дараах байдлаар тодорхойлсон байна:

Бага сургуулийн хувьд:

1. бие бялдар, оюун санааны хувьд эрүүл иргэнийг хөгжүүлэх;
2. амьдрах чадварыг хөгжүүлж, янз бүрийн харилцаа холбооны хэрэгслээр дамжуулан санаа, бодлоо илэрхийлэх чадвартай болох;
3. өөрсдийн сонирхол, чадвараа таньж мэдэх;
4. ***Солонгосын өв соёл, уламжлалыг ойлгож, суралцах;***
5. Амьдралын зөв, эрүүл дадал хэвшүүлэх, хөрш болон улс орноо хайрлах.

Дунд сургуулийн хувьд:

1. эрүүл, чийрэг бие бялдар, оюун ухааныг хөгжүүлж, өөрийгөө хөгжүүлэхийн тулд арвин туршлага хуримтлуулах;
2. амьдрах, суралцахад шаардлагатай суурь мэдлэг, асуудлыг шийдвэрлэх ур чадвар эзэмшсэн байх, санаа бодлоо бүтээлчээр илэрхийлэх чадвартай болох;
3. мэдлэг, туршлага дээр тулгуурласан төрөл бүрийн талбарын ажил мэргэжлийг судлах;
4. ***Солонгосын соёлын өв, уламжлалаараа бахархаж, цаашид хөгжүүлэх;***
5. ардчиллын үнэт зүйлс, үндсэн зарчмуудыг ойлгож, ардчилсан амьдралын танин мэдэгдэхүүнтэй болох.

Ахлах сургуулийн хувьд:

1. эрүүл, чийрэг бие махбод, оюун ухааныг хөгжүүлж, амьдралыг харах өөрсдийн өнцөг, амьдралын үнэт зүйлстэй болох;
2. бүтээлч байдлаар сэтгэн, бодох, шүүмжлэх;

[290] http://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=42697&type=part&key=16

3. ажил мэргэжлийн чиг баримжааг өөрсдийн сонирхол, ур чадварт суурилан хөгжүүлэх, цаашдын боловсролд шаардагдах өргөн хүрээтэй суурь мэдлэг, чадвартай болох;
4. ***даяаршсан нийгэмд Солонгосын соёл, уламжлалыг хадгалж, хамгаалж, түгээн дэлгэрүүлэх;***
5. үндэсний нийгэмлэгийн бүтээн байгуулалт, хөгжилд хувь нэмэр оруулах, дэлхийн иргэний хувьд мэдлэг, үнэт зүйлсийг хөгжүүлэх гэж тус тус заасан байна.

БНСУ-ын хувьд үндэсний өв, соёлын талаарх мэдлэгийг эх хэл, түүх, ёс зүй/ёс суртахууны хичээлийн агуулгад дараах байдлаар туссан байна.

БНСУ-ын Ерөнхий боловсролын үндэсний хөтөлбөрт бага, дунд боловсролын солонгос хэлний сургалт нь Солонгосын амин сүнс болох эх хэлээ бүтээлчээр хэрэглэх чадвар эзэмшүүлэхэд чиглэсэн байна. Энэ нь сурагчдыг эх хэлээ зөв, үр дүнтэй хэрэглэж сурснаар үндэсний ондоошил/үндэстний ижилсэл/амин чанарыг Солонгосын хөгжил, соёлыг баяжуулахад хувь нэмэр оруулна.  Бага, дунд сургуулийн солонгос хэлний хичээл нь эх хэлээр ярьж, уншиж, бичиж чадвар олгохоос гадна үндэснийхээ хэл, соёлыг сонирхох сонирхлыг нэмэгдүүлэх, эх хэл, соёлоо дээдлэн хүндэтгэх, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

Ёс зүй/ёс суртахууны ухагдахуун нь 1950-иад онд анх сургалтын хөтөлбөрт туссан бөгөөд цаг үеийн нийгмийн нөхцөл, байдал, хэрэгцээ шаардлагатай уялдан хэд хэдэн удаа өөрчлөгдсөн байна. БНСУ-ын анхны бие даан баталсан Сургуулийн хөтөлбөрт (1955-1963) ёс зүйн боловсрол нь нийгмийн ухааны хичээлийн агуулгад багтаж байсан. Ёс зүйн хичээлийг Боловсролын яамнаас батлагдсан журмын дагуу зааж эхэлсэн бөгөөд ёс зүйн боловсрол нь иргэний боловсролд чиглэж байсан (АНУ-ын “ардчилсан иргэний боловсрол” дээр суурилсан).

▪ 1973 онд ёс суртахууны хичээл нь сургалтын хөтөлбөрт бие даасан хичээл болж орсон бөгөөд улмаар 1974 онд ахлах сургуульд ёс суртахууны хичээлээр үндэсний ёс зүйг[291] судалж эхэлсэн. Тухайн үед ёс зүйн хичээл социализмын нөлөөг эсэргүүцэх, эдийн засгийг сэргээх, үндэсний уламжлалыг сэргээхэд чиглэгдэж байсан.

▪ 1973-1982 онд ёс зүйн хичээл бага, дунд сургууль болон дээд сургуульд гэсэн гурван үндсэн чиглэлээр орох болсон.

▪ 1982-1988 онд уг хичээл заах арга бүрэн шинэчлэгдсэн бөгөөд хэлэлцүүлэг хэлбэрээр хичээл заагдах болсон.

▪ 1989-1994 онд амьдралын ардчилсан байдал илүү тусгагдах болсон.

▪ 1995-1999 онд хүнлэг байдал, итгэл үнэмшил, ёс зүйн хүмүүжлийн үндсэн төлөвшил олгогдоход чиглэсэн. Энэ үеэс хоёр Солонгос нэгдэл ба Солонгос улс нэгдсэний дараа гэсэн хоёр үеийн амьдралын зорилгыг тусгайлан заах болсон, мөн “national identity” (үндэсний ондоошил/үндэстний ижилсэл/амин чанар)-ыг томьёоллыг тусгасан.

▪ 2000 оноос буюу одоо мөрдөгдөж буй 7 дугаар сургалтын хөтөлбөрт “ethnic identity” (үндэс угсаа) гэх олголт их орсон байна. 7-10-р ангийн ёс зүйн хичээлийн сурах бичиг нь 1) хувийн амьдрал, 2) гэр бүл, хөрш, сургууль дахь амьдрал, 3) нийгмийн амьдрал, 4) үндэсний болон хамт олны амьдрал[292] гэх 4 хэсгээс бүрдэж байна. Эдгээрт “national identity” гэж тусгайлан томьёолоогүй ч 8, 10-р ангийн сурах бичгийн 4 дахь хэсэг буюу “үндэсний болон хамт олны амьдрал”-д дээрх ойлголтыг тусгасан байна. Тухайлбал, 8-р ангийн ёс зүйн сурах бичгийн “үндэсний болон хамт олны амьдрал” хэсэг 4 бүлгээс бүрдэж байна. Үүнд:

1. **Солонгосын үндэсний хөгжил ба соёлыг эзэмшихүй** (*Korean national development and cultural fluency*);
2. Төрийн болон үндэсний хөгжлийн ач холбогдол (*The importance of the state and national development*);

[291] national ethics
[292] national and community life

3. Төр, улс үндэстнийг зөв хайрлах (*Correct love of the state and nation*);
4. Нэгдэл ба Хойд болон Өмнөд Солонгосыг нэгтгэх хүч чармайлт (*Unification and strong will for the reunification of the North and South (Korea)*).

7 дахь сургалтын хөтөлбөрт орсон ёс зүйн хичээлийг ерөнхийд нь үзвэл Солонгос үндэс угсаа, хоёр Солонгосын нэгдэл болон даяаршил гэсэн 3 асуудлыг хөндсөн байна. Хэдийгээр эдгээр асуудлууд нь өмнөх сургалтын хөтөлбөрүүдэд багтаж ирсэн хэдий ч шинэ хөтөлбөрт дээрх асуудлуудад харьцангуй их ач холбогдол өгсөн байна.

*Хүснэгт 5. Ёс зүйн хичээлийн агуулга*

| Хичээлийн ерөнхий агуулга | 3-р анги | 4-р анги | 5-р анги | 6-р анги | 7-р анги | 8-р анги | 9-р анги | 10-р анги |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| - "Би" ёс суртахууны субъект болох нь | - "Ёс суртахуун"-ыг хэрхэн судлах вэ<br>- Миний үнэ цэнэтэй амьдрал | - Шударга амьдрал<br>- Бие даасан амьдрал | - Сэтгэл хөдлөлийн менежмент<br>- Амьдралын тусгалууд | - Бардамнал ба өөрийгөө хөгжүүлэх<br>- Өөрийнхөө зан авирт хариуцлага хүлээх<br>- Зоригтой үйлдэл | (Хүн ба ёс суртахуун)<br>- Ёс суртахууны ойлголт<br>- Ёс суртахууны асуулт, асуудлууд<br>- Ёс суртахууны үйлдэл | (Ажиллах, сурах)<br>- Ажиллах, зугаацах<br>- Сурах, ирээдүйн төлөвлөгөө<br>- Төлөвлөгөө ба амжилт | (Амьдралын зорилго)<br>- Өөрийгөө танин мэдэх<br>- Аз жаргалтай амьдрал | (Хүн ба эрх чөлөө)<br>- Эрх чөлөө ба өөрийгөө жолоодох<br>- Ёс суртахууны үнэлгээний процесс |
| - Өөр хоорондоо болон нийгмийн харилцаа | - Гэр бүлээ хайрлах, бие зөв авч явах<br>- Талархлаа илэрхийлэх<br>- Нөхөрлөл ба найз нөхөдтэйгээ бие зөв авч | - Амлалтдаа эзэн болох<br>- Олон нийтийн ёс зүй<br>- Интернет ёс зүй | - Хөршүүдтэйгээ, зөв сайн харьцах<br>- Бие биедээ туслах<br>- Харилцан ярилцах болон зөрчлийг шийдвэрлэх<br>- Компьютер тоглоомонд донтохоос сэргийлэх | - Хууль, дүрэм журам сахих<br>- Ажиглалт<br>- Зөв, шударга үйл<br>- Бусдад санаа тавьж, ойлголцох | (Хүмүүжил ба ёс суртахуун)<br>- Гэр бүл болон ёс суртахуун<br>- Найз болон нөхөрлөлийн утга учир, үнэ цэнэ<br>- Хөршүүддээ санаа тавих, халамжлах<br>- Кибер орчин дахь ёс суртахуун | (Өсвөр үеийнхэн ба ёс суртахуун)<br>- Өсвөр үеийнхэн, хүн чанар алдагдах асуудал<br>- Асуудлыг энхийн замаар шийдвэрлэх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх<br>- өөр хүйстэнтэй нөхөрлөх | (Хүний нэр төр, хүний эрх)<br>- Хүний нэр төр ба цөөнхийн эрхийг хамгаалах<br>- Жендерийн эрх тэгш байдлыг ёс суртахууны ойлголт | (Нийгмийн шударга ёс ба ёс зүй)<br>- Нийгмийн институци ба ёс зүй<br>- Нийгмийн ёс зүйн асуудлууд |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| - Улс, үндэстэн болон дэлхийн хамтын нийгэмлэг | - Улс үндэстний бэлгэ тэмдэг ба улсаа хайрлахуй<br>- Үндэстний хоёр хуваагдсаны шалтгаан | - Улс болон үндэс угсаагаар бахархах<br>- Хоёр улс нэгдэх шаардлага | - Хойд Солонгос дахь амьдрал болон иргэдийг ойлгох<br>- Гадаад амьдарч буй Солонгос иргэдийг ойлгох | - Үл тэвчих байдал ба тэвчээр<br>- Нэгдлийн алсын хараа<br>- Тайван дэлхий | Миний амьдрал ба эх орон<br>- Улсын алсын хараа<br>- Улс болон өөрийгөө хөгжүүлэх | (Нэгдэл ба үндэстэн угсаатны нэгдлийн ёс зүй)<br>- Нэгдэх хэрэгцээ, шаардлага<br>- Хойд Солонгосын иргэд ба үндэстэн нэгтнээ хайрлах<br>- Нэгдлийн алсын хараа | (Дэлхийн энх тайван ба хүн төрөлхтнийг хайрлах)<br>- Бусад соёл, ёс заншлыг ойлгож, хүндэтгэх<br>- Дэлхийн энх тайван ба хүн төрөлхтнийг хайрлахыг үйл хэрэг болгохуй | Улс, үндэстний ёс зүй<br>- Улс ба ёс зүй<br>- Үндэс угсаа ба ёс зүй |
| - Байгаль, хүрээлэн буй орчинтой харьцах харьцаа | - Хүний амьдралын үнэ цэнэ | - Байгаль орчин ба байгаль орчныг хадгалж, хамгаалах | - Жинхэнэ гоо үзэсгэлэн | - Хайр ба нигүүсэл | (Байгаль орчин ба ёс суртахуун)<br>- Байгаль орчин ба хүний амьдрал<br>- Байгаль орчинд ээлтэй амьдрах | (Соёл ба ёс суртахуун)<br>- Жинхэнэ гоо үзэсгэлэн<br>- Урлаг ба ёс суртахуун<br>- Шинжлэх ухаан ба ёс суртахуун | (Амьдрал ба шашин)<br>- Амьдралын хязгаар<br>- Шашин ба ёс суртахуун | (Төгс амьдрал)<br>- Энх тайван амьдралыг эрэлхийлэх<br>- Төгс хүн ба төгс нийгэм |

## 2.СИНГАПУР

Сингапур Улсын боловсролын тогтолцооны хувьд Заавал эзэмших боловсролын тухай хууль (*Compulsory Education Act, 2000*)-д заасны дагуу 2003 оноос хойш төрсөн 6-15 насны хүүхэд заавал эзэмших боловсрол эзэмшинэ. Үүнд: 6 жилийн бага боловсрол, дөрвөөс таван жилийн дунд боловсрол орох ба дараагаар нь коллеж, политехникийн сургууль, эсхүл Техникийн боловсролын институт (ТБИ)-д элсэн суралцдаг байна. Бага боловсрол нь англи хэл, эх хэл, математикт чиглэсэн нийтлэг сургалтын хөтөлбөрийг мөрддөг дөрвөн жилийн суурь шатнаас бүрдэнэ. Бага сургуульд заадаг бусад хичээлүүд нь иргэний ба ёс суртахууны боловсрол, нийгэм судлал, эрүүл мэнд, биеийн тамир, дүрслэх урлаг, хөгжим зэрэг болно. Суурь боловсролын тухай хуулийн 7-р зүйлд заасны дагуу суурь боловсрол эзэмших насны хүүхэд (6-15 нас)-ийг сургуульд хамруулаагүй эцэг, эх/асран хамгаалагчид 5000 доллар хүртэл торгууль ногдуулах, эсхүл 12 хүртэл сар хорих ял шийтгэх, эсхүл хамтад нь хэрэглэнэ.

Сингапурын боловсролын тогтолцооны үндсэн зарчим нь сурагчид тохирсон сургалт явуулах арга (streaming)-д суурилсан (бага сургуулийн 5 дугаар ангиас эхлэн сурагч өөрийн хэмнэлээр хөгжих боломжийг олгодог) тогтолцооноос 2008 онд судлагдахуунд суурилсан цогц тогтолцоонд шижлсэн байна. Бага сургуулийн 6 дугаар анги төгсөх үедээ бүх сурагчид англи хэл, математик, эх хэл, шинжлэх ухааны хичээлээр бага сургууль төгсөх шалгалт өгдөг байна. Шалгалтын дүнг үндэслэн сурагчдыг дунд сургуулийн түргэвчилсэн (сурагчдын 60%), энгийн академик (сурагчдын 25%), энгийн техникийн (сурагчдын 15%) гэсэн хөтөлбөрүүдэд хуваарилдаг байна.

Түргэвчилсэн хөтөлбөрийн сурагчид Боловсролын ерөнхий гэрчилгээ (GCE)-ний О түвшний шалгалт өгдөг дөрвөн жилийн хөтөлбөрөөр суралцдаг. Энгийн академик курсийн сурагчид дөрвөн жилийн GCE N-түвшинд хүрэх хөтөлбөр судлах ба тав дахь жилдээ О түвшний шалгалт өгч болдог байна. Энгийн техникийн хөтөлбөр нь дөрвөн жилийн GCE N-түвшний хөтөлбөрийн дараа сурагчдыг техникийн дээд боловсрол, ажил мэргэжил олгох, эсхүл дунд боловсролын дараах Техникийн боловсролын институтэд бэлтгэдэг байна. Их сургуульд элсэх сурагчид О түвшний шалгалтыг алгасан Интеграцчилсан хөтөлбөрийн сургуулиудад сурч болдог байна.

*<u>Гадаад хэлний сургалт</u>*

Үндсэн хуульд заасны дагуу Сингапурын албан ёсны хэл нь малай, мандарин, тамил болон англи хэл юм. Сургуулийн өмнөх болон сургуулийн боловсролын сургалтын хөтөлбөр нь англи хэл дээр суурилсан байх ба сурагчид өөрийн эх хэлээ давхар сурдаг. Эх хэл (малай, мандарин, тамил)-ий хувьд сурагчид бага, дунд сургуульдаа ахисан түвшний эх хэлний хичээлийг сонгон суралцах боломжтой бөгөөд дунд сургуульдаа тус хичээлийг үзэж суралцсан тохиолдолд дараагийн шат буюу бага коллежид үзэхгүй байж болдог. Дээрхээс гадна тодорхой шалгуур, шаардлага хангасан тохиолдолд дараах 8 хэлнээс сонгон суралцах болдог байна. Үүнд: малай (тусгай хөтөлбөр), мандарин (тусгай хөтөлбөр), бхаса-индонез, араб, франц, герман, япон болон испани хэл орж байна.

*<u>Үндэсний өв, соёлыг ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт тусгасан байдал</u>*

Сингапур Улсын хувьд үндэсний өв, соёлтой холбоотой асуудлыг *Character and Citizenship Education (CCE)* буюу Иргэний боловсролын хичээлд судалдаг байна. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийн Иргэний боловсролын хичээлийн зорилго, зорилтыг дараах байдлаар тодорхойлсон байна.

Зорилтын 1-4 нь хувь хүний төлөвшилд чиглэсэн байна. Үүнд:

1. Хувь хүний сайн сайхан, үр дүнд хүрэхийн тулд өөрийгөө ойлгуулах, өөрийгөө удирдах чадварыг эзэмшүүлэх;
2. Ёс суртахууны зарчмуудыг дээдэлсэн, шударга зарчмыг баримтлан хариуцлагатай шийдвэр гаргах;
3. Хүмүүсийн харилцан хүндэтгэл дээр суурилсан эерэг харилцааг бий болгоход нийгмийн ухамсар, харилцааны чадварыг ашиглах;
4. Уян хатан байж, сорилт бэрхшээлүүдийг боломж болгох чадвартай байх;

Зорилтын 5-8 нь 21-р зууны иргэнийг удирдлага болгон нийгмийн гишүүний хувьд соёлтой, идэвхтэй, хариуцлагатай иргэн болгоход чиглэсэн байна. Үүнд:

5. ***Улс улс үндэстнээ байгуулахад оролцох, үндэсний ондоошил/үндэстний ижилсэл/амин чанарын (national identity) бахархал;***
6. ***Сингапурын нийгэм-соёлын олон янз байдлыг ойлгон үнэлж, нийгмийн нэгдмэл байдал, эв нэгдлийг хөхүүлэн дэмжих, хамгаалах;***
7. Бусдын төлөө санаа тавьж, нийгэм, улс үндэстнийхээ хөгжил дэвшилд идэвхтэй хувь нэмэр оруулах;
8. Олон нийт, үндэсний болон дэлхийн асуудлуудад хариуцлагатай, мэдээлэлтэй иргэний хувиар хандах, байр суурие илэрхийлэх.

*Иргэний боловсролын хичээлийн бага, дунд, их сургуулийн өмнөх (pre-university) сургуульд үзэх нийт цаг, агуулга*

| Иргэний боловсролын хичээлийн бүрэлдэхүүн | Агуулга |
|---|---|
| **Иргэний боловсролын хичээл (ИБ)** | Бага сургууль<br>Үнэ цэнэ, мэдлэг, чадвар болон иргэний боловсролын хичээлийн эх хэл дээр зааж сургах<br>Дунд сургууль<br>Үнэ цэнэ, мэдлэг, чадвар болон иргэний боловсролын хичээл |
| **Form Teacher Guidance Period (FTGP)** | Нийгмийн ур чадвар болон сэтгэл хөдлөлөө удирдах чадвар эзэмшүүлэх (үүнд цахим орчин дахь аюулгүй байдал болон ажил мэргэжлийн чиг баримжаа олгох) ба багш сурагчийн харилцаа |
| **Сургуульд суурилсан иргэний боловсрол (School-based CCE)** | Сургуулийн үнэ цэнэ, сургуулиас зохион байгуулах арга хэмжээг багтана |
| **Иргэний боловсролын хичээлийн удирдамжийн модуль (CCE guidance module)** | • Мэргэжил сонгох (ECG)<br>• Цахим орчин дахь аюулгүй байдал (CW)<br>• Эрүүл мэндийн сургалт (SEd) |

Бага сургуулийн хувьд:

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1-3-р анги | ИБ-ын хичээл 30 цаг | FTGP 15 цаг | School-based CCE 15 цаг | Жилд 60 цаг |
| 4-р анги | ИБ-ын хичээл 45 цаг | FTGP 15 цаг | School-based CCE 15 цаг | Жилд 75 цаг |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5-6-р анги | ИБ-ын хичээл 45цаг | FTGP 15 цаг | 4 цаг | School-based CCE 11 цаг | Жилд 75 цаг |

Дунд сургуулийн хувьд:

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1-5-р анги | ИБ-ын хичээл 20 цаг | CCE guidance module 13 цаг | School-based CCE 27цаг | Жилд 60 цаг |

Их сургуулийн өмнөх боловсролын хувьд (Pre-university):

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2-3-жил | ИБ-ын хичээл 40 цаг | Cohort level CCE 40 цаг | Customized CCE learning experoence | 2-3 жилд 80 цаг |

*Хүснэгт 6. Иргэний боловсролын хичээлийн агуулга*

| Д/д | Иргэний боловсролын хичээлийн зорилго | Зорилго (Боловсролын шат тус бүрт) | | | Гол үнэт зүйл |
|---|---|---|---|---|---|
| | | Бага | Дунд | Их сургуулийн өмнөх | |
| 1 | Хувь хүний сайн сайхан, үр дүнд хүрэхийн тулд өөрийгөө ойлгуулах, өөрийгөө удирдах чадварыг эзэмшүүлэх; | Хөдөлмөрөөрөө бахархах | Сурч боловсрох хариуцлагаа ухамсарлах | Төгс төгөлдрийг илэрхийлэхдээ зорилготой байх | Хариуцлага |
| | | Зөв дадал зуршил, урлагийн талаарх мэдлэгтэй болох | Биеийн тамираар хичээллэх, урлагийн талаарх мэдлэгтэй болох | Эрүүл амьдралын хэв маягийг эрэлхийлэх, гоо зүйн мэдрэмжтэй болох | |
| 2 | Ёс суртахууны зарчмуудыг дээдэлсэн, шударга зарчмыг баримтлан хариуцлагатай шийдвэр гаргах; | Буу, зөвийг ялгах чадвартай байх | Ёс суртахуунтай байх | Зөв гэсний төлөө тэмцэх ёс суртахууны зоригтой байх | Хариуцлага, шударга байдал |
| 3 | Хүмүүсийн харилцан хүндэтгэл дээр суурилсан эерэг харилцааг бий болгоход нийгмийн ухамсар, харилцааны чадварыг ашиглах; | Бусадтай хамтран ажиллах, хуваалцах, асран халамжлах чадвартай байх | Багаар ажиллаж, бусдад санаа тавих | Нийгмийн хариуцлагатай байж, янз бүрийн улс үндэстэн, соёлтой хамтран ажиллах чадвартай байх | Хүндлэл |
| 4 | Уян хатан байж, сорилт бэрхшээлүүдийг боломж болгох чадвартай байх; | Өөрийн хүч чадал, давуу талаа хөгжүүлэх | Өөрийн ур чадвар, чадалдаа итгэж, өөрчлөгдөж чаддаг байх | Саад бэрхшээлийг даван туулах чадвартай байх | Уян хатан байдал |
| | | Юмс үзэгдлийг сонирхох | Бүтээлч сэтгэлгээтэй байх | Шинэлэг, ажил хэрэгч байх | |
| 5 | **Улс улс үндэстнээ байгуулахад оролцох, “national identity” (үндэсний ондоошил/үндэстний ижилсэл/амин чанар)-ын бахархал;** | Улс орноо таньж мэдэх, хайрлах | Улс орондоо итгэх итгэл ба юу чухал болохыг ойлгох | Сингапурын иргэн байхын бахархал, дэлхий дахин дахь Сингапурын байр суурийг ойлгох | Хариуцлага |
| 6 | Сингапурын нийгэм-соёлын олон янз байдлыг ойлгон үнэлж, нийгмийн нэгдмэл байдал, эв нэгдлийг хөхүүлэн дэмжих, хамгаалах; | Бусадтай хамтран ажиллах, хуваалцах, асран халамжлах чадвартай байх | Багаар ажиллаж, бусдад санаа тавих | Нийгмийн хариуцлагатай байж, янз бүрийн улс үндэстэн, соёлтой хамтран ажиллах чадвартай байх | Хариуцлага, эв нэгдэл |
| | | Өөртөө итгэлтэйгээр өөрийгөө илэрхийлэх, сэтгэж бодох | Олон янзын үзэл бодлыг ойлгож, харилцах чадвартай байх | Шүүмжлэлтэйгээр бодож, үнэмшилтэйгээр харилцах чадвартай байх | |
| 7 | Бусдын төлөө санаа тавьж, нийгэм, улс үндэстнийхээ хөгжил дэвшилд идэвхтэй хувь нэмэр оруулах; | Өөрийн хүч чадал, давуу талаа хөгжүүлэх | Өөрийн ур чадвар, чадалдаа итгэж, өөрчлөлтөд дасан зохицох чадвартай байх | Саад бэрхшээлийг даван туулах чадвартай байх | Хариуцлага, халамж |
| | | Бусадтай хамтран ажиллах, хуваалцах, асран халамжлах чадвартай байх | Багаар ажиллаж, бусдад санаа тавих | Нийгмийн хариуцлагатай байж, янз бүрийн улс үндэстэн, соёлтой хамтран ажиллах чадвартай байх | |
| | | Юмс үзэгдлийг сонирхох | Бүтээлч сэтгэлгээтэй байх | Шинэлэг, ажил хэрэгч байх | |
| 8 | Олон нийт, үндэсний болон дэлхийн асуудлуудад хариуцлагатай, мэдээлэлтэй иргэний хувиар хандах, байр сууриа илэрхийлэх. | Буу, зөвийг ялгах чадвартай байх | Ёс суртахуунтай байх | Зөв гэсний төлөө тэмцэх ёс суртахууны зоригтой байх | Хүндлэл, хариуцлага |
| | | Өөртөө итгэлтэйгээр өөрийгөө илэрхийлэх, сэтгэж бодох | Олон янзын үзэл бодлыг ойлгож, харилцах чадвартай байх | Шүүмжлэлтэйгээр бодож, үнэмшилтэйгээр харилцах чадвартай байх | |
| | | Улс орноо таньж мэдэх, хайрлах | Улс орондоо итгэх итгэл ба юу чухал болохыг ойлгох | Сингапурын иргэн байхын бахархал, дэлхий дахин дахь Сингапурын байр суурийг ойлгох | |

## 3.ЯПОН

*Эрх зүйн орчин*[293]

Японы Үндсэн хуулийн 26 дугаар зүйлд "Бүх хүн хуульд заасны дагуу өөрийн ур чадварт тохирсон тэгш боловсрол эзэмших эрхтэй. Бүх хүн өөрийн асран хамгаалалтад байгаа хүүхдийг хуульд заасан ерөнхий боловсролтой болгох үүрэгтэй. Заавал эзэмших боловсрол үнэ төлбөргүй байна" гэж заажээ.

Үндсэн хуульд заасан энэ бодлогод тулгуурлан 1947 оны 3 дугаар сард Боловсролын суурь хуулийг баталсан бөгөөд тус хуулиар боловсролын салбарт баримтлах дараах дөрвөн зарчмыг дэвшүүлэн тавьсан байна. Үүнд:

- ✓ Хүмүүжүүлэх зорилгод тулгуурласан боловсролын бодлого;
- ✓ Боловсролын тэнцүү боломж ба хүйсийн тэгш байдал;
- ✓ Сургуулийн ардчилсан, үл ялгаварлах тогтолцоо;
- ✓ Үнэ төлбөргүй олгох заавал эзэмших боловсролын 6-3 тогтолцоо (6 жилийн бага сургууль, 3 жилийн дунд сургууль).

Мөн хуулиар сургуулийн насны бүх хүүхдэд заавал эзэмших боловсрол буюу 9 жилийн боловсролыг үнэ төлбөргүй олгох, нийгмийн боловсрол, гэр бүлийн боловсрол олгох тухай зохицуулалт, улс төрийн боловсрол, шашны боловсрол олгоход хориглох зарим зохицуулалтыг тус тус тусгасан байна. Мөн үндэсний болон орон нутгийн боловсролыг зүй зохисгүй байдлаар хянахыг хориглосон байна.

Боловсролын суурь хуульд хамгийн сүүлд 2006 оны 12 дугаар сард нэмэлт, өөрчлөлт орсон байх бөгөөд боловсролыг тойрсон асуудал, шинжлэх ухаан, технологийн дэвшил, мэдээллийн дэвшилтэт технологи, хөгширч буй нийгэмд нөлөөлж буй байдал, гэр бүлийн амьдралын хэв маяг, хүүхдийн хүрээлэн буй орчны өөрчлөлт зэрэг олон асуудлууд урган гарснаар зайлшгүй нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага тулгарсан байна.

Гэхдээ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа өмнөх хуулиар тогтоосон нийтлэг зарчим, Японы уламжлал, соёлыг уламжлан үлдээсэн байна. Хуульд заасан боловсролын суурь бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор 2008 оны 07 дугаар сард Засгийн газраас "Боловсролыг дэмжих үндсэн төлөвлөгөө"-г боловсруулан баталсан. Энэ төлөвлөгөөг 10 жил тутам гаргахаар тогтсон ба уг төлөвлөгөөгөөр дараагийн 10 жилд хэрэгжүүлэх үндсэн чиглэлийг тогтоодог. Бусад бүх төсөл, хөтөлбөр үндсэн чиглэл буюу төлөвлөгөөтэй уялдан хэрэгжиж байгаа нь тухайн улсын боловсролын салбар цэгцтэй, ойлгомжтой, үр нөлөө өндөртэй хөгжиж байгаагийн илрэл юм.

Тус улсад одоогоор Боловсролын суурь хуульд нийцүүлэн баталсан дараах хуулиуд үйлчилж байна. Үүнд:

- Сургуулийн боловсролын тухай хууль *School Education Law* (сургуулийн зохион байгуулалт, менежментийг зохицуулсан);
- Нийгмийн боловсролын тухай хууль *Social Education Law* (нийгмийн боловсролын үйл ажиллагааг зохицуулсан);
- Орон нутгийн боловсролын байгууллага болон орон нутгийн боловсролын удирдлагын тухай хууль *Law Concerning Organization and Functions of Local Educational Administration.*

*Ерөнхий боловсролын тогтолцоо*[294]

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, технологийн яам нь боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага юм. Яам нь боловсролын салбарын нэгдсэн бодлого боловсруулж тогтоох, сургалтын хөтөлбөр боловсруулах, багш, ажилчдын цалингийн хэмжээг тогтоох, муж, орон нутгийн сургуулийн санхүүжилт олгох, Японы боловсролын бүх үйл ажиллагаанд хяналт тавих зэрэг ажлыг хариуцдаг байна.

Японд улсын болон хувийн сургууль үйл ажиллагаа явуулдаг. Ихэнх улсын

---

[293] Боловсрол, соёл, шинжлэх ухаан, технологийн яамны цахим хаяг http://www.mext.go.jp/en/policy/education/overview/index.htm

[294] Timss & pirls international study center http://timssandpirls.bc.edu/timss2015/encyclopedia/countries/japan/

сургуулийн санхүүжилтийг Засгийн газраас санхүүжүүлж, орон нутгийн сургуулийн санхүүжилтийг тухайн орон нутгаас санхүүжүүлдэг. Гэхдээ засгийн газраас орон нутгийн сургуульд зарим санхүүжилт олгодог байна.

Харин хувийн сургууль нь сургалтын төлбөр, хандив, бизнесийн хөрөнгө оруулалтаас санхүүждэг боловч Засгийн газраас мөн бага хэмжээний санхүүжилт олгодог.

Японд бага ангийн сурагчдын 1.1 хувь, дунд ангийн сурагчдын 7 хувь, ахлах ангийн сурагчдын 31.1 хувь нь хувийн сургуульд суралцдаг байна.

Тус улс нь 6-3-3 загвар буюу 6 жилийн бага сургууль *(shogakko)*, 3 жилийн дунд сургууль (*chugakko)* , 3 жилийн ахлах сургууль *(kotogakko)* гэсэн ерөнхий боловсролын тогтолцоотой. Заавал эзэмших боловсролд бага болон дунд боловсрол ордог. Нийт 6-15 насны хүүхдүүдийн 96-98 хувь нь ерөнхий боловсрол эзэмшсэн байдаг.

Японы тусгай хэрэгцээт ерөнхий боловсролын сургуульд харьцангуй хүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд суралцдаг. 2007 оноос зөвшөөрөгдсөн зарим энгийн ерөнхий боловсролын сургуулиуд тусгай ангитай болсон ба энэ ангид хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд суралцдаг байна. Мөн эмнэлэгт хэвтэж буй өвчтэй хүүхдүүдэд зориулсан ангийг эмнэлэгт байгуулсан байдаг байна.

Японы боловсролын тогтолцооны онцлог нь бага болон дунд ангид албан ёсны шалгалт авч, дүн тавьдаггүй харин ахлах ангид элсэн орохдоо шалгалт өгдөг байна. Мөн хүүхдүүдийг чадвараар нь төрөлжсөн анги болгож хуваадаггүй ба бүх хүүхэд тэгш боловсрол эзэмших ёстой гэсэн зарчмыг баримталдаг. Үүнээс гадна амжилттай суралцах нь төрөлхийн оюун ухаанаас илүү тухайн хүүхдийн хичээл зүтгэл, хөдөлмөр хамгийн чухал гэж үздэг. Мөн тухайн хүүхдийн сурлагын амжилтад эцэг эх, багш, сурагч гэсэн гурвалсан холбоо хамгийн чухал ба сурагч амжилт гаргаагүй бол эцэг эх, багш, сурагчийн аль аль нь хариуцлага хүлээнэ. Энэ тогтолцоо нь сурагч болон багш, эцэг эхийн хариуцлагыг дээшлүүлдэг байна.

Мөн тус улс нь боловсролын салбарт оруулж буй хөрөнгө оруулалтын хэмжээнд бус тухайн салбарт хуваарилагдаж буй хөрөнгө оруулалтыг зөв, оновчтой хуваарилахад онцгой анхаардаг. Үүний нэг илрэл нь тухайн салбарт хуваарилагдаж буй хөрөнгө оруулалтын ихэнх нь багшийн хөгжил, сурагчийн хөгжилд зориулагддаг бол сургуулийн барилга, тоноглол, сурах бичиг зэрэг нь хамгийн энгийн, өртөг багатай байдаг байна.

*Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр*

Яамнаас боловсруулсан сургалтын хөтөлбөрийг улсын хэмжээнд удирдамж болгон мөрдөх үүрэгтэй ба энэхүү сургалтын хөтөлбөрийн агуулгыг нарийвчлан тогтоож өгдөг. Сургалтын хөтөлбөрийг боловсруулахдаа эхлээд бүрэн эзэмших ёстой сэдвүүдийг жил бүрээр зааж өгч, жилээс жилд дэвшил гаргана гэж тооцсоны дагуу хөтөлбөрийн уялдаа холбоонд маш өндөр ач холбогдол өгч боловсруулдаг байна. Яамнаас хөтөлбөрт зориулан сургуулийн түвшинд ашиглах гарын авлагыг хичээл тус бүрээр боловсруулж хэвлэдэг.

Японы сурах бичгүүд товч бөгөөд цомхон байдаг. Мөн маш хямд өртгөөр бүтсэн, 100 аас ихгүй хуудастай нимгэн хавтастай ном байдаг. Тухайн хичээл дээр улирал бүр 1 сурах бичиг хэрэглэх ба сурах бичгийн агуулга нь хамгийн гол ухагдахуунуудад анхаарсан байдаг.

Бага ангийн хичээлийн хөтөлбөрт япон хэл, нийгэм судлал, математик, шинжлэх ухаан, амьдрах орчин, хөгжим, зураг, гар урлал, биеийн тамир, гэрийн аж ахуй гэсэн хичээлүүд багтдаг. Мөн нэмэлтээр **ёс суртахууны хичээл** ордог.

Дунд ангийн хичээлийн хөтөлбөрт япон хэл, нийгэм судлал, математик, шинжлэх ухаан, хөгжим, зураг, биеийн тамир, үйлдвэрлэлийн урлаг, гэрийн аж ахуй, **гадаад хэл**, сонгон судлах хичээлүүд багтдаг. Мөн нэмэлтээр **ёс суртахууны хичээл** орно.[295]

Японд гадаад хэлийг 7-р ангиас нь зааж эхэлдэг. Гадаад хэл заах тухайд Япон хэл, соёлыг бүрэн танин мэдсэний дараа гадаад хэл заах нь үр дүнтэй гэсэн бодлогыг

[295] https://www.nuffic.nl/en/publications/find-a-publication/education-system-japan.pdf

баримталдаг байна.[296]

1-ээс 6 дугаар ангийн хичээлийн үргэлжлэх хугацаа 45 минут, 7-оос 9 дүгээр ангийн хичээлийн үргэлжлэх хугацаа 50 минут байдаг.

*Хүснэгт 7. Бага болон дунд ангид судлах хичээлийн цаг* [297]

| ХИЧЭЭЛИЙН ТӨРӨЛ | АНГИ | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| **Япон хэл** | 272 | 280 | 235 | 235 | 180 | 175 | 140 | 140 | 105 |
| **Нийгэм судлал** | - | - | 70 | 85 | 90 | 100 | 105 | 105 | 140 |
| **Тоо бодлого** | 114 | 155 | 150 | 150 | 150 | 150 | - | - | - |
| **Математик** | - | - | - | - | - | - | 140 | 105 | 140 |
| **Шинжлэх ухаан** | - | - | 70 | 90 | 95 | 95 | 105 | 140 | 140 |
| **Амьдрах орчин** | 102 | 105 | - | - | - | - | - | - | - |
| **Хөгжим** | 68 | 70 | 60 | 60 | 50 | 50 | 45 | 35 | 35 |
| **Зураг, гар урлал** | 68 | 70 | 60 | 60 | 50 | 50 | - | - | - |
| **Өрхийн эдийн засаг** | - | - | - | - | 60 | 55 | - | - | - |
| **Биеийн тамир** | 90 | 90 | 90 | 90 | 90 | 90 | - | - | - |
| **Уран зураг** | - | - | - | - | - | - | 45 | 35 | 35 |
| **Эрүүл мэнд, биеийн тамир** | - | - | - | - | - | - | 105 | 105 | 105 |
| **Үйлдвэрлэлийн урлаг, гэрийн урлаг** | - | - | - | - | - | - | 70 | 70 | 35 |
| **Гадаад хэл** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **140** | **140** | **140** |
| **Ёс суртахуун** | **34** | **35** | **35** | **35** | **35** | **35** | **35** | **35** | **35** |
| **Дүгнэлт хичээл** | - | - | 105 | 105 | 110 | 110 | 50 | 70 | 70 |
| **Сонгон судлах хичээл** | 34 | 35 | 35 | 35 | 35 | 35 | 35 | 35 | 35 |
| **НИЙТ /ЖИЛД/** | **782** | **840** | **910** | **945** | **945** | **945** | **1015** | **1015** | **1015** |

*Сургалтын хөтөлбөр, агуулгад үндэсний өв, соёлыг тусгасан байдал*

1890 онд Эзэн хаан Боловсролын тухай зарлиг гаргасан ба энэхүү зарлигаар зайлшгүй эзэмших шинэ боловсролын тогтолцооны өөрчлөлтөд Японы үнэт зүйлийг гол болгон баримтална гэж тунхагласан байна. Энэ нь үнэнч зүтгэл, ахмадын хүндэл, гэр бүлийн гишүүд, хань ижил, анд нөхөдтэй тогтоосон харилцаа зэрэг ёс суртахууны чанаруудыг чухалчлахыг сануулсан зарлиг байсан юм.

Японы суурь боловсролын тухай хуулиар ёс суртахуун, ёс зүйн боловсролыг заавал эзэмшүүлэх албан боловсрол гэж заасан ба энэ нь Японы үндэсний өв, соёлтой салшгүй холбоотой юм.

Ёс зүйн боловсрол нь тухайн сурагч Япон орны үнэт зүйлийг таньж ойлгох, улмаар өөрийн орны соёл, уламжлалыг хадгалах, үнэт зүйлээ өвлүүлэн авч явах иргэнийг төлөвшүүлэх зорилготой юм. Иймд ерөнхий боловсролын сургуульд ёс зүй, ёс суртахууны боловсрол олгоход маш их анхаардаг байна.

Ерөнхий боловсролын сургуульд ёс суртахууны хичээлийг дараах 4 төрлийн агуулгад тулгуурлан заадаг.[298]

1. Өөрийнхөө тухай: Хүн бүр бие даасан байх, өөрсдийн хийж чадах зүйлээ хийх, хэм хэмжээтэй амьдрах.
2. Бусад хүмүүстэй харилцах харилцаа: Хүмүүстэй шударга харилцах, хүмүүстэй эелдэг харилцах.
3. Байгаль, эрхэм дээд зүйлтэй харилцах: Байгалийн гамшиг, байгаль, амьтны ач холбогдлыг мэдрэх.
4. Нийгэм болон бүлгүүдийн тухай: Олон нийтийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, дүрэм журмаа дагах, амлалтаа биелүүлэх.

[296] Сургуулийн өмнөх ба бага боловсролын түвшинд гадаад хэл заах эхлэх насыг хуульчлан тогтоох боломж, жишиг. Лавлагаа мэдээлэл. УИХ-ын Тамгын газар, Судалгаа, шинжилгээний хэлтэс. Эмхтгэл 17.
[297] Moral education in Japan https://www.nier.go.jp/English/educationjapan/pdf/201303MED.pdf
[298] Moral education in Japan https://www.nier.go.jp/English/educationjapan/pdf/201303MED.pdf

## 4.ФИНЛАНД

*Ерөнхий боловсролын тогтолцоо*

Финланд Улс нь PISA-ийн бүх үнэлгээнд тэргүүн эгнээнд тогтмол эрэмбэлэгддэг боловсролын тогтолцоогоор дэлхийд тэргүүлэгч улсын нэг юм.

1960-аад оны сүүл үе хүртэл нийт иргэдийн 60 орчим хувь нь хөдөө амьдарч, хүүхэд залуусын ихэнх нь 6 жилийн боловсрол буюу бага боловсрол эзэмшиж байсан ба тухайн үед бага, дунд сургууль нь тусдаа үйл ажиллагаа явуулж байсан байна.

Парламентаас боловсролын тогтолцоондоо шинэчлэл хийх зорилгоор 3 удаа комисс байгуулж ажилласан ба комисс тус бүрээс гарсан зөвлөмжид “Финландын бүх хүүхэд сурч боловсроход тэнцүү боломжоор хангах, үүнд нийцсэн боловсролын тогтолцоо бий болгох” талаар зөвлөмжүүдийг гаргасан байх ба үүний дагуу 1968 оны 11 дүгээр сард 9 жилийн (бага, дунд сургуулийг нийлүүлсэн) сургууль бүхий Суурь боловсролын тухай хуулийг баталсан байна. Шинээр батлагдсан Суурь боловсролын тухай хууль нь 1972 оноос шат дараатайгаар хэрэгжин, 1977 он гэхэд орон даяар шинэ тогтолцоонд шилжиж дууссан байна. Энэхүү хууль батлагдсанаар Финландын боловсролын тогтолцоо үндсээрээ өөрчлөгдсөн байна.

Тус улсын Боловсрол, соёлын яамны харьяа Боловсролын үндэсний зөвлөл нь ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол, насанд хүрэгчдийн боловсролын зорилго, агуулга, арга барилыг хөгжүүлэх үүрэгтэй мэргэжлийн байгууллага юм. Тус зөвлөл нь Үндэсний сургалтын хөтөлбөрийг боловсруулж, батлах мөн боловсролын системийг үнэлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг байна. Финланд нь засаг захиргааны 6 мужид хуваагддаг ба муж тус бүр Боловсрол, соёлын яаманд харьяалагдах Боловсрол, соёлын газартай байна.[299]

Тус улсын ерөнхий боловсролын тогтолцоонд чанартай, үр ашигтай, тэгш боломжоор хангасан, өрсөлдөх чадвартай байх зэрэг үндсэн зарчмуудыг баримталдаг байна. Финланд хүүхдүүд хуульд заасны дагуу 6 настайдаа бэлтгэл ангид заавал явах үүрэгтэй ба үүний дараа 7 настайдаа 1 дүгээр ангид элсэн ордог байна. Бага, дунд шатны сургуулийг 9 жилийн бүрэн дунд сургууль гэнэ. Заавал эзэмших боловсролд бага, дунд боловсрол ордог. Бүрэн дунд сургууль төгссөн сурагч 3 жилийн ахлах сургууль, эсхүл 3 жилийн техник мэргэжлийн сургуульд элсэн орох боломжтой.

Финландад хувийн болон улсын сургууль байдаг боловч хувийн сургуулиудад улсын сургуультай адил хэмжээний санхүүжилтийг улсаас олгоно. Мөн хувийн сургуулиудад нь сургалтын төлбөр авахыг хориглосон ба элсэлтийн хувьд улсын сургуулийнхтай адил шаардлага тавьж, сурагчдыг сонгон шалгаруулахад тусгай шаардлага, нөхцөл тавихыг хориглодог байна.

Ерөнхий боловсролын сургууль жилд 190 цаг буюу өдөрт 4 цаг хичээллэдэг ба энэ нь бусад оронтой харьцуулахад харьцангуй бага цаг юм.

Финланд сурагчдын сурлагын амжилтад багшийн чанар, ур чадвар чухал үүрэгтэй байдаг. Засгийн газраас багшлах ажилд мэргэжлийн өндөр босго тогтоож, багш бэлтгэх сургалтын хугацааг уртасгаж, сурагчдын хяналтын үүргийг багш нарт олгосон нь мэргэжлийн хувьд илүү бие даасан байдалтай болж багшийн мэргэжлийг нэр хүндтэй мэргэжил болгож чадсан байна. Энэ нь нийгэм дэх тэдний байр суурийг дээшлүүлж улмаар багш бэлдэх хөтөлбөрт авьяастай, тэмүүлэлтэй засуулын тогтвортой урсгалыг татаж чадсан байна.

Тус улсад үндэсний онцлогоос шалтгаалан сургуулиуд нь харьцангуй жижиг буюу цөөн тооны (300 орчим) сурагчтай, нэг анги дунджаар 20 хүүхэдтэй байдаг. Сурагч өөрийн гэрт хамгийн ойрхон сургуульд суралцах ба эцэг, эхийн хүсэлтээр өөр сургуульд суралцах боломжтой.

---

[299] Юнескогийн Олон Улсын боловсролын лавлах
http://www.ibe.unesco.org/fileadmin/user_upload/archive/Countries/WDE/2006/WESTERN_EUROPE/Finland/Finland.htm

Мөн сурагчдын эрүүл, аюулгүй, тав тухтай орчинг бүрдүүлэхэд онцгой анхаарч, илчлэг өндөртэй өдрийн хоол, эрүүл мэнд болон шүдний эмнэлгийн үйлчилгээ, тусламж хэрэгтэй сурагчдад нэмэлт үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлдэг байна. Боловсролоос гадна эдгээр иж бүрэн үйлчилгээг үзүүлэх нь тухайн сурагч амжилттай суралцах нөхцөлийг бүрдүүлж, Финландын сурагчдын сурлагын амжилт ерөнхийдөө жигд өндөр үзүүлэлттэй байдгийн нэг шалтгаан нь юм гэж үздэг байна.

Мөн Финландын тусгай боловсрол шаардлагатай сурагчдын 50 хувь нь энгийн сургуульд суралцдаг ба энэ нь бусад оронтой харьцуулахад харьцангуй өндөр үзүүлэлт юм. Сургууль бүр тусгай хэрэгцээт сурагчдад зориулсан багштай ба эдгээр багш нар тусгай хэрэгцээт сурагчдыг энгийн сурагчидтай хамт сургахад шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, ангийн сурагчдаасаа сурлагаараа хоцрохоос сэргийлэх арга хэмжээ авч ажилладаг.[300]

*Сургалтын хөтөлбөр*

Ерөнхий боловсролын асуудал эрхэлсэн Боловсролын үндэсний зөвлөлөөс үндэсний хэмжээнд мөрдөх үндсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулдаг ба энэхүү хөтөлбөрт хичээлийн сэдвүүдийн ерөнхий агуулга болон зорилтуудыг тусгасан байдаг. Үндсэн сургалтын хөтөлбөрийн дагуу муж бүр сургалтын хөтөлбөрөө боловсруулна, мужийн сургалтын хөтөлбөрт нийцүүлэн сургууль бүр сургалтын хөтөлбөрөө боловсруулж мөрддөг. Үндсэн сургалтын хөтөлбөрт 10 жил тутам буюу 1985, 1994, 2004 болон 2014 онуудад шинэчлэл хийн мөрдөж байна.

Суурь боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлд Боловсролын агуулгыг дараах байдлаар томьёолсон байна.[301]

4. Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр нь 14-р зүйлд заасны дагуу батлагдсан байх ба, үүнд дараах гол хичээлүүд багтана: эх хэл, уран зохиол, хоёр дахь эх хэл, гадаад хэл, хүрээлэн буй орчны судалгаа, эрүүл мэндийн боловсрол, шашны боловсрол болон ёс зүй, түүх, нийгмийн ухаан, математик, физик, хими, биологи, газар зүй, биеийн тамир, хөгжим, дүрслэх урлаг, гар урлал мөн өрхийн эдийн засаг зэрэг хичээлүүд.

5. Сурагч нь сургалтын хөтөлбөрт тодорхойлсны дагуу 1-р хэсэгт дурдсанаас бусад үндсэн суурь боловсролын хичээлийг заалгах, эдгээр хичээлүүдийн заримыг нь, эсхүл бүгдийг сонгох зэрэг чөлөөтэй сонгон суралцах боломжтой.

Мөн хуулийн 14 дүгээр зүйлд Үндсэн сургалтын хөтөлбөр болон хичээлийн цагийн хуваарийг дараах байдлаар тусгасан байна.

1. Засгийн газар энэхүү хуульд заасан үндэсний боловсролын ерөнхий зорилго болон хичээлийн заавар зөвлөмж, хичээлийн групп/бүлэг болон хичээлүүдийг заах цагийн хуваарийг тодорхойлно.
2. Боловсролын үндэсний зөвлөл нь энэ хуульд заасан сургалтын хөтөлбөрүүд, заавар зөвлөгөө болон бусад боловсролд хамаарах зорилт, хичээлүүдийн үндсэн агуулга болон орон нутгийн боловсролын байгууллагын харьяаллын хүрээнд гэр-сургуулийн хамтын ажиллагаа, сурагчдын халамжийн үндсэн зарчим зэргийг тус, тус тодорхойлно.
3. Сургуулийн өмнөх боловсролын хувьд, 2-р дэд бүлэгт дурдсан хичээлийн цагийн хуваарийг Боловсролын яам, Нийгэм эрүүл мэндийн яамтай хамтран боловсруулна. Сургуулийн өмнөх боловсрол, сурагчдын халамжийн болон гэрийн сургуулийн хамтын ажиллагаа зэрэг дэд хэсгийн 2-т дурдсан гол хөтөлбөрийн тухай шийдвэрийг Боловсролын үндэсний зөвлөл шийднэ.

Мөн хуулийн 15 дугаар зүйлд: Боловсрол олгогч байгууллага нь энэ хуульд заасан сургалтын хөтөлбөрийг батална. Финланд, Швед, сами болон бусад хэл дээр явагдах боловсрлын хөтөлбөр тус бүрээр тусдаа хөтөлбөр батална.

---

[300] Финландын боловсролын тогтолцооны товч мэдээлэл http://www.oph.fi/download/146428_Finnish_Education_in_a_Nutshell.pdf
[301] Финландын Суурь боловсролын тухай хууль https://www.finlex.fi/en/laki/kaannokset/1998/en19980628.pdf

Дээрх хуулийн зохицуулалтын дагуу Засгийн газраас нийтлэг сэдвийн хүрээнд тухайн жилийн 7 хоногт үзэх хичээл, цагийн хуваарийг баталдаг. Энэ хуваарь нь жишиг хуваарь бөгөөд Үндэсний сургалтын хөтөлбөрт нийцүүлэн муж болон сургуулиуд хичээл, цагийн хуваариа өөрсдөө батлах эрхтэй байдаг. Хэдийгээр 1-6 дугаар ангийн сурагчид ижил программаар хичээллэх ёстой боловч цаг болон хичээл сонголтын уян хатан бодлогын хүрээнд муж болон сургуулиуд өөр өөр сэдэв дээр төвлөрч болдог. Мөн нэмэлт судлах хичээлийг эцэг эх, асран хамгаалагч сонгох эрхтэй байдаг.

Финландын сургалтын хөтөлбөрийн бас нэг онцлог нь Үндсэн хуулийн 17 дугаар хэсэгт заасны дагуу албан ёсны Финланд, Швед хоёр хэлтэй байдагт оршино. Иймд тухайн сурагч өөрийн эх хэлээ үзэхээс гадна албан ёсны 2 дахь хэлийг 6 дугаар ангиасаа үзэхээр хөтөлбөрт тусгасан байдаг. Гэхдээ тухайн мужийн онцлогоос шалтгаалан мужийн сургалтын хөтөлбөрт эрт заахаар тусгасан бол аль ч ангиас эхлэн суралцах боломжтой.

Харин гадаад хэлийг Засгийн газраас баталсан хуваарийн дагуу 3 дугаар ангиас албан ёсоор үзэхээр тусгасан байдаг ч мөн мужийн онцлогоос шалтгаалан мужийн сургалтын хөтөлбөрийн дагуу аль ч ангиас эхлэн суралцах боломжтой.

*Хүснэгт 8. Бага, дунд ангид судлах хичээлийн цаг*[302]
(7 хоногт үзэх хичээлийн цаг)

| ХИЧЭЭЛИЙН НЭР | АНГИ | | | | | | | | | Нийт цаг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | |
| Эх хэл, уран зохиол | 14 | | 18 | | | | 10 | | | 42 |
| Гадаад хэл | | | 9 | | | | 7 | | | 16 |
| 2 дахь албан ёсны хэл | | | | | | 2 | 4 | | | 6 |
| Математик | 6 | | 15 | | | | 11 | | | 32 |
| Байгаль орчин | 4 | | 10 | | | | | | | |
| Биологи, газар зүй | | | | | | | 7 | | | |
| Физик, хими | | | | | | | 7 | | | |
| Эрүүл мэнд | | | | | | | 3 | | | |
| Байгаль орчин, байгалийн судалгаа | 14 | | | | | | 17 | | | 31 |
| Шашин, ёс зүй | 2 | | 5 | | | | 3 | | | 10 |
| Түүх, нийгэм | | | 5 | | | | 7 | | | 12 |
| Хөгжим | 2 | | 4 | | | | 2 | | | 8 |
| Дүрслэх урлаг | 2 | | 5 | | | | 2 | | | 9 |
| Гар урлал | 4 | | 5 | | | | 2 | | | 11 |
| Биеийн тамир | 4 | | 9 | | | | 7 | | | 20 |
| Өрхийн эдийн засаг | | | | | | | 3 | | | 3 |
| Урлаг болон сонгон судлах хичээл сонгоход | 6 | | | | | | 5 | | | 11 |
| Урлаг болон сонгон судалсан хичээлд нийтдээ | | | | | | | | | | 62 |
| Зөвлөгөө өгөх | | | | | | | 2 | | | 2 |
| Нэмэлт сэдэв | 9 | | | | | | | | | 9 |
| Нэмэлтээр гадаад хэл | | | 12 | | | | | | | 12 |
| Нэмэлтээр 2 дахь эх хэл | | | | | | | 4 | | | 4 |
| Нийт хамгийн багадаа судалбал зохих цаг | | | | | | | | | | 222 |

**5.НОРВЕГ**

Норвег Улс нь “Бага, дунд боловсролын тухай хууль”-ийг (Боловсролын тухай хууль)[303] 1998 онд баталсан бөгөөд 2010-2014 онд нэмэлт, өөрчлөлтүүд оруулсан байна.

Норвегийн боловсролын бодлого нь нийгэм-соёл, оршин суугаа газраас үл хамааран нийгмийн бүх гишүүдэд эрх тэгш боловсрол олгох зарчимд суурилдаг. Боловсролын байгууллагуудын гол зорилго нь мэдлэг, соёлын ур чадварыг дээшлүүлэхээс гадна иргэдийн нийгмийн хэрэгцээг хангаж, нийгмийн сайн сайхан байдлыг дээшлүүлэх явдал

[302] Засгийн газрын тогтоол, 2012.06.28
http://www.oph.fi/download/179422_distribution_of_lesson_hours_in_basic_education_2012.pdf
[303] https://www.regjeringen.no/contentassets/b3b9e92cce6742c39581b661a019e504/education-act-norway-with-amendments-entered-2014-2.pdf

байна. Норвегийн суурь боловсрол нь сурагчдад өөрийгөө илэрхийлэх чадвар, хэл яриа, унших, бичих, ур чадварт суралцах чадварыг суулгах ба хэл, соёл, ёс заншлыг таниулах, хадгалан өвлүүлэх, бусад соёл, ёс заншлыг хүндэтгэх, нийгэмд идэвхтэй оролцох, насан туршийн мэдлэг олгоход чиглэсэн байна.

Бие махбодын болон сэтгэцийн эмгэгтэй хүмүүс, түүнчлэн ямар нэгэн нөхцөл байдлаас шалтгаалан тогтмол сургалттай сургуульд суралцах боломжгүй хүмүүст тусгай боловсрол олгодог.

Стортинг (Норвегийн Парламент) болон Засгийн газар нь боловсролын салбарын төсвийн хөрөнгийн хуваарилалтыг төлөвлөх, хуваарилах үүрэгтэй. Боловсрол, судалгааны яам нь боловсролын тогтолцоог хянах, төрийн боловсролын бодлогын хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий захиргааны байгууллага юм.

Норвег нь ерөнхий стандартад суурилсан сургуулийн нэг тогтолцоотой. Засгийн газрын тогтоосон сургалтын стандартыг хянахын тулд улсын сургалтын хөтөлбөрийг боловсруулан, мөрддөг байна. Заавал эзэмших боловсролын хөтөлбөрийн дагуу арван жилийн боловсрол эзэмших бөгөөд үүнд бага, бүрэн бус дунд, бүрэн дунд сургуулиуд багтана. Боловсролын байгууллагуудын үүрэг нь бүхий л хот, бүс нутагт хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдэд тохирох боловсролоор хангах явдал байна. Орон нутгийн засаг захиргаа нь бага болон дунд сургуулиудын үйл ажиллагааг хариуцдаг бол бүрэн дунд сургуулийн удирдлага, зохион байгуулалтыг бүс нутгийн түвшинд хариуцна.

Норвегид ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгох ба үүнд бүрэн дунд боловсрол орно. Бие даасан хувийн сургуулиуд нь нэмэлт боловсрол олгодог. Бага, дунд боловсролын захиргаа нь боловсролын стандартыг хангасан тохиолдолд бие даасан сургууль байгуулж болоно. Бие даасан сургуулиудын сургалтын хөтөлбөрүүд нь тогтоосон шаардлагыг хангасан байх ба тодорхой шаардлагуудыг хангасан тохиолдолд төрөөс санхүүжилт олгоно.

Норвегид 6-16 насны хүүхдэд 10 жилийн заавал эзэмших боловсрол олгоно. Сургуулийн боловсрол нь 3 шатлалтай байна. Үүнд: бага сургууль (Барнекол), бүрэн бус дунд сургууль (Уустралски), бүрэн дунд сургууль (Видегатеенде сколол) гэсэн 3 шатлалтай.

Бага сургуульд ихэвчлэн 1-ээс 4-р анги, дунд сургуульд 5-аас 7-р анги, ахлах сургуульд 8-аас 10-р анги хүртэл суралцдаг байна. Бага сургуульд заавал судлах хичээлд математик, эх хэл, англи хэлнээс гадна, уран зураг, дуу хөгжим мөн христийн шашин, ёс суртахууны боловсрол, хөдөлмөр болон сонгон нэг нэмэлт хичээл байна. Заавал судлах хичээлүүдээс гадна сурагчид ихэвчлэн (90%) хоёр дахь гадаад хэл сурдаг байна. Сургуулийн эхний өдрөөс эхлэн сурагчдад хүн бүр хувийн зан чанар нь бусадтай харилцсанаар хөгждөг гэдгийг зааж сургаж эхэлдэг байна. Иймд сургалт нь сурагчдын гаргаж буй шийдвэр, тэдгээрийн үр дагаврыг хамтдаа үнэлэхэд суралцах байдлаар зохион байгуулагддаг. Багш нар сурагч бүртэй долоо хоногийн туршид гүйцэтгэх гэрийн болон сургуулийн ажлын төлөвлөгөөг гаргадаг. Багш нар өдөр бүрийн эцэст тусгай тэмдэглэлийн дэвтэрт хүүхдүүдийн амжилтыг тэмдэглэж, шаардлагатай бол эцэг эхчүүдэд ажиглалтаа бичдэг. Норвегийн сургуулийн 1-ээс 7-р ангид дүн тавьдаггүй. Гэхдээ: "багаар ажиллах," "хэлэлцүүлэг," "шийдвэр гаргах" зэргийг дүгнэдэг байна. Сурагчдад 8-р ангиас эхлэн дүн тавих ба шинэ хичээлүүд нэмэгддэг байна. Үүнд: эдийн засаг, экологи, нягтлан бодох бүртгэл ба мэргэжлийн чиг баримжаа олгох хичээлүүд байна.

6 настай 1 дүгээр ангийн бага сургуулийн (Barneskole) сурагчдын хичээл нь хүүхдийг хөгжүүлэх тоглоомын хэлбэрээр явагддаг бөгөөд унших, бичих, тоо бодох чадвартай болж англи хэл сурч эхэлдэг. Хоёрдугаар ангийн хөтөлбөр нь математик, түүх, газарзүй, байгалийн шинжлэх ухааны суурь хичээлүүд орж эхэлдэг байна. Тавдугаар ангиас нийгмийн ухааны хичээлүүд үзэж эхэлдэг байна. Дунд сургуульд сурагчид дээрх хичээлүүдэд гүнзгийрүүлэн судлах бөгөөд 8-р ангиас эхлэн сурагчид өөрсдийн сонирхлоор (valgfag) гадаад хэлнээс герман, франц, испани, эсхүл норвег хэлийг гүнзгийрүүлэн суралцах боломжтой. Дунд сургуульд суралцсан дүнг үндэслэн сурагчид өөрсдийн сонгосон ахлах сургуульд суралцах боломжтой.

1997 онд явагдсан боловсролын шинэтгэлээр сургуульд хамрагдах насыг 7-оос 6 нас болгосон байна. Суурь боловсрол буюу 1-ээс 10-р анги нь үнэ төлбөргүй байна. Жилд 38 долоо хоног хичээллэдэг. Бага сургуульд долоо хоногт 20 цагийн хичээл судална. Математик – 4 цаг, норвег хэл – 6 цаг, байгалийн судлал – 1 цаг, англи хэл – 1 цаг, зураг, хөдөлмөр, биеийн тамир, дуу хөгжим тус бүр - 1-2 цаг, шашин судлал- 2 цаг. Шашны хичээл нь Норвегийн сургуулиуд нь 250 жилийн өмнөөс сүм хийдийг даган байгуулагдаж байсантай холбоотой ба өдгөө библи судлах/шашин судлах нь түүх судлахтай адил гэж тооцдог байна. Ахлах сургууль нь 3 жил байх ба төгсөгчдийн дундаж нас 18-19 нас байна. Сургалтын сүүлийн жил (VG3) сурагчид төгсөлтийн шалгалт өгнө. Ахлах сургууль тус бүр хоёр салбартай байх ба энэ нь академийн сургалт, мэргэжил олгох сургууль байна. Мэргэжил олгох сургуульд хоёр жил суралцсаны дараа сурагчид холбогдох газар, албан байгууллагад цалинтай дадлага (2 жил) хийх бөгөөд, дадлагын хугацаа дууссаны дараа боловсролын гэрчилгээ, мэргэжлийн диплом олгодог.

Ахлах сургуулийн эхний жилд заавал үзэх хичээлд 30 цаг зарцуулдаг. Үүнээс хойш заавал үзэх хичээлийн цаг буурах бөгөөд 2 дахь жилд – 18 цаг, сонгон судлах хичээл – 12 цаг, 3 дахь жилд - 14 цаг, сонгох судлах хичээл – 16 цаг байна. Норвегийн ахлах сургуулиудад шалгалтыг түүвэрлэн явуулах бөгөөд ахлах сургуулийн эхний жилд сурагчдын 10 хувь, хоёр дахь жилд – 25 хувь, гурав дахь жилд сурагчдын 50 хувийг тус тус шалгалтад хамруулдаг байна. Сурагчдад шалгалт авахаас 2 өдрийн өмнө хэн, ямар хичээлээр шалгалт өгөхийг мэдэгддэг байна. Эдгээр сурагчдыг Норвегийн Шалгалтын нарийн бичгийн газраас сурагчдын талаарх мэдээлэл, тэдний сурлагын амжилтын талаарх мэдээллийг авалгүй сонгодог байна. Суралцагчдын шалгалт өгөх хичээлүүд тогтмол байх ба үүнд: мэдээлэл зүй, эдийн засаг, математик (амаар болон бичгээр) мөн англи хэл ордог байна. Дээрх жагсаалтаас 1-2 хичээлээр шалгалт авах бөгөөд төгсөлтийн шалгалтад дээрхээс гадна норвег хэл болон 1 хичээл нэмэлтээр оруулдаг байна.

Ерөнхий боловсролын сургуулиа төгссөний дараа сурагчид их дээд сургууль, коллежид элсэн суралцах зэрэг сонголтоос гадна 1 жил Ардын сургуульд Folkehogskole (Folk high school) суралцаж болдог байна. Энэ төрлийн сургууль анх 150 жилийн өмнө Дани Улсад үүссэн ба өдгөө Скандинавын орнуудад ойролцоогоор 400 орчим байдгаас Норвегид 82 ардын сургууль байдаг байна. Тэдгээр нь ихэвчлэн хот, суурин газраас зайдуу байрлан, спорт, аялал жуулчлал, гадаад хэл, норвег хэл, соёл, гэрэл зураг, хөгжим, театрын урлаг, нийгмийн шинжлэх ухаан, сурган хүмүүжүүлэх ухаан, сэтгүүл зүй зэрэг чиглэлээр дагнадаг байна. Тус сургуулийн диплом нь мэргэжлийн гэрчилгээ бус, харин их, дээд сургуульд элсэх оноонд нэмж тооцож болдог байна.

## 6.КАНАД

Канадын хувьд холбооны түвшинд боловсролын салбарыг хариуцсан салбар яам байхгүй ба үндэсний боловсролын нэгдсэн систем байдаггүй. Канадын Үндсэн хууль (1867он)-д боловсрол олгохтой холбоотой эрх, үүргийг мужуудад олгосон байна. Канад нь арван муж, гурван нутаг дэвсгэрээс бүрдсэн холбооны улс юм. Хойд Канадыг бүрдүүлдэг гурван нутаг дэвсгэр (Нунавут, Баруун хойд бүс нутаг, Юкон)-т үйлчлэх холбооны хуульд мужийн нутаг дэвсгэр бүр боловсрол олгох үүрэг хариуцлагыг адил тэгш хүлээнэ (comparable responsibility) гэж заасан байна. Канадын ерөнхий боловсролтой холбоотой асуудлыг Канадын боловсролын тухай хууль (Education Act), Канадын боловсролын хадгаламжийн тухай хууль (Canada Education Savings Act), муж тус бүрийн боловсролын хуулиудаар зохицуулдаг.

13 мужид яамд, эсхүл департамент нь бага, дунд боловсролын түвшинд боловсрол олгох, зохион байгуулах, үнэлгээ өгөх үүрэгтэй байна. Муж, нутаг дэвсгэр бүр нь өөрийн түүх, соёл болон хүн амын сургалтын хэрэгцээг хангах суурь боловсролын тогтолцооны хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, сургалтын хөтөлбөр, практикийг бий болгоод байна.

Канад Улсад 2013-2014 оны хичээлийн жилд улсын, бага болон дунд сургуульд 4,706,025 сурагч элссэн байна. Бага боловсролд хамрагдах насны хувьд муж улсуудын хувьд харилцан адилгүй байгаа хэдий ч 5 наснаас бага сургуульд элсэн орж, дунд боловсролыг 18 насанд эзэмшиж, төгсөх нь түгээмэл байна.

Газар нутаг, мужуудын боловсролын асуудал хариуцсан сайд нар нь Канадын боловсролын яамны зөвлөлийг бүрдүүлэх ба (Council of Ministers of Education,Canada) Зөвлөлийн хүрээнд харилцан сонирхож буй асуудлаар хэлэлцэх болон арга хэмжээ авахаар хамтран ажилладаг байна.[304]

<u>*Боловсролын тогтолцоо*</u>[305]

Канадын боловсролын тогтолцоог сургуулийн өмнөх, бага болон дунд боловсрол гэж 3 хувааж үздэг байна. Канад Улсад хүүхдүүд муж, нутаг дэвсгэрээс хамааран 5-6 наснаас эхлэн 16-18 нас хүртэл суралцдаг байна. Хичээлийн жилийн 8-р сарын сүүлчээс эхлэн 6-р сарын сүүлч хүртэл хичээллэнэ. Дунд сургуулийг амжилттай төгссөн сурагчдад бага дунд боловсролын гэрчилгээ олгох ба улсын сургуулиуд нь боловсролыг үнэ төлбөргүй олгоно.

Канадын боловсролын тогтолцоог улсдаа боловсролын үзүүлэлтээр тэргүүлдэг Онтарио мужийн жишээн дээр авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Сургуулийн өмнөх насны боловсролд:

- Цэцэрлэгийн өмнөх боловсрол (3-5 нас)
- Бага боловсрол 1-8-р анги (5-6 наснаас 13-14 нас)
- Дунд боловсрол 9-12-р анги (14-15 наснаас-18-21 нас)* -*Зөвхөн Онтарио мужийн хувьд: Дунд сургуулийн сурагчид сургуулиас чөлөө авч болох ба үүнд хугацааны ямарваа нэгэн хязгаар тогтоогоогүй байна*.

Канадын муж, нутаг дэвсгэр бүрийн хувьд сургуульд хамрагдах нас, бага, дунд, ахлах сургуульд суралцаж жил зэргийг ялгаатай тогтоосон байна.

Онтарио мужийн хувьд ойролцоогоор 1,4 сая сурагчид ерөнхий боловсролын сургуульд суралцдагаас бага сургуульд 4000 сурагч сурдаг байна. Бага боловсролын сургалт нь хүүхдийн анхаарлыг төвлөрүүлэх, сурагчдын чадавхыг нээхэд чиглэгдсэн байдаг. Онтарио мужийн 8000 гаруй дунд сургуульд 700,000 гаруй сурагч сурдаг байна.

**7. ХБНГУ**

<u>*Боловсролын тогтолцоо*</u>

ХБНГУ нь 16 муж улс-Ландераас бүрдэнэ. Холбооны Засгийн газар болон муж улсуудын эрх үүргийг Үндсэн хуулиар тогтоосон. Холбооны Боловсрол, судалгааны яам нь боловсролын асуудалтай холбоотойгоор зөвхөн ерөнхий удирдамжуудыг батлах ба муж улс бүр өөрсдөө хууль тогтоомжоо батлан мөрдөнө. Иймд муж улс бүрийн боловсролын тогтолцоо нь харилцан адилгүй байна.

ХБНГУ-ын дээд боловсрол нь “хосолмол тогтолцоо” (binary system)-ын үндсэн дээр явагддаг ба энэ нь академик болон техник, мэргэжлийн боловсрол гэж хуваагддагт оршино. Хичээлүүд нь ихэвчлэн герман хэл дээр авагдах ба Болонийн процессийн хүрээнд англи хэл дээрх хөтөлбөрүүд (гол төлөв магистрын зэрэг олгох)-ийн тоо нэмэгдэж байна.[306]

ХБНГУ нь 6-15 насны (16 нас-Берлин, Бранденбург, Бремен) бүх хүүхдэд заавал эзэмших суурь боловсрол олгоно.

Бага боловсрол (*Primarstufe*)-ыг бага сургууль (*Grundschule)*-д олгох ба 6-10-нас хүртлээ хамрагдана. Германы боловсролын тогтолцоонд зөвхөн бага сургуульд бүх сурагчид нэг төрлийн сургуульд хамрагддаг ба нийтлэг хөтөлбөрийн дагуу ерөнхий хичээл үзнэ. Бага сургуулиа дүүргэсний дараа сурагчид төрөлжсөн дунд сургуулиудад элсэн суралцана. Сурагчдыг авьяас, чадвар сурлагыг үндэслэн холбогдох сургуулиудад хуваарилна. Хуваарилах механизм нь муж мужаар ялгаатай байна. Ихэнх муж улсад эцэг, эхчүүд нь хүүхдээ мэргэжлийн сургалттай дунд сургууль, эсхүл их дээд сургуульд бэлтгэх

---

[304] Канадын боловсролын яамны зөвлөлийн бага, дунд боловсролын цахим хаяг https://www.cmec.ca/680/Elementary-Secondary_Education.html
[305] http://www.edu.gov.on.ca/eng/secondary.html
[306] https://www.nuffic.nl/en/publications/find-a-publication/education-system-germany.pdf

дунд сургуульд оруулахыг өөрсдөө сонгох эрхтэй байдаг бол зарим муж улсад сургуулийн тодорхойлолт нь сургуулийн элсэлтэд ихээхэн нөлөөлдөг бол зарим муж улсад сурагчийн сурлагын голч дүнг үндсэн үзүүлэлт болгон хуваарилдаг байна.

Дунд сургууль нь 10-16 насны сурагч хамрагдах дунд сургууль I (*Sekundarstufe/Sekundarbereich I)* болон 16-19 насны сурагч хамрагдах дунд сургуульд II (*Sekundarstufe*/*Sekundarbereich II)*-д хуваагдана.

- Дунд сургууль I (Sekundarstufe I) нь гимназийн 5-10 анги, Хаупцчүл (*Hauptschule, 9-р анги)* болон Реалсчүл (*Realschule, 10-р анги)* зэргийг хамарна.
- Дунд сургууль II (Sekundarstufe II) нь гимназийн хоёр дахь хэсэг дунд сургууль (*Oberstufe*)-ийн 11-13-р анги, тусгай ахлах сургууль, мэргэжлийн сургалт, ажил, хичээл хосолсон дадлага-сургалт зэргийг хамарна.

Сурагчид нь хамгийн багадаа нэг гадаад хэлийг доод тал нь 5 жил сурах ба гимназид гадаад хэл нь заавал сурах хичээлийн тоонд багтдаг.

*Үндэсний өв соёлыг сургалтын хөтөлбөрт тусгасан байдал*

Германы бага, дунд сургуулиудын сургалтын хөтөлбөрөөс үзэхэд үндэсний өв, соёлыг хэд хэдэн хичээлийн хүрээнд судалж байна. Үүнд: газар зүй, улс төрийн шинжлэх ухаан, түүх, эх хэл, гадаад хэл, дуу хөгжим, шашин судлал зэрэг байна.

## 8.ЭСТОНИ

Эстони Улсад Парламент, Засгийн газар болон Боловсрол, шинжлэх ухааны яам нь боловсролын салбартай холбоотой бодлого боловсруулж, эрх үүргийг хэрэгжүүлнэ. Тус улс нь ХБНГУ-тай адил дээд боловсролын "хосолмол тогтолцоо"-той, академик судалгаанд болон мэргэжлийн сургалтад чиглэсэн гэж хуваагдана. Албан ёсны хэл эстони ба үндэсний цөөнх болох орос сурагчдад зориулсан эстони, орос хоёр хэл дээр явагдах сургалтын хөтөлбөртэй сургуулиудтай.[307]

Эстоний Суурь сургууль болон бүрэн дунд сургуулийн тухай хууль (*Basic Schools and Upper Secondary Schools Act*)-д заасны дагуу суурь боловсрол нь заавал эзэмших боловсролын доод хэмжээг заана. 10 дугаар сарын 1-ний байдлаар *7 нас хүрсэн хүүхэд* бүр сургуульд элсэн суралцах ба суурь боловсрол эзэмшиж дуусах нас 17 байна.

Орон нутгийн, эсхүл хотын засаг захиргаа нь өөрийн нутаг дэвсгэр дээр амьдарч буй хүүхэд бүрийг суурь боловсролоор хангах үүрэг хүлээнэ. Сургуульд хүүхдийг хуваарилахад дараахыг үндсэн шалгуур болгоно. Үүнд: сургуулийн байршил (хүүхдийн гэрт хамгийн ойр байрлах сургууль), хүүхдийн ах, эгч нь явдаг сургууль болон эцэг, эхийн сонголт зэрэг байна.

Суурь боловсролыг эцэг, эхийн хүсэлтээр, эсхүл эрүүл мэндийн шалтгаанаар гэрээр олгож болно. Зайны сургалтыг 17 нас хүрсэн, эсхүл онцгой тохиолдолд 17-с доош насны сурагчдад зөвлөх комиссын саналыг үндэслэн олгоно. Бага сургуульд хамрагдахаас өмнө хүүхдийн сургуульд элсэхэд бэлэн байгаа эсэхийг сургуулийн өмнөх боловсролын байгууллага (СӨБ-д хамрагддаггүй хүүхдийг хүүхдийн асран хүмүүжүүлэх байгууллага болон Бүс нутгийн зөвлөх төв) үнэлнэ.

Сургуульд хамрагдахаар заасан наснаас бага насны хүүхдийг эцэг, эхийн хүсэлт болон сургуульд бэлэн эсэхийг үнэлэх эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийг үндэслэн сургуульд хамруулж болно.

Сургууль бүр өөрийн харьяанд байгаа хүүхэд бүрийг хүлээн авах үүрэгтэй. Эцэг, эх нь хүүхдээ орон тоо байгаа тохиолдолд харьяаны өөр сургуульд элсүүлж болно. Хүүхдүүд нь өөрсдийн харьяа сургуульд элсэлтийн шалгалтгүй орох бол зарим тусгай/гүнзгийрүүлсэн сургалттай, элсэлтийг улсын хэмжээнд зохион явуулдаг сургууль нь хүүхдийн авьяас, чадварыг тогтоох элсэлтийн шалгалт авч болно. Хувийн сургуулиуд нь элсэлтийн нэмэлт шалгуур тогтоож болдог байна.

[307] https://www.nuffic.nl/en/publications/find-a-publication/education-system-estonia.pdf

Харин хөрөнгө оруулалтын төрөл зүйлийн даатгал нь хандив болон бүх насны бодлогыг багтаасан байх ба, шимтгэлээ төлж буй бүх цаг хугацаанд хүчинтэй байна. Үндсэндээ шимтгэлийн зарим хэсгээр хөрөнгө оруулалт хийж өртөг бүтээнэ. Үүнийг даатгуулагчийг нас барахаас ч өмнө бэлэн мөнгөний хэлбэрээр олгох боломжтой.

**Нийтийн хариуцлагын даатгал**

Даатгуулагч этгээдийн зүгээс гуравдагч этгээдэд учруулсан хохирлыг даатгагчаар нөхөн төлүүлэхээр тохиролцож хийсэн албан журмын даатгал юм. Энэ нь жолоочийн, эмчийн, өмгөөлөгчийн хариуцлагын даатгал гэх мэт олон төрөл байна. Нийтийн хариуцлагын даатгалын харилцааг Автотээврийн аюулгүй байдал, хариуцлагын тухай хууль болон Даатгалын тухай хуулиар тус тус зохицуулдаг.

**Барилга болон эд хөрөнгийн даатгал**

Энэ даатгал нь хүний эд хөрөнгө, хогшил, эсхүл агуулах нөөц зэргийг гал, ус болон газар хөдлөлт, аянга, шуурга, дэлбэрэлт, хулгай зэрэг бусад хохирлоос хамгаалах зорилготой. Энэхүү даатгалын харилцааг Даатгалын тухай хууль, Газар хөдлөлтийн тухай хууль болон Автотээврийн аюулгүй байдал, хариуцлагын тухай хуулиар тус тус зохицуулдаг байна.

## 3.ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС (АВСТРИ, ШВЕЙЦАР)

Даатгуулах үүргийг хуулиар тогтоосон даатгалыг албан журмын (заавал хамрагдах) даатгал гэнэ.[330] Олон улс оронд тээврийн хэрэгслийн хариуцлагын даатгал, ажил мэргэжлийн хариуцлагын даатгал болон ялангуяа, нийгмийн даатгалыг албан журмын даатгал (АЖД)-д хамруулдаг байна. Гэхдээ хамгийн гол нь албадан гишүүнчлэлтэй байх төрийн даатгалын систем (ялангуяа нийгмийн даатгал) үү, аль эсхүл хувийн даатгалд заавал даатгуулах үүрэг хүлээсэн байна уу гэдгээрээ л ялгаатай байдаг. Германд гуравдагч этгээдийг хамгаалах зорилгоор хийгддэг даатгал болох тээврийн хэрэгслийн, ажил мэргэжлийн болон анчны хариуцлагын даатгалууд гэж бий. Ажил мэргэжлийн хоршооны хувьд, хөдөлмөрийн ослын эсрэг даатгалын хуулиар энэхүү хамгаалалтыг төрөөс албадан гишүүнчлэлтэй байлгах замаар хэрэгжүүлсэн байдаг.

Хуульчилсан албан журмын даатгал нь Германы Үндсэн хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тусгагдсан хүний үндсэн эрх болох гэрээ хэлцлийн эрх чөлөөний зарчимтай харшилдаж байдаг. Ийнхүү албан журмын даатгалаар гэрээ хэлцлийн эрх чөлөөг хязгаарлах нь онцгой үндэслэлтэй юм. Тухайлбал, гуравдагч этгээдийг хамгаалах (хариуцлагын даатгалын хувьд), эрүүл мэндийг хамгаалах болон хэрэглэгчийг хамгаалах нь учир шалтгаан мөн.

Даатгалын компанийн хувьд албан журмын даатгал хийхдээ албадан гэрээ байгуулах нь олонтоо. Түүхэнд албан журмын даатгал нь даатгалын монопольтой ихээхэн холбоотой байсан гэж үздэг.

### Нийгмийн даатгал

Германд нийгмийн даатгал нь доорх 5 даатгалаас бүрдэнэ.[331] Үүнд:

1. Өвчтөний даатгал;
2. Тэтгэврийн даатгал;
3. Ослын даатгал;
4. Ажилгүйдлийн даатгал;
5. Асаргааны даатгал[332] зэрэг болно.

Австрид нийгмийн даатгал нь доорх 4 даатгалаас бүрдэнэ.[333] Үүнд:

1. Өвчтөний даатгал;
2. Тэтгэврийн даатгал;
3. Ослын даатгал;
4. Ажилгүйдлийн даатгал орно.

Швейцарт нийгмийн даатгал нь доорх 8 даатгалаас бүрдэнэ.[334] Үүнд:

1. Өвчтөний даатгал;
2. Өндөр насны болон тэжээгчээ алдсаны даатгал (ӨНТАД);
3. Ослын даатгал;
4. Ажилгүйдлийн даатгал;
5. Тахир дутуугийн даатгал (ТДД);
6. Ажил мэргэжлийн халамж;
7. Цэргийн ба иргэний алба хаах болон амаржсан үеийн хөдөлмөр орлуулалт;
8. ӨНТАД болон ТДД-ын нэмэлт зэрэг болно.

---

[330] Албан журмын даатгал-Pflichtversicherung(*германаар)* https://de.wikipedia.org/wiki/Pflichtversicherung

[331] Нийгмийн даатгал (*германаар*) Sozialversicherung (Deutschland (*германаар))* https://de.wikipedia.org/wiki/Sozialversicherung_(Deutschland)

[332] Pflegeversicherung (*германаар)*

[333] Нийгмийн даатгал (Австри)-Sozialversicherung (Österreich)-*германаар* https://de.wikipedia.org/wiki/Sozialversicherung_(%C3%96sterreich)

[334] Нийгмийн даатгал (Швейцар)-Sozialversicherungen (Schweiz)-*германаар* https://de.wikipedia.org/wiki/Sozialversicherungen_(Schweiz)

Германд нийгмийн даатгалын эрх зүйн үндсийг Нийгмийн тухай багц хууль (НТБХ) бүрдүүлдэг байна. Нийгмийн даатгалын багц хууль нь доорх хуулиудаас бүрдэнэ. Үүнд:

- Нийгмийн даатгалын бүх салбаруудад хамаарах ерөнхий агуулга: Нийгмийн тухай багц хуулийн 4 дүгээр боть;
- Өвчтөний даатгал: НТБХ-ийн 5 дугаар боть;
- Тэтгэврийн даатгал: НТБХ-ийн 6 дугаар боть;
- Ослын даатгал: НТБХ-ийн 7 дугаар боть;
- Асаргааны даатгал: НТБХ-ийн 11 дүгээр боть;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих: НТБХ-ийн 3 дугаар боть болно.

Аж ахуйн нэгж (ААН)-үүдэд нийгмийн даатгалын шалгалтыг тодорхой давтамжтайгаар тогтмол оруулах замаар энэхүү зохицуулалтуудыг даган мөрдөж байгаа эсэхэд хяналт тавьдаг.

Түүнээс гадна НТБХ-ийн 1 болон 10 дугаар зүйлд тус тус тусгасан ерөнхий зохицуулалтуудыг мөн мөрдөнө. Эзэнт гүрний даатгалын дүрэм[335] (1913-1992 онд германы эрхзүйн тогтолцооны цөм нь байсан)-ийн цөөн зарим заалтыг ч бас мөрддөг.

Нийгмийн даатгалын ихэнх хэсэг нь шимтгэл (гишүүнчлэлийн хураамж)-ээс бүрдэх бөгөөд зарим салбарт төсвөөс (Эрүүл мэндийн сан) санхүүждэг байна.

Австрид нийгмийн даатгалын эрх зүйн орчныг доорх хуулиуд бүрдүүлдэг. Үүнд:

- Нийгмийн даатгалын ерөнхий хууль;
- Тариачны нийгмийн даатгалын хууль;
- Аж ахуй (бизнес) эрхлэгчийн нийгмийн даатгалын хууль;
- Чөлөөт ажил мэргэжил эрхлэгчийн нийгмийн даатгалын хууль;
- Төрийн албан хаагчийн өвчний болон ослын даатгалын хууль;
- Тэтгэврийн ерөнхий хууль.

Австрийн Нийгмийн даатгалын ерөнхий газар нь нийгмийн даатгалын чип карт үйлдвэрлэлт болон ашиглалтын охин компани (ХХК) байгуулсан байдаг. Мөн өвчтөний даатгалын бүх байгууллага мэдээллийн технологийн үйлчилгээ эрхлэх охин компани (ХХК)-тай байдаг. Тариачны болон аж ахуй эрхлэгчийн нийгмийн даатгалын газар нь арын алба[336] хамтран залгуулах зорилгоор конторын удирдлагын ХХК байгуулсан бөгөөд хожим нь төрийн албан хаагчийн болон төмөр зам, уул уурхайн даатгалын газрууд нэгдсэн байна.

Швейцарт нийгмийн даатгалын эрх зүйн орчны үндсийг Швейцарын Холбооны Үндсэн хуулийн 111-114 дэх болон 116-117 дахь зүйлүүд тавьдаг.

111 дэх зүйлд, өндөр нас, тэжээгчээ алдсан болон тахир дутуугийн халамжийг зохицуулах “Гурван-Баганат-Зарчим” нэртэй бүтцийг тодорхойлсон байдаг. 112 дахь зүйлд ӨНТАД болон ТТД, 113 дахь зүйлд ажил мэргэжлийн халамж, 114 дэх зүйлд ажилгүйтлийн даатгал, 116 дахь зүйлд гэр бүлийн нэмэгдэл болон амаржсан эхийн даатгал, 117 дахь зүйлд өвчтөний болон ослын даатгалыг тус тус зохицуулсан байна.

Ийнхүү ӨНТАД болон ТДД, тэдгээрийн нэмэлт нь швейцар-гурван-баганат-системийн эхний багана болох төрийн баганыг илэрхийлдэг бөгөөд хүний үндсэн хэрэгцээг найдвартай хангах зорилготой юм.

**Хариуцлагын албан журмын даатгал**

Германд хариуцлагын албан журмын доорх даатгалууд бий. Үүнд:

- Тээврийн хэрэгслийн хариуцлагын даатгал (Европын ихэнх улсад);

[335] Reichsversicherungsordnung (*германаар)*
[336] Backoffice-*англиар*

- Ажил мэргэжлийн хариуцлагын даатгал (хуулийн өмгөөлөгч, патентын өмгөөлөгч, нотариус, архитектор, инженер, эдийн засгийн захирагч[337] (эдийн засгийн шалган байцаагч болон татварын зөвлөх) болон эмчийн хувьд албан журмын);
- Үйлдвэрлэлийн хариуцлагын даатгал (тодорхой салбар болон аж ахуй эрхлэх чиглэлээр);
- Анчны хариуцлагын даатгал (анчны үнэмлэх олгох нөхцөл болдог);
- Гэрийн амьтан тэжээгчийн хариуцлагын даатгал (тухайлбал, нохой) зэрэг болно.

Германы аялал жуулчлалын эрх зүйд 1994 оноос хойш шинээр тогтсон нэг онцлог гэвэл, аялал жуулчлалын багц[338] үйлчилгээ үзүүлэгч компаниуд нь **дампуурлын үр дагаврын эсрэг албан журмын даатгалд** хамрагдсанаа нотолж аяллын аюулгүй байдлын гэрчилгээ авдаг болсон.

**Галын даатгал**

Галын даатгал нь дэлхий дээрх хамгийн эртний даатгал бөгөөд Германы Хамбург хотын зөвлөлөөс 1676 онд анх “Хамбургийн галын касс” нэртэйгээр байгуулж байжээ. Үндэс суурийг нь шар айргийн үйлдвэрүүдийн 1591 онд байгуулсан “Хамбургийн галын гэрээ” тавьсан гэж үздэг. Галын даатгал нь анхнаасаа албын журмынх байсан бөгөөд 1994 он хүртэл хэрэгжсэн байдаг. Гэвч Кассел хотод одоо болтол Галын касс ажилладаг бөгөөд 90-ээд оны сүүлчээр орон нутгийн Хадгаламжийн касс (банк)-анд даатгал хэлбэрээр нэгт-гэсэн байдаг.[339]

Одоо Галаас хамгаалалтын татвар нэртэй болсон бөгөөд Германд муж улсын харин Австрид холбооны улсын татвар (хэдийгээр холбооны татвар боловч мужуудад шууд хуваарилдаг)-т багтдаг байна. Галаас хамгаалалтын татварыг галын даатгал (галын улмаас үйлдвэрлэл зогсолтын даатгалыг оруулан) болон байшин барилга, эд хогшлын даатгал хийгдсэн нөхцөлд шимтгэлд нь ногдуулж авдаг байна.[340]

Шинэ мянганы эхэн хүртэл **зандалчилал** (терроризм)-аас үүдэлтэй хохирлыг галын даатгалд хамруулдаг байсан боловч 2011.09.11-ний өдрийн үйл явдлаас хойш бүх даатгалын байгууллага уг эрсдэлийг даатгалын гэрээнээсээ түр хасаад байсан юм. Энэ хооронд зандалчилалын эрсдэлийг төрийн оролцоо бүхий “Экстремус-Даатгал” ХК (хувьцаат компани буюу олон нийтийн нийгэмлэг)-д даатгуулж болно. Гэхдээ зөвхөн ААН (аж ахуйн нэгж)-д хамаарах ба хувь хүн хангалттай нөхцөлөөр даатгуулах боломж хараахан бүрдээгүй байгаа болно.[341]

## 4. БҮГД НАЙРАМДАХ АЗЕРБАЙЖАН УЛС

Азербайжан улсад албан журмын даатгалын харилцааг **Бүгд Найрамдах Азербайжан Улсын Албан журмын даатгалын тухай хуулиар** *(Law of the Azerbaijan Republic on Compulsory insurances)*[342] зохицуулдаг. Өөрөөр хэлбэл, албан журмын даатгалын тухай бие даасан хуультай орон юм.

Мөн зарим нэр төрлийн албан журмын даатгалыг тусдаа хуулиар зохицуулдаг. Тухайлбал, аудиторын мэргэжлийн хариуцлагын албан журмын даатгал, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал гэх мэт.

Азербайжан улсад албан журмын даатгалын асуудлыг хариуцах үүрэгтэй *Албан журмын даатгалын хороо* ажилладаг. Албан журмын даатгалын хороо нь Бүгд Найрамдах Азербайжан Улсын Иргэний хууль болон Албан журмын даатгалын тухай

---

337 Wirtschaftstreuhänder (*германаар)*
338 Pauschalreise (*германаар)*
339 Г.Алтан-Оч нар “Үл хөдлөх хөрөнгийг ‘Галын заавал даатгал’-д хамруулах эрхзүйн зохицуулалтын зарим жишиг, гадаадын туршлага” СТ-14/432 2014 УИХТГ-ын Судалгааны эмхэтгэл-20
340 Мөн тэнд
341 Мөн тэнд
342 Бүгд Найрамдах Азербайжан Улсын Албан журмын даатгалын тухай хууль http://isb.az/wp-content/uploads/2015/03/LAW-ON-COMPULSORY-INSURANCES-Adopted.pdf

хуулийн дагуу байгуулагдсан мэргэшсэн үйл ажиллагаа явуулдаг байгууллага бөгөөд даатгуулагч болон гуравдагч этгээд буюу хохирогчийн эрх ашгийг хамгаалах, мөн Албан журмын даатгалын тухай хуульд заасан шаардлагыг хангасан, албан журмын даатгалын тогтолцоог тогтворжуулах, хөгжүүлэх, хууль тогтоомжид заасан бусад үүргийг биелүүлэх зорилготой.

Албан журмын даатгалын тухай хуульд тодорхойлсноор дараах албан журмын даатгалууд байна[343]. Үүнд:

- Үл хөдлөх хөрөнгийн албан журмын даатгал (*Compulsory real property insurance*);
- Үл хөдлөх хөрөнгийг ашиглахтай холбоотой гуравдагч этгээдийг хамгаалах хариуцлагын албан журмын даатгал (*Compulsory third party liability insurance associated with the use of the real property*);
- Авто тээврийн хэрэгслийн гуравдагч этгээдийг хамгаалах хариуцлагын албан журмын даатгал (*Compulsory third party liability insurance of motor vehicles*);
- Зорчигчийн гэнэтийн ослын албан журмын даатгал (*Compulsory personal accident insurance of passengers*);
- Хөдөлмөрийн осол болон мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын албан журмын даатгал (*Compulsory insurance against loss of professional work capacity as a result of labor accidents and occupational diseases*);
- Олон улсын зам тээврийн Ногоон картын даатгалын систем (Green Card) зэрэг болно.

**Үл хөдлөх хөрөнгийн албан журмын даатгал**
(*Compulsory real property insurance*)

Үл хөдлөх хөрөнгийн албан журмын даатгалтай холбоотой харилцааг Бүгд Найрамдах Азербайжан Улсын Албан журмын даатгалын тухай хуулийн холбогдох зүйл заалтаар зохицуулна. Галын болон бусад нөхцөл байдлын улмаас үл хөдлөх хөрөнгөд учирсан аливаа эвдрэл, гэмтлийн хохирлыг нөхөн төлөх зорилгоор үл хөдлөх хөрөнгийн албан журмын даатгалыг хэрэглэдэг.

Холбогдох эрх бүхий байгууллагаас гаргасан жагсаалтад заасан барилга байгууламж, орон сууц болон орон сууцны бус зориулалттай үл хөдлөх хөрөнгө, орон сууцны зориулалтай хаус, байшин барилга, мөн төрийн өмчийг заавал даатгуулах ёстой.

Орон сууцтай холбоотой албан журмын даатгал нь барилга байгууламжийн элементүүд, өрөө тасалгаа, хаалга болон цонхны элементүүд, цэвэр бохир усны шугам, хийн хоолой, халаалтын шугам, холбоо, цахилгааны болон бусад шугам утас, гоёл чимэглэлийн элементүүд, бүх төрлийн гадна болон дотор засал чимэглэл, хана, тааз, шал зэрэг бүхий л төрлийн материалууд гэмтсэн тохиолдолд нөхөн олговор олгоно.

Үл хөдлөх хөрөнгийн объектод Азербайжаны хуулиар зөвшөөрөгдөөгүй газар баригдсан, эсвэл засгийн газар болон мужын захиргаанаас нураах шийдвэр гарсан, баригдаж дуусаагүй, аюултай нөхцөл байдалд байгаа үл хөдлөх хөрөнгүүд орно.

**Үл хөдлөх хөрөнгийг ашиглахтай холбоотой**
**гуравдагч этгээдийг хамгаалах хариуцлагын албан журмын даатгал**
*(Compulsory third party liability insurance associated with the use of the real property)*

Үл хөдлөх хөрөнгийг ашиглахтай холбоотой гуравдагч этгээдийг хамгаалах хариуцлагын албан журмын даатгалыг Бүгд Найрамдах Азербайжан Улсын Албан журмын даатгалын тухай хуулиар зохицуулна.

Энэ даатгал нь тухайн үл хөдлөх хөрөнгийг ашиглах явцад, мөн тухайн барилга байгууламжийг барих, засварлах, сэргээн босгох, эсвэл бусад ажлыг гүйцэтгэх үеэр гуравдагч этгээдийн эрүүл мэнд болон эд хөрөнгөд учруулсан хохирлыг нөхөн олгох зорилготой.

---

[343] http://isb.az/en/

Уг даатгалд байшин, барилга байгууламж, орон сууц, мөн хуулийн этгээдийн үйл ажиллагаа явуулж буй байгууламж, талбай болон хувь хүний үйл ажиллагаа явуулах зориулалтаар эзэмшдэг байгууламж, талбай зэрэг үл хөдлөх хөрөнгийг хамруулдаг. Энэ төрлийн үл хөдлөх хөрөнгө эзэмшдэг бол даатгалд заавал даатгуулна.

**Авто тээврийн хэрэгслийн гуравдагч**
**этгээдийг хамгаалах хариуцлагын албан журмын даатгал**
*(Compulsory third party liability insurance of motor vehicles)*

Уг даатгалтай холбоотой харилцааг Бүгд Найрамдах Азербайжан Улсын Албан журмын даатгалын тухай хуулиар зохицуулна.

Энэхүү даатгалыг Азербайжаны нутаг дэвсгэрт авто тээврийн хэрэгслийг ашиглах явцад хувь хүний эрүүл мэнд болон эд хөрөнгө, мөн хуулийн этгээдийн эд хөрөнгөд учирч болох хохирлыг нөхөн төлөх зорилгоор хэрэглэдэг.

Авто тээврийн хэрэгслийн гуравдагч этгээдийг хамгаалах хариуцлагын албан журмын даатгал нь дараах төрлийн тээврийн хэрэгсэл эзэмшигчдэд хамаарах бөгөөд авто тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн багтаамж нь 50см$^3$-ээс илүү эзэлхүүнтэй байна. Үүнд:

- Зорчигч тээврийн хэрэгсэл болон ижил зориулалттай бусад тээврийн хэрэгсэл;
- Ачааны машин болон ижил зориулалттай бусад тээврийн хэрэгсэл;
- Микро-автобус, автобус болон ижил зориулалттай бусад тээврийн хэрэгсэл;
- Мотоцикл болон моторт дугуйнууд;
- Авто зам, ойн аж ахуй болон хөдөө аж ахуйн зориулалтаар ашигладаг тракторууд;
- Троллейбус, трамвай зэрэг болно.

**Зорчигчийн гэнэтийн ослын албан журмын даатгал**
*(Compulsory personal accident insurance of passengers)*

Зорчигчийн гэнэтийн ослын албан журмын даатгалтай холбоотой харилцааг Бүгд Найрамдах Азербайжан Улсын Албан журмын даатгалын тухай хуульд заавал даатгуулахаар зохицуулсан. Энэ даатгалыг агаар, ус, төмөр, авто замуудаар зорчих явцад зорчигчдын эрүүл мэнд, амь насанд учирч болзошгүй хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор хэрэглэдэг. Уг даатгалд заавал хамрагдах ёстой.

**Хөдөлмөрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний**
**улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын албан журмын даатгал**[344]
*(Compulsory insurance against loss of professional work capacity as a result of labor accidents and occupational diseases)*

Энэ нь Бүгд Найрамдах Азербайжан Улсын Албан журмын даатгалын тухай хуулиар зохицуулагдана. Энэхүү даатгалд даатгуулснаар хөдөлмөрийн осол болон мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас амь насаа алдах, эсвэл эрүүл мэндэд хохирол учруулснаар хөдөлмөрийн чадвар алдах тохиолдолд нөхөн олговор олгоно. Уг даатгалд дараах этгээд заавал даатгуулж, даатгалын гэрээ байгуулах үүрэгтэй. Үүнд:

- Азербайжан болон гадаад улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан бөгөөд тус улсад үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд, үүнд албан газар, байгууллага тэдгээрийн салбар, төлөөлөгчийн газар зэрэг нь өмчийн болон зохион байгуулалтын хэлбэр харгалзахгүй хамрагдах;
- Төрийн байгууллагууд;
- Хуулийн этгээд байгуулахгүйгээр аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй хувь хүн (физические лица, занимающиеся предпринимательской деятельностью без создания юридического лица);
- Сонгуулийн байгууллагууд;
- Аж ахуйн үйл ажиллагаа болон хувиараа хөдөлмөр эрхэлж буй хувь хүн (физические лица, занимающиеся предпринимательской и трудовой деятельностью индивидуальным образом) хамрагдана.

[344] http://isb.az/ru/istehsalatda-bedbext-hadiseler-ve-pese-xestelikleri-neticesinde-pese-emek-qabiliyyetinin-itirilmesi-hallarindan-icbari-sigorta-ru/

Дараах хүмүүс даатгалд заавал хамрагдах ёстой. Үүнд:

- Бүгд Найрамдах Азербайжан Улсын Хөдөлмөрийн хууль болон Иргэний хуульд заасны дагуу хуулийн этгээд болон аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг хувь хүнтэй хөдөлмөрийн гэрээ, эсвэл иргэний гэрээ байгуулан ажиллаж буй этгээд, төрийн албан хаагчид, бусад албан хаагчид (Тусдаа хуулиар зохицуулагдах тул цэргийн албан хаагчид, "Шүүх болон хууль сахиулах байгууллагын албан хаагчийн төрийн тусгай албан журмын даатгалын тухай хууль"-ийн 2 дугаар зүйлд заасан байгууллагуудад, мөн "Цэргийн албан хаагчийн төрийн тусгай албан журмын даатгалын тухай хууль"-ийн 2 дугаар зүйлд заасан байгууллагуудад ажилладаг тусгай цолтой этгээд үүнд хамаарахгүй);
- Сонгуульт ажилтай бөгөөд нийгмийн даатгалд заавал хамрагддаг ажилтан (үүнд Парламентын 2 танхимын гишүүд хамаарахгүй) ;
- Үйлдвэрлэлийн дадлагад гарч буй оюутан, сурагчид;
- Аж ахуйн нэгжид ажиллаж буй цэргийн албан хаагчид;
- Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн үр дагаврыг арилгах ажиллагаанд ажиллаж буй этгээд, мөн дайны болон онцгой нөхцөлд ажиллаж буй этгээд;
- Аж ахуйн үйл ажиллагаа болон хувиараа хөдөлмөр эрхэлж буй хувь хүн;
- Бүгд Найрамдах Азербайжан Улсын Хөдөлмөрийн хуулийн дагуу тус улсад хөдөлмөрлөж байгаа гадаадын иргэн болон харьяалалгүй этгээд нь хөдөлмөрийн гэнэтийн осол, эсвэл мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдах тохиолдолд уг даатгалд мөн адил хамрагдана (Бүгд Найрамдах Азербайжан Улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу нийгмийн даатгалд заавал даатгуулахгүй гадаад иргэн орохгүй).

Даатгалын гэрээнд хөдөлмөрийн гэнэтийн осол болон мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдах тохиолдолд нөхөн олговрыг холбогдох байгууллагаас зохих журмын дагуу тооцоолсон жилийн цалингийн хэмжээг үндэслэн тогтооно. Нөхөн олговорийг дараах тохиолдолд олгоно. Үүнд:

- Хөдөлмөрийн гэнэтийн осол, эсвэл мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас амь насаа алдах;
- Хөдөлмөрийн гэнэтийн осол, эсвэл мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдах зэрэг болно.

Нөхөн олговрыг сар бүр, нэг удаа, нэмэлт гэсэн 3 хэлбэрээр олгодог.

**Олон улсын зам тээврийн ногоон картын даатгалын систем**
*(Green card)*

Ногоон картын системийг 1949 онд НҮБ-ын Европын Эдийн засгийн Комисс (UNECE)-аас санаачлан боловсруулсан бөгөөд хил дамнасан зам тээврийн хөдөлгөөнийг хөнгөвчлөх зорилготой гаргасан байна.

Энэ нь гишүүн орнуудын хувьд оролцогч талуудын авто тээврийн хэрэгслийн даатгалын гэрээний дагуу гуравдагч этгээдийг хамгаалах хариуцлагын даатгалыг харилцан хүлээн зөвшөөрөх тухай гэрээ юм.

Ногоон картын гэрээнд заасны дагуу гишүүн орны засгийн газраас гаргасан авто тээврийн хэрэгслийн даатгалын гэрээний гуравдагч этгээдийг хамгаалах хариуцлагын даатгал нь гишүүн орнуудын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр гэж тооцогдоно. Одоогийн байдлаар тус гэрээнд 48 орон гишүүнчлэлтэй байна. Гишүүн орон бүрт Ногоон картын Хороо ажилладаг.

Азербайжан Улс нь 2012 онд Ногоон картад нэгдэх хүсэлт гаргаж, гишүүнээр элссэн. Ийнхүү гишүүн орон болсноор Албан журмын даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд Ногоон карттай холбоотой зохицуулалтуудыг оруулсан. Эдгээр зохицуулалтыг 2016 оны 1 дүгээр сарын 1-нээс даган мөрдөж байна.

**Аудиторын мэргэжлийн хариуцлагын албан журмын даатгал**
*(On compulsory insurance of auditors professional liability)*

Энэ даатгал нь **Бүгд Найрамдах Азербайжан Улсын Аудиторын мэргэжлийн хариуцлагын албан журмын даатгалын тухай хууль** *(The Law of the Republic of Azerbaijan on compulsory insurance of auditor's professional liability)* буюу тусгайлсан хуулиар зохиулагддаг.

Уг хуулиар Азербайжан улсад аудитын үйлчилгээ явуулдаг хувь хүн болон хуулийн этгээдийн мэргэжлийн хариуцлагын албан журмын даатгалтай холбоотой харилцааг зохицуулах, түүний зохион байгуулалт, эрх зүй болон эдийн засгийн зарчмуудыг тодорхойлно.

Дараах тохиолдлуудыг аудиторын мэргэжлийн хариуцлагын даатгалд хамруулна[345]. Үүнд:

- Аудитын үйлчилгээний салбарт мөрдөгдөж буй норматив, хууль тогтоомж, стандарт, дүрэм журмын шаардлагыг зөрчих;
- Нягтлан бодох бүртгэл (санхүүгийн) болон татварын тайлангийн алдаа, зөрчилтэй мэдээллийг илрүүлж чадаагүй;
- Илэрсэн алдаа болон зөрчлийг арилгах зөв зохистой зөвлөмж өгч чадаагүй;
- Аудитын ажлыг чанар муутай гүйцэтгэх, ажлыг хугацаанд бүрэн гүйцэт хийж дуусгаагүй;
- Нууцлалын зарчмыг зөрчих зэрэг орно.

## Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалтай холбоотой харилцааг **Бүгд Найрамдах Азербайжан Улсын Нийгмийн даатгалын тухай хуулиар** (*Закон Азербайджанской Республики О социальном страховании*) зохицуулах бөгөөд нийгмийн даатгалын эрх зүй, эдийн засаг, зохион байгуулалтын үндсийг тодорхойлно.

Нийгмийн даатгал нь заавал даатгуулах (албан журмын даатгал) ба сайн дурын даатгал гэсэн 2 хэлбэртэй байна[346]. Заавал даатгуулах нийгмийн даатгал нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй бүх этгээдэд хамааралтай. Мөн хуульд заасан бусад этгээд хамрагдана.

Дараах тохиолдлуудад нийгмийн даатгалаас мөнгөн төлбөр олгоно[347]. Үүнд:

- Тэтгэврийн насанд хүрсэн;
- Хөгжлийн бэрхшээлтэй, эсвэл 18 нас хүртэлх эрүүл мэндийн байдал хязгаарлагдмал иргэн;
- Гэр бүлийн тэжээгчээ алдсан;
- Түр хугацаагаар хөдөлмөрийн чадвар алдсан (хуулиар тогтоосон хугацаанд);
- Жирэмсний;
- Хүүхэд төрүүлсний;
- Хүүхэд асрах;
- Нас барах;
- Сувилал эмчилгээний хэрэгцээнд зэрэг болно.

## Эрүүл мэндийн даатгал

Эрүүл мэндийн даатгал нь Бүгд Найрамдах Азербайжан Улсын Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар *(Закон Азербайджанской Республики О медицинском страховании)* зохицуулагддаг. Хуулиар эрүүл мэндийн даатгалын зохион байгуулалт, эрх зүй, эдийн засгийн үндэслэлийг тодорхойлж, эрүүл мэндийн даатгалын субъектуудын хоорондох харилцааг зохицуулна.

---

[345]Аудиторын мэргэжлийн хариуцлагын албан журмын даатгалын тухай хууль, 3 дугаар зүйл http://www.audit.gov.az/uploads/On_compulsory_insurance_of_auditors_professional_liability.pdf

[346] Бүгд Найрамдах Азербайжан Улсын Нийгмийн даатгалын тухай хууль, Нэгдүгээр бүлэг, 2 дугаар зүйл https://online.zakon.kz/Document/?doc_id=30596502#pos=29;-168

[347] Бүгд Найрамдах Азербайжан Улсын Нийгмийн даатгалын тухай хууль, Нэгдүгээр бүлэг, 4 дүгээр зүйл https://online.zakon.kz/Document/?doc_id=30596502#pos=29;-168

Уг даатгал нь нийгэм хамгааллын үйлчилгээний нэг хэлбэр бөгөөд даатгуулсан тохиолдолд эрүүл мэнд болон эм тарианы тусламж үйлчилгээ авах боломжтой.

Эрүүл мэндийн заавал даатгуулах даатгалаас (албан журмын даатгал) гадна эрүүл мэндийн сайн дурын даатгалтай бөгөөд энэ нь гэрээний үндсэн дээр хүн амыг эрүүл мэнд болон хамааралтай бусад үйлчилгээгээр хангана.[348]

Эрүүл мэндийн заавал даатгуулах даатгалын асуудлыг хариуцдаг *Төрийн Эрүүл мэндийн Албан журмын даатгалын агентлаг (Государственное Агентство обьязательного медицинского страхования)* ажилладаг бөгөөд 2007 онд Ерөнхийлөгчийн зарлигаар байгуулагджээ. Агентлаг нь дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулна[349]. Үүнд:

- Эрүүл мэндийн заавал даатгуулах даатгалын хүрээнд төрийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх;
- Хүн амын бүх давхаргыг шаардлагатай эмнэлгийн тусламж үйлчилгээгээр хангах боломжийг сайжруулах;
- Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих зорилгоор эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангах зэрэг болно.

Эдгээрээс гадна төрийн тусгай албан хаагчдад зориулсан дараах албан журмын даатгалын төрлүүд байх ба энэ нь тусгайлсан хуулиар зохицуулагдана. Үүнд:

- **Шүүх болон хууль сахиулах байгууллагын албан хаагчийн төрийн тусгай албан журмын даатгал** нь Шүүх болон хууль сахиулах байгууллагын албан хаагчийн төрийн тусгай албан журмын даатгалын тухай хуулиар (*Закон Азербайджанской Республики Об обьязательном государственном личном страховании работников судебных и правоохранительных органов);*
- **Цэргийн албан хаагчийн төрийн тусгай албан журмын даатгал** нь Цэргийн албан хаагчийн төрийн тусгай албан журмын даатгалын тухай хуулиар *(Закон Азербайджанской Республики Об обьязательном государственном личном страховании работников судебных и правоохранительных органов);*
- **Гадаад оронд суугаа дипломат ажилтнууд болон гадаад орны байгууллагад ажилладаг ажилтнуудын албан журмын даатгал** нь Бүгд Найрамдах Азербайжан Улсаас гадаад оронд суугаа дипломат ажилтнууд болон гадаад орны байгууллагад ажилладаг ажилтнуудын албан журмын даатгалын тухай хуулиар (*Law "On compulsory insurance for officers of diplomatic missions of the Republic of Azerbaijan in foreign countries and international institutions*) тус тус зохицуулагдана.

## 5. БҮГД НАЙРАМДАХ МАКЕДОН УЛС

Бүгд Найрамдах Македон Улсад албан журмын (заавал) даатгалын харилцааг дараах хуулиудаар зохицуулж байна. Үүнд:

- Даатгалын тухай хууль *(Law on Insurance);*
- Замын хөдөлгөөний (албан журмын) даатгалын тухай хууль *(Law on compulsory traffic insurance);*
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль *(Law Health Insurance);*
- Бүрэн санхүүжилттэй тэтгэврийн (заавал) даатгалын сангийн тухай хуулиудаар *(Law on Mandatory fully funded Pension insurancy)* зохицуулагдана.

### Даатгалын тухай хууль[350]

*( Law on Insurance)*

Даатгалын тухай хууль нь 2006 оны 1-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж

[348]Бүгд Найрамдах Азербайжан Улсын Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Нэгдүгээр бүлэг, нэгдүгээр зүйл http://base.spinform.ru/show_doc.fwx?rgn=2725

[349]Государственное Агентство обязательного медицинского страхования http://its.gov.az/ru/i-tsda-haqq-nda/umumi-m-lumat/

[350]Македон Улсын Даатгалын тухай хууль,2006 http://www.libertas-nstitut.com/de/MK/nationallaws/insurance.pdf

эхэлсэн,12 бүлэг, 147 зүйл ангитай. Энэ хуулийн зорилго нь амьдралын болон амьдралын бус даатгалын нөхцөл, давхар даатгал болон албан журмын (заавал) даатгалын үйл ажиллагаа эрхэлж буй даатгалын болон давхар даатгалын компаниуд, брокерын компаниуд, тэдгээрийн үйл ажиллагааг хянах, зохицуулахад оршино. Энэ хуульд заасан журмын дагуу иргэн, хуулийн этгээд даатгалын компанитай даатгалын харилцаанд орох ба Засгийн газар болон хувь хүн, хуулийн этгээд хэрэв хүсвэл эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээ гадаадын даатгалын компани болон давхар даатгалын компанид даатгуулж болно. Энэ хуулийн 5-р бүлгийн 54-р зүйлд зааснаар дараах ***албан журмын (заавал***) даатгалын төрлүүд байна. Үүнд:

- Нийтийн тээврийн хэрэгслээр зорчигчдын даатгал;
- Моторт тээврийн хэрэгсэл эзэмшигчийн гуравдагч этгээдэд учруулсан хохирлын хариуцлагын даатгал;
- Агаарын хөлөг эзэмшигчийн гуравдагч этгээдэд учруулсан хохирлын хариуцлагын даатгал;
- Хөдөлгүүрт завь, хөлөг онгоц эзэмшигчийн гуравдагч этгээдэд учруулсан хохирлын хариуцлагын даатгал;
- Төмөр замын тээврийн хэрэгсэл эзэмшигчийн (галт тэрэг, трамвай) гуравдагч этгээдэд учруулсан хохирлын хариуцлагын даатгал болно.

Энэ хуулийн 5-р бүлгийн 55-р зүйлд зааснаар тээврийн хэрэгсэл эзэмшигч буюу зорчигчид авто замын хөдөлгөөнийг эхлүүлэхээс өмнө даатгалын компанитай албан журмын (заавал) даатгалын гэрээг байгуулна. Автомашины даатгалыг хариуцдаг Үндэсний Даатгалын Агентлаг нь даатгалын нөхцөл, хураамж, шалгуурыг тогтооно.

**Нийтийн тээврийн хэрэгслээр зорчигчдын даатгал.** Энэ хуулийн 57-р зүйлд зааснаар нийтийн тээврийн үйлчилгээнд бүртгүүлсэн тээврийн хэрэгсэл эзэмшигчид даатгалын компанитай гэрээ байгуулна. Хуулийн 59-р зүйлд зааснаар даатгал төлсөн тохиолдолд амь насаа алдсан бол 1250 евро, хөдөлмөрийн чадвар алдсан тохиолдолд 2500 евро, түр зуур ажиллах чадваргүй болсон тохиолдолд 600 евро тус тус нөхөн олговор олгодог байна (хуулийн 59-р зүйлд).

**Моторт тээврийн хэрэгсэл эзэмшигчдийн гуравдагч этгээдэд учирсан хохиролын хариуцлагын даатгал.** Энэ хуулийн 61-р зүйлд моторт тээврийн хэрэгсэл, автомашин эзэмшигчийн даатгалд амь нас, эрүүл мэнд нь хохирсон гуравдагч этгээдийн хохирлыг төлөх (автомашины хариуцлагын даатгал) болон тээврийн хэрэгсэл, машины чиргүүлийг даатгаж гэрээ байгуулна. Нийтийн тээврийн замын хөдөлгөөнд оролцож буй бүх хөдөлгүүр, тээврийн хэрэгсэлийг бүртгэлжүүлнэ. 12 сар тутамд техникийн үзлэгт орох ба автомашины хариуцлагын даатгалаас даатгалын гэрчилгээтэй байх, тээврийн хэрэгсэлийн эзэмшигч, жолоочид учирсан хохирлыг хариуцах, тээврийн хэрэгсэлийг жолоодох үедээ осолдсон тохиолдолд нөхөн олговор авах эрхтэй (хуулийн 63-р зүйл). Автомашины хариуцлагын даатгалын хэмжээ нь ачааны бүх тээврийн хэрэгсэл, автобус - 100,000 евро, бүх төрлийн тээврийн хэрэгсэл-50,000 евро тус бүрийг Македон Улсын Үндэсний банкны ханшаар нөхөн олговорыг олгоно (хуулийн 64-р зүйл). Энэхүү хуулийн 65-р зүйлд зааснаар эрүүл мэндийн даатгал, тахир дутуугийн болон тэтгэврийн даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг даатгалын компани нь даатгуулсан аж ахуйн нэгжийн эрүүл мэндийн болон бусад зардлыг нөхөн олгох, эрүүл мэндийн даатгалын хуулийг дагаж мөрдөх, тахир дутуугийн болон тэтгэврийн даатгалын хураамжтай холбоотой асуудлуудаар үүрэг хариуцлага хүлээнэ.

**Агаарын хөлгийн эзэмшигчдийн гуравдагч этгээдэд учирсан хохиролын хариуцлагын даатгал.** Энэ хуулийн 81-р зүйлд агаарын хөлгөөр бүртгүүлсэн агаарын хөлөг эзэмшигчдийн амь нас, гуравдагч этгээдийн эрүүл мэндэд учруулсан хохирол, техникийн эвдрэл гэмтэлтэй холбоотой хохирлыг даатгалын компани нөхөн барагдуулна. Агаарын хөлгөөр зорчиж буй хүмүүсийг гуравдагч этгээд гэж үзнэ. Даатгалын нөхөн олговрыг доорх хүснэгтээс харна уу.

*Хүснэгт 1*

| | *Агаарын хөлгийн төрөл* | *Даатгалын дүн (евро)* |
|---|---|---|
| 1. | Агаарын нийтийн тээврийн зорчиж буй барааны жин<br>a) 2,700 кг жинтэй.<br>b) 2,701-аас 5 700 кг жинтэй.<br>c) 5,701-аас 27,000 кг жинтэй.<br>d) 27,001 аас 72,000 кг жинтэй.<br>e) 72,000 кг жинтэй | <br>50,000<br>100,000<br>300,000<br>600,000<br>1,000,000 |
| 2. | Бусад агаарын хөлөг<br>a)цаасан шувуу, хэт хөнгөн гулсалт ба паранер<br>б) Хөдөлгүүр, баллон, хөдөлгүүрт цаасан шувуу, хөдөлгүүртэй нисэх онгоц<br>c) Спортын зориулалтын хөдөлгүүрт агаарын хөлөг иргэдийн хувийн хэрэгцээнд<br>d) Бусад зориулалтаар ашиглагддаг агаарын хөлөг (арилжааны үйл ажиллагаа) захиргааны гүйцэтгэл, эрдэм шинжилгээний ажил, шинжлэх ухааны үйл ажиллагаа, эрүүл ахуйн тусламж, галаас хамгаалах<br>e) Ажилчдын сургалтад ашиглагддаг агаарын хөлөг | <br>3,000<br>5,000<br>6,000<br>25,000<br>20,000 |

Македон Улсын агаарын зайд нэвтрэх гадаадын агаарын хөлөг даатгалд хамрагдах ёстой.

**Хөдөлгүүрт завь, хөлөг онгоцны эзэмшигчдийн гуравдагч этгээдэд учирсан хохиролын хариуцлагын даатгал.** Энэ хуулийн 82-р зүйлд заасны дагуу хөлөг онгоц эзэмшигчид буюу хөдөлгүүртэй завь 1.5 HP-аас дээш даацтай хөдөлгүүртэй завь, бизнес , спорт, зугаа цэнгэлийн зориулалтаар ашиглах хөлөг онгоцыг регистрийн санд бүртгүүлж, хөлөг онгоц буюу хөдөлгүүрт завь эзэмшигч нь гуравдагч этгээдэд учирсан амь нас, бие махбодь, эрүүл мэндийн хохирол, тээвэрлэлтийн эвдрэл, сүйрлийг даатгуулдаг байна. Даатгалын нөхөн олговын хэмжээг дараах хүснэгтээс харна уу. Үүнд:

*Хүснэгт 2*

| | *Хөлөг онгоцны төрөл* | *Даатгалын дүн (евро)* |
|---|---|---|
| 1. | хөлөг онгоц, тийрэлтэт хөдөлгүүр, цахилгаан завь (HP 5 хүртэлх даац ) | 7,500 |
| 2. | завь, дарвуулт завь, цахилгаан завь (HP 5-15 даац ) | 15,000 |
| 3. | усан онгоц, завь, хөлөг онгоц, бусад хөлөг онгоцууд (HP 15-50 даац) | 40,000 |
| 4. | хөлөг онгоц (HP 50 дээш даац) | 100,000 |

Даатгал нь 12 сарын хугацаанд хүчинтэй байна. Гадаад улсын харьяат эзэмшигч гадаад улсад байгаагаа нотлох баримтыг гаргаснаар даатгалын гэрээ байгуулж болно.

**Төмөр замын тээврийн хэрэгсэл эзэмшигчдийн гуравдагч этгээдэд учирсан хохирлын хариуцлагын даатгал.** Энэ хуулийн 83-р зүйлд төмөр замын тээврийн хэрэгсэл эзэмшигчид тээврийн хэрэгслээ бүртгүүлж, гуравдагч этгээдийн амь нас, бие махбодь, эрүүл мэндэд учирсан хохирлыг барагдуулах зорилгоор даатгалын компанид даатгуулна. Төмөр замын тээврийн хэрэгслээр зорчиж буй хүмүүсийг гуравдагч этгээд гэж нэрлэнэ. Энэ хуулийн 1 дэх заалтыг эзэмшигч, хэрэглэгчдэд хамгийн доод хэмжээ нь 500,000 еврогийн нөхөн олговор олгодог байна.

## Замын хөдөлгөөний ( албан журмын) даатгалын тухай хууль[351]

*(Law on compulsory traffic insurance)*

Замын хөдөлгөөний (албан журмын) даатгалын тухай хууль нь 2008 онд батлагдсан бөгөөд 9 бүлэг 77 зүйлтэй. Замын хөдөлгөөний даатгал нь заавал даатгалын тухай хуулиар зохицуулагддаг бөгөөд энэ хуульд дараах тээврийн хэрэгслийн эзэмшигчийн даатгалыг хамруулжээ. Үүнд:

- нийтийн тээврийн зорчигчид;
- автомашин, тээврийн хэрэгсэл болон чиргүүл эзэмшигч;
- агаарын хөлөг эзэмшигч;
- хөлөг онгоц, моторт завь эзэмшигч, гуравдагч талуудын учирсан хохирол зэрэг асуудлууд юм.

Тус хуульд зааснаар тээврийн хэрэгсэл эзэмшигч нь хөдөлгөөнд оролцохоосоо өмнө заавал даатгалын компанитай гэрээ хийж, даатгуулсан байхыг шаарддаг. Даатгалын үйл ажиллагаа эрхлэх компани нь тусгай зөвшөөрөлтэй байна. Авто тээврийн хэрэгслийг бүртгэх, бүртгэлийн хугацааг сунгах асуудлыг заавал даатгалын гэрээнд тусгана. Албан журмын даатгалын гэрээний үйл ажиллагаа эрхлэгч нь тээврийн хэрэгсэл эзэмшигчийн зөвшөөрлөөр гэрээ байгуулах ба хуульд заасны дагуу даатгалын нөхцөл, даатгалын хугацаа, эрдсэл, үнэлгээ, ноогдох шимтгэл, тарифыг гэрээнд тусгасан байна.

**Нийтийн тээврийн зорчигчдын даатгал[352]*.*** Нийтийн тээврийн хэрэгслээр зорчигч нь нийтийн тээврээр үйлчлүүлэхдээ заавал даатгал хийлгэсэн байна. Үүнд: Хот хоорондын болон нийтийн, олон улсын нийтийн тээврийн хэрэгсэл автобус, автотээвэр, төмөр зам, хөлөг онгоц, ачаа тээвэрлэх, жуулчин тээвэрлэх хэрэгсэл, онгоц түрээслэх, агаарын хөлөг, тийрэлтэт онгоц зэрэг бүх тээврийн хэрэгслийн үйлчилгээг хамруулна. Хэрэв нийтийн тээврээр зорчиж яваа үед амь насаа алдсан тохиолдолд нийтийн тээврийн даатгалын доод хэмжээгээр тооцно. Нийтийн тээврээр зорчиж байхдаа хөдөлмөрийн чадвар алдсан бол эмчилгээний зардал, нөхөн олговрыг нөхөн төлнө[353].

Энэ хуулийн 44-р зүйлд ***Автомашины хариуцлагын Даатгалын Комисс***[354]-ын үйл ажиллагааг зохицуулсан. Македон Улсын Засгийн газар нь автомашины хариуцлагын даатгалын комиссын гишүүдийг томилох ба комисс нь ерөнхийлөгч, 3 гишүүнээс бүрдэнэ. Комиссын нэг гишүүнийг ерөнхийлөгч, нөгөө гишүүнийг Сангийн Яамны санал болгосны дагуу Даатгалын Хяналтын Агентлаг, нэг гишүүнийг Үндэсний Даатгалын Агентлаг тус тус томилно. Комисс нь автомашины хариуцлагын даатгалын шимтгэлийн тарифын дээд, доод хувь хэмжээг тогтооно. Тарифыг “Төрийн Хэвлэл”-ээр олон нийтэд нийтэлнэ.

Мөн 47-р зүйлд зааснаар **Агаарын хөлөг эзэмшигчийн гуравдагч этгээдийн хариуцлагын даатгал**[355] нь Бүгд Найрамдах Македон Улсын иргэний агаарын хөлөг эзэмшигч нь бүртгэгдсэн байх ба даатгалын гэрээ байгуулах үүрэгтэй байна. Энэ нь агаарын хөлөгт амь насаа алдах буюу бие махбодь гэмтэх, эрүүл мэндийн хохирол учрах, сүйрэлд орох зэрэг нислэгийн үед гарах аливаа эрсдэлд даатгалын компани нь гуравдагч этгээдийн учирсан хохирлыг бүрэн төлөх үүрэг хүлээнэ. Гадаадын агаарын хөлгийн хувьд Македоны бүсийн агаарын зайд нэвтрэх олон улсын гэрээтэй байна.

**Хөлөг онгоц, моторт завь эзэмшигчид гуравдагч этгээдийн хариуцлагын даатгал**[356] нь амралт чөлөөт цаг, спорт болон бизнес, зугаа цэнгэлийн зорилгоор бүртгүүлсэн хөлөг онгоц, моторт завь эзэмшигчид даатгалын гэрээ байгуулна. Даатгалын гэрээнд гуравдагч этгээдийн амь нас, бие махбодид бэртэл гэмтэл учрах, эрүүл мэндийн хохирол учрах, тээвэрлэлтийн явцад эд зүйлс гэмтэх, устаж үгүй болох зэрэг хохирлуудыг нөхөн төлөхөөр заажээ. Энэ даатгал зорчигчдод хамаарахгүй. Хөлөг онгоц, моторт завь эзэмшигч гуравдагч этгээдийн хариуцлагын даатгалын төлбөрийг Македоны Үндэсний

---

[351] Македон Улсын Замын хөдөлгөөний (албан журмын) даатгалын тухай хууль http://www.aso.mk/dokumenti/regulativa/zakoni/LAW ON COMPULSORY TRAFFIC INSURANCE_EN.pdf

[352] Insurance of passengers in the Public Transport

[353] Македон Улсын Албан журмын (замын хөдөлгөөний) тухай хуулийн хуулийн 10-р зүйл

[354] Commission for Automobile Liability Insurance

[355] Third party Liability Insurance of Aircraft Owners

[356] Third party Liability Insurance of Owners Vessels,that is Motor Boat

Банкны денарын ханшаар тооцно. Гадаад орны хөлөг онгоц, моторт завь эзэмшигч нь моторт завь болон хөлөг онгоц эзэмшдэг гэдгээ нотлох үүрэгтэй[357].

**Эрүүл мэндийн даатгалын тухай хууль[358]**
*( Law Health Insurance)*

Бүгд Найрамдах Македон Улсын Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар Македон улсын иргэдийг эрүүл мэндийн даатгалд хамруулах болон эрүүл мэндийн даатгалын сангаас үзүүлэх даатгалын үйлчилгээний харилцааг зохицуулсан. Тус улсын хуульд зааснаар эрүүл мэндийн даатгал нь албан журмын (мандатор) болон сайн дурын гэсэн 2 хэлбэртэй байна.

Эрүүл мэндийн албан журмын даатгалыг ил тод, эв санааны нэгдэлтэй, тэгш эрхтэй, үр ашигтай байх зарчмын дагуу зохион байгуулах, иргэдийг энэ хуульд заасан нөхцөлийн дагуу албан журмын даатгалд хамруулах болон эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, даатгалын сангаас мөнгөн хэлбэрээр нөхөн олговор олгохтой холбоотой харилцааг зохицуулахад энэ хуулийн зорилго чиглэгдэнэ.

Энэ хууль 1995 онд батлгадсан бөгөөд 5 бүлэг 96 зүйлтэй. Хуульд заасны дагуу эрүүл мэндийн албан журмын даатгалыг Бүгд Найрамдах Македон Улсын Эрүүл мэндийн даатгалын сангаас, сайн дурын эрүүл мэндийн даатгалыг Даатгалын компаниуд хэрэгжүүлнэ.

Энэ хуулийн 1-р бүлэгт *Mandatory health insurance* буюу албан журмын даатгалд (төр болон даатгуулагчаас) хамрагдах этгээдүүдийг тусгайлан заасан байна. Албан журмын даатгалд даатгуулагч этгээд нь даатгуулагч болон түүний гэр бүлийн гишүүд байна. Энэ хэсгийн 5-р зүйлд заасан дараах этгээдүүд заавал даатгалд хамрагдана. Үүнд:

1. Хуулийн этгээдэд ажиллагсад, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, төрийн үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээд болон институтад ажиллагсад, төрийн албан хаагчид, орон нутгийн өөрөө удирдах байгууллага болон Скопеж хотын захиргаанд ажиллагсад;

   1а) худалдааны компанийн захирлуудын зөвлөлийн гишүүд, менежментийн багийн гишүүд;

   1б) Түр ажилд зуучлах зуучлагчийн тухай хуульд (*Law on Agencies for Temporary Employment*) заасны дагуу түр ажил эрхэлж буй этгээд;

2. Македон Улсын иргэн боловч Македоны газар нутагт үйл ажиллагаа явуулж буй гадаадын хуулийн этгээд, байгууллага, институтад ажиллагсад, Олон улсын гэрээ хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол гадаадын дипломат төлөөлөгчийн газар болон консулын албанд ажиллагсад;
3. Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн;
4. Хөдөө аж ахуй ба хөдөөгийн хөгжлийн тухай хуульд заасан 2 болон 3-р категорийн хөдөө аж ахуйн холдинг эзэмшигчид;
5. Шашны байгууллагад ажиллагсад;
6. Одоогоор түр ажилгүй байгаа боловч ажилгүйдлийн улмаас даатгалаас мөнгөн хэлбэрээр нөхөн олговор авч байгаа иргэн;
7. Гадаадад хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд тухайн оронд ажиллаж байх хугацаандаа тухайн орны хуулиар, эсвэл олон улсын гэрээ хэлэлцээрийн дагуу эрүүл мэндийн албан журмын даатгалд хамрагдаагүй Македон Улсын иргэн, гэр бүл нь Македон Улсын нутаг дэвсгэрт амьдардаг бол гадаадад хөдөлмөр эрхлэхээсээ өмнө гэр бүлийн гишүүдээ заавал даатгалд хамруулах;

[357] Македон Улсын Албан журмын (замын хөдөлгөөний) тухай хуулийн хуулийн 49-р зүйл
[358] Македон Улсын Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
http://www.refworld.org/pdfid/5aa125974.pdf

8. Тэтгэвэр болон тахир дутуугийн тэтгэмжийн хуулийн дагуу тэтгэвэр болон цалин хөлсний нөхөн олговор авагч этгээд;

9. Македон Улстай Нийгмийн даатгалын хэлэлцээрт ороогүй улс орнууд болон Македон улстай нийгмийн даатгалын хэлэлцээрт орсон боловч хэлэлцээрээр эрүүл мэндийн даатгалд хамрагдах эрхийг нь нээж өгөөгүй улс орнуудын даатгалын компаниас өндөр насны тэтгэвэр болон тахир дутуугийн тэтгэмж авдаг, Македон улсын иргэн эх орондоо оршин суух хугацаандаа;

10. Тогтмол санхүүгийн туслалцаа авагч этгээд, хүлээн зөвшөөрөгдсөн цагаачлалын статустай этгээд, асран хамгаалагчийн гэр бүлд байдаг этгээд, нийгмийн хамгаалалын институт (институтын доторхи болон гаднах хамгаалалт)-ын хараа хяналтанд байдаг этгээд, өөр хэн нэгэн хувь хүнээс асаргааны болон мөнгө санхүүгийн нөхөн төлбөр авдаг этгээд, өнчин болон эцэг эхийн халамж асаргаанаас ангид статустай 18 хүртэлх насны хүүхэд, 26 нас хүртэл нийгмийн халамжаас санхүүгийн дэмжлэг авах эрх бүхий этгээд, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч бөгөөд Гэр бүлийн тухай хуулийн дагуу хамгаалалтанд авагдсан этгээд, төрийн халамж, дэмжлэгийн тусламжтайгаар бие даан амьдарч байгаа этгээд;

11. Олон улсын гэрээгээр тохиролцсон нөхцөлд хамрагдаагүй, Македон Улсын нутаг дэвсгэр дээр ажил үйлчилгээ эрхэлж буй гадаадын хуулийн этгээд, компани, институт, олон улсын байгууллага, дипломат болон консулын албанд ажиллаж байгаа этгээд;

12. Олон улсын гэрээгээр тохиролцсон нөхцөлд хамрагдаагүй Македон Улсын боловсрол байгууллага болон мэргэжлийн сургалтын байгууллагад элсэн суралцаж байгаа гадаадын этгээд;

13. Өөр нөхцөлөөр даатгуулаагүй шоронд ял эдэлж байгаа этгээд, түр саатуулагдан хоригдож байгаа этгээд, хүүхдийн хорих газарт боловсрол, хүмүүжлийн арга хэмжээнд хамрагдаж байгаа насанд хүрээгүй хүүхэд;

14. Үндэсний чөлөөлөх дайнд *(National Liberation War)* оролцогч, дайнд оролцож тахир дутуу болсон этгээд, дайнд оролцогчид болон дайнд амь үрэгдэгсдийн ар гэр, Дэлхийн 2-р дайнд оролцож тахир дутуу болсон этгээд, Македоны тусгаар тогтнолын төлөөх тэмцэл, үзэл бодлынхоо төлөө хавчигдан гадуурхагдсан, хэлмэгдсэн этгээд иргэд, SFRY (*Socialist Federal Republic of Yugoslavia*)–ийн задралын үеэр дайнд амь үрэгдсэн Македоны иргэн, тэдгээрийн гэр бүлийн гишүүд, эцэг эх;

15. Энэхүү зүйлийн 1-14-т заасан тусгай нөхцөлд хамрагдаагүй Македон улсын иргэд.

Хуулийн 8-р зүйлд эрүүл мэндийн даатгалын сангаас нөхөн олговор олгохтой холбоотой харилцааг зохицуулсан. Македон улсын хуулиар мандатор нөхцөлөөр заавал даатгалд хамрагдсан иргэдэд дараах тохиолдолд нөхөн олговор олгоно. Үүнд:

- ажлын байрнаас гадуур өвдсөн болон бэртэж гэмтсэн тохиолдолд;
- ажил мэргэжлээс шалтгаалах өвчин, ажлын байран дээр бэртэж гэмтсэн тохиолдолд.

Энэ хуулийн 17-р зүйлд зааснаар хөдөлмөрийн чадвараа түр зуур алдсан этгээдэд ажил олгогчоос нөхөн олговорын 70%-ийг, ажлын байран дээр гэмтэж бэртсэн, мэргэжлээс шалтгаалах өвчин туссан, цусны болон эд эрхтэний донор болсон үед болон жирэмсэн байх хугацаанд, хүүхэд төрүүлэх болон асрах хугацаанд энэ хуульд заасны дагуу 100%-ийн цалингийн нөхөн олговор олгоно.

**Бүрэн санхүүжилттэй тэтгэврийн (заавал) даатгалын сангийн тухай хууль**[359]

*(Law on Mandatory fully funded Pension insurance)*

Бүрэн санхүүжилттэй тэтгэврийн даатгалын сангийн тухай хууль нь 2003 онд батлагдсан ба 17 бүлэг 146 зүйл ангитай. Энэ хуулиар бүрэн санхүүжилттэй тэтгэврийн даатгалын сан, түүнийг байгуулах болон тэтгэврийн сангийн үйл ажиллагаа, түүний удирдлаган дор үйл ажиллагаа явуулдаг тэтгэврийн компаниуд болон тэтгэвэр тэтгэмж, хөдөлмөрийн чадвар алдалтын даатгалын системтэй холбоотой харилцааг зохицуулна. Эдгээр сан болон команиудын гол үүрэг нь хуулиар тогтоосон нөхцөлийн дагуу тэтгэврийн сангаас хуваарилагдсан хөрөнгийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах, сангийн хөрөнгийг хуримтлуулах болон хуваарилахад чиглэгдсэн үйл ажиллагаа явуулахад оршино.

Энэ хуульд заасны дагуу Бүрэн санхүүжилттэй тэтгэврийн сангийн үйл ажиллагааг хянан зохицуулах Агентлаг байгуулагдах ба энэ агентлаг нь Тэтгэврийн сан, Тэтгэврийн компаниудад тусгай зөвшөөрөл олгох, үйл ажиллагааг нь хянан зохицуулах үүрэгтэй.

Энэ хуулийн 3-р зүйлд тодорхойлсон “Тэтгэврийн компани” *(Pension Company),* “Тэтгэврийн сан*”(Pension Fund),* “Тэтгэврийн систем” *(Pension Scheme)* зэрэг байгууллагууд тэтгэврийн даатгалын тогтолцоонд тодорхой үүрэг гүйцэтгэнэ. Тэтгэврийн компани гэж тэтгэврийн сангийн менежментийг хэрэгжүүлдэг хувьцаат компани бөгөөд “Универсал тэтгэврийн компани” гэж нэрлэдэг. Тэтгэврийн сан гэж Тэтгэврийн компаниас байгуулж, менежементийг нь хэрэгжүүлдэг Нээлттэй сан *(Open-end Fund*)-г хэлнэ. Бүрэн санхүүжилттэй тэтгэврийн даатгалын санг хянан зохицуулах Агентлаг нь тэтгэврийн компани болон тэтгэврийн сангийн үйл ажиллагаанд хяналт тавина. Кастодиан *(Custodian*) нь тэтгэврийн сангийн данс дахь хөрөнгийг хадгалах болон энэ хуулиар тогтоосон бусад үүргийг хэрэгжүүлдэг Төв банкнаас олгосон лицензтэй банк юм.

[359] Македон Улсын Бүрэн тэтгэврийн ( заавал ) даатгалын тухай хууль
http://www.mse.mk/Repository/UserFiles/File/Misev/Regulativa/Zakoni%20ENG/Revised%20version%20of%20the%20Law%20on%20Mandatory%20Fully%20Funded%20Pension%20Insurance%20June%202006.pdf

**АШИГЛАСАН МАТЕРИАЛ:**


- Insurance-related Laws
  http://www.sonpo.or.jp/en/regulations/001.html
- Insurance in Japan
  https://www.startupoverseas.co.uk/starting-a-business-in-japan/insurance.html
- Social Insurance in Japan
  http://www.htm.co.jp/payroll-social-insurance-practices-japan.htm
- Employment Insurance Act
  http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=1910&vm=04&re=02
- Health Insurance Act
  http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail_main?re=&vm=02&id=2882
- National Health Insurance Act
  http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=2453&vm=04&re=02
- Automobile Liability Security Law (1955)
  http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail_main?re=&vm=02&id=2721
- Act on Earthquake Insurance
  http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=1888&vm=04&re=02
- Insurance Business Law (1995)
  https://www.fsa.go.jp/common/law/ins01.pdf
- Insurance act
  http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail_main?re=&vm=2&id=2775
- Pflichtversicherung
  https://de.wikipedia.org/wiki/Pflichtversicherung
- Sozialversicherung https://de.wikipedia.org/wiki/Sozialversicherung_(Deutschland)
- Sozialversicherung (Österreich)
  https://de.wikipedia.org/wiki/Sozialversicherung_(%C3%96sterreich)
- Sozialversicherungen (Schweiz)
  https://de.wikipedia.org/wiki/Sozialversicherungen_(Schweiz)
- https://elaw.klri.re.kr/kor_service/lawView.do?lang=ENG&hseq=45851
- http://www.sungto.co.kr/business-faq/labor-standard-act/social-insurances-four-compulsory-insurances/
- https://elaw.klri.re.kr/eng_service/lawTotalSearch.do
- https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=40189&lang=ENG
- https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=41243&lang=ENG
- LAW OF THE AZERBAIJAN REPUBLIC ON COMPULSORY INSURANCES
  http://isb.az/wp-content/uploads/2015/03/LAW-ON-COMPULSORY-INSURANCES-Adopted.pdf
- Compulsory Insurance Bureau
  http://isb.az/en/
- Закон Азербайджанской Республики от 18 февраля 1997 года № 250-IQ
  О социальном страховании
  https://online.zakon.kz/Document/?doc_id=30596502#pos=29;-168
- Закон Азербайджанской Республики от 28 октября 1999 года №725-IQ
  О медицинском страховании
  http://base.spinform.ru/show_doc.fwx?rgn=2725
- Государственное Агентство обязательного медицинского страхования
  http://its.gov.az/ru/i-tsda-haqq-nda/umumi-m-lumat/
- Закон Азербайджанской Республики от 5 октября 1999 года № 705-IQ
  Об обьязательном государственном личном страховании работников судебных и правоохранительных органов
  http://base.spinform.ru/show_doc.fwx?rgn=2737
- Закон Азербайджанской Республики от 20 мая 1997 года №296-IQ
  Об обьязательном государственном личном страховании военнослужащих
  http://base.spinform.ru/show_doc.fwx?rgn=19223

- http://isb.az/ru/istehsalatda-bedbext-hadiseler-ve-pese-xestelikleri-neticesinde-pese-emek-qabiliyyetinin-itirilmesi-hallarindan-icbari-sigorta-ru/
- Македон Улсын Даатгалын тухай хууль,2006 http://www.libertas-nstitut.com/de/MK/nationallaws/insurance.pdf
- Албан журмын (замын хөдөлгөөний) даатгалын тухай хууль http://www.aso.mk/dokumenti/regulativa/zakoni/LAW ON COMPULSORY TRAFFIC INSURANCE_EN.pdf
- Македон Улсын Даатгалын тухай хууль,2006 http://www.libertas-nstitut.com/de/MK/nationallaws/insurance.pdf
- Замын хөдөлгөөний (албан журмын) даатгалын тухай хууль http://www.aso.mk/dokumenti/regulativa/zakoni/LAW ON COMPULSORY TRAFFIC INSURANCE_EN.pdf
- Македон Улсын Эрүүл мэндийн даатгалын тухай хууль http://www.refworld.org/pdfid/5aa125974.pdf
- Бүрэн тэтгэврийн ( заавал ) даатгалын тухай хууль http://www.mse.mk/Repository/UserFiles/File/Misev/Regulativa/Zakoni%20ENG/Revised%20version%20of%20the%20Law%20on%20Mandatory%20Fully%20Funded%20Pension%20Insurance%20June%202006.pdf

# АЛСЫН ЗАЙН УДИРДЛАГАТАЙ, ХҮНГҮЙ ХӨДӨЛГӨӨНТ ТӨХӨӨРӨМЖ (ДРОН) АШИГЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ: МОНГОЛ УЛС БОЛОН БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

(Харьцуулсан судалгаа)

*Г.Алтан-Оч (Ph.D),*
*И.Жаргалзаяабямба*

## АГУУЛГА

УДИРТГАЛ

1. Тойм ойлголт
2. Монгол Улсын алсын зайнаас удирддаг, хүнгүй хөдөлгөөнт төхөөрөмж (дрон) ашиглалтын хууль эрх зүйн зохицуулалт
   - Иргэний нисэхийн дүрэм- 101
   - Иргэний нисэхийн дүрэм- 102
   - Зөвшилцөл
   - Зайнаас удирддаг агаарын хөлгийг бүртгэх
   - Зайнаас удирддаг агаарын хөлгийн операторын сургалт
   - Монголд дрон бүтээсэн жишээ
3. Бусад орнуудын туршлага
   - Ерөнхий мэдээлэл
   - Зохицуулалтын хамрах хүрээ (ЕХ-ны гишүүн улс, Австрали, Канад, БНХАУ, Израил, Япон, Шинэ Зеланд, Өмнөд Африк, Украин)
   - Хүнгүй хөлгийн системийн бүртгэл ба хаяг тэмдэг
   - Нислэгийн зөвшөөрлийн мэдэгдэл
   - Хүнгүй хөлгийн системийн оператор мэргэжлийн түвшин
   - Ашиглалтын шаардлага, нөхцөл

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

# УДИРТГАЛ

Судалгааны **“Монгол Улсын дрон ашиглалтын хууль эрх зүйн зохицуулалт, туршлага” гэсэн нэгдүгээр хэсэгт**: Монгол Улсын Иргэний Нисэхийн Ерөнхий газар болон Зам тээврийн яам, Харилцаа Холбооны Зохицуулах газар болон холбогдох байгууллагуудын албан ёсны цахим хуудасны мэдээллийг эх сурвалж болгон ашиглав.

Монгол Улсад алсын зайн удирдлагатай, хүнгүй хөдөлгөөнт төхөөрөмж (дрон) ашиглахтай холбоотой эрх зүйн зохицуулалт нь Иргэний нисэхийн тухай хууль, Радио долгионы тухай хууль, Иргэний нисэхийн багц дүрэм[360] (ИНД-1; ИНД-12; ИНД-19; ИНД-21; ИНД-26; ИНД-39; ИНД-43; ИНД-71; ИНД-91; ИНД-100; ИНД-101; ИНД-102 )-ээс бүрдэнэ.

Иргэний нисэхийн багц дүрмээс ИНД-101 хүнгүй агаарын хөлгийн үйл ажиллагааны дүрэм, ИНД-102 хүнгүй агаарын хөлгийн үйл ажиллагаа эрхлэгч, гэрчилгээжүүлэлтийн дүрмийг тусгайлан судалсан. Түүнчлэн зайнаас удирддаг агаарын хөлгийг бүртгэх, зайнаас удирддаг агаарын хөлгийн операторын сургалтыг шинээр нэвтрүүлсэн байдал ба Монгол Улсад дрон бүтээсэн жишээг хамруулан судлав.

**Бусад орнуудын туршлага гэсэн хоёрдугаар хэсэгт**: Европын Холбооны гишүүн улсууд, Австрали, Канад, Хятад, Франц, Герман, Израил, Япон, Шинэ Зеланд, Польш, Өмнөд Африк, Швед, Украин, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс (ИБУИНВУ)-ын туршлагыг судалсан болно.

Судалгаанд дээрх нэр дурдсан 14 улсын дроныг иргэний хэрэглээнд ашиглах, дрон (Хүнгүй хөлгийн систем)-ы бүртгэл, хаяг тэмдэг, нислэгийн зөвшөөрлийн мэдэгдэл, дроны операторын мэргэжлийн түвшин, дрон ашиглалтын шаардлага, нөхцөл зэргийг судалсан болно.

# АЛСЫН ЗАЙН УДИРДЛАГАТАЙ, ХҮНГҮЙ ХӨДӨЛГӨӨНТ ТӨХӨӨРӨМЖ (ДРОН) АШИГЛАЛТЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ:МОНГОЛ УЛС БОЛОН БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

## 1. ТОЙМ ОЙЛГОЛТ

Дэлхий даяар техник, технологийн өнөөгийн хөгжил дэвшлийг дагаад дроныг ашиглах хэрэгцээ, улам бүр өсөн өргөжсөөр байна. Дроныг дотор нь олон янзаар ангилж авч үздэг ч, мөн чанарын талаасаа бүх дрон– нисдэг робот юм. Энэ төрлийн робот өгөгдсөн даалгаварыг биелүүлээд эргэж үүрэндээ ирдэг, дүнгэнэж дуугардаг “ажилчин зөгий”–тэй төстэй байдаг учраас “дрон” гэж нэрлэжээ. Алсын зайн, программчлагдсан, удирдлагатай, нисгэгчгүй нисдэг төхөөрөмж-дроныг ерөнхийд нь цэргийн болон хэрэглээний зориулалттай гэж ангилна. Дрон нь нарны энерги, зай, түлшээр ажиллана.

Хүмүүнлэгийн болон гамшгийн тусламжийн үед ашиглах жижиг хөнгөн дроныг жишээлбэл; далайн хар шуурга, хар салхи, газар хөдлөлт, үер зэрэг гамшигт нэрвэгдсэн газар нутгийн 3D зурагийг авах, амьд үлдсэн хүмүүсийг хайх, гамшигт нэрвэгдсэн хүмүүст эм тариа, тусламжийн зүйлсийг хүргэх, тоглоом зугааны хэлбэрт ашиглах, мөн зарим газруудад пицца, пиво хүргэлт хийх гэх мэтээр эерэг сайн үйлсэд ашиглахын хажуугаар, мөн “буруу аргын” олон улсын терроризм, алан хядах үйл ажиллагаа, хар тамхи зөөвөрлөх зэрэг элдэв сөрөг үйл ажиллагаанд эрчимтэй хэрэглэх хандлага ажиглагдсаар байна.

Цагдаагийн дрон ихэвчлэн өндөр нарийвчлалтай, шөнийн дуран бүхий, хэт ягаан туяаны камераар тоноглогдсон байдаг бол иргэд зөвшөөрөлгүй эзэмшиж, ашиглаж хууль бус нислэг үйлдэн асуудалд орох нь элбэг байдаг. Дрон нь нисдэг төхөөрөмж тул хяналттай агаарын зайд ойр нисэх, хүн ам шигүү суурьшсан бүсэд нисэх зэргээр нисэхийн аюулгүй ажиллагаанд янз бүрийн эрсдэлийг үүсгэнэ.

[360] Дронтой холбоотой дүрмийн хамаарлыг хүснэгтээр хавсаргав.

*Дрон үйлдвэрлэлийн зах зээлийн өсөлтийн прогноз (млрд. долл.)* [361]




Гадаадын зарим орны туршлагаас үзэхэд, тухайлбал, ОХУ-д Засгийн газрын тогтоолоор «ОХУ-ын агаарын орон зайг ашиглах Холбооны дүрэм"-д нэмэлт өөрчлөлт оруулж, нисгэгчгүй нисэх аппаратыг эзэмшигч зөрчил гаргасан тохиолдолд "Захиргааны зөрчлийн тухай хууль"-ийн 11 дүгээр зүйлийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол торгох арга хэмжээ авдаг болжээ. Ийм зөрчил гаргасан хоёр мянган иргэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байсан тул агаарын зайг ашиглах агаарын зайн хууль зөрчсөн гэж үзэн таван мянган рублиэр торгодог байна.

Дроныг ашиглаж байгаа орнуудад 30 кг-с дээш жинтэй бол заавал "Нислэгт тэнцэх чадвар"-ын гэрчилгээ олгодог байна.

Зарим шинжээчдийн дүгнэснээр БНХАУ-ын алсын жолоодлогот нисэх төхөөрөмжийн тоогоор дэлхийд АНУ-ын дараа ордог, хэрэглээгээр АНУ, Израил Улс тэргүүлдэг байна. Шинжээчид нисгэгчгүй нисдэг аппаратын хөгжлийн хэтийн төлөвийн асуудлаар өөр саналтай байна. Дроны гол давуу тал нь нисгэгч амь үрэгдэх боломжгүй юм. Гэвч техник болон хууль эрх зүйн талаар дутагдалтай. Энэхүү төхөөрөмж нь программынхаа дагуу ажиллавал түүний чиг замыг нь өөрчлөх аргагүй. Гэвч эсрэг тал компьютерийн ердийн программ ашиглан алсын жолоодлогот нисэх төхөөрөмжийн хяналтыг сулруулах боломжтой. Түүнээс гадна хиймэл оюун бүхий нисгэгчгүй нисдэг аппарат байдлыг объектив үүднээс тэр болгон зөв үнэлж чадахгүй. Ийм буруу шийдвэрүүдийн уршгаар Ирак, Афганистан, Пакистанд энгийн номхон олон зуун хүн амь насаа алдсан гэж үздэг.

Нисгэгчгүй нисдэг системийг ажиллуулах мэргэжилтнүүдийг сургах шинэ хөтөлбөрийг саяхан ОХУ-ын БХЯ-ны хүрээнд хэрэгжүүлж эхэлжээ. Нисгэгчгүй нисдэг төхөөрөмжийн хөгжил нь орчин цагийн зэвсэглэлээр хөөцөлдөхийн нэг хэсэг болж байна.

2003-2012 онд Дэлхийн хэмжээнд янз бүрийн ангилалын нисгэгчгүй нисдэг аппаратуудыг 3,5 тэрбум доллараар худалдан авсан ба 10 жилийн дараа нисгэгчгүй нисдэг аппаратын зах зээл 70 тэрбум долларт хүрч өргөжинө гэж таамаглаж байна. Саяхан АНУ, Мексикийн хилийн ойролцоо метамфетамин хэмээх хар тамхи зөөвөрлөж байсан дрон осолдсон байна. Drug Enforcement Agency-ын мэдээлж байгаагаар 2012 оноос хойш хил орчимд кокайн болон бусад мансууруулах бодисуудыг тээвэрлэхэд 150 гаруй дрон ашигласан тохиолдол бүртгэгджээ.

Axis Drones-ын зохион бүтээгчид зоос шиг хэмжээтэй, нэг цэнэгээрээ 5-7 минут нисэх чадвартай дрон бүтээжээ. Маш жижигхэн, дөрвөлжин хэлбэртэй энэ

---

[361]Дрон үйлдвэрлэлийн зах зээлийн өсөлтийн прогноз,2022он https://blog.dti.team/wp-content/uploads/2018/02/drones5.png

шинэ загварын бас нэг сонирхол татах зүйл нь дроноо дотор нь авч явах боломжтой удирдлагын хамт худалдаанд гарна. Түүнийг шөнийн нислэгт гарахад нь зориулж гадна талд нь тод гэрэлтэгч диод гэрлүүд суулгаж өгсөн байна. Indiegogo цахим хуудсанд энэхүү дроны урьдчилсан захиалга нь 35 ам.долларын үнэтэй гарчээ. Дашрамд хэлэхэд, өмнө нь ердөө алганд багтах хэмжээтэй дрон дэлхийн хамгийн жижигт тооцогддог байв. Түүнийг бүтээж, худалдаанд гаргахын тулд Indiegogo хуудас ганцхан өдрийн дотор хөрөнгө оруулалтаа босгож чадсан жишээ байна.[362]

Дрон ашиглалттай холбоотойгоор Олон улсын иргэний нисэхийн салбарт тулгамдаж буй эрсдэлийг багасгах, нисэхийн аюулгүй ажиллагаанд нөлөөлөх, нөлөөллийг бууруулах чиглэлээр улс орон бүр дор бүрнээ зохицуулалт хийж, хяналтын аргачлал, ашиглалтын дүрмийг боловсруулж мөрдөж ажилладаг.

Иргэний нисэхийн бүх төрлийн үйлчилгээ эрхэлж буй байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд тавигдах шаардлагуудтай нэгэн адилаар зайнаас удирддаг агаарын хөлгийн системийг нисгэж буй хувь хүн, байгууллага нь зарим төрлийн иргэний нисэхийн дүрэм, журам, зааврын талаар мэдлэгтэй байх, тэдгээрийг дагаж мөрдөх зайлшгүй шаардлагатай тулгардаг байна.

## 2. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ (дронд хамаарах)[363]

Монгол Улсын Иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч хувь хүн, байгууллага бүр нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлыг хангаж ажиллах талаар тодорхой үүрэг хариуцлага хүлээнэ. Энэ харилцааг Иргэний нисэхийн тухай[364] Монгол Улсын хуулийн 2 дугаар бүлгийн 7 дугаар зүйлийн дагуу Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (Зам, тээврийн хөгжлийн яам)-аар батлагдсан Иргэний Нисэхийн багц дүрмийн дагуу зохицуулж байна.

Гишүүн орнуудын иргэний нисэхийн дүрмийг сайжруулах замаар Иргэний нисэхийн салбарт нэгдсэн дүрмийн зохицуулалтанд шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29 дугаар чуулганы А/29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын 1999 оны 5-р сарын 6-нд байгуулсан "Техник Хамтын Ажиллагааны Санамж Бичиг"–ийг үндэслэн Монгол Улсын Иргэний Нисэхийн багц дүрмийг боловсруулсан байна. Энэхүү Иргэний нисэхийн багц дүрэмд "Зайнаас удирддаг агаарын хөлөг[365]"-ийн системийн талаар дараах 2 үндсэн хэсэг тусгасан болно. Үүнд:

- Иргэний нисэхийн дүрэм 101 /ИНД-101/-"Жиро-глайдер ба парасейл, хүнгүй агаарын хөлөг, (бөмбөлөг, дроныг багтаасан), цаасан шувуу, пуужингийн үйл ажиллагааны дүрэм";
- ИНД-102–д хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч, гэрчилгээжүүлэлт" дүрмийг үйл ажиллагаандаа баримтлана.

"Дрон" хэмээх *хүнгүй агаарын хөлөг*[366] нь радио давтамж, радио долгионы тусламжтайгаар алсаас удирдагддаг. Энэхүү харилцааг Монгол Улсын "Радио долгионы тухай"[367] хуулиар зохицуулсан байдаг. Хуулийн зорилт нь радио долгионыг хуваарилах, ашиглах, хамгаалах, өмчлөх, эзэмшихтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Энэ хуулийн 7 дугаар зүйлд "Нийтийн хэрэглээний радио давтамжийн зурвасыг Монгол

---

[362] Иргэний нисэхийн ерөнхий газар http://www.mcaa.gov.mn/wp-content/uploads/2016/05/63-wings-2015.pdf

[363] Иргэний Нисэхийн Ерөнхий газар http://www.mcaa.gov.mn/?p=20527

[364] Иргэний нисэхийн тухай хууль http://www.legalinfo.mn/law/details/298

[365] Зайнаас удирддаг агаарын хөлөг гэдэг нь Иргэний нисэхийн багц дүрмийн 101.3 зааснаар "алсын удирдлагаар нисгэдэг хүнгүй агаарын хөлгийг хэлнэ." Үүнд: радио удирдлагатай агаарын хөлгийн загвар болон дроныг багтаасан байх ба утсан удирдлагатай, эсхүл чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвар багтахгүй. ИНОУБ (ICAO)-аас гаргасан нэр томьёо юм.

[366] ИНД-1 багц дүрэмд (59хууд)тодорхойлохдоо: "Бүхээгтээ нисгэгчгүйгээр ажиллахаар зохион бүтээгдсэн бөмбөлөг, утсаар удирдах агаарын хөлгийн загвар, чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвар болон зайнаас удирддаг агаарын хөлгийн хэлнэ" гэж заажээ.

[367] Хуулийн цахим хаяг: Радио долгионы тухай хууль http://www.legalinfo.mn/law/details/443

Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд, иргэн энэ хуулийн дагуу Зохицуулах Хорооноос тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг авч, бүртгүүлж ашиглана" гэж заажээ.

Манай улс иргэний нисэхийн салбараа хөгжлийн шинэ түвшинд хүргэхийн тулд нисэхийн аюулгүй ажиллагааг сайжруулах дэвшилтэт тоног төхөөрөмж, арга аргачлалыг нэвтрүүлэх, оролцогч талуудын ашиг сонирхолд нийцсэн агаарын зайг зохион байгуулах томоохон хэмжээний төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байгаа. Үүний нэг нь болох дээд агаарын зайд ажиглалтын систем нэвтрүүлэх ажлыг 2012 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ удаагийн шинээр ашиглалтад оруулсан 2 радартай нийлээд нийт 7 ажиглалтын станцтай болсон. Ингэснээр манай улсын дээд агаарын зайн радарын бүрхэлт сайжирч, өгөгдлийг илүү нарийвчлалтай хянах чадамжтай болж байгаа бөгөөд нийт агаарын зайн ажиглалтын бүрхэлт 80 хувьд хүрч, өнгөрөлтийн нислэгийн 90 хувийг ажиглалтын удирдлагаар хангах боломжтой болжээ.

**Иргэний нисэхийн дүрэм 101[368] (дроныг багтаасан)**

ИНД-101 нь зөвхөн 25 кг хүртэлх жинтэй зайнаас удирддаг агаарын хөлгийн хувьд дагаж мөрдөх баримт бичиг мөн. Харин 25 кг-аас дээш жинтэй зайнаас удирддаг агаарын хөлгийн үйл ажиллагаа эрхлэгч нь ИНД-102-ын дагуу гэрчилгээжсэн байна. Нийт жин нь 15-25 кг хүртэл жинтэй зайнаас удирддаг агаарын хөлөг бүтээх ажиллагааг эрх бүхий этгээд нь шалгасан байх ёстой бөгөөд ИНЕГ-ын даргаар зөвшөөрөгдсөн байна. ИНД-101-ийн дагуу зайнаас удирддаг агаарын хөлгийн үйл ажиллагаа явуулахад дараах 12 үндсэн зүйлийг анхаарах шаардлагатай. Үүнд:

1. Нийт жин нь 25 кг болон түүнээс дээш жинтэй зайнаас удирддаг агаарын хөлгийн үйл ажиллагаа эрхлэхгүй бөгөөд аюулгүй ажиллагааг хангасан байх;
2. Бусад хүмүүс, тэдгээрийн эд материал болон бусад агаарын хөлөгт эрсдэл учруулахааргүй бүх шатны арга хэмжээг авч байх (эрсдэлтэй гэж үзвэл нисгэхгүй байх);
3. Зөвхөн өдрийн гэрэлтэй цагаар нисгэх;
4. Бусад бүх төрлийн зорчигчтой буюу хүнтэй агаарын хөлөгт зам тавьж өгөх;
5. Тухайн агаарын хөлөгтэй ил харааны орчинг хадгалах буюу зайнаас удирддаг агаарын хөлгийг нүдэн баримжаагаар харж чадах орчинд л нисгэж (тухайлбал; дуран ашиглах, дэлгэцээр хянах, эсхүл ухаалаг утас гэх мэт өөр системийн тусламжтайгаар хянан нисгэхийг хориглоно) бусад төрлийн агаарын хөлгүүдээс аюулгүй зайд байгааг бататгах (эсхүл өөр бусад этгээдийг тодорхой нөхцөлд бусад агаарын хөлөгтэй аюулгүй зайд байгааг бататгаж байх);
6. Зайнаас удирддаг агаарын хөлгийг газрын түвшнээс дээш 120 м (400 фут)-ээс дээш өндөрт нисгэхгүй (зөвхөн тодорхой нөхцөлүүдийг хангаснаас бусад тохиолдолд);
7. Агаарын хөлгийг нисгэхээр төлөвлөж буй бүсийн агаарын зайн зохион байгуулалт, хязгаарлалтын талаар зохих мэдлэгтэй байх;
8. Аэродром, эсхүл аэродромоос 4 км-ээс дотогш зайнаас удирддаг агаарын хөлгийг нисгэхгүй байх (зөвхөн тодорхой нөхцөлүүдийг хангаснаас бусад тохиолдолд);
9. Хэрэв хяналттай агаарын зайд агаарын хөлгийг нисгэх тохиолдолд Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагад урьдчилан мэдэгдэж, зохих зөвшөөрлийг авсан байх;
10. Эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл аваагүй тохиолдолд тусгай зориулалтын агаарын зайд нисгэхгүй байх (тухайлбал, цэргийн үйл ажиллагааны бүс, хязгаарлалттай бүс гэх мэт);
11. Хэрэв хэн нэгний дээгүүр өндөрт нисгэхээр бол тухайн этгээдтэй харилцан зөвшилцсөн байх;

[368] http://www.mcaa.gov.mn/wp-content/uploads/2018/01/IND-101.pdf

12. Тогтоогдсон бүс, агаарын зай, объект дээгүүр нисгэх тохиолдолд тухайн бүс, агаарын зай, объектыг эзэмшигчтэй урьдчилан тохиролцсон байх.

Дээрх 12 зөвлөмж нь ИНД-101-р дүрмийг бүрэн төлөөлөхгүй бөгөөд хэрэв ИНД-101 болон ИНД-102-ын дагуу үйл ажиллагаа эрхлэхээр төлөвлөж байгаа тохиолдолд холбогдох дүрмийг сайтар судалж, өөрийн эрхлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааг дүрмийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд урьдчилан үнэлж, дүгнэсэн байна.

**Иргэний нисэхийн дүрэм 102[369]**

ИНД-102 нь зайнаас удирддаг агаарын хөлгийн үйл ажиллагааны эрсдлийг зохицуулна. Өргөдөл гаргагч нь ИНЕГ-т үйл ажиллагааны зааврaa хүргүүлж, тухайн үйл ажиллагаанд гарч болох аюулыг тогтоож, эрсдлийн үнэлгээ хийсэн, мөн эдгээр эрсдлийг бууруулах арга хэмжээг тодорхойлсон байна. ИНЕГ-аас өргөдөл гаргагчид ямар үйл ажиллагааны төрөл нь гэрчилгээжсэн байх шаардлагатай талаар зөвлөмж, зөвлөгөө өгөх боломжтой. ИНД-102-ын дагуу гэрчилгээжихэд энэ хоёр дүрмийн холбогдох шаардлагууд нэгэн адил тавигдана.

**Зөвшилцөл**

Зайнаас удирддаг агаарын хөлгийн үйл ажиллагаа эрхлэгч нь объектыг эзэмшигч болон хүмүүс дээгүүр агаарын хөлгөө нисгэх тохиолдолд урьдчилан зөвшилцсөн байх бөгөөд дараах 2 шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Агаарын хөлгийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүмүүс дээгүүр зайнаас удирддаг агаарын хөлгийг нисгэх бол энэ тухайгаа холбогдох хүмүүст нэн түрүүнд мэдэгдэж, зөвшилцөл хийхгүйгээр тухайн агаарын орон зайд нисгэхийг хориглоно;
2. Объектыг эзэмшигчтэй харилцан зөвшилцөлгүйгээр тухайн объектын харьяаллын хүрээн дэх агаарын орон зайд зайнаас удирддаг агаарын хөлгийг нисгэхийг хориглоно.

Дээрх шаардлага нь ИНД-101-ээр шаардагдах эрсдлийг бууруулахтай холбогдсон харилцааг зохицуулах чухал зүйл юм. Үүнээс гадна аливаа аюул эрсдлээс зайлсхийх, урьдчилан сэргийлэх олон тооны харилцаа, үүрэг хариуцлагууд байгаа болно. Хэрэв зөвшилцөл хийлгүйгээр, эсхүл зөвшилцөл хийх боломжгүй нөхцөлд зайнаас удирддаг агаарын хөлгийг нисгэх нь ИНД-101-ийн дагуу үйл ажиллагаа эрхлэхэд аюултай бөгөөд эрсдэлтэй үйл ажиллагаа явуулсанд тооцогдохыг анхаарах шаардлагатай.

Мөн зайнаас удирддаг агаарын хөлгийг нисгэх үйл ажиллагааг ИНД-102-ын дагуу гэрчилгээжүүлэх тухай өргөдлийг ИНЕГ-т гаргаж болно. ИНД-102-ын дагуу зохих үнэлгээг хийсний үндсэн дээр зайнаас удирддаг агаарын хөлгийг эзэмшигчийг дээр дурдсан зөвшилцөл хийх үүргийн аль нэг, эсхүл хоёулангаас нь чөлөөлөх тухай зөвшөөрлийг ИНЕГ-ын даргаас гаргаж болно.

ИНЕГ-ын “дрон”-ы үйл ажиллагааны зохицуулалтыг холбогдох дүрэм журамд тусгахдаа: “Дрон” буюу зайнаас удирддаг агаарын хөлгийг нисгэх үйл ажиллагааг зохицуулах Иргэний нисэхийн 101 болон 102-р дүрэм /ИНД-101, ИНД-102/-үүдийг боловсруулж, аливаа дрон эзэмшигч хувь хүн, байгууллагын үйл ажиллагаанд хязгаарлалт хийх бус, харин нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлыг хэрхэн хангах тухай тусгасан зөвлөмж, гарын авлагууд /зөвлөмжийн цувралууд, маягтууд/-ыг бэлтгэсэн байна.

ИНЕГ-аас эхний ээлжинд Монгол Улсад орж ирсэн болон бүтээгдсэн дронуудыг бүртгэлжүүлэх бөгөөд цаашид дроныг эзэмшигч хувь хүн, байгууллагад зохих зөвлөмж өгөх, шаардлагатай тохиолдолд зохих зөвшөөрлийг олгох гэх мэт үйл ажиллагааг зохион байгуулах болсон байна.

Манай улсад дроныг Хятад болон гадаадын бусад орноос оруулж ирэн нислэгийн үйл ажиллагаа явуулж байгаа ба тэдгээрийг эзэмшигчдийн эрх үүргийн холбогдох мэдлэгийн түвшин зохих шаардлагад нийцэхгүй байна. Монгол Улсад дрон төхөөрөмжийн талаар хууль дүрмийн зохицуулалт байхгүй мэт ойлгож, аливаа хурим найр, баяр ёслолын

---

[369] Иргэний нисэхийн ерөнхий газар ИНД-102, 2018-01http://www.mcaa.gov.mn/wp-content/uploads/2018/01/IND-102.pdf

үйл ажиллагаанд дрон ашиглаж зураг авах, хурдан морь дагах, тэр ч бүү хэл төрийн тэргүүн болон хүндэт зочин гийчдийн хамгаалалттай машин тэргийг гүйцэж дээрээс болон хажуугаас зураг авах, уул уурхайн компаниуд орон нутгийн геологи газар зүйн 3D зургийг авах, онгоцны аэродромуудын ойролцоо нислэг үйлдэж G ангиллын нам өндрийн агаарын хөлгийн нислэгт нөлөөлөх, олон улсын аэропортын бүсэд нислэг үйлдэх тэмцээн зохиох зэрэг үйл ажиллагаа явуулах нь түгээмэл болсон.

Дроныг сонирхогчдод зориулсан хууль тогтоомж гаргаж, одоогийн мөрдөж байгаа ИНД- 101 (Жиро- глайдер ба парасэйл, хүнгүй агаарын хөлөг, бөмбөлөг, дроныг багтаасан, цаасан шувуу, пуужингийн үйл ажиллагааны дүрэм)-ийн хүрээг дахин өөрчилж цогц төгөлдөр болгох, Монгол Улсын агаарын орон зайг ашиглах, Улсын нисэх ба Иргэний Нисэхийн тухай хуульд тодорхой заалт оруулж зөвшөөрөл олгож хариуцлага тооцдог болгох, дроныг жингийн болон нислэгийн өндөр ба хурдаар нь хязгаарлалт хийж нислэгийн зайгаар ангилах, байгаль орчинд ээлтэй, аюулгүй, хууль дүрмийн дагуу зөв нисгэх, тэмцээн болон шалгах нислэг үйлдэхэд нь зориулж тусгай (helipad) бууж хөөрөх талбайтай болгох, нисэх клубуудыг хууль дүрмэнд хамруулж ИНЕГ-с нисэх клубуудыг ИНД-149 –ийн дагуу гэрчилгээжүүлэх, хяналт шалгалтыг явуулдаг болох, нисгэгчгүй нисэх төхөөрөмжүүдийн нислэгүүдийг цэгцлэх шаардлага тулгамдаж байна.

### Зайнаас удирддаг агаарын хөлгийг бүртгэх[370]

Иргэний нисэхийн ерөнхий газраас хувь хүн, албан байгууллагын эзэмшиж буй дрон буюу зайнаас удирддаг агаарын хөлгийг бүртгэх ажлыг эхлүүлжээ. Агаарын зайн хэрэглэгчид болох агаарын тээвэрлэгчид болон бусад байгууллагуудын нэгэн адил дрон эзэмшигч хувь хүн, байгууллага нь Монгол Улсын агаарын зайн тодорхой хэсгийг дрон нисгэх үйл ажиллагаанд ашиглах тул нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлыг хангах үүднээс дроныг бүртгэлжүүлж, хэрэглээг цэгцлэх шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр төлөвлөсний эхнийх нь энэхүү бүртгэлийн ажиллагаа аж. Бүртгэлийг хоёр үе шаттай зохион байгуулсан бөгөөд сайн дурын бүртгэл хийгдэх бол 2017 оноос эхлэн дрон бүртгэх ажиллагааг албажуулж, бүртгэлгүй дроныг зөвшөөрөгдөөгүй бүс, хязгаарлалттай орон зайд нисгэх тохиолдолд холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авах юм байна.

Иргэний нисэхийн ерөнхий газраас эхний ээлжинд Монгол Улсад орж ирсэн болон бүтээгдсэн дронуудыг бүртгэлжүүлэх бөгөөд цаашид дроныг эзэмшигч хувь хүн, байгууллагад зохих зөвлөмж өгөх, шаардлагатай тохиолдолд зохих зөвшөөрлийг олгох гэх мэт үйл ажиллагааг зохион байгуулах юм.

### Зайнаас удирддаг агаарын хөлгийн операторын сургалт[371]

ИНЕГ-ын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албанаас зайнаас удирддаг агаарын хөлгийн операторын сургалтыг 2017 оны 3-р сарын 31-нд анх удаа зохион байгуулсан. Нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлыг хангах үүднээс зайнаас удирддаг агаарын хөлөг эзэмшигч хувь хүн, байгууллагыг бүртгэх ажлыг 2016 оны сүүлээр эхлүүлсэн бөгөөд ИНЕГ-аас гаргасан 101-р маягтын дагуу бүртгүүлсэн 22 иргэн энэхүү сургалтад хамрагдсан.

Дэлхий дахинд зайнаас удирддаг агаарын хөлгийг аж үйлдвэрийн хяналт-шинжилгээ, хөдөө аж ахуй, экологи, хэвлэл мэдээлэл зэрэг олон салбарт өргөн хүрээтэйгээр ашиглаж буй. Үүнийг дагаад зайнаас удирддаг агаарын хөлгийн операторын эрэлт хэрэгцээ ихсэх хандлагатай байгаа ба зарим нэг аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдсан байх шаардлагатай болж байгаа юм. Тухайлбал, нислэгийн онцгой нөхцөл байдлын үед нислэгийг зогсоох горим, цаг уурын онцлог, нислэгийн аюулгүй байдал, хүний хүчин зүйлийн талаар тусгай сургалтад хамрагдаагүйгээс болж, нисэх төхөөрөмж бусад барилга байгууламжийг эвдэх, хүн, амьтныг гэмтээх, нисэхийн хууль дүрэм болон иргэний хариуцлагын хуулийг зөрчих зэрэг асуудалтай тулгардаг байна.

Тиймээс зайнаас удирддаг агаарын хөлөг эзэмшигчдийг энэхүү сургалтад

[370] News.mn https://www.news.mn/?id=251605
[371] Зам, тээвэр хөгжлийн яам http://mrtd.gov.mn/single/56/item/1010

хамруулснаар онолын болон хууль, эрх зүйн мэдлэгтэй болж, нисэх төхөөрөмжийг холбогдох дүрмийн дагуу аюулгүй удирдан жолоодож сурахын зэрэгцээ нислэгийн аюулгүй байдлыг хангаж нислэг үйлдэх чадвартай болох юм.

Сургалтаар агаарын онол, Монгол орны цаг уурын онцлог, нислэгийн аюулгүй байдал, хүний хүчин зүйл, хүнгүй нисдэг төхөөрөмж, тусгай зориулалтаар ашиглах агаарын зай, Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль зэрэг сэдвээр НААХЗА-ны мэргэжилтнүүд хичээл заасан. Сургалтад хамрагдагсдад зайнаас удирддаг агаарын хөлгийн операторын сургалтад хамрагдсан тухай батламж болон гэрчилгээ олгосон бөгөөд ИНЕГ-аас цаашид зайнаас удирддаг агаарын хөлгийг зөвшөөрөгдөөгүй бүс, хязгаарлалттай орон зайд нисгэх тохиолдолд хуулийн дагуу арга хэмжээ авна.

### Монголд дрон бүтээсэн жишээ[372]

ШУТИС-ийн Мэдээлэл холбооны технологийн сургуулийн (МХТС) багш оюутнууд дрон буюу хүнгүй нисэх төхөөрөмжийг бүтээжээ. Энэхүү нисэх төхөөрөмжийн тусламжтай агаараас мониторинг хийх жишээлбэл, ховордсон амьтдыг хянах, тоолох, газрын зохион байгуулалт, кадастрын зураг гаргах, газар зүйн зураглал, зайнаас тандан судлах гэх мэт ажлуудыг хийдэг байна.

Энэ ажлын хэсгийн зорилго нь дроны 4 сэнсийг тогворжуулах ба түүнийг тогтворжуулахад математик аргыг ашиглан үр дүнтэй бодит төхөөрөмж бүтээхийг зорьсон байна. Стерео дүрс ашиглан дроныг тогтвортой барих судалгааны ажил одоохондоо хийгдээгүй, шинэлэг зүйл. Нэг камертай дроноор дүрс боловсруулдаг ч хоёр камерт байрлуулснаар тогтворжиж, бүрэн автомат болж, хүний оролцоогүйгээр байгаа орчиндоо зохицоод зураг дарж, урдаа байгаа саадыг мэдэрдэг болох юм. Дроныг гадаа задгай талбайд GPS-ийн тусламжтайгаар нисгэнэ. Харин байшин дотор оруулахаар GPS нь унтарчихаар хаана байгааг нь мэдэрдэггүй. Аюулгүй байдлын үүднээс их биед нь төө хэртэй төмөр бэхэлж, нэг сэнс нь 60 секунтэд 10 мянган удаа эргэнэ, хурдтай үедээ 20 мянган удаа ч эргэдэг. Дроны сэнсний аюулгүй ажиллагааг хангаж, өөрийгөө хамгаалах үүднээс нэмэлт бэхэлгээ, дөрвөн талд нь тор хийж авсаархан жижигхэн болгосон. Туршилтын нэг дроны жижиг сэнс нь л гэхэд 10 мянган төгрөгийн үнэтэй. Мотор хамгийн хямдхан нь 20 мянган төгрөгийн үнэтэй. Моторын удирдлага 20 мянга. Нэг дрон дөрвөн сэнстэй гээд бодоод үзэхээр жижигхэн энгийн дрон 200 мянган төгрөг болно. Өртгийн хувьд бусад зарж буй дроны хувьд хямд байгаа. Энэ багийг А.Батмөнх профессор удирдаад Азийн хөгжлийн банкнаас тодорхой хэмжээний санхүүжилт авч дроныг бүтээсэн. Манай орны хувьд боломжийн үнэтэй дрон үйлдвэрлэх боломжтой. Харин моторыг манай улс үйлдвэрлэж чадахгүй. Сэнсийг цутгаад моторын удирдлагыг ч хийж болох байх. Дроны их биеийг Монголдоо хийлгэж 3D принтерээр хэвлүүлж лазераар зоруулж хийлгэсэн. Цаашдаа санхүүлжилт олдвол эх орондоо үйлдвэрлэх бүрэн боломжтой. Ажиллах боловсон хүчин бэлтгэгдсэн байна.

Дроныг ашиглан Монгол Улсад олон зүйлийг хийж болно. Жишээлбэл, малчид малаа хаана явна гэдгийг дрон ашиглан мэдэж болно. Бэлчээр дээр байгаа малаа харна гэсэн үг. Малчдын ажил, цагийг маш их хөнгөвчилнө. Дрон 5-6 километр хөөрөх хүчин чадалтай. Удирдлагаасаа хамаараад 20 километр хүртэл хол нисэх чадалтай. Хэрэглээ нь хязгааргүй. Дроны давуу тал нь маневар сайтай, туулах чадвар өндөр. Нэг сул тал нь 30-40 минут ажиллах хүчин чадалтай. Цагт 100-200 километр цагийн хурдтай нисэх хүчин чадалтай. Жишээлбэл, Баянзүрх дүүргээс Баянгол дүүрэг рүү дрон ашиглан яаралтай эмнэлгийн тоног төхөөрөмж зөөлөө гэхэд 2-3 минутын дотор авчирч өгөх боломжтой. Сүүлийн 2 жилийн дотор хүмүүсийн дроны хэрэглээ маш хурдацтай өсөж байна. Манай улсад үйлдвэржилт сайн хөгжөөгүй учир энэ салбарт ажиллах оюутнуудыг сургуулиа төгсөхөд нь ажлын байраар хангах шаардлага гарч байна. Үйлдвэрлэлийн автомажуулалтын электроны чиглэлийн багш нарыг монголдоо ажиллуулах шаардлага тулгарч байна.

---

[372] МХТС-ийн ахлах багш Ц.Тэнгис “Дрон тухай” ярилцлага, 2017-07-07 http://medee.mn/mobile.php?eid=94842

## 3. ГАДААД ОРНЫ ТУРШЛАГА

### I. Ерөнхий мэдээлэл

Дэлхийн олон оронд Хүнгүй хөлгийн систем[373] (ХХС) буюу дроныг иргэний хэрэглээнд ашиглах явдал сүүлийн үед эрс нэмэгдсэн тул тэдгээрийн олон нийтийн болон үндэсний аюулгүй байдалд хор нөлөө үл үзүүлэх, найдвартай ажиллагаа болон үндэсний, түүхэн дурсгалт буюу байгалийн цогцолбор газар нутгийг хамгаалах үйл ажиллагааг зохицуулах шаардлага тулгарч байна.[374] Австрали, Канад, Хятад, Франц, Герман, Израил, Япон, Шинэ Зеланд, Польш, Өмнөд Африк, Швед, Украин, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс (ИБУИНВУ) болон Европын Холбооны зохицуулалтын туршлагаас үзэхэд газрын эзний өмчийн болон хувийн нууцлалын эрх буюу дроныг ажиллуулахад оролцож буй бусад хүмүүсийн асуудлыг хөндсөн байна.

Иймэрхүү асуудлыг зохицуулах талаар олон улсын стандарт бий болгох ажил Олон улсын Иргэний Нисэхийн Байгууллага (ОУИНБ)[375]-д хийгдэж байна. ОУИНБ-аас 2011 онд ХХС-ийн талаар 328 тоот удирдамжийг[376] гаргажээ.

Европын Комисс одоогийн байдлаар дроны ашиглалтын дүрэм, журмуудыг зохицуулахыг [377] эрмэлзэж байна. Ингэхдээ хэмжээнээс үл хамааран бүх дроныг ЕХ-ны нисэхийн аюулгүй байдлын хамрах хүрээнд багтаах санал гаргаад байна.

Дроны ашиглалтын талаар дээрх 13 улс болон ЕХ-ны зохицуулалтаас харахад, дроныг нэр томьёоны хувьд янз бүрээр нэрлэсэн байна. Жишээлбэл, “хүнгүй хөлгийн систем”[378] (ХХС), “хүнгүй нисдэг машин” (ХНМ)[379] буюу “зайнаас нисгэгчтэй хөлөг” (ЗНХ)[380]. Жигдлэх зорилгоор, мөн ОУИНБ-ын хэрэглэж байгаа нэр томьёо гэдгээр нь дроныг цаашид ХХС гэж нэрлэлээ. Үүнд бүх төрлийн хүнгүй систем, машин[381] болон хөлөг[382] багтах бөгөөд харин (сонирхол) хобби болон зугаацах зорилгоор хийсэн загварын хөлөг хамрагдахгүй.

### II. Зохицуулалтын хамрах хүрээ

ХХС-ийн ашиглалтыг жин болон ашиглалтын хэлбэрээс хамааруулан зохицуулахаар журамласан байна.

1. **Европын Холбооны гишүүн улсууд**

ЕХ-ны гишүүн улсуудад 150 кг-аас дээш жинтэй том иргэний дроны ашиглалтыг хуулиар зохицуулах бөгөөд Европын Нисэхийн Үйлчилгээний Агентлаг[383] (ЕНҮА) хяналт тавина. Үүнээс жижиг дроны ашиглалтыг одоогийн байдлаар ЕХ-ны түвшинд зохицуулахгүй тул ЕХ-ны гишүүн орнууд дангаараа зохицуулж байна.

Францад 25 кг-аас ихгүй жинтэй ХХС-ийг нислэгийн тодорхой нөхцөлийг хангаж байх хугацаанд турших буюу шалгах зорилгоор ашиглахад ерөнхийдөө тусгай зөвшөөрөл шаардлагагүй. Харин 150 кг хүртэлх жинтэй ХХС-ийг “онцгой ажилд”[384] арилжааны зорилгоор[385] (албан байгууллага) ашиглах бол зохицуулалтад хамрагдана.

Германд 25 кг-аас илүү жинтэй ХХС-ийг ашиглах хориотой. Харин 5 кг-аас дээш жинтэй ХХС-ийг ашиглахын тулд эзэн нь Германы муж улсын нисэхийн газрын Нислэгийн

---

[373] ИНД-1 багц дүрэмд тодорхойлохдоо: “Бүхээгтээ нисгэгчгүйгээр ажилладаг агаарын хөлөг болон түүний холбогдох элементүүдийг хэлнэ” гэжээ.

[374] “Дроны зохицуулалт” Конгрессийн Эрхзүйн номын сан-“Regulation of Drones” The Law Library of Congress, Global Legal Research Center, 2016-англиар file://regulation-of-drones.pdf

[375] International Civil Aviation Organization (ICAO)

[376] Circular-англиар

[377] harmonise-англиар

[378] “Unmanned Aircraft System” (UAS)-англиар

[379] “Unmanned Aerial [or Air] Vehicles” (UAVs)-англиар

[380] “Remotely Piloted Aircraft” (RPA)-англиар

[381] Vehicle-англиар

[382] Aircraft-англиар

[383] European Aviation Service Agency

[384] “particular activities”-англиар

[385] commercial use-англиар

зөвшөөрөл авсан байх шаардлагатай. 5 кг-аас бага жинтэй, шаталтын моторгүй ХХС-ийг 2 жилийн хугацаанд нисгэх ерөнхий зөвшөөрөл олгоно. Ерөнхий зөвшөөрлийг тодорхой муж улсын хувьд л олгох бөгөөд бусад мужид хүчингүй байж болно.

Польшийн хувьд 25 кг-аас бага жинтэй ХХС-ийг бүртгүүлэхгүй байж болно. 25 кг-аас хэтэрвэл нислэгийн зөвшөөрөл хэрэгтэй бөгөөд зарим ашиглалтыг хязгаарлана.

Шведэд ХХС-ийг жин болон ашиглалтын хувьд олон ангилсан байдаг. Арилжааны болон эрдэм шинжилгээний зорилгоор ашиглах болон операторын хараанаас гадуур нисдэг ХХС-ийн хувьд ерөнхийдөө Шведийн Тээврийн Агентлагаас тусгай зөвшөөрөл (лиценз) авах шаардлагатай.

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад[386] 20 кг-аас доош жинтэй ХХС-ийн хувьд нисэх чадварын[387] болон хөлгийн багийн[388] тусгай зөвшөөрөл (лиценз)-ийн шаардлагаас чөлөөлөгдөх бөгөөд 20-150 кг жинтэй бүх төхөөрөмжинд Агаарын Навигацийн Дүрэм[389] (АНД) үйлчилнэ. Ийм онгоцны оператор нь бусад олон зүйлээс гадна нисэх чадварын гэрчилгээ, нисэх зөвшөөрөл болон тусгай зөвшөөрөл бүхий хөлгийн багтай байх шаардлагатай.

**2. Австрали**

Тус улсад саяхан дүрэм журмаа шинэчилсэн бөгөөд 2 кг-аас хөнгөн жинтэй ХХС-ийн хувьд зайнаас нисгэх тусгай зөвшөөрөл (лиценз) болон операторын гэрчилгээ (сертификат) шаардлагагүй. Мөн 2-25 кг жинтэй ХХС-ийн хувьд, хэрэв хүний өөрийн эдлэн газар дээгүүр зарим зориулалтаар нисгэх болон стандарт үйл ажиллагааны нөхцөл шаардлагатай нийцэж байвал дээрхтэй адил чөлөөлөгдөнө. Дээрхтэй төстэй нөхцөл байдалд 25-150 кг жинтэй ХХС-ийг ашиглахад зайнаас нисгэх лиценз шаардлагатай. Үүнээс том ХХС болон зугаацах бус[390] зорилгоор жижиг ХХС-ийг ашиглах бол зайнаас нисгэх лиценз болон операторын гэрчилгээ авсан байх шаардлагатай.

**3. Канад**

Канадад ХХС-ийг ашиглахын тулд түүний зориулалт нь зугаацах буюу үл зугаацах эсэх, мөн жингээс хамааруулан оператор нь тусгай нисэх үйл ажиллагааны гэрчилгээ авах шаардлагатай боловч зарим тохиолдолд хөнгөлөх боломжтой. 35 кг хүртэлх жинтэй ХХС-ийн хувьд, зугаа цэнгэлийн зориулалтаар ашиглах бол ийм гэрчилгээ шаардлагагүй. Үл зугаацах зориулалтаар болон 35 кг-аас илүү жинтэй (зориулалтаас үл хамааран) ХХС-ийг ашиглахын тулд дээрх гэрчилгээг авсан байвал зохино. 2 кг хүртэл болон 2-25 кг жинтэй ХХС-ийг хэрэглэгч нь хэрвээ аюулгүй ажиллагааны шаардлагыг чанд сахих чадвартай бол мөн чөлөөлөгдөнө.

25 кг буюу хүртэлх жинтэй ХХС-ийн дүрмийг шинэчлэхээр ажиллаж байгаа болно. Өөрчлөлт орсоноор зугаацах болон үл зугаацах хэрэглээ гэсэн ангилалгүй болно. Уг өөрчлөлтийн төсөл нь ХХС-ийн ашиглалтын эрсдэлд тулгуурлан ангилалтын системийг боловсруулсан бөгөөд 25 кг буюу давсан жинтэй ХХС-ийн хувьд лицензийн шаардлага тавьсан хэвээр байх ажээ.

**4. Хятад**

Хятадын Иргэний Нислэгийн Зохицуулах Газар нь саяхан ХХС-ийг зохицуулах түр журам баталсан. 1.5 кг хүртэлх ХХС-ийн хэрэглээ ерөнхийдөө зохицуулалтгүй байгаа болно. Түр журамд хоосон үеийн цэвэр жин нь хамгийн ихдээ 116 кг буюу хөнгөн буюу хөөрөх үеийн бохир жин хамгийн ихдээ 150 кг буюу хөнгөн, мөн нислэгийн хурд нь 100 км/цаг-аас хэтрэхгүй ХХС-ийг хамруулна. Тариалангийн талбай, бэлчээр нуга болон ойг хамгаалах зориулалтаар ашиглах, хөөрөх үеийн бохир жин нь хамгийн ихдээ 5 700 кг буюу хөнгөн болон газрын гадаргуугаас 15 м-ээс хэтрэхгүй өндөрт нисэх “ургамал хамгаалалтын

[386] United Kingdom
[387] Airworthiness-англиар
[388] Flight-crew-англиар
[389] Air Navigation Order-англиар
[390] nonrecreational-англиар

ХХС", мөн 4 600 куб м-ээс хэтрэхгүй эзэлхүүнтэй хийлдэг хүнгүй агаарын (хөлөг) онгоц[391]-ийг уг түр журмаар зохицуулна.

**5. Израил**

Израилийн эрх зүйн орчин нь бүхий л ХХС-ийн хэрэглээг түүний жин буюу ашиглалтын төрлөөс үл хамааран ерөнхийдөө тусгайлан өргөн дэлгэр журамласан байдаг бөгөөд бүх төрлийн (хөлөг) онгоцонд хамаарах ерөнхий журмууд ч мөн ХХС-д хамаардаг байна.

**6. Япон**

Японы Агаарын тээврийн тухай хуулинд зааснаар, 200 грамм (7 унц) буюу түүнээс хөнгөн жинтэй ХХС-ийг лицензжүүлэх болон дугаар авахаас чөлөөлнө.

**7. Шинэ Зеланд**

Шинэ Зеландад хүнгүй хөлгийг жингээр нь ялгадаг. 15-25 кг жинтэй ХХС-ийн хувьд холбогдох төрийн байгууллагын зааврaар зохион бүтээгдээгүй, эсхүл зохих хүн буюу байгууллагаас шалгаж, зөвшөөрөл өгөөгүй бол ашиглах хориотой. Ийм ХХС-ийг хуулиар тогтоосон ашиглалтын хязгаарлалтын хүрээнд ашиглах боломжтой. 25 кг-аас их жинтэй болон ашиглалтын хязгаарлалтаас давсан ХХС-ийг Иргэний Нисэхийн Газраас олгосон Хүнгүй агаарын хөлгийг ашиглах гэрчилгээний үндсэн дээр ашиглана.

**8. Өмнөд Африк**

Өмнөд Африкт 1 болон 2 дугаар ангиллын[392] ХХС-ийг ашиглахын тулд зөвшөөрөл шаардлагатай. Энэхүү ангилал нь цаашлаад хувийн, арилжааны, аж ахуйн нэгжийн болон ашгийн бус хэрэглээ гэсэн дэд ангиллуудад хуваагдана. ХХС-д тавигдах техникийн болон ашиглалтын нөхцөл шаардлагууд нь хэрэглээний төрлөөс хамаарна. Жишээ нь, хувийн хэрэглээнд зөвхөн 1А (1.5 кг-аас бага жинтэй) буюу 1Б (7 кг-аас хөнгөн жинтэй) ангиллын ХХС-ийг л ашиглах боломжтой. Хувийнхаас бусад хэрэглээнд зөвшөөрлийн бичиг, бүртгэлийн гэрчилгээ болон ХХС-ийн ашиглалтын гэрчилгээ шаардлагатай. ХХС-ийн ашиглалтын хязгаарлалтын түвшин нь түүний ашиглалтын нарийн түвэгтэй байдлаас шууд шалтгаална. Хяналттай агаарын орон зайд хараaны үзэгдэх шугам[393] (ХҮШ)-аас гадуурх (ХҮШГ[394]) хэрэглээнд нэмэлт хязгаарлалтууд тавигдана.

**9. Украин**

Украины хуулийн этгээд, эсхүл Украинд оршин суудаг хувь хүний өмчлөлд байдаг, эсхүл оршин суугч бус эзнээс Украины оператор түрээслэсэн буюу зээлсэн ХХС-ийг оруулаад бүх агаарын хөлгийг бүртгүүлэх шаардлагатай. Харин зугаа цэнгэл болон спортын үйл ажиллагаанд ашиглах, хөөрөх үеийн жин нь 20 кг-аас хэтрэхгүй агаарын хөлөг энд хамаарахгүй.

## III. ХХС-ийн бүртгэл ба хаяг тэмдэг

Нилээд орон зарим төрлийн ХХС-ийг бүртгэх ба хаяг тэмдэгжүүлэх шаардлагыг тавьдаг. Шведэд бүх ХХС нь операторын нэр болон телефон утасны дугаар, мөн гэрчилгээний дугаар (хэрэв байгаа бол), эсхүл операторын хараанаас гадуур ашиглах зориулалтаар гэрчилгээ авсан бол бүртгэлийн дугаар бүхий тэмдэгтэй байвал зохино.

Израилийн иргэн буюу Изралийн аж ахуйн нэгжийн эзэмшилтэй бүх ХХС-ийг Израилийн Иргэний Нисэх-д бүртгүүлэх шаардлагатай. ХХС нь Израилийн бүртгэлийг нотолсон мэдээлэл, үйлдвэрлэгчийн нэр болон бүртгэлийн дугаар бүхий тэмдэгтэй байна. Түүнээс гадна бүх ХХС нь галд тэсвэртэй тусгай зөвшөөрлийн хавтан (таваг[395])-тай байвал зохино.

Өмнөд Африк (ӨА)-т бүртгэлтэй ХХС нь ӨА-ийн иргэншилтэй байх бөгөөд иргэншил

[391] Airship-англиар
[392] Class-1 and Class-2-англиар
[393] visual line of sight (VLOS)-англиар
[394] Beyond visual line of sight (BVLOS)-англиар
[395] plates-англиар

болон бүртгэлийн тэмдэглэгээг[396] агуулсан, товойлгож үйлдсэн тодорхойлолтын хавтан (таваг)-тай байна.

ХХС-ийг аюултай байдлаар буюу хууль бусаар хэрэглэсэн тохиолдолд оператор/эзэмшигчид нь хариуцлага тооцох чадвартай байх зорилгоор 0.5 кг-аас дээш жинтэй бүх ХХС-ийг бүртгэх хуулийн төслийг Германы Тээвэр ба Тоон Дэд бүтцийн[397] Яам боловсруулж байна.

## IV. Нислэгийн зөвшөөрлийн мэдээлэл

Шаардлагатай мэдээлэл болон баримтын түвшин судалсан улс орнуудад харилцан адилгүй байна. Жишээ нь, Канадад ХХС-ийг ашиглахын тулд ерөнхийдөө хүсэлт гаргагчийн томилсон, ашиглалтанд хяналт тавих үүрэг хүлээсэн хүний тодорхойлолтыг шаарддаг.

Францад туршилтын болон шалгах зориулалтаар ХХС нисгэх зөвшөөрөл авах хүсэлт нь туршилтын нислэгийн төсөөлж буй нөхцөлүүдийг тодорхойлолт, газар дээр болон агаарт байгаа гуравдагч этгээдийн аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээг агуулсан байна. Арилжааны зориулалтаар ашиглах ХХС-д зөвшөөрөл олгохдоо түүний аюулгүй байдлыг хангасан баримттай дүн шинжилгээ, туршилт явуулсан тухай загварын гэрчилгээг шаарддаг байна. Мөн ХХС-ийг ашиглахад аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг тодорхойлсон операторын мэдүүлэг[398] шаардлагатай байдаг.

Германд ерөнхий буюу тусгай зөвшөөрлийг авах талаар хувь хүн хүсэлт гаргаж байгаа бол нэр, хаяг, төрсөн огноо болон газрыг тодорхойлох шаардлагатай байдаг. Харин аж ахуйн нэгж бол компанийн нэр, мөн бүртгэлтэй төлөөлөгч болон ХХС-ийг ашиглах бүх ажилтнуудын нэр, хаяг, төрсөн огноо болон газрыг бүртгүүлэх шаардлагатай.

Германы тусгай нислэгийн зөвшөөрөл хүсэж байгаа бол ерөнхий зөвшөөрөл авахад шаардагдах мэдээллээс гадна ХХС-ийг ашиглахаар төлөвлөж буй газар зүйн болон техникийн өгөгдөл; операторын мэдлэг чадвар; мэдээлэл нууцлах илэрхийлэл[399]; хэрэв байвал холбогдох эрх бүхий зохицуулах байгууллага буюу цагдаагийн газар, эсхүл эрх бүхий байгаль хамгаалах төрийн байгууллагын зөвшөөрлийг нэмэж шаардана.

Шинэ Зеландад жижиг ХХС-ийн хувьд ерөнхийдөө урьдчилан зөвшөөрөл авах шаардлагагүй боловч 15-25 кг жинтэй ХХС-ийг ашиглахад зарим нөхцөл, шаардлага тавигддаг байна. Харин 25 кг-аас дээш жинтэй ХХС-ийн ашиглалтанд илүү өргөн шаардлага тавигдана. Үүнд: ашиглалтыг голчлон хариуцах хүний тодорхойлолт[400]; ашиглалтын үед хэрэглэгдэх бодит байршлын дэлгэрэнгүй мэдээлэл; хүн, өмч хөрөнгө болон бусад агаарын хөлөгт үзүүлэх мэдэгдэж байгаа болон болзошгүй аюулын талаарх мэдээлэл; тэдгээр аюулаас үүдэлтэй эрсдлийн үнэлгээ; эрсдлийг сулруулах болон удирдахад авч хэрэгжүүлэх арга хэмжээний заавар[401]. Бие бүрэлдэхүүний мэдлэг, чадвар болон эрүүл мэндийн[402] магадлал, нотолгоо шаардлагатай. Мөн агаарын хөлгийн төрөл, таних тэмдэг[403], хэрэглэж байгаа хяналтын систем, ашиглалтын дэг журам болон аюулгүй нисэх байдлын үнэлгээ шаардлагатай байдаг.

Өмнөд Африкт хувийн бус зориулалтаар ХХС-ийг ашиглах бол зөвшөөрлийн бичиг болон бүртгэлийн гэрчилгээ шаардлагатай байдаг. ХХС-ийн загвартай холбогдох болон аюулгүй байдлын стандартын дагуу бичиг баримтыг хүсэлт гаргагч мэдүүлсэнийг үндэслэн зөвшөөрлийн бичиг гардаг байна.

## V. ХХС-ийн операторын мэргэшлийн түвшин

Зарим оронд ХХС-ийн операторын мэргэшлийн түвшинд тусгай шаардлага тавьдаг.

---

396 marks-англиар
397 Digital Infrastructure-англиар
398 declaration-англиар
399 statement-англиар
400 identification-англиар
401 description-англиар
402 fitness-англиар
403 identification-англиар

Австралид ХХС-ийг ашиглахын тулд оператор нь мэргэшсэн, тодорхой бэлтгэл сургуулилт дүүргэсэн болон ХХС-ийг хамгийн багадаа тогтоосон цаг нисгэж туршсан байх шаардлагатай байдаг. Хэрэв аж ахуйн нэгж (ААН) нь том ХХС буюу зугаацах бус зориулалтаар жижиг ХХС-ийн операторын гэрчилгээ авахыг хүсэж байгаа бол ХХС-ийг аюулгүй ашиглах зориулалтын барилга байгууламж, дэг журам болон бие бүрэлдэхүүнтэй байвал зохино.

Францад "онцгой [арилжааны] үйл ажиллагаа"-нд ашиглах ХХС-ийн оператор нь ерөнхийдөө хүнтэй агаарын хөлгийг нисгэх онолын мэдлэг чадвартай гэдгийг нотолсон гэрчилгээтэй байх шаардлагатай. Тэд мөн адил практик дадлагын дамжаа дүүргэсэн байвал зохино. Нисгэгчээс алслагдах хэвтээ зай нь 1 км-ээс илүүгүй агаарт нисэх ХХС-ийн нисгэгч[404] нь нэмэлт нөхцөлийг хангасан байх шаардлагатай. Үүнд: хүнтэй агаарын хөлгийн нисгэгчийн тусгай зөвшөөрөл (лиценз) болон тодорхой хугацааны нисгэгчийн практик туршлага. Агаарын бөмбөлгөөс бусад 25 кг-аас дээш жинтэй дроны нисгэгч нь иргэний нисэхийн асуудал хариуцсан яамны бүрэн эрхт төлөөлөгчийн өмнө нислэг үйлдэж үзүүлэх шаардлагатай байдаг.

Германд 5-25 кг жинтэй ХХС-ийг ашиглах зөвшөөрөл авахын тулд операторын мэдлэг, туршлагын талаарх мэдээлэл болон дасгал бэлтгэл хийсэн тухай нотолгоог хавсаргаж мэдүүлэх шаардлагатай байдаг.

Израилд ХХС-ийн операторыг оруулаад бүх агаарын хөлгийн оператор нь оршин суух болон иргэншил, ажлын газар болон үндсэн бизнесийн байршилтай холбогдох тодорхой нөхцөлийг хангасан байвал зохино. Арилжааны зориулалтаар ашиглах бол нэмэлтээр агаарын хөлгийн өмчлөл, ашиглалтанд зайлшгүй шаардагдах тоног төхөөрөмжүүд, Израил дахь хүссэн газар нутагт нисэх болон буух зөвшөөрөл гэсэн шаардлагууд тавигдана. Түүнчлэн, оператор нь явуулах үйл ажиллагааны төрөл болон ашиглах тоног төхөөрөмжинд тохирсон тусгай зөвшөөрөл бүхий лицензийг олж авсан байвал зохино. Цаашилбал, олгох лицензийн төрөл нь операторын төрх (характеристик)-өөс шалтгаалдаг. Жишээлбэл, дадлагажигч, ХҮШГ (хараань үзэгдэх шугам гадуурх) нисэх хүнгүй агаарын хөлөг (ХАХ)-ийн нисгэгч, ХХС-ийн нисгэгч, ХХС-ийн зааварлагч, нислэгийн төрлөөс (дотоодын, гадаадын, туршилтын) болон ХХС-ийн төрөл, зэрэглэл[405], ангилалаас хамаарна.

Шинэ Зеландад 25 кг-аас дээш жинтэй буюу ерөнхий ашиглалтын хязгаарлалтаас гадуур ХХС-ийг ашиглах бол мэргэшил буюу лицензээр үзүүлэх, эсхүл тусгай дадлага хийсэн болон холбогдох туршлагаа нотлох шаардлагатай болдог.

Польшид арилжааны ХХС-ийн оператор нь Польшийн Иргэний Нисэхийн Газар олгосон мэдлэг, чадварын гэрчилгээтэй байвал зохино. Уг гэрчилгээг хувь хүнд эрүүл мэндийн үзлэг, онолын болон практикийн шалгалт болон даатгалыг үндэслэн олгоно. Гэрчилгээ нь тодорхой жин (2 кг хүртэлхээс 150 кг хүртэл)-гээр болон ХХС-ийн ангилал (нисэх онгоц[406], нисдэг тэрэг[407], агаарын хөлөг[408] буюу олон сэнст[409])-аар хязгаарлагдана. ХҮШ ашиглалтын гэрчилгээ авах бол холбогдох дүрэм, журам болон онолын суурь мэдлэг (агаарын орон зай, түргэн тусламж, нислэгийн дүрэм г.м.)-тэй эсэхээ мэдүүлэх бөгөөд онолын болон практикийн шалгалтанд тэнцсэн байх шаардлагатай байдаг. Харин ХҮШГ ашиглалтын гэрчилгээ авах бол онолын болон практикийн шалгалтанд тэнцэхээс гадна дадлагын сургалтад (мэргэжил дээшлүүлэх курсэд) хамрагдсан байх шаардлагатай болдог.

Шведэд 7 кг-аас илүү жинтэй ХХС-ийг ХҮШ-ын дотор ашиглах бол оператор нь 18 нас хүрсэн байвал зохино. Харин ХҮШГ ашиглах бол оператор нь хамгийн залуудаа 21 настай болон хамгийн хөгшиндөө 67 настай байх бөгөөд эрүүл мэндийн тодорхой түвшний гэрчилгээтэй байх шаардлагатай болдог. Нас болон эрүүл мэндийн шаардлагаас гадна

---

[404] pilot-англиар
[405] category-англиар
[406] airplane-англиар
[407] helicopter-англиар
[408] airship-англиар
[409] multirotor-англиар

хүнгүй агаарын системийн сургалтын хөтөлбөрт хамрагдсан тухай Шведийн Тээврийн Агентлагаас олгосон гэрчилгээтэй байвал зохино. Мөн Ерөнхий заавар[410]-т тусгасны дагуу нисгэгч нь Европын Нисэхийн Аюулгүй Байдлын Агентлагийн Гүйцэтгэх захирлын баталсан Нислэгийн аюулгүйн стандартын талаар мэдлэгтэй байвал зохино.

## VI. Ашиглалтын шаардлага, нөхцөл

Улс орнуудын нэг бүрчилсэн судалгаанаас харахад, ашиглалтанд янз бүрийн нөхцөл, шаардлагууд тавигдаж байна. Тэднээс жишиг болохуйц шаардлагуудыг дор жагсаав. Үүнд:

### 1. Сансрын[411] (орон зайн) хязгаарлалт

Франц, Герман, Япон, Польш болон ИБУИНВУ улсуудад ХХС-ийг хүмүүс болон нийтийн цугларалт дээгүүр нисгэдэггүй байна. Цэргийн байгууламж, нисэх талбарын[412] замын хөдөлгөөний[413] бүс, шорон болон АЦС (атомын цахилгаан станц) зэрэг нууцлаг байршлын дээгүүр нисгэхийг олон оронд хязгаарладаг байна. Үүнд: Франц, Израил, Герман, Япон, Шинэ Зеланд, Польш, Швед, Өмнөд Африк, Украин болон ИБУИНВУ. Мөн Франц, Израил болон Швед улсад түүхэн онцгой хөшөө болон/ дархан цаазат газар[414](үндэсний парк) буюу байгалийн нөөц газар[415] дээгүүр урьдчилан зөвшөөрөл авахгүйгээр нисгэхийг хориглоно.

Хятад, Герман, Израил, Япон, Польш, Швед зэрэг улсад онгоцны буудлын хяналтын бүсэд ХХС ашиглахыг тусгайлан зохицуулдаг байна.

Израилд нисгэхийг хориглосон, хязгаарласан болон аюултай гэж үзсэн газрын нарийвчилсан жагсаалт гаргасан байна. Уг жагсаалтанд газар зүйн координат болон тухайн газрын дээгүүрх хамгийн бага болон их нислэгийн өндрийг тусгадаг байна. Иймэрхүү газрын тухай Хятадад хуулиндаа болон дүрэмдээ (журамдаа) тусгасан байна. Харин Шведэд ХХС-ийг нисгэхийг хориглосон газрыг газрын зураг дээр нарийвчлан тэмдэглэсэн байна.

### 2. Радио холбоо

Зарим оронд ХХС-д ашиглаж байгаа радио долгионы давтамжийг агаарын хөдөлгөөний хяналт, хөдөлгөөнт гар утас буюу түргэн тусламжийн үйлчилгээ зэрэг амин чухал радио системд хөндлөнгийн нөлөө (интерференц) оруулахгүйн тулд зохицуулсан байна. Үүнд: Хятад, Шинэ Зеланд, Швед, Польш, Өмнөд Африк болон НВУ. НВУ-д 35 Мгц давтамжийн зурвасыг зөвхөн агаарын загварт зориулан дангаар нь ашигладаг байна.

### 3. Харааны үзэгдэх шугам

ХХС болон түүний операторын хоорондох (харааны үзэгдэх шугам) ХҮШ-ын талаар улс орнууд янз бүрийн байдлаар хандаж байна.

Австралид, хэрэв урьдчилан зөвшөөрөл олгоогүй бол ХХС-ийг ерөнхийдөө ХҮШ-ын хүрээнд ашиглах шаардлагатай байдаг.

Хятадад ХҮШ дотор нисгэх ХХС-ийг зөвхөн өдрийн цагаар[416] ашиглах боломжтой байдаг. Энэхүү шаардлага нь ХҮШГ нисгэх ХХС-д хамаарахгүй. Гэхдээ ХҮШ болон ХҮШГ (харааны үзэгдэх шугам гадуурх) дотор нисгэх ХХС-ийн аль аль нь хүнтэй агаарын хөлөгт зам тавьж өгвөл зохино.

Германд ерөнхийдөө 25 кг-аас илүү жинтэй ХХС-ийг бүх цаг үеийн туршид ХҮШ дотор байлгах шаардлагатай байдаг.

Японд 200 гр-аас дээш жинтэй ХХС-ийн оператор нь ХХС болон түүний эргэн тойрныг байнга өөрийн нүдээр харж байвал зохино.

---

[410] General guidelines-англиар
[411] spatial-англиар
[412] Airfield-англиар
[413] traffic-англиар
[414] National parks-англиар
[415] Natural reserves-англиар
[416] Day time-англиар

Шинэ Зеландад 25 кг-аас бага жинтэй ХХС-ийг ашиглалтын гэрчилгээгүй нисгэж болох боловч оператор хөлөг хоёр ХҮШ дотор байх шаардлагатай байдаг. Харин ХХС-ийг ХҮШГ ашиглах бол гэрчилгээ шаардлагатай байдаг.

Польшид ХХС-ийн нислэгийн мэдлэг, чадварын гэрчилгээтэй бол ХҮШ дотор буюу ХҮШГ нөхцөлд ашиглахыг зөвшөөрөх боловч ХХС-жин 25 кг-аас хэтэрсэн тохиолдолд зарим ашиглалтын хязгаарлалт тавигдана (жишээ нь, зөвхөн ХҮШ, хүн ам суурьшсан газар, хүмүүс болон өмч хөрөнгөөс хамгийн багадаа нисгэх зай).

Шведэд 7 кг-аас хөнгөн ХХС-ийн хувьд ерөнхийдөө ХҮШ дотор тодорхой түвшнээс дээш кинетик энерги үүсгэхгүй байх шаардлагатай байдаг.

Өмнөд Африкт ХҮШГ ашиглах бол тусгай зөвшөөрөл шаардлагатай.

НВУ-д 20 кг-аас хөнгөн ХХС-ийг ашиглахдаа бусад хөлөг, хүн, машин, онгоц болон байгууламжийг мөргөхөөс сэргийлэн шууд, бусад тусламжгүйгээр болон хараанаас алдахгүйгээр нислэгийн замд байнга хяналт тавьж байх шаардлагатай байдаг.

**4. Аюулгүй байдлын онцлог**[417]

Зарим улсад аюулгүйн тоноглолыг ХХС-д суурилуулсан байдаг.

Францад ХХС-ийг ашиглахын урьдчилсан нөхцөл болгож загварын гэрчилгээ авсан байх шаардлагатай. Загварын гэрчилгээ олгохын тулд хүн амын суурьшлаас гадуур, ашиглалтын бүсэд гуравдагч этгээд байхгүй болон нисгэгчээс хэвтээ зай нь 1 кг-аас хэтрэхгүй байх, энэхүү хэвтээ зайны хязгаараас давуулахгүй байх автомат системтэй байх, эсхүл хязгаараас хэтэрсэн тохиолдолд ажиллах дохиоллын системтэй байх зэрэг шаардлагууд тавьдаг.

Францад 2 кг буюу түүнээс хүнд ХХС-ийг суурьшлын бүсэд ашиглахдаа, гуравдагч этгээдийн дээгүүр нисгэхгүй, нисгэгчээс хэвтээ зай нь 100 м-ээс хэтрэхгүй, ХХС нь гуравдагч этгээдийг хамгаалах тоноглолтой байна. Хэрэв нисгэгчтэй холбоо тасарвал энэхүү систем нь ХХС өөрийгөө автоматаар буулгах горимд шилжүүлнэ. 4 кг-аас дээш жинтэй ХХС-ийн хувьд агаарын хөлгийн хурдыг нисгэгчид мэдүүлж байх төхөөрөмжтэй байх шаардлагатай. Ийм төхөөрөмж нь ХХС-ийн үндсэн хяналтын холбооноос хамааралгүй бие даасан байх ёстой ба хэрэв ХХС унавал дуут сэрүүлэг өгөх ёстой.

Шведэд ХХС нь хэрэв шаардлагатай бол түүнийг унтраах зорилготой ослын тоноглолтой байх шаардлагатай. Мөн ХХС-ийн автомат нислэгийн системийг дарах системтэй байвал зохино. Зарим төрлийн ХХС-ийн хувьд гадны эх үүсвэр буюу цаг агаарын тайлагдашгүй үзэгдлээс үүдэлтэй буруу сигналын эсрэг хамгаалалт, хариулагчтай[418] байх болон мөргөлдөхөөс сэргийлэх систем зэрэг нэмэлт тоноглолтой байх шаардлагатай.

**5. Даатгал**

Зарим улсад ХХС-ийн оператор нь газар дээр байгаа гуравдагч этгээдийн хариуцлагыг хаах даатгалтай байхыг шаарддаг. Үүнд: Хятад, Герман, Польш, Швед, Өмнөд Африк болон НВУ (20 кг-аас хүнд ХХС-ийн хувьд).

[417] Features-англиар
[418] Transponder-англиар

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ


- Иргэний нисэхийн ерөнхий газар http://www.mcaa.gov.mn/wp-content/uploads/2018/01/IND-102.pdf
- Хуулийн цахим хаяг: Иргэний нисэхийн тухай хууль http://www.legalinfo.mИрn/law/details/298
- Иргэний Нисэхийн Ерөнхий газар http://www.mcaa.gov.mn/?p=20527
- Иргэний Нисэхийн Ерөнхий газар http://www.mcaa.gov.mn/wp-content/uploads/2018/01/IND-101.pdf
- Иргэний нисэхийн ерөнхий газар http://www.mcaa.gov.mn/wp-content/uploads/2018/01/IND-102.pdf
- Хуулийн цахим хаяг: Радио долгионы тухай хууль http://www.legalinfo.mn/law/details/443
- News.mn Хөлгийг бүртгэх https://www.news.mn/?id=251605
- Зам тээврийн хөгжлийн яам (сургалт) http://mrtd.gov.mn/single/56/item/1010
- Иргэний нисэхийн ерөнхий газар ( Алсын жолоодлогот нисдэг төхөөрөмж) http://www.mcaa.gov.mn/wp-content/uploads/2016/05/63-wings-2015.pdf
- МХТС-ийн ахлах багш Ц.Тэнгис “Дрон тухай” ярилцлага, 2017-07-07 http://medee.mn/mobile.php?eid=94842
- Гадаад орны туршлага “Дроны зохицуулалт” Конгрессийн Эрхзүйн номын сан- “Regulation of Drones” The Law Library of Congress, Global Legal Research Center, 2016-*англиар* file://regulation-of-drones.pdf
- Дрон үйлдвэрлэлийн зах зээлийн өсөлтийн прогноз,2022он https://blog.dti.team/wp-content/uploads/2018/02/drones5.png

# 3
# БҮЛЭГ

## ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛ

# ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ АРД НИЙТИЙН САНАЛ АСУУЛГААР БАТАЛСНЫ ДАРАА АЛБАЖУУЛАХ, ХЭВЛЭН НИЙТЛЭХ, ХҮЧИН ТӨГӨЛДӨРТ ТООЦОХ ПРОЦЕССТОЙ ХОЛБООТОЙ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

(Харьцуулсан судалгаа)

*Г.Билгээ, Ц.Болормаа*
*Р.Оргилмаа*

## АГУУЛГА

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг ард нийтийн санал асуулгаар батасны дараа албажуулах, хэвлэн нийтлэх, хүчин төгөлдөрт тооцох процесстой холбоотой гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт:

1. **Киргиз Улс**
   а) Бүгд Найрамдах Киргиз Улсын Үндсэн хууль
   б) БНКУ-ын Ард нийтийн санал асуулгын тухай үндсэн хуульчилсан хууль
2. **Эстони Улс**
   а) Бүгд Найрамдах Эстони Улсын Үндсэн хууль
   б) БНЭУ-ын Ард нийтийн санал асуулгын тухай хууль
3. **Ирланд Улс**
   а) Бүгд Найрамдах Ирланд Улсын Үндсэн хууль
   б) БНИУ-ын Ард нийтийн санал асуулгын тухай хууль (1994)[419]
4. **Франц Улс**
   а) Бүгд Найрамдах Франц Улсын Үндсэн хууль
   б) БНФУ-ын Үндэсний Ассамблейн дэгийн тухай хууль
   в) БНФУ-ын Үндсэн хуулийн зөвлөлийн тухай хууль
5. **Өмнөд Солонгос Улс**
   а) Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндсэн хууль
   б) БНСУ-ын Ард нийтийн санал асуулгын тухай хууль

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

[419] Referendum Act, 1994. www.irishstatutebook.ie/eli/1994/act/12/enacted/en/print

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Төр, нийгэм, эдийн засаг, эрх зүйн системийн тогтвортой байдлыг хангах үүднээс Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хуульчлан тогтоосон тусгай дэгээр зохицуулдаг бөгөөд энэхүү зохицуулалт нь улс орон бүрт өөр өөрийн гэсэн онцлогтой байна.

Судалгаанд хамрагдсан 5 улсад Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг ард нийтийн санал асуулгаар эцэслэн баталсны дараа төрийн тэргүүн (Киргиз, Эстони, Ирланд, Өмнөд Солонгос), эсхүл үндсэн хуулийн шүүх (Франц) нь батламжлах (гарын үсэг зурах) буюу тунхаглан зарлаж байна.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль албан ёсоор хэвлэгдсэн өдрөөс (Киргиз), Сонгуулийн төв хороо ард нийтийн санал асуулгын дүнг хүлээн зөвшөөрснөөр (Өмнөд Солонгос), хуульд өөрт заасан хугацаанд (Ирланд), хууль тунхагласнаас хойш 3-аас доошгүй сарын дараа (Эстони) хүчин төгөлдөр үйлчилж эхлэхээр зохицуулсан бол Франц Улсад энэ хугацааг тодорхой заасан зохицуулалт олдоогүй болно. Үүнээс үзэхэд, улс орон бүр Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийг батламжлах, хүчинтэйд тооцох хугацаа, дэг харилцан адилгүй байгаа нь харагдаж байна.

**а) Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг ард нийтийн санал асуулгаар баталсаны дараа баталгаажуулах эрх бүхий субъектийн талаар:**

**Киргизийн** Ард нийтийн санал асуулгын тухай Үндсэн хуульчилсан хуулиар "**ард нийтийн санал асуулгаар батлагдсан шийдвэрт нэмэлт баталгаажуулалт шаардлагагүй**"-гээр бүх нийтээр дагаж мөрдөх бөгөөд Үндсэн хуульд зааснаар **Ерөнхийлөгч гарын үсэг зурна** (хугацаа заагаагүй). Тус улсын туршлагаас үзэхэд, 2016 оны 12 дугаар сарын 11-ны өдөр ард нийтийн санал асуулгаар Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хууль[420] батлагдсан бөгөөд энэ хуулийн 2 дугаар зүйлд заасны дагуу Ерөнхийлөгч нь уг хуульд гарын үсэг зурж, тунхагласан байна.

**Ирланд Улсын Ерөнхийлөгч** нь Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Үндсэн хуульд нийцсэн эсэх, ард нийтийн санал асуулга хуулийн дагуу явагдсан эсэхийг хянан үзсэний дараа **гарын үсэг зурж, нийтлүүлнэ**.

Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг **Өмнөд Солонгост Ерөнхийлөгч нь** нэгдсэн дүнг хүлээн авсан даруйдаа **батламжлах**, **Эстонид Ерөнхийлөгч нь** нэн даруй **тунхаглахыг** эдгээр улсын Үндсэн хууль, Ард нийтийн санал асуулгын тухай хуульд тус тус заасан байна.

**Франц Улсын** Үндсэн хуулийн зөвлөлийн тухай хуульд зааснаар **Үндсэн хуулийн зөвлөл** буюу Үндсэн хуулийн шүүх нь ард нийтийн санал асуулгаар дэмжигдсэн хуулийг **зарлигаар баталгаажуулахаар** (хугацаа заагаагүй) заасан байна.

**б) Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг ард нийтийн санал асуулгаар баталсаны дараа хүчин төгөлдөр үйлчилж эхлэх хугацааны талаар:**

**Эстонид** ард нийтийн санал асуулгаар батлагдсан Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хууль нь хуульд өөрт заасан хугацаанд хүчин төгөлдөр болох бөгөөд энэ хугацаа нь хуулийг тунхагласнаас хойш 3-аас доошгүй сар байхаар тус улсын Үндсэн хууль, Ард нийтийн санал асуулгын тухай хуульд тус тус заасан байна.

**Киргизид** ард нийтийн санал асуулгаар батлагдсан аливаа шийдвэр нь ард нийтийн санал асуулгын асуултын томьёололд тусгайлан заагаагүй бол **албан ёсоор хэвлэгдсэн өдрөөс** эхлэн хүчин төгөлдөр болно. Харин 2016 оны ард нийтийн санал асуулгаар батлагдсан Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн тухайд уг хуулийн 2 дугаар зүйлд хууль албан ёсоор хэвлэгдсэн өдрөөс хойш **15 хоногийн дараа хүчин төгөлдөр болохоор** заасан байсан.

---

[420] О внесении изменений в Конституцию Кыргызской Республики от 28 декабря 2016 года № 218.

**Өмнөд Солонгос**ын Үндсэн хуульд зааснаар Сонгуулийн төв хорооноос ард нийтийн санал асуулгын дүнг **хүлээн зөвшөөрснөөр** Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болно.

**Ирланд** болон **Францад** Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхлэх хугацааг тодорхой заагаагүй байна.

Ирландын хувьд ард нийтийн санал асуулгын урьдчилсан дүн гарсны дараа сонгуулийн хэсэгт томилогдсон эрх бүхий албан тушаалтан[421] ард нийтийн санал асуулгын дүнгийн тухай түр гэрчилгээ олгож, албан ёсны сонинд нийтэлнэ. Ийнхүү нийтэлснээс хойш 7 хоногийн дотор иргэдээс ард нийтийн санал асуулгын талаар Дээд шүүхэд гомдол гаргаж болох бөгөөд хэрэв гомдол гараагүй, эсхүл гомдлыг хэрэгсэхгүй болсон тохиолдолд ард нийтийн санал асуулгын тухай гэрчилгээг албан ёсны болгоно.

## СУДАЛГААНЫ ХЭСЭГ

## ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ АРД НИЙТИЙН САНАЛ АСУУЛГААР БАТАЛСНЫ ДАРАА АЛБАЖУУЛАХ, ХЭВЛЭН НИЙТЛЭХ, ХҮЧИН ТӨГӨЛДӨРТ ТООЦОХ ПРОЦЕССТОЙ ХОЛБООТОЙ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Судалгаанд Эстони, Киргиз, Ирланд, Франц, Өмнөд Солонгос зэрэг орнуудыг хамруулсан бөгөөд эдгээр орнуудад Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг ард нийтийн санал асуулгаар батлахтай холбоотой харилцааг дор дурдсан хуулиудаар зохицуулж байна. Үүнд:

1. Киргиз:
   - Үндсэн хууль[422];
   - Ард нийтийн санал асуулгын тухай Үндсэн хуульчилсан хууль[423];
2. Эстони:
   - Үндсэн хууль[424];
   - Ард нийтийн санал асуулгын тухай хууль[425];
3. Ирланд:
   - Үндсэн хууль[426];
   - Ард нийтийн санал асуулгын тухай хууль, 1994[427];
4. Франц:
   - Үндсэн хууль[428];
   - Үндэсний Ассамблейн дэгийн тухай хууль[429];
   - Үндсэн хуулийн зөвлөлийн тухай хууль[430];
5. Өмнөд Солонгос:
   - Үндсэн хууль[431];
   - Ард нийтийн санал асуулгын тухай хууль[432];
   - Ард нийтийн санал асуулгын тухай хуулийг хэрэгжүүлэх журам[433];
   - Үндэсний Ассамблейн тухай хууль[434].

---

[421] Сонгуулийн хэсэгт томилогдсон эрх бүхий албан тушаалтан - ард нийтийн санал асуулгын үед сонгуулийн хэсэгт томилогдон ажиллах эрх бүхий албан тушаалтан (1994 оны Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн 15 дугаар зүйл).
[422] Конституция Кыргызской Республики. http://cbd.minjust.gov.kg/act/view/ru-ru/202913?cl=ru-ru
[423] Конституционный закон Кыргызской Республикиот 31 октября 2016 года № 173О референдуме Кыргызской Республики. http://cbd.minjust.gov.kg/act/view/ru-ru/111452
[424] Конституция Эстонской Республики. Принята 28 июня 1992 года. Вступила в силу 3 июля 1992 года. https://www.president.ee/ru/republic-of-estonia/constitution-of-the-republic-of-estonia/index.html
[425] Закон о референдуме (Всенародном голосовании). Принят 13 марта 2002 года. http://estonia.news-city.info/docs/sistemsw/dok_iegdao/page3.htm
[426] Constitution of Ireland. www.irishstatutebook.ie/eli/cons/en
[427] Referendum Act, 1994. www.irishstatutebook.ie/eli/1994/act/12/enacted/en/print
[428] Constitution of the French Republic. www.constituteproject.org/constitution/France_2008?lang=en
[429] Rules of Procedure of the National Assembly www.legislationline.org/download/action/download/id/2084/file/France_Rules_Procedure_NationalAssembly_2007htm/preview
[430] Institutional Act on the Constitutional Council. www.conseil-constitutionnel.fr/conseil-constitutionnel/root/bank_mm/anglais/texts.pdf
[431] Constitution of the Republic of Korea. www.constituteproject.org/constitution/Republic_of_Korea_1987?lang=en
[432] Referendum Act. https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=39981&lang=ENG
[433] Enforcement Decree of the Referendum Act. https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=44781&lang=ENG
[434] National Assembly Act. https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=44198&lang=ENG

## 1.КИРГИЗ УЛС

**а) Үндсэн хууль:**

**9 дүгээр бүлэг. Үндсэн хуульд өөрчлөлт оруулах журам**

114.1.Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг Жогорку Кенеш (Парламент)-ээс тогтоосноор ард нийтийн санал асуулгаар баталж болно.

114.2.Парламентын төлөөлөгчдийн олонхын саналаар, эсхүл 300 мянган сонгогчдын санаачилснаар Үндсэн хуулийн 3, 4, 5, 6, 7, 8 дугаар бүлгийн заалтуудад өөрчлөлт оруулна.

114.3.Парламент нь Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн барьсан өдрөөс хойш 6 сарын дотор батална.

Парламент нь Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 3-аас доошгүй удаа хэлэлцэх ба хэлэлцүүлэг хооронд завсарлах хугацаа 2 сар байна. Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Парламентын нийт төлөөлөгчдийн 2/3-оос доошгүйн олонхын саналаар батална.

Парламентын нийт төлөөлөгчдийн 2/3-оос доошгүйн санаачилж Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг ард нийтийн санал асуулгаар оруулна.

114.5.Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд Ерөнхийлөгч гарын үсэг зурна.

**б) Ард нийтийн санал асуулгын тухай Үндсэн хуульчилсан хууль:**

7.1.Ард нийтийн санал асуулгыг Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, үндсэн хуульчилсан хууль болон бусад хуулийн төслүүд, мөн улс орны бусад чухал асуудлаар явуулна.

31.3.Санал асуулгын хуудсанд ард нийтийн санал асуулгаар оруулж байгаа асуудлын текст, “зөвшөөрнө”, “татгалзана” гэсэн хариултын хувилбарыг заах ба түүний доор хоосон дөрвөлжин байрлуулна.

Хэрэв ард нийтийн санал асуулгад өөр хувилбарын асуулт орох бол “Бүх хувилбараас татгалзана” гэсэн санал илэрхийлэх хувилбарыг заана. Хувилбар бүрийн баруун талд хоосон дөрвөлжин байрлуулах ба энэ тохиолдолд ард нийтийн санал асуулгад оролцогч нь зөвхөн нэг хувилбарыг сонгох эрхтэй.

Хэрэв ард нийтийн санал асуулгаар хэд хэдэн асуулт орох бол санал асуулгын хуудас тус бүрт нэг асуулт оруулна. Санал асуулгын хуудсанд мөн “Бүх хувилбараас татгалзана” гэсэн санал илэрхийлэх хувилбарыг заана. Асуулт бүрийн баруун талд хоосон дөрвөлжин байрлуулах ба энэ тохиодолд ард нийтийн санал асуулгад оролцогч нь бусад асуултуудын хариултаас үл хамааран асуулт бүрт хариулна.

37.1.Сонгуулийн төв хороо нь ард нийтийн санал асуулга явуулсан өдрөөс хойш 35 хоногийн дотор орон нутгийн сонгуулийн хороодоос ирүүлсэн санал асуулгын дүнг нэгтгэнэ.

Сонгуулийн төв хороо нэгдсэн дүнгийн хурал заавал хийх ба хурлаар ард нийтийн санал асуулгыг бэлтгэх, зохион байгуулах явцад гарсан зөрчлийн талаар хүлээн авсан бүх өргөдөл (гомдол)-ийг хэлэлцэж, өргөдөл (гомдол) тус бүрээр шийдвэр гаргана.

37.3.Жагсаалтад бүртгэгдсэн оролцогчдын 30-аас дээш хувь нь ард нийтийн санал асуулгад оролцсон тохиолдолд Сонгуулийн төв хорооноос ард нийтийн санал асуулгыг хүчинтэйд тооцно.

Хэрэв ард нийтийн санал асуулгад оролцогсдын талаас дээш хувь нь асуултыг дэмжсэн бол батлагдсанд тооцно.

Хэрэв хариултын хувилбаруудын аль нь ч ард нийтийн санал асуулгад оролцогчдын талаас дээш хувийн санал аваагүй бол Сонгуулийн төв хороо нь ард нийтийн санал асуулгад оролцогсдын хамгийн олон санал авсан хариултын хувилбарыг хүлээн зөвшөөрнө.

Хэрэв ард нийтийн санал асуулгад оролцогчдын талаас дээш хувь нь хариултын бүх хувилбараас татгалзсан бол Сонгуулийн төв хороо нь ард нийтийн санал асуулгаар орсон бүх асуултаас татгалзсанд тооцно.

39.1.Сонгуулийн ерөнхий хороо нь хэсгүүдээс ирсэн саналын дүнг Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудсанд нэн даруй байршуулна.

Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудсанд байршуулсан саналын дүн нь урьдчилсан дүн бөгөөд эрх зүйн үр дагавар агуулаагүй болно.

39.2.Сонгуулийн ерөнхий хороо нь ард нийтийн санал асуулгын дүнг гаргаснаас хойш нэг өдрийн дотор ард нийтийн санал асуулгын нэгдсэн дүнг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтэлнэ.

39.3.Сонгуулийн ерөнхий хороо нь ард нийтийн санал асуулгын нэгдсэн дүнг гаргасан өдрөөс хойш 14 хоногийн дотор ард нийтийн санал асуулгын дүн, ард нийтийн санал асуулгын асуултад “зөвшөөрнө”, “татгалзана” гэж санал өгсөн оролцогчдын дүнг албан ёсоор хэвлүүлнэ.

39.5.Ард нийтийн санал асуулгаар батлагдсан шийдвэр нь ард нийтийн санал асуулгын асуултын томьёололд заагаагүй бол албан ёсоор хэвлэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

40.1.Ард нийтийн санал асуулгаар батлагдсан шийдвэрт нэмэлт баталгаажуулалт шаардлагагүй бөгөөд бүх нийтээр заавал дагаж мөрдөнө, Бүгд Найрамдах Киргиз Улсын нийт нутаг дэвсгэрт үйлчилнэ.

## <u>2.ЭСТОНИ УЛС</u>

### а) Үндсэн хууль:

105.Рийгикогу (Парламент) нь улс орны амьдралд хамаарах хуулийн төсөл, эсхүл бусад асуудлыг ард нийтийн санал асуулгаар батлуулах эрхтэй.

Санал асуулгад оролцогчдын олонхын саналаар иргэдийн шийдвэр гарна.

Ард түмний санал асуулгаар батлагдсан хуулийг Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нэн даруй тунхаглана. Ард нийтийн санал асуулгын дүнг төрийн байгууллагууд заавал биелүүлнэ.

Хэрэв ард нийтийн санал асуулгаар оруулсан хуулийн төсөлд “тийм” гэж олонх санал өгөөгүй бол Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь Парламентын ээлжит бус сонгуулийг зарлана.

162.Үндсэн хуулийн “Нийтлэг үндэслэл” гэсэн 1 дүгээр бүлэг, “Үндсэн хуульд өөрчлөлт оруулах” гэсэн 15 дугаар бүлэгт зөвхөн ард нийтийн санал асуулгаар нэмэлт, өөрчлөлт оруулна.

163.Дараах журмаар батлагдсан хуулиар Үндсэн хуульд өөрчлөлт оруулна:

1) ард нийтийн санал асуулгаар;

2) Парламентын дараалсан 2 бүрэн эрхийн бүрэлдэхүүнээр;

3) Парламент нэн яаралтай дэгээр.

Үндсэн хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн хэлэлцүүлгийг 3 үе шаттай хэлэлцэнэ. Ингэхдээ хуулийн төслийн анхны болон хоёр дахь хэлэлцүүлэг хооронд завсарлах хугацаа 3-аас доошгүй сар, хоёр дахь болон эцсийн хэлэлцүүлэг хооронд завсарлах хугацаа 1-ээс доошгүй сар байна. Үндсэн хуульд өөрчлөлт оруулах хуулийг эцсийн хэлэлцүүлгээр шийдвэрлэнэ.

164.Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг ард нийтийн санал асуулгаар оруулахад Парламентын бүрэлдэхүүний 2/3-ын саналаар шийдвэрлэнэ. Парламент ийнхүү шийдвэрлэсэн өдрөөс хойш 3-аас доошгүй сарын дараа ард нийтийн санал асуулгыг явуулна.

167.Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг тунхаглах ба хуульд өөрт заасан хугацаанд хүчин төгөлдөр болох бөгөөд энэ хугацаа нь хуулийг тунхагласнаас хойш 3-аас доошгүй сарын дараа байна.

**б) Ард нийтийн санал асуулгын тухай хууль:**

1.1.Парламентын шийдвэрээр Үндсэн хуулийн 1, 15 дугаар бүлэгт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг ард нийтийн санал асуулгаар оруулна.

30.1.Хэрэв ард нийтийн санал асуулгаар хуулийн төслийг оруулах бол санал асуулгын хуудсанд хуулийн төслийн нэр, эсхүл Парламентын шийдвэрээр хуулийн төсөл, “Та хуулийн төслийг батлах уу?” гэсэн асуулт болон дараагийн мөрөнд “тийм”, эсхүл “үгүй” гэсэн хариултын хувилбарыг бичнэ.

63.1.Сонгуулийн хороо нь ард нийтийн санал асуулгын дүнг олон нийтэд зарласан өдөр ард нийтийн санал асуулгаар батлагдсан хууль болон ард нийтийн санал асуулгын дүнг Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчид танилцуулна. Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь хуулийг нэн даруй тунхаглана.

63.2.Ард нийтийн санал асуулгаар батлагдсан Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хууль нь хуульд өөрт заасан хугацаанд хүчин төгөлдөр болох бөгөөд энэ хугацаа нь хуулийг тунхагласнаас хойш 3-аас доошгүй сарын дараа байна.

64.Хэрэв ард нийтийн санал асуулгаар оруулсан хуулийн төсөлд “тийм” гэж олонх санал өгөөгүй бол Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь ард нийтийн санал явуулах тухай шийдвэр гаргасан Парламентын бүрэн эрх дуусаагүй тохиолдолд Парламентын сонгуулийн тухай хуульд заасан журмын дагуу Парламентын ээлжит бус сонгуулийг зарлана.

## 3.ИРЛАНД

**а) Үндсэн хууль:**

46.1.Үндсэн хуульд өөрчлөлт, эсхүл нэмэлт, эсхүл зарим зүйл, заалтыг хүчингүй болгох замаар өөрчлөлт оруулах бол энэ зүйлд заасан журмыг баримтална.

46.2.Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай бүх саналыг Төлөөлөгчдийн Танхимд хуулийн төсөл хэлбэрээр өргөн баригдах бөгөөд Парламентын хоёр танхимаар батлагдсан, эсхүл батлагдсанд тооцсон гэж үзвэл ард нийтийн санал асуулгын тухай хууль тогтоомжийн дагуу ард нийтийн санал асуулгаар оруулж ард түмнээр батлуулна.

46.3.Ийм хуулийн төслийг “Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай” гэж нэрлэнэ.

46.4.Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд бусад аливаа агуулагыг оруулахгүй.

46.5.Ерөнхийлөгч нь Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Үндсэн хуулийн энэ зүйлд заасан журмыг хангасан эсэх, хуулийн төслийг Үндсэн хуулийн 47 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу ард түмнээс баталсан эсэхийг хянан үзсэн даруйдаа хуулд гарын үсэг зурна. Үүний дараа Ерөнхийлөгч Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг нийтлүүлнэ.

47.1.Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг ард түмнээр батлуулахын тулд ард нийтийн санал асуулгаар оруулна. Ард нийтийн санал асуулгаад оролцогсдын олонх Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дэмжсэн бол Үндсэн хуулийн 46 дугаар зүйлд заасны дагуу ард түмэн баталсанд тооцно.

**б) Ард нийтийн санал асуулгын тухай хууль (1994)[435]:**

40.1.Сонгуулийн хэсэгт томилогдсон эрх бүхий албан тушаалтан[436] нь орон нутгийн бүх хэсгүүдээс энэ хуулийн 37 дугаар зүйлд заасан тайланг хүлээн авч нэгдсэн тайлан гаргах бөгөөд ард нийтийн санал асуулгын дүнгийн тухай түр гэрчилгээ олгоно.

---

[435] Referendum Act, 1994. www.irishstatutebook.ie/eli/1994/act/12/enacted/en/print

[436] Сонгуулийн хэсэгт томилогдсон эрх бүхий албан тушаалтан - ард нийтийн санал асуулгын үед сонгуулийн

40.2.Сонгуулийн хэсэгт томилогдсон эрх бүхий албан тушаалтан нь ард нийтийн санал асуулгын дүнгийн тухай түр гэрчилгээ олгосны дараа түр гэрчилгээний хуулбарыг Iris Oifigiuil[437] сонинд нийтлүүлнэ.

40.3.Дээд шүүх ард нийтийн санал асуулгын дүнгийн тухай түр гэрчилгээг албан ёсны болгосны дараа сонгуулийн хэсэгт томилогдсон эрх бүхий албан тушаалтан нь гэрчилгээг батламжлах бөгөөд гэрчилгээний хуулбарыг Ерөнхийлөгч болон Taoiseach-д хүргүүлнэ.[438]

41.Дээд шүүхийн мастер[439] нь энэ хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу ард нийтийн санал асуулгын талаар гомдол гарсан эсэх талаар сонгуулийн хэсгийн эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэнэ.

42.1.Ард нийтийн санал асуулгын дүнгийн тухай түр гэрчилгээний талаар Дээд шүүхэд энэ хуулийн дагуу гомдол гаргаж болно.

42.2.Дээд шүүхэд ард нийтийн санал асуулгын дүнгийн талаарх гомдлыг Ард нийтийн санал асуулгын тухай гэрчилгээг Iris Oifigiuil сонинд нийтэлснээс хойш 7 хоногийн дотор гаргана.

## 4.ФРАНЦ УЛС

### а) Үндсэн хууль:

42.3.Засгийн газар болон парламентын гишүүдийн санаачилсан хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг харьяалах танхимд хэлэлцүүлэхээр хуваарилснаас хойш 6 долоо хоногийн дараа хийнэ. Хуулийн төслийг өөр танхимаар хэлэлцүүлэхээр шилжүүлснээс хойш 4 долоо хоногийн дараа хэлэлцэнэ.

89. Парламентын гишүүд болон Ерөнхий сайдын санал болгосноор Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл санаачлах эрхтэй.

Засгийн газар болон парламентын гишүүдийн санаачилсан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг энэ хуулийн 42 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан хугацаанд хоёр танхимаар хэлэлцэн батална. Төсөл нь ард нийтийн санал асуулгаар дэмжигдэн эцэслэгдэнэ.

Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь Засгийн газраас санаачилсан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг Конгрессын (хамтарсан) хуралдаанаар хэлэлцүүлэхээр шилжүүлсэн бол санал өгсөн гишүүдийн 3/5-ын саналаар дэмжигдсэнд тооцогдоно. Энэ тохиолдолд ард нийтийн санал асуулга явуулахгүй. Конгрессын товчооны үүргийг Үндэсний Ассамблей гүйцэтгэнэ.

### б) Үндэсний ассамблейн дэгийн тухай хууль:

**X хэсэг. Ард нийтийн санал асуулга явуулахыг санаачлах**

126.1.Засгийн газар болон Үндэсний Ассамблейн гишүүдийн санаачилсан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Үндсэн хуулийн 89 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу бусад хуулийн төслүүдийн адил хэлэлцэж санал өгнө.

126.2.Үндэсний Ассамблей нь хуулийн төслийг Сенатаар батлах журмын дагуу

---

хэсэгт томилогдон ажиллах эрх бүхий албан тушаалтан (1994 оны Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн 15 дугаар зүйл).

437 Iris Oifigiuil (Official Journal) – Ирландын Засгийн газрын албан ёсны сонин.

438The Department of the Taoiseach (Irish: *Roinn an Taoisigh*) is the government department of the Taoiseach [1] of Ireland. It is based in Government Buildings, the headquarters of the Government of Ireland, on Merrion Street in Dublin.

Министерство Премьер-министра Ирландии (ирл. *Roinn an Taoisigh*) — министерство созданное в составе Правительства Ирландии, которое обеспечивает деятельность главы исполнительной власти Республики Ирландия - ирл. *Taoiseach*.[1]

439 Дээд Шүүхийн мастер нь Ирландын тойргийн шүүхийн нарийн бичгийн даргатай адил чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд иргэний хэргээр захиргааны шинжтэй асуудал шийдвэрлэх эрх мэдэлтэй байдаг. Эх сурвалж: https://lauraonlaw.wordpress.com/2012/09/26/structure-function-jurisdiction-of-the-high-court-of-ireland/

баталсан тохиолдолд хуулийн төслийг Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчид шилжүүлнэ.

**в) Үндсэн хуулийн зөвлөлийн тухай хууль:**

49.Үндсэн хуулийн зөвлөл нь ард нийтийн санал асуулгын ерөнхий дүнд хяналт тавьж ажиллана.

51.Үндсэн хуулийн зөвлөл нь ард нийтийн санал асуулгын дүнг олон нийтэд зарлана. Үндсэн хуулийн зөвлөл нь ард нийтийн санал асуулгаар дэмжигдсэн хуулийг зарлигаар баталгаажуулна.

## 5.ӨМНӨД СОЛОНГОС

**а) Үндсэн хууль:**

**10 дугаар бүлэг. Үндсэн хуулийн өөрчлөлт**

128.1.Үндэсний Ассамблейн нийт гишүүдийн олонх, эсхүл Ерөнхийлөгч Үндсэн хуульд өөрчлөлт оруулахыг санаачилна.

129.Ерөнхийлөгчийн Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг 20 болон түүнээс дээш хоногийн хугацаагаар хэвлэн нийтэлнэ.

130.1.Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийг нийтэд зарласнаас хойш 60 хоногийн дотор Үндэсний Ассемблейгаар хэлэлцэх эсэхийг хэлэлцэж, Үндэсний Ассемблейн нийт гишүүдийн 2/3-ын саналаар шийдвэрлэнэ.

130.2.Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг Үндэсний Ассемблейгаар хэлэлцэн шийдвэрлэснээс хойш 30 хоногийн дотор ард нийтийн санал асуулга явуулна. Санал асуулгын дүнг Үндэсний Ассамблейн сонгуульд оролцох эрх бүхий сонгогчдын олонхын саналаар батална.

130.3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу санал асуулгын дүнг хүлээн зөвшөөрснөөр Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болж, Ерөнхийлөгч нэн даруй батламжилна.

**б) Ард нийтийн санал асуулгын тухай хууль:**

**IX бүлэг Санал асуулгын эцсийн дүн**

87 дугаар зүйл (Дүнг нэгтгэх)

1.Сонгуулийн төв хороо нь Хот (болон хөдөө орон нутгийн) сонгуулийн хороодоос ирүүлсэн дүнг хүлээн авч санал асуулгад оролцох иргэдийн тоо, оролцсон иргэдийн тоо, дэмжсэн болон эсэргүүцсэн, түүнчлэн хүчингүй саналын дүнг нэн даруй нэгтгэн гаргана.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар дүнг нэгтгэн гаргахад Сонгуулийн төв хорооны гишүүдийн ихэнх нь байлцах шаардлагатай.

89 дүгээр зүйл (Нэгдсэн дүнг хэвлэх болон мэдэгдэх)

Сонгуулийн төв хороо нь 87 дугаар зүйлд заасны дагуу санал асуулгын дүнг нэгтгэсний дараа хэвлэн нийтэлж, Ерөнхийлөгч болон Үндэсний Ассамблейн даргад мэдэгдэнэ.

91 дүгээр зүйл (Эцсийн дүнг батламжлах)

Ерөнхийлөгч нь энэ хуулийн 89, 90 дүгээр зүйлд заасны дагуу ард нийтийн санал асуулгын нэгдсэн дүнг хүлээн авсан даруйдаа батламжилна.

**АШИГЛАСАН МАТЕРИАЛ**


- Referendum Act, 1994. www.irishstatutebook.ie/eli/1994/act/12/enacted/en/print
- О внесении изменений в Конституцию Кыргызской Республики от 28 декабря 2016 года № 218.
- Конституция Кыргызской Республики. http://cbd.minjust.gov.kg/act/view/ru-ru/202913?cl=ru-ru
- Конституционный закон Кыргызской Республикиот 31 октября 2016 года № 173О референдуме Кыргызской Республики. http://cbd.minjust.gov.kg/act/view/ru-ru/111452
- Конституция Эстонской Республики. Принята 28 июня 1992 года. Вступила в силу 3 июля 1992 года. https://www.president.ee/ru/republic-of-estonia/constitution-of-the-republic-of-estonia/index.html
- Закон о референдуме (Всенародном голосовании). Принят 13 марта 2002 года. http://estonia.news-city.info/docs/sistemsw/dok_iegdao/page3.htm
- Constitution of Ireland. www.irishstatutebook.ie/eli/cons/en
- Referendum Act, 1994. www.irishstatutebook.ie/eli/1994/act/12/enacted/en/print
- Constitution of the French Republic. www.constituteproject.org/constitution/France_2008?lang=en
- Rules of Procedure of the National Assembly www.legislationline.org/download/action/download/id/2084/file/France_Rules_Procedure_NationalAssembly_2007htm/preview
- Institutional Act on the Constitutional Council. www.conseil-constitutionnel.fr/conseil-constitutionnel/root/bank_mm/anglais/texts.pdf
- Constitution of the Republic of Korea. www.constituteproject.org/constitution/Republic_of_Korea_1987?lang=en
- Referendum Act. https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=39981&lang=ENG
- Enforcement Decree of the Referendum Act. https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=44781&lang=ENG
- National Assembly Act. https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=44198&lang=ENG
- Referendum Act, 1994. www.irishstatutebook.ie/eli/1994/act/12/enacted/en/print
- Iris Oifigiuil (Official Journal) – Ирландын Засгийн газрын албан ёсны сонин.
- The Department of the Taoiseach (Irish: *Roinn an Taoisigh*) is the government department of the Taoiseach [1] of Ireland. It is based in Government Buildings, the headquarters of the Government of Ireland, on Merrion Street in Dublin.
- Министерство Премьер-министра Ирландии (ирл. *Roinn an Taoisigh*) — министерство созданное в составе Правительства Ирландии, которое обеспечивает деятельность главы исполнительной власти Республики Ирландия - ирл. *Taoiseach*.[1]

# ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ ДАХЬ УЛС ТӨРИЙН НАМ БА НАМЫН САНХҮҮЖИЛТИЙН ТАЛААРХ ЗОХИЦУУЛАЛТ

(Харьцуулсан судалгаа)

*Ц.Болормаа, Г.Билгээ*

## АГУУЛГА

Нэг. **Улс төрийн намын талаарх Үндсэн хуулийн зохицуулалт**

1.1. Улс төрийн нам байгуулах тухай зарим улсын Үндсэн хуулийн зохицуулалт

1.2. Улс төрийн намд тавих хязгаарлалтын тухай зарим улсын Үндсэн хуулийн зохицуулалт

1.3. Улс төрийн намын хариуцлагын тухай зарим улсын Үндсэн хуулийн зохицуулалт

1.4. Улс төрийн намд хориглосон үйл ажиллагааны тухай зарим улсын Үндсэн хуулийн зохицуулалт

Хоёр. **Улс төрийн намын санхүүжилт**

2.1. Төрөөс санхүүжих

2.2. Хувийн хандивлагчдаас санхүүжих

2.3. Төр болон хувийн хосолсон хувилбараар санхүүжих

2.4. Хувиараа хандивлагчдад зарцуулалтын талаар нээлттэй тайлагнах

2.5. Зарцуулах журам

2.6. Зарцуулалтын нээлттэй тайлан

2.7. Хууль сахиулах, албан шаардлага

2.8. Хэвлэл мэдээллийн хэрэгсэллээр мэдээлэл түгээх

## НЭГ. УЛС ТӨРИЙН НАМЫН ТАЛААРХ ҮНДСЭН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэхдээ Техасын Их Сургууль, Чикагогийн Их Сургууль, Лондонгийн Их Сургууль, АНУ-ын Энх тайвны институтаас хамтран хэрэгжүүлсэн төслийн хүрээнд бий болгосон олон улсын Үндсэн хуулийн нэгдсэн сан буюу www.constituteproject.org цахим хуудас дахь эх сурвалжийг ашиглав.

Тус цахим хуудаст байршуулсан 192 орны Үндсэн хуульд улс төрийн намын талаар зохицуулсан эсэх, хэрэв зохицуулсан бол хэрхэн зохицуулсныг түүвэрлэн үзэхэд:

1. улс төрийн нам байгуулах тухай зохицуулсан - 121 улс;
2. улс төрийн намд тавих хязгаарлалтын тухай зохицуулсан - 94 улс;
3. улс төрийн намын хариуцлагын тухай зохицуулсан - 38 улс;
4. улс төрийн намд хориглох үйл ажиллагааны тухай зохицуулсан - 57 улс байна.

192 улсаас 86 улсын[440] Үндсэн хуульд хүнийг “улс төр”-ийн үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байхыг тодорхой заасан байна. Мөн дээрх улс орнуудаас 5 нь “нам төвтэй” улс байх бөгөөд эдгээр нь Хятад, Конго, Куба, БНАСАУ, Вьетнам зэрэг улс орнууд байна.

Хамрагдах улс орнуудыг дээр дурдсан 4 ангиллаар дараах хүснэгтэд харуулав.

[440] Азербайжан, Албани, Антигуа Барбуда, Армени, Багамын арлууд, Барбадос, Белиз, Бенин, Болгар, Боливи, Босни-Герцеговин, Ботсвана, Буркина Фасо, Вьетнам, Гамби, Гвиана, Гвиней, Герман, Грек, Гренада, Гүрж, Доминика, Доминикан, Египет, Замби, Зимбабве, Их Британи (ИБУИНВУ), Кабо Верде, Камбож, Кипр, Кирибати, Колумби, Конго (Бүгд Найрамдах Ардчилсан), Косово, Лесото, Либер, Ливи, Маврикий, Мадагасгар, Македон, Малави, Мали, Мальдив, Мальта, Маршалын арлууд, Мозамбик, Молдав, **Монгол**, Науру, Нигер, Нигери, Нидерланд, Өмнөд Судан, Панам, Папуа Шинэ Гвиней, Парагвай, Португал, Руанда, Румын, Самоа, Сан-Томе Принсили, Сент-Висент ба Гренадин, Сент-Луис, Словак, Словени, Соломоны арлууд, Сомали, Судан, Таджикистан, Тайвань, Тайланд, Того, Тувалу, Турк, Туркменистан, Украин, Унгар, Хорват, Чад, Чех, Швейцар, Шинэ Зеланд, Шри Ланк, Эквадор, Эстони, Ямайка.

*Хүснэгт 1. Үндсэн хуульд улс төрийн намын талаарх зохицуулалт*

| № | ***Үндсэн хуулийн зохицуулалтын агуулга, улсын тоо*** | ***Улсын нэр*** |
|---|---|---|
| 1. | Улс төрийн нам байгуулах тухай зохицуулсан - 121 улс | Азербайжан, Албани, Алжир, Ангол, Андорра, Аргентин, Армени, Афганистан, Багамын арлууд, Барбадос, Белиз, Бенин, Болгар, Боливи, Бразил, Буркина Фасо, Бурунди, Бутан, Вануату, Венесуэль, Габон, Гаити, Гамби, Гана, Гватемал, Гвиана, Гвиней, Гвиней-Бисау, Герман, Гондурас, Грек, Гүрж, Доминикан, Египет, Жибути, Замби, Зимбабве, Зүүн Тимор, Ирак, Иран, Испани, Итали, Йемен, Йордан, Кабо Верде, Камбож, Кени, Киргиз, Колумби, Коморос, Конго (Бүгд Найрамдах Ардчилсан), Коста-Рика, Кот д'Ивуар, Латви, Либер, Ливи, Литва, Мавритани, Мадагасгар, Македон, Малави, Мали, Мальдив, Марокко, Мексик, Мозамбик, Молдав, Монгол, Монтенегро, Мьянмар, Намиби, Непал, Нигер, Нигери, Никарагуа, Норвег, Өмнөд Африк, Өмнөд Солонгос (БНСУ), Өмнөд Судан, Пакистан, Папуа Шинэ Гвиней, Парагвай, Перу, Польш, Португал, Руанда, Румын, Сальвадор, Сан-Томе Принсили, Сейшелийн арлууд, Сент-Китс ба Невис, Сент-Луис, Серби, Сири, Словак, Соломоны арлууд, Сомали, Судан, Суринам, Сьерра-Леоне, Тажикистан, Тайланд, Танзани, Того, Тувалу, Тунис, Турк, Туркменистан, Уганда, Узбекистан, Украин, Унгар, Фижийн арлууд, Франц, Хорват, Чад, Чех, Эквадор, Экваторын Гвиней, Эстони, Этиоп |
| 2. | Улс төрийн намд тавих хязгаарлалтын тухай зохицуулсан - 94 улс | Албани, Алжир, Ангол, Аргентин, Армени, Афганистан, Болгар, Боливи, Бразил, Бурунди, Бутан, Габон, Гаити, Гамби, Гана, Гвиана, Гвиней, Гвиней-Бисау, Герман, Гондурас, Гүрж, Доминиканhttps://www.constituteproject.org/constitution/Dominican_Republic_2015?lang=en, Египет, Жибути, Зимбабве, Ирак, Иран, Испани, Йемен, Йордан, Кабо Верде, Казахстан, Камерун, Кени, Кипр, Киргиз, Колумбиhttps://www.constituteproject.org/constitution/Colombia_2015?lang=en, Коморос, Конго (Бүгд Найрамдах Ардчилсан), Коста-Рика, Кот д'Ивуар, Либер, Ливи, Литва, Маврикий, Мавритани, Македон, Марокко, Мексик, Мозамбик, Монгол, Монтенегро, Мьянмар, Непал, Нигери, Никарагуа, Өмнөд Солонгос (БНСУ), Өмнөд Судан, Папуа Шинэ Гвиней, Парагвай, Перу, Португал, Руанда, Румын, Сальвадор, Сан-Томе Принсили, Сейшелийн арлууд, Сенегал, Серби, Сири, Словак, Сомали, Судан, Сьерра-Леоне, Тажикистан, Тайланд, Танзани, Того, Тунис, Турк, Туркменистан, Уганда, Узбекистан, Украин, Унгар, Фижийн арлууд, Филиппин, Франц, Хорват, Чех, Чили, Эквадор, Экваторын Гвиней, Этиоп |
| 3. | Улс төрийн намын хариуцлагын тухай зохицуулсан - 38 улс | Албани, Армени, Болгар, Буркина Фасо, Бутан, Гамби, Гвиана, Герман, Гүрж, Египет, Жибути, Кабо Верде, Колумби, Либер, Македон, Марокко, Мексик, Молдав, Монтенегро, Мьянмар, Никарагуа, Өмнөд Солонгос (БНСУ), Пакистан, Польш, Руанда, Румын, Словак, Словени, Сьерра-Леоне, https://www.constituteproject.org/constitution/Sri_Lanka_2015?lang=enТайван, Танзани, Турк, Узбекистан, Филиппин, Хорват, Чили, Шри Ланк, Эстони |
| 4. | Улс төрийн намд хориглосон үйл ажиллагааг зохицуулсан - 57 улс | Албани, Алжир, Ангол, Армени, Афганистан, Беларусь, Белиз, Болгар, Буркина Фасо, Бутан, Габон, Гамби, Гвиней-Бисау, Герман, Гүрж, Египет, Жибути, Ирак, Итали, Кабо Верде, Кени, Киргиз, Кот д'Ивуар, Либер, Ливи, Мавритани, Мадагасгар, Македон, Марокко, Мексик, Молдав, Монтенегро, Мьянмар, Непал, Нигерhttps://www.constituteproject.org/constitution/Niger_2010?lang=en, Өмнөд Солонгос (БНСУ), Пакистан, Панамhttps://www.constituteproject.org/constitution/Panama_2004?lang=en, Польш, Руанда, Румын, Сенегал, Серби, Сири, Сьерра-Леоне, Таджикистан, Тайван, Танзани, Туркменистан, Узбекистан, Украин, Филиппин, Хорват, Чили, Шри Ланк, Экваторын Гвиней, Эстони |

## 1.1.Улс төрийн нам байгуулах тухай гадаадын зарим улсын Үндсэн хуулийн зохицуулалт

Улс төрийн нам байгуулах тухай асуудлыг Үндсэн хуульдаа тусгасан 121 улс байна. Эдгээр улсуудын улс төрийн нам байгуулах тухай Үндсэн хуулийн зохицуулалтыг нэгтгэн үзвэл, иргэд сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж улс төрийн нам (эсхүл улс төрийн байгууллага)-ыг чөлөөтэй байгуулах эрхтэй байна. Ингэхдээ улс орнуудын Үндсэн хуульд дараах онцлог зохицуулалтууд тусгагдсан байна. Үүнд:

- төрөөс намын үйл ажиллагааны эрх чөлөөг хангах;
- намын зорилго нь Үндсэн хууль болон бусад хуульд нийцсэн байх;
- нам нь төрийн эрх мэдлийг шууд хэрэгжүүлэхгүй, төрийн эрх мэдлийг хяналтандаа байлгахыг хориглоно;
- намын үйл ажиллагаа нь үндэсний эрх ашигт нийцсэн байх;
- нам нь иргэдийн улс төрийн хүсэл зоригийг төлөвшүүлэх, илэрхийлэхэд оролцох;
- нам нь үндэсний тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хууль дээдлэх ёс болон ардчилалын зарчмуудад тулгуурлах;
- намын хөрөнгө, санхүүжилт, тэдгээрийн эх үүсвэр, олон нийтээс авах хандивын хэмжээг нийтэд мэдээллэх үүрэгтэй байх;
- нам нь улс төрийн олон ургалч үзлийг илэрхийлэх;
- хэнийг ч албан хүчээр намын гишүүн болгохгүй байх;
- намын нэр нь аливаа шашин шүтлэг, сүм хийдийн бэлгэдлийг агуулахгүй байх гэх мэт онцлог шинжийг агуулж байна.

*Хүснэгт 2. Улс төрийн нам байгуулах тухай зохицуулалт*

*Албан бус орчуулга*

| *№* | *Улсын нэр* | *Үндсэн хуулийн зохицуулалт* |
|---|---|---|
| 1. | **Армени** | 8.2.Улс төрийн нам байгуулах, үйл ажиллагаа явуулах нь чөлөөтэй. Намуудад үйл ажиллагаа явуулах хууль зүйн тэгш боломжийг хуулиар баталгаажуулна.<br>8.3.Улс төрийн нам нь ард түмний улс төрийн хүсэл зорилгыг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.<br>8.4.Улс төрийн намын бүтэц, үйл ажиллагаа нь ардчиллын зарчимд нийцсэн байна.<br>46.1.Иргэн бүр бусад иргэнтэй хамтран нам байгуулах, намын гишүүн болох эрхтэй. Хэнийг ч албан хүчээр намын гишүүн болгох ёсгүй. |
| 2. | Болгар | 11.3. Бүх улс төрийн нам нь иргэдийн улс төрийн хүсэл зоригийг төлөвшүүлэх, улс төрийн хүсэл зоригоо илэрхийлэхэд нь хөндлөнгөөс оролцоно.<br>Улс төрийн намыг үүсгэн байгуулах, татан буулгах үндэслэл, нөхцөл, журам болон үйл ажиллагааны үндсийг хуулиар тогтооно. |
| 3. | **Герман** | 21.1.Улс төрийн нам нь ард түмний улс төрийн хүсэл зориг бүрэлдэхэд дэмжиж оролцоно.<br>Иргэд улс төрийн намыг чөлөөтэй байгуулж болно.<br>Намын дотоод зохион байгуулалт нь ардчилсан зарчмуудад нийцсэн байна.<br>Нам нь өөрийн хөрөнгө, түүний эх үүсвэр, санхүүжилт болон зарлагыг нийтэд тайлагнах үүрэгтэй. |
| 4. | Хорват | 6.Улс төрийн нам үүсгэн байгуулах эрх чөлөөтэй.<br>Улс төрийн намын дотоод зохион байгуулалт үндсэн хуулийн суурь зарчим болон ардчиллын зарчимд нийцсэн байна.<br>Улс төрийн намууд өөрийн хөрөнгөтэй байх бөгөөд эд хөрөнгийн эх сурвалжаа нийтэд мэдээлэх үүрэгтэй…<br>Улс төрийн намын эрх зүйн байдал болон санхүүжилтийг хуулиар зохицуулна. |
| 5. | Эстони | 48.Хэн ч ашгийн бус аливаа холбоо үүсгэн байгуулах эрхтэй. Зөвхөн Эстони Улсын иргэд улс төрийн намд харьяалагдана…<br>Аливаа байгууллагууд, холбоод болон улс төрийн намын зорилго, эсхүл үйл ажиллагаа нь Эстонийн Үндсэн хуулийн дэглэмийг хүчээр өөрчлөхөд чиглэсэн, |

| | | |
|---|---|---|
| | | эсхүл эрүүгийн хариуцлага хүлээхүйц бусад зөрчил гаргахыг хориглоно.<br>Шүүх хууль зөрчсөн гэж үзсэн улс төрийн нам, эсхүл намуудын эвсэл болон адилтгах байгууллагыг торгох, үйл ажиллагааг нь түдгэлзүүлэх болон тухайн улс төрийн намыг татан буулгана. |
| 6. | Унгар | 8.3.Улс төрийн нам нь эвлэлдэн нэгдэх эрхийн үндсэн дээр байгуулагдаж, үйл ажиллагаа явуулна.<br>Улс төрийн нам ард түмний улс төрийн үзэл бодлыг төлөвшүүлэх, илэрхийлэхэд оролцоно.<br>Улс төрийн нам нь төрийн эрх мэдлийг шууд хэрэгжүүлэхгүй. |
| 7. | Норвег | 101.Хүн бүр аливаа хөдөлмөрийн байгууллага болон улс төрийн нам байгуулах, элсэх болон намаас гарах эрхтэй.<br>…[441] |
| 8. | Словак | 2.Иргэд улс төрийн нам, улс төрийн хөдөлгөөн болон холбоог үүсгэн байгуулж болно. |
| 9. | Серб | 5.Улс төрийн намын үүрэг нь ардчилсан ёсны хүрээнд иргэдийн улс төрийн хүсэл зоригийг төлөвшүүлэх, хүлээн зөвшөөрөхөд оршино.<br>Улс төрийн намыг байгуулах нь чөлөөтэй. |
| 10. | Турк | ***68****. Иргэд улс төрийн нам үүсгэн байгуулах, намд элсэх болон намаас гарах эрхтэй. Арван найм ба түүнээс дээш насанд хүрсэн иргэн намын гишүүн болж болно.* |
| 11. | Румын | *8.2.Улс төрийн намыг үүсгэн байгуулах болон үйл ажиллагааны нөхцөл, журмыг хуулиар тогтооно.*<br>*Улс төрийн нам нь иргэдийн улс төрийн хүсэл зоригийг төлөвшүүлэх болон илэрхийлэхдээ үндэсний тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдал, хууль дээдлэх болон ардчиллын зарчмуудыг хүндэтгэнэ.* |
| 12. | БНСУ | 8.1.Улс төрийн намыг чөлөөтэй үүсгэн байгуулах бөгөөд олон намын тогтолцоотой байна. |
| 13. | **Испани** | 6.Улс төрийн нам нь ард түмний олон ургалч үзэл, иргэдийн улс төрийн хүсэл зоригийг төлөвшүүлэх болон илэрхийлэх улс төрийн оролцооны чухал хэрэгсэл мөн. Улс төрийн намыг үүсгэн байгуулах болон намын үйл ажиллагаа нь Үндсэн хууль болон бусад хуульд нийцсэн байна.<br>Намын дотоод бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа нь ардчилсан байна. |
| 14. | **Итали** | 49.Итали Улсын иргэн хэн ч ардчилсан үйл явцаар дамжуулан үндэсний бодлого тодорхойлоход хувь нэмрээ оруулахын тулд улс төрийн намыг чөлөөтэй байгуулах эрхтэй. |
| 15. | **Камбож** | 42.Кхмер иргэд нь аливаа холбоо болон улс төрийн нам байгуулах эрхтэй. Энэ эрхийг хуулиар тогтооно. Кхмер иргэд үндэсний ололт, нийгмийн дэг журмыг хамгаалахын төлөө олон нийтийн байгууллагын үйл ажиллагаанд хамтран оролцож болно. |
| 16. | **Молдав** | 41.1.Иргэн бүр нам, нийгэм-улс төрийн бусад байгууллагад чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхтэй.<br>Нам, нийгэм-улс төрийн бусад байгууллага нь иргэдийн улс төрийн хүсэл зоригийг тодорхойлох, илэрхийлэх болон хууль дээдлэх ёсны дагуу сонгуулийн үйл явцад оролцоход нь хамтран ажиллана. |
| 17. | **Польш** | 11.1.Бүгд Найрамдах Польш Улс нь улс төрийн нам байгуулах болон тэдгээрийн үйл ажиллагааны эрх чөлөөг хангана.<br>Улс төрийн намыг Польш иргэдийн сайн дурын үндсэн дээр тэгш эрхийн зарчимд үндэслэн байгуулна. Улс төрийн намын зорилго нь төрийн бодлогыг тодорхойлоход ардчилсан арга замаар нөлөөлөхөд оршино. |
| 18. | **Португал** | **51 дүгээр зүйл. Улс төрийн холбоо болон нам**<br>51.1.Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө нь улс төрийн холбоод, нам байгуулах, эсхүл намууд нэгдэх эрхийг агуулахаас гадна тэдгээрээр дамжуулан хамтын хүчээр, ардчилсан ёсоор ард түмний хүсэл зоригийг бүтээж, улс төрийн эрх мэдлийг зохион байгуулахыг ойлгоно. |

[441] Улс төрийн намын тухай бусад заалтыг судалгааны холбогдох хэсэгт оруулсан.

| | | |
|---|---|---|
| | | 51.2.Хэн ч нэгээс дээш улс төрийн намын гишүүнээр нэгэн зэрэг бүртгүүлэхгүй, хэн ч хуулийн дагуу байгуулагдсан аль нэг намын гишүүн болсон, эсхүл намын гишүүнчлэлээ больсныхоо төлөө аливаа эрхийг нь хасахыг хориглоно.<br>51.3.Намын тунхагласан үзэл баримтлал эсхүл үндсэн зарчмаар нь ялгаварлалгүйгээр улс төрийн намуудыг ямар нэгэн шашин болон сүм хийдтэй шууд холбогдох нэр авах, мөн төрийн болон шашны сүлд тэмдэгтэй ижил төсөөтэй сүлд тэмдэг хэрэглэхийг хориглоно.<br>51.4.Нам нь аль нэг бүс нутгийн үндсэн шинж, хүрээг хамарсан нэр, үзэл баримтлалтай байх ёсгүй.<br>51.5.Улс төрийн нам нь үйл ажиллагаандаа ил тод байдал, ардчилсан удирдлага, зохион байгуулалт болон бүх гишүүдийн оролцоог хангах зарчмыг удирдлага болгоно.<br>51.6.Улс төрийн намын санхүүжилт, түүнд тавигдах шаардлагууд, олон нийтээс авах хандивын хэмжээ хязгаар, хөрөнгө болон дансны мэдээллийг нийтэд мэдээлэхийг хуулиар зохицуулна. |
| 19. | **<u>Румын</u>** | 8.2.Улс төрийн нам байгуулах болон улс төрийн намын аливаа үйл ажиллагаа хуульд заасан журмын дагуу явагдана.<br>Улс төрийн нам нь иргэдийн улс төрийн хүсэл зоригийг тодорхойлох, илэрхийлэх, үндэсний тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хууль дээдлэх ёс, ардчиллын зарчмуудыг хүндэтгэхэд хувь нэмэр оруулна. |
| 20. | Суринам | 53.1.Төр нь иргэдийн хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд улс төрийн нам байгуулах эрх чөлөөг хүлээн зөвшөөрнө.<br>53.2.Улс төрийн нам нь үндэсний тусгаар тогтнол, ардчиллыг хүндэтгэх шаардлагатай.<br>53.3.Улс төрийн нам эрхээ хэрэгжүүлэхдээ дараах зүйлсийг харгалзан үзнэ:<br>а) улс төрийн намын зорилго нь Үндсэн хууль болон бусад хуулийг зөрчихгүй байх;<br>б) нам нь хуулиар тогтоосон шалгуурыг хангасан Суринам иргэнд нээлттэй байх ба Суринам иргэн нь намын үндсэн зарчмыг хүлээн зөвшөөрсөн байх;<br>в) намын дотоод зохион байгуулалт нь ардчилсан байх;<br>г) сонгогчдод улс төрийн намын улс төрийн болон сонгуулийн хөтөлбөрийн талаар мэдээлсэн байх;<br>д) нам нь жил бүр орлогын эх үүсвэр болон тайлангаа Бүгд Найрамдах Суринам Улсын албаны ёсны сонин (Official Journal of the Republic of Suriname) болон бусад сонинд нийтлэх;<br>е) улс төрийн нам үйл ажиллагааныхаа нээлттэй, ил тод байдлыг хангаж, сайн засаглалын зарчмууд болон хуулиар тогтоосон журмын дагуу явуулах;<br>ё) үндэсний ашиг сонирхлыг хөхиүлэн дэмжихийн тулд нэгдсэн зорилготой хөтөлбөр боловсруулах. |

### 1.2.Улс төрийн намд тавих хязгаарлалтын тухай зарим улсын Үндсэн хуулийн зохицуулалт

Улс төрийн намд тавих хязгаарлалтыг дэлхийн 94 улсын Үндсэн хуульд тусгасан байна.

Улс орны Үндсэн хуулийг судлан үзэхэд дараах “**нийтлэг хязгаарлалт**”-ыг Үндсэн хуулиар тогтоосон байна:

- Нам нь үндэсний эв нэгдэл, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, үндэсний аюулгүй байдлыг алдагдуулахгүй байх;
- төрийн эрх мэдлийг шууд хэрэгжүүлэхгүй байх, төрийн эрх мэдлийг өөрийн хяналтад байлгахгүй байх;
- намын зорилго, үйл ажиллагаа нь ардчилалын суурь зарчмуудыг зөрчихгүй байх;
- намын үйл ажиллагаа нь Үндсэн хууль, бусад хуульд нийцсэн байх;
- иргэдийн улс төрийн хүсэл зорилгыг бүрдүүлэх, илэрхийлэхэд оролцох зэрэг нийтлэг хязгаарлалтыг Үндсэн хуульд тусгасан байна.

Мөн дараах “**онцлог хязгаарлалт**” ч байна. Үүнд:

- нам нь үндэсний ашиг сонирхлыг нэн тэргүүнд авч үзэх;
- нам нь сонгуулийн ашгийн төлөө сонгогчдын үндэс угсаа, бүс нутаг, шашин шүтлэгийг ашиглахгүй байх;
- намын нэр, үзэл баримтлал нь аль нэг бүс нутгийг хамарсан шинжгүй байх;
- намын нэр, үзэл баримтлал аль нэг шашны бэлгэдэл, номлолыг илэрхийлэхгүй байх;
- нам арилжааны үйл ажиллагаа эрхлэхгүй[442];
- улс төрийн намын зорилго, үйл ажиллагаа нийцэж байх ёстой;
- нам нь хүйсийн тэгш эрх, харилцан ойлголцлыг хангах;
- нам хөтөлбөр, үйл ажиллагаагаараа үндэсний энх тайвныг хангах ёстой;
- хилийн гадна байгуулсан улс төрийн байгууллага, үйл ажиллагааг хориглоно зэрэг хязгаарлалтууд тавигдсан байна.

*Хүснэгт 3. Улс төрийн намд тавих хязгаарлалтын тухай зохицуулалт*

| № | Улсын нэр | *Үндсэн хуулийн зохицуулалт* |
|---|---|---|
| 1. | Серб | 5.Улс төрийн нам нь төрийн эрх мэдлийг шууд хэрэгжүүлэхгүй, эсхүл төрийн эрх мэдлийг өөрийн хяналтад авахгүй. |
| 2. | **Франц** | 4.Улс төрийн нам болон бүлгүүд нь иргэдийн сонгох эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Улс төрийн нам болон бүлгийг чөлөөтэй байгуулж, үйл ажиллагаа явуулна.<br>Улс төрийн нам болон бүлгүүд нь үндэсний бүрэн эрхт байдал, ардчиллын зарчмуудыг баримтална.<br>Улс төрийн нам болон бүлэг нь Үндсэн хуулийн энэ зүйлийн 2 дахь догол мөрт[443] заасан зарчмыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.<br>Үндсэн хууль нь улс төрийн нам, бүлгүүдийн ардчилал, олон ургалч үзэл, эрх тэгш оролцооны илэрхийллийн баталгаа болно. |
| 3. | **Бутан** | 15.1.Улс төрийн нам нь бусад бүх эрх ашгаас үндэсний эрх ашгийг нэн тэргүүнд тавих бөгөөд энэ зорилгоо хангахын тулд хариуцлагатай, сайн засаглалын төлөө иргэдийн хүсэл зориг, үнэт зүйлд үндэслэсэн сонгууль явуулна.<br>15.3.Нэр дэвшигчид болон улс төрийн намууд сонгуулийн ашгийн төлөө сонгогчдыг үндэс угсаа, бүс нутаг, шашин шүтлэгийг ашиглах ёсгүй. |
| 4. | Йордан | 16.2.Йорданчууд нийгэмлэг, холбоо, улс төрийн нам байгуулах эрхтэй бөгөөд тэдгээрийн зорилго нь хуульд нийцсэн, арга барил нь энх тайвныг эрхэмлэсэн, дүрэм нь Үндсэн хууль зөрчөөгүй байна. |
| 5. | **Кени** | 91.1.Бүх улс төрийн нам нь:<br>а) хуулиар тогтоосон үндэсний хэмжээнд зохион байгуулагдах;<br>б) ардчилсан сонгуульт удирдах байгууллагатай байх;<br>в) үндэсний эв нэгдлийг хөхиүлэн дэмжих;<br>г) сайн засаглалын ардчилсан зарчмуудыг дагаж мөрдөн, нам доторхи шударга, чөлөөт сонгуулийг дэмжиж тогтмол явуулах;<br>е) хүн бүрийн, ялангуяа цөөнх, эмзэг бүлгийнхний улс төрийн оролцооны эрхийг хангах;<br>ё) хүний эрх, үндсэн эрх чөлөө, хүйсийн эрх тэгш байдлыг хүндэтгэн дэмжих;<br>ж) Үндсэн хуулийн зорилго, зарчим болон хууль дээдлэх ёсыг хангах;<br>з) улс төрийн намын ёс зүйн дүрмийг батлан дагаж мөрдөх. |
| 6. | Коста-Рика | 98. ...<br>Улс төрийн нам нь улс төрийн олон ургальч үзлийг илэрхийлж, иргэдийн хүсэл зоригийг тодорхойлоход оролцох болон улс төрийн оролцоог хангах үндсэн арга хэрэгсэл болно.<br>Улс төрийн намыг чөлөөтэй байгуулах ба намын үйл ажиллагаа нь Үндсэн хууль |

[442] Турк Улсын зохицуулалтыг Хүснэгт 4-т бүхлээр нь оруулсан тул тэндээс үзнэ үү.
[443] Франц Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйл:
…Үндсэн хууль нь сонгуульт болон бусад албан тушаалд, мөн мэргэжлийн болон нийгмийн хариуцлагатай албан тушаалд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш боломжийг дэмжинэ.

| | | |
|---|---|---|
| | | болон бусад хуульд нийцсэн байна.<br>Улс төрийн намын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаа ардчилсан байна. |
| 7. | **Мозамбек** | 74.1.Нам нь улс төрийн олон ургальч үзлийн илэрхийлэл байна. Нам нь ард түмний хүсэл зоригийг төлөвшүүлж, илэрхийлэхэд оролцох бөгөөд энэ нь төрийн удирдлагад ард түмний ардчилсан оролцоог хангах үндсэн хэрэгсэл болно.<br>74.2.Улс төрийн намын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаа ардчилсан байна.<br>75.1.Улс төрийн нам нь үндэсний эв нэгдэл, ардчилсан үнэт зүйлсийг чин сэтгэлээсээ хүндлэх үүднээс Үндсэн хууль болон бусад хуульд бататгасан зарчмуудыг баримтална.<br>75.2.Улс төрийн нам нь өөрсдийн зорилгыг тодорхойлж, хэрэгжүүлэхдээ дор дурдсан зарчмыг баримтална:<br>а) нам үндэсний хэмжээний байх;<br>б) үндэсний эрх ашгийг хамгаалах;<br>в) олон нийтийн санаа бодол, ялангуяа үндэсний томоохон асуудлуудлыг тодорхойлох;<br>г) иргэний эх оронч үзлийг бэхжүүлэх, Мозамбик үндэстэнг нэгтгэх.<br>75.3.Нам нь улс төрийн болон иргэний боловсролоор дамжуулан улс орны энх тайван, тогтвортой байдлыг хангахад хувь нэмэр оруулна.<br>75.4.Нам байгуулах болон зохион байгуулалт, үйл ажиллагааг хуулиар тогтооно. |
| 8. | Монтенегро | 54.Гадаадын иргэдийн байгуулсан улс төрийн байгууллага болон үйл ажиллагаа, Монтенегро Улсын гадна байгуулсан улс төрийн байгууллага, түүний аливаа үйл ажиллагааг хориглоно. |
| 9. | **Мьянмар** | 404.Улс төрийн нам:<br>а) зорилго нь Холбоог задруулахгүй, үндэсний эв нэгдлийг хангах, тусгаар тогтнолыг үүрд хадгалах;<br>б) төрд үнэнч шударга байна.<br>405.Улс төрийн нам:<br>а) үнэнч шударга, дэг журамтай хөгжиж байгаа олон намын ардчилсан тогтолцоог хүлээн зөвшөөрч хэрэглэх;<br>б) Үндсэн хууль болон хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бусад хуулийг хүндэтгэн сахих;<br>с) хуульд нийцүүлэн улс төрийн намыг байгуулж, бүртгүүлэх үүрэгтэй. |
| 10. | Руанда | 56.Улс төрийн нам нь өөрийн удирдах зөвлөлийн гишүүдийг томилохдоо руандачуудын нэгдмэл байдал, хүйсийн тэгш байдал, харилцан ойлголцлыг байнга хангана.<br>Улс төрийн нам нь Үндсэн хууль болон бусад хуулийг дагаж мөрдөнө. Улс төрийн нам нь ардчилсан зарчимд нийцсэн байх бөгөөд үндэсний эв нэгдэл, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, үндэсний аюулгүй байдлыг алдагдуулахыг хориглоно. |

### 1.3.Улс төрийн намын хариуцлагын тухай зарим улсын Үндсэн хуулийн зохицуулалт

Дэлхийн 38 орны Үндсэн хуулиар улс төрийн нам (байгууллага)-д хариуцлага тооцох үндэслэл, хариуцлагын төрөл болон түүнийг ногдуулах субъектийг заасан байна.

***а) Хариуцлага тооцох үндэслэл:***

- Үндсэн хууль болон бусад хуульд харшилсан аливаа үйл ажиллагааг дэмжсэн, явуулсан бол (*төрийн эрх мэдлийг шууд хэрэгжүүлэх, төрийн эрх мэдлийг хяналтандаа авах г.м*);
- гадаадын эх үүсвэрээс мөнгө, тусламж авсан бол;
- улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд заналхийлсэн бол;
- сонгуулийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн бол;
- ардчиллын үндсэн зарчимтай зөрчилдсөн үзэл санаа, уриа дэвшүүлсэн, үйл ажиллагаа явуулсан бол.

***б) Хариуцлагын төрөл:***

- торгох;
- улсын дэмжлэгээс хэсэгчлэн болон бүрэн хасах;
- түдгэлзүүлэх (үйл ажиллагааг түр зогсоох);
- сонгуульд оролцох эрхийг хасах;
- тараах (татан буулгах).

***в) Хариуцлага ногдуулах субъект:***

- Үндсэн хуулийн шүүх;
- Улсын дээд шүүх;
- шүүх.

Улс төрийн нам Үндсэн хууль зөрчсөн эсэхийг шалгуулах хүсэлт гаргах субъектийн тухайд зарим улсад Засгийн газар, Гүржийн Үндсэн хуульд тусгайлан заасан олон субъект байх бол ихэнх улсын Үндсэн хуульд тус субъектийг тусгайлан заагаагүй байна.

Улс төрийн намд хариуцлага тооцох үндэслэл, хариуцлагын төрөл, түүнээс үүсэн гарах хууль зүйн үр дагаврыг тодорхой зохицуулсан улс бол Турк Улс байх тул зохицуулалтыг нь доорх хүснэгтээс нарийвчлан үзнэ үү.

*Хүснэгт 4. Улс төрийн намын хариуцлагын тухай зохицуулалт*

| **№** | ***Улсын нэр*** | ***Үндсэн хуулийн зохицуулалт*** |
|---|---|---|
| 1. | Хорват | 6.Улс төрийн нам өөрийн хөтөлбөр, эсхүл хүч хэрэглэсэн үйл ажиллагаагаар чөлөөт ардчилсан ёсыг унагаж, Хорватын Бүгд Найрамдах улсын оршин тогтнолд аюул учруулах зорилго агуулсан бол тухайн улс төрийн намыг Үндсэн хуулийн бус гэж үзнэ.<br>Улс төрийн намыг үндсэн хуулийн бус эсэх асуудлыг Хорват Улсын Үндсэн хуулийн цэц шийдвэрлэнэ. |
| 2. | Эстони | 48.Аливаа байгууллага, нэгдэл, улс төрийн нам хууль зөрчсөн эсэхийг зөвхөн шүүх тогтоох бөгөөд хууль зөрчсөн нь тогтоогдсон улс төрийн намын үйл ажиллагааг зогсоох, татан буулгах, торгох эсэхийг шүүх шийднэ. |
| 3. | Турк | 68.Улс төрийн намын үйл ажиллагаа, дотоод журам нь ардчилсан зарчимд нийцсэн байна.<br>Эдгээр зарчмын хэрэгжилтийг хуулиар зохицуулна.<br>Улс төрийн нам нь арилжааны үйл ажиллагаа явуулахгүй.<br>Улс төрийн намын орлого, зарлага нь зорилготойгоо нийцэх ёстой. Энэ журмын хэрэгжилтийг хуулиар зохицуулна. Улс төрийн намын орлого, худалдан авалт, зарлагын аудитыг Үндсэн хуулийн цэцээс хуульд заасны дагуу, аудитын зарчим, арга барилаар хийх ба хууль зөрчсөн тохиолдолд зохих хуулийн дагуу хариуцлага тооцно.<br>Үндсэн хуулийн цэц нь аудит хийхдээ мэргэшсэн шүүхээс мэргэжлийн |

| | | |
|---|---|---|
| | | туслалцаа авна. Аудитын дунд Үндсэн хуулийн цэцээс гарсан шийдвэр эцсийнх байна.<br>Прокуророос гаргасан улс төрийн намыг татан буулгах хүсэлтийг давж заалдах шатны шүүхээр хэлэлцсэнийг Үндсэн хуулийн цэц эцэслэн шийдвэрлэнэ.<br>Улс төрийн намын үзэл баримтлал, мөрийн хөтөлбөр нь Хуулийн 68-р зүйлийн 4-р хэсгийн заалтыг зөрчсөн нь тогтоогдвол тухайн намыг бүрмөсөн татан буулгана.<br>Улс төрийн намын үзэл баримтлал, мөрийн хөтөлбөр нь Хуулийн 68-р зүйлийн 4-р хэсгийн заалтыг зөрчсөн шалтгаанаар намыг бүрмөсөн татан буулгах нь Үндсэн хуулийн цэц тухайн намыг хууль зөрчсөн үйлдлүүдийн гол цөм болохыг тогтоосон тохиолдолд хэрэгжинэ.<br>Улс төрийн намын гишүүд дээрх үйлдлүүдийг идэвхтэйгээр хэрэгжүүлсэн, нөхцөл байдлыг ил далдаар Их хурал, Тэргүүлэгч болон шийдвэр гаргах дээд түвшний хүрээнд, мөн намын гүйцэтгэх аппаратын байгууллагууд, хэсгийн хурлуудаар, Туркийн Үндэсний Ассамблейн гүйцэтгэх зөвлөлийн түвшинд үйлдсэн, эсвэл намын бүтэц нь тэр аяараа хамарсан тохиолдолд тухайн намыг дээрх үйлдлийн гол цөм болсон гэж үзнэ.<br>Үндсэн хуулийн цэцээс тухайн намыг бүр мөсөн татан буулгахын оронд шүүхээр тогтоосон гэм буруугийн хэмжээнээс нь хамааран төрөөс дэмжлэг тусламж авах байдлыг нь хэсэгчлэн болон бүрмөсөн хорьж болно.<br>Бүр мөсөн татан буугдсан намыг өөр нэрээр дахин байгуулах боломжгүй.<br>Хэлсэн үг, хийсэн үйлдлээс нь болж бүрмөсөн татан буугдсан намын үүсгэн байгуулагчид, гишүүд тухайн намыг татан буулгах тухай Үндсэн Хуулийн Цэцийн шийдвэр хэвлэгдэн албан ёсоор нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 5 жилийн дотор өөр ямар нэгэн намын үүсгэн байгуулагч, гишүүн, удирдах албан тушаалд байж болохгүй.<br>Гадаад улсын төр, олон улсын байгууллага, бизнесийн байгууллага, хувь хүнээс тусламж авсан улс төрийн намыг бүрмөсөн татан буулгана.<br>Улс төрийн намын үүсэл, үйл ажиллагаа, тэдгээрийн удирдлага, задрах явц, төрийн дэмжлэгээс бүтнээр болон хэсэгчлэн хасагдах, сонгуулийн зардал, улс төрийн намаас нэр дэвших зэрэг асуудлыг дээрх зарчимд суурилсан холбогдох хуулиар зохицуулна. |
| 4. | БНСУ | 8.4.Хэрэв улс төрийн намын зорилго, үйл ажиллагаа нь ардчилалын үндсэн зарчимтай зөрчилдөж байна гэж үзвэл Засгийн газар энэ талаар Үндсэн хуулийн шүүхэд гомдол гаргах ба Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн дагуу улс төрийн нам тарна. |
| 5. | ХБНГУ | 21.2. Өөрийн зорилго, эсхүл үзэл баримтлалынхаа хүрээнд ардчилсан чөлөөт үндсэн зарчмыг нураах, устгах, эсхүл Холбооны Бүгд Найрамдах Герман улсын оршин тогтнолд аюул учруулахуйц намыг Үндсэн хуулийн бус гэж үзнэ.<br>Холбооны Үндсэн хуулийн цэц нь улс төрийн намыг Үндсэн хуулийн бус эсэхийг шийдвэрлэнэ. |
| 6. | Словени | 160.Үндсэн хуулийн цэц нь улс төрийн намуудын үйл ажиллагаа, дүрмийг Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянан шийдвэрлэнэ. |
| 7. | **Албани** | 131.1.Үндсэн хуулийн шүүх дор дурдсан асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэнэ:<br>д) намууд болон бусад улс төрийн байгууллагууд Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх, тэдгээрийн үйл ажиллагаа нь Үндсэн хуулийн 9 дүгээр зүйлд[444] нийцэж байгаа эсэхийг; |
| 8. | **Бутан** | 15.11.Зөвхөн Улсын дээд шүүхийн шийдвэрээр улс төрийн намыг татан буулгана:<br>а) хэрэв улс төрийн намын зорилго, үйл ажиллагаа нь Үндсэн хуульд |

[444] Албанийн Үндсэн хуулийн 9 дүгээр зүйл:
1.Улс төрийн намыг чөлөөтэй байгуулна. Байгууллага нь ардчилсан зарчимд нийцсэн байх ёстой.
2.Улс төрийн намууд болон бусад байгууллагуудын тоталитар дэглэмд үндэслэх, арьс өнгө, шашин шүтлэг, бүс нутаг, эсхүл үндэсний үзэн ядалтыг өдөөх, дэмжих, төрийн эрхийг авах, эсхүл төрийн бодлогод нөлөөлөхийн тулд хүчирхийллийг ашиглах, мөн нууц шинж чанартай хөтөлбөр, үйл ажиллагаа явуулахыг хуулиар хориглоно.
3.Улс төрийн намууд нь санхүүгийн эх үүсвэр, түүний зардлыг олон нийтэд байнга нээлттэй байлгана.

| | | |
|---|---|---|
| | | харшилсан бол;<br>b) хэрэв гадаадын эх үүсвэрээс мөнгөн хөрөнгө, тусламж авсан бол;<br>c) парламент, эсхүл хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулийн бусад үндэслэлээр;<br>d) сонгуулийн тухай хуулийг зөрчсөн бол. |
| 9. | **<u>Гүрж</u>** | 26.6.Олон нийтийн, эсхүл улс төрийн холбоодын үйл ажиллагааг зөвхөн шүүхийн шийдвэр болон органик хуулиар тогтоосон журмын дагуу түр зогсоож, эсхүл хориглож болно.<br>89.1.Гүрж Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Парламентын 1/5-ээс доошгүй гишүүд, шүүх, Абхази, Ажараагийн автономит бүгд найрамдах улсын төлөөллийн дээд байгууллагууд, Сакребулосийн нутгийн өөрөө удирдах ёсны төлөөллийн байгууллагууд, Шүүхийн дээд зөвлөл, Ардын хамгаалагч, эсхүл иргэний гаргасан гомдолд үндэслэн органик хуулиар тогтоосон журмын дагуу Гүрж Улсын Үндсэн хуулийн шүүх дор дурдсан асуудлуудыг шийдвэрлэнэ:<br>c) иргэдийн улс төрийн холбоодын зохион байгуулалт, үйл ажиллагаа Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг; |
| 10. | **<u>Пакистан</u>** | 17.2.Пакистан Улсад (төрийн) алба хаагаагүй иргэн бүр Пакистан Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг тогтоосон хууль тогтоомжид заасан хязгаарт улс төрийн нам байгуулах, эсхүл намын гишүүн байх эрхтэй.<br>Хуулийн дагуу Холбооны Засгийн газар нь Пакистан Улсын тусгаар тогтнол, бүрэн бүтэн байдалд хохирол учруулж байгаа улс төрийн нам байгуулагдсан, эсхүл үйл ажиллагаа явуулж байгаа талаар мэдэгдэнэ.<br>Холбооны Засгийн газар мэдэгдэл хийснээс хойш 15 хоногийн дотор Дээд шүүхэд энэ асуудлыг шилжүүлэх ба Дээд шүүхийн гаргасан шийдвэр эцсийнх байна. |
| 11. | **<u>Польш</u>** | 188.Үндсэн хуулийн шүүх дор дурдсан асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэнэ:<br>4)улс төрийн намуудын зорилго, үйл ажиллагаа нь Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар; |
| 12. | **<u>Тайвань</u>** | 5.Хэрэв улс төрийн намын зорилго, эсхүл үйл ажиллагаа нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын бүрэн эрхт байдал, эсхүл үндэсний Үндсэн хуулийн эрх чөлөөт, ардчилсан дэг журамд аюул учруулж байвал түүнийг Үндсэн хууль зөрчсөн гэж үзнэ. |

## 1.4.Улс төрийн намд хориглосон үйл ажиллагааны тухай зарим улсын Үндсэн хуулийн зохицуулалт

Улс төрийн намд хориглох үйл ажиллагааны талаарх зохицуулалтыг 57 улсын Үндсэн хуульд тусгасан байна. Үндсэн хуулиар дор дурдсан үйл ажиллагааг хориглосон байна. Үүнд:

- улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын эсрэг үйл ажиллагаа явуулахыг;
- ардчилсан болон хууль дээдлэх ёсны зарчим, олон ургальч үзлийн эсрэг үзэл баримтлал, уриа дэвшүүлж, үүнд чиглэсэн үйл ажиллагаа явуулахыг;
- арьс өнгө, хүйс, шашин, хэл, газар зүйн байршил, үндэсний цөөнх дээр үндэслэж нам байгуулахыг;
- цэрэг, цэрэгжсэн, эсхүл нууц үйл ажиллагаа эрхэлсэн байгууллага байгуулахыг;
- гадаадаас мөнгөн хөрөнгө, хандив авахыг;
- улсын хөрөнгө авах, ашиглах, шамшигдуулахыг;
- хээл хахууль, авлигын шинжтэй үйлдэл хийх болон зохион байгуулахыг;
- төрийн болон орон нутгийн байгууллагууд нам байгуулах, намын үйл ажиллагаа явуулахыг хориглох;
- албан үүргээс гүйцэтгэхээс бусад тохиолдолд төрийн болон орон нутгийн төрийн байгууллага, хууль сахиулах байгууллагуудын албан хаагчид улс төрийн намын үйл ажиллагаа явуулахыг хориглох;
- гадаадын улс төрийн намууд (байгууллагууд)-тай хамаатай байхыг;

- нацизм, фашизм, коммунизмын загвар дээр үндэслэсэн үйл ажиллагаа явуулахыг тус тус хориглосон байна.

*Хүснэгт 5. Улс төрийн намд хориглосон зохицуулалт*

| № | Улсын нэр | Үндсэн хуулийн зохицуулалт |
|---|---|---|
| 1. | **Ангол** | 17.2.Улс төрийн намын дүрэм, үйл ажиллагаа нь хуульд нийцсэн байх ёстой бөгөөд дараах үндсэн зарчмыг баримтална:<br>а) улс төрийн намын үйл ажиллагаа нь үндэсний эрх ашигт нийцсэн байх;<br>б) дүрмээ чөлөөтэй батлах;<br>в) зорилгоо олон нийтэд түгээх;<br>г) гишүүнээр элсүүлэх эрх чөлөөтэй байх, нэг гишүүнчлэлтэй байх эрхтэй;<br>д) зөвхөн энх тайвнаар зорилгодоо хүрэх; (цэрэг, цэрэгжсэн байгууллага байгуулах, эсхүл ашиглахыг хориглох)<br>е) зохион байгуулалт, үйл ажиллагаа нь ардчилсан байх;<br>ё) улс төрийн намуудын гишүүнчлэлийн доод хязгаарыг хуулиар тогтоох;<br>ж) гадаадын засгийн газар, төрийн байгууллагын мөнгөн болон эдийн засгийн хандив авахыг хориглох;<br>з) төрийн хөрөнгийг ашиглах данс нээхийг хориглоно. |
| 2. | **Афганистан** | 35.Афганистаны ард түмэн хуульд заасан журмын дагуу улс төрийн нам байгуулах эрхтэй бөгөөд ингэхдээ:<br>1)улс төрийн намын үзэл баримтлал болон дүрэм нь Үндсэн хуульд заасан Исламын шашин, зарчмууд, үнэт зүйлстэй зөрчилдөхгүй байх ёстой;<br>2)улс төрийн намын зохион байгуулалт, санхүүжилтийн эх үүсвэр ил тод байх ёстой;<br>3)цэргийн, эсхүл хагас цэргийн зорилго, зохион байгууллагатай байх ёсгүй;<br>4)улс төрийн намууд нь гадаадын улс төрийн намууд болон бусад байгууллагуудтай хамаатай байх ёсгүй.<br>Нам байгуулах, тэдний үйл ажиллагаа нь овог, ашиг сонирхлын явцуурал, хэл, шашны хуваагдлыг хориглоно. Хуулийн дагуу байгуулагдсан намууд, эсхүл эвслийг эрх зүйн үндэслэл, шүүхийн шийдвэргүйгээр тарааж үл болно. |
| 3. | **Египет** | 74.Иргэд хуулийн дагуу улс төрийн нам байгуулах эрхтэй.<br>Гарал үүсэл, хүйс, шашин, бүлэг, газарзүйн байршилд үндэслэж улс төрийн нам байгуулах, эсхүл үйл ажиллагаа явуулж үл болно. Ардчилалд заналхийлсэн, нууцлагдмал, цэргийн, эсхүл цэргийн шинжтэй аливаа үйл ажиллагаа явуулж болохгүй. |
| 4. | **Кени** | 91.2.Улс төрийн намд дор дурдсан үйл ажиллагааг хориглоно:<br>а)арьс өнгө, угсаа, хүйс, шашин, хэл, бүс нутагт үндэслэх, эсхүл үзэн ядалтыг өмгөөлөхийг эрэлхийлэх;<br>б)өөрийн гишүүд, дэмжигчид, сөрөг хүчнийхэн, эсхүл бусад этгээдэд хүч хэрэглэх, айлгах, эсхүл дэмжих;<br>в)цэрэгжсэн хэлбэр, цагдаа, эсхүл түүнтэй ижил төстэй байгууллага байгуулах, дэмжих;<br>г)хээл хахууль, эсхүл бусад төрлийн авлигын шинжтэй үйлдэл хийх;<br>д)энэ бүлэг, эсхүл парламентын шийдвэрт зааснаас бусад тохиолдолд өөрийн, эсхүл сонгуульд нэр дэвшигчийнхээ ашиг сонирхлын төлөө улсын хөрөнгийг авах, ашиглах. |
| 5. | **Киргиз** | 4.4.Бүгд Найрамдах Киргиз Улсад дараах зүйлийг хориглоно:<br>1)төр, орон нутаг болон намын байгууллагууд нэгдэхийг; төрийн болон орон нутгийн байгууллагуудад нам байгуулах, үйл ажиллагаа явуулахыг; албан үүрэг гүйцэтгэхээс бусад тохиолдолд төрийн болон орон нутгийн албан хаагчид намын үйл ажиллагаа явуулахыг;<br>2)арми, хууль сахиулах байгууллагуудын албан хаагчид, шүүгчид улс төрийн намд үүрэг гүйцэтгэхийг, мөн улс төрийн аль нэг намыг дэмжсэн мэдэгдэл хийхийг; |

| | | |
|---|---|---|
| | | 3)шашны, эсхүл үндэсний цөөнхөд суурилсан улс төрийн нам байгуулахыг, мөн шашны холбоод улс төрийн зорилгод хүрэхийг;<br>4)цэрэг дайны хэлбэрээр иргэдийн нийгэмлэг байгуулахыг;<br>5)улс төрийн нам, нийгмийн болон шашны байгууллага, тэдний төлөөлөгчийн газрууд, салбаруудын үйл ажиллагаа нь улс төрийн зорилго агуулахыг, үндсэн хуулийн байгууллыг хүчээр өөрчлөхийг, үндэсний аюулгүй байдлыг доройтуулахыг, арьс өнгө, нийгэм, үндэстэн, ястан, шашин хоорондын мөргөлдөөнд хүргэхийг хориглоно. |
| 6. | **Либер** | 80-р зүйл.<br>а) улс төрийн намын зорилго болон гишүүд, дэмжигчдийн зан үйл нь Либер Улсын чөлөөт ардчилсан нийгэмд хор хохирол учруулах, эсхүл Бүгд Найрамдах Улсын тусгаар тогтнолд заналхийхийг оролдож буй нам, эсхүл байгууллагын бүртгэлийг хүчингүй болгоно.<br>б) Аливаа этгээд, эсхүл бүлэг этгээдээр хүч хэрэглэн, эсхүл албадан улс төрийн аливаа зорилго, ашиг сонирхлыг хамгаалуулахаар сургасан, тоноглосон аливаа этгээд, эсхүл бүлэг этгээдийг зохион байгуулсан нам болон улс төрийн бусад байгууллагыг бүртгэхгүй. Хэрэв бүртгэсэн бол бүртгэлийг хүчингүй болгоно. |
| 7. | **Молдав** | 41.4.Өөрийн зорилго, эсхүл үйл ажиллагаагаараа улс төрийн олон ургальч үзэл, хууль дээдлэх ёсны зарчмууд, Бүгд Найрамдах Молдав Улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын эсрэг үйл ажиллагаа явуулж байгаа нам, бусад нийгэм-улс төрийн байгууллагыг Үндсэн хууль зөрчсөн гэж үзнэ.<br>41.6.Гадаадын иргэдээс бүрдсэн намын үйл ажиллагааг хориглоно. |
| 8. | **Непал** | 269.5.Хэрэв улс төрийн намын нэр, зорилго, бэлгэ тэмдэг, далбаа нь шашин болон улс орны нийгмийн эв нэгдлийг эвдэх, эсхүл хуваах зорилгыг агуулж байвал тус улс төрийн намыг бүртгэхгүй. |
| 9. | **Польш** | 13.Улс төрийн нам болон бусад улс төрийн байгууллагуудын хөтөлбөр нь тоталитар аргад, үйл ажиллагаа нь нацизм, фашизм, коммунизмын загварт үндэслэхийг, мөн хөтөлбөр, эсхүл үйл ажиллагаа нь арьсны өнгө, үндэсний үзэн ядалтыг дэмжихийг, эрх мэдэл олж авах, эсхүл төрийн бодлогод нөлөөлөхийн тулд хүчирхийлэл хэрэглэхийг, өөрийн зохин байгуулалт, гишүүдийнхээ нууцыг хадгалахыг тус тус хориглоно. |
| 10. | **Экваторын Гвиней** | 9.2.Экваторын Гвинейн Улсын улс төрийн намуудын нэр нь 1968 оны 10 дугаар сарын 12-ны өдрөөс өмнө оршин байсан намын нэртэй ижил байж болохгүй бөгөөд овог аймаг, угсаатан, бүс нутаг, тойрог, хот, хүйс, шашин шүтлэг, нийгмийн байдал, мэргэжил, эсхүл эрхэлж байгаа ажилд үндэслэх ёсгүй бөгөөд улс төрийн намуудын үйл ажиллагаа нь үндэсний эрх ашигт нийцсэн байх.<br>Улс төрийн нам байгуулах, түүний үйл ажиллагааг хуулиар зохицуулна. |

## *Хоёр. УЛС ТӨРИЙН НАМЫН САНХҮҮЖИЛТ*

Улс төрийн намын санхүүжилтийг зохистой шийдвэрлэх нь улс төрийн төдийгүй эдийн засгийн хувьд ихээхэн ач холбогдолтой. Өнөө үед эдийн засгийн хямралыг арилгах, нам дахь авлигын сүлжээг саармагжуулах үйл явц намуудын санхүүжилтийн асуудлыг хэрхэн шийдвэрлэснээс ихээхэн хамаарч байна.

Намын санхүүжилтийг аливаа улс төрийн намын оршихуйн суурь нөхцөл гэж үздэг. Нам санхүүжилтийн асуудлаа зүй зохистой шийдвэрлэсэн байдлаас хамаарч улс орны улс төрийн амьдрал, тогтолцоо, улмаар эдийн засгийн өнөөгийн төлөв байдал тогтворжин зүгшрэх учиртай. Намын санхүүжилтийг үр нөлөөтэй, зохистой шийдвэрлэх ямар хувилбар, боломж, механизм, гарц шийдэл байгаа талаар улс төрчид, судлаачид санал бодлоо идэвхтэй солилцсоор байна. Ардчиллын төлөөх үндэсний сан (NED)-аас эрхлэн намын санхүүжилттэй холбоотой судалгааг хэвлүүлсэн байна.[445]

Улс төрийн намууд бол төлөөллийн ардчилалд онцгой үүрэгтэй оролцогч институт мөн. Энэ агуулгаараа үзэл суртлын болон төрийн бодлого зохицуулалтын үйл хэрэгт чухал нөлөөтэй, мөн улс төр дэх шударга өрсөлдөөнийг дэмжихэд намуудын үүрэг их юм. Намууд гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтэд түгээх, мөн гүйцэтгэгчийн үүргийг өөртөө хүлээдэг. Өөрөөр хэлбэл, засгийн газрын шийдвэр, бодлого боловсруулах үйл явцад иргэдийн оролцоог хангах үр нөлөөтэй суваг, чухал механизм нь улс төрийн намууд байдаг.

Улс төрийн намууд өөрт хамаарах үүргээ ардчилсан, үр өгөөжтэй байдлаар бүрэн дүүрэн хэрэгжүүлэхийн тулд санхүүгийн болон бусад бодит эх үүсвэр, эдийн засгийн хувьд хүчтэй байж, түүний дэмжлэгт түшиглэх нь тэдний оршин тогтнох хийгээд улс төрийн намын байнгын, тасралтгүй үйл ажиллагааг хангах суурь нөхцөл болдог. Ингэхдээ тухайн хуримтлуулсан нөөц боломжийг өөрийн улс төрийн институцийн суурь бүтцийг бэхжүүлэх, иргэдтэй харилцах, тэдний улс төрийн оролцоог дээшлүүлэх, нийгмийг нийгэмшүүлэх үйл хэрэгт зохистой ашиглах, түүний хүртээмж нөлөөг өргөн түвшинд түгээн дэлгэрүүлэх нь намуудын эн тэргүүнд анхаарах зүйл мөн.

Ихэнх ардчилсан орнуудад улс төрийн намууд өөрсдийн санхүүжилтийг хувийн болон төрийн эх үүсвэрээс авч үйл ажиллагаагаа явуулдаг. Ингэхдээ дараах хоёр зүйлийн харьцаа тэнцвэрийг хангах тал дээр анхаардаг байна. **Израил**ийн улс төрийн намуудын санхүүжилтийн дийлэнх хувь (85 орчим хувь)-ийг улсаас дэмжлэг авах байдлаар санхүүждэг бол **АНУ**-ын улс төрийн намууд их төлөв хувийн секторын эх үүсвэрээс санхүүждэг байна. Гэтэл **АНУ**-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн кампанит ажлын зардал, үйл ажиллагааны эх үүсвэр нь шууд төрийн сангаар дамжин суурь санхүүжилтээ авдаг онцлогтой. Энэ нь намууд төрийн болон хувийн хэвшлийн эх үүсвэрийн санхүүжилтийн харилцан хамаарал, тэнцвэрийг аль болохоор хангахад анхаардаг гэдгийг харуулж байна. Намын санхүүжилтийн дээрх хоёр хувилбар нь улс төрийн орчны хамаарал, нөлөө үр дүнг шаардахын хамт түүнд зохион байгуулалтын болон захиргааны нэмэлт тодорхой арга хэмжээг зайлшгүй авч хэрэгжүүлэхийг шаарддаг.

Зарим тохиолдолд төрийн болон хувийн эх үүсвэрээс зэрэгцэн санхүүжих хэлбэр нь маргаан дагуулдаг хэдий ч түүнийг Үндсэн хуулиар баталгаажуулан зөвшөөрдөг тул бэрхшээл төдийлөн үүсдэггүй байна. **АНУ**-д улс төрийн намууд дахь хувиараа хандивлагчид нь тус орны Үндсэн хуулиар хамгаалагдаж байдаг төдийгүй тэдэнд олгогдсон үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх суурь эрх чөлөө нь нээлттэй хэрэгждэг.

Бусад улс орнуудад тухайн улс төрийн намуудад хандив өгөх хувиараа хандивлагчдын хандивын хэмжээг хуулиар тодорхой хязгаарласан байдаг. Энэ нь улс төр дэх иргэдийн тэгш байдлыг хангах, баян ядуугийн ялгааг багасгах, хувь хүний авьяас чадварыг хөгжүүлэхэд тустай байдаг аж. Зарим улс орнуудын Үндсэн хуулинд улс төрийн

[445] National Democratic Institute for International Affairs (NDI). The Public Funding of Political Parties: An International Comparative Study. National Endowment for Democracy (NED). Jet line Visual Communications, Johannesburg, South Africa. 1999. Эх сурвалж: **Улс төрийн намуудын санхүүжилт: харьцуулсан судалгааны тойм.** Орчуулсан О.Хатанболд (Ph.D). Философи, эрхийн асуудал. XXXI боть. ШУА-ийн Философийн хүрээлэн. УБ., 2016. 354-362 дахь тал.

намуудын үйл ажиллагааг дэмжих зорилгоор тэдэнд тодорхой санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг хүлээн зөвшөөрдөг. Тухайлбал, **Франц, Герман, Малави, Мексик, Намиби, Португал** зэрэг улс орнуудад улс төрийн намуудыг төрөөс санхүүжүүлдэг байна.

Харин **Өмнөд Африк**ийн Үндсэн хуулинд улс төрийн намуудын нийгэмд гүйцэтгэх үүргийг улс орон дахь олон үндэстэн ястнуудын хүрээнд бий болсон ашиг сонирхлуудыг жигд анхааран харгалзаж, тэдний төлөө ажиллах явдал гэж үздэг.

**ӨМНӨД АФРИКИЙН БҮГД НАЙРАМДАХ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИАС (1996)**

**55-р зүйл. Үндэсний Ассамблейн бүрэн эрх**

2.Үндэсний Ассамблейн хуралдааны дэгийн тухай хууль тогтоомжид дор дурдсан асуудлыг тусгана:

б) Үндэсний Ассамблейд төлөөлж буй цөөнхийн намууд Үндэсний Ассамблей, түүний Хороодын үйл ажиллагаанд ардчиллын зарчмын дагуу оролцох;
в) улс төрийн намууд, тэдгээрийн удирдлагууд Үндэсний Ассамблейд чиг үүргээ үр дүнтэй гүйцэтгэх боломжийг бүрдүүлэхийн тулд Үндэсний Ассамблейд суудалтай бүх улс төрийн **намд тэдгээрийн төлөөлөлтэй тэнцүү санхүүгийн болон улс төрийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;**

**236-р зүйл. Улс төрийн намуудын санхүүжилт**

Олон намын ардчиллыг, үндэсний хэмжээний хууль тогтоомжийг сахин биелүүлэх зорилгоор улс төрийн намыг санхүүжүүлж, тэдний үндэсний болон бус нутгийн түвшин дэх хууль тогтоох үйл ажиллагаанд эрх тэгш, тэнцүү байдлыг хангаан ажиллахыг чухалчилна.

Эндээс үзэхэд, улс орнууд улс төрийн намыг санхүүжүүлэхдээ тухайн нам нь хууль эрх зүйн хүрээнд тогтвортой ажиллах, ардчиллын суурь зарчимд үндэслэсэн улс төрийн намуудын шударга өрсөлдөөн, улс төрийн оролцооны зохистой орчинг хэрхэн бодиттой хангаж буйг нь үндэслэн тэдний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг болохыг харуулж байна. Үүний тулд хууль эрх зүйн хүрээнд дараах асуудлуудыг нухацтай авч үзэхийг чухалчлах хэрэгтэй болдог. Үүнд:

1) намын санхүүжилтийн тогтолцооны гол үндэс юу болох; төрөөс санхүүжих нь тухайн улс төрийн намд санхүүжилтийн үндсэн эх үүсвэр болж чадаж буйг тодруулсан байх; хувиараа хандивлагчид санхүүжилтийн нийт хэдэн хувийг бүрдүүлдэг эсэх, хувийн болон төрийн санхүүжилтийн зохистой харьцаа тэнцвэрийг хэрхэн, яаж хангах; төрийн санхүүжилтийн эх үүсвэрийг ямар болзлоор хэрхэн түгээх; төрийн санхүүжилтийн зарцуулалтыг хэрхэн тайлагнах;
2) улс төрийн намуудын санхүүжилтийн зарцуулалтад ямар зохицуулалт, механизм, арга хэмжээг авч хэрэгжүүлж буй; санхүүгийн нөөц чадавхын зарцуулалтын хэмжээг тогтоох боломжтой эсэх; зарцуулалтын эргэн тайлагнах хэлбэр түүний хэрэгжилт ямар болох;
3) улс төрийн намуудад хувиараа хандивлагчдын зүгээс үзүүлж буй санхүүгийн дэмжлэгт ямар зохицуулалт хийгдэх; хувиараа хандивлагчид намд санхүүгийн хандив өгөхөд нь ямар нэгэн хязгаар байдаг эсэх; Хувиараа хандивлагчдаас авсан санхүүгийн дэмжлэгийн зарцуулалтын талаар тодруулга, тайлагнах ямар арга хэмжээ авдаг эсэх;
4) хууль сахиулах байгууллагуудын зүгээс улс төрийн намын санхүүжилтийн тогтолцоо, түүний хэрэгжилтийн үйл явцад шударга зарчмын хэрэгжилт, эргэж хянах хэлбэр, түүний бодитой үр өгөөжтэй, үнэн зөв эсэх; тухайн хяналтын байгууллага нь засгийн газрын болон бие даасан хараат бус байгууллагын аль нь байх эсэх, түүнийг нь хэн удирдах, тэдний эрх мэдлийн байдал ямар байх;
5) хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хэрхэн харилцах улс төрийн намууд чөлөөт,

шударга хэвлэл мэдээллээс татаас, дэмжлэг авдаг эсэх; хэвлэл мэдээллийн байгууллагууд улс төрийн намуудаас чөлөөт болон тодорхой хэлбэрээр татаас авдаг эсэх.

Дээрх шаардлагуудыг шийдвэрлэснээр улс төрийн намуудын санхүүжилтийн хэлбэр механизмын тухай дараах чиг баримжаа гарч байна. Үүнд:

1. төрөөс санхүүжих;
2. хувийн хандивлагчдаас санхүүжих;
3. төр болон хувийн санхүүжилтийн хосолсон хувилбараар санхүүжих;
4. хувиараа хандивлагчдад зарцуулалтын талаар нээлттэй тайлагнах;
5. зарцуулах журам;
6. зарцуулалтын нээлттэй тайлан;
7. хууль сахиулах, албан шаардлага;
8. хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл түгээх.

Ихэнх ардчилсан улс орнуудад улс төрийн намууд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тиймээс улс төрийн намуудын зүгээс олон нийтийн өмнө хүлээсэн үүргээ хууль эрх зүйн хүрээнд чанд нарийн гүйцэтгэж, улмаар санхүүгийн дэмжлэгээ зохих журмын дагуу тайлагнаж, олон нийтийн өмнө хариуцлага хүлээх чадвартай байхыг шаарддаг. Энэ нь тухайн улс орнуудад хариуцлагатай, шударга, ил тод, нээлттэй үйл ажиллагааг явуулах ардчилсан улс төрийн намуудын үйл ажиллагааны хамгийн чухал үүрэг, үнэт зүйлс болж байна.

### 2.1.Төрөөс санхүүжих

Олон улсын түвшинд хийгдсэн харьцуулсан туршлагаас үзэхэд, улс төрийн намуудын төрөөс санхүүжих хэлбэр нь янз бүрийн зорилготой хэрэгждэг. Төрийн санхүүжилтийн тогтолцоо нь сонгуулийн үйл ажиллагааг дэмжихийг илүүд үздэг байх, эсхүл улс төрийн намуудад сонгуулийн үйл явцад зардлаа хэтрүүлснээс үүдсэн санхүүгийн алдагдлаа нөхөх зорилгоор тэдэнд бага хэмжээний грант төслөөр дэмжлэг үзүүлэх хэлбэр байна.

Улс төрийн намуудыг төрөөс санхүүжүүлэх хоёр дахь чухал хэлбэр нь парламентын сонгуулиар дамжуулан улс төрд оролцогчдод дэмжлэг үзүүлэх хэлбэр юм. Үүнийгээ улс төрийн намын “дотоод үйл ажиллагааны зардал” гэж тайлбарладаг. Үнэндээ, төрийн санхүүжилтийн тогтолцоо нь тухайн улс төрийн намуудын төлөөллийн үндсэн зарчим, тэгш байдлыг тэнцвэржүүлэх зорилготой хуваарилалтын хэлбэр болдог.

### 2.2.Хувийн хандивлагчдаас санхүүжих

Хувийн хандивлагчдаас санхүүжих нь ихэнх улс орнуудад амжилттай хэрэгжиж буй санхүүжилтийн нэг хувилбар юм. Хувийн хандивлагчдаас санхүүгийн дэмжлэг авч, улс төрийн үйл ажиллагаагаа явуулах нь санхүүжилтийн түгээмэл хэлбэр болдог. Улс төрийн намуудын хувьд намын гишүүдээс санхүүгийн дэмжлэг авахын зэрэгцээ нам бус бусад дэмжигчдийн зүгээс санхүүгийн хандив цуглуулах явдал нэлээд өргөн хүрээг хамардаг. Намын санхүүжилтийн хүрээн дэх хувийн хандивлагчид болон улс төрийн намуудын хоорондын итгэлцлийн гол түлхүүр нь харилцан тайлан гаргах явдал юм.

**Германд**[446] улс төрийн намыг төрөөс санхүүжүүлэхдээ тодорхой хувь тогтоох бөгөөд тухайн улс төрийн намд хуулийн хүрээнд тодорхой нөхцөлтэйгөөр санхүүжилтийг олгодог. Энэ нь тухайн улс төрийн намуудыг хувийн хандивлагчдаас авсан санхүүгийн дэмжлэгийн өмнө хариуцлага хүлээж, тайлагнахыг баталгаажуулдгаар онцлогтой. Хувийн хандивлагчдад итгэл үзүүлэхдээ тухайн хандивлагчдын хандив өгөх эрх зүйн болон бусад талын боломжийг хангах тал дээр анхаардаг байна. Тэгэхдээ хандивлагчийн намын болон улс төрийн тогтолцоо, үйл явцад шууд хөндлөнгөөс оролцох явдлыг сааруулах тал дээр ч мөн давхар анхаардаг байна.

[446] Act on Political Parties of 24 July 1967. Эх сурвалж:
https://www.bundestag.de/blob/189734/2f4532b00e4071444a62f360416cac77/politicalparties-data.pdf

## ХБНГУ-ЫН УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛИАС (1967)

**18 дугаар зүйл. Төрөөс үзүүлэх санхүүжилтийн зарчим, хүрээ**

(1) Үндсэн хуульд заасны дагуу намуудын үйл ажиллагааг хэсэгчлэн санхүүжүүлнэ. Төрийн сангаас санхүүжилт хуваарилах шалгуур нь намуудын Европын холбоо, Бундестаг, Орон нутгийн парламентын сонгуульд санал авсан хувь болон түүний гишүүдийн татвар, төрийн байгууллагуудад сонгогдсон албан тушаалтнуудын болон хүлээн авсан бусад хандивын нийт дүнтэй тэнцүү байна.

(2) Төрийн сангаас улс төрийн намуудад жил бүр хуваарилж болох санхүүжилтийн дээд хэмжээ 133 сая евро (дээд хязгаар) байна.

(3) Улс төрийн намууд төсвөөс хэсэгчилсэн санхүүжилтийн хүрээнд жилд дараахь нийт дүнг авна:

1. намуудын нэрсийн жагсаалтад хүчин төгөлдөр санал тус бүрт 0,70 евро;
2. хэрэв намын нэрсийн жагсаалтыг Орон нутгийн түвшинд хүлээн зөвшөөрөөгүй бол тухайн намд өгсөн санал тус бүрт 0,70 евро;
3. бусад эх сурвалжаас авсан евро тус бүрт 0.38 евро (гишүүнчлэлийн татвар, хандив, албан тушаалд сонгогдсон албан тушаалтнуудын өгсөн, эсхүл хуулийн дагуу авсан хандив); хандивыг зөвхөн нэг хүнд ногдох хэмжээ нь 3,300 хүртэл еврог тооцно.

Энэ хэсгийн 1, 2-т заасан хэмжээг өөрчлөхийн тулд намд өгсөн 4 сая хүртэлх хүчин төгөлдөр саналд 0.85 евро авна.

**19а дугаар зүйл. Санхүүжилтийн түвшинг тодорхойлох журам**

(1) Германы Бундестагийн Ерөнхийлөгч улс төрийн намд хуваарилагдах өнгөрсөн жилийн төрийн сангийн санхүүжилтийн хэмжээг жил бүрийн 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор тодорхойлно…

**24 дүгээр зүйл. Орлого, зарлага**

(4) Орлого нь:

1. гишүүдийн татвар;
2. сонгуульт албан тушаалтнуудын өгсөн хандив, түүнтэй төстэй тогтмол шимтгэл;
3. хувь хүмүүсээс өгсөн хандив;
4. хуулийн этгээдээс өгсөн хандив;
5. үйл ажиллагаанаас олсон орлого;
6. хөрөнгийн орлого;
7. хэвлэмэл материалаас олсон;
8. төрийн сан;
9. бусад орлого;
10. намын салбар байгууллагаас авсан буцалтгүй тусламж;
11. энэ зүйлийн 1-10-д заасан нийт орлого зэргээс бүрдэнэ.

(5) Зарлага нь:

1. боловсон хүчний холбоотой зардал;
2. үйл ажиллагааны зардал:
   а) өдөр тутмын үйл ажиллагаа;
   б) намын үндсэн ажил;
   в) сонгуулийн кампанит ажил;
   г) активын удирдлага, түүний хүү;
   д) бусад сонирхол;
   е) бусад зардлууд;
4. намын салбар байгууллагуудад олгосон буцалтгүй тусламж;
6. энэ зүйлийн 1-3-д заасан ний зардал зэргээс бүрдэнэ.

**25 дугаар зүйл. Хандив**

(1) Улс төрийн намууд хандив хүлээн авах эрхтэй. Хандивыг 1,000 хүртэл еврогийн бэлэн мөнгөөр хийж болно. Улс төрийн намын нэрийн өмнөөс хандив хүлээн авсан намын гишүүд нь хандивыг нэн даруй намын санхүүгийн асуудалд хариуцсан Гүйцэтгэх хорооны гишүүнд шилжүүлнэ. Намын санхүүгийн асуудал хариуцсан Гүйцэтгэх хорооны гишүүн, эсхүл тухайн намын орон тооны ажилтан-гишүүн нь хандивыг захиран зарцуулах эрх олж авсан үед хандив авсан гэж үзнэ. Хандивлагч этгээдэд хандивыг нэн даруй буцаан өгсөн бол улс төрийн нам хандив хүлээн авсанд тооцохгүй.

### 2.3.Төр болон хувийн хосолсон хувилбараар санхүүжих

Улс төрийн намуудын хувийн хандивлагчдаас санхүүжих явдлыг хязгаарлахын тулд дараах хоёр хүчин зүйлсийг авч үзэх хэрэгтэй. Үүнд:

1) зөвшөөрөгдсөн тодорхой хэмжээний хандивыг хүлээж авах;
2) тогтсон эх үүсвэрээс санхүүжих, тухайлбал, **Израил** болон **АНУ**-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн төрийн болон хувийн хандивлагчдын зүгээс санхүүжих хосолсон механизмтай.

**Энэтхэг**ийн хувьд, хувиараа аль нэг улс төрийн намд хандив өгөх тохиолдолд тухайн хандивын хэмжээний хязгаарыг тогтоосон байдаг төдийгүй тухайн хандивлагчид ямар нэгэн албан тушаал олгох, амлалт өгөх явдлыг шууд хориглодог байна. **Өмнөд Африкт** улс төрийн намуудад шууд хандив өгөх асуудалд төдийлөн анхаарал хандуулдаггүй, харин тусгай санд хандивыг татан төвлөрүүлэхийг зорьдог байна. Мөн Өмнөд Африкт улс төрийн намуудыг санхүүжүүлэхдээ юуны өмнө тухайн намыг парламентад болон орон нутгийн хууль тогтоох байгууллагад оролцож буй төлөөллийг харгалзах байдлаар улс төрийн намуудын төлөөллийг нэн тэргүүнд авч үзэх байдлаар санг бүрдүүлдэг ажээ.

Түүнчлэн зарим хуульд хувийн хандивлагчдын эх үүсвэрт тодорхой хязгаарлалт хийдэг. Үүнийг тодорхой хоёр энгийн шалтгааны улмаас хязгаарладаг байна. Энэ нь тухайн улс төрийн намуудын санхүүжилтэд гадаадын болон нэр үл мэдэгдэх хувь хүн, байгууллагаас санхүүжихийг хатуу хориглодог. Харьцуулсан судалгаанд хамрагдсан **Австрали, Канад, Герман, Энэтхэг, Израил, Швед, Шинэ Зеланд, Өмнөд Солонгос, Зимбабве, АНУ, Өмнөд Африк** зэрэг улс орнуудад нэр үл мэдэгдэх хандивлагчдаас ирүүлсэн хандиваар улс төрийн намууд санхүүжихийг хатуу хориглодог байна.

**АНУ, Канад, Энэтхэг, Израил** зэрэг улсуудын хувьд гадаадын хандивлагчдаас ямар нэгэн санхүүгийн дэмжлэг, хандив цуглуулах, авахыг шууд хориглодгийн зэрэгцээ **Герман, Израил, АНУ**-ын хувьд томоохон үндэстэн дамнасан, эсхүл том хэмжээний корпорацуудаас улс төрийн намуудад хандив өгөх, санхүүгийн дэмжлэг авахыг мөн хатуу хориглосон байдаг.

### 2.4. Хувиараа хандивлагчдад зарцуулалтын талаар нээлттэй тайлагнах

Ихэнх улс төрийн намуудын санхүүжилтийн тогтолцоонд нийтлэг хадгалагддаг шинж бол хувиараа хандивлагчдад тэдний санхүүжилтийн талаар нээлттэй тайлан хийхийг нэн тэргүүнд шаардаж, онцгой анхаарал хандуулдаг явдал юм. Харин эл судалгаанд хамрагдсан улс орнуудаас **Өмнөд Африк, Швед, Зимбабве** зэрэг улсад хувь хандивлагчдаас ирүүлсэн хандивын зарцуулалтад ямар нэгэн санхүүгийн нээлттэй тайлан, танилцуулга хийдэггүй. Гэсэн хэдий ч ихэнх орнуудад улс төрийн намуудад өгөх хандивын босгыг тогтоосон байдаг бөгөөд үүний гол зорилго нь тодорхой хэмжээнээс дээш хандив өгөхийг зөвшөөрсөнтэй холбоотойгоор зарцуулалтын талаарх санхүүгийн нээлттэй тайлан хийх механизмыг давхар бий болгосон явдал юм. Санхүүжилтийн босгын хувьд улс орон бүр янз бүрийн хэмжээ тогтоосон байдаг. **Канад** тухайн улс төрийн намуудад 80 ам.доллараас дээш хандив өгсөн бүх хүмүүс, дэмжигчдэд санхүүгийн нээлттэй тайланг гаргаж өгөх үүрэгтэй, **Герман**д сонгуулийн хандивын босгыг ойролцоогоор 11.000 ам.доллараар тогтоосон бол, **Израил**д хандив өгсөн бүх хүмүүст хандивын зарцуулалтын тайланг танилцуулах, тэд тайлан өгөх үүрэгтэй ч хандивын

тогтсон босго гэж байдаггүй.

Өөрөөр хэлбэл, улс төрийн намуудын захиргааны аппаратын зүгээс санхүүгийн нээлттэй тайланг олон улсын жишиг загварыг үндэслэн тайлагнадаг. Тухайн хандивын тайланг хандивлагчдын нэрсийн жагсаалт, хаягийн бүртгэлийн дагуу жагсаан тайлагнах бөгөөд ихэнхи улс оронд санхүүгийн нээлттэй тайлан-тэнцэлийг жил бүрээр гаргаж тайлагнадаг байна.

### 2.5.Зарцуулах журам

Улс төрийн намын санхүүжилтийн зарцуулалтыг тайлагнах журам нь ерөнхийдөө тухайн хандивын хэмжээ, зарцуулалтын хэлбэр гэсэн тодорхой хүчин зүйлсээс хамаардаг байна. Улс төрийн намын хандивын зарцуулалтыг зөвшөөрөгдсөн хэмжээгээр хязгаар тогтоох нь түгээмэл байдаг.

Судалгаанд хамрагдсан улс орнуудад энэхүү томьёоллын дагуу өөрсдийн хандивын зарцуулалтын хэмжээ, хязгаарыг тогтоосон найман улс байхад, **Австрали, Герман, Швед** зэрэг орнуудын хувьд улс төрийн намуудын хандивын зарцуулалтын хэмжээний талаар ямар нэгэн хязгаар тогтоогоогүй байна. Харин **Өмнөд Солонгос, Шинэ Зеланд** зэрэг орнууд улс төрийн намын сонгуулийн үйл ажиллагаанд зориулан хандивласан хандив, мөнгөний зарцуулалтыг хараат бус бүлгүүдийн дэмжлэгтэйгээр хязгаартайгаар зарцуулж түүнийгээ тайлагнана. Улс төрийн намуудын хандивын зөвшөөрөгдсөн хэмжээний хандивын зарцуулалтын хэлбэр, мөнгөн дүнгийн хязгаарыг хуулийн зүйл, заалтаар тодорхойлон гаргасан байдаг. Ингэхдээ улс орнуудад улс төрийн намын санхүүжилтийг хувийн зорилгоор ашиглах, зарцуулахыг хатуу хориглодог ч тодорхой хэмжээний зөвшөөрөгдсөн зарцуулалтыг тодорхой тайлагнахыг чухалчилдаг. **Герман**ы хуулинд зөвшөөрөгдсөн зардлыг дараах долоон хэсэгт ангилан хувааж тус бүрээр нь тодорхойлсон байдаг. Тухайлбал, намын албан хаагчид, одоогийн бизнесийн үйл ажиллагаа, намын ерөнхий үйл ажиллагаа, сонгууль, ашиг орлого, бусад зарцуулалт, төсвийн хуваарилалт болон хэсэгчилсэн хуваарилалт, зарцуулалтыг багтаасан байна.

### 2.6.Зарцуулалтын нээлттэй тайлан

Улс төрийн намын санхүүжилтийн зарцуулалтын тайланг бараг бүх тогтолцоонд нийтлэг байдаг. Эл судалгаанд хамрагдсан улс орнууд болон **Швед**ээс бусад орнуудад зарцуулалтын тайланг төдийлөн чухалчилдаггүй. Мэдээж хэрэг, ихэнх орнуудад санхүүжилтийн зарцуулалтыг тайланг шаардах боловч **Австрали, Канад** зэрэг улсад зарцуулалтын босгыг нарийн сайн тогтоосон байх боловч түүнийг заавал тайлагнахыг шаарддаггүй байна. Улс орнууд тайлагнахдаа өөр хоорондоо ялгаатайгаар тайлагнана.

Намын санхүүжилтийн зарцуулалтын тайлангийн чухал асуудал бол тухайн намын санхүүгийн үйл ажиллагаа, зарцуулалтын талаарх мэдээллийг олон нийтэд мэдээлэх, тэдний саналыг тусгах явдал мөн. Энэ талаар хийгдсэн туршлага нь өөр хоорондоо ялгаатай. **Австрали, Герман, Энэтхэг, Израил, Шинэ Зеланд, АНУ** зэрэг орнууд зарцуулалтын санхүүгийн нээлттэй тайланг нийтэд түгээж болдог. Харин **Канадын** хувьд олон нийтийн өмнө танилцуулахын зэрэгцээ бие даасан хөндлөнгийн байгууллагуудаар хянуулж, хөндлөнгийн тайлан бичүүлэх зэрэг хосолмол аргыг хэрэглэдэг байна. **Солонгос**ын тухайд санхүүгийн зарцуулалтыг намын удирдах албан тушаалтнууд, сонгуулийн төв байгууллагын албан хаагчид, нэр дэвшигчид болон намын ажилтнуудад танилцуулах тогтолцоотой. Харин **Өмнөд Африк, Зимбабве** зэрэг орнуудад санхүүгийн нээлттэй тайлан танилцуулах орчин байдаг хэдий ч түүнийг яг нарийвчлан дагаж мөрддөг талаарх тодорхой мэдээлэл, кейс байдаггүй.

### 2.7.Хууль сахиулах, албан шаардлага

Хууль сахиулах байгууллагуудын хувьд улс төрийн намын санхүүжилтийн тогтолцооны үйл ажиллагааны болон хэрэгжилтийн байдлыг хөндлөнгөөс шүүмжлэлт байр суурьнаас нарийвчлан хянахад анхаардаг. Энэхүү үйл ажиллагааны эрх, үүргийг хууль сахиулах байгууллагуудад шууд олгосон нь ихээхэн чухал зүйл. **Канад, АНУ, Шинэ Зеланд, Өмнөд Африк** зэрэг орнуудад энэ чиглэлээр бие даасан хараат бус байгууллагыг засаг захиргааны дунд шатны байгууллагуудын төлөөллийг оролцуулсан байдлаар төрийн байгууллагын статустайгаар байгуулсан байдаг. Дурдсан улс орнуудад хараат бус

сонгуулийн хорооны дэргэд төрийн сангаас хуваарилагдсан санхүүжилтийн зарцуулалт, намуудын төсвийн хуваарилалт зэргийг хянах, хөндлөнгийн дүгнэлт өгөх хууль шүүхийн эрх бүхий эрх зүйн этгээдийг томилон маргааныг тасалж, шийдвэрлэх эрхийг олгодог. **Израилд** энэхүү эрх бүхий этгээдийг хууль сахиулах байгууллагаас томилж Төрийн хянагч (State Comptroller) гэж нэрлэдэг.

**Германд** энэ тохиолдолд Бундестагийн (Парламентын доод танхимын) дарга энэ албыг хашдаг. Хуульд заасны дагуу Бундестагийн дарга тухайн улс төрийн нам төрийн санхүүжилтийг хэрхэн зарцуулсан болон сонгогдсон улс төрийн нам үүнийг хэрхэн хуваарилсан эсэхийг хянан шалгаж, хэрэв ямар нэгэн алдаа дутагдал гарсан бол тухайн намд торгууль, шийтгэл ногдуулах эрх мэдэлтэй байдаг байна. Сонгуулийн хороо нь улс төрийн намуудын санхүүжилтийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих, мөрдөн шалгалт хийх, прокурорын дүгнэлт гаргуулж, хэрвээ шаардлагатай тохиолдолд холбогдох хэрэг үүсгэж, шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлэх бүрэн эрхтэй.

**2.8.Хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл түгээх**

Ихэнх улс төрийн намуудын хувьд хэвлэл мэдээллийн байгууллагуудад зарцуулах хөрөнгө зардал ихээхэн чухал байр эзэлдэг. Тухайлбал, Сонгуулийн кампанийн үеэр хэвлэл мэдээлэлд намын нийт санхүүжилтийн 40-70 орчим хувийг зарцуулдаг бөгөөд энэ нь улс төрийн намуудын санхүүжилтийн тогтолцоонд тодорхой жин дарж, намуудын мэдээллийн хэрэгслээр үйл ажиллагаагаа сурталчлах, үйл хэрэгт нь зарцуулагддаг байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэх мэдээллийн цаг нь хоёр үндсэн аргаар хангагдана.Энэ нь засгийн газраас тодорхой тогтсон хэвлэл мэдээллийн байгууллагуудыг санхүүжүүлэх, эсхүл засгийн газрын зүгээс өөрийн зөвшөөрөлтэй мэдээллийн хэрэгслээр дамжуулан тэнцвэртэй мэдээллийг олон нийтэд давтамжтай байдлаар цацах боломжийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ. Түүнчлэн хувийн болон төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл дамжуулах боломж орчинг тэнцвэртэй бүрдүүлэхийг чухалчилдаг. Ихэнх оронд олон нийтийн телевиз, радио байдаг бөгөөд тэдгээр нь парламентын болон сонгуулийн улс төрийн үйл ажиллагаанд оролцоход нь улс төрийн намуудад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

**Германд** энэ үүргийг хэрхэн ханган биелүүлж буйг тус улсын Үндсэн хуулийн шүүхээс өгсөн зөвлөмж, чиглэлийн дагуу олон нийтийн болон хувийн салбарын хэвлэл мэдээллийн хэрэгслээр тэнцвэртэй дамжуулахыг шаарддаг. Гэхдээ улс төрийн намуудын зүгээс энэ чиглэлээр нарийн тогтсон стандарт, мөрдөх журам төдийлөн байхгүй ч, **АНУ** зэрэг зарим улсад төрийн болон хувийн хэвшлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр улс төрийн намууд өөрсдийн үйл ажиллагааг сурталчлах, олон нийтэд түгээхэд арилжааны хамгийн доод үнийг санал болгодог.

**Канадад** чөлөөт, хувийн салбарын хэвлэл мэдээллийн хэрэгслээр өөрийн үйл ажиллагааг сурталчлах мэдээллийн цагийг дамжуулах нарийн тогтсон нөхцөл байдал байдаггүй ч тухайн мэдээллийг дамжуулахдаа аль нэг талыг баримталсан байдлаас аль болох зайлсхийх, тэнцвэртэй байр суурийг ханган ажиллахыг шаарддаг. Зарим орнуудад улс төрийн намуудад мэдээллийн цагийг олгохдоо тодорхой хязгаартайгаар олгодог. Түүнчлэн **Энэтхэг, Израил** зэрэг улсад улс төрийн намууд сонгуулийн кампанийн үеэр төлбөртэй сурталчилгаа, нэвтрүүлэг явуулахыг хатуу хориглодог. **Австрали, Канад, Шинэ Зеланд, Швед, АНУ**-д зар сурталчилгаанд төлбөр төлөхийг зөвшөөрдөг. Канадад сонгууль болохоос өмнөх 48 цагийн дотор сурталчилгаа явуулахыг хориглоно.

**Солонгос**т улс төрийн намуудад төлбөртэй нэвтрүүлэг, сурталчилгаа явуулахыг зөвшөөрдөггүй ч харин нэр дэвшигчдэд зөвшөөрдөг. Хэрэв тухайн улс төрийн намууд, нэр дэвшигчдийн зүгээс өөрсдийн үйл ажиллагааны талаар бэлтгэсэн нэвтрүүлгийг өөрсдөө хийсэн бол түүнийг олон нийтэд түгээх, өргөн нэвтрүүлгээр цацах тохиолдолд эхлээд хэвлэл мэдээллийн хэрэгслийн байгууллагуудаас тухайн нэвтрүүлгийг хянан үзэж, тодорхой шалгуураар хяналт тавьсны дараа уг мэдээллийг олон нийтэд цацдаг байна. **Австрали, Канад, Солонгос, Шинэ Зеланд, АНУ** зэрэг улс орнууд үүнтэй нэгэн адил тодорхой дагаж мөрдөх зохицуулалттай.